Монгол Улсын Үндэсний Номын Сан

Нийтийн номын сангуудын

тайлан 2015

Редактор: Д.Энхтунгалаг /МАЗЭШХ-ийн дарга /

Эмхэтгэсэн: Г.Гүнжинлхам /Ахлах аргазүйч /

Улаанбаатар хот

2016 он

НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН ТАЙЛАН -2015

Ред: Д.Энхтунгалаг /МАЗЭШХ-ийн дарга/

Эмхэтгэсэн: Г.Гүнжинлхам /Ахлах аргазүйч/

Хэвлэлийн хэмжээ

Хэвлэлийн эхийг “Содпресс” хэвлэлийн компанид бэлтгэж хэвлэв.

Улаанбаатар хот, 2015 он

ӨМНӨХ ҮГ

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй аймаг, нийслэлийн нийтийн номын сангууд жил бүр хийсэн ажлынхаа үр дүн, тайланг Үндэсний номын сангийн аргазүйн хэлтэст явуулсныг бид эмхтгэн, 12 дэх удаагаа та бүхэнд хүргэж байна.

Энэхүү “Нийтийн номын сангуудын тайлан” эмхтгэл нь үйлс нэгт нөхөд өөрсдийн ажлын амжилт, үр дүнг бусад номын сангуудтай харьцуулан судлах, харилцан туршлага солилцох, өдөр тутмын ажил болоод цаашдын төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэхэд зохих хувь нэмэр болно хэмээн найдаж байна.

Та бүхний илгээсэн тайланг эмхтгэхийн зэрэгцээ номын сангийнхаа давуу, сул талд дүн шинжилгээ хийхэд хялбар байх үүднээс тайлан тус бүрээс номын сангийн гол үзүүлэлтэд харьцуулсан судалгааг хийж, схем, диаграммаар хавсаргалаа.

Хамтран ажилласанд талархлаа дэвшүүлье.

НОМЫН ЦАГААН БУЯН УЛАМ ДЭЛГЭРЭХ БОЛТУГАЙ.

Монгол улсын Үндэсний номын сан

Мэдээлэл-аргазүй, эрдэм шинжилгээний хэлтэс

Tel: 70-11-23-97

Website: www.nationallibrary.mn

Агуулга

Өмнөх үг 3

Монгол Улсын Үндэсний Номын Сангийн 2015 оны бүтээгдэхүүн
нийлүүлэлтийн ажлын тайлан 7

Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын төв номын сангийн 2015
оны үйл ажиллагааны болон бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний
тайлан 77

Хүүхдийн Төв Номын сангийн 2015 оны ажлын тайлан 101

Архангай аймгийн нийтийн номын сан мэдээллийн төвийн 2015 оны
жилийн ажлын тайлан 186

Баян-Өлгий аймгийн нийтийн номын сангийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 211

Баянхонгор аймгийн нийтийн номын сангийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 221

Булган аймгийн төв номын сангийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 247

Говь-Алтай аймгийн нийтийн номын сангийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 277

Говьсүмбэр аймгийн нийтийн номын сангийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 286

Дархан-Уул аймгийн төв номын сангийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 292

Дархан-Уул аймгийн Хүүхдийн Номын Ордоны 2015 онд
хийсэн ажлын тайлан 312

Дорноговь аймгийн төв номын сангийн 2015 онд

хийсэн ажлын тайлан 332
Дорнод аймгийн төв номын сангийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 341
Дундговь аймгийн төв номын сангийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 369
Завхан аймгийн төв номын сангийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 379
Орхон аймгийн номын төвийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 389
Өвөрхангай аймгийн төв номын сангийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 402
Өмнөговь аймгийн төв номын сангийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 416
Сүхбаатар аймгийн нийтийн номын сангийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 431
Сэлэнгэ аймгийн нийтийн номын сангийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 463
Төв аймгийн нийтийн номын сангийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 489
Увс аймгийн төв номын сангийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 498
Ховд аймгийн нийтийн номын сангийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 521
Хөвсгөл аймгийн нийтийн номын сангийн 2015 онд
хийсэн ажлын тайлан 569
Хэнтий аймгийн нийтийн номын сангийн 2015 онд

хийсэн ажлын тайлан 587

Аймгуудын судалгаа -2015 603

ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2015 ОНЫ
ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

НЭГ.НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт *(тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)* ***бүрээр хүрэх түвшин***	***Жинхэнэ гүйцэтгэл*** *(тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)*	***Нийт арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ*** *(Нийт арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо)*
1	2	3
1. “Үндэсний хөгжлийн цогц бодлого”- Стратегийн зорилт. 2. Хүн амд соёл, урлагийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж, иргэдийн оюуны хэрэгцээг хангах талаар дорвитой ахиц гаргана”-ын хүрээнд дэвшүүлсэн зорилт: ***НЭГ.”Соёлын өв, оюуны бүтээлийг цуглуулан баяжуулж, нээлттэй хүртээмжтэй мэдээлллээр үйлчлэх” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:***		

1. Сан хөмрөгт судалгаа хийж, шинэ ном хэвлэлээр баяжуулах, номын сангийн арга ажиллагаанд оруулах, уншигчдад мэдээллээр үйлчлэх ажлын хүрээнд: 1.1. Номын худалдаа, нөхөн бүрдүүлэлт, бэлэг солилцоогоор шинэ ном авах шинжлэх ухааны төрөл, салбараар ангилах, дансанд бүртгэх, ажиллах, карт бичих. Архив, Бэлтгэл фондыг шинэ номоор бүрдүүлэх, харилцаат номын сангуудад ном илгээх, хүлээн авах:	**Нийт**: **4100 ширхэг ном авахаас 4107 ширхэг 1320 нэрийн 34 262 343 төгрөгийн номоор сан хөмрөгийн бүрдүүлэлт хийсэн байна. 109.6%** ➢ Шинээр 1611 ширхэг 297 нэрийн 27 784 547 төгрөгийн ном худалдан авсан ➢ Бэлгийн журмаар 2496 ширхэг 946 нэрийн 31 494 016 төгрөгийн ном ➢ Нөхөн бүрдүүлэлтээр 50 ном авахаас 250 нэрийн 299 ш 1 589 817 төгрөгийн ном ➢ Эрдмийн зэрэг горилсон 116 нэрийн 128 диссертац болон хураангуйг 1 192 000 төгрөгөөр авч фактурлан ангилагчид шилжүүлэв. ➢ 4 392 700 төгрөгийн 51 нэрийн 58 ш сонин, 40 нэрийн 56 ш сэтгүүл захиалсан ➢ Тогтмол хэвлэлийг захиалгын дагуу хүлээн авч, холбогдох хэсэгт бүртгэн шилжүүлж, 5 нэрийн сонинг цахим хэлбэрээр уншуулж байна ➢ ССАЖЯ-ны санаачлагаар орчуулж, Монголын Үндэсний номын сангаас эмхтгэн гаргасан “Ном хадгалах хамгаалах” гарын авлага /2972x9=26748 ширхэг/ 9 цуврал товхимолыг номын сангуудын тоо, судалгааг гарган жагсаалт хийж, нийтийн бүх номын сангууд, их, дээд сургууль, ЕБС-ийн номын сангийн эрхлэгч, ном бүрдүүлэгчдэд хүлээлгэн өгч байна. ➢ Гадаадын номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудад 4 578 368 төгрөгийн 77 нэрийн 305 ном илгээж, 7 853 422 төгрөгийн 249 нэрийн 316 ном, 174 670 төгрөгийн 12 нэрийн 830 сонин, 740 450 төгрөгийн 181 нэрийн 590 сэтгүүл хүлээж авсан. Нийт 4 578 368 төгрөгийн ном илгээж, 8 768 542 төгрөгийн ном, хэвлэл хүлээн авлаа	

1.1.1. Бүрдүүлэлтээр ирсэн номыг шинжлэх ухааны төрөл салбараар ангилж, дансалж бүртгэнэ. 1.1.2. Бүрдүүлэн авсан номыг ажиллана. 1.1.3. Бүрдүүлэлтээр ирсэн номонд карт бичиж, байрлуулна. 1.1.4. Архивын болон бэлтгэл фондыг шинэ номоор бүрдүүлнэ. Шинэ ном авах- 4100, Ангилах-4050, данслах–4150, Ажиллах – 4050, Карт бичих, байрлуулах – 6500, Харилцаат номын санд илгээх ном–300, хүлээн авах ном-300, сонин – 800, сэтгүүл- 300	- 4050 ном ангилахаас 1956 нэрийн 4136 ширхэг ном ангилав - 4150 ном данслахаас 1862 нэрийн 4338 ширхэг ном данслав • Бэлтгэл фондын 1988-2010 оны 3411 ширхэг зарлагыг 2012 оны тооллогын дутагдлын жагсаалт, бэлтгэл фондын нэгбүрчилсэн бүртгэлтэй тулган шалгасан • Захирлын 2015 оны 4-р сарын 21-ний А/22 тоот тушаалын дагуу Солонгос номын танхимын номын санч Т.Түвшинтунгалагийн хариуцаж байсан номыг тоолж дорно дахины фондын номын санч П.Анхмаад хүлээлгэн өглөө. Уг танхим нь албан ёсны данс бүртгэлгүй байсан бөгөөд нийт 4353 ш ном тоолж хүлээн авч, дансны дугаараар эрэмбэлэн цэгцэлж албан ёсны дүнг гаргалаа. Мөн гүйцэд ажиллагаа хийгдээгүй 45 ширхэг номыг тусад нь бүртгэж хүлээлгэн өгсөн. • Нэгдсэн бүртгэлийн 12 ширхэг дэвтэр хөтөлсөн. • Бэлтгэл номын фондын 2 021 600 төгрөгийн 59 нэр төрлийн 148 ширхэг номын зарлагыг нэг бүрчилсэн бүртгэл болон электрон бүртгэлээс “хасалт” тэмдэглэгээ хийж, 293 ширхэг шинээр орсон номыг электрон бүртгэлд шивж оруулсан. • Номын данс цэгцлэх, хянах ажлын хэсгийг байгуулж ажиллаж байна • Архивын фондод давхардаж бүртгэгдсэн 2119 ш номноос 222 ш монголд, 799 ш явуулын, 1098 ш акталж жагсаалт гаргахаар албан тоот хүргүүлсэн. -4050 ном ажиллахаас 1859 нэрийн 4025 ширхэг ном ажиллав Үүнд: Худалдааны 448 нэрийн 1337 ширхэг, солилцооны 249 нэрийн 316 ширхэг, бэлгийн 1252 нэрийн 1960 ширхэг нөхөн бүрдүүлэлтийн 252 нэрийн 284 ширхэг ном, 123 нэрийн 128 ширхэг диссертац, хураангуй, CD тус тус ажилласан -6500 ширхэг карт бичихээс 5460 ширхэг карт бичсэн Үүнд: Монгол фондын 967 нэрийн 2386 номонд 2553 ш, өрнө дахины фондын	

	Каталогийн ажлын талаар: • Шинээр монгол 2553 ш, өрнө дахины 680 ш, монгол судлалын 154 ш, диссертацийн 337 ш, архивын 1736 ш карт байрлуулан; • Монгол ТАК 3-4, 10,11,19, Орос ТАК 130-131, Орос аравтын 64,189, Монгол судлалын ТАК 17, Албаны орос ҮДК 111-138, Орос ҮДК 5-10, Монгол судлалын албаны МС-1, МС-2, Өвөрмонголын 463, Монгол судлалын 4-6-р шогол, Диссертацийн 44, 61,63-р шоголуудыг данс, фонд, электрон каталогтой тулган редакц хийж, • Албаны монгол судлалын И-Ко, МС-1,2, Орос ҮДК 5-10, Монгол ТАК 10-11,19, Орос аравт 17, 64, Монгол судлалын 2-3, Орос ТАК 130 дугаар шоголуудыг шинэчлэн хуулан, • Албаны орос үсгийн 111-138, Орос ҮДК 9-24, 44-52, Гадаад ҮДК 531-534, Орос ТАК 131-134,Гадаад ТАК 486, 488-489, Монгол судлалын 2-3 дугаар шоголд ялгагч шинэчлэн бичиж, • Уншигчдад байнга зөвлөгөө, лавлагаа өгч ажиллан, өгөгдсөн 95 лавлагааг бүртгэлд бүртгэлээ. Архив ба бэлтгэл фондын ажлын талаар: • Архив, бэлтгэл фондод 717 картыг хүлээн авч байрлуулж, 349 нэгж сонин сэтгүүлд ялгагч хийв. • Архивт шинээр 905 ном хүлээн авч байрлууллаа • Архивт 99 нэрийн шинэ тогтмол хэвлэл хүлээн авахаас 48 нэрийн сонин, 51 нэрийн сэтгүүл хүлээн авч байрлуулан 432 нэгж тогтмол хэвлэлийг хавтаслуулж, хүлээн авлаа. • 32549 номыг цэгцэлж байрлууллаа. • Бэлтгэл фондод шинээр 240 ном авлаа. • Бэлтгэл фондоос захирлын зөвшөөрлийн дагуу-101 нэрийн, 2 890 318 төгрөгний үнэ бүхий 213 ш номыг зарлагадаж, баримтыг бүртгэлийн номын санчид өгч, дансанд тэмдэглэгээ хийлгэв. Хяналтын тооллогын талаар:	

1.2. Номын сангийн уламжлалт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, уншлагын танхимуудаар чанартай үйлчилгээ үзүүлэх: 1.2.1. Ерөнхийлөгчийн нэрэмжит танхимаар 6000 уншигч, судлаачдад 20.000 номоор 1.2.2. Их уншлагын танхимаар 32000 уншигчдад 100.000 номоор үйлчилнэ. -Солонгос мэдээллийн төв, Тогтмол хэвлэл, интернэт болон төлбөртэй үйлчилгээ-ний танхимуудаар 3750 уншигчдад үйлчилнэ. 1.2.3.Уншигч үйлчлүүлэгч-дээс сэтгэл ханамжийн судалгаа авч, санал хүсэлтийг судалж шийдвэр-лэнэ. /2 удаа/ 1.2.4. Цахим уншлагын танхим байгуулж шинэ үйлчилгээг нэвтрүүлэн, уншигчийн хүрээг өргөтгөж, үйлчилгээний соёлыг сайжруулна.	**1.2. Тайлангийн хугацаанд 40 440 ирцэд 130 540 ном, хэвлэл олгохоос 52 168 ирцэд 131 133 ном олгож үйлчиллээ.** **1.2.1**. -Их уншлагын танхим 43357 уншигчдад 94961 ном хэвлэлээр, Ерөнхийлөгчийн нэрэмжит танхим 6088 уншигчдад 20361 номоор үйлчилсэн ба 2278 гар бичмэл номоор үйлчилж, 735 хүнд аман лавлагаа өгсөн. **1.2.2.** Солонгос мэдээллийн төв 202 уншигчдад 644 ном хэвлэлээр үйлчилж, 202 хүнд аман лавлагаа өгсөн. -Тогтмол хэвлэлийн уншлагын танхимаар 2521 уншигчдад 15167 сонин сэтгүүлээр, интернет танхимаар 326 уншигчдад тус тус үйлчиллээ. Хууль зүйн хүрээлэнтэй хамтарч ажилласны дүнд “Хууль дээдлэх ёс”, “Хууль зүйн мэдээллийн эмхтгэл” сэтгүүлүүдийг үнэ төлбөргүй захиалан авч үйлчлэх нөхцөлийг бүрдүүлсэн. -3905 уншигчид үнэмлэх сунгалт хийж, 2218 уншигчдад шинэ үнэмлэх нээв. Шинээр үнэмлэх нээлгэж буй уншигчдад лавламж зөвлөгөө өгч ажиллалаа. Байгууллага хоорондын номын түр солилцоогоор үйлчлэх тухай Хамтын гэрээний төслийг шинэчлэн боловсруулж батлуулан ном солилцооны гэрээг 5 байгууллага, их дээд сургуулийн номын сантай хийв. Үүнд: Улаанбаатар хотын музей, Дүрслэх урлагийн музей, Үндэсний статистикийн хороо, Технологийн дээд сургууль, ХААИС -Номын сангийн цахим үйлчилгээний талаар, асуулга бүхий судалгааг 138 уншигчаас авч нэгтгэсэн ба судалгааны дүгнэлтээс гарсан үр дүнгээр дараах ажлуудыг хийж байна. Үүнд: Онлайн захиалгын үйлчилгээг туршилтын байдлаар нэвтрүүлэх, Уншлагын танхимын интернэт орчинг бүрдүүлэх, Доктороос доош зэрэгтэй уншигчдад эрдэм шинжилгээний мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх г.м. 1.2.4. Цахим уншлагын зориулалтаар ашиглахаар тохижуулсан тус танхимд интернэтэд холбогдох 5 суурин компьютер, цахим сонин унших мэдрэгчтэй 4 дэлгэц, “Мөнхийн үсэг” ХХК-тай гэрээ байгуулж 100 ш цахим ном агуулсан 5 ширхэг цахим ном уншигч төхөөрөмжийг байрлуулсан. Өдөр тутмын 5 нэрийн сонингийн 1990 оноос хойшхи дугааруудыг сканнердан цахим сан бүрдүүлснийг сан хөмрөгт нь бүртгэсэн. Уншигчдад тав тухтай байдлыг хангах, чөлөөт орчин бүрдүүлэх зорилгоор тус танхимд 725 500 төгрөгийн засвар үйлчилгээг хийж, талбай бага эзлэх орчин үеийн шийдэл	

1.3. Алслагдсан иргэдийн эрэлт хэрэгцээг судлах, шинэ ном хэвлэл, мэдээллээр үйлчлэх: 1.3.1. Явуулын номын сангийн үйлчилгээг сурталчилна 1.3.2. Ном хандивлах арга хэмжээг зохион байгуулж, явуулын номын сангийн сан хөмрөгийг баяжуулна.	**1.3.1.“Ардын элч” явуулын номын сан үйлчилгээг:** - Архивын фондын давхардсан 700 гаруй уран зохиолын номыг ялгаж, мөн Ном бүрдүүлэх, боловсруулах, солилцох хэлтсээс 56 нэрийн 112 ширхэг сурах бичиг, - “Мөрөөдөл” багийнхан 150 номыг хандивлан өгснийг “Ардын элч” явуулын номын сангийн фондонд шилжүүлэхээр болсон. **1.3.2.Хандивын үйл ажиллагааны хүрээнд:** - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвд явуулын номын сангаас 50 гаруй ном хэвлэлийг хандивлалаа. - БЗД-ийн болон ХУД-ийн Албан бус насан туршийн боловсролын төвүүдэд **57** ширхэг номыг хандиваар олгосон. -Хууль зүйн хүрээлэнгээс “Ардын элч” явуулын номын санд **92** ширхэг номыг хандиваар авч уншигчдад үйлчиллээ	
1.4. Номын соёл, уламжлал, ном хэвлэлийг олон нийтэд сурталчлах:	**1.4. Соёлын арга хэмжээг олон нийтэд сурталчлах, хүргэх ажлын хүрээнд:** 1.4.1. -Монгол Улсын Архивын ерөнхий газар, Чагдаржав сан хамтран эмхэтгэсэн **“Түшээт засаг, Хошой чин ван Гадинбалын Чагдаржав”** /баримт бичгийн эмхтгэл, тэргүүн боть/ номын нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 130 орчим эрдэмтэд, улс төр, нийгмийн зүтгэлтнүүд оролцсон. -**Франц Монголын дипломат харилцаа** үүссэний 50 жилийн ойд зориулсан номын үзэсгэлэн, франц хэл дээрх ном, хэвлэлийг сурталчлах арга хэмжээг зохион байгуулсан. Энэ үйл ажиллагааны хүрээнд МҮНС-ийн сан хөмрөгөөс дээжлэн 90-ээд бүтээл, Монгол-Францын найрамдлын нийгэмлэгийн тэргүүн, Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Х.Бэхбат, ахмад дипломатч, орчуулагч Т.Төмөрхүлэг, Д.Лхамсүрэн нарын монголын тухай франц хэл дээр хэвлэгдсэн түүх, соёл, шинжлэх ухааны судалгааны үнэ цэнэ бүхий номын цуглуулгаас, түүнчлэн багш нарын бүтээлээс дээжлэн 160-аад ном, нийтдээ 250 гаруй номоор уншигч олон түмний хүртээл болгон үзэсгэлэн дэглэлээ. Тус арга хэмжээнд БСШУ-ны дэд сайд Б.Тулга, Францын Элчин сайд, нийгэмлэгийн ажилтнууд зэрэг албаны хүмүүс уншигч, уран бүтээлчид, орчуулагчид зэрэг 70 орчим хүн оролцлоо.	

1.4.1. Шинэ номын баяр, зохиолч уншигчдын уулзалт зохион байгуулна	-СГЗ, Яруу найрагч, сэтгүүлч Ц.Чимиддоржийн мэндэлсний 60 жилийн ойд зориулсан **“Төгөлдөр найраг”** эрдэм шинжилгээний бага хурал, “Нууц товчооны морьд” номын нээлт“, “Нууц товчооны морьд” уран зургийн үзэсгэлэнгийн нээлт, МУ-ын ҮНС-ийн 94 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулав. 70 орчим эрдэмтэд, судлаачид, зохиолч, яруу найрагчид оролцсон ба Ц.Чимэддоржийн уран бүтээлийн талаар 5 илтгэл тавигдаж, хэлэлцүүлэг, дурсамж өрнүүллээ. Арга хэмжээг “Эх орон”, CTV-5, MNB, UBS, Монгол HD телевизүүдээр сурталчиллаа. **-Хубилай хааны мэндэлсний 800** жилийн ойн хүрээнд зохион байгуулж буй “Хөөмэйн баяр” олон улсын наадмын эрдэм шинжилгээний хурлын арга хэмжээг зохион байгуулалцлаа. Энэ хуралд Монголын алдарт хөөмийчид Довчингийн Сундуй, Нанжидын Сэнгэдорж, Баатарын Одсүрэн, Дашдоржийн Цэрэндаваа, Эжээгийн Товгой, Таравжавын Ганболд, Гэндэнпилийн Явгаан, залуу үеийн шинэ хөөмийчид, ОХУ-ын Тува улсын хөөмийч Владимир Соян, Монгол улсаас хөгжим судлаач А. Цэдэн-Иш, Ж.Энэбиш, ОХУ-ын Тува улсын эрдэмтэн З.К. Кыргызова, ОХУ-ын Тува улсын судлаач К.Ю. Хлынов, БНХАУ-ын ӨМӨЗОрны эрдэмтэн Гэрэлхүү, мөн Япон улсын эрдэмтэн Камимура Акира, ХБНГУ-ын эрдэмтэн Бернхард Вульф зэрэг нийт 120 гаруй төлөөлөгч оролцлоо. Энэ үеэр Монгол шуудан ХХК-ний Маркны газартай хамтран “Хубилай хаан-800” маркны үзэсгэлэнгийн нээлтийг хийлээ. Уг арга хэмжээнд 180 гаруй марк сонирхогчид оролцлоо. **-“Хүмүүс үзэл бодлоо илэрхийлэхүй”** номын нээлт 2015-10-14-нд Их уншлагын танхимд зохион байгуулагдлаа. Номын зохиогч зөвлөлдөх ардчиллын загалмайлсан эцэг Жэймс Фишкин, номыг монгол хэлнээ хөрвүүлсэн УИХ-ын гишүүн Г.Занданшатар нар оролцож уншигчдын асуултанд хариулан, харилцан ярилцав. Арга хэмжээнд УИХ-ын гишүүд, ТББ-ууд, АНУ-ын ЭСЯ-ны төлөөлөгчид зэрэг 140 орчим уншигч, төлөөлөгчид оролцлоо. **-Жил бүр уламжлал** болгон зохион байгуулдаг **“Бид номонд дуртай-2015”** номын баярыг амжилттай зохион байгуулж, дараах арга хэмжээнүүдийг явууллаа: • Ардын уран зохиолчидтой уншигчид уулзах уулзалт • “Бид номын санчид” өдөрлөг: “Бид номын санчид” видио танилцуулга, мэргэжил	

1.4.2.“Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг БСШУЯ болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулна.	1.4.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, үндэсний хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх, эх хэлээ эрхэмлэн дээдлэх, бичиг соёлын дурсгалаа сурталчлах зорилгоор **“Би Монгол бичигтэн”** уриатай **Үндэсний бичиг үсгийн баярыг** 12 дахь удаагаа зохион байгуулсан. БСШУЯ, МУҮНС-аас санаачилсан энэхүү баярт МУИС-ийн МХСС, МУБИС, Хотын төв номын сан, Хүүхдийн номын ордон, Соёлын өвийн төв, Соёлын боловсролын сургууль, “Хүмүүн бичиг” сонин, “Бичиг соёл” төв, Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиуд, Жиком пресс хэвлэлийн газар, телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагууд зэрэг төрийн болон төрийн бус олон байгууллага хамтран оролцож нэрийн хуудас, албан тоотын бланк, байгууллагын хаягийг монгол бичгээр хэвлэх зэрэг үйлчилгээ явагдлаа. “ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛЫГ ДЭЛГЭРҮҮЛЭГЧ” цол тэмдгээр 1 ажилтан шагнуулсан. Үндэсний бичиг үсгээ дээдлэх, хэрэглээг нь өргөжүүлэх талаар CTV-5, MNB, UBS, Монгол HD зэрэг телевизээр ярилцлага, мэдээлэл хийсэн ба баярын арга хэмжээг Үндэсний телевизийн “Зочны цаг”, ТВ5- телевизийн “Цаг” хөтөлбөрийн зочны ярилцлага, “Цаг” хөтөлбөрийн мэдээгээр давтамжтайгаар, Монголын радиогоор тус тус сурталчилсан. Баярын хүрээнд дараах арга хэмжээнүүд явагдлаа: - “Болор цомын шүлгүүдийг босоо монгол бичгээрээ” уралдааныг зохион байгуулж уралдаанд шалгарсан 150 орчим бүтээлүүдийн үзэсгэлэн, бичиг үсгийн дурсгалуудаар цахим үзэсгэлэн, үнэт ховор номын үзэсгэлэнгүүдийг дэлгэн үзүүллээ - “Болор цомын эзэд” зохиолч, уншигчдын уулзалтыг Монголын зохиолчдын эвлэлтэй хамтран зохион байгуулсан. Уулзалтанд Ардын уран зохиолч Т.Галсан, Д.Урианхай, Ц.Хулан, Б.Ичинхорлоо, Ж.Баяржаргал, Л.Моломжамц, Б.Мягмаржав, Н.Гантулга зэрэг зохиолч, яруу найрагчид оролцож уран бүтээлийнхээ талаар уншигч оролцогчидтой санал сэтгэгдлээ хуваалцан харилцан ярилцаж, өөрсдийн шүлэг яруу найргаас уншин, уншигчдын сонирхсон асуултад хариуллаа. Уулзалт ярилцлагыг яруу найрагч П.Нямлхагва хөтлөн явуулсан ба СУИС-ийн СБС, НУДС-ийн оюутнууд, номын сангийн ажилтан, ажилчид нийт 100 гаруй хүн оролцлоо. 22 зохиолчид “Болор цом”-ын шагнал	

1.5.1.Номын сангийн ном хэвлэлийг уншигч олон нийтэд сурталчлах: 1.5.2. Шинэ номын болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргах 1.5.3. Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг номын сангийн вэб сайтанд гаргаж сурталчлах	1.5.1-“Өнө Мөнхийн Алтай” номын үзэсгэлэн: “Алтайн өдрүүд” арга хэмжээний хүрээнд Говь-Алтай аймгаас төрөн гарсан зохиолчдын бүтээлээр “Өнө Мөнхийн Алтай” номын үзэсгэлэнг 312 номоор гаргаж, үнэт ховор номын музейгээр нээлттэй үйлчилж ажиллав. Үзэсгэлэнгийн хаягуудыг гадна, дотор Led-ээр гаргасан ба үнэт ховор номын музейд зарим зохиолчдын номын үзэсгэлэнг гаргаж зохиолч, бүтээлийн нэрийг нэг бүрчлэн бичиж байрлуулж сурталчилсан. -Тэмдэглэлт үйл явдал, цаг үеийн арга хэмжээнд зориулан **сэдэвчилсэн** болон **шинэ номын үзэсгэлэн** нийт 36 удаа 3244 номоор гарган сурталчилж МАЗЭШХ болон ФХХэлтэстэй тус тус хамтран ажиллалаа. Үүнд: ➢ **-Сэдэвчилсэн номын үзэсгэлэн:** Үндсэн хуулийн өдөрт – 66 ном, Д.Сүхбаатарын мэндэлсний 122 жилийн ойд – 60 ном, НҮБ. Юнеско: Хүний эрх – 53 ном, Багш нарын баярын өдөрт–86 ном, Сар шинийн баярт – 92 ном, Олон Улсын эмэгтэйчүүдийн баярын өдөрт – 111 ном, Монголын зэвсэгт хүчний баярын -107 ном, Монгол-Францын дипломат харилцаа - 50 жил – 250 ном, Хүний эрхийн өдөрт – 86 ном, Монгол хүн сансарт ниссэний баярын өдөрт – 65 ном, Дэлхийн эрүүлийг хамгаалах өдөрт – 125 ном, Дэлхийн номын өдөр /Өвөрмөц номын/ – 98 ном, Үндэсний бичиг үсгийн баяр /Монголчуудын бичиг үсгийн дурсгал/ – 97 ном, Ялалтын баярын өдөрт – 99 ном, Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт – 121 ном, Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолын өдөрт-79, Ардын хувьсгалын 94 жилийн ойд-86, Хэлмэгсэдийн өдөрт-66, Монгол улсад байнгын ажиллагаатай парламент-51, Соёл урлагийн ажилын баярын өдөрт-142, Байгаль орчин хамгаалах өдөрт-112, Олон улсын оюуны өдөрт-76, Дэлхийн статистикийн өдөрт-49, УБ хот үүсэж байгуулагдсаны 370 жил-67, Монгол Бахархлын өдөрт-128, Т.Намжилын уран бүтээлийн үзэсгэлэн-20, МУҮНСан 94 жил-99, Монгол Улс тунхагласны ой-102, Аймгуудын номын сангийн үзэсгэлэн- “Монголын талаар бичсэн Монгол судлаач орос эрдэмтдийн бүтээл”-ийн үзэсгэлэн-158 **-Шинэ номын үзэсгэлэнг** 8 удаа нийт 675 гадаад, дотоодын номоор гаргалаа.	

1. **“Төрөөс баримтлах соёлын бодлого”- 2.1.3. “**Соёлын өвийг хадгалж, хамгаалах, өвлөн уламжлах, баяжуулан хөгжүүлэх, 5.1.Соёлын бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан соёл, урлагийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” **зорилтын хүрээнд:**

2. “Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр”-ийн 4.1. Соёлын баримтат өвийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, 4.4. “Соёлын баримтат өвийг судалгааны эргэлтэд оруулах, сурталчлах; 5.1.Соёлын бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан соёл, урлагийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” **арга хэмжээний дэвшүүлсэн зорилт**:

ХОЁР: **“Эрдэм шинжилгээ, арга зүйн удирдлагыг боловсронгуй болгох” стратегийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:**

2. Эх бичиг сурвалж судлал, хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд: 2.1.Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг эрчимжүүлэх: 2.1.1. МҮНС-ийн “Эрдмийн зөвлөл”-ийн ажиллах дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулж ажиллана. 2.1.2. “Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулна. 2.1.3. Юнескогийн Монгол дахь Үндэсний Комисс, “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн Үндэсний Хороотой хамтран бүс нутгийн хөтөлбөрт нэр дэвшүүлэх 1-2 өвийн судалгаа, тодорхойлолтыг боловсруулж бэлэн болгоно	2.1. -“Эрдмийн Зөвлөл”-ийн ажиллах журмыг боловсруулалцаж БСШУ-ны сайдаар батлууллаа. -“Соёлын баримтат өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2015 оны болон 2016 онд хийх ажлын санал төлөвлөгөө, худалдан авах шаардлагатай техник хэрэгслийн жагсаалт, зардлын тооцоог гаргаж БСШУЯаманд хүргүүллээ. -Соёлын баримтат өвийг бүртгэх шалгуур үзүүлэлт зааврыг СӨТ-тэй хамтран хийж бэлэн болгосон. -“Түшээт хан аймгийн 20 хошуу нутгийн зураг” дээрх уул усны нэрийг хөрвүүлэн 2013 онд хэвлэгдсэн “Монгол орны газар нутгийн атлас” дахь газар орны нэртэй тулган судалж байна. -Монгол судлал, гар бичмэл номын фондод хадгалагдаж байгаа гар бичмэл, барын Банзрагч /26 судар/ болон “Таравчинбо” /27/ судруудын бүтээсэн он цаг болон бичвэрийн харьцуулсан судалгааны ажлыг хийж байна. -Иргэн Д.Түвшинд хадгалагдаж буй Жадамба, Тарбачэнбо зэрэг алтаар бичсэн судар номуудыг Эрдмийн зөвлөлийн гишүүн, судлаач Отгонбаатартай хамтран он цагийг тогтоов. - Дэлхийн дурсамж хөтөлбөрийн Ази номхон далайн бүс нутгийн өвийн тодорхойлолт бичих семинар 8-р сард Хятад улсад явагдсан бөгөөд түүнд зориулж "Хутагт багшийн чинад хязгаарт хүрсэн найман мянгат" номын талаар presentation бэлтгэж unesco-ийн монголын үндэсний комисст хүлээлгэн өгсөн. -"Мэргэд гарахын орон" төвд, монгол толь бичгийн 1924 онд бүтээгдсэн модон барыг Дэлхийн дурсамж хөтөлбөрийн Ази номхон далайн бүс нутгийн өвд нэр дэвшүүлэхээр тодорхойлолт, материалыг бэлтгэж ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисст 2015 оны 10 сарын 25-д хүлээлгэн өгсөн.	

2.1.4. Номын сан судлал, номын түүхтэй холбогдолтой эрдэм шинжилгээ, онол практикийн 1-2 өгүүлэл, илтгэл бичиж нийтлүүлнэ 2.1.5. Аймгуудын тайланд дүн шинжилгээ хийж, эмхтгэн номын сангийн вэб хуудсанд байрлуулна	“Номын сан-номзүйн ангилал” 2 боть номыг нийтийн номын сангуудын хүсэлтийн дагуу 1 боть болгон хэвлүүлэхээр редакц хийж, дахин хэвлэлтэд бэлтгэв -Номын сангийн бүхий л үйл ажиллагааг судлах лавлах бичгийг боловсруулж, хэвлэлтэд өгөхөд бэлэн болгов - “Номын сангуудын тулгамдсан асуудлууд” сэдвийн хүрээнд арга зүйч, ном зүйч нар номын сан, номзүй, ном судлалын холбогдолтой эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд илтгэл бэлтгэж оролцов. - Аймаг, хотын номын сангуудын СУ судалгаанд дүн шинжилгээ хийх ажлаар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн ба төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллежийн нийт 125 номын санчийн, ерөнхий боловсролын сургуулийн 105 номын санчийн, 21 аймгийн 960 номын санчийн судалгааг авч нэгтгэв. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа их, дээд, коллежийн номын сангуудыг судалж нийт 125 номын сангийн хаяг, утасны жагсаалтыг шинэчлэв. “Нийтийн номын сангуудын тайлан-2014” эмхтгэлийг бэлтгэн хянуулж, цахим хэлбэрээр вэб-д байршуулав.	
2.2. Хосгүй, үнэт ховор, гар бичмэл ном судрын хадгалалт хамгаалалтыг сайжруулах: 2.2.1. Дэлхийн болон бүс нутгийн өвүүдийг нийтэд сурталчилж, хадгалалт хамгаалалт, судалгаа шинжилгээний ажлын тайлан гаргана. 2.2.2. Богд хаан эх дагинад өргөсөн өргөмжлөлийн	**2.2**.-"Сахиусан Дара эх", “Есөн эрдэнийн Ганжуур”-ын дэлхийн өвийн батламж хүлээн авах, Номын сангийн хууль хүлээж авах үйл ажилгааны видео бичлэгийг хийж, монтажлав. -"Өвөг дээдсийн өв их эрдэнэ" МҮОНР-ийн 10 минутын шууд нэвтрүүлэг хийж, бичлэгийг хадгалав. -Монгол телевиз, Соён гэгээрүүлэгч телевизүүдэд дэлхийн өв болон баримтат өвийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгөн, МҮОНТ-ийн “Нэвтэрхий тольд нэвтрэхүй” нэвтрүүлгийн бичлэг хийх ажилд оролцож хамтран ажиллалаа. -- Богд хаан “эх дагина-д өргөсөн” өргөмжлөлийн дутуу мэдээллийг гүйцээх ажил хийгдэж байгаа.	

2.2.3. Герман улсад сэргээн засварлаж, хүлээн авсан 1260 ширхэг "Үйсэн дээрх бичиг"-ийг данс бүртгэлд авна. 2.2.4.Үнэт ховор болон үндэсний баримтат өвийг сурталчлах ажлыг тусгай хөтөлбөрөөр зохион байгуулах, "Үнэт ховор музейн танилцуулгыг шинэчлэн хэвлүүлнэ. 2.2.5.Гар бичмэл, барын ном судраас 565 хуудсыг сэргээн засварлаж, технологийн картжуулалт хөтлөн судар бүрт тохирсон хайрцаг, дугтуй хийнэ 2.2.6. Сканнерт оруулах боломжгүй ном судрыг сэргээн засварлана.	2015 оны 10 сарын 20-ны захирлын №А/65 тоот тушаал гарсны дагуу "Үйсэн дээрх бичиг"-ийг нэг бүрчилсэн бүртгэлд авах комисс томилогдсон. Тус комисс нь 4 удаа хуралдаж, гарсан шийдвэрийн дагуу Герман улсаас сэргээн засварлагдаж ирсэн "УТНС С-1" гэсэн лац тэмдэг бүхий хайрцагт байгаа "Үйсэн дээрх бичиг"-тэй танилцаад, захиргааны хурлаар санал оруулж арга зүйн хэлтсийн арга зүйч, ном зүйч нарын гаргасан аргачлалын дагуу бодит эх материалыг анх хүлээж авсан баримт, дагалдаж ирсэн 2 боть каталогтой тулган одоогийн байдлаар 1252 ширхэг үйсэн дээрх бичгийг хүлээж авлаа. Герман улсаас дагалдаж ирсэн 2 боть каталогийг орчуулснаар судлах, данслах, ангилах, ажиллах зэрэг номын сангийн анхан шатны бүртгэлд бүртгэх ажил бүрэн хийгдэх тул орчуулгын ажлыг хийж байна. -БНЭУ-н элчин сайдын яамны ажилтан нарт зориулж үнэт ховор ном судрын болон төвд бусад хэл дээр хэвлэгдсэн энэтхэг улсын судлалтай холбогдолтой номоор үзэсгэлэн гаргаж тайлбар хийн дэлгэж үзүүлсэн. Мөн Туркийн Элчин сайд, Кувейтийн элчин сайдуудтай уулзалт хийн "Үнэт ховор ном, судрын музей", төвд номын фондыг үзүүлж хамтран ажиллахаар ярилцсан. -Гар бичмэл 565 хуудас сэргээн засварлахаас "Зүүн хан улсын гуравдугаар дэвтэр", "Манж үеийн судар", "Үс авахын үйл болой", "Чин улсын үед үнэн сүжигт илдэн Чин вангаас харъяат хошуундаа тушаан гаргаж байсан элдэв хэргүүд", "Монгол үсэг урьд цагаас хэрхэн явсны төлөв" зэрэг 5 нэрийн 612 хуудас гар бичмэл сэргээн засварлав. -Сэргээн засварласан номонд технологийн картжуулалт хөтөлж, тохирох хайрцаг, дугтуй хийж холбогдох фондод хүлээлгэн өгөв. -Сканерт оруулах боломжгүй 1755 хуудас бүхий 18 гар бичмэл ном болон 2ш зургийг цахим сан бүрдүүлэгчээс хүлээн авч сэргээн засварлан, бүртгэл хөтөлж хүлээлгэн өгөв.	

2.3. “Номын сангийн тухай” хууль, Монгол Улсын Засгийн Газрын тогтоолын дагуу номын сангуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажиллагааг боловсронгуй болгох ажлын хүрээнд: 2.3.1. “Номын сангийн зөвлөл”-ийн журмыг шинэчлэн боловсруулж, номын сангийн салбарын үйл ажиллагааг сайжруулахад чиглүүлэн ажиллана 2.3.2. Аймаг орон нутгийн номын санд томилолтоор ажиллаж, арга зүйн зөвлөгөө өгнө. /6 -8 аймагт/ 2.3.3. Хотын болон их дээд сургууль, ЕБС-ийн номын сангуудад биечлэн очиж арга зүйн зөвлөгөө өгнө.	2.3.1. “Номын сангийн мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам”-ыг боловсруулалцаж БСШУ-ны сайдаар батлууллаа -Үндэсний номын сангийн МАЗЭШХ, НББСХэлтсүүд “Номын сангийн мэргэжлийн зөвлөл”-ийн ажлын албаны үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа 2.3.2. -Жилийн хугацаанд 6-8 аймаг, сумдын номын санд биечлэн очиж аргазүйн зөвлөгөө өгөхөөс Баянхонгор аймгийн төв номын сан, Өлзийт сумын нийтийн номын сан; Орхон аймгийн номын төв; Говь-Алтай аймгийн төв номын сан, Дэлгэр сумын нийтийн номын сан, Тайшир сумын нийтийн номын сан; Дорноговь аймгийн төв номын сан, Ховд аймгийн төв номын сан, Эрдэнэбүрэн сумын нийтийн номын сан, Баян-Өлгий аймгийн төв номын сан, Сагсай сумын нийтийн номын сан, Хөвсгөл аймгийн төв номын сан, Алаг-Эрдэнэ сумын номын сан, Хатгал тосгоны номын сан, Сэлэнгэ аймгийн төв номын сан зэрэг 8 аймаг, 7 сумын нийт 15 номын санд биечлэн очиж, үйл ажиллагаатай нь танилцан, холбогдох аргазүйн зөвлөгөөг өгч, сургалт семинар явуулан сертификат гардуулав. -Хотын болон их, дээд сургуулиас ирсэн хүсэлтийн дагуу “Отгонтэнгэр” их сургуулийн номын сан, Улсын Ерөнхий Прокурорын сургалт судалгааны төвийн номын сан, “Этүгэн” их сургууль, Монголын Үндэсний их сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж аргазүйн зөвлөгөө өгөв. 2.3.3. Хотын болон их, дээд сургуулиас ирсэн хүсэлтийн дагуу “Отгонтэнгэр” их сургуулийн номын сан, Улсын Ерөнхий Прокурорын сургалт судалгааны төвийн номын сан, Баянхонгор аймгийн МСҮТ-ийн номын сан, Говь-Алтай аймгийн АУИС-ийн салбар, МСҮТ, Хан-Тайшир эрдмийн цогцолбор, 1 ба 3 дугаар дунд сургууль, Дэлгэр болон Тайшир сумын ЕБС, Ховдын их сургууль болон Политехникийн коллеж, 1 дүгээр дунд сургуулийн номын сан, Эрдэнэбүрэн сумын сургуулийн номын сан, Дорноговь аймгийн ЭМШУИС, 5 дугаар дунд сургуулийн номын сан, Баян-Өлгий аймгийн 2 ба 5 дугаар бүрэн дунд сургууль, Сагсай сумын сургуулийн номын сан, ХИС-ийн харьяа “Далай ван” дээд сургууль, II дунд сургуулийн номын сан зэрэг нийт 17 ЕБС, коллеж, их сургуулийн үйл ажиллагаатай танилцаж аргазүйн зөвлөгөө өгөн, сургалт явуулж сертификат гардуулав.	

2.3.4. Онол арга зүйн “Номын санч” сэтгүүлийг гаргаж, нэгдсэн захиалгаар орон нутагт хүргэнэ. 2.3.5. “Сэргээн засварласан ном судар” товхимолыг бэлтгэн хэвлүүлнэ.	2.3.4. Мэргэжлийн онол-аргазүйн “Номын санч” сэтгүүлийн 2014 №4, 2015 оны №1-2 дугаарыг хэвлэн захиалгын дагуу номын сангууд болон Төв шууданд хүргүүллээ. -Номын санч сэтгүүлийн 2015 оны №1-д “Үндэсний бичиг үсгийн баяр-2015”, “Болор цом-2015 шилдэг шүлгүүд”, “Бага насны хүүхдээ номонд дурлуулах нь”, 2015 оны №2-д “Мотиваци”, “Номын санчид сайн үйлсийн аянд нэгдлээ” зэрэг мэдээллийг мөн “Номын сангуудын боловсон хүчний өнөөгийн байдал” сэдвээр материал бэлтгэж нийтлүүлэв - “Номын сангийн зөвлөл”-ийн ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж, тайлангийн хугацаанд захиргаатай хамтарч өргөтгөсөн хурлыг 4 удаа хийлээ. Зөвлөлийн хурлаар номын сангийн электрон каталогийн ажлыг эрчимжүүлэх асуудал, Marc форматын тухай, төлбөрт үйлчилгээний үнийн тариф, гар бичмэл ном судраар үйлчлэх журам, үндэсний бичиг үсгийн баярын тухай зэрэг цаг үеийн шаардлагатай асуудлуудыг хэлэлцэж, зохих шийдвэрүүдийг гаргалаа. МАЗЭШХэлтсээс 2015 онд мэргэжлийн зөвлөлөөр оруулах асуудлыг нэгтгэн гаргав. 2.3.5. Герман улсаас хэрэгжүүлж байгаа “Цаасан баримтат өвийг сэргээн засварлах” төсөлтэй хамтран “Сэргээн засварласан ном судар”ын гарын авлагыг хэвлүүлэхэд бэлэн болсон	
2.4. Номын сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөх эрх зүйн баримт бичиг, дүрэм, журам боловсруулах, хэрэгжилтэнд хяналт тавих ажлын хүрээнд: 2.4.1.“Номын сангийн тухай хууль”- ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулж ажиллана. 2.4.2. “Номын сангийн тухай” хуульд тусгагдсан	2.4.1. “Номын сангийн тухай” хуулийг хэрэгжүүлэх 2015 оны төлөвлөгөөний хүрээнд тал бүрийн арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд: хуулийн эхийг МҮНС-ийн “Үнэт ховор ном, судрын музей”-д үүрд хадгалуулах ёслолын ажиллагаа /10 гаруй телевиз, сонины сэтгүүлчид тэдээлэл авч нэвтрүүлэг болон мэдээг орон даяар гаргасан/, “Үндэсний бичиг үсгийн баяр-2015”, “Номын баяр-2015” зэрэг томоохон арга хэмжээнүүдийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй зэрэгцүүлэн хуулийг сурталчлах, гарын авлага материал тараах, радио, телевизэд ярилцлага өгөх, аймаг орон нутагт хийсэн сургалт семинарын хөтөлбөрт тусгаснаар хуулийг хэрэгжүүлэх талаар сурталчилж, ярилцлага явууллаа. -“Соёлын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд орон нутгийн номын сангуудаас ирсэн саналыг нэгтгэж өөрийн саналын хамт БСШУЯаманд хүргүүлэв.	

2.4.4. Үндэсний Номын сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөх эрх зүйн баримт бичиг, дүрэм, журам боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулна	2.4.4. Захирлын 2014 оны 12 сарын 18-ны А/63 дугаар тушаалын дагуу “Ажлын байрны тодорхойлолт” боловсруулах ажлын хэсэг томилж нийт 44 ажлын байрны тодорхойлолт буюу давхардсан тоогоор 60 номын санчийн АБТ-ыг шинэчлэн боловсруулж, мэргэжлийн зөвлөл болон захиргааны зөвлөлөөр шинэчилсэн ажлын байр тус бүрээр танилцуулан, санал солилцож, нэмж засварласан эцсийн хувилбарыг хоёр хувиар бэлтгэн гаргаж, баталгаажууллаа. -Захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг “Үндэсний номын сангийн хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулж Захиргааны Зөвлөлөөр хэлэлцүүлэв. -“Маркетингийн багийн ажиллах журам”, “2015 онд хийх ажлын төлөвлөгөө”, “Шинэ байранд орох бэлтгэл ажлын төлөвлөгөө”, “Мэргэжлийн ур чадварын нэмэгдэл олгох журам”-ыг боловсруулж баталгаажуулав. -”Хөдөлмөрийн гэрээ” хамт олноор хэлэлцүүлж Захиргааны Зөвлөлийн хурлаар 2 удаа хэлэлцүүлэн баталгаажуулан ажиллагсадтай шинэчлэн байгуулсан. -“Хөдөлмөрийн дотоод журам”-ыг хамт олноор хэлэлцүүлж Захиргааны Зөвлөлийн хурлаар 1 удаа хэлэлцүүлсэн ба 12-р сард баталгаажуулна.	

2.5. Номын санчдыг чадавхижуулахад мэргэж-лийн туслалцаа үзүүлэх: 2.5.1. Нийтийн, их дээд сургууль, ЕБС, эрдэм шинжилгээний байгууллагын номын санчдад мэргэжлийн зөвлөгөө өгнө. /100 номын санч/ 2.5.2. Мэргэжил аргазүйн фондыг шинэ ном хэвлэлээр баяжуулж, номын санчид, оюутнуудад мэргэжлийн холбогдолтой гарын авлагаар үйлчилнэ 2.5.3. Номын санчдад зориулж, мэргэжил дээшлүүлэх чиглэлээр 6-8 сургалт зохион байгуулна	2.5.1. Мэргэжлийн онол, практикийн сургалт семинарыг 6-8 удаа явуулахаас 14 удаа хийв. Үүнд: Соёлын дээд сургуулийн зайны сургалтад 32 цагийн хичээл, “Отгонтэнгэр” их сургуулийн номын санчдад 4 цагийн, нийтийн номын сангуудад 152 нийт 188 цагийн хичээлийн хөтөлбөр боловсруулан бэлтгэж сургалт зохион байгуулсан. -“Номын санч-мэдээллийн ажилтан таны ширээнд” гарын авлага боловсруулан гаргаж орон нутгийн номын санч нарт хүргүүллээ. Номын санчдын судлах номын жагсаалтыг хавсаргасан. -“Ном хадгалж, хамгаалах тухай” 9 цуврал брошюрийг хэвлүүлж, монгол улсад үйл ажиллагаа явуулж буй бүх төрлийн номын сангуудад гарын авлага болгон хүргүүллээ. -“Ном хадгалж хамгаалах ажлын уламжлал шинэчлэл” гарын авлага хэвлүүллээ. -БСШУЯ-нд болсон статистикийн мэдээлэл гаргах арга зүйн сургалт, ХТНС-нд зохион байгуулагдсан “Америкийн номын сангийн өнөөгийн өнгө төрх, чиг хандлага” сэдэвт уулзалт, ярилцлага, МНСК-аас явуулсан сургалтууданд хамт олныг хамруулав. -Хот, хөдөө, их, дээд сургууль. албан байгууллагын 100 номын санчид мэргэжлийн зөвлөгөө өгөхөөс 102 номын санчид мэргэжлийн аргачлал, зөвлөгөө өгөв -Соёлын сургуулийн төгсөх курсын 4 оюутны, үйлдвэрлэлийн дадлагыг удирдан зохион байгуулж, тайланг нь хамгаалуулав. -Мэргэжил- аргазүйн фондыг 20 шинэ ном, хэвлэлээр баяжуулахаас 22 орос, монгол ном, хэвлэлээр баяжуулав -“Номын санч” сэтгүүлийн картын сангийн гараар бичсэн 125 картыг шинэчилж байрлуулав	

Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр”-ийн 4.1. Соёлын баримтат өвийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, 4.2. Соёлын баримтат өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, 4.3. Соёлын баримтат өвийг сэргээн засварлах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг хангах арга хэмжээнүүдийн хүрээнд дэвшүүлсэн зорилт: **ГУРАВ. “Номын сангийн мэдээллийн технологийн үйлчилгээг боловсронгуй болгох, шинэ технологи нэвтрүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ**		
3.1.Мэдээлэл технологийн үйлчилгээг боловсронгуй болгох ажлын хүрээнд: 3.1.1. “Starsoft” компаниар боловсруулж буй сканнерт орсон ном судрыг унших програмуудын засваруудыг дуусгаж, цахим үйлчилгээг боловсронгуй болгоно. 3.1.2. Интернэтийн компьютеруудад програм шинээр суулгаж, интернэтийн үйлчилгээг боловсронгуй болгоно.	-3.1. Номын санд зориулсан нээлттэй эхийн Коха системийг Үндэсний номын санд суурилуулах ажлыг эхлүүлж дараах ажлуудыг хийж гүйцэтгэв: ➢ Коха системийн серверт номын сангийн дотоод сүлжээ, интернэт сүлжээ, номын сангийн гаднаас холбогдох сүлжээний тохиргоог хийсэн. ➢ Бар код, ном хэвлэлийн төрөл зүйл, ангилал, ном, диссертаци, архив, уншигчийн баазын дэлгэрэнгүй тайлбар, уншигчийн үнэмлэхний соронзон туузат болон IC карт, тайлан мэдээ зэргийг тайлбарласан баримт бэлтгэж өгсөн. ➢ Монгол ном, Диссертаци, Архив фонд, Ойрын фонд зэрэг фондуудын баазыг Коха системд хөрвөж оруулсан. ➢ Одоогийн L-Soft системийн уншигчийн баазыг цэвэрлэн Коха системд оруулсан. Коха системийн уншигчийн бүртгэл хэсгийг тохируулж, цаасан бүртгэх хуудсыг мөн засварлаж монгол, англи хэл дээр гаргасан. ➢ Их уншлагын танхимд Коха систем дээр ном захиалга, ном олголт, ном хураалтын хэсэгт туршилт хийж тэмдэглэл хөтөллөө. -“Starsoft” компаниар боловсруулж буй сканнерт орсон ном судрыг унших програмуудын цахим уншлагын системийг боловсронгуй болгох, нэмэлт өөрчлөлтүүд болох 12 ажлын саналыг боловсруулж, Захиргааны зөвлөлөөр хэлэлцэн, гүйцэтгэгч	

3.1.3. Вэб сайтын Joomla хувилбарыг шинэчилнэ. 3.1.4. Номын сангийн электрон каталогийн баазад редакц хийх, нэмэгдсэн монгол ном, диссертацийн	Старсофт ХХК-д хүлээлгэн өглөө. Тус компани нь эхний ээлжинд дижитал номын програмыг сайжруулах 6 нэмэлт өөрчлөлтийг шийдвэрлэж өгсөн. Үлдсэн засвар, үйлчилгээг хийлгэж байгаа бөгөөд Flash технологи дээр хийгдсэн цахим ном унших системийг вэб суурьтай болгосноор номын хуудас богино хугацаанд ачаалагдах, тухайн нэг хуудсыг үзэхдээ өмнөх хуудсуудыг нэг бүрчлэн эргүүлсний дараа биш шууд үзэх боломжтой болгов. - Монгол номын электрон каталогийн баазад 2320 ном, 65 диссертаци, 220 өвөр монгол ном, 28 монгол бичгийн номуудыг нэмж уншигчдын хүртээл болгов. Ном нэмэх бүрд баазаа Backup хийж, нэмэгдсэн номуудыг тухай бүр вэбийн электрон каталогруу оруулж байна. - Интернетийн сүлжээг шинэчлэх ажлын хүрээнд худалдаж авах шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт гаргаж, сүлжээний зураглал үйлдсэн. 3 давхрын сүлжээний утаснуудыг нэгдсэн байдлаар холбогддог болгосон. Бусад давхруудын сүлжээг ойрын хугацаанд зураглалын дагуу холбохоор ажиллаж байгаа. Утасгүй сүлжээний төхөөрөмжийг шинэчилж, хурдыг сайжруулж, найдвартай байдлыг өндөржүүлсэн. -Интернет кабелийн шугамуудыг давхар бүрээр нь тусгайлан татаж, цэгцтэй болгосон. Их уншлагын танхим, эрдэм шинжилгээний уншлагын танхим, каталогийн өрөөнд utp кабель шинээр татсан. Ингэснээр их уншлагын танхимд wifi цацдаг болгосон. -Интернэтийн өрөөний компьютеруудад холбогдох програмуудыг суулгаж номын санчийн компьютераас нээдэг болгож хяналт тавих боломжийг бүрдүүлсэн. -“Шинэ номын мэдээ” сэтгүүлүүд болон “Шилэн данс” цэс үүсгэж мэдээг тухай бүр байршуулж байна. -L-Soft системийн баазад шинээр нэмэгдсэн номыг вебийн электрон каталогийн баазад оруулж, хэрэглэгчдийн хүртээл болгож байна. -Вэб сайтыг шинэчлэх ажлыг хийж байна. 8 цэсэд хангалтгүй мэдээллүүд байршдаг	

бичлэгүүдийг үндсэн бааз, вэб сайтын электрон каталог руу шилжүүлнэ. 3.2.Ном судрын улсын бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг боловсронгуй болгох: 3.2.1. Улсын болон номын сангийн бүртгэл мэдээллийн санд бүртгэгдсэн өвүүдийн мэдээллийн баазад нэмэлт мэдээллийг оруулж архивлана	байсан бол шинэчлэл хийснээр 24-26 талбарт мэдээллүүдийг байршуулах болно.Тухайлбал: мэдээлэл арга зүйн цэс, орон нутгийн номын сангуудын мэдээлэл, монгол бахархал, номын мэдээ, захиалга, солилцоо, электрон каталог г.м. Мэдээллүүд монгол /кирилл, монгол бичиг/, англи, орос хэл дээр хийгдэнэ. -Уншигчийн баазын L-Soft системээс Uniface системрүү хөрвөж ороогүй алдаатай мэдээллийг шүүж гарган засч, IC картны дугаарыг хадгалсан хүснэгтийг үндсэн баазад харгалзуулан оруулж уншигч бүртгэлийн баазыг бүрдүүллээ. Үүнтэй зэрэгцүүлэн уншигчийн дугаар буруу орсон, орон дутуу бичигдсэн, нэг дугаар дээр 2 уншигч бүртгэгдсэн 171 бичлэг, нэг уншигчийн мэдээлэл өөр өөр уншигчийн дугаар дээр 2-3 бүртгэгдсэн, уншигчийн дугаар байхгүй бичлэгүүд, IC картны дугаар буруу орсон 94 бичлэг зэргийг баазаас шүүн гаргаж, засаж залруулав. -L-Soft системийн компьютерууд болон хурууны хээгээр цаг бүртгэх төхөөрөмжийн огноог улс даяар зуны болон өвлийн цагийн хуваарьт шилжсэнтэй холбогдуулан тохируулаа. -L-Soft системийн баазад буруу орсон 23 номын дансны дугаар, фондын заалтуудыг засав. 3.2. -УНБМСан болон МҮНСангийн БМСангийн мэдээллийн баазад 516 өвийн мэдээллийг нэмж оруулсан. -“Үндэсний соёлын өвийн мэдээлллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийн RCH улсын нэгдсэн бүртгэл мэдээлэлийн сангийн програмд 135634 иж бүрдэл 2974884400 үнэ бүхий 516 ширхэг өв 15371 зургаар баримтжуулан хадгаллаа. -Мэдээллийн нэгдсэн баазыг zip file болгон соёлын өвийн төвд 2 удаа хүлээлгэн өгсөн. -Ерөнхий бүртгэлийн дэвтэрт бичигдсэн өвийн дэлгэрэнгүй мэдээллийг Register програмын мэдээлэлтэй тулгаж, нэгтгэн Word file болгон хуулав. Register болон RCH програмын мэдээллийг тулган шалгахад зөрүүтэй мэдээлэл гараагүй болно.	

3.2.2. Register болон RCH програмын мэдээллийг тулгаж, мэдээллийн санг нягтлан шалгана. 3.2.3. Дилав хутагтын “Жадамба” судрын мэдээллийн сан, дэлхийн болон бүс нутгийн өвүүдээр видео мэдээллийн сан бүрдүүлж архивлана. 3.2.4. Үнэт ховор өвүүдийн бүртгэл мэдээллийн санг цаасан хэлбэрээр бүрдүүлж, архивлана. 3.2.5. “Үнэт ховор номын музей”-н үзмэрүүдийн тайлбаруудыг шинэчлэн боловсруулж, байрлуулна. 3.3. Мэдээллийн цахим сан бүрдүүлэх, үйлчилгээг сайжруулах:	-Register програмын мэдээллийг шалгаж дуусаад Word file болгож архивласан ба нийт 386 нүүр мэдээлэл болсон. - Үнэт ховор номын музейд хадгалагдаж буй өвүүдийн фото зургаар мэдээллийн сан бүрдүүлж дуусгасан. 9 DVD zip file болгон архивлаж хадгалан СӨТ- д хүлээлгэн өгсөн. Эдгээр зурагнуудаас "Монголын музейн шилдэг үзмэр" 3 боть цомогт багтаж байгаа бөгөөд 2-р ботид 90 өвийн зураг хэвлүүлэх ажилд хамтран оролцсон. -9 эрдэнийн Ганжуурын ном зүйн бүртгэл хийх ажлыг эхлүүлсэн. -Дилов хутагтын "Жадамба" судрын тухай холбогдох мэдээллийг цуглуулж эх судрыг гэрэл зургаар олж мэдээллийн санг бүрдүүлэн 32 бүлгээс 17 бүлгийн нь өндөр гэгээний дөрвөлжин үсгээр хуулан бичиж, галиглав. - Үнэт ховор номын музейд хадгалагдаж буй өвүүдийн фото зургаар мэдээллийн сан бүрдүүлж дуусгав. -УНБМС-ийн фото мэдээллийн санд 15371 зургийг 13 DVD-д дахин хуулж, архивлан хадгалав. -"Сахиусан Дара эх" “Есөн эрдэнийн ГАНЖУУР”-ын видео бичлэг, "Өвөг дээдсийн өв их эрдэнэ" шууд нэвтрүүлгийн бичлэг зэргийг архивлан хадгалсан. -“Үнэт ховор номын музей”-н тайлбаруудыг нэмж, шинэчлэн байрлуулсан ба танилцуулга хийх мэдээлэл, зурагнуудыг хэвлэлтэнд өгөхөд бэлэн болгосон 3.3.-Цахим сан бүрдүүлэх ажлын хүрээнд Дөрвөд Ойрдын түүх, Сайн ноён хан аймаг Цэцэрлэгмандалын Байнбайшир уулын хошуу нутгийн цэс, Жавзан хутагтын шавь дархадын нутгийн цэс дэвтэр, Алтан товч хэмээх оршвой, Догшин ноён хутагтын сургаал оршвой, Жүн дагины түүх, Цагаан Жамбалын сан оршвой, Монголыг хүрээлсэн ээзрхэг улсуудын хоорондын байдлыг товчлон үзүүлсэн түүх, Хутагт их үүлэн судар оршвой, Амарын зохиосон түүхэн ноорог, Гадаад Монголын Төрийг засах	

3.3.1. Монгол гар бичмэл ном судрын 58500 хуудас тоон хэлбэрт оруулах ажлыг хийж, хадгалалтын найдвартай орчныг бүрдүүлэх.	явдлын яамны бичиг, Юань улсын нууц түүхийн дараа зохиосон бичиг зэрэг 303 боть /32377 хуудас/ гар бичмэл ном судрыг тоон хэлбэрт оруулж уншигчдад үйлчилж байна. Мөн эдгээр гар бичмэл судруудыг дансны дугаар, номын нэр, хуудасны тоо, хэмжээ, гар бичмэлийн гэмтлийн байдал зэрэг 8 үзүүлэлтээр тодорхойлох, хард дискэнд хуулж хадгалах ажлуудыг хийсэн -Сонины цахим мэдээллийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор өдөр тутмын Ардын эрх, Өдрийн сонин, Үндэсний шуудан, Үнэн, Ардчилал зэрэг нэрийн сонингуудын тоон хэлбэрт орсон файлуудыг: - pdf файлаас зурган файл руу хөрвүүлэх., - зурган файлыг хуваах., - тоон баазад оруулахад бэлтгэх, - баазад оруулах, хадгалах ажлууд хийгдэж байна. -“Үндэсний шуудан” сонины 75 дугаарыг зурган файл руу хөрвүүлэх, “Өдрийн сонин”-ы 2011 оны бүх дугаарууд, 2012 оны эхний улирлын дугааруудыг хуваах ажлыг хийлээ. “Монголын мэдээ” сонины 2013 оны бүх дугаар, 2014 оны хагас жилийн дугааруудыг баазад оруулан хадгаллаа.	
3.3.2. Ерөнхийлөгчийн нэрэмжит уншлагын танхимын үйлчилгээнд дижитал уншлагын системийг боловсронгуй болгож, цахим хэлбэрт орсон гар бичмэл номоор уншигчдад үйлчлэх.	-Монгол судлалын фондоос 958 боть ном буюу 56925 хуудас гар бичмэл, барын ном скайнердан тоон хэлбэрт оруулан сторож серверт хуулах, архивлах ажлыг хийж, тоон мэдээллийн сан бүрдүүлж байна. - Номын сангийн камерын хяналтыг сайжруулж шаардлагатай ажлын байруудад тухайлбал монгол номын, гар бичмэлийн, дорно дахины, тогтмол хэвлэлийн, өрнө дахины фондын 2, 3-р давхарт, төвөд номын фонд болон их уншлагын танхимд бүгд 27 камерыг шинээр суурилуулав. Нийт 59 камер ажиллаж байна. -Ерөнхийлөгчийн нэрэмжит уншлагын танхимаар орчин үеийн өндөр хүчин чадалтай техник технологийг ашиглан үнэт, ганц хувь бүтээлүүдийг тоон хэлбэрт оруулж, touch дэлгэцээр уншигч, судлаачдад үйлчилж байна.	

3.3.3. Номын санчдын судалгааг үндэслэн 20000 хуудас эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл болон шаардлагатай номыг тоон хэлбэрт оруулах.	-Ганц хувь гар бичмэл ном судрын эх оригиналь хувийг гэмтэхээс сэргийлж, уншигч судлаачдад зөвхөн тоон хэлбэрээр үйлчлэх бодлогыг баримтлан ажиллаж, эрдэм шинжилгээний уншлагын танхимаар захиалгын дагуу 367 боть гар бичмэлийг тоон хэлбэрт оруулан уншуулж, үйлчлэв. -“Microsoft office excel” дээр сканерт орсон номуудыг 8 үзүүлэлтээр нийт 1381 номын жагсаалт хийж хадгалав. -24996 хуудас ном, 265 диссертацийг цахим хэлбэрт оруулав.	
3.3.4. Сканнерт орсон гар бичмэл, барын ном, эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл болон ном, бусад баримтыг хянах, хард диск, серверт хуулж, архивлан хадгалах.	-“Microsoft office exel” дээр 150 нэрийн диссертацийн жагсаалтыг 13 үзүүлэлтээр хийж хадгалсан ба нийт 265 нэрийн диссертац цахим хэлбэрт орсон. - Сонин сэтгүүлийн өгүүллийн 1988-2008 он хүртэлх он дараалсан номзүйн бүртгэлийг Zotero програмд оруулж, лавлагаанд зориулсан мэдээллийн бааз үүсгэх ажлыг хийж байна. Энэхүү бүртгэл нь 20 жилийн 138 нэрийн сонин, сэтгүүлд нийтлэгдсэн мэдээ, материал, судалгаа шинжилгээний өгүүлэлийг хамарсан үндэсний хэмжээний томоохон номзүйн бүртгэл бөгөөд уншигч, судлаачид, номын санчдын лавлагааны чухал хэрэглэглэхүүн болох юм. 2015 онд Өдрийн сонины 550 материал, Төрийн мэдээлэл-193 материал, Өнөөдөр сонины 1165 материал тус тус нэмжээ. Бусад сонин, сэтгүүлийн 1835 мэдээллийг /карт/ шивж оруулсан. -Сканнердсан 281 номыг шалгаж, 149 ном шаардлага хангасан учир хүлээн авч, 132 номыг буцаахаар тэмдэглэл хөтлөв. -“Монголын мэдээ” сонины 2015 оны 9 сарын 11 хүртэлх дугааруудыг pdf файлаар хүлээн авч, мөн JPEG зурган файлд хөрвүүлж давхар хадгалж байна.	
3.3.5.Бүрдүүлсэн цахим санг	- Бүрдсэн дижитал санг номын сангийн үндсэн бүртгэлд авах ажлыг гадаад орнуудын номын сангийн туршлагаас үзэж судлахад номын сан нь цогц програм нэвтрүүлснээр хуулиар зохицуулагдан бүртгэлийн ажил хийгддэг байна. Иймд ҮНС нь “Коха” програмыг нутагшуулан нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэж дууссанаар номын санд	

номын сангийн үндсэн бүртгэлд авах ажлыг судалж эхлүүлэх.	бүрдүүлсэн цахим мэдээллийн бүх санг үндсэн бүртгэлд авах боломж бүрдэнэ.	

1. **“Үндэсний хөгжлийн цогц бодлого”- Стратегийн зорилт. 2. Хүн амд соёл, урлагийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж, иргэдийн оюуны хэрэгцээг хангах талаар дорвитой ахиц гаргана”-ын хүрээнд:**

2. Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр”-ийн 4.4. Соёлын баримтат өвийг судалгааны эргэлтэд оруулах, сурталчлах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ хангах арга хэмжээнүүдийн хүрээнд дэвшүүлсэн зорилт:

ДӨРӨВ. “Лавлагаа – номзүйн үйлчилгээг боловсронгуй болгох, уншигчдад мэдээлэл-номзүйн үйлчигээг үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ

4.1.Улсын ном зүйн бүртгэлийг бэлтгэх, лавлагаа ном зүйн үйлчилгээг үзүүлэх 4.1.1. Үндэсний ном зүйн бүртгэл болох “Сонин сэтгүүлийн өгүүллийн ном зүй”/1988-2008/-н 1-р ботийг хэвлэлтэнд бэлэн болгоно. 4.1.2.”Монгол Улсын Үндэсний номын сангийн архивын бүртгэн мэдээлэл номзүй” номын үргэлжлэл VI ботийг хэвлэлтэнд бэлтгэнэ. 4.1.3.”Шинэ номын мэдээ”бэлтгэх үйл ажиллагааг боловсронгуй болгон, товхимлыг цаг хугацаанд бэлтгэж, цаасан болон электрон хэлбэрээр уншигч, байгууллагуудад сурталчилна. /сар бүр/ 4.1.4. Тогтмол хэвлэлийн өгүүллийн төрөлжсөн	-“Монгол улсын Үндэсний номын сангийн архивын бүртгэн мэдээлэх номзүй”-н VI ботийг хэвлэлтэнд бэлтгэв. -“Сэргээн засварласан гар бичмэлийн тухай товхимол”-ын эхийг хэвлэлтэд бэлтгэв. -“Сонин, сэтгүүлийн өгүүллийн номзүй”-н II ботийн эх бэлтгэх Zotero программд 3005 картыг шивсэн. -Zotero программын тусламжтайгаар номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй франц хэл дээрх номын номзүйг хийж цахим сүлжээнд /online site/ оруулах ажлыг хийж байна. -“Шинэ номын мэдээ” товхимлын №1-12 дугаарыг бэлтгэн, хянаж хэлтсүүд, харъяа байгууллага, номын сангийн уншигч, хувь хүмүүст сар бүр майл хаягаар нь хүргэж сурталчлав. №1, 3, 5, 7, 9, 11 -г 189 хүнд, №2, 4, 6, 8, 10, 12-г 189 хүнд -Тогтмол хэвлэлийн өгүүллийн картын сан”-д бүрэн редакци хийж, мэдээлэл хуучирсан картыг хасч, шинэ ялгагч нэмэн, дотоод гадаад чимэглэлийг шинэчлэн, шинэ шүүгээнд шилжүүлэв. Өдөр тутмын сонингууд шүүж нийт 1222 карт бичиж байрлуулав. -“Төрийн мэдээлэл” сэтгүүл тогтмол авч лавлагааны фондыг баяжуулж байна. Мөн Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2014 оны дугааруудыг хавтаслуулж үдүүлэв.	

картын санд 1920 карт бичиж байрлуулна. 4.1.5.“Монгол Улсын хуулиуд” картын санд шинээр гарсан хууль тогтоомжид карт бичих, уншигчдад сурталчилна. 4.1.6.”Санамж өгөх номзүйн бүртгэл” 2-ыг бэлтгэн гаргаж, уншигчдад ном хэвлэлийг сурталчилна. 4.1.7.Лавлагааны фондыг шинэ ном хэвлэлээр тогтмол баяжуулж, номзүйн картын сангуудыг электрон каталогт оруулна. 4.1.8.Уншигч хэрэглэгчдээс хүссэн аман лавлагааг 200 хүнд номзүйн лавлагааны аппарат ашиглан өгч үйлчилнэ.	-“Монгол улсын хуулиуд” картын санд “Төрийн мэдээлэл” сэтгүүлээс нийт 240 ш карт бичиж байрлуулав. -“Туулийн талаар ном болон тогтмол хэвлэлд нийтлэгдсэн зүйлсийн номзүйн бүртгэл”, “Монголын уламжлалт анагаах ухаан” зэрэг санамж өгөх номзүйн бүртгэлүүдийг хянав. -Монголын мэдээ сонинг цахимаар авдаг бөгөөд цахим хэвлэлийн картын өгүүллийн санг зохион байгуулж байна. Тайлангийн хугацаанд нийт 1320 ширхэг өгүүлэл, шүүмж, танин мэдэхүйн зөвлөгөө зэрэг мэдээ мэдээллүүдээр тус мэдээллийн санг баяжуулсан байна. -Мэдээллийн самбарыг шинэчлэн хийж, тавигдах мэдээллийн чанарт хяналт тавьж ажиллалаа. -“Уншигч, хэрэглэгчдээс хүссэн аман лавлагаа”-г нийт 126 хүнд номзүйн лавлагааны аппарат ашиглан өгч үйлчилсэн байна. -Виртуаль лавлагааны албаар 141 хэрэглэгчдэд лавлагаа өгч үйлчилсэн бөгөөд өгөгдсөн лавлагаанд хяналт тавьж ажиллав. -Сэдэвчилсэн бичгийн лавлагаа 9-ийг бэлтгэж өгөв.	

4.1.9. Номын сангийн вэб сайтын байнгын ажиллагааг хангах, “Виртуаль лавлагааны алба” вэб хуудсыг ажиллуулна. 4.1.10.Номын электрон үзэсгэлэн гаргах, вэб дээрх хувилбарыг боловсронгуй болгоно. 4.1.11. Эрдэм шинжил-гээний болон цахим үйлчилгээний танхимын үйлчилгээний журмыг шинэчлэн боловсруулна.	-2014 оны 01-р сарын 01-нээс 06-р сарын 15-ны хугацаанд номын сангийн www.nationlibrary.mn сайтанд 31231 хэрэглэгч хандалт хийж, 74462 хуудсыг үзэж сонирхсон байна. -Номын сангийн Web сайтад тавих “Цагаан сар” сэдэвт электрон үзэсгэлэн гаргав. - Мэргэжлийн холбогдолтой 127 ном, гарын авлага, сэтгүүлээр үйлчлэв.	
“Төрөөс баримтлах соёлын бодлого”- 2.1.3.Соёлын өвийг хадгалж, хамгаалах, өвлөн уламжлах, баяжуулан хөгжүүлэх хүрээнд дэвшүүлсэн зорилт: **ТАВ. “Ном судрын хадгалалт хамгаалалтыг сайжруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ**		
5.1. Сан хөмрөгийн хад-галалт, хамгаалалт, зохион байгуулалт, эмх цэгцийг	-Сэргээн засварлах лабораторийн вакуумжуулах, нөхөх, сэргээн засварлалтын ширээ халаах пресс зэрэг техник тоног төхөөрөмжүүдийн тусламжтайгаар гар бичмэл ном судрыг сэргээн засварлах ажлыг хийж байна. Үс авахын үйл болой, Манжийн үеийн	

сайжруулах: 5.1.1. Өрнө дахины фондыг бүрэн тоолох бэлтгэл ажлыг хангаж, тооллогын ажлыг эхлүүлнэ. 5.1.2.Хяналтын системийн найдвартай ажиллагааг хангаж, засвар үйлчилгээ, хяналтыг сайжруулна. 5.1.3. Галын дохиолол, хамгаалалт болон сантехник, дулааны найдвартай ажиллагааг хангаж ажиллана. 5.1.4.Фондуудын ном хэвлэлийн эмх, цэгц, байрлал, зохион байгуулалтыг сайжруулж, 130000 номыг байрлуулах, цэгцлэх ажлыг хийнэ. 5.1.5.Төвд 5775 ном судрыг дансалж, 2310 номыг электрон каталогт оруулна.	судар, Бадамсамбуу багшийн зохиосон архины уг гарвал, Зүүн хан улсын түүх, Монгол үсэг урд цагаас хэрхэн явсны төлөв нэрт 5 гар бичмэл, барын ном судрын хадгалалтын орчин нөхцөлийг сайжруулж, сэргээн засварласан. -“Номын баринтаг” хөтөлбөрийг JCI ТББ-тай хамтран зохион байгуулж 3550 ширхэг баринтагийг хүлээн авлаа. Хөтөлбөр нь 2-3 жил үргэлжлэх юм. - Өрнө дахины номын фондын бүрэн тооллого хийгдэх ажлын хүрээнд бэлтгэл ажлыг хангах зорилгоор тус фондонд судалгаа хийж тооллого хийх талаар схем зураглал гаргаж, арга зүйч, ном зүйчдэд танилцуулан аргачлал гаргуулах, тус фондын номыг ариутгах ажил хийгдэж байна. Өрнө дахины фондын номуудад байрын сунгалт хийж 171255 номыг эмхэлж цэгцэлсэн. -Хяналтын системийн найдвартай ажиллагааг хангаж, камеруудын бичлэгийг тогтмол шалгаж, гэмтлийг тухай бүр засварлан тэмдэглэл хөтөлж байна. Шинээр бүх фондууд, шаардлагатай ажлын байруудад камер байрлуулсан. -16 бүсийн байрлал холбох боломжтой дохиололын ерөнхий станц, фото электрон хийцтэй утаа мэдрэгч 210 ш, өсөлтийн нормтой дулаан мэдрэгч 162 ширхэгийг суурилуулж, галын хор 68 ш, галын шланкны иж бүрдэл, ус сорох цахилгаан насос зэрэг галын дохиоллын систем, тоног төхөөрөмжтэй боллоо. Галаас сэргийлэх комиссыг байгуулж ажлын төлөвлөгөөг батлан, схем зураг, зарлан мэдээлэх төлөвлөгөөг гаргууллаа. Нийслэлийн онцгой байдалтай хамтран номын сангийн ажилтнуудад галын дохиололын системийг ажиллуулах, энгийн багаж зэвсгээр галаас урьдчилан сэргийлэх сургалтуудыг зохион байгуулсан. -Фондуудын ном хэвлэлийн эмх, цэгц, байрлал, зохион байгуулалтыг сайжруулж 149 578 номыг шинээр ба буцаан байрлуулж, 240153 ном судар, 97 нэгж 372 сэтгүүл эмхэлж цэгцлэв. -4117 төвд ном судрыг ялган цэгцэлж, компьютерийн каталогт орсон ном судраас 5775	

5.1.6.Тооллогын дараах төлбөр барагдуулах ажлыг зохих журмын дагуу хийж гүйцэтгэнэ. 5.1.7. 4620 хэвлэмэл ном сэлбэн засч, 605 нэгж сонин сэтгүүлийг хавтаслана. 278000 номыг ариутгана.	номыг дансанд бичиж бүртгэн, 2310 каталогт оруулж, 4620 карт бичиж хэвлэн гаргав. Төвд судар номын лавлагааг 23 хүнд 189 номын лавлагаа өгч бүртгэсэн, үүнээс сэдэвчилсэн лавлагааг бичгээр 2 хүнд 15 номын жагсаалт гарган өгсөн. 77 баринтаг номд донтор ялгагч хийж, 558 төвд судрыг шинээр баринтагласан. - Захирлын 2015 оны 07-р сарын 08-ны Б/21 тоот тушаалын дагуу Ойрын фондын номын санч П.Олзвойг тэтгэвэрт гарах болсонтой холбогдуулан Ойрын фондын номын санч Б.Чулуунбатад хүлээлцүүлэх тооллогыг 07 сарын 01-нээс эхлэн ажлын 4 хоногт хийж гүйцэтгэлээ. Тооллогоор дутсан 6 номын өр тооцоог барагдуулж дууссан. -5702 хэвлэмэл ном сэлбэн засч, 325 нэгж сонин сэтгүүлийг хавтаслав. 273 224 номыг ариутгасан. -1505 ш хятад хэлний хуучин номын дансны дугаарыг компьютерт бичиж, хэвлэн, нааж байрлуулсан. -Солонгос мэдээллийн танхимаас 5264 ном хэвлэлийг Дорно дахины фондонд шилжүүлэн авч байрлуулав.	
“Төрөөс баримтлах соёлын бодлого”- 4.1.1.соёл, урлагийн салбарт оновчтой, бие даасан, тогтвортой бүтэц бий болгож, удирдлага, зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгох; 4.1.7.соёл, урлагийн байгууллага олсон орлогын төлөвлөгөөнөөс давуулсан болон хэмнэсэн орлогыг ажилтнаа сургах, давтан сургах, урамшуулах, байгууллагын хэвийн үйл ажиллагаагаа хангах арга хэмжээнд зарцуулах **ажлын хүрээнд дэвшүүлсэн зорилт:** **ЗУРГАА. “Хүний нөөцийн удирдлагыг боловсронгуй болгож, чадварлаг бүтээлч хамт олон бүрдүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ**		
6. Удирдлагын маркетинг, менежментийг боловсронгуй болгох хүрээнд:	- Маркетингийн багийг номын сангийн үйлчилгээг сайжруулж, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн нэмэлт үйлчилгээг нэвтрүүлэх, хөгжүүлэх зорилготойгоор МҮҮНС-гийн захирлын 2015.04.01-ны өдрийн А/16 тоот тушаалаар 15 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ажиллах хугацаанд “Үндэсний номын сангийн	

6.1. Байгууллагын дотоод хяналт, үнэлгээг сайжруулах, хүний нөөцийн хангамж, ашиглалтыг боловсронгуй болгох: 6.1.1. “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ын дагуу байгууллагын дотоод хяналтын бүрэлдэхүүнийг өөрчилж, зохион байгуулалтыг сайжруулна. 6.1.2. Шинэчлэн боловсруулсан ажлын байрны тодорхойлолтын дагуу ажлын байранд тавих хяналтыг сайжруулж, мөрдөж ажиллана.	хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулж хэлэлцүүлэх, номын сангийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдсэн хамтын ажиллагааны шинэ загваруудыг эрэлхийлж, мэргэжлийн хүрээнд гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарч ажиллах, төсөл хөтөлбөр боловсруулах, орчин үеийн техник, технологийг судалж нэвтрүүлэхэд санал, санаачлага гаргах, ажилтнуудын бүтээлч идэвх санаачилгыг нэмэгдүүлж, номын сангийн нэр хүндийг өсгөхөд чиглэгдсэн ажлуудыг зохион байгуулах зэрэг ажлуудыг удирдлагын дэмжлэгтэй хийсэн. -Үндэсний номын сангийн үйл ажиллагааг таниулах, иргэдэд ойртуулах, нийгэмд эзлэх байр суурь нэр хүндийг өсгөх зорилгоор: Соёлын дээд сургуулийн эчнээ ангийн 9 оюутанд, Улаанбаатар дээд сургуулийн 5 номын санчид, 2-р сургуулийн 38 сурагчид Японы хүүхдийг Ивээх Сан Монгол дахь Хөтөлбөрийн 2 ажилтан, БЗД-ийн 84-р сургуулийн 39 сурагч, Соёлын боловсролын сургуулийн 8 оюутан, Улаанбаатар Их сургуулийн магистрант, докторант 8 оюутан, Чингэлтэй дүүргийн 17-р сургуулийн 8а ангийн 17 сурагчид зэрэг нийт 159 хүнд үйлчилгээний танхимууд, зарим фонд, үнэт ховор номын музейн үйл ажиллагаатай танилцуулав. Мөн шинэ уншигчдад номын сангийн үйлчилгээг таниулах зорилготойгоор “Номын сангийн угтах үйлчилгээ”-г зохион байгуулж нийт 1000 орчим уншигчдад лавлагаа мэдээлэл өгсөн. “Соёл урлагийн ажилтны өдөр”-ийг тохиолдуулан БСШУЯам нийгмийн сайн сайханд уриалсан, энэрэнгүй хүнлэг нийгмийг төлөвшүүлэх, нийгмийн хариуцлага, манлайллыг өргөх зорилгоор сайн дурын үйл ажиллагааг санаачлан зохион байгуулсан бөгөөд энэ аянд Монголын Үндэсний номын сангийн хамт олон нэгдэж нийт ажиллагсад болон хамтран ажилладаг байгууллагуудын дунд ном хандивлах аяныг зохион байгуулж, ГССҮТ-ийн Түлэгдэл, нөхөн сэргээх, мэс заслын хүүхдийн тасгийн хүүхдүүдэд 1.500.000 орчим төгрөгийн үнэ бүхий 180 нэр төрлийн 300 гаруй ном, тоглоом бүхий “Номын булан”-г байгуулж ГССҮТ-ийн хамт олонд хүлээлгэн өгсөн.	

6.1.3.“Хөдөлмөрийн гэрээ”-г шинэчлэн байгуулна. 6.1.4.Үндэсний номын сангийн шинэ барилга ашиглалтанд орохтой холбогдон цаашид номын сангийн ажиллах бүтэц, орон тоо, хүний нөөцийн судалгааг гаргаж, БСШУЯ-нд хүргүүлнэ. 6.2. Номын санчид, ажилтан албан хаагчдын мэргэжлийг дээшлүүлэх, мэдлэг чад-варыг сайжруулах: 6.2.1. Номын сангийн ажилтнуудын мэдлэг чад-вараа дээшлүүлэхэд нь дэмжиж, номын сангийн	-Дотоод хяналт шалгалтын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ажиллах журмыг шинэчлэн найрууллаа. Ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулан ажиллаж байна. -Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоол болон МУҮНСангийн стратеги төлөвлөгөө, ажлын байрны шинжилгээ, судалгаа, ажил албан тушаалд тавигдах шаардлагыг үндэслэн “Ажлын байр, албан тушаалын тодорхойлолт”-ыг шинэчлэн боловсруулж 2015 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс мөрдөж ажиллаж байна. Номын санчдын ажлын үндсэн чиг үүрэг, хариуцлагыг нарийн тооцож, өдөр тутмын тэмдэглэл хөтлүүлэх, зарим ажилтнуудын ажлын байранд зураг авалт хийж ажлын байр албан тушаалын тодорхойлолттой нь харьцуулалт хийн ажлын ачааллыг зохицуулах чиглэлээр ажиллаж байна. Ингэснээр ажлын байрны чиг үүрэг тодорхой болж хөдөлмөрийн бүтээмж дээшилсэн. Ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, орон тооны давхацлыг арилгах, бүтцийг оновчтой болгох зорилгоор 8 ажилтны ажлын байрны зураг авалтыг сарын хугацаанд хийж байна. Шинэчлэн баталсан ажлын байрны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллахыг шаардсанаар 8 хүн номын сангийн мэргэжлийн бакалаврын зэрэг эзэмшихээр Соёлын дээд сургуульд суралцаж байна. -Нийгмийн хөгжил, хөдөлмөрийн харилцааны явцад үүссэн харилцааг зохицуулах чухал баримт бичиг болох “Хөдөлмөрийн гэрээ”-г өнөөдөр үүссэн харилцааг зохицуулахуйц түвшинд боловсруулж эрх үүрэг, хариуцлагыг илүү боловсронгуй болгож шинэчлэн найруулж, ажиллагсадтай шинээр гэрээ байгуулах ажлыг хийж дуусгалаа. -Шинэ барилга ашиглалтанд орохтой холбогдуулан бүтэц, орон тоо, хүний нөөцийг ССАЖЯ-ны шуурхай хурлаар хэлэлцүүлж байсан. Мөн БСШУ-ны дэд сайдад танилцуулсан. 2016 оны төсөвт стандартад заасны дагуу орон тоотой байх саналыг тусгасан байгаа.	

мэргэжлээр гүнзгийрэн суралцах боломжийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана. 6.2.2. Гадаад, дотоодод	- Ажилчдын цалин, албан тушаалын болон хавсран гүйцэтгэх ажил үүргийн жагсаалт, ээлжийн амралтын хуваарийг батлан ажиллаж байна. -Байгууллагын зүгээс хүний нөөцийг чадавхижуулах, нарийн мэргэжлийн боловсон хүчнийг давтан сургах, /гар бичмэл сэргээн засварлагч, инженер техникийн ажилтнууд г.м/ гадаад хэлний боловсролыг дээшлүүлэх сургалтуудыг бодлогын түвшинд зохион байгуулан ажиллаж байна. -Номын сангийн шинэ систем “Коха програм”-ын танилцуулга, нэвтрүүлэх тухай сургалтыг 2 удаа зохион явуулав -Удирдах болон гүйцэтгэх түвшний ажиллагсад, маркетингийн багийнханд зориулж Эдийн Засгийн дээд сургуулийн багш доктор Амарсанаагаар “Менежментийн үндэс”, “Хамт олны менежмент” сургалтыг зохион байгуулав. -Үндэсний номын сангийн хүний нөөцийн судалгааг гаргаж, шаардлагатай боловсон хүчин мэргэжилтний жагсаалтыг гаргах, орон тоог нэмэгдүүлэх үндэслэлийг боловсруулллаа. Гар бичмэл сэргээн засварлагч, эрдэм шинжилгээний ажилтан, дижитал сан үүсгэх техникийн ажилтан, сүлжээний инженер, цаасны мэргэжилтэн, хятад, төвд, англи зэрэг гадаад хэлний мэргэжилтнүүд нэн тэргүүнд шаардлагатай байгааг судалгаа харуулж байна. -ОХУ, Чех, Сингапур,Тайланд, Хятадын Бээжин хотын ҮНС-уудад номын сангийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтанд номын санчдыг хамруулах, туршлага солилцох талаар санал явуулж нийт 15 ажилтан сургахаар төлөвлөж байна. -Байгууллагын зүгээс номын санчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах, гадаад хэлний боловсролоо дээшлүүлэхэд онцгой анхаарч, суралцах боломжоор хангаж, дэмжин ажиллаж байна. Үүнд: - ОХУ-ын Улан-удэ хотод “Байкал-2015: Соёл урлагийн менежмент” олон улсын сургалтанд 1 хүн	

богино хугацаанд сурах, мэргэжил дээшлүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа болон гадаад хэлний чиглэлээр суралцахад дэмжлэг үзүүлнэ. 6.2.3. Номын санчид, ажилчдад зориулсан төрөл бүрийн лекц, ярилцлага мэргэжлийн чиглэлийн уралдаан тэмцээн зохион байгуулна. /4удаа/	-Бээжин хотод зохион байгуулагдсан “Буддын шашны шинжлэх ухаан” Олон улсын ЭШ-ний бага хуралд 1 хүн - БСШУЯ-ны статистикийн мэдээлэл гаргах арга зүйн сургалтанд 4 хүн - Монголын номын сангийн консорциумаас зохион байгуулсан сургалтанд 4 хүн - Байгууллагын бичиг хэргийн архивыг байгуулж байгаатай холбогдуулан архивын ажлын комисс болон бүх ажилчдад АЕГ-ын мэргэжилтнээр 2 удаа хичээл заалгасан. -БСШУЯ-аас зохион байгуулсан “Соёлын бүтээлч үйлдвэрлэл” сургалтанд 2 ажилтан -Мэргэжил дээшлүүлэх сургалтанд 2 хүн -Гадаад хэлний сургалтанд 2 хүн -Соёлын дээд сургуульд 8 хүн - Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдөр, Цэргийн баярыг тохиолдуулан номын санчдын бие бялдар, авьяас чадварыг хөгжүүлэх зорилгоор волейбол, теннис, дардтс даам, шатрын 4 төрөлт тэмцээнийг байгууллагын ажилтнуудын дунд зохион байгууллаа. Уг тэмцээн нь 2014 оноос эхлэн уламжлал болон зохиогдож байна. Бүх ажиллагсбыг хамардаг энэхүү тэмцээнд 5 баг оролцдог бөгөөд багийн нэг гишүүн нэг спортын төрөлд орох эрх олгосон нь багийн хүн бүрийг хамрах нөхцлийг бүрдүүлсэн төдийгүй тэмцээнийг өрсөлдөөнтэй, сонирхолтой болгодог, хамт олны хүлээдэг тэмцээн болсон. Тэмцээнд түрүүлсэн баг шилжин явах цом, өргөмжлөлөөр шагнагддаг. -Улаанбаатар дээд сургуулийн номын сангаас зохион байгуулсан номын сангуудын уламжлалт сагс, волейбол, теннис, шатрын аварга шалгаруулах спортын тэмцээнд Үндэсний номын сангийн хамт олон багаараа 2-р байрт шалгарлаа. -Монголын соёлын ажилтны баярыг тохиолдуулан зохион байгуулсан 5 төрөлт тэмцээнд амжилттай оролцсон	

<table>
<tr><td colspan="3">“Төрөөс баримтлах соёлын бодлого”- 3.1.9.соёлын салбарт харилцан үр ашигтай гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх; 4.2.2.соёлын үнэт зүйлийг бүтээх, соёлын өвийг хадгалж хамгаалах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн санал санаачилга, үйл ажиллагааг дэмжих; 4.3.8.гадаад орны музей, архив, номын санд хадгалагдаж байгаа монголын түүх, соёлын холбогдох эд өлгийн зүйл, эх хэрэглэгдэхүүнийг судлах, хэвлэн нийтлэх, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа болгох, сурталчлах зэргээр олон нийтэд таниулах;
ДОЛОО. “Мэргэжлийн хүрээнд гадаад дотоодын байгууллагуудтай стратегийн түншлэл байгуулж, харилцан ашигтай ажиллах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ</td></tr>
<tr><td>7. Гадаад, дотоод хамтын ажиллагааг харилцан ашигтай өргөжүүлэх

7.1. Гадаадын үндэсний номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах

7.1.1. Гадаад орны Үндэсний номын сан, эрдэм шинжилгээний олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, гэрээний дагуу хамтран</td><td>• 10 орчим орны 20-оод номын сантай ном, хэвлэлийн солилцоо хийж гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлж байна.
• 2015 онд “Гадаад орнуудын номын сан эрдэм шинжилгээний байгууллагуудтай ном хэвлэл бүр солилцох гэрээ”-г шинэчлэн батлуулж, байнгын харилцаат номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудад илгээн саналаа хүргүүллээ.
• 2015 онд гадаад орнуудын номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудаас 249 нэрийн 316 ширхэг ном, 181 нэр төрлийн 590 ширхэг сэтгүүл, 12 нэр төрлийн 830 ширхэг сонин солилцоогоор хүлээн авч сан хөмрөгт гадаад номын бүрдүүлэлт хийсэн.
• Казакстан Улсын Үндэсний номын сан, Өвөр монголын Үндэсний номын сан, Сингапурын номын сангуудтай хамтарч ажиллах санамж бичгийг шинэчлэн баоловсруулж хамтарч ажиллагаагаа өргөжүүлж байна.
• ОХУ-ын Борис Ельциний нэрэмжит номын сантай харилцаа тогтоож, хамтран ажиллах санал солилцсон бөгөөд тус номын сангийн төлөөлөгчдийг МҮНС-ийн захиргаа хүлээн авч, нийт ажилчдын дунд уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, туршлага солилцсон.</td><td>.</td></tr>
</table>

ажиллана. 7.1.2. Гадаадад номын санчдыг сургах асуудлыг боловсруулах, туршлага судлах, олон улсын хуралд номын санчдыг оролцуулна. /2-3 номын санчийг хамруулах/	• ОХУ-ын Улаан Үд хотод зохион байгуулагдсан ”Байкаль-2015: Соёл урлагийн менежмент” ОУ-ын хамтарсан сургалтанд 1 ном зүйч оролцсон. • Бээжин хотод зохиогдсон “Буддын шашны шинжлэх ухаан” эрдэм шинжилгээний бага хуралд 1 ажилтнаа оролцуулснаар Хятад улсад хэвлэгдэн тараагдаж буй Ганжуур Данжуурын хөрвүүлэг 419 боть номыг бэлэг хандивын журмаар авах эрхийн бичгээр шагнагдлаа • ОХУ, Чех, Сингапур, Тайланд, Хятадын Бээжин хотын ҮНС-уудад номын сангийн чиглэлээр их дээд сургуулиудад мэргэжилтэн бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтанд номын санчдыг хамруулах, туршлага солилцох талаар санал явуулж, нийт 15 ажилтанг сургахаар төлөвлөж байна. • Харилцаатай ажиллаж байгаа Гадаадын номын сан болон эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгааг гарган харилцаагүй байсан Франц, Сингапур, Египетийн Александрын номын сантай холбоо тогтоож хамтран ажиллахаар гэрээг илгээлээ • Монгол – Австрали 2 улсын Засгийн Газрын хэлэлцээрийн дагуу монгол оюутнуудыг сургах Засгийн Газрын тэтгэлэгт хөтөлбөрийн магистрын сургалтанд нэг ажилтныг сургаж байна. • Өвөрмонголын Өөртөө Засах орны номын сантай хамтран ажиллах гэрээний дагуу 6 ажилтан хүрэлцэн ирж манай номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцно. • Юнескогийн Бээжингийн салбар болон Юнескогийн Монголын Үндэсний Комисстой “Цаасан баримтат өвийн хадгалалт, хамгаалалт” төсөл болон үнэт	

	ховор гар бичмэл ном судрыг бүс нутгийн өвд бүртгүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.	
7.2. Дотоод хамтын ажиллагааг эрчимжүүлэх 7.2.1. Төрийн болон төрийн бус бизнесийн, ном хэвлэлийн, соёл урлагийн байгууллагуудтай хамтран ном хэвлэл, үндэсний соёл уламжлалыг сурталчлах арга хэмжээг зохион байгуулна.	• Төрийн болон Төрийн бус байгууллагуудтай хамтран ном хэвлэлийг сурталчлах, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх, хамтарсан хэлэлцүүлгийг зохион байгуулах зэрэг олон талын ажлуудыг хийж байна. Тухайлбал: • Аймаг, нийслэлийн номын сангуудын үйл ажиллагаанд арга зүйн туслалцаа үзүүлж, бичиг үсгийн баярыг хамтран зохион байгууллаа. Тайлангийн хугацаанд Ерөнхийлөгчийн Тамгын Газар, аймгуудын Засаг Даргын Тамгын Газар, Төв номын сантай хамтран Өвөрхангай, Дундговь, Архангай аймгуудад Үндэсний бичиг үсгийн баярыг хамтран зохион байгууллаа. • “Бичиг соёл” төвтэй хамтран монгол уран бичлэгийг сурталчлах зорилгоор жил бүр зохион явуулдаг олон улсын уран бичлэгийн уралдааныг зохион байгуулахад нь дэмжиж оролцон хамтран ажилладаг. • Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сантай хамтарч ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. • JCI ТББ-тай хамтран “Номын баринтаг” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр 2-3 жил үргэлжилнэ • “Мөнхийн үсэг” ХХК-тай хамтран “Цахим уншлагын танхим”-ыг нээж ажиллуулж байна. • “Номын хишиг” ХХК-тай хамтран “Монгол генниссийн амжилт” ном гаргахаар ажиллаж байна. • Ерөнхийлөгчийн Тамгын Газартай хамтран “Мөнх тэнгэрийн бичиг” үзэсгэлэнг	

	зохион байгууллаа. Жил бүр уламжлал болон явагддаг бичгийн дурсгалын энэхүү үзэсгэлэнг хамтран явуулж байхаар хэлэлцлээ	
Монгол Улсын Үндэсний Номын сангийн дүрэм"-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хангах ажлын хүрээнд: **НАЙМ. Төсөв санхүү, бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ**		
8.Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, бүртгэл тооцооны системийг боловсронгуй болгох: 8.1. Төсвийг оновчтой хуваарилах, санхүүгийн тайлан мэдээ, үндсэн хөрөнгийн ашиглалт, бүртгэлийг сайжруулах: 8.1.1.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулна. 8.1.2.НББББББ-г боловсруулах, стандарт, журам зааврыг чанд мөрдөн санхүүгийн тайлан, мэдээг үнэн, зөв, хугацаанд нь	• Тус номын сан нь Монгол улсын Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2015 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулж, уг гэрээний дагуу 898.587.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагаагаар 22.103.5 мянган төгрөгийн орлого олж, батлагдсан төсвийг сар бүрийн хуваарийн дагуу үр ашигтай зарцууллаа. • Тайлангийн хугацаанд Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг мөрдлөг болгон НББОУС-д нийцүүлэн үйл ажиллагаагаа тайлагнаж ирлээ. Мөн Сангийн сайдын тушаалаар батлагдсан ТТ-1, ТТ-2, МГТ-1, ЗЭБ-2 маягтаар төсвийн гүйцэтгэлийг сар бүрийн 2-ны дотор үнэн зөв гаргаж, төсвийн статистик мэдээллийг Төрийн санд өгч хэвшлээ. НДШ-ийн болон татварын тайлан, хагас жилийн балансыг цаг хугацаанд нь үнэн зөв гарган өгсөн. • Үндсэн хөрөнгийн хагас жилийн тооллогоор 426 нэрийн 3.212.690.599 төгрөгийн үндсэн хөрөнгө тоолж, эд хариуцагч нараас дутсан зүйлгүй байлаа. Үүнээс 12.937.000 төгрөгийн үндсэн хөрөнгийг шинээр бүртгэн авч, тайлан балансанд тусгасан байна. Тайланг Захиргааны зөвлөлийн хурлаар оруулаа. • Захирлын 2015 оны А/13 тоот тушаалын дагуу 2015 оны 02-р сарын 26-ны өдрөөс эхлэн Архивын баримтыг ангилах, эмхлэн цэгцлэх, үдэж хавтаслах ажлын комисс 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилогдон, өдөрт 5 цагаар Архивын тухай хууль, байгууллагын архивын үндсэн заавар, журмын хүрээнд ажилласан.	

гаргана. 8.1.3. Үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, эд хөрөнгийн тооллого бүртгэлийг хагас, бүтэн жилд зохих журмын дагуу хийнэ. 8.1.4. Үндэсний номын сангийн архивын баримт материалыг цэгцэлж, зохих хууль, дүрмийн дагуу бүрдүүлнэ.	Ажлын хүрээнд 1951-2014 оны баримт бичгүүдийг шинээр ангилан ялгаж, дутууг нь олж нөхөн бүрдүүлэх, дугаарлах, товъёог бичих, баримтыг нягтлан шалгах, акталж устгах баримтыг ялгаж БББНШК-ын хурлаар оруулахад бэлтгэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Дээрх баримтуудыг ялгаж, тоос шороог нь цэвэрлэн “Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн нийтлэг баримт бичгийн хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт”-ын дагуу нягталж хадгалах хугацааг тодорхойлж устгах хэргийн бүртгэлүүдийг хөтөлсөн. Мөн агуулахад хадгалагдаж байсан хуучин бичиг баримт, хавтастай материалуудыг зөөж, цагийн бүртгэл зэрэг шаардлагагүй материалуудыг ялгаж, тоос шороог нь цэвэрлэж устгах баримтын жагсаалтанд бүртгэсэн. • Сангийн сайдын “Түүх соёлын дурсгал, үзмэр эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнэ тогтоох” тухай №140 тоот тушаалыг үндэслэн Үндэсний номын сангийн захирлын 2014 оны 10-р сарын 30-ны өдрийн 72 тоот тушаалаар томилогдсон “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн дансны үнэ шинэчлэн тогтоох комисс нь 10-р сарын 31-нээс 12-р сарын 03-ны өдөр хүртэл ажлын 24 өдөрт “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл” 7 дэвтэрт бүртгэгдсэн 516 дэсийн эд өлгийн зүйлийн үнийг тогтоож, нийт 2.974.884.400 төгрөгөөр үнэлсэн ба Үнэт ховор номын музейн ном судрын шинэчилсэн энэхүү үнэлгээг дансанд тусгалаа. • Захирлын 2014 оны А/54 тоот тушаалын дагуу томилогдсон комисс “Түүх соёлын дурсгалт зүйлсийг үнэлж бүртгэлд тусгах зөвшөөрөл олгох тухай” Төрийн Өмчийн Хорооны 2014 оны 359 дүгээр тогтоол, Сангийн сайдын “Түүх соёлын дурсгал, үзмэр эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнэ тогтоох” тухай №140 тоот тушаалыг тус тус баримтлан хил дээр хураагдсан 1 судар /”Гурван зуут”/, 8 модон бар, бэлгийн журмаар ирсэн 8 судар, номыг үнэлж БСШУЯ-ны Соёлын	

	хэлтсийн дарга Урантөгс болон мэргэжилтэн Бямбасүрэн нараар хянуулж үндсэн бүртгэлдээ бүртгэх зөвшөөрөл авлаа. Дээрх 26 654 500 төгрөгийн ном, судар, барыг Монгол судлал, гар бичмэлийн фондод бүртгэж аван судалгааны эргэлтэнд оруулах боломжтой болголоо.	
“Үндэсний хөгжлийн цогц бодлого”- Стратегийн зорилт. 2. Соёл, урлагийн байгууллагуудын материаллаг бааз, барилга байгууламжийн зориулалт, эрүүл ахуй, гоо зүй, техникийн болон үйлчилгээний чанарт тавигдах орчин үеийн хэрэгцээ шаардлагыг тусгасан стандартыг боловсруулж мөрдөх ажлын хүрээнд: **ЁС. Номын сангийн орчин нөхцлийг сайжруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ**		
9.Номын сангийн орчин нөхцлийг сайжруулах: 9.1. Үйлчилгээний тав тухтай орчин бий болгох: 9.1.1.Үндэсний номын сангийн шинэ барилгын ажлыг тасралтгүй явуулахад анхаарч, гүйцэтгэгч компани, зургийн компани-тай тогтмол харилцаатай ажиллаж, хяналт тавина.	• Шинэ барилгын ажлын явцад хяналт тавих ажлын хэсгийг Захирлын 2015 оны А/57 тоот тушаалаар 8 хүний бүрэлдэхүүнтэй томилсон. Ажлын хэсэг барилга дээр очиж ажлын явц байдалтай танилцан зургаар баримтжуулж, гүйцэтгэгч болон зургийн компанитай тогтмол холбоотой ажиллаж байна. Одоогийн байдлаар барилгын зоорийн давхраас 2 давхар хүртэл бүрэн баригдсан байна. • Уншигчдын тав тухтай байдлыг хангах зорилгоор 2, 3-р улиралд 1-р давхрын үнэмлэх нээлт, харуулын өрөө, өлгүүрийн хэсэгт засвар хийж, орчин үеийн техник хэрэгсэл, хүлээлгийн өрөөний ширээ сандал худалдан авч тохижуулсан. Энэхүү ажилд 15,6 сая орчим төгрөгийг зарцууллаа. • Хөрөнгө санхүүгийн боломжгүйгээс дээвэрт засвар хийгдээгүй боловч ус гоождог хэсгүүдэд хэсэгчилсэн байдлаар засвар хийх арга хэмжээг авсан. • Гадна талын худаг, узель, фондууд, өрөө тасалгаанууд, ариун цэврийн	

9.1.2.Номын сангийн 1-р давхрын үнэмлэх нээлт, харуулын өрөө болон өлгүүрийн хэсэгт засвар үйлчилгээ хийж, тохижуулна. 9.1.3.Номын сангийн барилгын дээвэрт хэсэгчилсэн засвар хийнэ. 9.1.4.Номын сангийн дулаан, сантехник, цахилгааны аюулгүй ажиллагааг хангаж, хэсэгчилсэн засвар үйлчилгээг тогтмол хийнэ.	өрөөнүүдэд сантехникийн засварууд хийж /100-гийн хаалт, изгон, контр, муфьт, винтель, жийрэг резин, холигч крант, уян холбоосыг шинээр сольсон./ эвдэрч гэмтсэн дулааны моторыг мэргэжлийн байгууллагаар засуулж ажиллагаанд оруулсан. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг ханган хаалга, цонхуудыг дулаалж, эвдэрсэн цоож, нугасуудыг засварласан. • Нийт обьектод цахилгааны үзлэг шалгалтыг байнга хийж, холболт, масс, кроткоос үүсэж болох зөрчлүүдийг цаг тухайд нь засварласан. Дулааны моторыг хянах самбарт засвар үйлчилгээг хийсэн. Уншлагын танхимын чийгшүүлэгчийг зассан • Дулаан, сантехникийн аюулгүй ажиллагаанд тогтмол хяналт тавьж, бохир цэвэр усны системд хэсэгчилсэн засвар, үйлчилгээг хийлээ. • Хувилан олшруулах үйлчилгээг автоматжуулж, орчин үеийн BIZHUB 3 үйлдэлт ухаалаг каноныг уншлага үйлчилгээнд нэвтрүүлж, уншигч хэрэглэгчдэд түргэн шуурхай чанартай үйлчилгээг үзүүлж байна.	
Монгол Улсын Үндэсний Номын сангийн дүрэм”-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хангах ажлын хүрээнд: **АРАВ. Ажилтнуудын нийгмийн асуудалд анхаарч, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ**		
10.Номын санчдын нийгмийн асуудлыг анхаарч,	• Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулийн 2-р бүлэг, “Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай” хуулийн 5-р зүйл, “Хөдөлмөрийн тухай” хуулийн 18-р	

урамшууллын системийг боловсронгуй болгох: 10.1. Нийгмийн халамж үйлчилгээг үзүүлэх: 10.1.1 Үйлдвэрчний Эвлэлийн Хороотой хамтын гэрээ байгуулж ажиллана. 10.1.2. Номын санчдын нийгмийн асуудалд анхаарч, халамж үйлчилгээг зохих журмын дагуу үзүүлнэ. 10.1.3.Эрүүл мэндийн үзлэгт нийт ажилтнуудыг хамруулна. 10.1.4. Байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан хүмүүсийг хүлээн авч, хүндэтгэл үзүүлнэ.	зүйлийг үндэслэн Үндэсний Номын Сангийн захиргаа, Үйлдвэрчний Эвлэлийн Хорооны хооронд ажилтнуудын нийгмийн асуудал, ажил эрхлэлт, хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл хөлс, урамшуулал, ажил амралт, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн нөхцөл, эрүүл мэндийг сайжруулах, хөдөлмөрийн харилцааг зохицуулах, ажил үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр 2015-2016 онд дагаж мөрдөх “Хамтын гэрээ”-г байгуулан ажиллаж байна. • Ажилчдад буцалтгүй тусламж болгон 330.000 төгрөг, мөнгөн шагнал 400.000 төгрөг, тэтгэмж 3 хүнд 13.584.849 төгрөг, ахмадуудыг сар шинийн баяраар хүлээн авах зардалд 859.910 төгрөг, ажилчдад цалингийн зөрүү 5.390.000 төгрөг зэргийг санхүүгийн боломжиндоо тулгуурлан олгосон. Мөн нийгмийн идэвхийг өрнүүлэх зорилгоор номын сангуудын дунд зохион байгууллагддаг “Биеийн тамир, спортын бага наадам”, “Март болон цэргийн баяр”-ын урлаг, спортын нэгдсэн арга хэмжээ,Үндэсний их баяр наадам, шинэ жил, соёл, урлагийн ажилтны өдрүүдийг тохиолдуулан мөнгөн урамшуулал олгож нийт ажиллагсдыг хамруулсан. • Нийт ажилтнуудын 80 гаруй хувийг 11-р сард эрүүл мэндийн үзлэгт хамруулж эмэгтэйчүүд, зүрх судас, дотрын эмчийн үзлэг, биохими, хелико бактери, эхо, зүрхний цахилгаан бичлэг зэрэг шинжилгээнд оруулсан. • Байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан 32 ахмадыг сар шинийн баяраар болон Ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлж хүлээн авсан. • Соёлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэхь хэсгийн 2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, Засгийн газрын 1996 оны 96 дугаар тогтоолыг үндэслэн “Мэргэжлийн ур чадварын нэмэгдэл олгох журам”-ыг шинэчлэн боловсруулж батлан ур чадварыг үнэлж дүгнэх комиссыг томилон, ажиллаж 2015 оны эхний хагас жилийн ажилд дүн шинжилгээ хийж захиргааны	

10.1.5. Шагнал урамшууллын системийг оновчтой болгож, зохих журмын дагуу ур чадварын нэмэгдэл болон бусад нэмэгдлийг олгоно.	зөвлөлд танилцууллаа. Ур чадварын нэмэгдэл болгож 43 хүнд нийт 5.957.869,75 төгрөг, нэмэгдэл хөлс 25 хүнд нийт 3.166.028.15 төгрөг олгосон. Үүний дүнд ажилчдын идэвхи санаачилга, үүрэг хариуцлага, ажлын бүтээмж эрс сайжирсан. • Олон жил үр бүтээлтэй ажилласан ажилтнуудын ажлыг дүгнэж төрийн одон медальд тодорхойлсноор 3 хүн Монгол улсын "Соёлын тэргүүний ажилтан" цол тэмдгээр, 1 хүн "Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч" цол тэмдгээр тус тус шагнагдлаа. • Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн хурлыг улиралд 1 удаа тогтмол хийхийн зэрэгцээ эх үрсийн баяраар нийт ажиллагсад болон гишүүдээ урамшуулах ажлыг зохион байгууллаа. • Номын санийн хоёр ажилтныг орон сууцны зээлд хамрагдахад дэмжин ажилласны зэрэгцээ байгууллагын дотоод журмын дагуу нөхцлийн нэмэгдэл 19 хүнд тус тус олголоо. • Энэ онд байгууллагаас 2 ажилтан өндөр насны тэтгэвэрт гарсан бөгөөд захиргаа болон хамт олноос ажил хөдөлмөрийн амжилтыг нь тэмдэглэсэн	

ХОЁР.ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

Гэрээнд тусгагдсан тусгай арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт *(тоо, чанар, хугацаа хүрэх үр дүн)* ***бүрээр хүрэх түвшин***	***Жинхэнэ гүйцэтгэл*** *(тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)*	***Тухайн тусгай арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ*** *(Тусгай арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо)*
1	2	3

1. Үндэсний номын сангийн шинэ барилгын ажлыг тасралтгүй явуулахад анхаарч, гүйцэтгэгч компани, зургийн компанитай тогтмол харилцаатай ажиллаж, хяналт тавина	Шинэ барилгын ажлын явцад хяналт тавих ажлын хэсгийг Захирлын 2015 оны А/57 тоот тушаалаар 8 хүний бүрэлдэхүүнтэй томилсон. Ажлын хэсэг барилга дээр очиж ажлын явц байдалтай танилцан зургаар баримтжуулж, гүйцэтгэгч болон зургийн компанитай тогтмол холбоотой ажиллаж байна. Одоогийн байдлаар барилгын зоорийн давхраас 2 давхар хүртэл бүрэн баригдсан байна.	
2. "Номын сангийн тухай хуульд тусгагдсан журмуудыг боловсруулна. Үүнд: "Цахим уншлагын үйлчилгээг үзүүлэх журам", "Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам", "Эрдмийн зөвлөлийн ажиллах журам"	-"Номын сангийн тухай" хуульд заасны дагуу Үндэсний номын сангийн дэргэдэх "Эрдмийн зөвлөл", "Мэргэжлийн зөвлөл"-ийн ажиллах журмыг боловсруулалцан БСШУ-ны Сайдын 2015 оны А/200 тоот тушаалаар батлууллаа. Мөн тус зөвлөлүүдэд ажиллах бүрэлдэхүүнийг томилуулж ажиллаж байна. -"Цахим уншлагын үйлчилгээг үзүүлэх журам"-ыг БСШУЯ-ны мэргэжилтэнтэйгээ ярилцаж энэ үйлчилгээг явуулж ирсэн УБ хотын Төв номын сангаар журмын төслийг хийлгүүлэхээр болсон.	
3. "Эрдэм шинжилгээний танхимын болон цахим уншлагын үйлчилгээний танхимын журмыг шинэчлэн боловсруулна.	-Захиргааны зөвлөлийн 2015 оны 03 сарын 26-ны өдрийн хуралдаанаар Ерөнхийлөгчийн нэрэмжит "Эрдэм шинжилгээний танхим"-ын үйлчилгээний журмыг хэлэлцэж шинэчлэн боловсруулж батлан мөрдөж ажиллаж байна.	
4. Цахим уншлагын танхим байгуулж шинэ үйлчилгээг нэвтрүүлэн, уншигчийн хүрээг өргөтгөж, үйлчилгээний соёлыг сайжруулна	- Интернэтэд холбогдох 5 суурин компьютер, цахим сонин унших мэдрэгчтэй 4 дэлгэц, Мөнхийн үсэг ХХК-тай гэрээ байгуулж 100 ш цахим ном агуулсан 5 ширхэг цахим ном уншигч төхөөрөмжийг байрлуулсан. Өдөр тутмын 5 нэрийн сонингийн 1990 оноос хойшхи дугааруудыг сканнердан цахим сан бүрдүүлснийг сан хөмрөгт нь бүртгэсэн. Уншигчдад тав тухтай байдлыг	

	хангах, чөлөөт орчин бүрдүүлэх зорилгоор тус танхимд 725500 төгрөгийн засвар үйлчилгээг хийж талбай бага эзлэх орчин үеийн шийдэл бүхий тавиур, хос буйданг байрлууллаа. Тус танхимд үйлчлүүлэгсдийг wifi орчин, үнэгүй интернэт, гадаадын нээлттэй эрхийн мэдээллүүдийг ашиглах боломжоор хангахын зэрэгцээ, ажиллах зааврыг таниулах, сонингийн мэдээллийг хялбар түргэн хайж олох зэрэг уншигчдын сэтгэлд нийцсэн үйлчилгээ үзүүлдэг таатай орчинг бүрдүүлсэн. 20 хүнд зэрэг үйлчлэх хүчин чадалтай. Мөн Баруун Вашингтоны их сургуулийн номын сангийн шинээр хэрэгжүүлж эхэлсэн The research-writing studio буюу судалгааны ажил бичиж буй судлаачдад туслах төвийн үйлчилгээг өөрийн номын сангийн баялаг баазд түшиглэн явуулах боломж бүрдсэн. /зургийг хавсралтаар/	

ДҮГНЭЛТ

Үндэсний номын сан нь тайлангийн хугацаанд соёл урлагийг хөгжүүлэх талаар баримталж буй Монгол улсын Засгийн Газрын бодлогыг хэрэгжүүлж, байгууллагын бүтэц зохион байгуулалтыг сайжруулах, оновчтой зохион байгуулах, хүний нөөцийг чадавхижуулах, номын сангийн үйлчилгээнд шинэ техник, технологи нэвтрүүлэх, үндэсний өв соёл, бичиг үсгээ хадгалж хамгаалах, сурталчлах, хот, хөдөө, орон нутгийн бүх төрлийн номын сангуудыг арга зүйн удирдлагаар хангах, номын сангийн хэвийн, аюулгүй ажиллагааг ханган уншигч үйлчлүүлэгчдийн тав тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх зэрэг олон асуудлуудыг амжилттай шийдвэрлэж ажиллалаа. Санхүү, хөрөнгө боловсон хүчний нөөцийн чадавхи боломжийн түвшинд байгаагүй ч дотоод нөөц бололцоогоо тулгуурлан мөн аж ахуй нэгж, хувь хүмүүс, гадаад, дотоодын ТББ-удтай хамтран ажилласны үр дүнд 2015 онд БСШУ-ны Сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хэрэгжүүллээ.

БСШУЯаманд уламжилж нэн тэргүүнд шийдвэрлүүлэхээр дараах асуудлуудыг хүргэж байна. Үүнд:

1. Үндэсний номын сангийн бүтэц, орон тоог нэмэгдүүлэх, боловсон хүчнийг чадавхжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх
2. “Үндэсний номын сангийн стратеги /2010-2016 он/”-ийг хэрэгжүүлэхэд бүх талын туслалцаа үзүүлэх
3. Дижитал номын сангийн орчинд шилжих бэлтгэл ажлыг эхлүүлж, өндөр хөгжилтэй орны их дээд сургуульд мэргэжилтэн бэлтгэх, номын санд нэвтрүүлэх цогц програм хангамжийг худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх
4. Үнэт ховор сан хөмрөгүүдийг хадгалах зориулалтын фондын барилгын өргөтгөл барих хөрөнгийг төсөвт суулгаж өгөх

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САН

ФОТО ТАЙЛАН – 2015 он

“Түшээт засаг, хошой чин ван Гадинбалын Чагдаржав” /баримт бичгийн эмхтгэл тэргүүн боть/-*ын *номын нээлт /2015.01.09/



Монгол Улсын Архивын ерөнхий газар, Чагдаржав сан хамтран эмхэтгэсэн “Түшээт засаг, Хошой чин ван Гадинбалын Чагдаржав” /баримт бичгийн эмхтгэл, тэргүүн боть/ номын нээлтийн арга хэмжээг Ерөнхийлөгчийн нэрэмжит танхимд зохион байгуулах ажлыг 2015 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгууллаа.

Монгол,Францын хооронд димломат харилцаа тогтоосны 50 жилийн ой /2015.01.30/

Монгол, Францын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой 2015 онд тохиож байгаатай холбогдуулан Монгол францын найрамдлын нийгэмлэг, Монгол улсын үндэсний номын сан хамтран 2015 оны 1-р сарын 30-ний өдөр энэхүү номын баярыг тэмдэглэн зохион байгууллаа.

Энэ үйл ажиллагааны хүрээнд МУҮНС-ийн сан хөмрөгөөс дээжлэн 90-ээд бүтээл, Монгол Францын найрамдлын нийгэмлэгийн тэргүүн, Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Х.Бэхбат, Ахмад димломатч, орчуулагч Т.Төмөрхүлэг, Д.Лхамсүрэн нарын монголын тухай франц хэл дээр хэвлэгдсэн түүх, соёл шинжлэх ухаан судалгааны үнэ цэнэ бүхий номын цуглуулгаас түүнчлэн багш нарын бүтээлээс дээжлэн 160-аад ном, нийт 250 гаруй номоор үзэсгэлэн гаргаж, уншигч олон түмэнд толилууллаа.

Энэ үйл ажиллагаанд францын уран зохиолыг сонирхогч, судлаач, уншигч, уран бүтээлчид оролцлоо.

“Номын сангийн тухай” хуулийн эхийг хүлээн авах

ёслолыг зохион байгууллаа.

“Номын сангийн тухай” хуулийн эхийг хүлээн авах, зохиолч, хэвлэлийн газраас Үндэсний сан хөмрөгт номын дээжээ хадгалуулах ёслолын ажиллагаа Үндэсний номын сангийн "Үнэт ховор номын музей"-д 2015 оны 02 дугаар сарын 03-ны өдөр зохион байгууллаа.



.

“Эмнести Интернэшнлийн тайлан 2014-2015” танилцуулах уулзалт /2015.02.25/

Хүний эрхийн боловсрол олгогч Монголын Эмнести Интернэшнлийн хэвлэлийн бага хурлыг Үндэсний номын сангийн Их уншлагын танхимд 2015 оны 2-р сарын 25-ны өдөр зохион байгууллаа. "Дэлхийн хүний эрхийн төлөв байдлын талаарх тайлан" танилцуулах уулзалтын үеэр дэлхийн хүний эрхийн төлөв байдалд ямар ололт амжилт, ухралт гарсан талаарх мэдээллийг өглөө.

Монголын Эмнести Интернэшнл /МЭИ/-ийн Гүйцэтгэх захирал Б.Алтантуяа, Монголын Үндэснийн номын сангийн дэд захирал Д.Бямбасүрэн, ЭИ-ийн Зүүн Азийн Бодлогын ахлах зөвлөх Ян Везэл, МЭИ-ийн УЗ-ийн гишүүн Д.Оюунсүрэн, Хуульчдын бүлгийн ахлагч Р.Очирбал, Сэтгүүлчдийн бүлгийн гишүүн Г.Энхбаатар, Ийгл телевизийн тоймч Г.Ганбаяр нар оролцож, дэлхий дахины хүний эрхийн төлөв байдал, бүс нутгийн тойм, Монгол улс дахь хүний эрх, сэтгүүлчийн хамгаалал сэдвээр илтгэл тавьлаа.

Уулзалтанд Их Британы Элчин сайдын яам, Германы Элчин сайдын яам, Иргэний нийгэм ТББ-ын төлөөлөл, ХЭҮК, Хууль зүйн сургуулийн багш оюутнууд, хувь хүмүүс мөн хэвлэл мэдээллийн байгууллагууд нийт 50 гаруй хүн оролцож, санал бодлоо хуваалцлаа.

Номын баринтаг төслийн нээлтийн үйл ажиллагаа /2015.04.23/

Арга хэмжээний үеэр Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны дэд сайд Б.Тулга, Монгол Улсын Үндэсний номын сангийн захирал А.Нансалмаа, JCI Капитал салбарын 2015 оны Ерөнхийлөгч Б.Амарзаяа нар “НОМЫН БАРИНТАГ” төсөлд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.

НОМЫН БАРИНТАГ төслийн үйл ажиллагааг дэмжиж төрийн соёрхолт, Монгол Улсын гавьяат багш, Шинжлэх ухааны доктор, Профессор Ш.Чоймаа, Их хамба лам Д.Чойжамц нар хүрэлцэн ирж Монголчууд бидний эрт дээр үеэс уламжлагдан ирсэн түүхэн өв соёл, номыг хүндэтгэн дээдлэх ёс, зан үйл, түүнийг хадгалан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээхийн ач тус, мөн номд баринтаг урлах, номыг баринтаглахын тухайд зэрэг сэдвүүдээр сонирхолтой яриаг өрнүүлэн хүрэлцэн ирсэн хүмүүсийн сонорыг мялаасан юм.

Төслийн нээлтийн өдөр манай JCI Капитал салбар байгууллагын гишүүн С.Мөнхгэрэл өөрийн оёсон баринтагуудаа Монгол Улсын Үндэсний номын сангийн удирдлагуудад хүлээлгэн өглөө. Төслийн хүрээнд “Номын баринтаг” төслийг хэрэгжүүлж, нийт 3000 гаруй ном судрыг баринтаглаад байна.

“БИ МОНГОЛ БИЧИГТЭН” ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР-2015” /2015.05.03-08/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, үндэсний хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх, эх хэлээ эрхэмлэн дээдлэх, бичиг соёлын дурсгалаа сурталчлах зорилготой зохион байгуулагдаж байгаа “Үндэсний бичиг үсгийн баяр-2015” арга хэмжээ 2015 оны 05-р сарын 03-ны 11.00 цагт Монголын Үндэсний номын сангийн өмнөх талбайд нээлтээ хийлээ. Уг арга хэмжээний нээлтэнд УИХ-ын гишүүн Д.Сарангэрэл, БСШУ-ны дэд сайд Б.Тулга, БСШУЯ-ны Соёл урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Гантөмөр, Номын сан, ном хэвлэлийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Баяраа, Соёлын баримтат өвийн бодлого хариуцсан мэргэжилтэн Л.Тэрбиш, Төрийн хэлний зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Нэргүй, МУ-ын гавъяат багш, доктор, профессор Ш.Чоймаа, ХНО-ы захирал Д.Оюунбилэг, “Хүмүн бичиг” сонины эрхлэгч Б.Элбэгзаяа, “Монголоороо” төвийн захирал дуучин Г.Эрдэнэчимэг нарын хүмүүс хүрэлцэн ирлээ.

Монгол бичгийг залах ёслол

Ардын багш Д.Чойжилсүрэнгийн нэрэмжит Монгол бичгийн улсын олимпиадын шилдэгүүдэд шагнал гардууллаа.

“Үндэсний бичиг үсгийн баяр-2015” арга хэмжээний хүрээнд Уран бичих төлбөрт үйлчилгээ, номын худалдаа, Үнэт ховор номын музейн үзэсгэлэн, монгол бичиг үсгийн цахим болон уламжлалт үзэсгэлэн, баринтаг хандивлах уулзалт хэлэлцүүлэг зэрэг үйл ажиллагаа зохион байгуулагдлаа.

Баярын үйл ажиллагаанд Үндэсний дуу бүжгийн чуулгын Уртын дуучин Отгонзул, бүжигчин Ганчимэг, Уртнасан, хөөмийч Цогтгэрэл нар уран бүтээлээ сонирхууллаа.

“Болор цом” хүртсэн яруу найрагчдын шүлгүүдийг уран сэтгэмжтэй, хичээнгүй бичих уралдааны бүтээлүүдийн үзэсгэлэн

“Болор цом”-ын шагналт яруу найрагч, уншигчдын уулзалт

“Болор цом”-ын шагнал хүртсэн яруу найрагчдын шүлгүүдийг уран сэтгэмжтэй, хичээнгүй бичих уралдааны шилдгүүдийг шалгаруулж шагнал гардууллаа.

“Монгол бичгийн цахим хэрэглээ” сэдэвт хэлэлцүүлэг, чөлөөт ярилцлага

“Мэргэжил сурталчлах” өдөрлөг /2015.05.07/

Соёлын боловсролын сургуулиас зохион байгуулж буй “Мэргэжил сурталчлах” өдөрлөгт Монгол Улсын Үндэсний номын сангаас “Сонин содон” номын үзэсгэлэн гаргаж оролцлоо.



Соёл Урлагийн ажилтны өдөрт зориулсан сайн дурын үйл ажиллагаа /2015.09.11/

Соёл урлагийн байгууллагууд нийгмийн сайн сайханд дагуулсан, энэрэнгүй хүнлэг нийгмийг төлөвшүүлэх, соёл урлагийн байгууллагын нийгмийн хариуцлага, манлайллыг өргөх зорилгоор сайн дурын үйл ажиллагааг санаачлан зохион байгуулсан бөгөөд Монгол Улсын Үндэсний номын сангийн хамт олон энэ аянд нэгдэж нийт ажиллагсад болон хамтран ажилладаг байгууллагуудын дунд ном хандивлах аяныг зохион байгуулж, ГССҮТ-ийн Түлэгдэл, нөхөн сэргээх, мэс заслын хүүхдийн тасгийн хүүхдүүдэд 1.500.000 орчим төгрөгийн үнэ бүхий 180 нэр төрлийн 300 гаруй номоор “Номын булан”-г байгуулж ГССҮТ-ийн хамт олонд хүлээлгэн өглөө.

Хамт олны дунд зарласан хандивын аян

Өрөөг тохижуулахаас өмнөх байдал ***“Номын булан” өрөөг тохижуулж байгаа байдал***

“Номын булан” өрөөг тохижуулсны дараах байдал

“Номын булан”-гийн нээлтийн арга хэмжээ:

Маркетингийн баг нь 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж, төсөл хөтөлбөр боловсруулах гадаад дотоодын номын сангуудын үйл ажиллагааны талаар судалж номын сандаа нэвтрүүлэх зэрэг олон үйл ажиллагааг явуулж байна.

Номын булангийн нээлтийн ёслол

ГССҮТ-ийн Түлэгдэл, нөхөн сэргээх, мэс заслын хүүхдийн тасгийн эмч сувилагчид

“Номын баяр – 2015” /2015.09.19/

“Номын баяр – 2015”-ыг 9-р сарын 19-ны өдөр Их эзэн Чингисийн талбай, УБ хотын дүүргүүд, бүх аймаг, суманд, Монгол Улсын Үндэсний номын сан, Улаанбаатар хотын төв номын сан, Хүүхдийн төв номын сан, 21 аймгийн номын сангууд, хэвлэлийн газрууд, номын дэлгүүрүүд, зохиолч, орчуулагч, сэтгүүлчид, хөдөө орон нутагт номын бизнес эрхлэгчид, Д.Нацагдоржийн нэрэмжит "Тэргүүний уншигч-Номын сайн нөхөр" тэмдэгтнүүд, номын элгэн садан, номд дурлагчид нэгэн дор цуглаж баяраа тэмдэглэлээ.

Арга хэмжээний хүрээнд Үндэсний номын сангаас зохион байгуулсан ажлууд:

Ерөнхийлөгчийн тамгын газраас бэлэглэж буй МУ-ын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн “Ардчилал бол сонголт”, “Ардчилал бол боломж”, “Ардчилал бол шийдэл”, “Ардчилал бол оролцоо”, “Ардчилал бол хариуцлага” 5 боть, нийт 3815 ширхэг номыг улсын хэмжээний бүх төрлийн номын санд хуваарийн дагуу тарааж өглөө.

“Мэргэжил сурталчлах”, “Номын сангийн хууль” сурталчилах арга хэмжээг зохион байгууллаа.

“Номын сангийн тухай хуулиас” хуулийн танилцуулга, “Ном унших арга”, “Уншина гэдэг гайгүй хэрэг”, “Ном унших арга тус” зөвлөмжүүдийг гаргаж олон нийтэд тарааж сурталчиллаа.

Номын сангийн шинэлэг үйлчилгээ-мэдээлэл танилцуулга, мэргэжил сурталчлах өдөрлөгийг зохион байгууллаа. Жич: “Бид номын санчид” видео танилцуулга /CD-ээр/ хавсаргав.

“Ардын уран зохиолч – уншигчдын уулзалт, ярилцлага”-ыг Чингис хааны талбайд МЗЭ, МУҮНС хамтран зохион байгууллаа.

Уулзалт ярилцлагыг яруу найрагч Мөнхбаатар хөтлөн явуулсан бөгөөд Ардын уран зохиолч, яруу найрагч П.Бадарч, Т.Галсан, Ш.Дулмаа, Б.Догмид, төрийн шагналт зохиолч Долгорын Нямаа нар уригдан оролцож үзэгч, уншигч өргөн олон, хүүхэд залууст хандан сэтгэгдэл, сэтгэлийн үг захиас хэлж, өөрсдийн уран бүтээлээс уншиж сонирхууллаа. Түүнчлэн Ардын уран зохиолч Д.Цоодолын “Тэнэг” шүлгийг “Сүлд” телевизийн дуу оруулагч Содбаяр, Ардын уран зохиолч П.Бадарчийн “Эхийн сэтгэл” шүлгийг СУИС-ийн оюутан Номин-Өлзий нар уншиж сонирхууллаа.

“Номын баяр – 2015” арга хэмжээний үеэр Монгол Улсын Үндэсний номын сангаас гаргасан номын үзэсгэлэн

“Ардын уран зохиолчдын бүтээлийн дээжээс” үзэсгэлэнг 449 номоор

“Шинэ ном - 2015” үзэсгэлэнг 100 номоор

“Номын санчийн ширээнд” үзэсгэлэнг 85 номоор

Хамгийн жижиг, хамгийн том ном” үзэсгэлэнг 98 номоор

үзэсгэлэнг тус тус гаргаж нийт 732 ном хэвлэлийг баярт оролцогч өргөн олонд сурталчиллаа.

“Дэлхийн өвөрмөц хийцтэй номын сангийн барилгууд” фото үзэсгэлэн гаргав. Үзэсгэлэнг цахим хэлбэрээр /CD-ээр/ хавсаргав.

“Номын ертөнц” ТББ-аас зохион байгуулсан “Би номд дуртай” уншигч хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг

Үндэсний номын сан номын баярт оролцогч хүмүүсээс авч “Номын ертөнц” ТББ-д хүлээлгэн өглөө.

ОХУ-ын Б.Н.Ельцины нэрэмжит Ерөнхийлөгчийн номын сангийн мэргэжилтнүүд Монгол Улсын Үндэсний номын санд айлчиллаа. /2015.10.08/

Монгол Улсад 55 дахь удаагаа зохион байгуулж буй Монгол, Оросын найрамдалт хамтын ажиллагааны өдрүүдийн хүрээнд 2015 оны 10 дугаар сарын 08-ний өдөр ОХУ-ын “Үндэсний” статустай 3 том номын сангийн нэг болох “Б.Н.Ельцины нэрэмжит Ерөнхийлөгчийн номын сан”-гийн системийн ахлах шинжээч Преображенская О.В., ахлах номзүйч Тарасова М.А., Россотрудничества агентлагийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын ахлах шинжээч Белунов В.Н. болон Улаанбаатар дахь Оросын шинжлэх ухаан, соёлын төвийн мэргэжилтнүүд Монгол Улсын Үндэсний номын сантай танилцаж, ажилтнуудтай уулзалт ярилцлага хийлээ.

Уулзалтын үеэр номын сангийн өмнө ид тулгамдаж буй дижиталчлалын талаар түлхүү ярилцаж туршлага солилцов. Энэхүү уулзалт нь манай хоёр номын сангийн хамтын ажиллагааны эхлэл болж өгсөнөөрөө маш өндөр ач холбогдолтой боллоо.

Дашрамд дурдахад, “Б.Н.Ельцины нэрэмжит Ерөнхийлөгчийн номын сан” нь 2009 онд ОХУ-ын Санкт-Петербург хотод байгуулагдсан бөгөөд дэлхийн хамгийн ховор, залуу номын сангуудын нэгд тооцогддог байна.

Энэхүү номын сан нь орчин үеийн хамгийн өндөр зэрэглэлийн техник тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон ба бүх материал нь дижитал хэлбэрээр байдаг байна. Номын сангийн фонд нь 400,000 гаруй түүхийн ховор баримт бичиг, ном болон архивын материалуудын электрон хувилбараас бүрддэг ажээ.

Соёлын гавъяат зүтгэлтэн, сэтгүүлч яруу найрагч Ц.Чимэддоржийн мэндэлсний 60 насны ойд зориулсан “Нууц товчооны морьд” номын нээлт, уран зургийн үзэсгэлэн, “Төгөлдөр найраг” эрдэм шинжилгээний бага хурал боллоо.

Гиннессийн дэлхийн амжилтууд 2016 номын нээлт боллоо.

2015 ОНД НОМЫН САНЧ-МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛАН ГАРГАСАН БҮТЭЭЛҮҮД

Монгол Улсын Үндэсний номын сан нь бусад номын санг мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг явуулдаг бөгөөд 2015 онд номын санчдад зориулан шинээр хэвлэн гаргасан гарын авлага, бүтээлүүдийг танилцуулж байна. Үүнд:







НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Цахим уншлагын танхимын тохижуулалт

Цахим уншлагын танхимыг эхлэлийг интернэтийн 5 ширхэг суурин компьютер, цахим сонин унших мэдрэгчтэй дэлгэцтэй 4 ш компьютер, өдөр тутмын 5 нэрийн сонингийн 1990 оноос хойшхи дугааруудыг сканнердсан цахим сантайгаар тавьсан. Тухайн үеийн өрөөний зохион байгуулалт зай багатай, тухгүй, гэрэлтүүлэг муу байсан тул өрөөнд засвар хийх шаардлага гарч захиргаанаас 725500 төгрөгийн зардлаар засвар үйлчилгээ хийж зай талбай бага эзлэх орчин үеийн шийдэл бүхий тавиур, хос буйданг хийж байрлуулсан. Мөн Мөнхийн үсэг ХХК-тай гэрээ байгуулж 100ш цахим ном бүхий 5 ширхэг төхөөрөмж байрлуулсан.

Дижитал танхимын үйл ажиллагааг албан ёсоор эхлүүлснээр Ерөнхийлөгчийн нэрэмжит эрдэм шинжилгээний танхимд үйлчлүүлэх эрх үүсдэггүй магистрантууд, оюутан судлаачдад зарим судалгааны ач холбогдол бүхий материалыг цахимаар үзүүлэх боломж бий болох юм. Тус танхимд wifi орчин, үнэгүй интернэт, гадаадын нээлттэй эрхийн мэдээллүүдийг ашиглах боломж, заавраар хангах, сонингийн мэдээллийн хялбар хайлт зэрэг уншигчдад хүрсэн таатай орчинг бүрдүүлж байна. Мөн Баруун Вашингтоны их сургуулийн номын сангийн шинээр хэрэгжүүлж эхэлсэн The research-writing studio буюу судалгааны ажил бичиж буй судлаачдад туслах төвийн үйлчилгээг өөрийн номын сангийн баялаг баазад түшиглэн явуулах боломж бүрдсэн.

Цаашид 1990 оноос өмнөх сонингийн цахим сан бүрдүүлэх ажлыг 2016 оноос эхлүүлнэ.

Вэб сайтын шинэчлэл





Вэб сайтыг хөгжүүлж сайжруулах, улмаар уншигчдад зориулсан Application зохиох ажлыг эхлүүлсэн. Шинэчилж буй загварт 16 төрлийн шинэчлэл, 25 модуль нэмэгдэж, үйлчилгээ, мэдээллийн цар хүрээ хэд дахин нэмэгдсэн. Тухайлбал, Монгол /кирил, монгол бичиг/, англи, орос хэл дээр

сонголт хийх боломжтой, номын хайлт, цахим номын булан, мэргэжил арга зүйн талбар г.м.

Олон Улсын “Коха” номын сангийн цогц программыг нэвтрүүлэх

Олон Улсын “Коха” номын сангийн цогц программыг нэвтрүүлэх ажил эрчимтэй хийгдэж байна. 10 үзүүлэлтээр тодорхойлогддог ном хэвлэл 1000 орчим үзүүлэлтээр тодорхойлогдохоос гадна дэлхийн аль ч улсаас Монголын Үндэсний номын сангийн



каталогт орж танилцах боломжтой болно.





Ухаалаг каноноор үйлчилж, хувцасны шүүгээ байрлуулах зэрэг техник технологийн дэвшлийг ашигласнаар боловсон хүчний оновчтой бодлого явуулах нөхцөл бүрдлээ.



Орчин үеийн тоног төхөөрөмж, тавилгаар тохижуулж, мэдээллийн самбар, хайлтын компьютерийг уншигчдад зориулан байрлууллаа.

Ховор ном, судар, гар бичмэл, нэг хувьтай ном, диссертацийг цахим хэлбэрт оруулж, техник хэрэгслийг бүрэн ашиглаж уншигч хэрэглэгчдэд үйлчилж байна.





Шинэ барилгын ажлын явцад комисс томилогдон хяналт тавьж ажиллаж байна.

Ажилтан, албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх зорилтот сургалтуудыг байнга явуулдаг. Тухайлбал:

Галын аюулгүй байдлыг хангах нь:



Bizhub ухаалаг хувилагч машины танилцуулга, хэрэглээ, зааварчилгаа

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ТАЙЛАН

Нэг. БОДЛОГЫН ЗОРИЛТ

1.1. Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон Эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтын биелэлт

Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2015 оны нийгэм эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд олон нийтэд мэдлэг олгох, мэдээллийг хүргэх, тэдэнд зориулсан соёл танин мэдэхүй, соён гэгээрүүлэх чиглэлийн ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:

Нэг. Агаар цэвэр Улаанбаатар:

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр: *“Агаар, хөрс болон орчны бохирдлыг бууруулах, усны эх үүсвэрийг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх”* заалтын хүрээнд төв болон салбар номын сангууд “Агаарын бохирдол бидний эрүүл мэндэд”, “Агаар хөрсний бохирдол”, “Хүүхэд – эрүүл ахуй”, “Орчны бохирдол хог хаягдал” сэдвүүдээр уншигч хэрэглэгчдийн дунд соёл танин мэдэхүйн ажил, мэдээлэл сурталчилгааны ажлуудыг зохион байгууллаа. Мөн дээрх ажлуудын хүрээнд номын үзэсгэлэн, зурагт хуудас, хэвлэмэл материалуудаар гарын авлага бэлтгэн тараалаа.

Хөрс болон орчны бохирдлыг бууруулах чиглэлээр: “Хөрсний бохирдол” лекц, “Хөрс-Орчны бохирдол” сэдэвт байнгын үзэсгэлэн, “Агаар-Хөрсний бохирдол”, “Орчны бохирдол - хог хаягдал”, “Хүүхэд-эрүүл ахуй” сэдвүүдээр мэдээллийн багц, 6 төрлийн 22 ширхэг боть ном, 18 ширхэг зурагт мэдээлэл, сэтгүүлийн хэвлэмэл материалаар мэдээллийн багц бэлтгэн 7 хоног тутам тогтмол мэдээлж уншигч үйлчлүүлэгчдэд сурталчилсан. Хүүхэд багачууд, хэрэглэгчдэд Эх дэлхий-Байгаль орчноо хайрлах хүмүүжил олгох үүднээс “Экологи” сэдэвт самбарын мэдээллийг тогтмол хугацаанд нь сольж хэрэглэгчдэд сурталчилсан.

Усны эх үүсвэрийг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр: ”Ус, агаар эрүүл амьдрал”, “Ус чандмань эрдэнэ” сэдэвт байнгын үзэсгэлэнг 12 ш боть номоор, ”Ус, агаар эрүүл амьдрал” цуврал мэдээллийг хийж сурталчилж байна. ”Дэлхий усны өдөр”-өөр

34ш боть ном, 2ш зурагт хуудас, 6ш хэвлэмэл материалаар үзэсгэлэн гаргаж хэрэглэгчдэд сурталчилсан.

Хоёр. Амины сууцтай Улаанбаатар:

*Гэр хорооллыг тохилог орон сууцны хороолол болгон хөгжүүлэх заалт*ын хүрээнд "Гэр хороолол-дахин төлөвлөлт" картын сан, "Амины орон сууц" ном сэтгүүлийн байнгын үзэсгэлэнг гаргаж уншигч үйлчлүүлэгчдэд сурталчлах ажлаа бүх салбар, төв номын сангийн хэмжээнд үргэлжлүүлэн хийж байна. "Гэр хорооллын дахин төлөвлөлт", "Ухаалаг төр" сэдэвчилсэн 5 нэр төрлийн тогтмол хэвлэлийг ашиглан 58 нийтлэл материалаар картын сангаа баяжууллаа. "Өрхийн санхүү-соёл амжилтын үндэс" сэдэвт уулзалтыг Улаанбаатар их сургуулийн ахлах багш Б.Оюунсүрэнтэй, "Зөв шийдвэр Гэрэлт ирээдүй" сэдэвт сургалтыг Америкт сургууль төгсөгчдийн холбоотой хамтран зохион байгуулсан.

Гурав. Ажил, орлоготой Улаанбаатар:

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл орлогын хүрээлцээгүй байдлыг бууруулах, орлого бий болгох үйл ажиллагаанд оролцуулах, оюутан залуучуудын зуны амралтаараа ажиллах, тэдэнд хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн хөдөлмөрийн харилцааны мэргэжилтэнтэй уулзалт зохион байгууллаа. Мөн төсөл хөтөлбөр, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн цагийн менежментийн талаарх номоор үзэсгэлэн гаргаж, дээрх сэдвүүдтэй холбоотой ном сэтгүүлээс түүвэрлэн гарын авлага, тараах материалуудыг хийж оюутан залуучууд, уншигчдад тараалаа.

Дөрөв. Аюулгүй, амгалан Улаанбаатар:

Иргэд, залуучууд, өсвөр үеийнхнийг архи, тамхи, мансуурлын хорт хэрэглээнээс татгалзах, урьдчилан сэргийлэх, нөлөөллийн үйл ажиллагааг соёл, урлагийн бүтээлээр дамжуулан хүргэх зорилтын хүрээнд:

- "Найрсаг Улаанбаатар", "Хотын соёл" хөтөлбөрийн хүрээнд байгууллагын "Үйлчилгээний стандарт" боловсруулж, үйлчилгээнд нэвтрүүлэн ажиллаж байна.
- Төв номын санд "Номтой орох уншлага"-ын танхим нээж, суудлын тоог 24-өөр нэмэгдүүллээ.
- Тамхины хяналтын тухай хуулийн хүрээнд "Номын сан-тамхигүй орчин", "Тамхины эсрэг хамтдаа", "Архигүй Тамхигүй –Ирээдүйн төлөө" байнгын үзэсгэлэн гаргаж,

иргэд олон нийтэд чиглэсэн соёл танин мэдэхүй, мэдээлэл сурталчилгааны ажлуудыг зохион байгууллаа.

- “Мансууралгүй ирээдүйн төлөө”, “Архи, тамхигүй өсвөр үе”, “Бид хорт зуршлаас татгалзаж байна”, “Тамхийг хаяснаар та хэр их мөнгө хэмнэх вэ” “Тамхи эрүүл мэндийг хордуулагч”, “Архи тамхигүй өсвөр үе” сэдвүүдээр мэдээлэл бэлтгэн хүргэж, уулзалтыг уншигчдын дунд 3 удаа зохион байгуулахад 93 уншигч хамрагдсан байна.
- Хар тамхи мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Хор хөнөөлийг бууруулах сүлжээний төв зэрэг байгууллагуудтай хамтран “Өнөөдөр тамхигүй өдөр” сэдэвт уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтаар хүний эрүүл мэнд, сэтгэцэд тамхи хэрхэн нөлөөлдөг тухай лекц уншиж, тамхидалт болон дам тамхидалтын хор уршгийг бууруулах талаар кино үзүүлж, ном болон хэвлэмэл материалаар сэдэвчилсэн үзэсгэлэн гаргасан. Үйл ажиллагаанд 42 иргэн хамрагдсан байна.
- “Улаанбаатарчууд уншиж байна” хөтөлбөрийг боловсруулж төв болон салбар номын сангуудын хэмжээнд номоор дамжуулан Улаанбаатарын иргэдийг соёлжуулах төрөл бүрийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж байна. Үүнд “Зугаатайуншлага”, “Бэлэгтэй уншлага” зэрэг аяныг зохион байгуулж, уншсан номтой нь холбогдуулан хүүхдүүдийн дунд уралдаан зохион байгуулж урамшууллаа. Мөн “Миний нийслэл хот”, “Хотын соёл”, “Улаанбаатарын эргэн тойронд”, “Уянгын Улаанбаатар” зэрэг соёл танин мэдэхүйн ажлуудыг зохион байгуулж дээрх сэдвүүдээр цуврал үзэсгэлэн, ном зүйн гарын авлага бэлтгэж уншигч хэрэглэгчдэд сурталчиллаа.
- 2015 оны “Улаанбаатарчууд уншиж байна” аяны хүрээнд Монгол Улсын Номын сангийн тухай хуулийг сурталчлах, фондын баяжилтыг сайжруулах үүднээс Нийслэлийн харъяа байгууллагуудын дунд “Ном хандивлах аян” зохион байгуулсан.

Тав. Авлигагүй Улаанбаатар:

Тухайн жилд шинээр гарсан хууль тогтоомжууд, Улсын Их хурал, Нийслэлийн Иргэдийн Хурлын тогтоолуудын эмхэтгэл болон бусад хуулийн ном товхимолуудаар номын үзэсгэлэн гаргаж уншигч хэрэглэгчдэд цаг тухай бүрт нь сурталчиллаа. Мөн МУИС-ийн ХЗС-ийн оюутнуудтай хамтарч Монгол Улсын хуулиудаас зарим заалтуудыг эмхэтгэн гарын авлага бэлтгэж 116-р сургуулийн багш, эцэг эхчүүдэд тараалаа. Мөн “Үндсэн хууль -23 жил”, “Ардчилал-авилга” сэдэвчилсэн үзэсгэлэн гаргалаа.

1.2. Архив, албан хэрэг хөтлөлт

1. Төлөвлөгөөний биелэлт: 2015 онд архив албан хэрэг хөтлөлтийн талаар дараах ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Улсын үзлэгт бэлдэх комисс 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр Захирлын 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/11 тоот тушаалаар батлагдаж, үзлэгт бэлтгэсэн. Үзлэгт бэлдэх 29 ажил бүхий тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан бөгөөд Нийслэлийн салбар комисст ажлаа шалгуулж Төрийн ажлын зохион байгуулалт 97.6%, Албан хэрэг хөтлөлт 96.4%, Байгууллагын архив 97.3%, Мэдээллийн технологи 96.3%, Дундаж үнэлгээгээрээ **96,7% “А”** үнэлэгдсэн.

Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/172 захирамжийн дагуу архивын өрөөнд шаардлагатай эйркондейшн, тоос сорогч, баримт устгагч, галын хор, галын самбар, хүрз, элсний хайрцаг зэрэг 1,014,300 төгрөгийн тоног төхөөрөмжөөр архивыг хангасан.

2014 оны баримтаар нөхөн бүрдүүлэлт хийх ажлыг Нөхөн бүрдүүлэлтийн хуваарийн дагуу хийлээ. ХХНЖ-ын дагуу 2014 оны Байнга хадгалах-24, 70 жил хадгалах-3, Түр хадгалах – 43, Гэрэл зургийн -4, Цахим баримт- 1, нийт **75 баримтаар** байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийж, данс бүртгэлийг үйлдэн ББНШК-ын хурлаар хэлэлцүүлэн баталсан.

2014 онд үүссэн гэрэл зургийн-4, цахим-5 /Тушаалын цахим хувь-1, архив, бичиг хэргийн эрхлэгчийн ажлын файл-4/, нийт 9 тусгай төрлийн баримтаар архивын сан хөмрөгийг баяжуулсан нь өмнөх онуудаас дэвшилттэй байна.

Байгууллагын “Албан хэрэг хөтлөлтийн журам”-ын хэрэгжилтийг хангах талаар гарын авлагыг хийж, ажиллагсдад тараан, журам танилцуулах сургалтыг нэгж тус бүрт 1, нийт 5 удаа Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэг дэх салбар номын сангууд гэх мэтээр тухайн ажлын байранд нь хүрч хийсэн нь ихээхэн үр дүнтэй, ажиллагсдын талархлыг хүлээсэн сургалт болсон.

Тайлант хугацаанд Архивын нэгдсэн сургалт 1 удаа, Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн сургалт 1 удаа, АХХ-ийн журам танилцуулах ажлын байрны сургалтыг 5 удаа, нийт 7 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Ажиллагсдын түвшин тогтоох сорилыг 2 удаа авч дүгнэн, дүнг Захиргааны хуралд танилцуулан, эргэн сургалт зохион байгуулах, нэгжийн дарга нарт үүрэг өгөх зэргээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан байна.

2. Өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлт:

Тайлант хугацаанд ирсэн 35 өргөдлийг 100 хувь барагдуулж ажилласан бөгөөд байгууллагын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 2 цаг 2 минут, өргөдөл гомдлын индекс 0,874 “А” үнэлгээтэй. Өргөдлийн индексээр нийслэлийн 196 байгууллагаас 21 дугаарт жагсаж байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа өнгөрсөн 2014 оныхтой харьцуулахад /2014 оны 6 хоног 15 цаг 47 минут/ 2 хоног 13 цаг 45 минутаар буурч, индекс /2014 оных 0,856/ 18-аар өссөн дүнтэй байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал тутам буюу 4 удаа гаргаж НЗДТГ-ын Иргэд хүлээн авах төвд хүргүүлж ажиллаа.

3. Хариутай бичгийн шийдвэрлэлт:

Энэ онд нийт 82 албан бичиг ирснээс хариу нэхсэн 40 албан бичигт бүртгэл хяналтын карт хөтлөн хяналт тавьж ажилласнаас 34 бичгийг хугацаанд нь шийдвэрлүүлж, 1 бичиг хугацаа хэтрүүлж, 2 бичиг хугацаа хэтэрч шийдвэрлэгдээгүй байна. Мөн 3 албан бичиг шийдвэрлэх хугацаагүй болоогүй хугацаандаа байна.

Хоёр. ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Уншлага үйлчилгээний талаар

Төв болон салбар номын сангийн хэмжээнд 2015 оны бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1.	Уншигч	23500	27237	115.90%
2.	Ирц	171000	287391	168.06%
3.	Ном олголт	427500	432845	101.25%

2015 оны уншлага үйлчилгээний төлөвлөгөөт үзүүлэлтүүд 101 -168 хувийн биелэлттэй байна. Үүнээс ном олголтын хэлбэрийг авч үзвэл нийт ном олголтын:

- Танхимаар үйлчлүүлэгсэд 88,3 хувь
- Зөөврийн үйлчилгээгээр 1.1 хувь
- Ном солилцоогоор 0.3 хувь
- Гэрээр ном олгохоор 10.3 хувийг тус тус эзэлж байна.



2010-2015 оны төлөвлөгөөт үзүүлэлтүүдийг харьцуулан харуулбал:

		2011		2012		2014		2015	
№	Үйлчилгээ нэр	Төлөв-лөгөө	Биелэлт	Төлөв-лөгөө	Биелэлт	Төлөв-лөгөө	Биелэлт	Төлөв-лөгөө	Биелэлт
1	Уншигч	60000	66309	60000	75581	29000	42933	23500	27237
2	Ирц	210000	230846	210000	210859	171000	191074	171000	287391
3	Ном олголт	585000	605286	585000	503617	427500	409137	427500	432845

Дээрх тоон үзүүлэлтээс үзэхэд “Номын сангийн орчин нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага” стандартад заасан үзүүлэлтээс 2012 оныг хүртэл уншигч 3 дахин их, ном олголт 2 дахин их байхаар төлөвлөн ажиллаж ирсэн. 2013 онд ЧД дэх салбар номын сангийн үйл ажиллагааг зогсоосон ба 2014 онд уншигч, ном олголт 1,5 дахин их, 2015 онд мөн уншигч 1,5 дахин их байхаар төлөвлөж ажилласан байна.

Өмнөх онуудад номын сангийн үйлчлүүлэгчийн 90% нь оюутан сурагчид байсан бол 2015 оны тоон үзүүлэлтийг өмнөх онуудтай харьцуулахад оюутан сурагчдийн эзлэх хувь 75%, иргэд 25% болж өссөн байна.

2.2. Фондын бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалтын талаар

2015 оны байдлаар 279 нэрийн 734 ширхэг 14,184,105 төгрөгийн шинэ, 49 нэрийн 49 ширхэг 306,000 төгрөгийн нөхөн бүрдүүлэлтийн, 219 нэрийн 880 ширхэг 8,637,200 төгрөгийн бэлэг хандивын ном авч фонд бүрдүүлэлт хийсэн. Ярьдаг номын

төвийн 45 нэрийн 525 ширхэг 837,000 төгрөгийн брайль ном, үндсэн фондон дахь 2080 ширхэг судар ном, АСМТ-ийн 191 нэрийн 202 ширхэг 214,400 төгрөгийн англи хэл дээрх номыг каталогжуулан тус тус техник ажиллагаа хийж, данс бүртгэлд бүртгэсэн байна .

Тогтмол хэвлэлийн захиалгыг чанартай хийж, дугаар ирэлт, хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж, эхний хагас жилд төвлөрсөн номын сангийн хэмжээнд 33 нэр төрлийн 3,217,504 төгрөгийн тогтмол болон цахим /4 нэрийн/ хэвлэл захиалан уншигчдад үйлчилж байна. Төвлөрсөн номын сангийн хэмжээнд 783 нэрийн 4470 номын мэдээллийг электрон каталогт оруулсан байна.

Хараагүй хүмүүст зориулсан DAISY төв: Харааны бэрхшээлтэй иргэдийн DAISY төвд 105 нэрийн 119 ширхэг цахим номыг CD, DVD дээр буулгаж, номын мэдээллийг каталогжуулахад бэлэн болгоод байна. Мөн харааны бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай, хүртээмжтэй програм хангамжаар үйлчилж, компьютерийн анхан болон дунд шатны ганцаарчилсан сургалт явуулж зөөврийн компьютер, ухаалаг гар утастайгаа ирж байгаа иргэдэд долоо хоног бүрийн мягмар гараг бүр интернетийн орчинд мэдээлэл олж авахад нь туслах үйлчилгээ үзүүлж, цахим ном тоглуулагчийг хэрхэн ажиллуулах, google орчуулагчийг хэрэглэх, skype facebook зэргээс мэдээлэл авах, ярьдаг програмыг ашиглан хэвлэмэл материалыг скайнердаж цахим файл болгон хадгалах зэрэг техник хэрэгслүүдийн хэрэглээний талаар зөвлөгөө өгч ажиллаж байна. “Хараагүй хүнтэй учирвал” гарын авлага бэлдэж, номын сангийн ажиллагсдад сургалт явуулж, МХҮХ-ийн дэргэдэх Нөхөн сэргээх сургалтын төвийн багш нар болон төгсөгчдийг урьж байгууллагын ажилчдыг алжаал тайлах массажид хамруулсан.

Хараааны бэрхшээлтэй иргэдийн брайль болон цахим номын сангийн үйлчилгээний танилцуулга бэлтгэж, албан ёсны www.facebook.com/bdalibrary facebook хуудсанд байршуулсан ба тайлангийн хугацаанд нийт 50 удаа мэдээлэл оруулж үйлчилгээний бүрэн танилцуулгыг шинэчилсэн.

50 нэрийн хүртээмжтэй цахим ном бүтээх төсөл нь БСШУЯ-аас дэмжигдэж 49 нэрийн номыг дижитал хэлбэрт оруулсан.

2015 оны гуравдугаар улиралд Япон улсын засгийн газраас бэлэглэсэн 2 брайль принтерийн нэгийг бүрэн ажиллагаанд оруулсан ба DAISY студийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор уншлагын танхимын 9 ширхэг BOOKSENSE цахим ном тоглуулагчийн болон MY STUDIO цахим ном бүтээгч програмын системийн шинэчлэлт хийж, OB програмыг шинээр нэвтрүүлсэн нь 3 өөр янзаар цахим номыг хүртээмжтэй хэлбэрт бүтээх боломжтой боллоо.



2015 оны 1 дүгээр улиралд МХҮХ-ны Брайль хэвлэлийн төвийн брайль принтерт Duxbury нэртэй шинэ брайлийн програм хангамж нэвтрүүлж, холбогдох заавар зөвлөгөөг нийт 10 гаруй удаа өгч шинээр ирсэн принтерт тохиргоо хийж өгсөн. 2015 оны 3 дугаар улиралд МХҮХ-ны дэргэдэх шинээр байгуулагдсан мэргэжил сургалтын үйлдвэрлэлийн төвийн 6 компьютерт монгол хэлний ярьдаг програм хангамж суулгаж үйлчилсэн.

2.3. Ном хэвлэл сэлбэн засах

Номын сангийн чөлөөт сонголттой уншлагын танхимын урагдаж гэмтсэн 614 номыг хэвлэлтийн анхны хэлбэр байдлыг алдагдуулахгүйгээр сэлбэн зассан ба бага гэмтэлтэй 1035 номыг номын санчид өөрсдөө сэлбэн зассан.

Төв номын сангийн тогтмол хэвлэлүүд болон санхүү, тасаг, салбаруудын баримтуудыг 308 нэгж болгон хавтасласан ба уншигчийн карт 6700 ширхэг, формуляр 3000 ширхэг хэвлэсэн.

Нийт 2261 ширхэг номонд техник ажиллагаа хийж, 1663 ширхэг номонд мэдрэгч ялтас нааж, нийт 783 нэрийн 4470 ширхэг номын мэдээллийг электрон каталогт оруулан, 2188 ширхэг баркод хэвлэсэн байна.

“Хамтдаа номоо эмчилье” аяны хүрээнд СУИС-ийн оюутнуудтай хамтран ном сэлбэн засах сургалтыг 2 удаа зохион байгуулсан ба төв болон салбар номын санд нийт 42 байгууллагын 100 гаруй хүнийг хамруулан 400 гаруй номыг сэлбэн зассан байна. Мөн салбар номын сангийн ХУТ-аар үйлчлүүлж буй сурагчдад “Номтой хэрхэн зөв харьцах номыг хайрлах” сэтгэлгээг төлөвшүүлэх зөвлөмж өгсөн.

2.4. Мэдээлэл, лавлагааны талаар

Тайлангийн хугацаанд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд номын сангийн лавлагааг нийт **13135** удаа өгсөн байна.



Хөдөлмөр хамгааллын ажилтны өдөрт, Цагаан сартай холбоотой номын жагсаалт, Daisy болгох номын жагсаалт, Шинэ үндсэн хууль батлагдсан өдөрт, Олон улсын гаальчдын өдөрт, Давсыг танин мэдье, Сүрьеэтэй тэмцэх өдөрт, Дорнод

аймагтай холбоотой номын жагсаалт, Цайтай холбоотой номын жагсаалт, Ховд хотыг чөлөөлсөн өдөр ба Ховд хоттой холбоотой номын жагсаалт, Төмөр замчдын өдөрт, "Өрхийн санхүүгийн боловсрол", "Хотын соёл", "Аюулгүй амгалан Улаанбаатар", “Агаарын бохирдол”, “Хөрсний бохирдол хог хаягдал”, “Усны бохирдол”, “Дэлхийн дулаарал”, “Интерьер дизайн”, ЮНЕСКО байгуулагдсан өдөр, Дэлхийн залуучуудын өдөр, Чихрийн шижинтэй тэмцэх өдөр, Хүчирхийллийн эсрэг олон улсын өдөрт, "Тамхи эрүүл мэндийг хордуулагч", "Уншихаа больвол сэтгэхээ болино", "Амины сууцаа тохилог болгоё" зэрэг сэдвээр номзүйн гарын авлагыг 75 удаа гаргаж сурталчилсан.

2.5. Соёл, танин мэдэхүйн ажлын талаар

Төв болон салбар номын сангуудын хэмжээнд соёл, танин мэдэхүйн ажлуудаа Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийн зорилтын дагуу төлөвлөн явуулахын зэрэгцээ өсвөр үе, залуучуудыг соён гэгээрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хэрэгцээтэй мэдлэг мэдээллээр хангахад чиглүүлэн явууллаа. Түүхэн ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулж нийт 404 үзэсгэлэн зохион байгуулснаас сэдэвчилсэн-330, шинэ номын-62, байнгын-12 үзэсгэлэн.

Тайлант хугацаанд уулзалт, лекц 157, уралдаан тэмцээн 19, чанга уншлага 130, сургалт 204 удаа зохион байгуулан явуулахад ойролцоогоор 20600 орчим оролцогчид хамрагдсан байна. Үүний заримаас дурдвал:

- “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг Улаанбаатар хотын нийтийн төв номын сан нь



төв болон салбар номын сангийн хэмжээнд 2015 оны 05 дугаар сарын 03-08-ны өдрүүдэд уншигч, олон нийтэд зориулж хэд хэдэн үйл ажиллагаа зохион байгуулсан. Үүнд: “УГЗ Төрийн зураач Ц.Ойдов, залуу зураач О.Андимана нарын “Чингис хаан ба Хөх Монгол” уран бичлэгийн үзэсгэлэн, Төв номын санд хадгалагдаж буй Соёлын баримтат өвийн мэдээлэл, Монгол түүхэн сурвалжийн үзэсгэлэн, , “Монгол бичиг,тод, соёмбо зэрэг бичиг үсгээр хэвлэгдсэн номын үзэсгэлэн болон “Би монгол бичигтэн”, “Уран бичлэг” сэдэвт ном хэвлэл, мэдээллийн үзэсгэлэнг гаргаж сурталчилсан. Төв болон салбар номын сангийн хэмжээнд “Монгол бичгийн үүсэл, хөгжил”, “Монголчуудын бичиг үсгийн түүх, тэдгээрийн онцлог, өнөөгийн хэрэглээ” зэрэг 5 уулзалт ярилцлага зохион байгуулсан.

- 2015 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр “Чингисийн талбай”-д зохион байгуулсан “Номын баяр”-ын арга хэмжээнд тус номын сангийн хамт олон сэдэвчилсэн номын үзэсгэлэн-3, мэдээлэл-6, зөвлөмж-2, санал асуулга-1 зохион байгуулсан. Тус арга хэмжээнд “Бид номын санчид хөтөлбөрт” өөрийн номын сангийн онцлог үйлчилгээ болон хараань бэрхшээлтэй иргэдийн “Ярьдаг номын сан”, “Америкийн соёл мэдээллийн төв”, Монгол Улсын “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хуулийг сурталчилж ажилласан. “Ном” хөтөлбөрийн хүрээнд Төв болон салбар номын санд нийтдээ уулзалт-7, чанга уншлага-3, номын сэдэвчилсэн үзэсгэлэн-16, мэдээлэл-7, зөвлөмж-3, уралдаан тэмцээн-2, санал асуулга-2 явуулж дүнг нэгтгэсэн.
- "Улаанбаатарчууд уншиж байна” тусгай төлөвлөгөөний дагуу ”Миний нийслэл хот”, “Улаанбаатарын түүхээс” сэдэвт цуврал үзэсгэлэнг 24 ширхэг ном, 9 ширхэг хэвлэмэл материалаар “Уянгын Улаанбаатар”,“Улаанбаатарын эргэн тойронд” сэдэвт дуу, шүлэг, ном зохиолд санамж өгөх ном зүйн гарын авлагыг уг сэдвийн дагуу 15 номын товч агуулгатай нь боловсруулан уншигч, хэрэглэгчдэд сурталчилсан. “Улаанбаатарчууд уншиж байна” ном хандивлах аяны хүрээнд 8348 ном ирснээс Мэдээлэл боловсруулалт автоматжуулалтын тасагт хэрэгцээтэй 4000 номыг шилжүүлж, үлдсэн 4348 номоос Хотын төв номын сангийн лавлагааны хэсэгт орон нутгийн фонд/350/, Чингилтэй дүүргийн хүүхдийн номын ордон/525/, Хан-Уул дүүргийн насан туршийн боловсролын төв /432/, Лос Анжелес хот руу/500/, Сүхбаатар дүүргийн насан туршийн боловсролын төвд/500/ тус тус өгөхөөр бэлтгээд байна. Үлдсэн 2307 номыг шинээр байгуулагдаж буй уншлагын газрууд болон хотын номын сангийн нүүдлийн номын сангийн фондод авч, алслагдсан дүүрэг, хорооны иргэдэд үйлчилгээ үзүүлэхээр болоод байна.

- Жүжигчин Л.Нурбулантай “Хүүхэд насны дурсамж”, хүүхдийн зохиолч Ж.Батноов харааны бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн сурагчидтай, О.Сундуйтай “Соёмбо сургуулийн 4-р ангийнхан, МУИС-ийн багш Р.Цолмон, Бэгзсүрэн нар “Од гараг орчлон ертөнцийн сүүлийн үеийн мэдээлэл”, 2-р сургуулийн багш Должинсүрэн “Шинэ жил ирлээ”, СУИС-ийн багш Д.Индра “Яруу найраг бол сэтгэлийн хөгжим”, хорооны нийгмийн ажилтан Д.Одонтуул “Мансууралгүй ирээдүйн төлөө”, ТББ-ын ажилтан Баясгалан “Архи тамхигүй ирээдүйн төлөө”, инженер Х.Пүрэвдагва “Дэлхийн дулаарал”, ТТДС-ийн багш Б.Должинсүрэн, ахмад багш С.Цэнгэл нар “Монгол бичгийн үүсэл хөгжил”, БСШУЯ-ны ажилтан Б.Батсүх “Мэргэжлээ сонгох нь”, УЗНАДС-тай хамтран “Ном бол ертөнцийг харах цонх мөн”, УБИС-ийн багш Б.Оюунсүрэн “Өрхийн санхүү-соёл амжилтын үндэс”, СХД-ийн хөдөлмөрийн харилцааны мэргэжилтэн Ш.Адъяасүрэн “Төсөл хөтөлбөр, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн тухай”, Төрийн банкны мэргэжилтэн О.Уянга “Оюутны багц болон хуримтлалын хадгаламж”, Сурган хүмүүжүүлэх ухааны доктор С.Дамба “Хүний ёс суртахуун-зан заншил” сэдэвт

уулзалтуудыг тус тус төв болон салбар номын санд зохион байгуулсан.

- Астрид Линдгрений мэндэлсний 108 жилийн ойг тохиолдуулан гар зураг, зохион бичлэгийн уралдаан, зохиолчийн уран бүтээлийн үзэсгэлэн, “Дээвэр дээр суудаг Карлсон” болон “Эмиль хүүгийн адал явдал” зохиолоор дүрийн тоглолт зэргийг хийж, МҮОНТ-ийн Соёл эрдэм нэвтрүүлгээр

сурталчилсан.

- Англи хэл, япон хэл, илтгэх урлаг, мэтгэлцээн, компьютерийн ба онлайн сургалт, тэргэнцэртэй иргэдэд зориулсан англи хэл, номын санчдын англи хэл зэрэг сургалт, хүүхдэд зориулсан тоглоомын өдөр, кино үдэш, 4H зэрэг 300 гаруй хөтөлбөрүүд Ярьдаг

номын сан болон Хөтөлбөрийн танхимд хийгдсэн.

- “Монгол бичгээр хэн сайн бичих вэ” сайхан бичгийн, “Хотын соёл биднээс эхэлнэ” гар зургийн, “Ном миний сайн нөхөр” зохион бичлэгийн уралдаан болон “Босоо монгол бичиг бидний бахархал”, “Номтой нөхөрлөсөн хүүхэд нас” сэдэвт АХА зэрэг тэмцээнийг тус тус зохион байгуулсан.
- О.Сундуй “Үнэг” өгүүллэг, “Сургамжит өгүүллэг-1” номоор, “Эвтэй 4 амьтан”, “Муур багш”, “Ухаант туулай” үлгэрээр, “Хөгжилтэй Өүжин дэлдэн хоёр”, Роберт Манчын "Ямар нэгэн гоё юм" зохиолоор, “Үлгэрийн цаг”, “Сургамжит өгүүллэг-2”, "Солигдсон хүүхэд", "Цондоолой, Цүндээлэй хоёр", "Өөрөөрөө байх шиг сайхан зүйл үгүй" зэрэг чанга уншлагыг монгол, англи хэлээр 130 гаруй удаа зохион байгуулж нийт 366 оролцогч хамрагдсан.

2.6. Интернет мэдээллийн үйлчилгээ

Автоматжуулалтын програм хангамжийн талаар

Тайлангийн хугацаанд суурин интернэтийг 35089 хэрэглэгч, утасгүй интернэтийг 4572 хэрэглэгч ашиглаж, нийт 39661 хэрэглэгчид интернетийн үнэгүй үйлчилгээ үзүүлсэн. Төв болон салбар номын сангуудын интернет үйлчилгээ хэвийн жигд явагдаж байна.

Үндсэн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд интернэтийн татаж /download/ байгаа хурд хамгийн ихдээ 90.26 Mbps, дунджаар 2,07 Mbps, түгээж /upload/ байгаа хурд хамгийн ихдээ 85,56 Mbps, дунджаар 1,17 Mbps хүрсэн байна.



Утасгүй интернэтийн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд интернэтийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 58,13 Mbps, дунджаар 1,08 Kbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 10,10 Mbps, дунджаар 94,54 Kbps хүрсэн байна.



КОХА програм: Тайлангийн хугацаанд КОХА програм дээр төлбөр тооцооны системийг бүрэн ажиллуулахаар удаа дараа туршилт хийсний үндсэн дээр Ординат ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд КОХА програм дээрх төлбөр тооцооны системийг бүрэн ашигладаг болж байна. Мөн номын татгалзлын бүртгэлийг КОХА програм дээр туршиж, холбогдох сургалтыг зохион байгуулан, гарын авлагыг гаргасан. Төв болон салбаруудын номын санч нарын ном каталогжуулсан статистик мэдээг гаргасан.

http://koha.pl.ub.gov.mn/ онлайн каталогт төв, салбар номын сангийн номын санчид 799 ширхэг номын мэдээллийг засаж, редактор хийсэн үзүүлэлттэй байна.



Цахим хуудас: Нийслэлийн мэдээллийн технологийн газрын серверт байрласан Хотын Төв Номын Сангийн вэб http://www.pl.ub.gov.mn -ийн агуулгыг шинэлэг байлгахад анхаарч ажилласан. Google Analytics програмын тусламжтайгаар вэбийн хэрэглээний үзүүлэлтийг 2015 оны оны 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 20-ний өдрийг хүртэлх хугацаанд тайлан гаргахад 39083 хэрэглэгч зочилж /visits/, 100625 хуудасны мэдээллийг үзжээ.

Онлайн каталог: http://koha.pl.ub.gov.mn -ийг Google Analytics тусламжтайгаар каталогт мэдээлэл хайж байгаа үзүүлэлт 2015 оны оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 20-ний өдрийг хүртэлх хугацаанд 124 934 хэрэглэгч зочилж /visits/ , 436 990 хуудасны мэдээллийг үзжээ.



Гурав. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

Тус номын сангаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ, уншигчаар бүртгүүлэх, гэрээр ном авахад шаардлагатай баримт бичиг, ажлын цагийн хуваарь, үйлчилгээний журам, дотоод журам, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэсэн тайлан мэдээ зэрэг холбогдох мэдээ, мэдээллийг www.pl.ub.gov.mn цахим хуудсаар мэдээлсэн.

Мөн байгууллагын үйл ажиллагааг ил тод мэдээлэх зорилгоор Төв болон салбар номын сангуудад “Нээлттэй мэдээлэл” самбарыг ажиллуулж, төлөвлөгөө, тайлан, дүрэм, журам, шинэ номын мэдээллүүдийг байршуулан сурталчилдаг.

3.2. Хүний нөөцийн ил тод байдал

Тайлангийн хугацаанд тус номын санд ажилтан авах зар болон номын сангийн хүний нөөцтэй холбоотой 13 мэдээллийг вэб хуудсанд байршуулсан ба мэдээллийн самбарт 3 удаа шинэчлэн байршуулж сонгон шалгаруулалтанд тэнцэж шаардлага хангасан ажил горилогчоор сул орон тоог нөхөн ажиллуулж байна.

Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Үйлчилгээний стандарт болон Улаанбаатар хотын нийтийн номын сангийн номын санчдын ёс зүйн дүрмийг номын сангийн цахим хуудас болон нээлттэй мэдээллийн самбарт байршуулсан.

Нийслэлийн нэгдсэн лавлагаа ub1234.mn цахим хуудаст байгууллагын хүний нөөцийн мэдээлэл шинэчилж ажиллаж байна.

3.3. Мэдээллийн ил тод байдал

Иргэдэд мэдээллийг ил тод, шуурхай хүргэх ажлын хүрээнд твиттерт 733 /байгууллагын твиттер 657, Америкийн соёл мэдээллийн төвийн твиттер-651/ жиргээ илгээгдэж, 441 дагагчтай, фейсбүүк хуудас 4868+23463 /байгууллагын-4868, АСМТ-5949, ХУД дэх салбар-517/ дэмжигчтэйгээр нийгмийн сүлжээгээр мэдээллийг түгээж байна.

www.pl.ub.gov.mn байгууллагын цахим хуудасны хэрэглээний үзүүлэлтийг Google Analytics програмын тусламжтайгаар тайлант хугацаагаар гаргахад 39083 хэрэглэгч зочилж /visits/, 100625 хуудасны мэдээллийг үзжээ.

Нийслэлийн мэдээллийн технологийн газраас өгсөн заавар журмын дагуу www.ulaanbaatar.mn цахим хуудсанд байршуулах байгууллагын танилцуулга, фото зураг зэрэг бусад холбогдох мэдээллийг бэлтгэн хүргүүлж ажилласан.

3.4. Төсөв, санхүүгийн ил тод байдал

Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад журмын дагуу төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах зорилгоор 2014 оны жилийн эцсийн тайлан, 2015 оны батлагдсан төсөв, төсвийн хуваарийг төв болон салбар номын сангуудын нийт ажиллагсдад дэлгэрэнгүй танилцуулж, номын сангийн дотоод сүлжээ болон байгууллагын вэб хуудсанд тавьж ил тод болголоо. 2014 оны санхүүгийн тайлан аудитаар зөрчилгүй стандарт дүгнэлттэй гарсан. Төсвийг үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулах, урсгал зардлыг хэмнэх үүднээс дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:

1. Байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх зарим зардлыг санхүүжүүлэх үүднээс өөрийн үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх зорилгоор зарим төлбөрт үйлчилгээний үнэ тарифыг өөрчилсөн.
2. Байгууллагын бүтэц орон тоо, чиг үүргийг хянан үзэж орон тоог нэмэгдүүлэхгүй байх үүднээс хүүхдээ асарч байгаа, өвчтэй, чөлөөтэй байгаа ажилтны оронд шинээр хүн томилохгүйгээр ажиллагсдын ажлын ачааллыг нягтруулан ажиллаж байна. Орон тоо бүтцийн хэмнэлтийг ажлын ачаалал, чанар хүртээмжийг бууруулахгүйгээр зөв оновчтой зохион байгуулах ажлыг үргэлжлүүлж байна.
3. 2015 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн Шилэн дансны тухай хууль болон түүнтэй холбогдон гарсан заавар, журам, захирамжийн дагуу төсөв санхүүгийн бүхий л мэдээллийг сар бүрийн 05-ны дотор болон гүйлгээ хийсэн тухай бүртээ Шилэн дансны нэгдсэн болон байгууллагын Шилэн данс цэсэнд байршуулж байна.

4. 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийт ажиллагсдын албаны хувцас болон энгэрийн тэмдэг, ажлын үнэмлэх шинэчлэх ажил төсвийн хүрэлцээ хангамж муугаас шалтгаалж хийгдэж чадахгүйд хүрсэн боловч, ажиллагсад өөрсдийн санаачлагаар албаны хувцас, ажлын үнэмлэхийг хувиасаа хийлгэсэн.
5. Суурин утаснуудын картын лимитийг багасгаж 10000 төгрөгөөс хэтрүүлэхгүйгээр хэрэглэж байна.
6. Цэвэрлэгээний болон хэвлэх, сэлбэн засах материалын хэрэглээ, орц нормативт байнга хяналт тавьж ажиллаж байна.
7. Ус, цахилгааны тоолуурын заалтад хяналт тавьж, хэрэглээг багасган ажилласан.
8. Бүрдүүлэлтээр худалдан авч байгаа номонд зөвшөөрлийн хуудсыг бөглүүлж, үнийг хэвлэлийн өртгөөр тооцон авснаар номын төсвийг 10%-иар хэмнэсэн.

3.5. Ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар

Ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, амжиргааны түвшинг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах зорилгоор 2015 оны байгууллагын үйл ажиллагаанд тусгагдсан болон Хамтын гэрээний дагуу олгогдох тэтгэмжийг цаг тухай бүрт нь олгож ажилласан.

2015 онд ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдэрлэхэд нийтдээ 40,919,811 төгрөг зарцуулжээ. Нийт ажиллагсдын 34,8% буюу 30 хүнд ур чадварын нэмэгдэл олгож, мөн 6 ажилтны цалингийн шатлалыг ахиуллаа.

Тэтгэвэрт гарсан үйлчилгээний 1 ажилтанд гурван сарын үндсэн цалинтай тэнцэх 1,300,000 төгрөгийн, нэг хүнд Соёлын тухай хуулийн дагуу 12 сарын цалинтай тэнцэх хэмжээний буюу 9,900,000 төгрөгийн, 50 нас хүрсэн 5 ажилтанд 400,000 төгрөгийн тэтгэмж болон, удаан хугацаагаар эмчилгээ хийлгэж байгаа нэг ахмадад 250,000 төгрөгийн буцалтгүй тусламжийг тус тус олгосон. Шинэ байранд орсон 3 хүнд 600,000 төгрөгийн урамшуулал, 70 нас хүрсэн 3 ахмадад 210,000 төгрөгийн урамшуулал олгов.

Гэр хороололд амьдардаг 8 ажилтанд түлээ нүүрсний хөнгөлтөнд 2,000,000 төгрөг, төрсөн нутагтаа амраад ирсэн 3 ажилтанд ирэх, очих замын зардал 194,000 төгрөг, гэр бүлд нь гачигдал тохиолдсон 10 ажилтанд 4,700,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж тус тус олголоо.

Нийт ажиллагсдын дунд зохион байгуулсан цасны баярт 1,500,000 төгрөг, Эх үрсийн баярыг тохиолдуулан байгууллагын 42 ажилтны 0-16 насны 59 хүүхдэд 740,000 төгрөг, Соёл урлагийн ажилтны баярын өдрийг тэмдэглэн 4,015,000 төгрөг, Ахмадын өдрөөр байгууллагын 52 ахмадыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэхэд 4,500,000 төгрөг зарцуулсан.

Улаанбаатар их сургуулиас номын санчдын дунд зохион байгуулсан спортын тэмцээн уралдаанд байгууллагын баг тамирчдыг оролцуулахад 1,399,000 төгрөг, Залуучуудын зөвлөлөөс зохион байгуулсан дугуйтай майхантай аяллыг дэмжиж 200,000 олгожээ.

Төв болон салбар номын сангуудын номын санч нарт гэрээр ном олгох үйлчилгээний хураамжийн орлогоос сар бүр номын санчдад орлогын дүнгийн 30 хувиар бодож 9,011,811 төгрөгийн урамшуулал олгосон.

3.6. Ажилтан, албан хаагчдын мэргэжил дээшлүүлэлт, ажлын байрны сургалтын талаар

“Хүний нөөцийн хөгжил” дэд хөтөлбөр боловсруулан ажилласан ба 2015 онд ажилтан бүрийн мэдлэг чадварыг дээшлүүлэх үүднээс Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт 7, номын санчдын дунд мэргэжлийн сургалт 4, үйлчилгээний стандартын талаар сургалт 1, бусад сургалтыг 15, нийт 27 удаагийн сургалтыг зохион байгуулаад байна. Үүнд:

- ❖ Номын сантай хамтын ажиллагаатай АНУ-ын элч сайдын яам, Америкийн Монгол судлалын төвөөс номын сангийн ажилчид болон их дээд сургууль, нийтийн номын сангийн номын санчдад Англи хэлний ярианы сургалт /Элизабет Күүк Фулбрайт хөтөлбөрийн англи хэлний туслах багш/, Америкийн номын сангуудын өнөөгийн төрх, чиг хандлага /Бээжин дэх Мэдээлэл лавлагааны төвийн бүс хариуцсан дарга Пэг Вольтер/ зэрэг сэдвээр сургалт явуулсан.
- ❖ Номын санч Б.Баярцогт АНУ, Австри улсад, Б.Шүрэнбагана Ц.Байгалмаа Филиппин улсад, Л.Гантулга Турк болон АНУ-д, Г.Наранцэцэг ОХУ-д тус тус номын сангийн чиглэлээр зохиогдсон хурал болон сургалт семинарт оролцоод ирсэн тухай тайлангаа ажилтнуудад танилцуулсан.
- ❖ Улаанбаатар хотын төв номын сан, Америкийн Монгол судлалын төвтэй хамтран ажилчдын дунд зохион байгуулсан Англи хэлний анхан шатны ярианы 6 удаагийн

сургалтанд 32 хүн оролцсон. Сургалтыг Фульбрайтын тэтгэлгийн туслах багш Элизабет Күүк явуулсан. Мөн СХД-ийн салбар номын сангийн номын санчдад номын санч Б.Баярцогт "Хөтөлбөр хэрхэн зохион байгуулах тухай" сургалтыг явуулсан. Мэдээллийн ажилтан Л.Гантулга Коха програмын татгалзлын бүртгэлийн талаар холбогдох сургалтыг хийсэн.

❖ "Хөдөлмөрийн харилцаа, Олон улсын конвенц" /МААХҮЭХорооны дарга М.Алтанцэцэг/, "Эмнэлгийн анхны тусламж" /Этүгэн дээд сургуулийн багш/, Харилцааны соёл /МУБИС н.Хишиг-Ундрах/, Байгууллагын харилцаа /Ганабелл интитутын сургагч багш Т.Амар/, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэрхэн үйлчлэх /М.Цэнгэл/, Номын санчийн ёсзүй /Г.Наранцэцэг/, Үйлчилгээний стандартын танилцуулга /Э.Тайванжаргал/ зэрэг сэдэвт сургалтанд бүх ажиллагсдыг хамруулсан.

Дөрөв. ШИНЭ САНААЧЛАГА, ҮР ДҮН

1. ***Өсвөр насны болон оюутан залуусын дунд "Сэтгэлзүйн клуб" ажиллуулах.***

2015 оны нэг сараас эхлэн "СЭТГЭЛ ЗҮЙ"-н клуб ажиллуулж " Өөрийгөө танин мэдэх нь", "Бусдыг сонсож сурах нь", "Бодлоо удирдах нь", "Бусдад өөрийгөө илэрхийлэх нь", "Стресс, уур бухимдлаа өөрөө зохицуулж сурах нь" сэдвүүдийн дор 18 удаагийн хичээлээр 216 хүнийг сургалтанд хамруулаад байна. Салбар номын санд оюутан сурагчдын хэрэгцээнд нийцүүлэх зорилгоор, хоёр өрөөг тохижуулан "Багаар ажиллах танхим" –ыг нээн ажиллуулж байна.

2. ***"Урамшуулалтай уншлага" үйлчилгээнд нэвтрүүлэх***

Баянзүрх дүүрэг дэх салбарын "Хүүхдийн уншлагын танхим"-д "Д.Нацагдоржийн нэрэмжит уншлага" зохион байгуулж олон ном уншсан уншигчдад "Урамшууллын купон"-гэрээр ном үнэгүй унших эрх олгож байна. "Гэр бүлийг уншлага" картын системд 36 гэрийн 121 хүн хамрагдав. "Бэлэгтэй уншлага" хүүхдүүдийг номтой нөхөрлүүлж уншсан номын тэмдэглэл хөтлөн, уншсан номтойгоо холбогдуулж олон бүтээлч ажил хийсэн. 27 хүүхдээс 52 дугаар сургуулийн 5-в анги сурагч В.Ганзоригийн бүтээл шалгарч тэргүүлсэн.

3. Номын татгалзлын бүртгэлийг Коха програмд нэвтрүүлж, холбогдох сургалт, гарын авлагыг зохион байгуулах

Ном татгалзлын бүртгэлийг КОХА програм дээр туршиж, холбогдох сургалтыг зохион байгуулан, гарын авлагыг гаргасан.

4. Харааны бэрхшээлтэй иргэдийн брайль болон цахим номын сангийн үйлчилгээний албан ёсны facebook хуудсыг нээн хөтөлж, олон нийтэд үйл ажиллагааны мэдээллийг хүргэх

Харааны бэрхшээлтэй иргэдийн брайль болон цахим номын сангийн үйлчилгээний www.facebook.com/bdalibrary фэйсбоок хуудсыг нээн хөтлөж 2015 онд нийт 50 мэдээлэл нийтэлж олон нийтэд хүргэсэн ба нийт 306 like-тайгаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага үйлчилгээнүүдийн дотор өндөр хандалттай байна.

5. Үйл ажиллагаа нь тогтмолжсон олон нийтийн номын 1-2 клубтэй холбоо тогтоож хамтран ажиллах

Номонд шимтэгчдийн клубтэй хамтран "Хамтдаа номоо эмчилье" аянг зохион байгуулж 42 байгууллагын 100 гаруй хүн уг аянд нэгдэж, 400 гаруй номыг сэлбэн зассан. Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн дэргэдэх “Миний ном” нэртэй оюутны клубтэй хамтарсан үйл ажиллагаанд 50 хүн оролцсон болно. АНОМ болон Bookclub гэсэн 2 номын клубтэй хамтарч 4 удаагийн уулзалтаар “Ваня ах”, “Алтан цонх”, “Гэм зэм”, “Дракула” 4 зохиол хэлэлцсэн ба 46 хүүхэд хамрагдсан байна.

6. *Төв болон салбар номын санд уншлага үйлчилгээний танхим нэмж, уншигчдын суудлын тоог нэмэгдүүлэх*

Төв номын санд 2014 онд 200 гаруй уншигчдын дунд явуулсан санал хүсэлтэд 70 гаруй хувь нь номын санд өөрийн номтой орж үйлчлүүлэх хүсэлтэй байсан. Үүний үндсэн дээр 2015 оны 09 дүгээр сард 24 суудал бүхий “Хувийн номтой орох уншлагын танхим” нээн ажиллуулж байна.

Тав. ХЭРЭГЛЭГЧДИЙН ҮНЭЛГЭЭ

Улаанбаатар хотын төв номын сан 2015 онд уншигч, хэрэглэгчдийн дунд хэд хэдэн санал асуулга явуулсан. Үүнд: “Үндэсний бичиг соёлын өдөр”, "Монгол бичгийн хэрэглээ, өнөөгийн байдлын тухай", “Үндэсний номын баяр”, "Номын сангийн үйлчилгээний тухай", “Цахим сонин уншлага үйлчилгээний тухай”, “Сонин уншлага үйлчилгээний тухай”, “Номын сангийн орчин, үйлчилгээ” зэрэг болно. Мөн санал асуулгыг нэг сэдвийг дагнасан цөөхөн оновчтой асуултуудаас бүрдсэн, зарим үйлчилгээг үнэлж дүгнүүлэх, шүүмжлэлтэй байр сууринаас хандах боломжийг олгосон байдлаар явуулж ирлээ. Цахим санал асуулгын үр дүн:

Санал асуулга бүрийн талаар дор товч дурдвал:

1. "Номын сангийн үйлчилгээ" сэдэвт санал асуулгыг уншигчийн дунд 5 асуулттайгаар явуулсан байна. Судалгаанд 18-45 насны 29 эмэгтэй, 11 эрэгтэй оролцсон байна. Оролцогчдын 95,1% нь үйлчилгээг сайн гэж үнэлсэн бол 4,8% нь дунд зэрэг, 0,1% нь хангалтгүй гэж үзсэн байна. Уншигч ихэвчлэн уншлагын танхим, гэрээр ном авахаар ирдэг бөгөөд номын сангийн үйлчилгээ хөнгөн шуурхай хэрэглэгчийн хувьд хүлээлт бага байдгийг энэхүү судалгааны дүн харуулсан юм.

2. "Хамтдаа номоо эмчилье" сэдэвт аяны үйл ажиллагаанд оролцсон 35 хүний дунд санал асуулга явуулсан. Судалгаанд нийт оролцогчид 100% арга хэмжээ зохион байгуулсанд талархал илэрхийлээд цаашид уламжлал болгон зохион байгуулахыг санал болгосон.

3. "Монгол бичгийн хэрэглээ" санал асуулгыг 40 уншигчийн дунд зохион байгууллаа. Мөн уг арга хэмжээний хүрээнд оролцогчдын хүрээнд " Монгол бичиг: Түүх, хэрэглээ" сэдэвт 5 асуулт бүхий санал асуулгыг явуулж дүнг гаргав. Оролцогчдын 0,3% нь монгол бичгийг сайн мэднэ, 0,3% нь огт мэдэхгүй, харин 99,4% дунд зэрэг мэднэ гэж хариулсан байна. Албан ёсны хэрэглээ бага тул амархан мартагддаг, албан хэрэглээг нэмэгдүүлэх нь чухал гэж гэж 100% хариулсан байна. Мөн монгол бичгийн гайхамшиг бол босоо хувь заяа, үндэсний бахархал гэсэн байна.

4. "Номын баяр"-ын өдрөөр уншигчдын дунд уран зохиолын номын ач холбогдол, их уншдаг, сүүлийн үед хүүхэд залуучуудын сонирхон уншиж буй номыг тодруулах зорилгоор 5 асуулт бүхий санал асуулга авсан ба энэ судалгаагаар хамгийн их уншигдсан зохиолууд:

- Ц.Оюунгэрэл “Ногоон нүдэн лам” /2008/, “Анна Франкийн өдрийн тэмдэглэл” /1982/
- Б.Сарантуяа “Сорхугтани” /2013/, Ж.Пүрэв “Усны гудамж” /1990/

5. Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн уншлага үйлчилгээ болон ажиллагсдын зан харьцааны талаар 5 асуулт бүхий судалгааг төв болон салбар номын сангийн бүх уншигчдийн дунд явуулсан бөгөөд энэ судалгаагаар номын сангийн үйлчилгээний орчин болон номын санч, үйлчилгээний ажилчдын уншигчидтай харьцах харьцааны тухай судалгаанд оролцогчдын 88% нь сайн, 9% нь дунд, 3% нь муу гэж үнэлсэн байна.

Судалгааны мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ:

1. Тасаг салбарын эрхлэгч нар салбар номын сангийн онцлог болон зохих төсөвт тохируулан уншигчдын онцлогт нийцүүлэн худалдан авах номын саналыг авч ном бүрдүүлэлтийг хийж байна. 2015 онд нийт 2361 ном шинээр бүрдүүлэн авсан. Мөн татгалзлын дэвтэрт бичигдсэн номын жагсаалтыг ном бүрдүүлэгчид гаргасан.
2. Төв болон салбар номын сангуудын интернет үйлчилгээ хэвийн жигд явагдаж байна. Тайлангийн хугацаанд суурин интернэтийг 35089 хэрэглэгч, утасгүй интернэтийг 4572 хэрэглэгч ашиглаж, нийт 39661 хэрэглэгчид интернетийн үнэгүй үйлчилгээ үзүүлсэн байна.
3. Коха програмд 2014-2015 оны турш нийт 118092 ном электрон катологт оруулсан ба хэрэглэгч уншигчдад электрон каталог ашиглах арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч ажилладаг.
4. Номын сангийн үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хянах зорилгоор 2015 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл өөрийн байгууллагын дотор Үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх сарын аяныг зохион байгуулж, “Үйлчилгээний соёл” сэдэвт бүтэн өдрийн сургалтанд нийт ажиллагсдыг хамруулсан.
5. Төв болон салбар номын сангийн уншлагын танхимуудад санал хүсэлтийн хайрцагийг тавьж ажиллуулж байгаа ба санал хүсэлтийн дэвтрээр 115 уншигч санал хүсэлтээ бичиж уламжилсаныг тухай бүрт нь шийдвэрлэж ажилласан.

ТАЙЛАНД ӨГӨХ ҮНЭЛГЭЭ

2015 онд 79 ажил үйлчилгээ хийхээр төлөвлөснөөс 73 нь 90-130%-ийн гүйцэтгэлтэй хийгдсэн бол 6 ажил нь төсөв хөрөнгийн хүндрэлээс шалтгаалан хийгдээгүй бөгөөд нийт 94.44%-ийн биелэлттэй байна. Хийгдээгүй 6 ажил нь:

1. Төв болон салбар номын сангуудын фондын тоосжилтыг бууруулах эрүүл аюулгүй үйлчилгээний орчинг бүрдүүлэх зорилгоор чийгшүүлэгч, тоос сорогч авахаар төлөвлөж байсан боловч холбогдох төсөв хасагдсан тул энэ ажил хийгдээгүй.

2. А.М.Горькийн нэрэмжит Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сангийн засварын ажлыг шийдвэрлүүлэхээр НЗДТГ-ын газар, НСУГ, ЧД-ийн тамгын газар гэх мэт холбогдох байгууллагуудад засварын ажлын төсөв, бусад бичиг баримтуудыг албан тоотоор удаа дараа хүргүүлсэн боловч шийдэгдээгүй байна.

3. БЗДүүргийн салбар номын сангийн байрны өргөтгөлийн асуудлаар тус дүүргийн Засаг дарга болон холбогдох хүмүүстэй уулзаж өргөтгөлийн зураг төсвийг хийлгэх тухай танилцуулан шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

5. БЗД-ийн салбар номын санд урсгал засвар хийх ажил төсвийн хүндрэлээс шалтгаалж хийгдээгүй.

6. Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан чиглүүлэгч хаяг болон гадаа хаяг төсөв хөрөнгийн хүрэлцээгүйгээс болж түр хойшлогдсон.

Цаашид анхаарах шаардлагатай дараах чухал асуудлууд байна. Үүнд:

1. Жил ирэх тусам буурч байгаа номын сангийн уншигч хэрэглэгч, ном олголтын тоог нэмэгдүүлэх үүднээс номын сангийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амд зөөврийн болон нүүдлийн номын сангийн үйлчилгээг өргөжүүлэн хүргэх, үйлчилгээг явуулах авто машины асуудлыг шийдвэрлэх

2. Номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд дотоод нөөц бололцоог бүрэн ашиглаж ажилтан бүр идэвх, санаачлагатай ажиллах шаардлагатай.

ХҮҮХДИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН

2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг: Удирдлагын үйлчилгээ

- Монгол Улсын засгийн газрын хууль тогтоомж, УИХ, ССАЖЯ-аас гаргасан хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан болно.

- "Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ"-г БСШУ-ны сайд Л.Гантөмөртэй байгуулж 2015 онд Хүүхдийн номын ордноос хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг батлуулав.

-Яамдын бүтцийн өөрчлөлтөөр ХТНС нь БСШУЯ-нд харьяалагдах болсонтой холбогдуулан байгууллагын нэн түрүүнд шийдвэрлэх зарим асуудлын талаар санал боловсруулж яаманд хүргүүлсэн. Үүнд: Номын сангийн шинэ байрын тухай асуудал, Хүүхдийн Төв Номын сангийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоотой холбоотой мэдээлэл зэрэг болно.

- "Номын сангийн тухай хууль"-ийн 17.3 дугаар заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 266 дугаар тогтоолоор Хүүхдийн Төв номын сан болгон өөрчилсөн. Энэ ажлын хүрээнд БСШУ-ны сайдын 9 дугаар сарын 24-ний өдрийн А\382 тоот тушаалаар Хүүхдийн Төв номын сангийн дүрэм, бүтцийг шинэчлэн баталсан. Байгууллагын нэр өөрчлөгдсөн тул улсын бүртгэлийн гэрчилгээ, хаяг, албан баланк, тамга тэмдгийг хууль дүрмийн дагуу шинэчилсэн.

-"Хүүхдийн номын ордон" барих газрын асуудлаар БСШУЯ, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Өмчийн харилцааны газар, Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийслэлийн Засаг дарга, Асар өргөө ХХК зэрэг газруудад албан бичиг хүргүүлэх болон уулзаж ярилцсан. Нийслэлээс "Хүүхдийн Төв номын сан" барих газрын асуудлыг Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн 2000 м/кв талбайг нөхөн олговортойгоор чөлөөлөх замаар шийдвэрлэсэн байгаа болно.

- "Номын сангийн тухай хууль"-ийн 17.3 дугаар заалт, БСШУ-ны сайдын А\382 тоот тушаалын 2.2 дугаар заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохиолч хэвлэлийн газруудад бичиг хүргүүлж, тогтоол хүлээн авах ёслолын ажиллагаа зохион байгуулж ойлголцолд

хүрснээр энэ онд 285 нэрийн 723 ширхэг ном, 54 CD нийт 3.862.924 төгрөгний номыг бэлгээр хүлээн авч сан хөмрөгөө аривжууллаа.

- Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 208.3-д тусгагдсан заалтыг хэрэгжүүлэх зорилгоор БСШУ-ны сайдын A\255 тушаалаар байгуулагдсан “Бүх нийтийн соёл, урлагийн боловсролыг дэмжих үндэсний хөтөлбөр” боловсруулах ажлын хэсэгт захирал Д.Оюунбилэг орж ажилласан.

- ХТНС-ийн 2015-2020 оны стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулан стратеги төлөвлөгөө боловсруулсан.

-“ХТНС-ийн ёс зүйн дүрэм”, 2015 оны төсөв зэрэг байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг цахим хуудсанд байршуулж мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.

- Бүх ажилтан, албан хаагчдын 2014 оны “Бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ”-г дүгнэж, 2015 оны төлөвлөгөөг баталсан.

- “ЕБС-ийн номын санчдын ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн журам боловсруулах”-Ерөнхий боловсролын сургуулийн номын санчдын ажил үүргийг тодорхой болгох, номын санчдад тавигдах шаардлагыг зохих түвшинд хүргэх зорилгоор Төрийн албаны зөвлөлийн 2004 оны “Ажлын байр (албан тушаал)-ын тодорхойлолтын загвар, заавар батлах тухай” 34 дүгээр тогтоолыг үндэслэн “ЕБС-ийн номын санчдын ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар”–ыг шинэчлэн боловсрууллаа. Боловсруулсан ажлын байрны тодорхойлолт нь амьдрал дээр хэрэгжихэд үндэслэлтэй байх зорилгоор номын санчдын дунд хэлэлцүүлэг явуулж санал авч байна.

-“Уншлагыг дэмжих журам” боловсруулан БСШУЯ-нд хүргүүлсэн. Журмыг номын санчид, мөн Хүүхдийн уран бүтээлчдийн “Эвт үзэг” төвийн зохиолч, эрдэмтэн судлаач нарын саналыг авч боловсруулсан. Энэхүү журам хэрэгжсэнээр Номын сангийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 24 дүгээр зүйлийн 2-т заасан “Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь уншлагыг дэмжих олон талт арга хэмжээг зохион байгуулах, тэргүүний уншигч-иргэн, гэр бүл байгууллагыг сурталчилах үйл ажиллагаатай холбогдсон харилцаа зохицуулагдах боломжтой болно. Номын сан болон уншлагын төвүүдийн үйл ажиллагааг дэмжин, нийгмийн бүх салбарт мэдлэг мэдээллийг эргэлтэнд оруулан монгол хүний оюун санааны болон эдийн засгийн чадамжийг дээшлүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

- Албан хэрэг хөтлөлт “Улсын үзлэг явуулах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2015 оны тавдугаар сарын 18-ны 195 дугаар тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 249 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд комисс томилон ажилласан. Комисс 2015 онд бичиг хэрэг, архивын улсын үзлэгт бэлтгэн байгууллагын бичиг хэргийг эмхэлж цэгцэлж, стандартын дагуу төлөвлөгөө гарган, архивт байрлуулахад бэлтгэж ажилалаа. Мөн архив бичиг хэргийн мэргэжлийн хүнээс биечлэн 5 удаа, утсаар 8 удаа комиссын гишүүдэд зөвлөгөө өгүүлсэн. Энэ хүрээнд 2010-2015 оны санхүүгийн - 128 ширхэг баримт, бичиг хэргийн 92 баримтыг байнга, түр хадгалах хугацаагаар нь ялган бүртгэж, архивлан авсан.

- ЕБС-ийн номын санчдыг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх зорилгоор байгуулагдсан сургалтын төвийн сургалт явуулах эрхийн гэрчилгээний 1 жилийн хугацаа дууссан тул СБД-ийн боловсролын хэлтэст хандаж гэрчилгээг сунгуулсан.

- “Цахим номыг бий болгох, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор хувийн хэвшлүүдтэй хамтран ажиллах” ажлын хүрээнд “Цагаан баавгай” хэвлэлийн газартай хамтран ажиллах эхлэл тавигдаж байна. Мөн Азийн сантай хамтран хүүхдийн ном хэвлэлийг цахим хэлбэрт оруулах ажлын хэсэгт захирал Д.Оюунбилэг орж ажилласан. Энэ ажлын хүрээнд хүүхдийн зохиолчидтой уулзах уулзалтыг 2 удаа зохион байгуулж, инженер Г.Оргил цахим номын санд тавигдах 15 ширхэг номыг скайнардан багцлан Азийн санд хүргүүлсэн.

-Хүүхдийн ТНС-аас зохион байгуулсан соёл олон нийтийн ажлыг зохион байгуулахдаа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Зөв монгол хүүхэд”, “Ном”,”Авъяас” хөтөлбөртэй уялдуулан зохион байгууллаа. Энэ онд нийт хүүхэд залуучуудыг номтой нөхөрлүүлэх тэдний авъяас билгийг нээхэд чиглэгдсэн 221 удаагийн ажлыг зохион байгуулсан. Хийгдэж байгаа ажлуудын чанрыг сайжруулахад анхааран ажиллаж “Болор судар” хэвлэлийн газар, “Аз хур” номын дэлгүүр, МУИС, “Эвт үзэг” хүүхдийн уран бүтээлчдийн төв, Азийн сан, ЕБС-иуд зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж 8 сая гаруй төгрөгөөр зохиолч, хүүхэд залуучуудыг урамшуулсан байна.

- ХТНС-ийн Мэдээллийн аюулгүй байдлын талаар байгууллагын хэмжээнд дагаж мөрдвөл зохих 3 баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

-“Шилэн дансны тухай хууль”-ийг мөрдөн ажиллаж цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.

-Байгууллагын дотоод хяналт шалгалт зохион байгуулах” журам шинэчлэн, 2015 оны төлөвлөгөөг гарган мөрдөж, тайланг Нийслэлийн мэргэжлийн хяналтын Соёлын байцаагчид цаг тухайд нь явуулж байна. Журмыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.

- Хүүхдийн Төв номын сангийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан, үр дүнгийн гэрээг захирал биечлэн боловсруулж нэгтгэх ажлыг хийж байна. Байгууллагын ажилтан албан хаагч бүр жилийн эцсийн тайлангаа хүн тус бүрээр хамт олныхоо өмнө тайлагнаж хэвшсэн. Энэ нь нэгнийхээ хийсэн ажлыг мэдэх, үнэлэх, үр дүнг тооцох бололцоог олгодог. Жил бүр ажилтан албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ, үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэн ажиллаж байна.

Нийгмийн халамж үйлчилгээ:

- Ур чадварын нэмэгдлийг энэ онд давхардсан тоогоор 15 ажилтанд 10-25 хувиар олгосон.

- Байгууллагын дотоод журмын дагуу 4 хүнд буцалтгүй олгосон байна.

- Цагаан сар болон ахмадын өдрөөр номын сангийн ахмад ажилтнуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.

- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр байгууллагын ажилчдын хүүхдүүдэд бэлэг өгсөн.

- Хамт олны хурлын шийдвэрээр 2014 оны төсвийн хэмнэлтийн урамшуулалд 3.686.743 төгрөг байснаас 2.186.743 төгрөгийг ажилтан албан хаагчдын нийгмийн асуудал шийдвэрлэхэд зориулж, 1.500.000 төгрөгийг буцалтгүй тусламж болгон олгосон байна.

- Зуны амралтаар 9 ажилтан Өвөрхангай аймгийн байгалийн цогцолборт газруудаар аялсан.

- Хамт олноороо “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн”-д мод тарьсан.

- Нийтийн биеийн тамир хөгжүүлэх ажлын хүрээнд 3 удаа биеийн тамирын заал түрээслэн авч бэлтгэл сургуулилалт хийсэн.

- Урсгал засвар хийх мөнгө хасагдсан тул ямар нэгэн засвар хийгдээгүй. “Мөрөөдөл”, “Герман хэлний уншлагын танхим”, Коридорын гэрэлтүүлгийг хэсэгчлэн сайжруулах ажлыг хийсэн.

- Ёслолын үйл ажиллагаанд хэрэглэх 20 сандлын гоёлын бүрээс хийлгэсэн. Мөрөөдөл танхим, Өрнө, Дорно танхимуудын хөшгийг шинэчилсэн.

- Номын санчид болон уншигчдын хэрэгцээнд зориулан 1,2 давхарт 4 шүүлтүүр бүхий ус цэвэршүүлэгч авч тавьсан.

- Номын санч Т. Батцэцэг “Үндэсний бичиг соёл”-ын өдрийг тохиолдуулан БСШУЯ-ны “Бичиг үсэг дэлгэрүүлэгч” цол тэмдэгээр шагнуулав.

- Буриадын ХАА-н Академи оросын уран зохиолыг уншигчдад таниулж байгаа ажлыг нь үнэлж номын санч И.Пүрэвбат, Д.Оюунчимэг нарт өргөмжлөл гардуулав.

- Номын сангуудын дунд зохион байгуулсан тэмцээнээс багаараа цом, мөнгөн шагналаар шагнуулж, Ганцаарчилсан төрөлд Л. Чинзориг теннисээр мөнгөн медаль, Б. Энхзул хүрэл медалийг тус тус авлаа.

Сургалт семинар:

- Ажилтан албан хаагчдын мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд анхааран ажиллаж байна. Номын сангийн бакалаврын сургалтанд 1 ажилтан сурч байна.

-БСШУЯ-ны Соёлын бодлогын газраас зохион байгуулсан “Соёл урлагийн менежмент” сургалтанд захирал Д.Оюунбилэг ,

-2015-11-19, 20-ны өдрүүдэд Монголын Номын Сангуудын Консерциумаас зохион байгуулсан “XXI зууны номын сангийн тулгамдсан асуудлууд. Library challenges in 21st century forum 2015” чуулга уулзалтанд хэлтсийн эрхлэгч Г.Буянцэцэг, арга зүйч Л.Батболор, номзүйч С.Тунгалаг, компьютерийн инженер Г.Оргил, каталогч Т.Бямбасүрэн, Д.Энхчимэг нар

- Арга зүйч Л.Батболор: БСШУЯ-ны хяналт үнэлгээ, дотоод аудитын газраас зохион байгуулсан “Соёл урлагийн байгууллагын статистик мэдээллийг хэрхэн боловсруулах нь” сэдэвт сургалтанд

- Хэлтсийн эрхлэгч Г.Буянцэцэг БСШУЯ-ны Соёлын бодлогын газраас зохион байгуулсан 8-р сарын сарын 15-20ны өдрүүдэд ОХУ-ын Бурядын Улаан-Үд хотод зохиогдсон Соёл урлагийн менежментийн сургалт семинарт.

- Каталогч Т.Бямбасүрэн: Library update-2015 Номын санчдын нэгдсэн зөвлөгөө сургалтанд

- Сэргээн засварлагч Б.Эрдэнэцэцэг: 8-р сарын 31- 9-р сарын 4-нд Гёте-Институтээс зохион байгуулсан “Ном сэргээн засварлах” сургалтанд тус тус оролцов.

- Улаанбаатар банкнаас зохион байгуулсан сургалт, сэтгэл зүйч Д.Даваасүрэнгийн “Харилцааны сэтгэл судлал“ сэдэвт сургалтанд байгууллагын нийт ажилтан албан хаагчид хамрагдсан.

Гадаад харилцаа:

- Олон Улсын номын сангийн холбоотой байнгын харилцаатай ажиллаж байна.

-Гадаадын номын сангуудын үйл ажиллагааг цахим хэлбэрээр судалж уншигчидтай ажиллах ажиллагаа, лавлагаа ном зүйн ажлын туршлагаас суралцан ажилдаа нэвтрүүлж байна.

- БСШУЯ- наас зохион байгуулсан ОХУ-ын Бурядын Улаан-Үд хотод зохиогдсон Соёл урлагийн менежментийн сургалт семинарт хэлтсийн эрхлэгч Г.Буянцэцэг оролцсон .

-БНХАУ-ын ЭСЯ, БСШУЯ-тай хамтран ном хэвлэлийн салбарт хамтран ажиллах улмаар ном гардуулах ёслолын үйл ажиллагааг зохион байгуулсан.

- Германы ЭСЯ, Гёте Институт, Тайваний Үндэсний Номын сан, Азийн сан зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал, Азийн сантай хамтран хүүхдийн цахим ном хийх төсөл, “Ухаалаг хотын оюунлаг хүүхдүүд” төслийн хүрээнд Уншлагын клубын гишүүдэд чиглэл өгөх танилцуулга уулзалт сургалт зохион байгуулсан. Гёте Институттэй хамтран шөнийн уншлага, Жааз хөгжмийн үдэшлэг хамтран зохион байгуулсан. Тайваний Үндэсний номын сантай ном солилцох ажлыг хийж байна.

- Энэ онд хамтран ажилладаг Гетё Институтээс 12 сая 600 мянган төгрөгний 276 ширхэг ном, хэвлэмэл бус материал,436 ширхэг тогтмол хэвлэл, Тайваний Үндэсний номын сангаас 10 ш ном 390 мянга 118 төгрөгийн ном ирсэн. Гёте Институт уншлагын танхимын тохижолтонд анхааран буйдан, кресло , хөгжмийн CD –ний тавиур зэргийг шинээр авч өгсөн.

Санхүү бичиг хэргийн үйл ажиллагаа:

Санхүүгийн ажлын хүрээнд:

- 2014 оны баримтыг Дундманхайдай аудитад шалгуулж, зөрчилгүй дүгнэгдсэн.

- 2014 оны санхүүгийн тайланг цаг тухайд нь БСШУЯаманд гаргаж өгсөн. Мөн БСШУЯаманд нийт 4 албан тоот өгч зардал хооронд шилжүүлгийг холбогдох зардалд шилжүүлэн гаргасан.

- Байгууллагын хагас жилийн балансаа БСШУЯаманд тушааж, мөн яаманд урьд оны төсвийн хэмнэлт болон төсөл арга хэмжээний зардлыг зардлын зүйл ангиар нь тус тусад нь мэдээ гаргаж өгсөн.

- Байгууллагын 2014 оны тайлан, мэдээг гаргаж татварын хэлтэст болон төрийн өмчийн хороонд хугацаанд нь өгсөн.

- 2014 оны хэмнэгдсэн төсвийн хэмнэлтийг дотоод журам болон захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тухай бүрд зохих тушаалын дагуу шийдвэрлэн ажилласан.

- Төрийн өмчийн хорооны програм шинэчлэгдсэнтэй холбогдуулан бүх тавилга эд хогшлыг бүртгэн хугацаанд нь оруулсан бөгөөд 93 хувиар дүгнэгдсэн.

- Сар бүр НД-ын хэлтэст тайланг өгч, ажилтнуудын нийгмийн даатгалын дэвтрийн бичилтийг хийн улиралд 1 удаа баталгаажуулж байна.

- 2015 онд эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн, төрөхийн өмнөх болон дараах 13 хүний листний мөнгийг бодож, НДХ-ийн тэтгэмжийн байцаагчаар хянуулан, байгууллагын дансаар дамжуулан мөнгийг нь олгосон.

- Сар бүрийн 10-ны дотор ажилтнуудын цалин болон зөөврийн номын санчийн цалинг сар бүр бодож олгож, няравтай тайлангаа тулгаж анхан шатны бүртгэлүүдийг хөтөлсөн.

- Сар бүр санхүүгийн тайланг гаргаж, Татварын хэлтэс, НД-ын хэлтэст өгч баталгаажуулсан.

- Ажилчдын эрүүл мэнд, нийгмийн даатгалын дэвтрийг 6 сар хүртэл хийж, СБД-ийн НД-аар улирал тутам баталгаажуулж байна.

- Няравын програмаар орлого, зарлагын гүйлгээг сар бүр шивж гарган ня-бод өгч байна. Нягтлантай санхүүгийн тайланг тулгаж анхан шатны бүртгэлийг хөтөлсөн.

- Төсвийн орлого, зарлагын сарын мэдээг дараа сарын 2-ны дотор төрийн санд өгч, байгууллагын өөрийн орлогыг танхим бүрийн ажилтнуудтай сард 2 удаа тооцоо хийж, сар бүрийн 25-ны дотор төрийн сангийн дансанд тушаасан.

- Жижиг мөнгөн сангаар нэг удаагийн тэтгэмж урамшууллын мөнгийг нягтлангаас авч цаг тухайд нь олгосон.

- 2015 оны байгууллагын болон СТӨ-ний эд хогшлын тооллогыг хийж, хяналт тавин ажилласан.

- 2015 оны 1-11-р сарын санхүүгийн баримтаа үдэж цэгцлэн архивт өгсөн.

Бичиг хэргийн ажлын талаар:

- Захирлын тушаал 28, ирсэн бичиг 10, явуулсан бичиг 100 төлөвлөн гаргаж, захиргааны зөвлөл ба хамт олны хурлын протоколыг хөтөлсөн.

-JAICA Олон улсын байгууллагын техник технологийн шинэчлэл төсөлд оролцох материал бэлдэж БСШУЯ-нд хүргэж өгсөн

- Монгол Улсын Засгийн Газар, 15 яамдад Хүүхдийн төв номын сан болох талаар Засгийн газарт санал оруулсан материалыг бэлдэж тарааж өгсөн.

- Бичиг хэрэг, архивын улсын үзлэгийн шалгалтанд бэлдэх комиссын гишүүнээр томилогдож 2010-2015 оны санхүү- 128 ширхэг баримт, бичиг хэрэг- 92 баримт бичгийг архивлан байнга, түр хадгалах хугацаагаар нь ялган бүртгэж авсан. 2010-2014 оны бичиг хэргийн дотоод товъёонуудыг хийсэн.

Байгууллагын маркетингийн үйл ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд:

Танхим танилцуулсан байдал: ХНО-ны танхимын ажилтнууд давхардсан тоогоор нийт 3325 ЕБС-ийн сурагчид болон оюутнууд, 387 багш номын санч эцэг эхчүүдэд танхимын үйл ажиллагааг танилцуулсан байна. Тухайлбал, 161-р цэцэрлэгийн хүүхдүүд, багш нар, Баянхонгор аймгийн номын санчид, Нийслэлийн 105-р сургуулийн 4-р ангийн сурагчид, Дорнод аймгийн номын санчид, Нийслэлийн28-р сургуулийн сурагчид, Гэр бүл хөгжлийн “Өнөр бүл” төвийн хүүхэд, багш нар ирж танилцжээ.

Цахим хуудсанд: ХНО үйл ажиллагаа, соёл танин мэдэхүйн ажлын тухай 62 орчим мэдээ мэдээлэл 168 зураг байршуулжээ. Монгол номын танхимын номын санч Д. Энхчимэг 2013 оноос Хүүхдийн номын ордны фейсбүүк хуудас нээж, болох үйл ажиллагааны зарлал, мэдээлэл, зураг, уншигчдын сонирхсон асуултанд хариулах гэх мэтээр хөтлөн явуулж байна.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр сурталчилсан байдал :

Захирал Д.Оюунбилэг МҮОНТ, UBS, TV-5, TV-9, ETV телевизээр, “Их мэдэх” танхимын номын санч Г. Дарьсүрэн Монголын радиогийн хүүхдийн редакцид 8 удаа ХНО-ны үйл ажиллагаа, “Их мэдэх” танхимын онцлогийн тухай мэдээ, мэдээлэл өгсөн. Олон улсын номын баярын өдөр, Хүүхдийн баярын “Нээлттэй хаалганы өдөр”- ийн тухай мэдээ мэдээллийг МҮОНТ, TV-5, TV-9, MNC телевизүүдэд өгсөн

Номын санч Н. Адьяа Монголын үндэсний радиогийн Боловсрол хүүхдийн нэвтрүүлэгт “Ном унших соёл”-ын талаар ярилцлага өгсөн.

Мөрөөдөл танхимын номын санч Т.Батцэцэг 6 сарын 1-нд “ЭКО”, “MNC” телевизүүдэд “Нээлттэй хаалганы өдөр”-ийн үйл ажиллагааны тухай мэдээ өгч танхимаа сурталчилсан.

Герман танхимд 5-р сарын 22-нд “25-р суваг” TV-ээс ЕБС-ийн номын сангийн фондыг нэмэгдүүлэх, ном цуглуулах “Book challange” сурталчилгааны 10 минутын зураг авалтыг зохион байгуулав.

2015.4.23. Зөөврийн номын ангийн ажилтан Б.Баярмаа Дэлхийн номын баяр болон зохиогчийн эрхийн өдрөөр Хүүхдийн зохиолч О.Сундуй, Нобелийн шагналтнууд хүүхдийн номын сангийн эрхлэгч Б.Батцэцэг, Хүүхдийн номын ордны зөөврийн номын сан уншигч хүүхэд багачууд, эцэг эхчүүддээ баярын мэндчилгээ дэвшүүлж, номтой нөхөрлөх, номыг хэрхэн зөв сонгож унших, эцэг эхчүүд хүүхдүүддээ хэрхэн зөв нөлөөлөх талаар гэр бүлийн радио 104.5-д шууд ярилцлаганд оров.

Дорно дахины танхим: ЕБ-ын 45-р сургуулийн ирэх жил төгсөх 11-р ангийн 9 сурагчид уламжлал болгон зохион явуулдаг “Мэргэжил бүхэн сайхан” ажлын хүрээнд манай номын сан болон номын санч мэргэжилтэй танилцахаар ирсэн юм. Энэ талаарх мэдээлэл нь “Өнөөдөр” сонины 2015.04.10. №085 дугаарт нийтлэгдсэн.

2015.9.9 Зөөврийн номын сангийн үйлчилгээг нийтэд хүргэж, сурталчлах зорилгоор өдөр тутмын хэвлэл “Өнөөдөр” сонинд “Ертөнцийн цонх”-оор хамтдаа харсан гэр бүл найрсаг байдаг, Зууны мэдээ сонинд “Зөөврийн үйлчилгээ нэвтрүүлжээ” зэрэг мэдээ мэдээлэл хэвлүүлсэн байна.

Хэлтсийн эрхлэгч Г.Буянцэцэг: 5-р сарын 28-нд “Мэдээллийн лавлах 1616”, 9-р сарын 21-нд “Мэдээллийн лавлах 1199”- д ХНО-ны талаарх ерөнхий мэдээлэл, танхимуудын цагийн хуваарийн талаарх мэдээллийг утсаар өглөө.

Номзүйч С.Тунгалаг: 24-р сургууль сонинд, ХНО-ны үйл ажиллагааны талаар Монголын радиод 30 минутын шууд ярилцлагад орсон. Мөн Р. Чойномын нэрэмжит утга зохиолын дугуйлангаас эрхлэн 7 хоног тутамд хэвлэгддэг “Залуу нас” сонинд Монголын хүүхдийн зохиолчдын уран бүтээлээс хүүхэд багачуудад таниулах зорилгоор доорх хүүхдийн зохиол бүтээлийг хэвлүүллээ. Үүнд:

- 2015-05-05-нд Нийтлэлч, Хүүхдийн зохиолч, Утга зохиолын шүүмжлэгч, Доктор (Ph.d), Профессор Чимидийн Арьяасүрэн “Боорцог” (Үлгэр);

- 2015-05-14-нд МЗЭ-ийн шагналт, хүүхдийн зохиолч Гомбын Ганболдын 13 номыг уншиж “Алтан тэмээ” (Хүүхдийн тоглоомон өгүүллэг);

- 2015-05-12-нд Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, хүүхдийн зохиолч Долгорын Батжаргалын 14 номыг уншиж “Чулуун сахиустай баавгай” (үлгэр);

- 2015-05-20 болон 2015-05-28-нд МЗЭ-ийн шагналт, Д.Нацагдоржийн шагналт, Төрийн шагналт, Соёлын гавьяат зүтгэлэн, хүүхдийн зохиолч Доржийн Гармаагийн 8 номыг уншиж “Гайхамшгийн орны зуслангийн найзууд” (Байгалийн танин мэдэхүйн тууж);

- 2015-06-02-нд МЗЭ-ийн шагналт, Д. Нацагдоржийн шагналт, МЗЭ-ийн Алтан өд шагналт, Соёлын гавьяат зүтгэлэн, хүүхдийн зохиолч Жамбын Дашдондогын 24 номыг уншиж “БИ-ХҮҮХДИЙН ЗОХИОЛЧ” (Нүүдлийн номын сангийн замд тохиолдсон явдал) зэрэг зохиол бүтээлүүдийг сонгон хэвлүүлсэн.

- 2015-10-07-нд Мадоннагийн цуврал, Д. Нацагдоржийн намтар, анхны номын талаар материалыг тус тус бэлтгэж “Залуу нас” сонинд өглөө.

Номын сангийн фондыг ном хэвлэлээр баяжуулах ажлын хүрээнд:

Энэ онд улсын төсвөөр 20.366.827 төгрөгний ном хэвлэл, бэлгээр 20.352.256 төгрөгний нийт 40 сая 719 мянга 083 төгрөгний ном хэвлэл бүрдүүлсэн. Зохиолч, хэвлэлийн газруудаас бэлгээр монгол болон гадаад хэл дээр нийт 1337 ш ном, 97 ширхэг хэвлэмэл бус материал бүрдүүлэв. Гёте Институтээс нийт 276 ширхэг ном, 436 ширхэг 6000 еврогийн ном хэвлэлээр фонд баяжилт хийв. Тайваний номын сангаас 390.118 төгрөгний 10 ширхэг ном шинээр хүлээн авсан байна.

Бүрдүүлэгч бүгд 50 фактурын 728 нэрийн 2365 ш ном, 145 ш аудио визуал материал 1853 ш дотоод сонин сэтгүүл 28.826.365 төгрөгний 4363 ш ном, аудио визуал материал, сэтгүүл, сонин бүрдүүллээ.

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
2500	2510	100.4 %

Ном бүрдүүлэх явцад дараах ажлыг гүйцэтгэлээ:

- 2015 оны монгол хэвлэл захиалгын гэрээг “Монгол шуудан” компанитай хийж 16 нэрийн сонин, 12 нэрийн монгол сэтгүүл захиалж 1.082.400 төгрөг.

- Тогтмол хэвлэл: 1853 ш сонин, 133 ш сэтгүүлүүдэд карт хөтлөж холбогдох танхимуудад өгч байна. “Ардын эрх” сонины 30 дугаар, “Үндэсний шуудан” сонины 66 дугаарыг бэлгээр авав.

- Худалдаагаар бүрдүүлсэн ном бүрт орлогын баримт бичив. Мөн ирсэн номонд фактур бичиж ном ангилагчид хүлээлгэн өгсөн.

- Уншигчдын эрэлт хэрэгцээг хангах зорилгоор “Интерном”, ”Аз хур”, дэлгүүрүүдээс 2015 онд борлуулалтаараа тэргүүлсэн “Очир эрхшээгч”, ”Тасдаж үл болох сарнай”, ”Чойбалсан 1, 2 дэвтэр”, ”Судасны чимээ”, ”Шилийн богд”, ”Үүлэн хээтэй орчлон”, Д.Цоодол “Бүтээлийн түүвэр” 1-4 боть, ”Хүүхэд залуучуудын нэвтэрхий толь” 1-2 боть, ”Монгол улсын ховор марк, мөнгөн тэмдэгт”, ”Шилийн богд”, ”Байгууллагын сэтгэл судлал” зэрэг номуудыг бүрдүүлсэн.

- Мөн “Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис” 1-3 боть, ”Монголын эх түүх” 1-6 боть зэрэг номуудыг бэлгээр авч фондоо баяжуулсан. Нийт үнэ 1.110.000 төгрөг

- Танхимуудын татгалзлын дэвтрийн дагуу “Их мэдэх” танхимын уншигчдад зориулж номын дэлгүүр болон хувь хүмүүсээс “Динза” комик номын цуврал 11-37, ”Ухаантай хүүхдийн ухаалаг ном”, “Гүнжийн тухай үлгэрүүд”, Дорно дахины уншлагын танхимд МУБИС-ийн номын сангаас бэлгээр хятад хэлний 41 нэрийн 53 ширхэг ном, 23 ширхэг CD-г нөхөн бүрдүүлэв.

- “Монгол улсын номын сангийн тухай” хуулийн дагуу хүүхдэд зориулсан хэвлэлийн бүтээгдэхүүн тус бүрээс 2 хувийг зохиолч, хэвлэлийн газруудаас үнэ төлбөргүй авч

архивын фондоо бүрдүүлэх зорилгоор 10 гаруй хэвлэлийн компаниудад хүсэлт гарган албан бичиг хүргэж зарим хэвлэлийн газруудаас архивлах номоо авч байна.

- “Монгол улсын номын сангийн тухай” хуулийг хүлээн авах арга хэмжээний хүрээнд хэвлэлийн компани болон зохиолчдоос бэлгээр 128 нэрийн 261 ш ном, 3 ш CD нийт 2.241,823 төгрөгний ном болон CD бүрдүүлэв.

- “Интерном“, ”Аз хур” ХХК номын дэлгүүрүүдтэй бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд сунгалт хийв.

- БСШУЯ-нд албан бичгээр хүсэлт гарган 12 жилийн сургуулийн 1-9 ангийн бүх сурах бичгийг бэлгээр 11 хэвлэлийн компаниас татан авч бүрдүүлж авсан. Үүнд: 63 нэрийн 245 ширхэг ном, 48 ш CD нийт үнэ 426.537 төгрөг.

Ном ангилах, данслах, ажиллах хүрээнд:

Шинээр ном хүлээн авах: Нийт 42 фактурын 2172 шинэ ном, 114 cd-ийг ном, 2286ш ном, cd бүрдүүлэгчээс фактураар тулган хүлээн авлаа.

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
2500	2286	91,4 %

Үүнийг фактураар нь авч үзвэл:

- Худалдааны монгол номын 1- 15-р фактурын 1253ш ном, 50cd
- Бэлгийн монгол номын 1-25-р фактурын 875ш ном, 64cd
- Худалдааны гадаад номын 1-2-р фактурын 44ш ном

Техник ажиллагаанд оруулсан байдал:

Нийт: 3072 ш номыг ангилж дансалж техник ажиллагаанд оруулснаас:

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
2500	3072	123%

- 2014 онд хүлээн авсан бэлгийн монгол номын 8-9-р фактурын 63ш ном, 1cd, бэлгийн гадаад номын 6-р фактурын 22ш ном, 2015 оны худалдааны монгол номын 1-15-р фактурын 1253 ном 50cd, бэлгийн монгол номын 1-25-р фактурын 875ш ном, 64cd,

худалдааны гадаад номын 1-2-р фактурын 44ш ном, нийт - 45 фактурын 2257ш ном, 115cd буюу 2372 ш шинэ ном, cd

- Мөн архивийн фондын 700ш номыг ангилж данслан, техник ажиллагаанд оруулсан.

Танхимуудад ном хуваарилан хүлээлгэж өгөх үйл ажиллагаа:

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
2500	3072	123%

2257ш шинэ ном 115ш cd буюу 2372 шинэ ном cd, архивийн фондын 700ш бүгд 3072 ш ном, аудио видео материалыг ангилж, нэг бүрчилсэн бүртгэлд бүртгэн, техник ажиллагаанд оруулж уншлагын 6 танхим болон архивийн фондонд дараах байдлаар хуваарилан хүлээлгэж өгсөн. Үүнд:

- Боловсрол танхимд 1080ш шинэ ном 19cd
- Мөрөөдөл танхимд 499ш шинэ ном 38cd
- Их мэдэх танхимд 450ш шинэ ном, 42 cd
- Архивийн фондонд 159ш ном 13ш cd
- Өрнө дахины уншлагын танхимд 54ш ном, 3ш cd
- Дорно дахины уншлагын танхимд 15ш ном хүлээлгэн өгсөн байна.

Нэгдсэн бүртгэлийн 671-715-р хэсэгт 45 фактурын 648 нэр төрлийн 2356ш ном, 13 нэр төрлийн 54ш cd-ийг бүртгэсэн байна.

Ном хэвлэл, аудио визуал материалыг каталогжуулах ажлын хүрээнд:

Шинэ ном электрон каталогт оруулах. Каталогчид нийт 750 нэрийн 2094ш шинэ номыг электрон каталогт орууллаа.

	Төлөвлөгөө:	Гүйцэтгэл:	Биелэлт:
Төрлөөр	800	750	93,7 %
Ширхэгээр	2500	2094	83,7 %

Электрон каталогт оруулсан номыг уншлагын танхимаар нь авч үзвэл:

Боловсрол хөгжил танхим - 337 нэр төрлийн 1055ш

Мөрөөдөл танхим – 123 нэр төрлийн 500ш

Их мэдэх танхим – 105 нэр төрлийн 412ш

Архивын фонд - 202 нэр төрлийн 202ш

Өрнө дахины танхим - 49 нэр төрлийн 147ш

Шинэ номыг хэлээр нь ялгавал:

Монгол хэл дээрх ном – 649 нэр төрлийн 1949ш

Орос хэл дээр ном – 71 нэр төрлийн 210ш

Англи хэл дээрх ном – 25нэр төрлийн 96ш

Монгол-Англи – 5 нэр төрлийн 21 ш

Англи- Монгол – 1нэр төрлийн 5 ш ном тус тус электрон каталогт шинээр оржээ.

Үүнээс: Каталогч Д.Жавзанпагма 400 нэр төрлийн 1285ш номонд номзүйн бичилт хийж электрон каталогт оруулллаа.

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
Төрлөөр	400ш	400ш	100%
Ширхэгээр	1250ш	1285ш	107%

Танхимаар нь авч үзвэл:

Боловсрол хөгжил танхим - 209 нэр төрлийн 660ш

Мөрөөдөл танхим – 57нэр төрлийн 235ш

Их мэдэх танхим – 60 нэр төрлийн 235ш

Архивын фонд - 124 нэр төрлийн ш 124ш

Өрнө дахины танхим - 16 нэр төрлийн 31ш

Хэлээр нь ялгавал:

Монгол хэл дээрх ном – 367нэр төрлийн 1192ш

Орос хэл дээр ном – 18 нэр төрлийн 27ш

Англи хэл дээрх ном – 15нэр төрлийн 66ш

Каталогч Т.Бямбасүрэн 350 нэр төрлийн 809ш номонд тус тус номзүйн бичилт хийж электрон каталогт оруууллаа.

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
Төрлөөр	400ш	350ш	87.5 %
Ширхэгээр	1250ш	1111 ш	88.8 %

Танхимаар нь авч үзвэл:

Боловсрол хөгжил танхим - 128 нэр төрлийн 395 ш

Мөрөөдөл танхим – 66 нэр төрлийн 265 ш

Их мэдэх танхим – 45 нэр төрлийн 177 ш

Архивын фонд - 78 нэр төрлийн 78 ш

Өрнө дахины танхим – 33 нэр төрлийн 116 ш

Хэлээр нь ялгавал:

Монгол хэл дээрх ном – 282 нэр төрлийн 757 ш

Орос хэл дээр ном – 53 нэр төрлийн 183 ш

Англи хэл дээрх ном – 10 нэр төрлийн 30 ш

Монгол-Англи – 5 нэр төрлийн 21 ш

Англи- Монгол – 1 нэр төрлийн 5 ш

Зураасан коджуулах талаар:

Каталогчид бүгд 3051ш номыг зураасан коджуулав. Үүнээс Д.Жавзанпагма 1940ш, Т.Бямбасүрэн 1111 номын зураасан кодыг хэвлэж номон дээр нь наан ангилагчид хүлээлгэн өгөв. Танхимын номын санчид 1889 номыг зураасан коджуулсан байна.

Үүнээс: каталогч Д.Жавзанпагма электрон каталогт шинээр оруулсан номын 1285ш, архивын фондын 390ш, Мөрөөдөл танхимын 242ш, Их мэдэх танхимын 63ш, каталогч Т.Бямбасүрэн 750 ш зураасан код, хуучин карт шинэчилсэн 361 ш зураасан кодыг хэвлэж, фондын болон холбогдох танхимуудын номын санчид хүлээлгэн өгсөн байна.

Мэдээллийн баазаас карт хэвлэх:

Каталогчид бүгд 2257ш картыг мэдээллийн баазаас хэвлэн гаргасан байна.

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	
	2300	2257	98.1%

Үүнээс: Каталогч Д.Жавзанпагма бүгд 1182ш каталогийн карт хэвлэснээс шинэ номын 800ш, хуучин карт шинэчилсэн 382ш, үүнээс 400ш картыг үсэг дараалльн каталогт байрлуулахаар каталогч Т.Бямбасүрэнд хүлээлгэн өгөв.

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	
	1150ш	1182ш	102%

Каталогч Т.Бямбасүрэн 1075ш карт хэвлэн гаргасанаас 792 ш шинэ, 283 ш хуучин карт шинэчилэн гаргаж, 400 ш картыг үсэг дараалльн каталогт байрлуулахаар каталогч Д.Жавзанпагмад хүлээлгэн өгсөн байна.

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	
	1150ш	1075 ш	93.4%

Каталогт карт байрлуулах:

Каталогчид төрөл болон үсэг дараалльн каталогт нийт 2230ш картыг ламинатордан байрлууллаа.

Төлөвлөгөө:	Гүйцэтгэл:	Биелэлт:
2300	2230	96.9%

Төрөл ангийн каталогт: Бүгд 1132ш карт байрлуулснаас шинэ 750ш, хуучин карт шинэчилсэн 382ш карт,

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
1150 ш	1132ш	98%

Үсэг дараалльн каталогт: Бүгд 1098 ш карт байрлуулснаас шинэ номын 696ш, хуучин 402ш картыг шинэчлэн хэвлэж тус тус байрлуулсан байна.

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт

1150 ш	1098	95.4 %

Каталогт редакц хийх: төрөл ангийн каталогт каталогч Д.Жавзанпагма:

- Цаасан карт хэвлэхийн өмнө шинээр оруулсан 400 нэр төрлийн номын бичлэгийг шалгаж алдааг тухай бүрд нь засаж янзлав.
- Архивын фондны 389ш номыг татаж редакц хийж дансыг нэмэн зураасан кодыг нь хэвлэж фондын номын санчид хүлээлгэн өгөв.
- Төрөл ангийн каталогийн 30000ш картанд редакц хийж 423 ш картыг ялгаж авав.
- Электрон каталогийн баазаас 382ш картыг хэвлэж 49ш картыг каталогоос хасалт хийв.
- Монгол номын фонднoос 59ш ном татаж редакц хийв.
- Архивын фондны номонд редакц хийх явцдаа 60ш номыг шинээр бичиж, 35ш номын бичилтийг нэгтгэж, Их мэдэх, Мөрөөдөл танхимын 700ш номын үнийг засаж, 300ш зураасан кодыг шинэчилж танхимын ажилтнуудад хүлээлгэн өгөв.
- Каталогийн 40 ялгагчийг шинэчлэн хийв.

Үсэг дарааллын каталогт каталогч Т.Бямбасүрэн:

- Цаасан карт хэвлэхийн өмнө шинээр оруулсан 350 нэр төрлийн номын бичлэгийг шалгаж алдааг тухай бүрд нь засаж редакцлав.
- Өмнө нь электрон каталогт орсон ш номыг фонднoос татаж бичлэгүүдийг засаж редакц хийв.
- Карт байрлуулах явцдаа бичиг үсэг нь баларсан, урагдсан ш картыг ялган авч бичлэгийг засаж 7000 ш картанд редакц хийж 267 картыг хэвлэн гаргав.
- Электрон каталогийн баазаас 63ш картыг хэвлэж 26ш картыг каталогоос хасалт хийв.
- Архивын фондын 129ш номонд редакц хийж зураасан кодыг хэвлэн гаргав.
- Каталогийн 15 ялгагчийг шинэчлэн хийв.

Каталогийн лавлагаа мэдээлэл өгөх талаар:

- Каталогийн жижүүрт нийт 244 удаа гарч, уншигчдад каталог ашиглах, номоо хэрхэн хайх, сонгох, захиалгын хуудсыг бичих талаар давхардсан тоогоор 4900 уншигчдад зөвлөгөө өгч ажиллалаа. Үүнээс каталогч Т.Бямбасүрэн 2200, каталогч Д.Жавзанпагма 2700 удаа уншигчдад каталогийн лавлагаа мэдээлэл өгсөн байна.

- Зарим номын шифрийг тодруулах, олдохгүй байгаа зохиолуудыг электрон каталогоос хайлт хийж олж өгөх зэрэг ажлуудыг байнга хийж байлаа.

-Электрон каталогийн хайлтын компьютерийг ажиллахад бэлтгэх, каталогийн шоголуудыг цэгцлэх ажлыг байнга хийж байлаа.

Номын сангийн автоматжуулалт болон програм хангамж, техник хангамжийн ажлын хүрээнд:

Компьютерийн засварын хүрээнд:

- Формат: Нийт 25-н компьютерийн 10-ыг форматласан бөгөөд холбогдох зааварчилгааг ажилтнуудад өгсөн.
- Ажилтнуудын компьютерийн хэрэглээний программ нийт 19 удаа суулган шинэчилсэн.
- Ном ангилагч С.Адъяаням, арга зүйч Л.Батболор нарт шинээр компьютер гаргаж өгсөн.
- Каталогч Д.Жавзанпагмын эвдэрсэн компьютерийг зассан.

Байгууллагын дотоод сүлжээ болон интернэтийн хүрээнд :

- 2015 оны эхний хагас жилд компьютерийн инженер Б.Сүхбаатар цахилгаан тасралтаас үүдэлтэй серверүүдэд гарсан 3 удаагийн их хэмжээний гэмтэл эвдрэлийг засварласан. Үүнд:

1. Router Microtik 1200 – manage тохируулга алдагдсан. Үүнийг үйлчилгээний ачаалал багассан үед дахин тохируулга хийх шаардлагатай байгаа.
2. Dell PowerEdge 400 SC хэт удаашралтай, сүлжээ удаашруулж байгааг засварлахаар шинээр Windows Server 2013 –ийг суулгах шаардлагатай компьютер нь хэт хуучирсан тул суулгаж болохгүй, инженерийн компьютерээр сольж, нэмэлт сүлжээний

карт тавьж байгууллагын сүлжээг сэргээсэн бөгөөд тус сүлжээнд холбогддог бүх комьютерт статик IP хаягжуулалт хийв.

3. LIB4U серверийн гэмтэлийг Wolves компаны мэргэжилтнүүдээр засварлуулж, тохируулж ажиллагаанд оруулсан.

- Windows XP үйлдлийн систем бүхий компьютерууд дотоод сүлжээнд саатал үүсгэснийг тогтоон тодорхойлж, хэрэглэгчийн компьютеруудын зарим хэсгийг static IP хаягтай болгох ажлыг каталогч Т.Бямбасүрэнд заан хамтарч гүйцэтгэн, компьютерийн дотоод сүлжээний найдвартай байдлыг хангаж 2 удаагийн тасалдлыг арилгасан ба тус хаягжуулалтын баримтыг хийлгүүлэн бүрдүүлсэн.

- Хагас жилийн хугацаанд 5 компьютерийн програм хангамжийг шинээр хийлгүүлсэн.

- LIB4U.Net програмын өөрчлөлтийг 3 удаа хийв. /Т.Бямбасүрэн, И.Пүрэвбат/.

- “Дорно дахины уншлагын танхим”-д интернэт дэд сүлжээг Т.Бямбасүрэнд биечлэн зааж хийлгүүлэв.

- Ня-бод 2 төрлийн програм /Suutgan 2.0, MS Framwork 4.0/ суулгаж, өнгөрсөн оны архивуудыг бэлтгэж өгөв.

- Лиценз антивирус Kaspersky Endpoint програмын хугацаа дуусч буй тул шинээр авах зааварчилгааг нябо, каталогч Т.Бямбасүрэн нарт хэлж шинэчлэх шаардлагатайг уламжлав.

- LIB4U Net 1.7 програмыг Windows 7 Ultimate үйлдлийн систем дээр ажилладаг болгоход Windows XP mode application-ы 3 нэрийн програмыг ашиглаж номын санд нэвтрүүлсэн ба хэрхэн ашиглахыг каталогч Т.Бямбасүрэнд зааварчлав.

- Microsoft-ын лицензтэй програм хангамжийг нийт 6 компьютерт суулгаж, алдаатай install DVD байгааг тодорхойлж, компьютерийн инженер Г.Оргилд хүлээлгэн өгөв.

- “Боловсрол хөгжил” танхимын компьютерийн эвдрэлийг тодорхойлсон ба сэлбэг авахуулж засварлан суурилуулсан, Одоо n-Computing install хүлээгдэж байна.

- Интернэтийн холболт 6 сарын 23-наас 9 сарын 16 хүртэл нийт 30 гаруй удаа тасарсан нь сервер комьпютерийн портын эвдрэл байлаа. Серверийн өрөөнд Герман танхимын рүүтерийг авч байрлуулав.

- MAGICNET ээс шилэн кабель татуулан дотоод сүлжээний асуудлыг бүр мөсөн шийдвэрлэв.

- Интернэтийн хурд 3GB байсныг 1GB болгож багасгаснаар сар бүрийн төлбөрийн 200000₮-г бууруулж 100000₮ болгосон.

- Герман танхимд рүүтер шинээр авч холболт хийсэн.

- Мөрөөдөл танхимын эвдэрсэн SWITCH-ийг актлан, ашиглахаа больсон байсан рүүтерийг ажиллуулсан /2 хоног/

- Өрнө дахины танхимын 1 компьютерт сүлжээний утас татсан.

- Арга зүйн өрөөний SWITCH-ийн ажиллахгүй байсан PORT-ийг олж тогтоон засварлав.

- Сэргээн засварлах өрөөнд гэмтэлтэй байсан SWITCH-ийг засварласан.

- Монгол фондын эвдэрсэн SWITCH-ийг засварласан /Солих шаардлагатай/

- Интернэтийн хурд бууруулсантай холбоотойгоор интернэтийн хурдыг хамгийн их хувьтай эзлэж байгаа Youtube, Facebook, Twitter, Goolingoo сайтуудыг сервер дээр хаах ажлыг гүйцэтгэлээ.

График дизайны хүрээнд:

- “Номын сангийн тухай” хуулийг хүлээн авах хүндэтгэлийн үйл ажиллагаанд зориулсан урилганы эх бэлтгэл

- “Номын сангийн тухай” хуулийг хүлээн авах хүндэтгэлийн үйл ажиллагаанд зориулсан хулдаасан хэвлэлийн эх бэлтгэл

-- Хүүхдийн төв номын сангийн логог шинэчлэхээр дөрвөн хувилбараар лого бэлтгэж гаргасан.

- Нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллага сурталчлах өдөрлөгт зориулан Хүүхдийн төв номын сангийн танилцуулга видео шинээр бэлтгэж хийж гүйцэтгэсэн.

- Хүүхдийн төв номын сан болгох тухай төслийн танилцуулга үзүүлэнг PREZI програм дээр тусгайлан хийж гүйцэтгэсэн.

- “Номын сангийн тухай” хуулийг хүлээн авах хүндэтгэлийн үйл ажиллагаанд зориулан 3 үзүүлэн хийж гүйцэтгэсэн. Үүнд: Зохиолч Д.Жамъяны номын нээлт, захирал Оюунбилэгийн нээлтийн үгэнд зориулсан үзүүлэн, мөн хүндэт зочдод гардуулах бэлгэнд зориулсан үзүүлэн зэрэг болно.

- “Нахиа” хүүхдийн ёгт үлгэрийн номын нээлтэнд зориулан хулдаасан хэвлэлийн эх болон энгэрийн тэмдэгийг эхийг бэлдсэн.

- Ажилтнуудад зориулан нэрийн хуудас шинээр хийхээр төлөвлөн дөрвөн төрлийн нэрийн хуудасны загварыг урьдчилсан байдлаар бэлтгэсэн.

- Байгууллагын уншигчийн үнэмлэх бүртгэлийн үйл ажиллагаанд цээж зураг авах үйлчилгээг санаачлан 12 сарын 1-нээс хэрэгжүүлэхээр төлөвлөн шаардлагатай хэрэгслийг бэлтгэсэн.

Вэб хөгжүүлэлт болон сошиал аккаунтын хүрээнд:

- Байгууллагын вэб сайтад “Шилэн данс”-ны материалыг оруулах талаар ня-бо Батбаатар, админ номын санч Д.Энхчимэг нарын хамт зөвлөлдөж хийж гүйцэтгэв.

- Вэбсайтыг шинэчлэх үүднээс 7 сарын 15-наас 8 сарын-10 ны туршид 5-н вэб хийж гүйцэтгэж түүнээс сонгон 3-ыг нь ашиглахаар болсон.

- Вэбсайтанд зориулж жилд төлдөг байсан 1,075,800 төгрөгийг 500,000 болгож багасгах арга замыг хайн судлаж олсон нь Америкийн Нэгдсэн Улсын HOSTMONSTER сайтаас хост (домэйн нэрийн үйлчилгээ) авахаар болсон. /14 хоног/

- Вэбсайтыг шинэчлэх 500.000 төгрөгний вэбхостыг худалдан авсан.

- Фэйсбүүк хуудасны “Хүүхдийн Номын Ордон” нэрийг “Хүүхдийн Төв Номын сан” болгон өөрчилсөн учраас шинэчилсэн вэб сайттайгаа холбогдуулан өөрчлөлт хийсэн.

- Вэбсайтын загварыг шинэчилж бэлэн болгосон

- Хуучин вэбсайтад байсан мэдээ мэдээллийг архивлан авч үлдсэн бөгөөд архивын ажил дууссаны дараа өөрчилсөн хувилбарыг туршихаар бэлэн болгоод байна.

- Шинэ жилд зориулан HTML кодоор вэб хийж түүнийгээ СД дээр хуулан ажилтнууддаа бэлэглэхээр бэлтгэсэн.

- Бүх ажилтнуудад зориулан вэбмэйл буюу bpc.mn мэйлийг ажиллагаанд оруулахад бэлэн болгоод байна.

- Хүүхдийн төв номын сан болсонтой холбогдуулан bpc.mn домайн хаягыг mccl.mn болгон өөрчлөх хүсэлтээ MAGICNET- д өгсөн бөгөөд 2 сарын 24нд шинэ домайн хаягынн дагуу үйл ажиллагаа явуулахаар гэрээг шинэчилсэн.

Арга зүйн ажлын хүрээнд:

ЕБС-ийн номын санчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх:

Арга зүйч Л.Батболор 45, номзүйч С.Тунгалаг 34 нийт 79 удаа мэргэжил арга зүйн зөвлөгөөг номын санчдад өгсөн байна. Үүнээс:

Арга зүйч Л.Батболор ЕБС-ийн 45 номын сангийн үйл ажиллагаатай танилцаж заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
45	45	100 %

- Үүнд: Нийслэлийн ЧД-ийн 23, 24, 5, 17, 49, 39, 57, СБД-ийн 45, 3, 11, 71, 31, 6, 1, СХД-ийн 76, 67, 105, 104, 42, 12, 9, 123, 81, 80, 92, 79, 53, 33, БЗД-ийн 48, 21, 44, ”Амгалан цогцолбор”, СБД-ийн 58, ”Шинэ үе”, “Хобби”, ”Оюунлиг”, “Олонлог” хувийн сургуулиуд болно.

- Увс аймгийн баруун туруун сумын номын санч Т.Нэмэх, Хөтөл хотын сургуулийн номын санч Т.Чимэгсүрэн, “Шинэ толь” хувийн сургуулийн Б.Батбуян, Төв аймгийн 10 жилийн 2-р сургуулийн номын санч Х.Эрдэнэжаргал нар биечлэн ирж арга зүйн зөвлөгөө авч тэдэнд хэрэгцээт гарын авлага материалыг бэлтгэж өгөв.

Номзүйч С.Тунгалаг:

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
22	34	154,5%

Төв аймгийн ТНС-гийн захирал, Говь-Сүмбэр аймгийн ТНС-гийн арга зүйч, Баян-Өлгий аймгийн ТНС-гийн захирал, 122-р сургуулийн номын санч, хувиараа хөдөлмөр эрхлэгч Батсайхан, Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн ажилтан Оюунгэрэл, Эрүүл мэндийн мэдээллийн төвийн ажилтан, Завхан аймгийн ТНС-ийн эрхлэгч, Баянхонгор аймгийн

номзүйч, Монгол-Японы мэдээллийн төвийн номын санч, Дархан-Уул аймгийн ТНС-ийн ном зүйч Н. Солонго, Говь-Сүмбэр аймгийн ТНС-ийн арга зүйч, Дундговь аймгийн Мандал сумын сургуулийн номын санч, Төв аймгийн Лүн сумын номын санч, Хүүхэд хөгжил, гэр бүл хамгааллын төвийн ажилтан, Нобелийн шагналтан хүүхдийн номын сангийн номын санч, 96, 38, 85-р сургуулийн номын санч нарт номын сангийн уншлагын танхимын зохион байгуулалт, Ном хөтөлбөрийн уралдааныг хэрхэн дүгнэх, номын сангийн арга зүйн ажлын зохион байгуулах, үнэгүй номыг үнэлэх, намтар номзүйн хэрхэн хийх, Чөлөөт сонголттой танхимын зохион байгуулалт, DDC ангиллаар ном ангилах, номзүйн ажлын өнөөгийн байдал, хэрхэн зохион байгуулах талаар цахим шуудан болон утсаар нийт 34 удаа лавлагаа мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгсөн.

Танхимын номын санчдад заавар зөвлөгөө өгөх

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
4	5	125 %

Танхимын номын санчдад заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Үүнд:

- Өрнө дахины уншлагын танхимын номын санч Пүрэвбатад “Чөлөөлөх дайны ялалтын түүхт 70 жилийн ой”
- “Мөрөөдөл” танхимын номын санч Арьяад “Дэлхийн номын баяр”- ыг угтаж хийх ажлын талаар тус харилцан ярилцаж заавар зөвлөгөө өглөө.
- “Боловсрол хөгжил” танхимын номын санчтай хамтран СГЗ, зохиолч, яруу найрагч Г.Мэнд-Ооёотой хийх зохиолч уншигчдын уулзалтыг зохион байгууллаа.
- Мөрөөдөл танхимын номын санч Арьяад зуны уншлагыг хэрхэн зохион байгуулах талаар харилцан ярилцаж төлөвлөгөө гарган ажиллахаар боллоо.
- Өрнө дахины номын санчдын орос хэлний сонголттой сургуулийн номын санчидтай холбож өгч цаашид хийх ажлын талаар харилцан ярилцлаа.

Номын санчдын сургалт семинар:

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
4	9	225 %

2015.01.12

Азийн сангаас зохион байгуулсан “Ухаалаг хотын оюунлаг хүүхдүүд” төслийн хүрээнд Уншлагын клубын гишүүдэд чиглэл өгөх танилцуулга уулзалт сургалтын үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэлээ. Тус сургалтын гол зорилго нь сурагчдад ном уншихын ашиг тус, ач холбогдол, давуу талуудын талаарх ойлголт мэдлэгийг олгоход зориулж уншлагын клуб байгуулж, клуб ажиллуулах аргачлал болон санаачилгуудыг өгч, мэдээллээр хангах чиглэл өгөхөд оршино.

Сургалтанд оролцсон сургуулийн номын санчдаас цаашид сургалтыг хэрхэн явуулах талаар авсан судалгаа санал хүсэлтийг нэгтгэж Азийн сангийн төслийн зохицуулагчид явууллаа.

2015.03.23-27

“ЕБС-ийн номын сан нь сургуулийн мэдээллийн төв болох нь “анхан шатны мэдлэг олгох мэргэшүүлэх сургалтыг Дорнод аймгийн сумдын сургуулийн номын санчдын дунд зохион явууллаа. Сургалтанд 20 номын санч хамрагдсан. Арга зүйч Л.Батболор сургалтын бэлтгэл ажлыг зохион байгуулж, “Номын сангийн каталог зохион байгуулалт”, “Номын сангаас зохиох соёл танин мэдэхүйн ажил”, ном ангилагч С.Адъяаням “Номын сан ном зүйн ангилал”, “Үндсэн бүртгэл хөтлөлт”, “Өдөр дутмын бүртгэл хөтлөлт” сэдвээр нийт 6 цаг, номзүйч С.Тунгалаг “Ном бүрдүүлэлт”, “ЕБС-ийн номын санд картын сан зохион байгуулах”, “Номын сангийн фондын зохион байгуулалт”, “Номын сангийн уншлага, үйлчилгээний ажил” сэдвээр тус тус онол практик хосолсон хичээл зааж, дадлага хийлгэв.

2015.03.28. Үзүүлэх сургалт

Нийслэлийн СБД-ийн 58-р сургуулийн номын сангаас уншигчдын дунд зохион байгуулсан соёл танин мэдэхүйн ажил болох зохиолч уншигчдын уулзалтын үйл ажиллагаанд дүүргийн сургуулийн номын санчид идэвхтэй оролцсоноос гадна сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж харилцан туршлага судалсан танилцах үзүүлэх сургалт боллоо. Зохиолч уншигчдын уулзалтыг зохиолч Б.Шүүдэрцэцэгийн “Ану хатан” түүхэн зохиолоор багш сурагчдын дунд зохион явуулав. Энэхүү уулзалтаар Манж Чин улсаас бүх Монголыг эзлэн авах гэсэн түрэмгий бодлогыг эцсээ хүртэл эсэргүүцсэн цогтой тэмцэгч Ойрдын Галдан бошигт хааны хамтран зүтгэгч нь Монгол эх орон газар шороонызхоо төлөө амь биеэ үл хайрлан явсан түүхт домгийн эзэн Ану хатны тухай уншигчид харилцан ярилцсан сайхан уулзалт болсон. Мөн тус сургуулийн номын сангийн

үйл ажиллагаатай номын санчид танилцаж, санал бодлоо солилцон, харилцан туршлага судаллаа.

2015.03.26 - 04.1

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулсан нийслэлийн ЕБС-ийн номын санчдын мэргэжил дээшүүлэх сургалтанд арга зүйч Л.Батболор “Номын сангаас соёл олон нийтийн ажлыг зохион байгуулах нь”, хэлтсийн эрхлэгч Г.Буянцэцэг “ХНО-ны уншлага үйлчилгээний шинэлэг үйл ажиллагаа”, номзүйч С.Тунгалаг “Хүүхдийг уншлагад бэлтгэх, удирдах нь”, “Эцэг эхэд өгөх зөвлөгөө” сэдвээр 2 удаа 3 цагийн хичээл заалаа. Сургалт БГД-ийн 20–р сургууль дээр зохион байгуулагдаж, нийслэлийн дүүргүүдийн сургуулийн номын санчид хамрагдсан.

2015.04.13-17.

“ЕБС-ийн номын сан нь сургуулийн мэдээллийн төв болох нь” анхан шатны мэдлэг олгох, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж нийслэлийн ЕБС-ийн 16 номын санчид хамрагдлаа. Сургалтын бэлтгэл ажил болох сургалтын хөтөлбөр, сургалтын бүртгэл, сургалтанд оролцсон номын санчдаас авах судалгаа зэргийг бэлтгэж номын санчдад тарааж өгөв. Арга зүйч Л.Батболор “Номын сангийн каталог зохион байгуулалт”, “Номын сангаас зохиох соёл танин мэдэхүйн ажил”, ”Номын сангийн стандарт, норм норматив” зэрэг сэдвээр 8 цагийн хичээл, номзүйч С.Тунгалаг “Ном бүрдүүлэлт”, “ЕБС-ийн номын санд картын сан зохион байгуулах”, “Номын сангийн фондын зохион байгулалт”, “Номын сангийн уншлага, үйлчилгээний ажил” сэдвээр тус тус хичээл заасан. Сургалтаар номын санчид нийт- 40 цагийн хичээл судалж сертификат гардаж авлаа.

2015.04.24.

Нийслэлийн ЕБС-ийн номын санчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх бие бялдраа хөгжүүлэх зорилгоор номын санчдын дунд спортын тэмцээнийг сагс, волейболын төрлөөр зохион явуулсан. Тус спортын уралдаан тэмцээнийг БЗД-ийн номын санчид зохион байгуулав. Энэхүү тэмцээнд бүх дүүргийн номын санчид баг тамирчдаа бүрдүүлэн идэвхтэй оролцсон. Спортын тэмцээнд

1-р байр Алтан медаль СХД-ийн тамирчид

2-р Мөнгөн медаль БГД-ийн тамирчид

3-р байр Хүрэл медаль ХУД-ийн тамирчид тус тус байр эзэлж нөхөрсөг сайхан тоглолт болж өндөрлөв.

2015.05.15

“Уран зохиолын нууцад нэвтрэхүй” сэдэвт уулзалт ярилцлагыг хүүхдийн уран бүтээлчдийн “Эвт үзэг” холбооны гишүүд нийслэлийн ЕБС-ийн номын санчидтай хамтран зохион зохион байгууллаа. “Эвт үзэг” төвийн тэргүүн, хүүхдийн зохиолч О. Сундуй номын санчидтай хүүхдийн зохиолчдын бүтээлийг уншигч багачуудад хэрхэн хүргэх, зохиолч уншигчдын уулзалтыг хэрхэн зохион байгуулах талаар харилцан ярилцаж санал бодлоо солилцсон уулзалт боллоо. Мөн ЕБС-ийн номын санчдын холбоо байгуулах, холбооны дүрмийг боловсруулах, улмаар олон улсын номын сангийн холбоонд элсэх талаар номын санчидтай хамтран ярилцаж санал бодлоо солилцлоо. “Сургууль дээр бидэнд юу тохиолддог вэ?” сэдэвт зохион бичлэгийн уралдааны удирдамжийг танилцуулав. Зохион бичлэгийн сэдэв нь хүүхдийн баяр хөөр, уйтгар гуниг, үерхэл нөхөрлөл, хүсэл мөрөөдөл, томчууд хүүхдийн хоорондын харилцаа саад бэрхшээл зэрэг сургууль дээр сурагч насанд тохиолддог үйл явдлуудын талаар чөлөөтэй бичиж илэрхийлэх бөгөөд ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдын дунд уралдааныг 10 сард зохион байгуулсан. Шагналыг шилдэг уншигчдын сүлд модны наадмын үйл ажиллагаан дээр гардуулан өгөхөөр шийдвэрлэв.

2015.10.21-22

Олон улсын сургуулийн номын санчдын өдрийг 2 дах жилдээ “Сургуулийн номын сангийн цаашдын зорилт” сэдвийн дор зохион явууллаа. Энэхүү баярын өдөр номын санчид харилцан санал бодлоо солилцож дүүргийн ахлагч нар дүүргийн номын сангийн үйл ажиллагааны талаар персентаци бэлтгэж тавьлаа. Шагналын хур буусан баярын өдөр болж номын санчдыг шагнаж урамшууллаа. Мөн Баян-буурал амралтын газар сургуулийн номын санчид хамт олонтойгоо чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүллээ.

2015.11.27

Чингэлтэй дүүргийн мэргэжлийн хяналтын газартай хамтран хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулийн номын санчдад номын сангийн анхан шатны бүртгэлийн хөтлөлт, ангилал, картын сангийн зохион байгуулалт, соёлын ажлыг хэрхэн зохион байгуулах талаар анхан шатны мэдлэг олгож сургалт зохион байгууллаа. Дүүргийн 5 сургуулийн номын санчид оролцсон. Номын санчдад хэрэгцээт гарын авлага болон ном бэлэглэсэн.

***Аргачлал боловсруулах*:**

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
4	7	175 %

- “Номын ертөнц” дүрийн тоглолттой уншигчдын бага хурал
- “Эрдмийн баяр” сэдэвт өдөрлөг хэрхэн зохион байгуулах тухай аргачлал
- Шидэт номын найзууд уран үсгийн чуулганы хөтөлбөр
- Мэргэжлийн холбогдолтой монгол орос англи хэл дээрх номын жагсаалт
- Хүүхдийн хэл ярианы хөгжилд номын гүйцэтгэх үүрэг, номтой нөхөрлүүлэх үйл ажиллагаа
- Фондын судалгаа / аргачлал/
- Тооллогын бэлтгэл ажлууд, ба тооллого тооллох аргууд зэрэг аргачлалыг боловсрууллаа.

Мөн “Нийтийн уншлагыг дэмжих олон талт арга хэмжээг зохион байгуулах журам”-ыг эхний байдлаар боловсруулж, БСШУЯ-нд өгөөд байна.

“Номын санч” сэтгүүлд мэдээ, мэдээлэл бэлтгэх:

Онол арга зүйн 2 мэдээллийг тус сэтгүүлд нийтлүүлэхээр өгөв. Үүнд:

- “Номын сангаас зохиох соёл танин мэдэхүйн ажил” – Олон улсын сургуулийн номын санчдын өдрийг тэмдэглэж ирсэн түүхээс арга зүйч Л.Батболор.
- “Ном уншлагын аргаар хүүхдийг төлөвшүүлэх нь” сэдэвт цуврал материалын үргэлжлэл - номзүйч С.Тунгалаг.

2015 оноос “Номын санч” онол арга зүйн сэтгүүл хагас жилд 1 удаа жилдээ 2 дугаар гарах болсон. Сэтгүүлд онолын материал авах шаардлага тавьж байгаа учраас ХНО-ны танхимуудын үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг нэгтгэж оруулаагүй болно.

Арга зүйн бусад ажил: Арга зүйч Л.Батболор:

- СУ судалгааны статистик мэдээллийг нэгтгэж БСШУЯ-ны мэргэжилтан Болдод e-mail хаягаар явуулсан.

- Захиралд 2004-2014 оны ХНО-оос зохион байгуулсан соёл танин мэдэхүйн ажлын статисик мэдээ тоог нэгтгэж өглөө

- ЕБС-ийн номын санчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж захиралд өгөв.

- БШСУЯ-ны мэргэжилтэн Баяраад нийслэлийн ЕБС-ийн мэргэжлийн бус бакпаврын зэрэгтэй номын санчаар ажиллаж байгаа хүмүүсийн судалгааг нэгтгэж e-mail хаягаар явууллаа.

- Хэлтсийн эрхлэгч Г. Буянцэцэгт ХНО-ыг 2015-2020 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөнд тусгах арга зүйн ажлын талаар санал өгөв.

Номзүйч С.Тунгалаг:

- Д. Жамъянгийн 5 боть шинэ номын нээлтэнд үзүүлэнт танилцуулга бэлтгэх аргачлалыг каталогчид өгсөн.

- 52-р цэцэрлэгийн ахлах ангид номын булан байгуулж, зөвлөгөө өгсөн.

- СУИС-ийн оюутны дадлагын хуваарийг гаргаж, Уншлага үйлчилгээний хэлтсийн эрхлэгчид хүлээлгэн өгсөн. 2015-04-16, 22-ны өдрүүдэд СУИС-ийн соёлын менежерийн төгсөх курсын оюутан Мөнхгэрэлийг ХНО-ны бичиг баримтуудтай танилцуулж, зохих материалуудыг бэлтгэж өгч, 2015-10-28нд СДС-ийн номзүй-мэдээллийн ангийн 3 оюутны дадлагын хуваарь гаргаж, удирдаж ажилласан. Мөн утсаар 8 удаа зөвлөгөө өгсөн.

- Нийслэлийн засаг даргын тамгын газар, Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас зохион байгуулдаг нийслэлийн “Шилдэг хүүхэд” шалгаруулах болзлыг гаргаж нийтэд сурталчиллаа.

Каталогч Д.Жавзанпагма:

- Ерөнхий боловсролын сургуулийн номын санчдын 2 удаагийн сургалтанд электрон каталогт ном хэрхэн оруулах талаар товч хичээл орж дадлага хийлгэв.

Сэргээн засварлагч Б.Эрдэнэцэцэг:

- “Их мэдэх” танхимын номын санч Г.Дарьсүрэнгийн орос хэлнээс орчуулсан “3 Баавгай” орос ардын үлгэр номыг редакцлав. Уг орчуулгаар танхимын номын санч

уншигчидтайгаа хамтран том ном бүтээн, соёл танин мэдэхүйн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Лавлагаа, номзүйн ажлын хүрээнд:

Номзүйч С.Тунгалаг:

Шинэ номын мэдээ

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
4	4	100%

Бүх уншлагын танхимуудын 291 шинэ номоор мэдээллийг гаргаж уншигчдын хүртээл болгосон.

Номзүйн жагсаалт

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
11	12	109%

Дараах сэдэв, агуулгаар болон зохиолчдын бүтээлийн номзүйн 12 жагсаалт, мэдээллийг гаргав. Үүнд:

- МУ соёлын гавьяат зүтгэлтэн, яруу найрагч орчуулагч Л. Хуушааны уран бүтээл
- Ардын уран зохиолч Б. Баастын уран бүтээл
- Соёлын гавьяат зүтгэлтэн Г. Мэнд-Ооёогийн уран бүтээл
- Дэлхийн шилдэг 50 ботийн жагсаалт
- Үндэсний бичиг соёлын өдөрт зориулсан номын жагсаалт
- МУ соёлын гавьяат зүтгэлтэн, нэрт орчуулагч Г. Акимын уран бүтээл
- 52-р цэцэрлэгт хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон хүүхдийн уран бүтээлийн
- Дан.Нямаагийн уран бүтээл
- “Үндэсний бахархлын өдөр”-т зориулсан номзүйн жагсаалт
- Бага насны хүүхдийн унших номын,

- ХНО хэвлэлийн хуудаснаа ном зүйд тогтмол хэвлэлд нийтлэгдсэн 18 материалыг нөхөн бүрэн эхээр нь шивж оруулсан зэрэг ном зүйн жагсаалт гаргасан.

Лавлагаа амаар болон бичгээр өгөх

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
1520	2075	136,5 %

Ц.Буянзаяагийн “Хадаас” өгүүллэг, Олон улсын номын сангийн холбооны тухай, Сүлжмэл эдлэлийн хийх арга, Боловсролын шилжилтийн үе 1990 оноос өмнө хойно, Л. Цэнд-Очирийн уран бүтээлийн шүүлт, Театрын түүх, Монгол ардын бүжгийн дэглэлт, С.Лочин “Гоё эгч хуушуур хоёр”, “Үрийн заяа гомдох вий” зохиолууд, Островский, Мольерийн намтар, жүжгийн зохиол, Багшийн сургалтын төлөвлөгөөг хэрхэн гаргах, Соёлын үнэт зүйлсийн жагсаалт, Соёлын глобалчлал, Хүүхдийг номтой нөхөрлүүлэх сэдвээр (1986-1990 он), Анхны сургууль байгуулагдсан түүх талаар зэрэг нарийвчилсан бичгийн лавлагааг 1-3 хоног хайлт хийн утсаар болон цахим хаягаар өглөө.

Ном хэвлэлийг сэргээн засварлах ажлын хүрээнд: Сэргээн засварлагч Б.Эрдэнэцэцэг:

Ном, хэвлэлийн сэргээн засварлах ажил.

Ном: Нийт – 559 ширхэг ном сэргээн засварлав.

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
550	559	101,6%

“Боловсрол хөгжил” танхим - 236 ширхэг ном

Архивын фонд - 40 ширхэг ном

“Мөрөөдөл” танхим - 231 ширхэг ном

Герман танхим - 7 ширхэг ном

“Их мэдэх” танхим - 19 ширхэг ном

Дорно дахины танхим - 2 ширхэг ном

Өрнө дахины танхим - 2 ширхэг ном

Санхүү - 17 ширхэг баримт

Архив - 5 ширхэг баримт

Сонин: 98хавтас сонинг нэг бүрчлэн шигшиж, үдэж хавтаслав. Мөн даалимбаар шил наав. Нийт – 55 хавтас сонинг үдэв.

Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
80 хавтас	98 хавтас	122,5%

Байгууллагын архивын баримтыг хавтаслах

Байгууллагын архивын баримтуудыг стандартын дагуу хавтаслан байршуулахад ном бүрдүүлэгч Ч.Энхтуяа, сэргээн засварлагч Б.Эрдэнэцэцэг нар дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд: 216 ширхэг баримтуудыг үдээ болон оёоноос салгаж нэг бүрчлэн шигшив. Санхүү 123 ширхэг, бичиг хэрэг 93 ширхэг байлаа. Тус баримтуудад хавтас эсгэж, үдэж, оёж, хавтаслан шил наав.

Ном сэргээн засварлах сургалт, арга зүйн ажил:

- 3-р сарын 26-нд Дорнод аймгийн ЕБС-н 20 номын санчид ном сэргээн засварлах онол, практик хосолсон сургалт явуулав.
- 10-р сард Гёте институт, Төв Архиваас хамтран хөдөө орон нутгийн архивын 30 ажилтнуудад зохион байгуулсан 3 хоногийн сургалтанд эксперт багшаар ажилласан.
- Гёте институтээс эрхлэн 5 хэлээр гаргаж буй “Сэргээн засварлах нэр томъёоны толь бичиг” номын нэр томъёог орчуулан гаргахад оролцов.
- Гёте институт, ЮНЕСКО-той хамтран “Хадгалалт хамгаалалт, сэргээн засварлах” гарын авлага гарган хэвлүүлэх үйл ажиллагаанд байгууллагын нэрийн өмнөөс оролцов. /Хүүхдийн Төв Номын Сангийн нэр болон лого тус номын нүүр хавтсан дээр хэвлэгдэнэ/

2. Уншлага үйлчилгээний ажил

Бүтээгдэхүүн	Төлөвлөгөө	Биелэлт	Гүйцэтгэл
ЕБС-ийн уншигч /2000төг/	1400	1633	116%
Насанд хүрэгчид, оюутан /3000төг/	1900	1914	101%
Нийт	3300	3547	107%

2014 онд Lib4U программын дагуу өдөр тутмын бүртгэлийг тогтмол хөтлөн нийт 3547 уншигчдад үнэмлэх нээж 8592 000 мянган төгрөгний орлогыг санхүүд тушаалаа. Үүнээс ЕБС-ийн сурагч 1633 ш, насанд хүрэгчид, оюутан 1914 ш уншигчийн үнэмлэх нээж үйлчилсэн. Үнэмлэх нээлгэсэн уншигчдын тухайн өдрийн он, сар, өдөр, овог, нэр, код зэргийг бичиж тооцооны тасалбарын хамт санхүүд тушааж байна.

Уншигчийн үнэмлэх шинээр нээлгэж байгаа уншигчдад ХНО-ны уншлагын танхимууд болон тэдгээрээр хэрхэн үйлчлүүлэх талаар заавар зөвлөгөө байнга өгч ажилласан.

Мөн мэдээллийн санд орсон уншигчдын мэдээлэл дутуу, 1 уншигчийн мэдээлэл олон дахин давхардсан, зарим уншигчийн үнэмлэх гараагүй, гарсан үнэмлэх нь 2,3 давхардсан зэрэг зөрчлүүд нилээд байсныг шүүж гараагүй үнэмлэхийг дахин гаргаж давхардсан үнэмлэхийг цэгцлэн карт нээлгэж байгаа уншигч бүрийн mail хаягыг мэдээлэлд нь оруулж байна.

Энэ нь гэрээр ном их гарч байгаатай холбогдуулан уншигчтай мэдээлэл солилцох, номын хугацааг сануулах зэрэг ач холбогдолтой.

Танхимуудын ирц ном олголт:

	Ирц			Ном олголт			Байрлуулалт		
	төл	Бие	хувь	төл	бие	хувь	төл	бие	хувь
Монгол фонд				37000	39577	101%	38000	38001	100%
Боловсрол хөгжил	26000	28178	108%	37000	38792	104%			
Мөрөөдөл	13000	13270	100%	24000	25432	105%	24300	25432	105%
Их мэдэх	4260	4933	115%	6000	13341	222%	6050	13833	228%
Герман	4500	7337	163%	8000	10472	131%	8000	10472	231%
Дорно	600	747	124%	1500	2006	133%	1500	2006	133%
Өрнө	3830	5412	141%	5600	7901	141%	5600	8376	149%
зөөвөр		**12995**			**9719**				
Нийт	**52190**	**72872**	**140%**	**119100**	**147240**	**123%**	**83450**	**98120**	**117%**

Зөөврийн номын сангийн үйлчилгээ:

д/д	Төв	Хүргэгдсэн номын тоо	Ном олголт	Ирц
1	“Содномун” ТББ	250	362	417
2	“Хүрээ тулга”дунд сургууль	400	1012	1512
3	“Өсвөр үеийн хөгжлийн төв”	150	236	207
4	Дэлхийн зөн Баянхошуу төв	320	1502	2132
5	Хотын захын гэр хорооллыг хөгжүүлэх сан	400	417	508
6	Харааны бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургууль	50	134	162
7	Сургалт үйлдвэрлэлийн Гэгээрэл төв	300	420	453
8	Сакура дунд сургууль	200	306	565
9	49-р цэцэрлэг	150	221	456
10	Хүслэн цэцэрлэг	280	400	617
11	189-р цэцэрлэг	300	530	816
12	Налайх 119-р сургууль	300	454	1070
13	110-р сургууль/ хорих анги/	200	252	229
14	Дэнжийн-1000	250	324	278
15	72-р цэцэрлэг	0	0	0
17	Нобелийн шагналтнууд хүүхдийн номын сан	350	806	1183
18	Чингэлтэй дүүргийн иргэний оролцооны хэлтэс	200	628	313
19	ШШГЕГ-ын харъяа 407-р анги/эмэгтэйчүүдийн хорих/	400	1098	1149
20	Өнөр бүл төв	180	127	507
21	ШШГЕГ-ын харъяа 421-р анги/эрэгтэйчүүдийн хорих/	200	398	329
22	66-р цэцэрлэг	60	92	92
	Нийт	4940	9719	12995

Зөөврийн номын сан нь 21 төвтэй хамтран ажиллаж 22 төвд **4940** ном хүргэж **13751** ирцэд **9719** ном уншуулсан байна. Энэ онд шинээр Гэр бүл хөгжлийн “Өнөр бүл” төв, ШШГЕГ-ын харъяа 407-р анги /эмэгтэйчүүдийн хорих/, ШШГЕГ-ын харъяа 421-р анги/эрэгтэйчүүдийн хорих/ хамтран ажиллалаа.

Танхимууд гэрээр ном олгосон байдал.

	Нийт ном олголт	Гэрээр	Танхимд
Монгол фонд	39577	**5974**	33603
Боловсрол хөгжил		-	
Мөрөөдөл	25432	2983	22449
Их мэдэх	13341	1484	11857
Герман	10472	4068	8988
Дорно	2006	221	1785
Өрнө	7901	476	7425
Нийт	**98729**	**15206**	**86107**

Дотоод ажил:Хүснэгт 1

Танхимууд	Ангил -сан ном	Данс	Эл каталогт нөөц үүсгэсэн номын тоо	Зохиогчийн тэмдэгт засах,редакц хийсэн ном	Зур. коджуулсан, таагжуулсан номын тоо
Монгол фонд			Ф.19 нэр т. 76 ш ном Архивт 28 нэр т. 28 ш ном 47 нэрийн 104 ш ном	Ф 1270 ш ном, архив 260 ш нийт **69 ред** **Нийт 1569**	172 зураасан код Фондын 172 ш, архивын 288 ш нийт 460 ш баркод Катлогчоос ирсэн 518ш баркод наав. Нийт 978 баркод
Боловсрол хөгжил					
Мөрөөдөл			5	973 ред	300 зураасан код
Их мэдэх			18	200	150 ялтас
ГМНС	**282**	**282**	307ш		282 ялтас
Өрнө дахины танхим			208	160 ред	
Дорно дахины танхим	169	169	7нэрийн 25 ш ном	-	169

Дүн	**451**	**451**	**563**	**2902**	**1889**

Хүснэгт 2

Танхимууд	Фонд баяжилт /ш/	Сэргээн засварлагчид /ш ном/	Солил Зөөвөрт гэрээр	Хяна л-тын карт	Лавл а-гаа	Шинэ номын мэдээнд /С. Тунгалаг/
1.Монгол фонд	**1080** ш ном, **19** ш CD, Архивт **54** ш ном, **13** ш CD	Ф-ын 236, Архив 40 **нийт 276 ш** Ф-ын 98 хав сон, Архивын фондын 5 төрлийн **20** хавтас **нийт 118 хав** сонинг үдүүлэв	ХИДС- 46 ш ном, Багануурын сур 30 **нийт 76 ш ном сол**		1215	116 ш ном
3.Мөрөөдөл	499 шинэ ном ,38ш CD	230 ш ном	21 ш сол 53 ш ном зөөвөр			27 ш ном
4.Их мэдэх	450 ш ном, 42 CD	19	Зөөвөрт 22	120		100
5.ГМНС	66 ш ном, 210 ш АВ мат, Конрад Аденауэрын сангаас 3ш Германы Элчин Сайдын Яамнаас 1ш ном тус тус бэлгээр авч, фондоо баяжууллаа. **Нийт 70 ш ном 210 CD**	6 ш ном		400		15
6.Өрнө дахины танхим	54 ном, 3 CD	2	10 зөөв			
7.Дорно дахины танхим	276 ш ном	1ш ном, 2 хав сонин	Сол- 6, Зөөвөрт 30 ш ном			15 ш ном
Дүн	**2483 ш ном, 325АВ мат**	**534 ш ном,120 ав сонин**	**103 ш сол 115зөөвөр**	**520**		**273 ш ном.**

Зөөврийн номын сан нь 21 төвтэй хамтран ажиллаж 22 төвд 4940 ном хүргэж 13751 ирцэд 9719 ном уншуулсан байна. Энэ онд шинээр Гэр бүл хөгжлийн “Өнөр бүл” төв, ШШГЕГ-ын харъяа 407-р анги /эмэгтэйчүүдийн хорих/, ШШГЕГ-ын харъяа 421-р анги/эрэгтэйчүүдийн хорих/ хамтран ажиллалаа.

Танхимууд гэрээр ном олгосон байдал.

	Нийт ном олголт	Гэрээр	Танхимд
Монгол фонд	39577	**5974**	33603
Боловсрол хөгжил		-	
Мөрөөдөл	25432	2983	22449
Их мэдэх	13341	1484	11857
Герман	10472	4068	8988
Дорно	2006	221	1785
Өрнө	7901	476	7425
Нийт	**98729**	**15206**	**86107**

Танхимуудад хийгдсэн бусад ажил:

Үнэмлэх нээлтийн ажилтан:

- Мөрөөдөл танхимын номын санч Т.Бямбасүрэнд Согоон цэцэг, Ойн гүнд голын хөвөөнд 2 ш ном, Өрнө дахины танхимын татгалзалын болон лавлагааны дэвтэр, Нугасны муухай дэгдээхий, Ямх охин үлгэрийг скайнардаж presentation бэлтгэв.
- Өрнө дахины танхимд “Countdown to grandma house” үлгэрийг скайнардаж, “Nigh nigh forest friends” үлгэрийн 8% канондаж өгсөн.
- Монгол номын фондод 200 ш, Өрнө дахины танхимд 80 ш гэрээр ном олгох хяналтын карт хэвлэж, зүсч өгсөн.
- Чойномын “Залуу нас” дугуйлангийн уулзалтын хаяг, Андерсений 210 жилийн ойгоор уран зураг, эссэ бичлэгийн уралдаанд шалгарсан бүтээлүүдийн үзэсгэлэнгийн хаяг, Д.Пүрэвдоржийн “Хар цас” найраглалаар хийсэн уран уншлагын уралдааны өргөмжлөлийг хийсэн.
- Өрнө дахины танхимд 12 ш санамжийг люминатордож өгсөн.

•	Ө. Бадамсэд “Чөлөөлөх дайны түүхт 70 жил” сэдвээр 26 ширхэг номоор номзүйн бүртгэл хийсэн.

•	10-р сарын 7-нд Нийслэлийн 5-р дунд сургуулийн 6”а” ангийг номын сантай танилцуулан 38н хүүхдэд уншигчийн үнэмлэх нээсэн.

•	Мөн 11-р сарын 3-нд ” Номонд дуртай монгол хүүхэд” аян зохион байгуулсан баян хошууны 49, 72-р дунд сургуулийн 27-н хүүхдийг номын сантай танилцуулав.

•	С.Адъяанямд 40 ширхэг номын бүртгэлийн хуудас канондаж өгсөн.

Монгол фондын номын санчид :

•	2009 -2011 оны 124 хавтасласан сонингуудыг зөөж тавиурт байрлуулсан.

•	2011-2014 оны архивын 5 төрлийн сонин, 2014 оны 4-р улирал, 2015 оны 1-р улирлын өдөр тутмын сонинг үдэлтэнд бэлтгэж өгч үдүүлсэн. (20 хавтас)

•	Каталогич Д.Жавзанпагмад редакци хийх 30 ширхэг ном өгч буцаан авсан

Их мэдэх танхимын ажилтан:

•	Их мэдэх танхимд байгаа орчуулгын уран зохиолын 2500 гаруй номыг номыг цэгцлэн редакц хийн зөрчилтэй 500 гаруй номыг ялгаж программд оруулав.

Герман танхимын ажилтан:

•	2015 онд 904 шинэ уншигч манай танхимд бүртгэгдлээ.

•	Танхимын номонд Формуляр шинээр 400 ширхэгийг хэвлэн, гэрээр олгож буй номонд нааж, буцах хугацааг тэмдэглэн үйлчилгээ үзүүллээ.

- Шинээр фондонд орж буй 210 аудио визуал материал, 72 ном бүгд 282 ш ном аудио визуал материалыг DDC ангиллаар ангилж, данслан, ялтас наав.
- Электрон каталогт 307 ш ном оруулснаас 210 АВ мат, 79ш ном, нийт 289 нэрийн шинэ, каталогт ороогүй байсан хуучин 18 ном байлаа. Гёте-Институтийн төлөөлөгчийн газарт 31 нэрийн 31 ном, материалыг шилжүүлж, каталогийн бүртгэлээс хассанаар 263 нэрийн 265ш, үүнээс 189 АВ материал, 76 ном каталогийн болон нэгбүрчилсэн дүнгээр программын бүртгэлд тусгагдсан болно.

•	Хэлний сургалтын 1номыг цавуутай гялгар уутаар хавтаслав.

- Аудио видео материал шинээр их ирсэнтэй холбогдуулан чөлөөт сонголтоор байрлуулж буй CD болон DVD-нд зориулж бичгийн цаасаар шинээр 80 ш уут хийж, дансны дугаараар шоголд байрлуулав.

- 3-р сард жаз хөгжмийн 10 ном, 21CD нийт 31 ш ном АВ материалыг мэдээллийн бааз болон данснаас хасалт хийж, Гёте-Институтийн төлөөлөгчийн газарт шилжүүлэн хүлээлгэж өгөв.

Зөөврийн номын сан:

- Зөөврийн номын сан нь 20 төвтэй хамтран ажиллаж байна. 2015 оны эхний хагас жилд шинээр Хүүхэд асран хамгаалах “Өнөр бүл” төв, Эмэгтэйчүүдийн хорих төв, Амгалан дахь хорих ангитай гэрээ хийж хамтран ажиллаж байна.

- 2015.1.30. Азийн сан, ДЗМОУБ-ын ХУД-ийн хөгжлийн хөтөлбөртэй хамтарсан “Ухаалаг хотын оюунлаг хүүхдүүд” хамтын ажиллагаанд зөөврийн номын сан хамтран ажиллаж байна. Энэхүү хамтын ажиллагаанд оролцож буй номын клубын сурагчдад уншуулах номын хуваарилалтыг хийж гардуулж өглөө.

- 2015.3.10 Зөөврийн номын сангийн орон тооны талаарх мэдээллийг УҮХ-ийн дарга Г. Дарьсүрэнд гаргаж өгсөн.

- 2015.6.22. Зөөврийн номын сангийн төвүүдийн нэр, байршил, уншуулсан ном, ирцийг графикаар англи, монгол хэл дээр хийлгэж захиралд өглөө.

Өрнө дахины танхим:

- Европ фондонд байгаа 2031 ш актлах номын жагсаалтанд тухайн номын падан фактурын он, дугаарыг шүүн нэмж бичив.

- Номын сангийн нарийвчилсан лавлагааг танхимын номын санчид 65 удаа, аман лавлагааг 2300 орчим хүнд өгсөн байна.

Монгол фонд: Аман лавлагааг 654 хүнд өгсөн

Мөрөөдөл танхим:

- 2015.04.13. Сүхбаатар аймгийн Хүүхдийн төв номын сангийн номын санч Цолмонтуяад танхимын үйл ажиллагааг танилцуулан, фондын зохион байгуулалтын талаар лавлагаа өгөв.

• 2015.04.14. БЗД-гийн “Бумбардай” цэцэрлэгийн эрхлэгч Гантуяад хүүхдийн жүжгийн зохиол сонгоход лавлагаа өгч, номыг шүүж өгөв

• 2015.10.13. СУИС-ийн Соёлын сургуулийн номын сангийн 3-р курсын оюутан Ш.Долгорсүрэнд ном хэрхэн байрлуулах ,фондын бүтэц зохион байгуулалт номын сангийн ангилалын талаар зааварчлан, ”Луу зураач” Хятадын үлгэрээр уншигч сурагчдад чанга уншлага хийх дадлага хийлгэв.

• 2015.10.14. Налайх дүүргийн “Хос уянга” сургуулийн бага ангийн багш Бадамжавт номын сангаар хэрхэн үйлчлүүлэх талаар лавлагаа өгөв.

Их мэдэх танхим: 2 удаа, аман лавлагааг 1000 орчим

• 25 р цэцэрлэгийн хөгжмийн багшид 0-3 насны хүүхдийн дууны номыг шүүж олж өглөө.

• Хүүхдийн жүжгийн зохиол, орчуулгын номын тойм мэдээг МУИС ийн 4 дамжааны оюутанд өглөө.

Герман танхим: 2 удаа

• Герман танхимын ажилтнууд 2-р сарын 6 нд СУИС-ийн оюутан, уншигч Б. Шинэбаярт германы ардын дууны талаар нарийвчилсан хайлт хийж, мэдээлэл өгөв.

• 5-р сарын 28-нд “Мэдээллийн лавлах 1616”, 9-р сарын 21-нд “Мэдээллийн лавлах 1199”- д ХНО-ны талаарх ерөнхий болон танхимуудын цагийн хуваарийн мэдээллийг утсаар өглөө.

Өрнө дахины танхим: Аман лавлагааг 298 хүнд

• TOEFL, SAT , IELTS –ийн шалгалтын номын тухай, Орос англи хэл дээрх Дэлхийн сонгодог уран зохиол, танин мэдэхүйн, Монголын түүх болон соёл урлаг , уран зохиолын англи орос хэл дээр хэвлэгдсэн номууд, Easy reading, Народные сказки, Atlas world, Subtitle – кинонуудын тухай, Орос хэл дээр Хөгжмийн лавлах толь, Орос хэлний дүрмийн тухай ном, Сэтгэл судлалын номын тухай лавлагааг 298 уншигчдад өгчээ.

Дорно дахины танхим:

• Монгол улсад солилцоогоор ирсэн солонгос 2 оюутанд Хүүхдийн номын ордон болон танхимын үйл ажиллагаа болон солнгос хэл дээрх номнуудыг танилцуулсан.

• Хотын номын сангийн дэд захиралд танхимын үйл ажиллагааг танилцуулав.

• Дархан хотоос ирсэн шилдэг уншигч танхимын үйл ажиллагааг танилцуулав.

• Монсудар хэвлэлийн компаний Хүүхдийн номын редакци япон, солонгос, тайваний хүүхдийн уран зохиолын номын хэвлэлтийн талаар танилцуулав.

Зөөврийн номын сан: 300 удаа аман лавлагаа

• Уншигч оюутан залуучуудад электрон каталог ашиглах талаар, электрон каталогоос ном шүүх арга, захиалгын хуудсын бичилт хийх лавлагааг 300 гаруй хүүхдэд, фондоос гэрээр ном авах үйлчилгээний талаарх мэдээ мэдээллийг цаг тухайд нь өгч үйлчиллээ.

• Мөн хүүхдийн номын ордны үйл ажиллагаатай танилцахаар ирсэн оюутан залуучууд, сурагчид, эцэг эхчүүд хөдөө орон нутгаас ирсэн номын санчид болон хэвлэл мэдээллийн ажилтан нарт цаг тухайд нь танилцуулга мэдээлэл өгч ажиллалаа.

Гадаад харилцаа:

Герман танхим:

• Танхимын үйл ажиллагааны 2014 оны дэлгэрэнгүй тайланг 1-р сарын сүүлчээр Сөүл дэх зүүн Азийн бүсийн номын сангийн захирал Андреа Бах, Гёте-Институтийн монгол дахь төлөөлөгчийн газрын захирал Сэбастиан Войч нарт электрон шуудангаар явууллаа.

• Танхимын үйл ажиллагааны талаар Гёте-Институтийн төлөөлөгчийн газартай утсаар болон электрон шуудангаар харилцаж, сард 1 удаа уулзаж ярилцан мэдээлэл солилцож ирлээ.

• 2015 онд фондоос хасах хэлний шинжлэх ухааны болон бусад шинжлэх ухааны номын жагсаалт, мөн шинээр захиалах хэлний шинжлэх ухааны номын нийт 3 төрлийн жагсаалтыг гаргаж Гёте-Институтийн төлөөлөгчийн газарт явууллаа.

Дорно дахины танхим:

• Тайваний Үндэсний номын сангаас 10 ш ном 390 мянга 118 төгрөгийн үнийн дүнгээр үндсэн хөрөнгөд бүртгэгдэв. Хүүхдийн номын ордноос бэлгээр 587 мянга 240 төгрөгийн 53 ш ном, худалдаагаар 180 мянган төгрөгийн 15 ш шинэ номын бүрдүүлэлт хийгдсэн.

• Тайваний Үндэсний номын сангийн гадаад солилцооны номын санчтай e-mail-ээр шинэ оны мэнд болон цагаан сарын мэндчилгээг явуулсан. Мөн онлайнаар шинэ оны эхний ном захиалга 1 удаа өгсөн.

• Күнзийн институтээс хэл шинжлэлийн хятад хэл дээр хэвлэгдсэн ном болон сэтгүүлийг манайд бэлгээр өгч болох хүсэлт тавьсаныг хүлээн авч тодорхой нэр төрлийн номыг өөрсдийн боломжоор өгч болно гэсэн хариу өгсөн юм. Мөн өөрсдийн эрхлэн гаргадаг монгол-хятад хэл дээрх орчуулга зүйн сэтгүүлийн шинэ дугаарыг манай танхимд бэлэглэлээ.

Танхим танилцуулсан байдал: ХНО-ны танхимын ажилтнууд давхардсан тоогоор нийт 3325 ЕБС-ийн сурагчид болон оюутнууд , 387 багш номын санч эцэг эхчүүдэд танхимын үйл ажиллагааг дэлгэрэнгүй танилцуулсан байна.

Жил д	**Байгууллагын нэр**	**Танхимын нэр**	**Оролцогсодын тоо**		
			Оюутан Хүүхэд	**Багш**	**Номын санчид**
1	161-р цэцэрлэгийн хүүхдүүд, багш Баянхонгор аймгийн номын санчид Нийслэлийн 105-р сургуулийн 4-р ангийн сурагчид Дорнод аймгийн номын санч нар Нийслэлийн28-р сургуулийн сурагчдад танхим танилцууллаа. /Номын санч Гүржавтай/ Гэр бүл хөгжлийн “Өнөр бүл” төвийн хүүхэд, багш нарт ХНО-ны 6 танхимыг танилцууллаа.	Боловсрол хөгжил танхим	400		
2	67-р сургуулийн 4з анги, 28-р сургуулийн 6-р анги, “Шинэ-Монгол” сургуулийн 7-р анги, 24-р сургуулийн 4е анги, 3-р сургуулийн 6-р анги, 97-р сургуулийн 3-р ангийн сурагчдад, 84-р сургуулийнхаа 6б ангийн 45 сурагч , 6в ангийн 46 сурагч,6г ангийн 50 сурагч, 7а ангийн 42 сурагч, 5-р сургуулийн Тогтохсүрэн багштай 6а анги, 97-р сургуулийн 4д ангийн 36 сурагч, 84-р сургууль 6г ангийн 50 сурагч, 38-р сургуулийн 6-р ангийн 2 бүлэг,1-р сургуулийн 1б ангийн сурагчид эцэг эхийн хамт, 12-р сургуулийн 5-р ангийн сурагчдад болон “Хүүхэд асрах төв”-ийн 56 хүүхдэд танхимын үйл ажиллагааг танилцуулав	Мөрөөдөл	**425**		

3	Төв Баяндэлгэр сум 2-р ангийн сурагчид 161-р цэцэрлэг / 7 анги /,75-р цэцэрлэг /1 анги/ 162-р цэцэрлэг / 4 анги/, 86-р цэцэрлэг /4 анги/ “Соёмбо” сургуулийн 2 анги, Оюуны ундраа 2 ангиуд,67-р сур 2 анги,161 цэцэрлэг,Бамбархан Оньсхон, 3-р сур 6 анги, СУИС-ийн соёлын менежерийн ангийн оюутнууд, “Маамуу нааш ир” 81 цэцэрлэг, 81,84,32, 121-р цэцэрлэг, 3,169,51,82-р цэцэрлэг, 4-р сур 3 анги, 21-р сур 4 анги, 24-р сур 2 ж анги, 67-р сур 3 анги, 3 сур 7 анги Нийт 17 цэцэрлэг, 21 анги, 10 сургууль, 17 анги зочилсон байна.	“Их мэдэх” танхим	**1108**	55	314
4	Хан уул дүүргийн, 14-р сургуулийн 8-р ангийн 24 сурагч 105-р сургуулийн 180 сурагч,Хөгжлийн бэрхшээлтэй 14 хүүхэд, сургалтанд оролцогч, Дорнод аймгийн 17 номын санчид, “Их мэдэх” танхимд зочилсон эцэг эхчүүд 30 хүн, СУИС-ийн “Соёлын менежмент” эчнээ 5 оюутан, 45-р сургуулийн 11-р ангийн 9 сурагч ,нийслэлийн ЕБС-ийн 10 номын санч “Шинэ Монгол” сургуулийн 7-р ангийн 50 сурагч, БГД-ийн хувийн цэцэрлэгийн 15 эцэг эхчүүд, “Өнөр бүл” хүүхдийн асрах төвийн 27 хүүхэд, 5-р сургуулийн 6-р анги 15 сурагч, 84-р сургуулийн 6-р анги 25 сурагч, ТББ-ийн шугамаар 27 сурагч, 38-р сургуулийн 4-р ангийн 10 сурагч, 38-р сургуулийн 6-р ангийн 14 сурагч, 38-р сургуулийн 4а ангийн 27 сурагч, 44-р сургуулийн 11-р ангийн 33 сурагч ,45-р сургуулийн 12 сурагч,12-р сургуулийн 5в ангийн 38 сурагч	Герман танхим Буянцэцэг	**502**		
	Баянхонгор аймгийн нийтийн номын сангийн 15 номын санчид, Дорнод аймгийн ЕБС-ийн 13 номын санчид, Их мэдэх танхимын сургалтанд ирсэн 16 аав ээж нарт, ЕБ-ын 14-р сургуулийн Улаан загалмайн гишүүн 18 сурагчид, 105-р сургуулийн 4-р ангийн 40 сурагчид. “Шинэ Монгол” дунд сургууль, ЕБ-ын 45, 28, 97, 3-р сургуулийн 3-9 ангийн нийт 193 сурагч болон номын санчдад.	Дорно дахины танхим			18
	14-р сургуулийн 8а анги, 105-р сургуулийн 4-р анги, 60-р сургуулийн 6-р анги, “Ухаалаг хотын оюунлаг хүүхдүүд” төсөлд хамрагдсан алслагдсан дүүргийн ЕБС-ийн сурагчид, 75-р цэцэрлэгийн эцэг эхчүүд, Хан уул дүүргийн алслагдсан ЕБС-ийн номын санчид, Дорнод аймгийн номын санчид, “Шинэ монгол” дунд сургуулийн 7-р ангийн сурагчид,28-р сургуулийн 10,11-р ангийн сурагчид, номын санч, Дүүргүүдийн ЕБС-ийн номын	Өрнө дахины танхим			

	санчид, 97-р сургуулийн 3-р ангийн сурагчид, 28-р сургуулийн 6-р ангийн сурагчид, багш, 28-р сургуулийн 4-р ангийн сурагчид, багш		800		
	“Ухаалаг хотын оюунлаг хүүхдүүд” төсөлд хамрагдаж буй эхний сурагчдыг ХНО-той танилцууллаа.		90		
			3325	**55**	**332**

Цахим хуудсанд: ХНО үйл ажиллагаа, соёл танин мэдэхүйн ажлын тухай 62 орчим мэдээ мэдээлэл 168 зураг байршуулжээ.

Монгол номын танхимын номын санч Д. Энхчимэг 2013 оноос Хүүхдийн номын ордны фейсбүүк хуудас нээж, болох үйл ажиллагааны зарлал, мэдээлэл, зураг, уншигчдын сонирхсон асуултанд хариулах гэх мэтээр хөтлөн явуулж байна.

№	**сэдэв**	**Танхимын ажилтны нэр**	**Мэдээ мэдээллийн тоо**
	Нийт **7** ширхэг мэдээлэл, зарлал, **168** ширхэг зураг оруулсан. Шилэн дансны хууль тогтоомжийн дагуу шинээр цэс нэмж, шилэн дансны нэгдсэн портал системтэй холбосон. Мэдээлэл арга зүй, техник ажиллагааны хэлтсийн 2015 оны I улирлын тайлан оруулж цэсийг засварласан Хүүхдийн төв номын сангийн facebook хуудсыг хөтлөн ажиллуулж байна.	Д.Энхчимэг	**7мэдээ мэдээлэл 168 зураг**
	1945 оны чөлөөлөх дайны түүхт 70 жилийн ойд зориулж дайны гол зорилго, ач холбогдол, үр дүнгийн талаар.чөлөөлөх дайн, дайнд оролцсон ахмад дайчид, ахмад дайчдын дурсамж, дуртгалын тухай бичигдсэн номын жагсаалт гаргаж тавьсан.	З.Алтанцэцэг	**3 удаа**
	Соёлын ажлын урилга, Дэлхийн хүүхдийн номын баярын өдөр зохион явуулсан Соёлын ажлын талаарх мэдээллийг байгууллагын вэб-д оруулсан. Өглөө.мн сайт нь манай уран бичлэгийн дугуйлангийн талаарх мэдээллийг нийтэлсэн байна. /2015.01.26/	Д. Алимаа	**12 удаа**

	Уран бичлэгийн дугуйлангийн хүүхдүүд “ХНО дугуйлан” ийн зар мэдээг Танхимын үйл ажиллагааны мэдээллийн самбарт зохион явуулж байгаа соёлын ажлын талаарх мэдээ мэдээллийг өнгөтөөр хэвлэж байрлууллаа.		
	Танхимаар уншуулж байгаа SAT–ын шалгалтанд зориулагдсан номуудын танилцуулга, “Англи хэлийг маш хурдан сурах нууц арга“ англи хэл сурах аргын тухай.(1-р хэсэг) “Англи хэлийг маш хурдан сурах нууц арга“ англи хэл сурах аргын тухай.(2-р хэсэг IBT,TOEFL,IELTS шалгалтуудад хэрхэн бэлдэж 100%-ийн тэтгэлгээр олон улсын ямар сургуульд хамрагдах вэ? танилцуулга Л. Керролл. “Алиса гайхамшгийн оронд“ зохиолын 150 жилийн ойд зориулсан зохиолын танилцуулга, уг зохиолыг аль танхимаас хэрхэн унших номын заалт зэргийг, Дэлхийн номын болон зохиогчын эрхийн өдөрт зориулсан зохиогчийн болон номын тухай мэдээлэл **1945 оны чөлөөлөх дайны 70 жилийн ойг угтсан цуврал**: • 1-р хэсэг Зөвлөлт-Японы дайн (1945 он) мэдээлэл, • 2-р хэсэг Д.Пүрэвдорж “Хар цас” найраглалыг сурталчилах зорилгоор бүрэн эхээр нь, • Д.Пүрэвдорж “Хар цас”найраглалаар уран уншлагын уралдаан зарлаж болзолыг байршууллаа. • МУ-ын Зэвсэгт Хүчний бэлтгэл хошууч Ц.Баатаржамцтай “Миний эх орон” сэдэвт уулзалтын мэдээлэл	ХНО-ы цахим хуудсанд Дорно дахины номын сангийн номын санчид Facebook-д	**15**
	1.2015.1.19нд “Номонд дуртай болох 10 сануулга” мэдээлэл 2.2015.3.23нд Дэлхийн хүүхдийн номын өдөр Х.К.Андерсены нэрэмжит бүтээлийн уралдааны удирдамжийг зөөврийн номын сангийн 10 төвд мэйлээр явуулж, мэдээллийн хуудсыг өөрийн facebook хуудсаар дамжуулан нийтэд хүргэж ажилласан. 3.2015.3.16 “Хүүхдийн уншлагыг сайжруулж, номонд дуртай болгох энгийн аргууд” мэдээлэл оруууллаа.	Зөөврийн номын сан	**4**

	4. 2015.4.19“Ном уншсанаар таны амьдралд гарах 10 өөрчлөлт”		
	Үлгэрийн цагийн зар, мэдээ, мэдээлийг 2 удаа тавьсан. 2015 оны 2 сарын 4-нд Монголд Зориулсан Ном хөтөлбөр Монголд Зориулсан Ном хөтөлбөрийн өдрөөр явуулсан үйл ажиллагааны талаар мэдээ 2 удаа оруулав. Номын баярын мэдээ	Их мэдэх Г. Дарьсүрэн	**6**
	Байгууллагын цахим болон Фэйсбүүк хуудсанд “Уншлагын үдэш” 2 удаагийн үйл ажиллагааны тухай мэдээллийг байршуулав.	Герман танхим	**2**
	Дондогийн Цэвэгмиид Дэлхийн номын өдөр Цагийн жамыг тодруулагч цаасан шувууны сургаал Хүүхдээ сонс Хүүхэд орчноосоо сурдаг 04/ 22 нд Дэлхийн номын өдөр Хүүхэддээ уншуулах шилдэг номын жагсаалт	Мөрөөдөл ХНО-ы цахим хуудсанд Facebook хуудаснаа	**7**
	2015.1.19 . “Номонд дуртай болох 10 сануулга” мэдээлэл **2015.4.9.** Г.Мэнд-Ооёогийн шинэ уран бүтээл, зохиолч уншигчдын уулзалт мэдээлэл. **2015.4.15.** Р.Чойномын нэрэмжит “Залуу нас” утга зохиолын дугуйлан хичээллэнэ мэдээлэл. **Facebook хуудсанд:** **2015.3** Дэлхийн хүүхдийн номын өдөр Х.К.Андерсены нэрэмжит бүтээлийн уралдааны удирдамж, мэдээллийн хуудсыг өөрийн facebook хуудсаар дамжуулан нийтэд сурталчилж ажиллаа. **2015.4.15** Төрийн шагналт, Соёлын Гавьяат зүтгэлтэн яруу найрагч Долгорын Нямаа гуайн уулзалтанд урьж байна. **22015.8.15** “Хүүхдийн сэвлэг үргээх найранд дуртай хүнээ урьдаггүй” мэдээлэл **015.10.6** “Аавын нэр” мэдээлэл	БХ танхим	**6**
нийт			**62 мэдээ мэдээлэл 168 зураг**

Байгууллага сурталчлах нээлттэй өдөрлөг:

2015.8.29 нд Эрх чөлөөний талбайд Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас зохион байгуулсан байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажилд оролцсон. Энэ ажилд байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан самбар гаргаж, Номын сангийн хууль сурталчлах ажлыг Хүүхдийн Төв Номын Сангийн хамт олон хийсэн.

Зөөврийн номын сан

2015.10.10 нд Гэр бүл хүүхэд хөгжлийн газраас зохион байгуулсан хүүхдийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах өдөрлөгт зориулж танхимын үйл ажиллагааны зурагт танилцуулгыг бэлтгэж өглөө.

<u>Соёл, танин мэдэхүйн ажлын хүрээнд:</u>

Сэдэвчилсэн болон шинэ номын үзэсгэлэн

Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг: 35 удаа 564 ш ном, 30 CD

Шинэ номын үзэсгэлэн: 24 удаа удаа 320 ш ном ш ном болон 63 АВ материалаар үзэсгэлэн гаргасан байна.

Д / д	Он сар өдөр		Тоо. Ш. ном/	танхим
Сэдэвчилсэн үзэсгэлэн				
1	2015 онд	“Ардчилсан шинэ үндсэн хуулийн 23 жил ” “Д.Сүхбаатарын мэндэлсний 122 жилийн ой ” “Бүсгүйчүүдийн нүдээр” , “Монгол цэргийн жавхаа” “Б.Баастын уран бүтээл”, “Д.Мэнд-Ооёогийн уран бүтээл”, “Үндэсний бичиг соёл”,д “1945 оны чөлөөлөх дайн 70 жил”, “Хэл ярианы баялаг ” , “Ховд аймгийн өдөр” , “2015 онд хэвлэгдсэн шинэ ном” сэдвээр, Д.Жамъян “Хубилай хаан” номын нээлтэнд **,** “Дэлхийн философичдын өдөр” , “Монгол бахархлын өдөр” Дан.Нямаагийн уран бүтээл”, “С.Дашдооровын 80 насны ой”-д “Б.Ренчингийн 110 насны ой”-д	17 удаа 355 ш ном	Монгол фонд Боловсрол хөгжил танхим
2	3-р сард 4-р сард	жаз хөгжмийн, хүүхдийн уран зохиолын шинэ ном CDболон хөгжмийн CD	14CD 16 CD 2 удаа 30 ш	Герман
5		Дэлхийн хүүхдийн номын баярыг угтаж Орос	4 удаа 51 ш	Өрнө дахины

		хэл дээрхи үлгэрүүд Л. Керролл. “Алиса гайхамшгийн оронд“ зохиолын 150 жилийн ойд Дэлхийн номын болон зохиогчийн эрхийн өдөрт зориулж Мөрөөдөл танхимтай хамтран орос, англи хэл дээр хэвлэгдсэн монгол зохиолчдын болон үлгэрийн номоор үзэсгэлэн Орос, англи хэл дээр хэвлэгдсэн шинэ номын үзэсгэлэн	ном	танхим
6	2015.1.22	“Ухаалаг хотын оюунлаг хүүхдүүд” хамтын ажиллагаанд оролцогчдод зориулан “Эртэч хүүхэд” хөтөлбөрийн танилцуулах зурагт үзэсгэлэнг гаргалаа.	1 удаа	Зөөврийн номын сан
7	2015.3 сар 2015.4 сар 2015.5 сар 2015.6 сар 2015.8 сар 2015.10 сар	Их мэдэх танхимд байгаа цуврал номноос ХК Андерсений үлгэрүүдээс Мэнд-Ооёогийн уран бүтээлээс “Их мэдэх” танхимд байгаа СӨНХ-д зориулсан жижиг ном Бага насныханд зориулсан дэлхийн зохиолчдын орчуулгын зохиол Оросын зохиолчдын орчуулгын хүүхдийн зохиолуудаас	20 9 1 20 16 20 6 удаа 86 ш	“Их мэдэх” танхим
	2015.4.2. 2015.4.23. 2015.6.1. 1015.9.28. 2015.11.26.	**04/02 нд** “ Х.К. Андерсений намтар уран бүтээл”**04/23 нд** “ Дэлхийн Номын Өдөр” **06/01 нд** “Хүүхдийн шилдэг зохиолууд” **09/28 нд** “Орос ардын үлгэрүүд” **11/26 нд** Д. Батжаргал “Зохиолчийн уран бүтээлээс”	5 удаа 72 ш ном	Мөрөөдөл
	1-р улирал	нийт	**35 удаа 564 ш ном, 30 CD**	танхимууд
Шинэ ном				
	1-3 сар	Шинэ ном	7 удаа 139 ш ном	Монгол фонд, БХ
		Шинэ ном	4 удаа 115	Мөрөөдөл
		Шинэ ном	1 удаа 22 ш	Их мэдэх
		Шинэ ном	4 удаа 63 ш ном болон	Герман

			AV мат	
		Шинэ ном	4 удаа 24 ш ном	Дорно дахины танхим
		Шинэ ном	2 удаа	Өрнө дахины танхим
		4-р сарын 22-нд 5-р сарын 24-нд	**2 удаа 20** ширхэг	Энхчимэг
Нийт			**24 удаа 320ш ном, 63CD**	**танхимууд**

<u>Соёл, танин мэдэхүйн ажлын хүрээнд :</u>

“Мөрөөдөл” танхим, “Их мэдэх” танхимуудад Оюунчимэг багштай 97-р сургуулийн 7б, Дэлгэрцэцэг, Ариунаа багштай 67-р сургуулийн 3, 4, 6-р анги, 5-р сургуулийн Чогсамба багш болон 2, 3, 6-р анги, 24-р сургуулийн Отгонцэцэг 2,3 –р ангийн нийт 10 гаруй бүлгийн сурагчид 7 хоногийн 2 өдрийг тогтмол уншлагын өдөр болгон тус танхимуудаар үйлчлүүлж байна.

Танхимуудад явуулж байгаа соёлын ажлыг уламжлалт болон цаг үеийн ажил гэж 2 хуваан тайланд тусгалаа.

Уламжлалт ажлын хүрээнд:

Зохиолч уншигчийн уулзалт- 5 танхимаар 23 удаа

Чанга уншлага- 5 танхимд 49 удаа

Номын баяр - 5 удаа

Үлгэрийн цаг– 18 удаа

Бичиг соёлын өдөрт: “Үндэсний бичиг соёл – X” улсын уралдаан

“Герман номын сан - герман номтой танилцах” сэдвийн хүрээнд

6.2.1.7. Зөөврийн номын сангийн соёл танин мэдэхүйн ажил

Герман танхимд: Шинэ жил 2014 оны 12 сарын 24-нд Гёте-Институттэй хамтран уншигчдад зориулсан зул сарын баярыг зохион байгуулав. Энэ үйл ажиллагаанд номын сангийн шилдэг 35 уншигчийг урьж, шилдэг 5 уншигчийг шалгаруулан урамшуулсан.

СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

Онцлох зарим ажлуудаас дурьдвал:

Нэг: Номын баяр-2015 БСШУ-ны Сайдын 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/386 тоот тушаалаар “Номын баяр-2015” арга хэмжээг Чингисийн талбайд 09 дүгээр сарын 19-ний өдөр тэмдэглэн өнгөрүүллээ. Уг арга хэмжээний хүрээнд Хүүхдийн ТНС-аас “Хүүхэд, хөгжим, яруу найраг” ажлыг Хүүхдийн уран бүтээлчдийн “Эвт Үзэг“ төвтэй хамтран зохион байгууллаа. Номын баярын үйл ажиллагаанд зориулан Чингисийн талбай дээр Хүүхдийн төв номын сангаас “Хүүхдийн уран зохиолын шинэ ном”- ын үзэсгэлэн, “Он цагийн хэлхээс” гэрэл зургийн үзэсгэлэн, хүүхдийн гар зургийн үзэсгэлэн гаргасан. Үйл ажиллагааны үеэр “Номын сангийн танилцуулга”, ном хэрхэн унших талаарх зөвлөмж зэргийг түгээсэн.”Номын баяр”-ын үйл ажиллагаанд БСШУ-ны сайд Л.Гантөмөр, Соёлын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Гантөмөр, мэргэжилтэн Б.Баяраа, ардын уран зохиолчид, аймаг,хотын номын санчид, уншигч олон оролцсон.

2015.09.18 Номын баярын үеэр Хүүхдийн Төв номын сангаас “Номын сангийн хуулийг хүлээн авах ёслолын ажилллагаа”-г зохион байгууллаа. “Номын сангийн тухай” хууль хүлээн авах хүндэтгэлийн үйл ажиллагаанд зориулан анх байгуулагдсан үеэс өдийг хүртэлх хугацааны түүхэн үйл явдлыг харуулсан байгууллагын гэрэл зургийн үзэсгэлэн гаргасан. Уг арга хэмжээнд Номын сангийн тухай хуулийг боловсруулах ажлын хэсгийн дарга, УИХ-ын гишүүн Ё.Отгонбаяр, БСШУЯ-ны Соѐлын бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Гантөмөр, хүүхдийн зохиолч, уран бүтээлчид, аймаг, хотын номын сангийн захирлууд, номын санчид болон 150 гаруй уншигч хүүхдүүдийн төлөөлөл оролцов. “Номын сангийн тухай” хуулинд

хүүхдэд зориулсан ном бүтээлээс тус номын санд заавал авч байх заалт тусгагдсанаар хүүхдийн зохиолчид өөрсдийн туурвисан уран бүтээлийн дээжсээ Хүүхдийн төв номын санд бэлэглэлээ. Мөн Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 266 дугаар тогтоол гарч “Хүүхдийн номын ордон”-г “Хүүхдийн төв номын сан” болгон өөрчилж, шинээр барилга барих газрын асуудлыг шийдвэрлэхээр болсонд уншигч хүүхдүүд талархаж “Миний мөрөөдлийн номын сан”-гаа зурж арга хэмжээнд ирсэн төрийн болон олон нийтийн байгууллагын зочид, хүүхдийн зохиолчдод бэлэг барив.

2015.09.19. “Номын баяр”-ын үйл ажиллагааны хүрээнд Хүүхдийн Төв Номын Сангийн “Их мэдэх” танхимын шилдэг уншигч, Нацагдорж тэмдгийн эзэн 23-р сургуулийн 8-р ангийн сурагч М. Байгалийн орчуулсан “Салхи хүчтэй шуурах үед” номын баяр “Боловсрол хөгжил” танхимд боллоо.

М. Байгал нь 4 наснаасаа эхлэн 9 дэхь жилдээ Хүүхдийн Төв Номын Сангийн “Их мэдэх” танхимаар үйлчлүүлж байна. Уншигч Байгал сүүлийн 2 жил зуны амралтаараа Америкийн зохиолч Денис Гослингер Орэнштейны “When the wind blows hard” гэдэг алдартай номыг орчуулж уншигчдын хүртээл болгож байна. М. Байгал болон тэдний гэр бүлийнхэний санаачлагаар үе тэнгийн хүүхэд багачуудад үлгэр дууриал болгох зорилгоор “Их мэдэх” танхимтай хамтран шинэ номын баярыг хийлээ. Номын баярт хүүхдийн зохиолчид, “Их мэдэх” танхимын уншигчид болон ангийнх нь сурагчид, 23-р сургуулийн багш сурган хүмүүжүүлэгчид урилгаар оролцсон.

Номын баярын үйл ажиллагааг нээж Байгал үг хэлж яагаад ном орчуулах болсон тухайгаа хүүхэд багачуудад ярьж өгч 15-р сургуулийн сурагчдын хамтлаг, 57-р сургуулийн 3 –р ангийн сурагч “Миний хайртай ордон” дуугаар аяа дууны мэнд өргөн барилаа. Мөн хүүхдүүдийн дунд АХА тэмцээн явуулж шалгарсан 2 хүүхдэд “Салхи хүчтэй шуурах үед” шинэ номноосоо бэлэглэв. Хүүхдийн зохиолч О. Сундуй, Л. Мөнхбат нар номын баярт оролцож өөрсдийн уран бүтээлийн дээжээс уншиж сонирхуулахаас гадна шүлэг уншсан хүүхдүүдэд зөвлөгөө өгсөн юм. М. Байгалийн гэр бүлийн зүгээс номын сангийн хуулийг хүндэтгэн номын сангийн архивт 2 хувь, “Их мэдэх” танхимын уншигчдад уншуулахаар 2 хувь нийт 4 хувь номыг номын санд бэлэглэв.

Хоёр: “Үндэсний бичиг, соёл” Улсын 10-р уралдаан

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 онд батлагдсан зарлигийг үндэслэн Хүүхдийн Номын Ордон, “Сод номун” төв ТББ санаачлан **“Үндэсний бичиг, соёл”**-ын өдрөөр жил бүр өсвөр үе, залуучуудыг Монгол үндэсний

бичиг, түүх соёлоо эрхэмлэн дээдэлдэг, үндэсний хэл бичгээ сурч, судалж, эзэмшүүлэх зорилгоор энэхүү уралдааныг зохион байгуулдаг.

Монгол бичгийн тэргүүний уншигч шалгаруулах улсын 10 дугаар уралдааны нээлтийн үйл ажиллагаанд БСШУЯ -ны яамны соёлын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн Л.Тэрбиш, Төрийн хэлний зөвлөлийн дарга Ж.Нэргүй, Монгол бичгийг дэмжих сангийн захирал доктор Н.Жадамбаа, Монгол бичгийг дэмжих сангийн гүйцэтгэх захирал доктор Г.Эрдэнэбаяр, мэдээллийн

МОНЦАМЭ агентлагийн “Хүмүн бичиг”сонины ерөнхий эрхлэгч, монгол хэл бичгийн нэрт судлаач Б.Элбэгзаяа, Монгол уламжлал Академийн захирал, доктор, проф. зохиолч Л.Дашням, Чой. Лувсанжавын нэрэмжит Хэл иргэншлийн дээд сургуулийн доктор, зохиолч, сэтгүүлч, н.Тогооч,”Их монгол ” дээд сургуулийн багш, Монгол улсын гавьяат багш Д.Эрдэнэцэцэг, “Монголоороо” төвийн тэргүүн, дуучин Г.Эрдэнэчимэг, Инж-мөрөн ТББ-ын тэргүүн С.Буянзаяа, Хөгжим бүжгийн коллежийн багш Ч.Сарнайцэцэг, Зохиолч, жүжигчин Энхтайван нар оролцлоо.

“Үндэсний бичиг, соёлын өдөр”-т зориулан БСШУЯ, Хүүхдийн Номын Ордон, “Сод номун” төв ТББ–аас 10 дахь жилдээ зохион байгуулсан монгол бичгийн тэргүүний уншигч шалгаруулах улсын уралдаанд энэ жил хот, 14 аймгаас шалгарсан 150-иад хүүхэд, залуучууд оролцлоо. **Уралдааныг** 5-7-р анги, 8-9-р анги, 10-12-р анги, Насанд хүрэгчид гэсэн 4 насны ангиллаар шалгаруууллаа. Шалгаруулалт насны ангилал тус бүрд 3 тэргүүний уншигч , 2 хүүхэд тусгайбайранд шалгарсан. Шалгарсан сурагчдыг тэргүүний уншигчийн батламж, ивээн тэтгэгчдийн шагналаар шагналаа.

Үүнд: 5-7-р ангийн тэргүүн байранд Хэнтий аймгийн Хэрлэн сумын 4-р сургууль 7-р анги Г. Отгонжаргал, Дундговь аймгийн Сайнцагаан сумын сурагч Сувд , Дундговь аймаг Мандал сумын сурагч Шүрээ нар орж тусгай байранд Дорноговь аймаг Замын–Үүд сум 2-р сургуулийн сурагч Наранхүү, Сэлэнгэ Хөтөл хотын дунд сургууль

Мөнхзул,

8-9р ангийн тэргүүн байранд Дорноговь аймаг Замын–Үүд сумын Одбилэг, Баянхонгор

аймаг Бөмбөгөр сумын Баясгалан, Баянхонгор аймаг Баянцагаан сумын Содномдаш шалгарч тусгай байранд УБ хот "Радуга" дунд сургуулийн Саранцэнд, Дархан-Уул аймгийн Намуун,10-12 ангийн тэргүүн байрт Дундговь Сайнцагаан сумын Ганбагана, Дархан-Уул аймаг Мон-турк сургуулийн Б.Билгүүн, Увс аймгийн Х. Даариймаа нар орж тусгай байрт Дархан-Уул аймаг 15-р сургуулийн Ц.Бадамцэцэг, ЧД-ийн 5-р сургууль Д.Аззаяа, Дорнод аймгийн Мөнхзул,Насанд хүрэгчдээс тэргүүн байрт МУИС 4-р курсын Жаргалдулам, Хэл–Иргэншил ДС-ийн Ариунболд, Хэл–Иргэншил ДС–ийн Урангоо орж, тусгай байрт МУБИС 2-р курсын З.Бямбасүрэн, МУИС 1-р курсын Жавзанпагма нар тус тус шалгарлаа.

Уралдааныг Монгол бичгийн сан, Монгол Уламжлал Академи, "Хүмүүн бичиг" сонин, Дашчойлон хийд, "Монголоороо" төв, "Багш" сонин, Монголын залуучууд холбоо, "Монголын сурагчдын холбоо","Сүмбэр-монбадрал" ХХК, "Их Монгол" дээд сургууль, Хэл иргэншлийн дээд сургууль, "Инж мөрөн" ТББ зэрэг байгууллагууд ивээн тэтгэж оролцлоо.

Гурав: 2015 оны 04 сарын 02-ны 11.00 цагт Дэлхийн хүүхдийн номын өдөр буюу Х.К.Андерсений төрсөн өдрийг тохиолдуулан хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх, номын ертөнцөөр аялуулах, тэдний сэтгэлгээ, уран чадвар, авьяасыг номоор дамжуулан тэлэх, хөгжүүлэх, олон нийтэд таниулах зорилгоор "Болор судар" хэвлэлийн газар, Азхур ХХК, Хүүхдийн номын ордон хамтран өдөрлөг зохион явууллаа. .

Өдөрлөгт: Нийслэлийн бага ангийн сурагчдын дунд Х.К Андерсений зохиолоос сэдэвлэн гар зураг, дунд ангийнханы дунд "Лусын охин" зохиолыг үргэлжлүүлэн бичих эсээ бичлэг, ахлах ангийн сурагчдын дунд жүжигчилсэн тоглолтын уралдааныг зарлан явуулав.

Гар зургийн уралдаанд: Их мэдэх танхим болон ЕБС-ийн бага ангийн сурагчдыг хамруулав. Уралдаанд нийт 80 гаруй бүтээл ирсэнээс Хүрээ тулга сургуулийн 3а анги сурагч Тамир, 3а анги Үүрцайх,1а анги Хишигдэлгэрэх /1- байр/, 1а анги Анударь , 2б анги Анхбаяр, 2б анги Номинжин, 1а анги Анужин, Налайх дүүрэг Голомт цогцолбор сургуулийн 4 анги Хулан, 5 анги Нурбахат,ЧД-ийн 37 -р сургууль 10-рт 4г анги Өсөхбаяр, ХУД-ийн 59-р сургууль11-рт 2а анги Оюун-Эрдэнэ Оюуны Ундраа цогцолбор сургууль 2в анги

Ариунзаяа , 2в анги Бямбацогт , 2в анги Маргад /3-р байр/ нарын 14 бүтээл 2-р шатанд шалгарч Боловсрол хөгжил танхимд үзэсгэлэн гаргав.

Зургийн уралдааны эхний байранд Хүрээ тулга сургуулийн 1–р ангийн сурагч Хишигдэлгэрэх, 2-р байранд Хүрээ тулга сургуулийн 1-р ангийн Анужин, 3-р байранд Оюуны ундраа сургуулийн 2в ангийн сурагч Маргад орлоо.

1-р байр 2-р байр 3-байр

Сургуулийн дунд ангийнханы дунд зохион явуулсан “Дараагийн хуудас” уралдааны 2-р шатанд 9 эсээ шалгарч үзэсгэлэнд тавигдлаа.

17-р сургууль Эрдэнэбулган, 17-р сургууль Батзолбоо, 17-р сургууль Нандин-Эрдэнэ, 17-р сургууль Номин-Эрдэнэ, 17-р сургууль Энхжаргал, Ану “Лусын дагина”, 116-р сургууль 8 а анги А. Сайханцэцэг “Лусын охин”, 23-р сургууль 7 г анги М. Байгаль , 2-р сургууль 11 а анги Х. Буянбат нарын бүтээл шалгарлаа. Үүнээс 1 байранд харааны бэрхшээлтэй 116-р сургууль 8 а анги А. Сайханцэцэг “Лусын охин” бүтээл шалгарсан байна.

2015.4.2. Дэлхийн хүүхдийн номын баяр буюу Х.К.Андерсены төрсөн өдрийг тохиолдуулан зарласан хүүхдийн бүтээлийн уралдаанд зөөврийн номын сангийн уншигч хүүхдүүд идэвхитэй оролцлоо. Уралдаан 3 сэдвийн дагуу явагдаж “Дараагийн хуудас”буюу Х.К.Андерсены “Лусын дагина”зохиолыг үргэлжлүүлэн бичих уралдааны төрөлд зөөврийн

номын сангийн хараaны бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн сурагч Сайханцэцэг 1-р байр, гар зургийн уралдааны төрөлд Хүрээ-тулга дунд сургуулийн Хишигдэлгэрэх 1-р байр, Анужин 2-рбайр, Анхбаяр, Тамир нар 3-рбайр, жүжигчилсэн тоглолтын төрөлд Дэлхийн зөн төвийн 67-р сургуулийн уншигч хүүхдүүд багаараа 2-р байрыг тус тус эзэллээ. Зөөврийн номын сангийн нийт төвүүдээс тус уралдаанд 15 хүүхэд оролцож уралдааны төрөл тус бүрт 5 хүүхэд, 1баг шагналт байрыг эзэлсэн нь зөөврийн номын сангийн уншигч хүүхдүүдийн идэвхи оролцоо нэмэгдсэнийг харуулж байна.

Ахлах ангийн сурагчдын дунд явуулсан жүжигчилсэн тоглолтын 2-р шатанд Нийслэлийн 9-р сургуулийн 10а анги “Лусын дагина” жүжигчилсэн тоглолт,Шавь цогцолбор 9г анги “Хааны шинэ хувцас” жүжигчилсэн тоглолт зэрэг 7 багийн тоглолт

шалгарсан. Үүнээс 1-р байранд 67-р сургуулийн 5–р анги “Хамгийн хурдан нь хэн бэ? тоглолт шалгарлаа. Уралдаанд түрүүлсэн хувь хүүхэд, багийн хамт олныг “Мөнхийн үсэг” ХХК-аас 5 сая 360 мянган төгрөгөөр шагнаж урамшуулсан.

Дөрөв: Эрдэм шинжилгээний хурал:

2015.11.18. МУИС-ийн Монгол хэл –Уран зохиолын тэнхим, Хүүхдийн Төв Номын Сан

хамтран “XXI зуун-Хүүхдийн Уран зохиол” сэдэвт оюутны эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа. Хуралд МУИС, МУБИС, СУИС-ийн 22 оюутан илтгэл тавьж, МУИС-ийн багш Д.Галбадрах, Д.Батжаргал, МУБИС-ийн багш Д.Оюунбадрах, Хүүхдийн зохиолч Б.Нацагдорж нар шүүгчээр ажиллалаа. Уралдааны:

1-р байрт МУИС-ийн оюутан Н. Анхбаяр ,2-р байрт МУБИС-ийн оюутан н.Баасантуяа “3-р байрт МУИС-ийн оюутан Э.Мөнхцэцэг нар шалгарлаа.

Тав: 2015.11.27. Монгол-Хятад ном, хэвлэлийн солилцооны хамтын ажиллагааны эхлэл болсон “Монгол үндэсний амьтны тухай ёгт үлгэр” ном бэлэглэх ёслолын ажиллагаа “Боловсрол хөгжил” танхимд боллоо. Ном бэлэглэх ёслолын ажилд БСШУЯ-ны соёлын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Гантөмөр, мэргэжилтэн Б.Баяраа, БНХАУ-ын Монгол улсад сууж буй элчин сайдын яамны зөвлөх Ян Чин Дун, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах орны Сонин, мэдээ, радио, телевизийн товчооны дарга Жан Буян нар оролцлоо. Энэхүү үйл ажиллагаа нь Монгол Хятад хоёр орны ном хэвлэлийн салбарт цаашид хэрэгжих томоохон ажлуудын эхлэл болж байгаагаараа онцлог юм. **Ёгт үлгэрийн 10 цуврал номноос** “Их мэдэх” танхимын уншигч Х. Хонгорзул “Заан хийгээд сармагчин” Мөрөөдөл танхимын уншигч 84-р сургуулийн 6 г ангийн сурагч А. Дөлгөөн “Арслан хийгээд шумуул” ёгт үлгэрийнг ирсэн зочдод уншиж өглөө. Ном хүлээн авах ёслолд МҮНС, ХоТНС болон дүүрэг бүрээс 3 номын сан, 5 аймгийн ном сан нийт 28 газрын төлөөлөгчид оролцож номоо гардан авлаа.

Зургаа. “Шидэт номын найзууд” уран үгсийн чуулган. Уран үгсийн чуулганыг жил бүр Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж Хүүхдийн уран бүтээлчдийн “Эвт үзэг” холбоо, Монголын Зохиолчдын эвлэлийн Хүүхдийн зохиолчдын үндэсний төв, Хүүхдийн номын ордон хамтран зохион байгуулж байхаар боллоо. Энэ удаагийн үйл ажиллагааны ивээн тэтгэгч байгууллагаар “Болор судар” хэвлэлийн газар оролцож уран уншигч хүүхэд багачуудыг шагнаж урамшуулав. Чуулганы гол зорилго нь хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх, тэдэнд зориулсан шилдэг уран бүтээлийг уншигчдад сурталчлан таниулахад оршиж байлаа. “Шидэт номын найзууд” уран үгсийн чуулганд хүүхдийн зохиолчдын 20 шинэ өгүүллэгийг уран уншигч хүүхэд залуучууд уншиж толилуулан ур чадвараараа өрсөлдөв.

Уралдаанд Д.Батжаргалын “Наян модны хөндий”, “ О.Сундуй “Шидэт малгай”, С.Сосорын “Чин хүсэл” зэрэг бүтээлүүдийг хүүхдүүд урнаар уншиж сонирхууллаа. Шилдэг уран уншигч, зохиолчдод 2 сая төгрөгний мөнгөн шагналыг “Болор судар” хэвлэлийн газраас гардуулав. Энэхүү ажил нь цаашид уламжлал болон жил бүр явагдаж “Болор судар” хэвлэлийн газраас шинээр гарсан хүүхдийн зохиолчдын өгүүллэгийг хэвлүүлж байхаар боллоо.

Соёл, танин мэдэхүйн ажлын хүрээнд:

Сэдэвчилсэн болон шинэ номын үзэсгэлэн

Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг: 35 удаа 564 ш ном, 30 CD

Шинэ номын үзэсгэлэн: 24 удаа удаа 320 ш ном ш ном болон 63 АВ материалаар үзэсгэлэн гаргасан байна.

Соёл, танин мэдэхүйн ажлын хүрээнд :

“Мөрөөдөл” танхим, “Их мэдэх” танхимуудад Оюунчимэг багштай 97-р сургуулийн 7б, Дэлгэрцэцэг, Ариунаа багштай 67-р сургуулийн 3, 4, 6-р анги, 5-р сургуулийн Чогсамба багш болон 2, 3, 6-р анги, 24-р сургуулийн Отгонцэцэг багштай 2,3 –р ангийн нийт 10 гаруй бүлгийн сурагчид 7 хоногийн 2 өдрийг тогтмол уншлагын өдөр болгон тус танхимуудаар үйлчлүүлж байна.

Танхимуудад явуулж байгаа соёлын ажлыг уламжлалт болон цаг үеийн ажил гэж 2 хуваан тайланд тусгалаа.

Уламжлалт ажлын хүрээнд:

Зохиолч уншигчийн уулзалт- 5 танхимаар 23 удаа

Чанга уншлага- 5 танхимд 49 удаа

Номын баяр - 5 удаа

Үлгэрийн цаг– 18 удаа

Бичиг соёлын өдөрт: “Үндэсний бичиг соёл – X” улсын уралдаан

“Герман номын сан - герман номтой танилцах” сэдвийн хүрээнд

Зөөврийн номын сангийн соёл танин мэдэхүйн ажил

Герман танхимд: Шинэ жил 2014 оны 12 сарын 24-нд Гёте-Институттэй хамтран уншигчдад зориулсан зул сарын баярыг зохион байгуулав. Энэ үйл ажиллагаанд номын сангийн шилдэг 35 уншигчийг урьж, шилдэг 5 уншигчийг шалгаруулан урамшуулсан.

Зохиолч уншигчийн уулзалт – 5 танхимаар 23 удаа болсон.

Боловсрол хөгжил танхим: 3 удаа

2015.4.9 Нийслэлийн ЕБС-ийн номын санчид, монгол хэл, уран зохиолын багш нарыг

Соёлын гавьяат зүтгэлтэн, яруу найрагч Гомбожавын Мэнд-Ооёотой зохиолчийг уншигчдтай уулзууллаа. Зохиолч Мэнд-Ооёо нь яруу найраг, хүүрнэл зохиол, бодрол бясалгал, нийтлэл судлалын 30 гаруй ном хэвлүүлсний зэрэгцээ түүний уран бүтээл англи, япон, хятад, бенгал, македони хэлнээ хөрвүүлэгдэн гарч байжээ. Уулзалтаар түүний шинэ уран бүтээл болох “Шилийн богд”, “Гэгээнтэн” номын танилцуулга болж, түүний гарын үсэгтэй номыг уулзалтанд ирсэн хүмүүс гардан авсан юм. Энэ удаагийн уулзалтанд зөвхөн сурган хүмүүжүүлэгч багш нар оролцсоноороо онцлог байлаа.

2015.4.22 Төрийн шагналт, Соёлын Гавьяат зүтгэлтэн яруу найрагч Долгорын Нямаатай хүүхэд, залуус уулзаж анхны шүлэгнээс нь эхлээд амьдрал замнал, уран бүтээлийнх нь тухай нэн сонирхолтой олон зүйлсийг сонслоо. Мөн уулзалтанд хүрэлцэн ирсэн залуусын дунд 5 хормын шүлгийн уралдаан зарлаж, тэргүүлсэн залуучууд Нямаа найрагчийн ээждээ зориулж бичсэн "ЭЭЖИЙН ӨДӨР" номыг нь гардан авсан юм.

2015.10.11. Соёлын гавъяат зүтгэлтэн, Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолч, яруу найрагч Дан.Нямаатай зохиолч уншигчдын уулзалт хийлээ. Уулзалтанд нийслэлийн ЕБС-ийн 16, 84, 24, 31, 67 сургуулийн ахлах ангийн сурагчид болон номын санчид, хэл уран зохиолын багш нар оролцлоо. Оролцогчид зохиолчийн намтар уран бүтээлтэй танилцаж, хүн

байх сэтгэлгээний талаар болон хүсэл мөрөөдөл, зорилгынхоо талаар олон сонирхолтой асуултандаа хариулт авлаа. Зохиолч “Миний амьдралын ертөнц” шинэ номоо уншигч хүүхдүүдэд танилцуулж хүүхдүүдийг хэрхэн номтой нөхөрлөх, уран зохиолын ямар номыг унших нь чухал зэргийг хэлж зөвлөгөө өгч байлаа.

Мөрөөдөл танхимд - 4 удаа

2015.03.03. Хүүхдийн зохиолч О.Сундуйг урин “Нууц товчооны нууцад нэвтрэхүй” сэдэвт уулзалт хийв. Уулзалтанд бэлдэж “Тэнгэрээс заяат төрсөн Тэмүүжин хүү” номыг Оюунчимэг, Чогсамба багштай 5-р сургуулийн 6 е,б ангийн сурагчид, Ариунаа багштай 67-р сургуулийн 5-р ангийн сурагчдаар уншуулж судлуулав. Уулзалтын үеэр сурагчдын дунд хөгжөөнт тоглоом, асуулт хариултын тэмцээнийг зохион явуулж, сурагчид сонирхсон асуултаа зохиолчдоос асууж, харилцан ярилцлаа. Нууц товчооны нууцад нэвтэрч их монгол улсын үүсэл хөгжил, ач холбогдол, хүмүүжил, эх хэлний бичлэг зэргээс суралцсан ач холбогдолтой уулзалт боллоо.

2015.04.15. 108 боть цувралын редактор Номинчимэд “Хэйди охин” зохиолынхоо талаар “Шинэ монгол” сургуулийн 7-р ангийн сурагчидтай уулзалт ярилцлага хийж, хүүхдүүдийн асуултанд хариулав.

2015.09.23. 47-р сургуулийн МХУЗ –ийн багш Дэлгэрмөрөнгийн хүсэлтээр 6-р ангийн хүүхдүүдийг Хүүхдийн зохиолч О.Сундуйтай уулзалт хийв.

2015.11.26. МЗЭ-ийн шагналт, профессор Хүүхдийн зохиолч Батжаргалтай “Зохиолч уншигчийн уулзалт” хийв. Уулзалтанд 67-р сургуулийн 5е ангийн хамт олон болон, 84-р сургуулийн сурагчид оролцов.Уулзалтын хөтөлбөрт:

- Зохиолчийн танилцуулга,
- харилцан асуулт-хариулт,
- сурагчдын бэлтгэсэн театрчилсан тоглолт зэрэг багтсан.

Зохиолч өөрийн номын бэлгийг анги хамт олонд гардуулан хамт зургаа авахуулцгаав. Зохиолчийн намтар уран бүтээлийг “Повер пойнт” программ дээр шивж уншигчдад дэлгэцээр танилцуулан, зохиолчийн бие даасан 20 номоор үзэсгэлэн гаргав.

Их мэдэх танхим:- 9 удаа

- “Нобелийн шагналтнууд” номын сантай хамтран МУГЖ Туяатай уулзах уулзалтыг эхний хагас жилд 4 удаа зохион байгуулсан. Уулзалтад 122-р цэцэрлэг, 86-р цэцэрлэгийн 200 гаруй хүүхдүүдийг хамруулав.

2015.3.26. О. Сундуйтай хийх уулзалт

Сонгино хайрхан дүүргийн 67-р сургуулийн Дэлгэрцэцэг багштай 3 анги, Хан-Уул дүүргийн 52-р сургуулийн 4 ангийн сурагчдыг Хүүхдийн зохиолч О. Сундуйтай уулзуулсан. Уулзалтанд 120 гаруй хүүхдүүд оролцов. Зохиолч Сундуйгийн уран бүтээлтэй танилцуулж, хүүхдийн дуунаас нь дуулж , Халиартай бин хүүхэлдэйн киног гаргаж үзүүлсэн. Хүүхдүүд зохиолчид өөрсдийн хийсэн бүтээлээсээ бэлэглэв.

2015.4.25 Соёлын гавьяат зүтгэлтэн, хүүхдийн зохиолч Одончимид.

“Их мэдэх” танхимын уншигчдыг Соёлын гавьяат зүтгэлтэн, хүүхдийн зохиолч Одончимидтэй уулзууллаа. Уулзалтанд 67-р сургуулийн 3 анги, Оюуны ундраа сургуулийн 2-р анги, 3-р сургуулийн 6-р анги, 4-р сургуулийн 4-р ангийн 100 гаруй хүүхдүүд оролцсон. Уулзалтыг мөрөөдөл танхимд зохион явуулав.

Уулзалтын үеэр:

- Одончимэд зохиолчийн уран бүтээлийг PPT-ээр танилцуулах
- Зохиол бүтээлээс нь хүүхдүүд уншиж, дуулах

- Хүүхдүүд зохиолчоос асуулт асуух, ярилцах
- Бэлэг солилцох ажлуудыг зохион байгууллаа.

2015.10.15. Хүүхдийн зохиолч О. Сундуйтай 24-р сургуулийн 2ж ангийн 30 сурагчийг уулзууллаа. Зохиолч О. Сундуйгийн шинэ уран бүтээл “Шарга даага”, Шүлэгч хүүхдүүд” номыг танилцууж, сурталчилсан. Хүүхдүүд Сундуй зохиолчийн шүлгээс уншин үлгэр, өгүүллэгээс нь уншиж танилцсан.

2015.12.1. Хүүхдийн зохиолч Махсэдийн Доржсүрэнтэй 52-р сургуулийн 4-р ангийн сурагчдыг уулзууллаа. Бага насны хүүхдэд зориулсан “Гайхал бор тэргүүтэн бичил өгүүллэгүүд” номноос танилцууллаа.

Дорно дахины танхимд

2015.11.27. Японы Олон улсын Манга авардсын “Гран при” шагнал хүртсэн “Бумбардай” цуврал номын зураач Н.Эрдэнэбаярыг Зохиолч уншигчдын уулзалтанд урьж оролцууллаа. Энэхүү уулзалтыг Үй цай хятад хэлний дунд сургуулийн 3-р ангийн 32 сурагчидтай хамтарч зохион явуулав.

Зөөврийн номын сан:

2015.1.31. "Ухаалаг хотын оюунлаг хүүхдүүд" хамтын ажиллагааны хүрээнд Хан-Уул дүүргийн 7 сургуулийн номын клубын 90 сурагчидтай хүүхдийн зохиолч О.Сундуй уулзалт хийж тэдэнтэй ном унших, ном бүтээх, номтой нөхөрлөх талаар харилцан ярилцаж өөрийн бүтээлүүдийг танилцууллаа. Зохиолч номын клубын сурагчдыг номтой нөхөрлүүлэх их аянд нь амжилт хүсч, үргэлж манлайлагч байхыг хүссэн юм.

2015.2.4. Хүүхдийн зохиолч Н. Мандалтай нийслэлийн 14-р сургуулийн 8в ангийн сурагчид Мөрөөдөл танхимд уулзалт хийлээ. Уулзалтаар хүүхдүүд түүний зохиол бүтээлийн баатруудын талаар сонирхолтой олон асуултандаа хариулт авсан юм.

2015.6.22. ХНО-той танилцах аялалын хүрээнд Гэр бүл хөгжлийн "Өнөрбүл" төвийн хүүхдүүдийг оролцуулсан. Энэ аяллын хүрээнддоорх ажлуудыг явуулав.

2015.6.27. Гэр бүл хөгжлийн "Өнөр бүл" төвийн хүүхэд багачуудыг ХНО-той танилцуулах аялалыг зохион байгууллаа. Танилцах аялалын хүрээнд:

- ХНО-ны 6 танхимаар аялуулж номын сантай танилцууллаа.
- Хүүхдийн зохиолч Б.Нацагдорж, О.Сундуй нартай уулзалт, Б.Нацагдоржийн "Хүслэн", "Яасан юм бол доо", "Чи ч сайн би ч сайн" үгнүүдэд Шинэ Монгол дунд сургуулийн багш Амарбаяр аялгуу хийснийг сурагч Бодьжин, Содбилэг, Номуундарь нар найзууддаа дуулж өгч ая дууны мэндчилгээ дэвшүүллээ. Энэ бүтээлүүд нь анхны сонсогч нартаа хүрч байгааг үг, аялгууг зохиогчид нь онцолж байлаа.
- Англи монгол хэлээр чанга уншлага: Хүүхдүүдэд Англи монгол хэл дээр чанга уншлагыг Америкийн Монгол судлалын төвийн мэргэжилтэн Оюундэлгэр, Chisato Fukuda нар хийлээ. Гадаад хүн ирж чанга уншлага хийсэн нь хүүхдүүдэд сонирхолтой байлаа. Тус төвийн 4 хүүхэд найз нартаа "Сайн нохой Бөөмбий" номоор чанга уншлага хийж, зохиолчдын шүлгийг 3 хүүхэд уншиж, бид хүүхдүүдийг номын бэлгээр урамшуулсан юм.
- "Гахайн гурван тоорой" хуруун хүүхэлдэйн тоглолтыг үзэж сонирхлоо.

Энэхүү аялалыг "Номтой нөхөрлөсөн гэр бүл" төслийнхөн хамтран зохион байгууллаа.

2015.9.11 “Соёл урлагийн ажилтны өдөр”-ийг тохиолдуулан нийгэмд хандсан дараах ажлыг зохион явууллаа. ШШГЕГ-ын харъяа хорих 411-р ангийн 110-р сургууль/ хүүхдийн хорих/ дээр зөөврийн номын сан ажиллуулж МЗЭ-ийн шагналт яруу найрагч Ишхүү, Сэр-Одын шагналт зохиолч Баттулга, Сэр-Одын шагналт яруу найрагч Минжинсайхан, Цэнд-Аюуш нартай зохиолч уншигчдын уулзалт –өдөрлөгийг зохион явууллаа. Өдөрлөгөөр яруу найрагчид өөрсдийн уран бүтээлээс хүүхэд залуус, өдөрлөгт хүрэлцэн ирсэн эцэг эхчүүдэд уншиж танилцуулж тус сургуулийн номын санд номын бэлэг гардуулсан юм.

2015.11.18. Налайх дүүргийн лаборатори 119-р сургуульд Хүүхдийн зохиолч СТА Ч.Наранцэцэг, Ц.Энхтүвшин нартай зохиолч уншигчийн уулзалтыг хийлээ. Уулзалтаар хүүхдүүд тэдний уран бүтээлийн талаар олон сонирхолтой асуултандаа хариулт авч, дуулж, дурсгалын зураг татуулсан юм.

2015.11.20 Зөөврийн номын сангийн Баянхошуу төвд Хүүхдийн зохиолч О.Сундуйтай зохиолч уншигчийн уулзалт хийлээ. Уулзалтаар зохиолч маань хүүхдүүдэд өөрийн шинэ уран бүтээлээсээ танилцуулж, хүүхдүүдэд уншиж өгсөн бүтээл болгон дээрээ хүүхдүүдтэй ярилцаж санал бодлоо солилцож, хөгжөөнт тоглоом тоглож, шагнаж урамшуулсан нь уншигч хүүхдүүдэд сонирхолтой байлаа.

Чанга уншлага: Их мэдэх танхимд 35, Мөрөөдөл танхимд 7 удаа, Өрнө дахины танхимд 5 удаа, Зөөвөрт 1 удаа, Герман танхимд 1 удаа нийт 49 удаа явуулсан.

Мөрөөдөл танхимд – 7 удаа

- 2015. 01. 28. Хүүхдийн зохиолч Л. Мөнхбат “Дүрсгүйчүүдийн сургууль, “Зүггүй нэртийн зөрүүдлэл”, “Барбид хайртай гөлөг” шүлгүүдээсээ 67-р сургуулийн 4е ангийн сурагчдад уншиж сонирхуулав.
- 2015.3. 25. Америкийн Монгол судлал төвөөс ирсэн Англи номноос Ном хөтөлбөрийн зохицуулагч Б. Оюундэлгэртэй хамтран Англи номын уншлагыг явуулав.
- 2015.04.02. “Дэлхийн хүүхдийн номын баярын арга хэмээний үеэр Х.К.Андерсений намтар, уран бүтээлийн танилцуулга, уран бүтээлийн үзэсгэлэн гаргав. “Үлгэрийн цаг”-аар “Дүрсгүй жаал хөвгүүн” үлгэрийг хүүхдүүд уншиж өгөв.
- 2015.09.19. 2015 оны номын баярын арга хэмжээний хүрээнд Хүүхдийн зохиолч О.Сундуйн “Зусланд болсон явдал“ зохиолоор 47-р дунд сургуулийн 6”в” ангийн сурагчдад болон танхимын уншигчдад чанга уншлага хийв.
- 2015.09.28. 5-р сургуулийн 7б ангийн хамт олныг хамруулан Оросын зохиолч И.А Крыловын “Тэмээлзгэнэ шоргоолж хоёр” “Чоно хөхөө хоёрын үлгэр” “Мичнүүд” зэрэг ёгт үлгэрээр чанга уншлага,харилцан ярилцлага, асуулт хариултын тэмцээн зохион явуулав.
- 2015.10.13. 5-р сургуулийн 7е ангийн 35 сурагчдад “Дэлхийн түүхийг бүтээсэн 100 эрхэм” номоос Ньютоны тухай уншиж, харилцан ярилцсан чанга уншлага зохион байгуулав.
- 2015.10.13. 5-р сургуулийн Тогтохсүрэн багштай 6а ангийнханд СУИС-ийн Соёлын сургуулийн номын сан мэдээллийн ангийн оюутан Долгорсүрэн ардын үлгэрээр чанга уншлага хийв.

Их мэдэх танхимд - 35 удаа

Чанга уншлага. Англи хэлний чанга уншлага 5 удаа, Монгол хэлээр чанга уншлага 30 удаа

Англи хэлний чанга уншлага

- 2015 оны 2 сарын 4-нд Монголд Зориулсан Ном хөтөлбөр Монголд Зориулсан Ном хөтөлбөрийн өдрийг "Их мэдэх" танхимд 52-р сургуулийн сурагчидтай тэмдэглэлээ. Сурагчид чанга уншлага хийж, ном хайж олох болон номын нэр таах тоглоом тоглож хөгжилдөв.
- Америкийн Монгол судлал төвөөс ирсэн Англи номноос Ном хөтөлбөрийн зохицуулагч Б. Оюундэлгэртэй хамтран Англи хэлний чанга уншлагыг 2 сарын 3, 3 сарын4, 2 сарын10, 2 сарын 24 нд 4 удаа явуулав. Англи хэлний чанга уншлагад Чогсамба багштай 5-р сургуулийн 6-р ангийн 10 сурагч, 24-р сургуулийн 6 ангийн 16 сурагчид нийт давхардсан тоогоор 100 гаруй хүүхэд хамруулсан.

Монгол хэлээр чанга уншлага: 30 удаа

2015 онд О. Сундуйгийн "Залхуу охин заан болсон нь" үлгэр өгүүллэг, Л. Түдэв "Будаг амилсан нь", Д. Гармаа "Аав цэцэрлэгт орсон нь" зохиолын хэсгээс, Д. Содномдоржийн "Норовын намтар" зохиол,Сутеев "Тахиа будаг хоёр", "Харандаа ба хулгана" Монгол ардын үлгэр Эвтэй 4 амьтан, энэтхэгийн үлгэр "Хемлата", Сайн нохой Бөөмбий, Амьтад зэрэг номоор чанга уншлага хийсэн.

Өрнө дахины танхим: 5 удаа

- "Tale's time" үлгэрийн цагаар 28-р сургуулийн 6-р ангийн англи хэлний групп уншигчдад 4 удаа давтагдсан тоогоор 51 сурагчдад PowerPoint программ дээр үлгэр бэлтгэн англи хэлээр танхимын уншигч Дөлгөөн уншиж өгсөн. Сурагчид сонссон үлгэрээрээ англи хэлнээс өөрсдөө орчуулан англи-монгол хэлээр бяцхан ном бүтээв. Үүнд:

  Night-Night, forest friends

  Countdown to grandma's house

  Llama Llama misses Mama (1-р хэсэг)

  Llama Llama misses Mama (2-р хэсэг

- Х.К. Андерсены зохиол “Ямх охин-Thumbelina”, “Нугасны муухай дэгдээхэй-Гадкий утёнок” зэрэг үлгэрүүдийг танхимын уншигч “Хөгжлийг инженерчлэгч” клубын сурагч Жамъянмядаг, Ангаах ухааны их сургуулийн 1-р курсын оюутан Болормаа нар орос, англи хэл дээр PowerPoint программ дээр бэлтгэж уншиж сонирхуулсан нь уншигчдын сэтгэлд хүрсэн сайхан ажил боллоо. Энэхүү ажилд 60-аад уншигчид оролцлоо.

Зөөврийн номын санд 1 удаа

2015.11.9 Нийслэлийн Баянгол дүүргийн 66-р цэцэрлэгийн бяцхан уншигч хүүхдүүдэд “Хулгана өргөст хэмх хоёр” номоор чанга уншлага хийлээ. Мөн зөөврийн номын сангийн 92 ширхэг номыг хүргэж үйлчиллээ.

Герман танхимд 1 удаа

- 11 сарын 16-нд Гёте-Институтийн монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран философич С.Молор-Эрдэнийн орчуулсан Эрих Фромын “Бий эсвэл байх” номоор 2 хэлний уншлага зохион байгуулж, орчуулагч С.Молор-Эрдэнэ болон 60 гаруй хүн оролцлоо.

Их мэдэх танхимд - 2 удаа

1.2015 оны 2 сарын 4-нд Монголд зориулсан Ном хөтөлбөрийн Номын баярыг “Их мэдэх” танхимд 52-р сургуулийн сурагчидтай хамт тэмдэглэлээ. Сурагчид чанга уншлага хийж, ном хайж олох болон номын нэр таах тоглоом тоглож хөгжилдөв.

Зөөврийн номын санд – 3 удаа

2015.4.24. БГД-ийн хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн “Номын баяр”

Дэлхийн номын баярыг тохиолдуулан Хүүхдийн номын ордны зөөврийн номын сан, БГД-ийн хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн

холбоо хамтран тус дүүргийн хувийн хэвшлийн 20 цэцэрлэгийн 200 гаруй хүүхэд багачууд, эцэг эхчүүдтэй “Номынбаяр”-ыг тэмдэглэн өнгөрүүллээ. Номын баяраар авъяаслаг хүүхдүүд аав, ээж, багш, найзууддаа дүрийн тоглолт, урлагийн шилдэг тоглолтуудаа үзүүлж, хүүхдийн зохиолч нартайгаа уулзаж, багш нар нь “Гахайн гурван тоорой” тоглолтыг хийлээ.

“Гэр бүлийн номын өдөр” өдөрлөг

2015.4.25 Зөөврийн номын сангийн **“**Нобелийн шагналтнууд” хүүхдийн номын сангийн санаачлагаар, JCI Их хүрээ салбартай хамтран “Гэр бүлийн номын өдөр”-ийг тэмдэглэлээ. Өдөрлөгт ирсэн хүүхэд багачууд аав, ээж, ах, эгч, өвөө, эмээтэйгээ хамтдаа уншиж, гэр бүлээрээ номтой нөхөрлөж, тоглож өдрийг дурсамж дүүрэн зугаатай өнгөрүүллээ. Хүүхдүүдийн дунд танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгуулж, хүрэлцэн ирсэн эцэг эхчүүдэд XXX-ийн институтын захирал Алтанцэцэг, Хүүхдийн зохиолч О.Сундуй, доктор профессор Дашням нар “Хүүхдийн хүмүүжлийн 80 хувь эцэг эхээс хамаардаг”, “Бага насны хүүхдэд ном сонгох нь”, “Монголчуудын уламжлалт хүмүүжлийн арга” сэдвүүдээр ярилцлага хийлээ.

3.2015.5.20. Монгол улсын гэр бүлийн хөгжлийн “Өнөр бүл” төвд хэрэгжих “Номтой нөхөрлөсөн гэр бүл” төслийн нээлтэнд оролцож, тус төвтэй хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурж, номын хандив өглөө. “Өнөрбүл” төв нь 2014 оноос хүүхэд багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулан номын сантай болсон. Тус төвийн номын санг тохижуулах төслийг

Австрали улсад төгсөгчдийн төслийн багийнхан хэрэгжүүлж байна. Төслийн нээлтэнд бидний ирээдүй болсон хүүхэд багачуудын оюунд хөрөнгө оруулалт хийхээр төрийн ба төрийн бус байгууллага, компани, хувь хүмүүс, зохиолчид оролцсон юм. Хүүхдийн номын ордон нь “Өнөр бүл” төвд зөөврийн ном хүргэж өгөхөөс гадна, тус номын санг тохижуулах ажилд хамтран оролцож байна.

***Үлгэрийн цаг* – Их мэдэх танхимд - 10 удаа, Мөрөөдөл танхимд 1 удаа, өрнө дахины танхимд 7 удаа нийт 18 удаа болжээ.**

Үлгэрийн цаг - 1

“Их мэдэх” танхимд 3 сарын 14 нд Азийн сан, Дэлхийн зөн Монголд олон улсын байгууллагатай хамтран явуулж буй “Ухаалаг хотын оюунлаг хүүхдүүд” үйл ажиллагааны хүрээнд Хүүхэд хөгжлийн төвийн сурагчдыг үлгэрийн цагт оролцуулав. СУИС-ийн Соёлын менежерийн ангийн дадлагын 2 оюутан жүжгийн ажлыг удирдан явууллаа. 60-р сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй 15 хүүхэд оролцов. Энэ ажлын үеэр :

- “Гурван баавгай” үлгэрийг ярьж өгөх
- СУИС-ийн номын сан мэдээллийн ажилтны 2-р дамжааны оюутнууд орос ардын үлгэр “Гурван баавгай” үлгэрээр жүжигчилсэн тоглолт үзүүлэх.
- “Гурван баавгай” үлгэрийн тухай ярилцах
- Тус үлгэрээр том хийж, хийсэн номыг нь тайлбарлуулах ажлуудыг хийлээ.

Жүжигт СУИС-ийн номын сан мэдээлэл зүйн 2-р дамжааны 5 оюутан, Варвара охинд ХНО-ны Их мэдэх танхимын уншигч нийслэлийн 23-р сургуулийн 7–р ангийн сурагч Байгаль нар оролцон тогллоо.

Том номын бэлдэц, ном хийж байгаа нь:

Хүүхдүүдийн бүтээсэн номоо бусад найзууддаа тайлбарлан ярьж өглөө.

Үлгэрийн цаг 2.

“Их мэдэх” танхимд 3-р сарын 28 нд Бага насны уншигчдын дунд “Гурван баавгай” үлгэрийг

уншиж өгөөд харилцан ярилцаж, том ном хийв. Үлгэрийн цагт 16 хүүхэд оролцов.

Үлгэрийн цаг 3. 3-р сарын 28 нд “Гурван баавгай” үлгэрээр том ном хийж гүйцээв. Сургуулийн хүүхдүүд номын зургийг зурж, цэцэрлэгийн хүүхдүүд номын чимэглэлийг хийв.

Үлгэрийн цаг 4. 5 сарын 16. Энэ удаагийн үлгэрийн цагаар "Чоно ба долоон ишиг" үлгэрийг танилцуулж, жүжигчин Туяатай уулзалт хийв. Үлгэрийн цагт 52-р цэцэрлэгийн бэлтгэл ангийн 20 гаруй хүүхдүүд оролцов.

Үлгэрийн цаг 5. 10 сарын 3. Үлгэрийн цаг 5. Их мэдэх танхимын Г. Дарьсүрэн "Оньсого тааж оюунаа хөгжүүлцгээе" оньсого таалцав. Ургамлын тухай оньсого

Үлгэрийн цаг 6. 10 сарын10. Үлгэрийн цаг 6 Их мэдэх танхимын Номын санч Г. Дарьсүрэн "Оньсого тааж оюунаа хөгжүүлцгээе" оньсого таалцав. Амьтны тухай оньсого

Үлгэрийн цаг 7. 10 сарын 24. Хүүхдийн зохиолч О. Сундуйгийн Залхуу охин заан болсон

нь үлгэр өгүүллэгээр явуулав. 81-р цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдүүдийг хамруулав.

"Шүлэгч хүүхдүүд" номонд орсон шүлгээс хүүхдүүд уншиж, зохиолч шинэ уран бүтээлээсээ уншиж сонирхуулав.

Үлгэрийн цаг 8. 10 сарын 24. Үлгэрийн цаг 8 "Их мэдэх" танхимын уншигч Мөнхжин "Нэгэн туулайн түүх" үлгэрийг уншигчдад ярьж өгөв.

Үлгэрийн цаг 9. 10 сарын31. "Их мэдэх" танхимын уншигч Х. Хонгорзул Монгол ардын үлгэр "Могжоохон даагатай жогжоохон хүү " үлгэрийг уншигч хүүхдүүдэд ярьж өглөө.

Үлгэрийн цаг 10. 11 сарын 21. "Оньсого тааж оюунаа хөгжүүлцгээе" ургамлын тухай оньсого.

Мөрөөдөл танхимд -1 удаа Д. Цэвэгмидийн 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Хун шувуу бодон гахай хоёр ” зохиолоор 67-р сургуулийн Ариунаа багштай 4е ангийн сурагчид жүжигчилсэн тоглолтыг үзүүлэв. Тоглолтонд оролцсон хүүхдүүдэд урамшуулал өгөв.

Өрнө дахины танхимд -7 удаа 71 оролцогч оролцсон байна.

“Tale’s time” үлгэрийн цагаар 28-р сургуулийн 6-р ангийн англи хэлний групп уншигчидад 7 удаа давтагдсан тоогоор 71 сурагчдад танхимын уншигч Дөлгөөн PowerPoint программ дээр бэлтгэн англи хэлээр уншиж өгсөн. Сурагчид сонссон үлгэрээрээ орчуулга хийж англи-монгол хэлээр бяцхан ном бүтээв. Үүнд:

- ***Night-Night, forest friends***
- **Countdown to grandma’s house**
- **Llama Llama misses Mama** (1-р хэсэг)
- **Llama Llama misses Mama** (2-р хэсэг)
- **Гадкий утёнок**
- **Чүдэнз худалдагч охин**
- **Ямх охин**

Дугуйлан уран бичлэгийн дугуйлан 13 удаа, Яруу найргийн “залуу нас” дугуйлан 9 удаа нийт 22 удаа хичээллэв.

1.Дугуйлан: Залуу нас дугуйлан долоо хоногийн баасан гаригт хийчээллэж нийт 9 удаа,

Уран бичлэгийн дугуйлан бямба гаригт нийт 13 удаа хичээлллэж байна.

2015.4.15 Боловсрол хөгжил танхимд “Залуу нас” Төрийн шагналт Р.Чойномын нэрэмжит "ЗАЛУУ НАС" утга зохиолын дугуйлангийн нээлт боллоо. Нээлтэд Ардын уран зохиолч Дөнгөтийн ЦООДОЛ, Шагдарын ДУЛМАА, Шаравын СҮРЭНЖАВ, болон Төрийн шагналт яруу найрагч Зундуйн ДОРЖ, Соёлын Гавьяат зүтгэлтэн Л.ДАШНЯМ, Д.Нацагдоржийн шагналт зохиолч Цэрэнтулгын ТҮМЭНБАЯР, МЗЭ-ийн болон М.Цэдэндоржийн нэрэмжит шагналт зохиолч, яруу найрагч Ломбын НЯМАА, МЗЭ-ийн болон "Алтан-Өд" шагналт зохиолч Ойдовын СОДНОМПИЛ, МҮЧЗХолбооны шагналт зохиолч, доктор Ц.ЭРДЭНЭБАТ, Монгол Улсын Гавьяат эдийн засагч Ц.ДАЛХАА, МЗЭ-ийн нарийн бичгийн дарга В.СЭЛЭНГЭ нар залуу уран бүтээлчдийнхээ хамт оролцлоо.

2015.4.26 Төрийн шагналт яруу найрагч Ренчиний Чойномын өвийг хамгаалах **“ӨД”** сангийн дэргэдэх **“ТАМГА”** уран бүтээлийн нэгдлээс санаачлан утга зохиолд шимтэн дурлагч, эхлэн бичигч, хэн бүхэнд нээлттэй Р.Чойномын нэрэмжит **“ЗАЛУУ НАС”** утга зохиолын дугуйланг долоо хоног бүрийн баасан гаригт ХНО-той хамтран хичээллүүлж байхаар боллоо**. “ЗАЛУУ НАС”** утга зохиолын дугуйланг хичээлүүлснээр шинэ залуу уран бүтээлчид өөр хоорондоо шүлэг бүтээлээ унших, харилцан нэгнээсээ суралцах, өнөө цагийн утга зохиолын сор болсон ахмад, дунд үеийн уран бүтээлчидтэй уулзах, тэднээс суралцах зэрэгт **“ЗАЛУУ НАС”** дугуйлан гүүр болон ажиллах болно. Р.Чойномын

“ӨД” сангаас залуу уран бүтээлчдийнхээ зохиол бүтээлийг олон нийтэд сурталчлах, утга зохиолын шинэ содон мэдээ мэдээллээр хангаж байхуйц долоо хоног тутмын **“ЗАЛУУ НАС”** сонинг гаргаж байна. Тус сонины нэг нүүрэнд Хүүхдийн Номын Ордон хүүхдийн зохиолчдынхоо уран бүтээлийг залуу үеийнхэнд таниулан сурталчилж байна.

Дорно дахины танхим: Уран бичлэгийн дугуйлан

Дорнын гайхамшиг гэгддэг уран бичлэг түүн дотроо монгол уран бичлэгийг үндэсний бичиг соёлоо дээдэлж, монгол бичгээр уран бичиж сурах зорилгоор хуучны уламжлалт дугуйлан хэлбэрээр байгуулагдсан Хүүхдийн номын ордны анхны дугуйлан “Уран бичлэгийн дугуйлан” нь 2014 оны 10-р сарын 25-наас эхлэн сард нэг удаа үнэ төлбөргүй хичээллж байна. Нийт 13 удаа хичээл орж давхардсан тоогоор 71 хүүхэд, залуучууд хамрагдлаа.

Дугуйлангийн хичээлийг залуу уран бүтээлч, уран бичээч Э.Найдандорж удирдан өөрийн боловсруулсан уран бичлэг бичиж сурахад суурь болох анхан шатны 9 элемент орсон байна. Мөн 6-р сарын хичээлийг багшийн урланд зочилж уран бүтээлч хүний орчинтой танилцсан юм

2015.01.24.1-р сарын буюу 4-р хичээл дээр шинэ элемент заав.

2015.02.28. 2-р сарын буюу 5-р хичээл дээр Хүүхдүүд өөрсдөө бие даан өмнө үзсэн элементүүдээ бичиж бие биедээ тусласан.

2015.03.14. 3-р сарын хичээл буюу 6 дахь хичээл дээр шинэ элемент сурцгаалаа. Дугуйлангийн хичээлээр одоо нийт 7 анхан шатны заавал мэдэх элемент заасан байна.

2015.04.18. 4-р сарын хичээл буюу 7 дахь хичээл дээр уран бичлэгийн хичээлийг сонирхож ирсэн шинэ залуучуудад багш өмнө нь заасан элементүүдээс бичиж үзүүлсэн юм. Байнгын болон шинэ сонирхож ирсэн 16 хүүхэд залуучууд ирсэн.

5-р сарын хичээл буюу 8 дахь хичээл дээр. Энэхүү хичээл зуны амралтын өмнөх сүүлийн хичээл байлаа. 6-р сарын хичээлийг сарын сүүлийн өдөр багшийн урланд зочилж уран бүтээлч хүний орчинтой танилцахаар болсон.

2015.06.30. Даалгавар өгч хүүхдүүд өөрсдийн бичиж чадахгүй байгаа элементээ асууж тодруулж байв. Зуны даалгаврыг өөрсдийн “ХНО дугуйлан” facebookхуудсанд оруулсан.

2015.09.19. 9-р сарын хичээл буюу 10 дахь хичээл дээр. Энэ удаагийн хичээлийг “Номын баяр 2015” өдөрт зориулж Нээлттэй хичээл зохион байгуулав. Хичээлд дугуйлангийн байнгын сурдаг 7 хүүхэд ирсэн юм.

10-р сарын хичээл буюу 11 дэхь хичээл дээр. Багш “Монгол” болон өөрийн нэрийг яаж уран бичиж болохыг хүүхдүүдтэй хамтарч бичив. 5 хүүхэд ирсэн.

11-р сарын хичээл 28-ны хичээлээр багш хүүхдүүдэд муутуун цаасаа хэрхэн хатуу цаасан дээр нааж биетэй болгох аргачлалыг заалаа.

***Клубын уулзалт, -* Их мэдэх, Герман, Өрнө дорны танхимуудаар нийт 55 удаа 667гаруй хүүхэд багачууд болон оюутан залуус оролцсон.**

"Их мэдэх" танхимд 5 удаа 50 гаруй хүүхдийг хамруулжээ.

2015 оны 2 сараас эхлэн 14 хоногт 1 удаа "Мичкогийн цаг" бага насны хүүхдийн англи хэлний клубын хүүхдүүд 5 удаа 50 хүүхэд хичээллэв.

Герман танхимд: 6 удаа 200 гаруй хүүхдүүд хамруулсан.

- Герман хэлний ярианы клуб эхний хагас жилд 6 удаа, 9-р сарын 26-наас хойш 14 удаа нийт 20 удаа ярилцлага зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 200 гаруй хүн оролцов. Бямба гараг бүр хичээллэж байна.

Өрнө дахины танхимд: 44 удаа 417 хүүхэд оролцлоо.

- **"Crazy Monkiez"** Англи хэлний клуб 14 удаа 151 хүүхдийг хамруулан доорхи ажлыг явуулсан. Үүнд:
  - Чөлөөт сэдвээр ярилцлага
  - Үгийн таавар ярилцлага
  - Шинэ дуу сонсож дууны утгын ярилцлага

- **“Берёзка” Орос хэлний клуб 18 удаа 120 хүүхдийг хамруулж** доорхи ажлуудыг явуулсан. Үүнд:
  - “Жестокий романс” кино үзэж чөлөөт ярилцлага
  - “В бои идут одни старики” кино хичээл, ярилцлага хийв.
  - танилцах уулзалт, кино хичээл зохион байгуулсан
  - Үг тогтоох аргачлал , дүрмийн сургалт
  - Орос улсын их дээд сургуулиудын тухай танилцуулга гэх мэт.
- **“Хөгжлийг инженерчлэгч” Англи хэлний клубын сурагчид 4 удаа 46 хүүхдийг** хамруулан доорхи ажлыг явуулсан.Үүнд:
  - Кино ярилцлага 1 удаа
  - Чанга уншлага 3 удаа
  - Шинэ дуу сурч сонсгол, дуудлага сайжруулах дасгал зэргийг 1 удаа
- **“Chapla” клуб: 8 удаа 100 гаруй хүнийг хамруулжээ.**

  2015 оны 10-р сараас эхлэн 28-р сургуулийн 8-10-р ангийн сурагчдын дунд англи хэлний ярианы клубыг ажиллуулж эхэлсэн бөгөөд нийт 8 удаа давхардсан тоогоор 100 гаруй хүүхдүүдийг хамруулан англи хэлний дуудлага сайжруулах зорилгоор мэтгэлцээн явуулах, шүлэг, дуу сурах, хөгжөөнт тоглоом тоглох, үг үсэглэх зэрэг арга хэмжээнүүд явагдаж байна. Энэхүү ажлын үр дүнгээ харах зорилгоор 2015оны 12-р сарын 19-ны өдөр сурсан зүйлээрээ танхимаа чимж тайлант өдөрлөг зохиох зорилготой ажиллаж байна. Мөн “Tale’s time” үлгэрийн цагийн бяцхан номын үзэсгэлэн гарна.

“Герман номын сан - герман номтой танилцах” **сэдвийн хүрээнд** танхимын үйл ажиллагааг сурталчлах үзүүлэн таниулах арга хэмжээг 5 удаа зохион байгуулж **89** хүн хамруууллаа.

Хүснэгтлэвэл:

№	Огноо	Сургууль анги	Хүний тоо
	1 сарын 9	Гёте-Институтийн герман хэлний сургалтын оролцогчид	28
	4 сарын 10	Гёте-Институтийн герман хэлний сургалтын оролцогчид	16
	8сарын28	Гёте-Институтийн герман хэлний сургалтын	15

		оролцогчид	
	10-рарын3	Гёте-Институтийн герман хэлний сургалтын оролцогчид	16
	11-р сарын 13	Гёте-Институтийн герман хэлний сургалтын оролцогчид	14
	нийт	**5 удаа**	**89**

Зөөврийн номын сан:

Зөөврийн номын сан нь 20 төвтэй хамтран ажиллаж хагас жилийн хугацаанд төвүүдэд **2480** ном хүргэгдсэнээс **6435** ирцэд **4344 ш** ном уншуулсан байна. Шинээр Гэр бүл хөгжлийн "Өнөр бүл" төв, ШШГЕГ-ын харъяа эмэгтэйчүүдийн хорих 407-р анги хамтран ажиллахаар гэрээ хийж хамтран ажиллав.

Зөөврийн номын сангаас явуулсан соёлын ажлыг хүснэгтлэвэл:

Д/Д	**Оролцсон байгууллага**	**Хэзээ**	**Оролцсон хүний тоо**
1	"Ухаалаг хотын оюунлаг хүүхдүүд" хамтын ажиллагааны хүрээнд Хан-Уул дүүргийн 7 сургуулийн номын клубын сурагчидтай уулзалт	1 сарын 31	98
2	Нийслэлийн 14-р сургуулийн 8в ангийн сурагчидтай уулзалт/Мөрөөдөл танхимд/	2сарын 4	25
3	Х.К.Андерсены нэрэмжит хүүхдийн бүтээлийн уралдаан	4 сарын 2	15
4	БГД-ийн хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн "Номын баяр"	4 сарын 24	206
5	"Гэр бүлийн номын өдөр" өдөрлөг	4 сарын 25	76
6	Гэр бүл хөгжлийн "Өнөр бүл" төвийн	6 сарын	37

	хүүхдүүдэд ХНО-той танилцах аялал	26	
7	66-р цэцэрлэгт чанга уншлага	11 сарын 9	92
8	Налайх дүүргийн 119-р сургуульд хүүхдийн зохиолч Ч.Наранцэцэг, Ц.Энхтүвшин нартай зохиолч уншигчийн уулзалт	11сарын 18	153
9	Баянхошуу ДЗөн төвд Хүүхдийн зохиолч О.Сундуйтай зохиолч уншигчийн уулзалт	11сарын 20	54
	Нийт	9 удаа	756

“Ухаалаг хотын оюунлаг хүүхдүүд” төслийн хүрээнд

2015.1.22 “Ухаалаг хотын оюунлаг хүүхдүүд” хамтын ажиллагаанд оролцогчдод зориулан “Эртэч хүүхэд” хөтөлбөрийн танилцуулах зурагт үзэсгэлэнг гаргалаа.

2015.1.23 “Ухаалаг хотын оюунлаг хүүхдүүд” хамтын ажиллагааны оролцогч 7 сургуулийн монгол хэл уран зохиол, англи хэлний багш нар болон номын санчдад номын сангийн шинэлэг үйлчилгээ болох “Эртэч хүүхэд” хөтөлбөрийнхөө туршлагаас танилцуулга хийлээ. Энэхүү төсөлд хамрагдаж байгаа нийт багш нарыг туршлага солилцуулах үүднээс Азийн сангийн азид зориулсан ном хөтөлбөрийн зохицуулагч Ч.Цэрэнхандтай хамтран багаар даалгавар дээр ажиллах 2 ажлыг зохион байгуулж амжилттай явууллаа.

2015.1.30 Азийн сан, ДЗМОУБ-ын ХУД-ийн хөгжлийн хөтөлбөртэй хамтарсан “Ухаалаг хотын оюунлаг хүүхдүүд” хамтын ажиллагаанд зөөврийн номын сан хамтран ажиллаж байна. Энэхүү хамтын ажиллагаанд оролцож буй номын клубын сурагчдад уншуулах шинэ ном тараасан. Ном тараах хуваарийг хийсэн.

2015.1.31 “Ухаалаг хотын оюунлаг хүүхдүүд” төсөлд хамрагдаж буй эхний 90 сурагчдыг ХНО-той танилцуулж, номын клубын гишүүн сурагчдад үүргэвчтэй номыг гардуулж өгөх үйл ажиллагаанд оролцлоо.

Зөөврийн номын сангаас хийсэн бусад ажил:

2015.4.7. ШШГЕГ-ынхарьяа эмэгтэйчүүдийн хорих 407-р ангитай хамтран ажиллах гэрээ байгуулж ном хүргэж өгөв. Тус төвийн онцлогт тохируулж, уншигчдын захиалгын дагуу англи, орос, хятад, солонгос, япон хэлний сурах бичиг, сүүлийн үеийн уран зохиолын шинэ ном, түүх, хувь хүний хөгжлийн ном, сонсдог ном хүргэж өглөө. Цаашид тэдний хүсэлт, эрэлт хэрэгцээг хангаж зөөврийн номын багцыг тус ангид 100 ширхэг, чанга дэглэмтэй ангид 100 ширхэг номоор бүрдүүлж хүргэж өгч уншуулж байх боллоо.

2015.5.21. Хүүхэд гэр бүл хөгжлийн “Өнөр бүл” төвийн номын санч Буянтөгст фондын зохион байгуулалтыг танилцуулж, арга зүйн зөвлөгөө өгч, ХНО-ны танхимуудтай танилцууллаа.

Цаг үеийн ажил:

Цаг үеийн ажилд тогтмол явуулдаггүй цаг үеийн шаардлагаар хийсэн ажлыг оруулла.

Чөлөөлөх дайны 70 жилийн ойд

Үдшийн уншлага

Лекц сургалт ярилцлага

Уралдаан тэмцээн, Мэтгэлцээн, Аха

Эрдэм шинжилгээний хурал

Өрнө дахины танхимаас 1945 оны Чөлөөлөх дайны 70 жилийн ойн тухай хүүхэд залууст сурталчлах зорилгоор Өрнө дахины танхимын номын санчид, Монгол номын фондын номын санч Энхчимэг, Үнэмлэх нээлтийн номын санч Бадамсэд нар хамтран доорх ажлуудыг явууллаа.

1945 оны чөлөөлөх дайны 70 жилийн ойг угтан Монгол номын фонд, СТМА-ын Хурандаа Г.К. Жуковын гэр музейн эрхлэгч-тайлбарлагч Э.Мөнхчулуун, 28-р сургуулийн номын сантай хамтран төлөвлөгөө гарган доорхи ажлуудыг хийлээ.

- Чөлөөлөх дайны тухай түүнд оролцож гарамгай гавъяа байгуулж явсан цэргийн жанжид, дайчид, тухайн дайнд хэрэглэгдэж байсан зэр зэвсгийн тухай материалыг ХНО-ны вэбд байршуулах,
- “Говь хянганд тулалдсан нь” орос монголын хамтран хийсэн кино ярилцлага хийх
- БХЯ-ны харъяа Монгол цэргийн музей, Г.К.Жуковын гэр музейг үзэж музейн эрхлэгч-тайлбарлагч Э.Мөнхчулуунтай ярилцлага хийх
- Д.Пүрэвдорж “Хар цас” найраглалыг сурталчлах зорилгоор уран уншлагын уралдааныг 7-12-р ангийн сурагчдын дунд зохион явуулж 28-р сургуулийн 9-р ангийн сурагч А.Хулан, 9-р ангийн сурагч Б.Балжинням зэрэг сурагчид амжилттай оролцлоо,
- Дайнд оролцож явсан цэргийн жанжид, дайчдын дурсамж, дурдатгал, уран зохиол, цэрэг дайны холбогдолтой зэрэг номын үзэсгэлэнг монгол номын фондоос татав
- Дайнд оролцож явсан цэргийн жанжид, дайчдын дурсамж, дурдатгал, уран зохиол, цэрэг дайны холбогдолтой зэрэг номын ном зүйг номын санч Ө.Бадамсэд гаргалаа
- “Миний эх орон” сэдвээр МУ-ын Зэвсэгт Хүчний бэлтгэл хошууч Ц.Баатаржамцтай уулзалт ярилцлагыг зохион байгууллаа
- Цэрэг дайны холбогдолтой Монголын уран сайхны 18 киногоор үзэсгэлэн гаргалаа. Дээрхи ажлуудыг зохион байгуулахдаа 28-р сургуулийн 10,11,12-р ангийн сурагчдыг бүх зохион байгуулсан ажлуудад оролцуулж байсан нь эх орноо хайрлах, ахмад үеэ

хүндэтгэх тэднээрээ бахархах, цэрэг арми, зэр зэвсгийн талаар танин мэдэх, мэдрэх, бахдах, эх оронч сэтгэлийг төрүүллээ.

- Дээрхи хийсэн ажлыг PowerPoint-р бэлтгэн, зураг тайлбартайгаар дэлгэн уншигчдад тайлагналаа.

Үдшийн уншлага: 2 танхимаар 4 удаа болов.

“Их мэдэх” танхимд 1 удаа

2014.12.29. Сэлэнгэ аймгийн эх хүүхдийг хамгаалах “Ирээдүйн хишиг сан” -гийн хүсэлтээр энэхүү ажлыг зохион байгуулж Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Билиг ДБ” сургуулийн 6а ангийн 10 сурагч оролцлоо. Энэ үдшийн хөтөлбөрт хүүхдүүдийг Мөрөөдөл танхимд танин мэдэхүйн ном уншуулж, Их мэдэх танхимд Ж. Дашдондог “Гэр” зохиолыг уншиж өгч, уншуулж, харилцан ярилцаж тус зохиолоос сэдэвлэн ханын сонин хийлээ. Мөн хүүхдүүдийн оюуныг хөгжөөх оньсого таах уралдааныг зохион явууллаа.

Энэхүү үйл ажиллагаанд Сэлэнгэ аймгийн тамгын газрын телевизийн бичлэг дагаж нэвтрүүлэг хийв.

Герман танхимд: 3 удаа

Германы нэрт зохиолч Эллис Каутын "Эдэр мужаан ба Пумукл" (Ellis Kaut. "Meister Eder und sein Pumukl") номоор “Уншлагын үдэш” соёл танин мэдэхүйн үйл ажиллагааг 2 удаа зохион байгуулж, нийт 31 сурагчид хамрагдлаа. Хүүхдүүд хамт олноороо номын сантай танилцаж, ном уншиж, кино үзэж, тоглож, дуулж үдшийг хөгжилтэй өнгөрүүлэн, номын санд хонож үйлчлүүлэв. Хүүхдүүд "Эдэр мужаан ба Пумукл" номын тухай дууг сурч, киног нь үзэж, номын талаарх мэдлэгээ бататгав.

“Уншлагын үдэш” үйл ажиллагаанд Гёте-Институтийн захирал Сэбастиан Войч, АНУ-ын дуучин Наталий Жон, Бразил улсын хөгжимчин Паула Кардосо, Герман улсын хөгжимчин Мартин Ценкэр, Хөгжим бүжгийн коллеж дахь ”Гёте хөгжмийн танхим”-ын оюутнууд зочноор оролцлоо.

“Уншлагын үдэш” үйл ажиллагаа: 4-р сарын 24-нд 38-р сургуурийн 4-р ангийн 15 сурагчид герман хэлний багш Цэрэндолгорын хамт

5 сарын 15-нд 48-р сургуулийн 7-р ангийн 16 сурагчид герман хэлний багш Энхтуяа, Анхмаа нарын хамт тус тус оролцов.

2015.11. 27. „Buchstabenvogel”, „Drei ist einer zu viel” номоор хийсэн “Уншлагын үдэш” үйл ажиллагаанд 38-р сургуулийн 4-р ангийн б бүлгийн 15 сурагчид герман хэлний багш Гантуяа, дадлагын багш Б.Мандхай нарын хамт тус тус оролцов.

Лекц сургалт – 4 удаа

Герман танхим-1 удаа

1-р сарын 23-нд ХНО-д Азийн Сангаас зохион байгуулсан номын санчдын сургалт семинарт танхимын ажилтан Г.Буянцэцэг “Герман танхимаас зохион байгуулж буй соёл танин мэдэхүйн ажил” сэдвээр номын санчдад мэдээлэл өглөө.

Их мэдэх танхим-1удаа

Азийн сангаас зохион байгуулсан Хан-Уул дүүргийн номын санчдын сургалт дээр Их мэдэх танимын ажилтан Г. Дарьсүрэн” Номын сан ба гэр бүл” сэдэвт номын санчдад мэдээлэл хийсэн.

Боловсрол хөгжил танхим -2 удаа

Номын санч Б. Баярмаа “Ухаалаг хотын оюунлаг хүүхдүүд” хамтын ажиллагааны оролцогч 7 сургуулийн монгол хэл уран зохиол, англи хэлний багш нар болон номын

санчдад номын сангийн шинэлэг үйлчилгээ болох “Эртэч хүүхэд” хөтөлбөрийнхөө туршлагаас танилцуулга сургалт зохион байгууллаа. Энэхүү төсөлд хамрагдаж байгаа нийт багш нарыг туршлага солилцуулах үүднээс Азийн сангийн азид зориулсан ном хөтөлбөрийн зохицуулагч Ч.Цэрэнхандтай хамтран багаар даалгавар дээр ажиллах 2 ажлыг зохион байгуулж амжилттай явууллаа.

2015.2.28нд “Явган явахад цаг гаргах хэрэгтэй” лекцийг ЭМШУИС-ийн оюутан Э.Тамир, Б.Амраа нар уншигчдад зориулан явууллаа.

Уралдаан тэмцээн, мэтгэлцээн – АХА- 4, уран илтгэлийн тэмцээн 1 удаа,

“Их мэдэх” танхим: - уралдаант цэнгээнт АХА тэмцээн- 2 удаа

2014. 12. 24. Төв аймгийн Баяндэлгэр сумын 3-р ангийн 14 сурагч эцэг эхийн хамт ХНО-той танилцав. Энэ ажлын үеэр ХНО-той танилцах аялал, “Сайн нохой Бөөмбий” зохиолтой танилцаж, Мөрөөдөл танхимын номын санч Бямбасүрэн хүүхдүүдийн дунд АХА тэмцээнийг явуулав. АХА тэмцээнд 3 хүүхдийг шалгаруулж ном, номын хавчуургаар шагнаж урамшуулав

- 3-р сарын 26. Нийслэлийн 67-р сургуулийн 3з ангийн сурагчдын эцэг эхийн 1 өдрийг ХНО-ны их мэдэх танхимд явуулав. Эцэг, эхийн нэг өдрөөр эцэг эхчүүдэд зориулсан “Хүүхдийг номонд дуртай болгоход анхаарах нь”, “ХНО-оос эцэг эхчүүдэд зориулан явуулдаг соёлын ажлууд”-ыг танилцуулж, эцэг эхчүүдийн дунд АХА тэмцээнийг явуусан.

.

Боловсрол хөгжил танхим-1 удаа

2015.1.27. “Оюуны давалгаа IV” улсын аварга шалгаруулах уран илтгэлийн тэмцээнд МСХ-ны 60 хүүхдийг бэлтгэж амжилттай оролцууллаа. Тус уралдаанаас шалгарсан хүүхдүүдийн шагналыг БСШУЯ, Соёлын өв, ХНО-ноос нийт 50 ширхэг номыг бэлэг болгон гардуулахад хамтран ажилласан.

Мөрөөдөл танхимд - 2 удаа

- 2015.02.04. Танхимын номын санч Бямбасүрэн, номын санч Бадамсэд нар 67-р сургуулийн 4е ангийн сурагчдад “Эрхий мэргэн” үлгэрийг үзүүлж, харилцан ярилцаж АХА тэмцээн явуулав.
- **2015.04.15 нд** Д. Цэвэгмидийн 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Хоньчин найдан” туужаар тэмдэглэл, зураг зуруулах, АХА тэмцээн, зохиолын талаар ярилцах ажлыг СУИС-ын Соёлын сургуулийн дадлагын 2 оюутантай хамтран зохион байгуулж тэргүүлсэн сурагчдыг урамшуулав.

Герман танхимд - 2 удаа

- 5-р сарын 2-нд Герман хэлний мэтгэлцээнийг зохион байгуулж, 40 гаруй хүн оролцлоо.

- 11 сарын 18-нд Герман Монголын Бизнес Эрхлэгчдийн Холбоо, Гёте-Институтийн монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран Эрих Фромын “Бий эсвэл байх” номын мэтгэлцээнийг зохион байгуулж, герман монгол уншигч, нийт 40 гаруй хүн оролцлоо.

Өрнө дахины танхимд

- 20-р сургуулийн 7-р ангийн сурагчдын дунд англи үгийг үсэглэх тэмцээнийг зохион байгуулж идэвхтэй оролцсон хүүхдүүдийг 1-3-р байр эзлүүлэн ном бусад зүйлээр урамшууллаа. Үүнд: 28 хүүхэд оролцлоо.

Уншлагын аян: 2 танхимд 4 удаа болсон.

Мөрөөдөл танхимд: 4 удаа

2015.04.18. 97-р сургуулийн 3-р ангийн сурагчид “Чингис хаан” комик цуврал номоор уншлагын аялал хийв

2015.10.16. 67-р сургуулийн 4”в” ангийн сурагчид Ж. Дашдондог зохиолчийн 20 гаруй зохиолоор уншлагын аян хийв.

Налайх дүүргийн “Хос уянга” дунд сургуулийн 4-р ангийн 15 сурагчид танхимтай танилцан “Хорвоотой танилцсан түүх” сэдэвт уншлагын аян өрнүүлж номын сантай танилцан, номын сангийн талаар аман лавлагаа авч сургуулийнхаа ”Амьдралаас суралцдаг ХОС+УЯНГА сургууль минь” номоо хүүхдүүдийн захидлын хамт дурсгав.

2015.04.18. 97-р сургуулийн 3-р ангийн сурагчид “Чингис хаан” комик цуврал номоор уншлагын аялал хийв

“Их мэдэх” танхимтай танилцах аялал

2014. 12. 24. Төв аймгийн баяндэлгэр сумын 3-р ангийн 14 сурагч эцэг эхийн хамт ХНО-той танилцав. Энэ ажлын үеэр ХНО-той танилцах аялал, “Сайн нохой Бөөмбий” зохиолтой танилцаж, Мөрөөдөл танхимын номын санч Бямбасүрэн хүүхдүүдийн дунд АХА тэмцээнийг явуулав. АХА тэмцээнд 3 хүүхдийг шалгаруулж ном, номын хавчуургаар шагнаж урамшуулав.

Дөрөв: Аж ахуйн ажлын талаар

-СТӨ-ний дулааны инженер болон цахилгааны инженертэй холбоо барин 2 метр цахилгааны утас татуулан ус цэвэршүүлэгчийг холбуулсан. Мөн анхааруулга болон хайрцагийг бэлтгэж байрлуулсан ба 1-р давхарын эмэгтэй 00-ын 1 суултуурыг шинээр авч тавиулсан. 2-р давхарын цахилгааны автоматыг солиулсан.

- 1-р давхарын эмэгтэй 00-д засвар оруулах талаар СТӨ-ний аж ахуйн дарга болон бусад холбогдох хүмүүстэй 23 удаа очиж уулзан танхимуудыг үзүүлж, жижиг засвар үйлчилгээг хийлгэсэн. Мөн СТӨ-ний дулааны инженер болон цахилгааны инженер, сантехникийн ажилтанг 48 удаа утсаар дуудан гарсан гэмтлүүдыг засуулсан.

-Сургалтын өрөөнөөс эд хогшил зөөж, агуулах 1-д байрлуулсан. Мөн эд аж ахуйг тухайн үед нь цэгцлэн зохих газруудад байрлуулж ажилласан.

-Харуулын ажилтнууд 2015 онд 344 удаа нийт 8256 цагийн үүрэг гүйцэтгэн, 15433 захиалгын хуудсыг уншигчдад олгон, 395 060 төгрөгийн орлогыг цаг тухайд нь тушааж, уншигчийн картыг олгож ажилласан. Ажил хүлээлцэх бүрдээ рапорт тогтмол хөтөлж байна. Мөн гадна талбайн цэвэрлэгээгээ тогтмол хийж байна.

-Хог, хаягдлыг өглөө бүр машинд ачуулж байна. Мөн эвдэрч гэмтсэн ширээг засаж зохих танхимд нь хүлээлгэн өглөө.

-Хувцас хадгалагч нар 2015 онд 37 000 уншигч үйлчлүүлэгчдийн хувцас эд зүйлсийг алдаж үрэгдүүлэхгүй үйлчилсэн. Мөн уншигчдыг хувийн номтой оруулахгүй байх талаар шаардлага тавьж ажилласан. Үйлчлэгчийн амралтын өдрүүдэд 00-ын цэвэрлэгээ хийж байна. 1 ээлжийн хүн өвчтэй

- Өлгүүрийн дутуу номерийг өөрсдийн хүчээр нөхөж хийсэн.

-Үйлчлэгч нар 2015 онд өдөр бүр өрөөнүүдийн хогийг авч чийгтэй цэвэрлэгээ хийж 7 хоногт 1 удаа өрөөнүүдэд их цэвэрлэгээ хийдэг. Мөн фитнесийн өрөөг өнжөөд 1 удаа цэвэрлэж байна. Боловсрол танхимын цонх, танхимуудын хөшигийг авч улиралд 1 удаа угааж индүүдэж хийсэн. Сард 1 удаа сандлын бүрээсүүдийг угааж байна. Мөн 1,2 давхрын 00, усны өрөөг долоон хоногт 3-4 удаа цэвэрлэж, сэргээн засах өрөөний угаалтуурыг цэвэрлэж байна.

- 2015 онд бүх нийтийн цэвэрлэгээг 4 удаа хийж, гадаа талбайг ариутган угааж, хог хаягдлыг цаг тухайд нь ачууллаа. СТӨ болон 8-р хорооны захиргаанд цэвэрлэгээний тайланг бичиж, зурагжуулж 3 удаа өгсөн.

Тав: Бусад ажил:

Мөрөөдөл танхимд:

- 2015.01.09. О.Цэндсүрэнгийн “Ойн гүнд голын хөвөөнд” “Тэргүүн хорооны Нанзад” “Нутаг усны шивнээн” зэрэг зохиолыг О.Цэндсүрэнгийн үр хүүхдүүдэд танхимаас татан өгөв.
- 2015.3. 28. “Оюунт монгол” реалити шоуны техникийн зөвлөлийн хурал, “Оюунт монгол” реалити шоуны 5 багийн зураг авалт болов.

Дорно дахины танхимд:

- Хүүхдийн зохиолчдын “Эвт үзэг” төвийн уулзалт болсон.
- Уншигчийн интернэт ашиглах 2 компьютерийг каталогч Бямбасүрэн холболт хийж ажиллагаанд оруулж өгсөн.
- Танхимын үйл ажиллагааны танилцуулгын самбарт орон зай гаргаж нэмж нэг мэдээлэл хэвлэж байрлуулав.
- ”Галбингаа” хүүхдийн сургалтын төв 2 өдөр танхимд бичлэг хийсэн.
-

- Хятадын Манжуурын номын сангийн төлөөлөгчдөд танхимын үйл ажиллагаа болон зохион явуулж буй соёлын ажлын талаар танилцууллаа.
- МҮОНРТ-ийн Соёл, урлагийн редакциас хүүхдийн зохиолч Ж.Гун-Аасүрэнгийн уран бүтээлийн ярилцлага, орчуулагч, зохиолч Ж.Нэргүй болон судлаач, орчуулагч н. Магсаржавтай нартай хийсэн ярилцлагын бичлэгийг танхимд авлаа.

Өрнө дахины танхим:

- 1945 оны чөлөөлөх дайны 70 жилийн ойг угтсан СТМА-ыг Хурандаа Г.К.Жуковын гэр музейн эрхлэгч-тайлбарлагч Э.Мөнхчулуунтай хамтран төлөвлөгөө гарган ажиллаа. /Энэхүү ажилд 10 төрлийн ажлыг Хүүхдийн номын ордон-Өрнө дахины танхим, Монгол номын фонд, Хурандаа Г.К.Жуковын гэр музей, Монгол цэргийн музей, 28-р сургуулийн номын сан хамтран ажилласан./
- Хүүхдийн баяраар хөдөө орон нутгын асрамжийн хүүхдүүдэд зориулж англи хэл дээрх 140 номыг хандивлалав.
- Нийслэлийн өдөрлөгт зориулан танхим сурталчилах үзэсгэлэн гаргасан.
- Номын баярын үйл ажиллагаанд оролцож танхим сурталчилсан.
- 1-р давхарын коридор, танхимд их цэвэрлэгээ хийсэн.
- “Номын сангийн хууль”-ийг хүлээн авах, Хүүхдийн төв номын сан болсон баярын үйл ажиллагааны арга хэмжээнд оролцон “Алтан нөхөд” Fasebook групын найзуудын хамт номын сандаа 100 ном хандивласан.

-Өвлийн бэлтгэл ажлаар танхимын цонх дулаалсан.

Монгол фонд:

- Инженер Б.Сүхбаатарт өндөр насны тэтгэвэрт гаргахад нь номын санч И. Пүрэвбат, Б.Энхзул нартай хамтран зургийн цомог хийж дурсгав.
- 2009-2011 оны 124 хавтасласан сонингуудыг зөөж тавиурт байрлуулав.
- 6-р сарын 26-нд Гэр бүл хөгжлийн “Өнөр бүл” төвийн хүүхдүүдэд “Гахайн гурван тоорой” хүүхэлдэйн жүжиг тоглосон байна.

Хүүхдийн Номын Ордон шинээр Хүүхдийн Төв Номын Сангийн хамт олон 2015 оны төлөвлөгөөт амжилт бүтээлээр дүүрэн үдлээ.

АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Мэдээлэл түгээх –Уншлага үйлчилгээ

Нийтийн номын сан нь 2015 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн байдлаар 1096 уншигч шинээр бүртгэж, 28730 иргэсдэд 62702 номоор үйлчилж, уншигч–хэрэглэгчдийн өсөн нэмэгдэж буй оюуны эрэлт хэрэгцээнд нийцүүлэн соёлч , хөнгөн шуурхай үйлчилгээг эрхэм зорилго болгон ажиллаж байна.

Нийтийн уншлагын танхимд: Нийт 500 уншигч шинээр бүртгэж 10000 иргэсдэд 20000 ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр үйлчиллээ.

Хүүхдийн уншлагын танхимд: Нийт 472 уншигч шинээр бүртгэж 13508 иргэсдэд 30262 номоор үйлчилсэн байна.

Гэрээр ном олголт: Нийт 3487 иргэсдэд 6400 ном, тогтмол хэвлэлээр үйлчилсэн байна.

“Их мэдэх” танхимд: Цэцэрлэгийн 3-6 насны хүүхдүүд, ЕБС-ийн 1-3-р ангийн сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн тэдний оюун ухаан, хэл яриа, танин мэдэхүйг хөгжүүлэх зорилгоор нийт 560 хүүхдэд 1120 номоор үйлчиллээ.

Интернет танхимд: 14-өөс дээш насны 1360 хүүхэд, 18-аас дээш насны 125 оюутан, залууст интернет-цахим мэдээллийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэв.

Зөөврийн номын сангийн үйлчилгээ: Нийт 121 уншигч шинээр бүртгэж 778 иргэсдэд 6040 ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр үйлчилсэн байна.

“Миний номын өргөө” танхим:

ЯХИС-ийн “Миний номын өргөө” хөтөлбөрт Эрдэнэбулган сумын хэмжээнд 1,2 дугаар ээлжинд нийт 32 хүүхдийг хамрууллаа. Тус хөтөлбөр нь цэцэрлэгт хамрагдаагүй 5 настай хүүхдүүдийг гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр юм. Хөтөлбөрт хамрагдах хугацаанд хүүхэд бүр гэр бүлийн орчинд ном-тоглоомын 10 багцыг судлан сургуульд бүрэн бэлтгэгдэх юм.

Шинээр бүртгүүлсэн уншигчдын тоог сүүлийн 3 жилийн дундажтай харьцуулахад энэ жилд 44,5%-иар өссөн үзүүлэлт харагдаж байна.



Номын сангаар үйлчлүүлсэн иргэд болон ном олголтын байдлыг сүүлийн 3 жилийн дундажтай харьцуулахад энэ онд иргэсэд 91,9%-иар, ном олголт 7,2%-иар өссөн үзүүлэлттэй байна.



	2012 он	2013 он	2014 он	2015 он
Ирэгсэд	7625	9571	20019	23811
Ном олголт	42688	48640	57278	53111

ХҮҮХДИЙН УНШЛАГЫН ТАНХИМЫН АНГИЙН УНШЛАГА

2015 онд Хүүхэд “Ном” хөтөлбөрийн хэрэгжүүлэх, хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх, тэдний ном унших үйл явцыг дэмжин, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ангийн уншлагыг тусгай хувиарын дагуу зохион байгууллаа. Ангийн уншлагад идэвхитэй оролцсон сургууль ангиудаас дурдвал:

Хүмүүн 1-р сургуулийн Ч.Цэнд-Аюуш багштай 4в анги, Ганчимэг багштай 4д анги, Энхцэцэг багштай 3г анги, 1-р сургуулийн Э. Долгордорж багштай 4б анги, 1-р сургуулийн Ш. Мөнхболор багштай 4а анги, Хүмүүн 2-р сургуулийн Мөнхбилэг багштай 6в анги, Хүмүүн 2-р сургуулийн Долгорсүрэн багштай 3а анги, Бадамдорж багштай 8б анги, Нандинцэцэг багштай 1а анги, Я. Угандэлгэр багштай 3г анги, Д.Лхам багштай 2б анги, Б. Лхамаа багштай 3в, Д.Анх туяа багштай 3д анги, И.Эрдэнэтуул багштай 4в анги, Д. Нандинцэцэг багштай 2а анги, Д. Нарантөгс багштай 2в анги, А. Мягмарсүрэн багштай 2г анги, Дэлгэрзаяа багштай 4г анги, Эрдэнэчимэг багштай 5в анги, Ч. Батжаргал багштай 1б анги, Л. Энхмаа багштай 5б анги, Т. Мандах багштай 4б анги,

Ч.Даваачимэг багштай 5а анги, М. Отгонтөгс багштай 1а, Г. Батжаргал багштай 1в анги, А. Оюунчимэг багштай 4а анги, И. Зул багштай 5б анги, Ж. Баярсайхан багштай 1г анги, 4-р сургуулийн 4-р сургуулийн Ж.Аззаяа багштай 4б анги, 4-р сургуулийн Алтанцэцэг багштай 6а анги, IV сургуулийн Цэрэндэжид багштай 6б анги, Билгүүн сургуулийн 6в зэрэг ангиуд тогтмол ангийн уншлага хийж, номын тэмдэглэл хөтөлж хэвшсэн.

2. Фондын хадгалалт хамгаалалт:

- 2014 оны 4-р улирал болон 2015 оны 1-р улиралд захиалсан сонин, сэтгүүлийг үдэж хавтаслан үндсэн фондод 25 нэгж сонин, 7 нэгж сэтгүүлийг шилжүүлэн данс бүртгэлд авлаа.
- Улиралд 1 удаа, жилдээ 4 удаа их цэвэрлэгээ хийж фондын номуудын тоосыг унагаж цэвэрлэлээ.
- Нийт 185 урагдаж гэмтсэн ном хэвлэлийг нурууг үдэж, сэлбэн засалт хийж уншлагад гаргасан.
- 1970-1991 оны бүх сонин болон Архангайн үнэн 1959-1969 оны сонинг дугаараар нь үдэж, хавтсыг шинэчлэн архивт байрлуулав.
- 2015 оны 2-р улиралд захиалсан өдөр тутмын хэвлэлийн 4 нэгж сонинг үдэж хаягжууллаа.

3. Фондын баяжилт

“Номын коллектор” ХХК , БСШУЯ, байгууллага, иргэдээс хандивласан 130 нэр төрлийн 206 ширхэг номыг номын сан- номзүйн ангиллаар ангилж, техник ажиллагааг хийж, номын нэг бүрчилсэн бүртгэлд дансалж , уншлагын танхим, үндсэн фондод хуваарилан олгов.

Хуудас нь салж, урагдаж, гэмтсэн 95 ширхэг номын нурууг үдэж цэгцлэв. Мөн 2015 оны 3-р улиралд захиалсан өдөр тутмын 4 нэгж сонинг А.Оюунцэцэг, Л.Өсөхбаяр нар манаач П. Төмөрбаатартай хамтран үдэж хавтасласан.

4. Номын үзэсгэлэн –Мэдээлэл сурталчилгаа:

Уншигчдын оюуны эрэлт хэрэгцээ нийцүүлэн шинэ болон төрөлжсөн номын үзэсгэлэнг 59 удаа гаргаж, олон нийтэд сурталчиллаа. Үүнд :

Нийтийн уншлагын танхим:

1. Англи хэлний дүрэм, англи хэл эхлэн суралцагсдад зориулсан гарын авлага, номын үзэсгэлэн
2. “Гэр гэртээ тогооч” хоолны номын үзэсгэлэн
3. Техникийн шинжлэх ухааны номын үзэсгэлэн
4. Хүүхдийн танин мэдэхүйн комикс номын үзэсгэлэн
5. “Дэлхийн хүүхдийн эрдэнэсийн сан”-цуврал номын үзэсгэлэн
6. Дэлхийн сонгодог зохиолын 50 боть номын үзэсгэлэн
7. Сар шинийн баярыг тохиолдуулан “Монгол ёс заншлаа дээдэлье” сэдэвт номын үзэсгэлэн
8. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт “Эмэгтэйчүүд- эрүүл мэнд” сэдэвт үзэсгэлэн
9. Монгол цэргийн өдөрт зориулсан “ Цэргийн жанжнууд сэдэвт үзэсгэлэн”

10. “Таны танин мэдэхүйд” сэдэвт үзэсгэлэн
11. “Дэлхийн шилдэг 50 боть” номын үзэсгэлэн
12. Монголын сонгомол уран зохиол “
13. “Гадаадын хүүхдийн уран зохиол”
14. “Залуу хүний заавал унших 100 ном” сэдэвт үзэсгэлэн

16. “Монголын хүүхдийн уран зохиол” сэдэвт үзэсгэлэн

17. Монголын түүх, шашин, гүн ухааны салбарын номоор тус тус үзэсгэлэн.

18. Түүх, эрх зүйн чиглэлийн номын үзэсгэлэн

19. Сурган, сэтгэл судлалын чиглэлийн номын үзэсгэлэн

20. “Монголын түүх”, “Байгалийн шинжлэх ухаан”, “Урлаг”, ”Хэлний шинжлэл”, “Монголын шинэ үеийн уран зохиол” зэрэг сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 5 удаа гаргаж сурталчилсан

21. “Монгол ардын аман зохиол”, “Монголын түүх”, “Байгалийн шинжлэх ухаан”, “Хүүхдийн уран зохиол”, “Урлаг”, ”Хэлний шинжлэл”, “Монголын шинэ үеийн уран зохиол”, “Танин мэдэхүй”, “Гадаадын уран зохиол” зэрэг сэдэвчилсэн 1578 номоор 33 удаа үзэсгэлэн гаргаж сурталчилсан.

22. Монголын болон гадаадын уран зохиолын номын үзэсгэлэн

23. Сурган, сэтгэл судлал, шашны чиглэлийн номын үзэсгэлэн

ХҮҮХДИЙН УНШЛАГЫН ТАНХИМД:

1. Монголын хүүхдийн зохиолчдын уран зохиолын номын үзэсгэлэн

2. Англи хэлний дүрэм, англи хэл эхлэн суралцагсдад зориулсан гарын авлага, номын үзэсгэлэн
3. Хүний эрхийн чиглэлийн гарын авлага, номын үзэсгэлэн
4. Хүүхдэд зориулсан шүлэг, яруу найргийн номын үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.
5. “Ухаан далай номноос эхтэй” 12 боть цуврал номын үзэсгэлэн
6. “Эрдмийн далай” сэдэвт цуврал номын үзэсгэлэн

7. “Танин мэдэхүйгээ хөгжүүлцгээе” сэдэвт үзэсгэлэн
8. “Монгол ардын үлгэрүүд” сэдэвт үзэсгэлэн
9. “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын өдөрт зориулан хүүхдийн номын фондын монгол бичгээр хэвлэгдсэн ном, монгол хэлний толь бичиг, эх хэл- бичиг, соёлын түүхтэй холбогдол бүхий номын үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.
10. “Миний номын өргөө” танхим, “Их мэдэх танхим” танхимд цэцэрлэгийн насны хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролд зориулан танин мэдэхүй, сэтгэхүйн хөгжүүлэх, үлгэр, түргэн хэллэг, хүүхдийн дуу, шүлгийн номоор үзэсгэлэн гаргаж үйлчиллээ.
11. “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын өдөрт зориулан Нийтийн номын сангийн үндсэн фондод хадгалагдаж буй эртний үнэт ховор номын үзэсгэлэн гаргаж олон нийтэд сурталчилав.

12. “Монголын хаад” цуврал номын үзэсгэлэн
13. “Хүүхдийн танин мэдэхүйн боловсролд” сэдэвт үзэсгэлэн
14. Хичээлийн шинэ жилийн нээлтэнд зориулан “Сурах бичгийн үзэсгэлэн”, хүүхдэд зориулсан шинэ номын үзэсгэлэн,“Дэлхийн сонгомол - 50 боть” номын үзэсгэлэн
15. “Сурах бичиг, хичээлийн гарын авлага” номын үзэсгэлэн
16. “Дэлхийн хүүхдийн сонгомол зохиолын эрдэнэсийн сан” цуврал номын үзэсгэлэн
17. TOEFL-ийн шалгалтанд бэлтгэх англи номын үзэсгэлэн

18. “Миний номын өргөө” төслийн хүрээнд ирсэн үлгэр, танин мэдэхүйн номын үзэсгэлэн
19. “ Үлгэрийн ертөнцөөр аялацгаая” сэдэвчилсэн 1152 номоор 18 удаа үзэсгэлэн гаргаж уншигч-хэрэглэгчдэд сурталчиллаа.

Дэлхийн Хүүхдийн номын өдөрт зориулан дараах нэрийн үзэсгэлэнг гаргаж уншигчдын хүртээл болголоо.

1. “Г.Х.Андерсены үлгэрийн ертөнцөөр аялцгаая ” үзэсгэлэн
2. “Том ном ”-ын үзэсгэлэн
3. Хүүхдүүдэд зориулсан англи номын үзэсгэлэн
4. Монголын хүүхдийн шилдэг номын үзэсгэлэн
5. “Их мэдэх” танхимд Цэцэрлэгийн 3-6 насны хүүхдэд зориулсан танин мэдэхүй, үлгэрийн номын үзэсгэлэн гаргаж, уншигчдад сурталчиллаа.
6. Жижиг номын үзэсгэлэн
7. 1960-1980-аад оны хүүхдийн уран зохиол, үлгэрийн номын үзэсгэлэн
   ЕБС-ийн сургалтын гарын авлага, сурах бичгийн үзэсгэлэн

“Номын баяр-2015” арга хэмжээний үеэр Г. Дэмидын талбайд шинэ номын үзэсгэлэнг тус тус гаргаж олон нийтэд сурталчиллаа.

Үзэсгэлэнгийн танхимд “Монголын болон гадаадын хүүхдийн уран зохиол” сэдэвт номын үзэсгэлэн гаргаж, уншигчдад сурталчиллаа.

Цахим мэдээ мэдээлэл, сурталчилгаа

Аймгийн нийтийн номын сангийн вэбсайт болох library.ar.gov.mn сайтад цаг үеийн шинэ шинэ мэдээлэл, номын сангаас зохион явуулж буй бүхий л үйл ажиллагаа, арга хэмжээ, хөтөлбөрүүд мөн уншигч үйлчлүүлэгчид хэрэгцээтэй мэдээллээр баяжуулж байна.

Үүнд: Номын тухай сонирхолтой баримтууд, Үнэгүй ном, Ном унших ашиг тусын тухай 10 зөвлөмж, Яруу найргийн тэмцээн боллоо, Хүүхэд багачуудын заавал унших номын жагсаалт, Маш сонирхолтой өвөрмөц шийдэлтэй номын тавиурууд, Хүн төрөлхтний түүхийг өөрчилсөн 10 ном, Хүүхдийн шинэ ном хэвлэгдэн гарлаа, Урилга, Үндэсний бичиг үсгийн баяр, Миний номын өргөө, Дэнж хотойтол сайхан наадаарай, Хичээлийн шинэ жилийн мэнд хүргэе, Соёл урлагийн ажилтнуудын баярын мэнд хүргэе, Номын баяр, Номын баяр тэмдэглэн өнгөрүүллээ зэрэг мэдээ, мэдээллүүд багтана.

5. Лавлагаа, мэдээллийн ажил

Иргэд, уншигч, үйлчлүүлэгчдийг хүссэн мэдээллийг цаг тухай бүрт нь нийтийн номын сангийн архивт хадгалагдаж буй сонин, сэтгүүлээс шүүн лавлагаа өгч үйлчилсэн.Үүнд:

2012-2014 оны өдрийн сонин 12 нэгж , 2011-2014 оны төрийн мэдээлэл сэтгүүл 12 нэгж, 2013 оны Архангайн амьдрал сонин

1970-1990 оны “Намын үнэн” сонин 49 нэгж, 1968-1990 оны Архангайн амьдрал сонин 28 нэгж, 2008-2014 оны “Төрийн мэдээлэл” сэтгүүл 16 нэгж, 2014 оны 1 нэгж, 2014 оны “Төрийн мэдээлэл” сэтгүүл 2 нэгж, нийт 70 нэгж сонин, сэтгүүл

Төрийн мэдээлэл 1996-2004 оны сэтгүүл, Архангайн амьдрал 2000- 2014 оны сонин, сэтгүүл

“Намын үнэн” сонин 1970-1980 он, “Архангайн амьдрал” 1960-1975 он, “Төрийн мэдээлэл” 2010-2014 оны сэтгүүл

1960-1995 оны “Архангайн амьдрал” сониноос Тээврийн байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ойд зориулан тус салбарын түүхтэй холбогдол бүхий мэдээлэл

Архангайн үнэн сонины 1959-1990 оны 30 нэгж сонин, Төрийн мэдээлэл 2012-2014 оны 6 нэгж сонин, сэтгүүл

Төрийн мэдээлэл, хууль зүйн мэдээлэл сэтгүүлээс хууль тогтоолын картын сан зохион байгуулж, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2013-2014 оны дугааруудаас уншигч үйлчлүүлэгчдийн хэрэгцээт мэдээллийг шүүн өгч ажиллалаа.

11 дүгээр сард “Төрийн мэдээлэл”, “Хууль зүйн мэдээлэл сэтгүүл”- ийн 2014 оны дугаарууд, “Архангайн үнэн” 1960-1990 он, “Архангайн амьдрал” сонины 2012-2014 оны дугаарууд, “” Архангайн толь” сонины 2012-2014 оны дугааруудаас уншигчдын хэрэгцээт мэдээллийн лавлагаа өгч үйлчиллээ.

6. Мэргэжил, арга зүйн ажил:

Фондын номын санч, номзүйч каталогич Л.Өсөхбаяр 2015 онд давхардсан тоогоор нийт 20 удаа мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ганцаарчилсан сургалт явуулсан. Үүнд:

2-р сард Өлзийт, Батцэнгэл, Хангай сумын номын санч нарт утсаар

3-р сард Хотонт, Цэнхэр, Өгийнуур , Хашаат, Эрдэнэмандал зэрэг сумын номын санчдад

5-р сард Цахир сумын номын санч Амармэндэд номзүйн ангиллаар ном ангилах, бүх техник ажиллагааг хийх, номын нэг бүрчилсэн бүртгэлд ном данслах, номын үзэсгэлэн

гаргах , номын сангийн өдөр тутмын бүртгэл хөтлөх аргачлал, Булган сумын номын санч Цолмонд каталогийн карт хэвлэн гаргаж, үсэг дараалал болон шинжлэх ухааны салбараар эрэмбэлж төрөл ангийн каталогт байрлуулах, бар код , формуляр хэвлэх, ном хэвлэлийг дахин үнэлэх журмын талаар арга зүйн зөвлөгөө өглөө.

Мөн 6-р сард Батцэнгэл, Булган, Өлзийт, Ихтамир, Жаргалант, Хайрхан, Хотон, Цэнхэр зэрэг сумдын номын санч нарт мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгсөн мөн Эрдэнэмандал, Өндөр-Улаан, Хангай сумдын номын санч нарт номын сан- номзүйн ангиллаар ном ангилах арга зүй болон бусад ажлын талаар мэргэжлийн зөвлөгөө өгч ажилласан.

Мэдээлэл технологийн ажилтан Б.Ариунзаяа 2015 он Monbiblio програм, компьютерийн хэрэглээний талаар нийт 14 удаа ганцаарчилсан болон утсаар зөвлөгөө өгч ажилласан. Үүнд:

2-р сард Хотонт, Хайрхан сумдын номын санч нарт

8-р сард Спортын цогцолбор сургуулийн номын санч Л.Болорцэцэг, Хангай сумын номын санч Х. Эрдэнэчимэг, Тариат сумын номын санч О. Гандолгор нарт

9-р сард Спортын цогцолбор сургуулийн номын санч Л.Болорцэцэгт, Булган сумын номын санч Г. Цолмонд, Өлзийт, Батцэнгэл, Хайрхан сумдын номын санч нарт Monbiblio программын талаар

10-р сард Өгийнуур, Батцэнгэл, Хангай сумдын номын санчид, Спортын цогцолбор сургууль, Хүмүүн 2-р сургуулийн номын санч нарт мэргэжил- арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Мөн Нийтийн номын сангийн LIB4U программыг ажиллагаанд оруулан, ном шивэх, электрон каталогт шилжих ажлыг үргэлжлүүллээ.

7. Сургалтанд хамрагдсан байдал

Аймгийн Нийтийн номын сан дээр ЯХИС-ийн “Миний номын өргөө” төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Архангай аймаг дахь Японы Хүүхдийг ивээх сангаас зохион байгуулсан “Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь төсөл 2012-2016” –ийн хүрээнд зохион байгуулсан 2 өдрийн сургалтанд захирал О.Мөнхтуяа, хүүхдийн номын санч А.Ундармаа нар хамрагдлаа.

1-р сарын 13-16-ны өдрүүдэд ЯХИС –ийн “Миний номын өргөө” төслийн хүрээнд Өвөрхангай аймагт зохион байгуулсан туршлага солилцох уулзалт-аялалд хүүхдийн

номын санч А. Ундармаа оролцсон.

Аймгийн Нийтийн номын сан дээр ЯХИС-ийн “Миний номын өргөө” хөтөлбөр хэрэгжихтэй холбогдуулан 4-р сарын 8-9-ны өдрүүдэд ЯХИС-аас зохион байгуулсан “Идэвхжүүлэгчдийн хариуцлага-хамтын ажиллагаа” сэдэвт 2 өдрийн сургалтанд хүүхдийн номын санч А.Ундармаа Улаанбаатар хотноо хамрагдав.

4-р сарын 23-нд Аймгийн ХГБХХ-ээс “Хүүхэд, хамгааллын дэлхийн 7 хоног”-т зориулан зохион байгуулсан “Улаанбаатар” их сургуулийн сэтгэл судлаач, доктор профессор Т.Намжил багшийн “Гэр бүлийн боловсрол” сэдэвт 2 цагийн сургалтанд хүүхдийн номын сан А.Ундармаа, Л.Өсөхбаяр, үйлчлэгч Ё.Алтантариа нар хамрагдлаа.

Монгол улс дахь ЮНЕСКО-гийн салбараас МУ-ын 21 аймагт зохион байгуулсан “Хариуцлагатай залуу манлайлагч” сэдэвт 2 хоногийн сургалтанд мэдээлэл-технологийн ажилтан Б. Ариунзаяа хамрагдсан.

9-р сарын 3-ны Архивын улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнг аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Бичиг хэргийн ажилтнуудын сургалт”-нд мэдээлэл-технологийн ажилтан Б. Ариунзаяа хамрагдсан.

9-р сард Японы хүүхдийг ивээх сангаас зохион байгуулсан “Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь ” төсөл 5-6 настай хүүдийн сургууль бэлтгэгдсэн байдлыг судлах судалгааны арга зүйн сургалтанд фондын номын санч, ном зүйч, каталогич Л.Өсөхбаяр хамрагдлаа.

8. Электрон каталоги

Үндсэн фондын 647 нэр төрлийн 680 ном, нийтийн уншлагын танхимын ойрын фондын 210 нэр төрлийн 234 номыг электрон каталогит шивж оруулаа.

9. Соёл олон түмний ажил

“Би Эх орны цэрэг-2015” яруу найргийн тэмцээн

Зэвсэгт хүчний 94 жилийн ой, Холх голын байлдааны түүхт ялалтын 76 жилийн ойд зориулан зохион байгуулсан “Би Эх орны цэрэг -2015” яруу найргийн тэмцээн 2015 оны 03 сарын 17-ний өдөр Архангай аймгийн

ЗДТГ –ын зааланд болж өнгөрлөө. Энэхүү тэмцээнийг Архангай аймгийн цэргийн штаб, Аймгийн нийтийн номын сан хамтран зохион байгуулсан бөгөөд тус тэмцээний шүүгчээр СГЗ, зохиолч, сэтгүүлч Гочоогийн Жамц, Зохиолч сэтгүүлч Самбуугийн Бараанасан, Залуу яруу найрагч Чойжилсүрэнгийн Мөнхбаяр нар ажилласан.

Тус тэмцээнийг ЕБС-ийн ахлах бүлгийн сурагчид болон насанд хүрэгчдийн дунд зохион байгуулсан бөгөөд 50 гаруй яруу найрагчид өрсөлдснөөс Нэгдүгээр байранд 4-р сургуулийн 10 а ангийн сурагч Ч.Бямбадолгор, Хоёр дугаар байранд залуу яруу найрагч Б.Жамъянхүндэв, Гуравдугаар байранд 3-р сургуулийн 8б ангийн сурагч Ү.Жавзмаа, Тусгай байранд 3-р сургуулийн М.Анударь нар тус тус шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

“Би Эх орны цэрэг ” яруу найргийн тэмцээнийг жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар төлөвлөөд байгаа бөгөөд энэ жилийн яруу найргийн тэмцээнээр нийт 150 гаруй яруу найраг сонирхогч, уншигч, зохиолч, хүүхэд багачуудыг хамруулан оролцуулсан байна.

Үндэсний бичиг үсгийн баяр

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 06 сарын 24-ний өдрийн 105 дугаар зарлигийн хэрэгжүүлэх, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, үндэсний бичиг соёлоороо бахархах үзэл, ухамсрыг олон түмний оюун санаанд төлөвшүүлэх, сурах, судлах эрмэлзэл төрүүлэх, монголчуудын үндэсний өв соёлоо



сэргээн хэрэглэх, дэлгэрүүлэх ажлыг олны хүртээл болгох зорилго тавин “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг 6 сарын 1-ний өдөр Аймгийн Нийтийн номын сангийн байранд тэмдэглэн өнгөрүүллээ.

Энэхүү үйл ажиллагааг Нийтийн номын сангаас ЗДТГ, МУБИС-ийн харъяа Архангай Багшийн сургуулийн хүмүүнлэгийн ухааны тэнхим, Зураач урчуудын холбоотой хамтран зохион байгуулсан.

Насанд хүрэгчдийн дунд “Зөв сайхан бичигтэн”, “Түргэн уншлага”,

“Уран бичлэг”-ийн уралдаан, ЕБС-иудын дунд, ахлах бүлгийн сурагчдын дунд “Зөв сайхан бичигтэн”, “Түргэн уншлага”-ын уралдааныг зохион байгуулж, нийтийн дунд “Архангайн сайхан бичигтэн” уралдааныг зарлаж, ирүүлсэн бүтээлээс шилдгийг шалгаруулан, шагнаж урамшууллаа.

Мөн МУБИС-ийн Архангай аймаг дахь Багшийн сургуулийн Хүмүүнлэгийн ухааны тэнхимээс ЕБС-иуд, их, дээд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш нарын дунд “Монгол бичгийн онол, арга зүй” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж, шилдэг илтгэлийг 3-н байраар шалгаруулаа.



Нийтийн номын сангийн уншлагын танхимуудад “Бичиг соёлоо дээдэлье” сэдэвт монгол бичгээр хэвлэгдсэн номын үзэсгэлэн гаргаж, олон нийтэд сурталчилсан бөгөөд Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд бэлтгэсэн бүтээлийн үзэсгэлэнг гарган олон нийтэд танилцуулж сурталчилсан.

Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан ЯХИС-ийн “Миний номын өргөө” өртөөг ажиллуулж, хүүхэд багачуудад ном, тоглоомын багцаар үйлчиллээ.

“Номын баяр-2015”

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 08 сарын 24 –ний өдрийн 158 дугаар зарлтгийн хэрэгжүүлэх, орон нутагт ном унших хөдөлгөөн өрнүүлэх, хүүхэд залуучуудын ном унших сонирхолыг хөхүүлэн дэмжих, зөв удирдан чиглүүлэх, номын өв санг баяжуулах, ном унших ая холбогдолыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Номын баяр-2015” арга хэмжээг 10-р сарын 24-ний өдөр Г.Дэмид жанжины талбайд аймгийн ЗДТГ, БСГ –тай хамтран зохион байгууллаа. Номын баярын арга хэмжээнд аймгийн засаг дарга Д.Бат-

Эрдэнэ, аймгийн ЗДТГ-ийн дарга Б.Лхагвасүрэн, ХБХ –ийн дарга Д.Оюунчимэг, НХХ-ийн дарга Ш.Нямдаваа нар оролцож, хүндэтгэл үзүүлсэн.

“Номын баяр-2015” арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаанд Эрдэнэбулган сумын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд зохиолын баатрын дүрд хувиран, маск парадаар жагсаж оролцов.

Арга хэмжээний хүрээнд цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдүүдийн дунд “Үлгэрийн баатрууд амилсан нь”

дүрийн тоглолт, ЕБС-ийн бага бүлгийн сурагчдын дунд “Түргэн хэллэг”-ийн уралдаан, дунд бүлгийн сурагчдын дунд МУ-ын төрийн шагналт, зохиолч Сономын Удвалын зохиол бүтээлээр жүжигчилсэн “Дүрийн тоглолт”, ахлах бүлгийн сурагчдын дунд “Хайр” богино өгүүллэгийн уралдааныг тус бүр зохион байгуулж, шилдгүүдийг шалгаруулан урамшуулсан бөгөөд Тус арга хэмжээнд нийт 1500-2000 хүүхэд багачууд, эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчид, уншигч хэрэглэгч нар оролцсон өргөн хүрээг хамарсан үйл ажиллагаа болж өндөрлөсөн.

Мөн “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж, аймаг, нийслэлийн Нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм, номын сан, уншигчийн эрх, үүргийг сурталчилан, уншигчийн карт нээж, иргэд, олон нийтээс санал хүсэлт авч, шинэ номын үзэсгэлэн, номын худалдаа, ном хандивлах, бэлэглэх, онч мэргэн үгстэй номон чихэр тараах зэрэг үйл ажиллагаанууд зохион байгуулагдлаа.

Хотонт, Батцэнгэл суманд зохион байгуулсан “Номын баяр-2015” арга хэмжээ

2015.11.10. Хотонт суманд “Номын баяр-2015” арга хэмжээг хөдөөгийн алслагдсан сумдын иргэдийг хамруулах, тэдэнд шинэ мэдээллээр үйлчлэх, сурталчилах зорилгоор зохион байгуулав.

МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2013-2016 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрдэм боловсролтой монгол хүн, хүүхэд багачуудыг номонд дуртай болгох зорилгоор Хотонт сумын номын сантай хамтран “Номын баяр”-ын өдрийг зохион байгууллаа.

Аймгийн Нийтийн номын сан номын үзэсгэлэн, номын худалдаа, Хотонт сумын номын сан, тус сумын Ахлах сургуулийн номын сан, Эрүүл мэндийн газар , цэцэрлэг хамтран номын үзэсгэлэн, сурагчдын бүтээлийн үзэсгэлэн, эцэг, эх хүүхдийн хамтын бүтээлийн үзэсгэлэнг тус бүр гаргаж,

“Авьяас”, “Ном” хөтөлбөрийн хүрээнд “Үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн тоглолт, “Том ном ” бүтээлийн уралдааныг дүгнэж, урамшууллаа.

"Том ном " бүтээлийн уралдаанд Б. Буянзаягийн "Балхүү зураг зурсан нь", М. Бадар-Уганы монгол ардын үлгэр "Болдоггүй бор өвгөн", Ж.Өсөхжаргалын "Цагааханы зүүд" зэрэг бүтээлүүд шалгарсан. "Үлгэрийн баатрууд амилсан нь" дүрийн тоглолтонд Хотонт сумын ахлах сургуулийн 5б ангийн

сурагчдын С.Маршакийн зохиол "Тэнэг бяцхан хулганы үлгэр" сэдэвт дүрийн тоглолт "Тэргүүн" байр эзэллээ.

Номын баярын үйл ажиллагаанд багш, сурагчид, цэцэрлэгийн хүүхэд багачууд, эцэг, эх нийт 100 хүн хамрагдлаа.

2015.11.11. Батцэнгэл сумнад зохион байгуулсан номын баяр:

Батцэнгэл сумын Соёлын төвийн номын сан, сургуулийн номын сантай хамтран "Номын баяр-2015 " арга хэмжээг зохион байгууллаа.

Номын баярын арга хэмжээний хүрээнд

сурагчдын урлагийн тоглолт, "Үлгэрийн баатрууд амилсан нь" дүрийн тоглолтууд, "Ном" хөтөлбөрийн хүрээнд хийсэн

сурагчдын бүтээлийн үзэсгэлэн, сумын номын сангийн номын үзэсгэлэн зэрэг арга хэмжээг зохион байгууллаа.

“Үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн тоглолтонд Батцэнгэл сумын ЕБС-ийн Цэндсүрэн багштай 4а ангийн сурагчдын С.Маршакын “Муурын байшин”, Алтанчимэг багштай 7а ангийн сурагчдын “Хэлдэг гурав хийдэг ганц”, Наранхүү багштай цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхдүүдийн “Ногооны зах дээр” дүрийн тоглолтууд шалгарлаа.

Аймгийн Нийтийн номын сангаас хүүхэд болон насанд хүрэгчдэд зориулсан шинэ номын үзэсгэлэн, “Аз хур” номын их дэлгүүрийн Архангай аймаг дахь салбартай хамтран ажиллаж шинэ номын худалдаа зохион байгуулж, алслагдсан сумдын иргэдэд ном, мэдээллийн үйлчилгээг хүргэх үйл ажиллагааг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд сумын удирдлага, төрийн албан хаагчид, багш, сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүд, эцэг эхийн төлөөлөл, иргэд оролцож нийт 250 гаруй хүн хамрагдлаа.

10. Шинэлэг ажил

“Миний номын өргөө” –ний нээлтийн үйл ажиллагаа

2015 оны 05 сарын 18 –ний өдөр Дэлхийн банкны итгэлцлийн сан болох Японы нийгмийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хүүхдийг ивээх сангаас МУ-ын БСШУЯамтай хамтран хэрэгжүүлж буй “Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь ” төслийн хүрээнд гэр бүлийн орчинд хүүхдийг сургуульд бэлтгэх хөтөлбөрийн дагуу 4 аймгийн 30 суманд амжилттай хэрэгжиж байгаа “Миний номын өргөө ”-г Архангай аймгийн Нийтийн номын сангийн байранд нээх нээлтийн үйл ажиллагаа боллоо.

Энэхүү номын өргөө нь ном тоглоомын 10 багцыг ашиглан цэцэрлэгт хамрагдаагүй 5 настай хүүхдүүдийг гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэж, СӨБ-ын анхан шатны мэдлэгийг сонирхолтой, хөгжөөнтэй байдлаар эзэмших боломж олгож байна. Нэг багцад хүүхдэд зориулсан үлгэр, танин мэдэхүй, дуу, шүлгийн 10 ном, сэтгэхүй хөгжүүлэх, гар зүгшрүүлэх, өнгө дүрс ялгах 3 тоглоом багтсан байдаг бөгөөд энэхүү багцыг хүүхэд 7

хоногийн дотор эцэг эх асран хамгаалагчийн тусламжтайгаар уншиж, судлан, тоглож өөрийгөө хөгжүүлэх юм.

Нэг багцыг 7 хоног тутамд солих бөгөөд дахин нэг багц авч хэрэглэнэ. Ийнхүү нэг хүүхэд 100 ном 30 тоглоом тоглож хичээл эхлэхээс өмнө сургуульд бэлтгэгдэн 1-р ангид элсэн суралцах боломжтой болно.

Бид хүүхдэд гарсан ахиц, дэвшлийн талаар судалгаа явуулан гарааны, явцын, эцсийн шатны үнэлгээ тогтоон, эцэг эх, асран хамгаалагчид нь заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

Миний номын өргөө нь эхний ээлжийн 9 хүүхдийг хөтөлбөрт хамруулж,Тэдний 3 хүүхэд нь 1-р ангид элсэн амжилттай суралцаж байна.

2015 оны 10 сарын 08-ний өдөр Хөгжлийн бэхшээлтэй хүүхдүүдэд зориулсан 2-р ээлжийн хөтөлбөрт арга хэмжээг эхлүүлж 4 хүүхдийг сонгон авч тусгай багцыг олго эхэлсэн. Өнөөдрийн байдлаар 2 дахь багцаа судалж байна.

Мөн Эрдэнэбулган сумын 4-р багийн 9-р цэцэрлэгийн 19 хүүхэд тус хөтөлбөрт хамрагдаж эхлээд байгаа бөгөөд 2015 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр ЯХИС-тай хамтран эцэг эх, асран хамгаалагч нарт сургалт зохион байгуулж, гэрээ хийн, багц олгох үйл ажиллагаа зохион байгууллаа.

Сэтгэхүй хөгжүүлэх тоглоомууд

Багцуудад багтсан зарим ном

1-р ээлжийн Миний номын өргөө төсөлд хамрагдаж буй М.Рэнцэндорж ээж эгч дүүгийн хамт.

Уг төсөлд хамрагдаж буй Б.Энхсаран эцэг, эх, эгчийн хамт 5 дахь багцаа авч байна

1-р ээлжийн миний номын өргөө төсөлд хамрагдсан Г. Анхбаяр ээжтэйгээ хамт дараагийн багцаа солиулахаар ирээд байгаа нь



2 дахь ээлжийн тусгай хөтөлбөрт хамрагдаж буй Ц.Үүлэн

2 дахь ээлжийн хөтөлбөр. А.Солонго гарааны үнэлгээ тогтоолгож байгаа нь

2 дахь ээлжийн хөтөлбөр. багцаа гардан авч байгаа нь.

Номын санчид 2 дахь ээлжийн тусгай хөтөлбөрийн багц ашиглалтын талаар зөвлөгөө мэдээлэл өгч байгаа нь

11. Бусад ажил

1. Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Цасны баяр-2014” арга хэмжээнд хамт олноороо идэвхитэй оролцосон.
2. Сар шинийн баярыг угтан аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөлийн сүлжээ байгууллагуудаас зохион байгуулсан “Сүүтэй лекц” сургалтанд номын санч А.Ундармаа, А.Оюунцэцэг нар хамрагдлаа. Хүний эрхийн үндэсний комиссын Архангай дахь салбарын Хүний эрхийн ахлах мэргэжилтэн Энхтүвшин нь “Хүний эрх, хамгаалал, зөрчил” сэдэвт сургалт зохион байгуулж, оролцогч хүн бүр сүү хандивлах ажиллагаа боллоо.
3. 4-р сарын 21-ний өдөр буюу Дэлхийн Хүүхдийн номын өдөрт зориулсан аймгийн “АВ” телевизийн “Зочин” нэвтрүүлэгт хүүхдийн номын санч А.Ундармаа оролцож, хүүхдийн уншлагын танхим, “Их мэдэх” танхимын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан танилцууллаа.
4. 4-р сарын 25-ны өдөр. Бүх нийтийн цэвэрлэгээний өдөр хамт олноороо хариуцсан талбайгаа цэвэрлэж, хогийг ачууллаа.
5. 5-р сарын 1. “Мод тарих-Үндэсний өдөр”-өөр хамт олноороо Булган уулын баруун талд 9 ширхэг бургас мод тарьж аймгийнхаа ногоон хөгжилд хувь нэмэр оруулсандаа талархалтай байна.
6. 5-р сарын 4. Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан МУИС-ийн багш, түүх судлаач Өлзийбаярын “Та яагаад эх түүхээ судлах ёстой вэ?” сэдэвт лекцэнд хамт олноороо хамрагдсан.
7. 5-р сарын 13. Аймгийн ХГБХХ, Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Архангай -1,2 ОНХХ хамтран зохион байгуулсан гэр бүл судлаач М.Баясгалангийн “Гэр бүл” лекцэнд номын санч Л.Өсөхбаяр, мэдээлэл технологийн ажилтан Б.Ариунзаяа нар хамрагдлаа.
8. Байгууллагын гадна талбайд хайс хийж, зүлэгжүүлэх болон номын сангийн танхимуудыг цэцэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.
9. Архангай аймагт Аудитын байгууллага үүсч хөгжсөний түүхт 20 жилийн ойн баярын хурал, МУ-ын Засгийн газрын болон УИХ-ын гишүүд оролцсон хуралд хамт олноороо идэвхтэй оролцлоо.

10. Монгол Улсын ардын хувьсгалын 94 жилийн ой, Их Монгол улс байгуулагдсны 809 жил, Архангай аймаг байгуулагдсны 92 жилийн ойн баяр наадмын үйл ажиллагаанд хамт олноороо наадмын талбайн чимэглэл хариуцан ажилласан.
11. Аймгийн Мэргэжлийн Хяналтын газраас зарласан “Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын сарын аян”-ы нээлтийн арга хэмжээнд оролцож, “Номын сангийн тухай хууль”, аймаг, хотын Нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм, уншигчийн эрх үүргийг сурталчилан, шинэ ном, лавлах толь бичгийн үзэсгэлэн гаргаж олон нийтэд сурталчиллаа./Хамрагдсан хүний тоо 120-130/
12. Архивын улсын үзлэгт бэлтгэн байгууллагын бүхий л албан бичиг баримтыг эмхлэн цэгцлэх ажлыг хийж гүйцэтгэж Архивын газрын дарга Гантуяагаар шалгуулан алдаа дутагдалуудаа залруулсан.
13. 09-р сарын 21-ний өдөр МУ-ын Соёл, урлагийн ажилтны баярын өдрийн арга хэмжээнд хамт олноороо идэвхтэй оролцлоо.
14. 10-р сарын 22-нд бүх нийтийн цэвэрлэгээний өдрөөр Музейн баруун талын балгасны дотор, гадна орчны талбайг хамт олноороо цэвэрлэж, хогийг ачууллаа.

БАЯН-ӨЛГИЙН АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2015 оны аймгийн Засаг даргатай хийсэн Үр дүнгийн гэрээний бүрэлдэхүүн хэсэг болох үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу тайлант онд номын сангийн үйлчилгээг орчин үеийн дэвшилтэт арга хэлбэрээр баяжуулж, уншигч бүрийн оюуны хэрэгцээ шаардлагыг хангахуйц хүссэн мэдээллийг цаг тухайд нь хүргэж, түргэн шуурхай үйлчлэв. Ажлаа сараар болон долоо хоногоор төлөвлөн ажиллав. Энэ онд манай байгууллагад бүтээлч ажлууд, шинэлэг үйлчилгээ багагүй хийгдсэн болно. Үүнд:

- Шинэ байртай болж, тохилог орчин бүрдлээ.

- Үйлчилгээний таатай орчин бүрдэж, уншлагын танхим 2 – оор нэмэгдэж, 180 хүний суудалтай 5 танхимтай болов. Бүх танхим чөлөөт сонголтоор үйлчилж байна.

“Бяцхан уншигчдын танхим” төсөл боловсруулан Дэлхийн Зөн ОУБ – ын Баян – Өлгий ОНХХ – т хандаж, дэмжигдэн **4.2₮ сая төгрөгийн** тэтгэлэгээр /LCD зурагт, CD тоглуулагч/, тохижилт /хивс, 40 сандал, 1 ширээ, ном гарын авлагад / “Бяцхан уншигчдын танхим” нээж, СӨБ – ийн хүүхдүүдэд үйлчилж байна.

- Соёл, танин мэдэхүйн танхимыг шинээр нээж, соёлын арга хэмжээ, ном тойруулсан ажлуудыг тогтмол хийж хэвшлээ.

- Сүүлийн 3 жил номын аянг тогтмол зохион байгуулж, хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх хөдөлгөөн өрнүүлэн ажиллав.



- “Зуны уншлага” хөтөлбөр 2 дахь жилдээ амжилттай хэрэгжиж, хамгийн олон ном уншсан 5 уншигчийн гэрийн номын санд 30 ном бэлэглэв. Нийт 2 жилд

10 хүүхдийн гэрийн номын санг 300 номоор баяжуулав.

- Ажилгүй ээзгтэйчүүдэд зориулсан "Ашигтай зөвөлгөө" 10 хоногийн сургалтыг зохион байгуулж, аймгийн ЭМГ–ын сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, аймгийн МХГ – ын хүнс, эрүүл ахуйн аюулгүй байдлын улсын байцаагч, аймгийн Цагдаагийн газрын хүүхдийн байцаагч, ХГБХ – ийн гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийтийн номын сангийн мэдээллийн ажилтан нар хичээл заав. Нийт 200 гаруй ажилгүй эмэгтэйчүүд хамрагдав.

- Тогыз хумалах, шатар, даам, яруу найрагийн дугуйлан хичээллүүлж сүүлийн 3 жилд 180 гаруй хүүхдүүдийг хамруулж, багш нарыг ДЗОУБ – ын Баян – Өлгий ОНХХөтөлбөрөөс цалинжуулав.

- Номын сангийн үйлчилгээг хөдөөгийн 13 сум 9 багт 3 жил зохион байгууллаа. ДЗОУБ – ын Баян – Өлгий ОННХ – ийн тэтгэлэгээр тээврийн зардал, томилолтын зардлыг шийдвэрлүүлдэг.

- Эцэг эхчүүдэд “Номын аялалд гарцгаая” сэдэвт ажлыг 2013, 2014 онд Өлгий сумын сургуулиудад зохион байгуулж номын сан, номтой нөхөрлөхийн ач тусыг мэдрүүлэх ухуулан сурталчлах ажлыг зохион байгуулсанаар номын сангийн уншигчдын тоо эрс өсөв.

- Үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн. Үүнд:



- Материаллаг баазын бэхжилт хийгдэж, номын сангийн орчны стандарт хангагдсан.

- Номын модон тавиурыг 100% шинэчлэв.
- Чөлөөт уншлагын танхимын 47 ш тавиуртай болов.
- Номын 40% - ийг соронзон ялтасжуулав.
- Соронзон хаалгатай болов./ Яамнаас 2014 онд шагналаар/

- Камержуулж, галын дохиоллын системтэй болсон.
- Зориулалтын уншигчдын хувцас, цүнхээ хадгалдаг шүүгээтэй болсон

- **Номын баяжилт.** Сүүлийн 3 жилд нийт 38.5 сая төгрөгийн 5421 ширхэг номоор фондоо баяжуулсан ба казах уран зохиол, үлгэр, танин мэдэхүйн 2615 ширхэг номтой болсон нь гадаад харилцаа холбоо бэхжиж байгаа ба аймгийн удирдлагын хөөцөлдөөн, ажлын үр дүн юм.

- 1432ш цахим номоор фондоо баяжуулуулж, Таблет төхөөрөмжтэй болов. 2500 гаруй казах номоор номын фондоо баяжуулсан нь сүүлийн 10 жилд авагдаж байгаагүй арга хэмжээ боллоо. Уран зохиолын, танин мэдэхүйн,

хүүхдүүдийн хөдөлгөөнт номтой болсоноор уншигчдын сонирхолыг татаж байна.

- Сумдын номын сангуудын үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангаж, ХШҮ тогтмол графикийн дагуу хийлээ. Бүх сумдын номын сангууд номоо электрон каталогт оруулж, үйлчилгээгээ автоматжууллаа.

Тулгамдаж буй асуудал:

- ✓ Ном худалдан авах зардлыг нэмэгдүүлэх /2015 онд 4.2 сая төгрөгийн төсөвтэйгээс 1.2 сая төгрөгөөр тогтмол хэвлэл захиалдаг/
- ✓ Номын сангийн орон тооны асуудал. 3 манаач, 1 үйлчлэгч, мэдээллийн ажилтан, ном зүйч, өдрийн жижүүр, нийт 6 орон тоо нэн шаардлагатай.
- ✓ Интернет танхим нээх
- ✓ СТМА- ын танхимыг ширээ, сандалтай болгох /10 ширээ, 20 сандал/
- ✓ Цахим ном хаялтын төхөөрөмжтэй болох

Аймгийн нийтийн номын сангийн үйл ажиллагааны талаар товч танилцуулга

Тус номын сан нь нийт 144.0 сая төгрөгийн төсөвтэй, 13 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Батлагдсан төсвөөс 11 хүнийг үндсэн цалингаар, 2 манаач, 1 үйлчлэгчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулж байна.

Уншлагын 5 танхимтай./насанд хүрэгчдийн, гэрээр ном олгох ба уншлагын, хүүхдийн уншлагын танхим – 2, бяцхан уншигчдын танхим/

Сүүлийн 3 жилийн ажлын үр дүн:

- Шинэ байр - тохилог орчин бүрдлээ.

- Үйлчилгээний таатай орчин бүрдүүлж, шинэлэг хэлбэрийн ажлуудыг санаачлан нийлээ.

  - Уншлагын танхим 2 – оор нэмэгдэж, 5 танхимаар үйлчилж байна.

  - Уншлагын танхимыг чөлөөт сонголттой болгов.
  - Соёл, танин мэдэхүйн танхимыг шинээр нээж, соёлын арга хэмжээ, ном тойруулсан ажлыг тогтмол хийж хэвшлээ.

- Бяцхан уншигчдын танхим нээж, тохижуулан сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдүүдийг номтой нөхөрлүүлж байна.
- Сүүлийн 3 жил номын аянг тогтмол зохион байгуулж байна.
- “Зуны уншлага” –ыг 2 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.
- “Үлгэрийн цаг”
- Ажилгүй эзэгтэйчүүдийн сургалт
- Тогыз хумалах, шатар, даам, яруу найрагийн дугуйлан хичээллүүлж 3 жилд 180 гаруй хүүхдүүдийг хамруулж, багш нарыг ДЗОУБ – ын Баян – Өлгий ОНХХөтөлбөрөөс цалинжуулав.
- Номын сангийн үйлчилгээг хөдөөгийн 13 сум 9 багт 3 жил зохион байгууллаа. ДЗОУБ–ын Баян–Өлгий ОННХ–ийн тэтгэлэгээр тээврийн зардал, томилолтын зардлыг шийдвэрлүүлдэг.
- Эцэг эхчүүдэд “Номын аялалд гарцгаая” сэдэвт ажлыг 2013, 2014 онд Өлгий сумын сургуулиудад зохион байгуулж номын сан, номтой нөхөрлөхийн ач тусыг мэдрүүлэх ухуулан сурталчлах ажлыг зохион байгуулсанаар номын сан уншигчтай болов .

- Үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн Үүнд:

Он / **Үзүүлэлт**	**2012**	**2013**	**2014**	**2015** /одоогийн байдлаар/	**Номын эргэлт**
Уншигч	10709	25450	33195	23838	
Олгосон ном	21420	43070	44385	37856	79.8%

- Материаллаг баазын бэхжилт хийгдэж, номын сангийн орчны стандарт хангагдсан.

Он / **Үзүүлэлт**	**2012**	**2013**	**2014**	**2015**
Үнийн дүн	15.2 сая	7.6 сая	31.1сая	9.3 сая

- Номын модон тавиурыг 100% шинэчлэв.
- Чөлөөт уншлагын танхимын 47 ш тавиуртай болов.
- Номын 40% - ийг соронзон ялтасжуулав.
- Соронзон хаалгатай болов./ Яамнаас 2014 онд шагналаар/
- Камержуулж, галын дохиоллын системтэй болсон.

- Зориулалтын уншигчдын хувцас, цүнхээ хадгалдаг шүүгээтэй болсон

Номын баяжилт

Он / Үзүүлэлт	2012	2013	2014	2015 /одоогийн байдлаар/
Үнийн дүн	2.1 сая	19.6 сая	10.2	7.5
Тоо ширхэг	276	2721	1499	1117

- Цахим номоор фондоо баяжуулуулж, Таблет төхөөрөмжтэй болов. /1432ш/
- 2500 гаруй казах номоор номын фондоо баяжуулсан нь 2005 оноос хойч авагдаж байгаагүй арга хэмжээ боллоо.

- **СТМАжлын чанар, үр ашгийг дээшлүүлж, хүртээмжийг нэмэгдүүлсэн.**

  - Аймгийн чанартай уралдаан тэмцээнүүдэд аймаг, сумдыг хамруулж байна.
  - СТМА – ын нэр төрлийг олшруулан шинэлэг хэлбэрээр зохион байгуулж байна.

- Сумдын номын сангуудын үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангаж, ХШҮ тогтмол графикийн дагуу хийж байна. Сумдын номын сангуудын 80% нь мэргэжилтэй боловсон хүчнээр хангагдан, үлдсэн 4 номын санч эчнээгээр суралцаж байгаа ба 2016 онд 100% мэргэжилтэй боловсон хүчнээр хангагдах болно. Бүх сумдын номын сангууд номоо электрон каталогт оруулж, үйлчилгээгээ автоматжуулсан.

Тулгамдаж буй асуудал:

- ✓ Ном худалдан авах зардлыг нэмэгдүүлэх /2015 онд 4.2 сая төгрөгийн төсөвтэйгээс 1.2 сая төгрөгөөр тогтмол хэвлэл захиалдаг/
- ✓ Номын сангийн орон тооны асуудал. 3 манаач, 1 үйлчлэгч, мэдээллийн ажилтан, ном зүйч, өдрийн жижүүр, нийт 6 орон тоо нэн шаардлагатай.
- ✓ Интернет танхим нээх
- ✓ СТМА- ын танхимыг ширээ, сандалтай болгох /10 ширээ, 20 сандал/
- ✓ Цахим ном хаялтын төхөөрөмжтэй болох

БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1.НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

1.1. Лавлагаа арга зүйн ажил

1.1.1 Лавлагаа

Цахим программын бүртгэл ашиглан 498 уншигчдад лавлагаа өгч, амаар 111 уншигчдад, утсаар 58 уншигчдад, 116 уншигчдад цаасан каталог ашиглах, 113 уншигчид электрон каталог ашиглах талаар заавар зөвлөгөөг өгч, холбогдох бүртгэлүүдийг хөтөлж, номын 1200 гаруй каталогийг скочдож каталогит байрлуулахад бэлтгэлээ. Ганжуур, данжуур номын цуврал, Цондоолой, Цүндээлэй цуврал, “Миний бяцхан одой морь” 1-10 цуврал, “Динза” цувралууд болон нийт 24 номыг татгалзлаар бүртгэж, шинэ номын захиалгад оруулж, эдгээрээс 18 номыг нь авсан байна.

Л.Түдэв, Ш.Ванчаарай, Д.Нацагдорж, Г.Акимийн намтар уран бүтээлээр уншигчдад зориулсан ном зүйн бүртгэл, “Ш.Ванчаарай” санамж өгөх ном зүйн гарын авлагыг бэлтгэн уншигчдад сурталчилж. ном зүйн бүртгэлийг баяжууллаа.

1.1.2. Каталог, картын сан: Уран зохиол, улс төр бусад шинжлэх ухааны 238 номыг каталогийн картыг төрөл, анги, үсэг дараалаар каталогт байрлуулж, 2015 оны “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 01-21 хүртэлх дугааруудаар орон нутгийн картын санг баяжууллаа.

1.1.3. Арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд, ЕБС-иуд, МСҮТ, Соого Сейкео, ХҮДС-ийн номын сангийн ажилтай танилцан хагас бүтэн жилд 2 удаа арга зүйн зөвлөгөө өгч, номын сангийн программгүй Баян-ойт, Номгон бага сургууль, Эрдэнэмандал сургуулиудад программтай болохыг, Номундалай сургуулийн номын санг фондын ном 100% электрон каталогт оруулж дуусгахыг зөвлөж, МСҮТ-ийн номын санч Ч.Пүрэвмаагийн үйл ажиллагаан дээр үзүүлэх сургууль явуулж, өөрийн байгууллага дээр Баянлиг сумын номын санч, Баян-ойт, Эрдэнэмандал сургуулийн номын санчдыг дадлага хийлгэлээ. Бууцагаан, Галуут, Богд сумын сургуулийн болон Соёлын төвийн номын сангийн ажил байдалтай биечлэн танилцаж, арга зүйн зөвлөгөө өгч, Галуут, Баянлиг, Баян-Өндөр, Жаргалант сумын номын санд утсаар 2 удаа арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

1.2. Фондын үйлчилгээ:

1.2.1.Фонд баяжилт: Номын фондыг худалдаагаар 3.300.200 төгрөгний 256 ширхэг номоор, хандив бэлгээр 1.432.196 төгрөгний 126 ширхэг номоор фондыг

баяжуулж, улирал тутам 8 нэр төрлийн тогтмол хэвлэл, сэтгүүлийг улирал тутамд 343.000 төгрөгөөр захиалж, уншигчдад үйлчилж байна. Сонин сэтгүүлийг сар сараар нь нийт 36 нэгж болгон үдэж, сонин сэтгүүлийн фондонд байрлуулав.

1.2.2. Номын үзэсгэлэн:

Шинэ номын үзэсгэлэнг 4 удаа 100 номоор, сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 27 удаа 838 номоор гаргалаа.

1.2.3. Ном сэргээн засварлалт:

Нэгж тасгуудаас урагдаж муудсан, хавтас, хуудас салсан нийт 514 номыг сэргээн засварлаж, бүртгэл хөтөлсөн.

Монголын уран зохиол, гадаадын уран зохиол, байгалийн шинжлэл, техник, хөдөө аж ахуй, анагаах, шинжлэх ухааны төрлөөр нь зохиогч болон номын нэрийн үсгийн дараалаар 45000 номыг нарийвчлан ялгаж, 120 ялгагчийг хийж, электрон каталогт ороогүй 320 номын жагсаалт гаргарж, 295 номыг электрон каталогт оруулж, бар код формулярыг номонд нааж, каталогийн картыг гаргав. Данс давхардсан 8 ном байсныг залруулан ажиллаа. Фондноос цахим үйлчилгээгээр 1776 номыг уншлагын танхимууд, гэрээр ном олгох тасгаар олгож, шинээр худалдан авсан номуудад стандартын дагуу бичилт хийж, номын товч антацитайгаар шинэ номын мэдээг 2 удаа гаргаж сурталчиллаа.

Шинээр ирсэн 301 ширхэг номыг электрон каталогт оруулж бар код, формуляр каталогийн картыг хэвлэн гаргаж, байрлуулан, ховор номын мэдээллийн санг “Монгол ганжуур”, “Монгол даанжуур”, “Монголын бурхан шашны урлаг” 1-2 боть номоор баяжууллаа.

Номын формуляр хөтлөлтөнд сар бүр хяналт тавьж ажиллахад, лавлагаа, нийтийн уншлагын танхим жигд сайн хийгдэж хүүхдийн уншлагын танхим жигдэрч чадаагүй байна.

<u>1.3. Уншигчдад үйлчлэх үйлчилгээ:</u>

Байнгын 3964 уншигчдад, 34959 ирцэд, 55319 ном олгож үйлчилсэн. Уншлагын танхимуудаас электрон цахим үйлчилгээгээр 1, 4, 5, 6, 10, 11, 12-р

цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн 523 уншигчдад, электрон цахим номоор 393 уншигчдад үйлчилсэн. Өдөр тутмын сонин, сэтгүүлээр давтагдсан тоогоор 100 хүнд үйлчилсэн.



<u>Номын сан хоорондын ном солилцоо</u>: Ном солилцооны гэрээг, Ахмад настны асрамжийн төв, АЗДТГ, ШШГГ, Номгон ахлах сургууль, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төвтэй байгуулж, гэрээний хүрээнд 9 удаа 93 ном олгож ажиллалаа.

<u>Нүүдлийн номын сангийн</u> үйлчилгээг аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асрах төв, эх үрсийн баяр, Номын баяраар Баганат талбайд 2 удаа, 11-р цэцэрлэг, Ахмадын өргөө, ШШГГ, ХАА-н газар, Өлзийт МСҮТ, Ардын хувьсгалын 94 жилийн ойн баяр наадмаар дуурсахын хөндийд, “Хүрэн морь” яруу найргийн наадмаар Галуут сумд, Соёлын ажилтны өдрөөр Бууцагаан сумд хүргэж, нийт 7 удаа 756 номыг 1718 уншигчдад сурталчлан үйлчилсэн байна.

1.4. Сургалт, дугуйлан:

1.4.1. Орон нутгийн номын санчдад зохион байгуулсан сургалт

-Соёлын дээд сургуультай хамтран Улаанбаатар хотод орон нутгийн ЕБС-ийн номын санчдад номын сангийн анхан шатны мэдлэг олгох, сертификатын 21 хоногийн сургалтыг явуулж, нийт 18 хүнийг хамруууллаа.

-2015 оны 04 сард МҮНС-ийн арга зүйн хэлтсийн дарга Д.Энхтунгалаг, ахлах арга зүйч Г.Гүнжинлхам нар манай номын сан, МСҮТ, Өлзийт сумын номын сангийн ажил байдалтай танилцан, сургалт зохион байгуулж, сургалтанд 17 хүн хамрагдлаа. Өгсөн зөвлөгөөний дагуу ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэн ажилласан.

1.4.2.Хамрагдсан сургалтууд.

Захирал Б.Түвшинчимэг Буриад улсын Дорнод Сибирийн соёл урлагийн академид 3 өдрийн сургалтанд, БСШУЯ, Монголын соёл урлагийн хөгжлийн академитай хамтран зохион байгуулсан “Соёлын бүтээлч үйлдвэрлэл” сургалтанд сууж мэдлэг боловсролоо дээшлүүлсэн.

Боловсрол соёлын газар, Монголын соёл урлагийн хөгжлийн академи, соёлын байгууллагуудтай хамтран “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-орон нутгийн хөгжилд” онол арга зүйн сургалтыг соёлын байгууллагуудын мэргэжлийн ажилчдад 2 өдөр зохион байгуулж, байгууллагаас 7 хүн оролцож Сертификат гардан авлаа.

-“Соёлын бүтээлч үйлдвэрлэл-орон нутгийн хөгжилд” сургалтын үеэр номын сангаас орон нутгийн номын санчдад захирал Б.Түвшинчимэг “Номын сангийн тухай хууль, баримталж буй хууль эрх зүйн баримт бичгүүд”, ном зүйч Б.Должин “Харилцааны соёл” сэдвээр, фондоч Я.Гэрэлтуяа “Фондын зохион байгуулалт, тооллого” сэдвээр, номын санч Наранцэцэг “Соёлын олон нийтийн ажил зохион байгуулах” сэдвээр тус тус сургалт явуулж, Monbiblio программд ном оруулж буй явцын талаар мэдээллийн ажилтан Дондовжамц танилцуулж, сургалтанд 19 сумын номын санчид хамрагдсан.

1.4.3. Уншигчдад зориулсан сургалтууд:

-“Ном унших соёл” сургалтыг хүүхдийн уншлагын танхим, нийтийн уншлагын танхимаас нийт 12 удаа 640 хүнд явуулж, АХА тэмцээнийг “Ном унших соёл” болон бусад соёл олон нийтийн ажил, сургалтын үеэр 12 удаа 370 уншигчдад зохион явуулжээ.

-ЕБС-ийн ахлах ангийн 50 сурагчдад **“Цагаан сарын бэлгэдэл”** сэдэвт сургалт, “Монгол соёл-Монгол заншил” сэдвээр асуулт хариултын тэмцээн явуулж, тэмцээний тэргүүн байрыг “Эрдэм” ахлах сургуулийн 10А ангийн сурагч Азжаргал, дэд байрыг “Соого Сейкео” сургуулийн 9Б ангийн сурагч Мөнхжин нар тус тус эзэллээ.

-Угийн бичгийн сарын аяны хүрээнд ЕБС-ын 294 хүүхдэд, Баянхонгор сумын 8 багийн 360 иргэд, Цагдаагийн хэлтсийн 55 албан хаагч, нийт 709 хүнд ургийн бичгээ хэрхэн хөтлөх, ураг удам гэж чухам юу болох, угийн бичиг хөтөлсөний ач холбогдлын талаар 6 удаагийн сургалтыг байгууллагаас болон ахмад настан Г.Цэрэнтэй хамтран зохион байгууллаа.

1.4.4. Дотооддоо зохион байгуулсан сургалтууд:

Ахмад багш Сандагдоржийн монгол бичгийн хичээлд 12 удаа оролцож, монгол бичгийн ном, сурах бичиг худалдан авч үргэлжлүүлэн бие даан суралцаж байна. Сургалтын үр дүнд 7 ажилтан анхан, дунд шатны мэдлэгээ бататгаж, 2 ажилтан анхан шатны мэдлэгтэй болсон.

“Аймгаараа бүжиглэе” аяны хүрээнд зохион явуулж буй нийтийн цэнгээнт бүжгийн сургалт, Архив, албан хэрэг хөтлөгч ажилтнуудын дунд зохион байгуулсан 2 өдрийн сургалт, Хөдөлмөрийн хэлтсээс явуулсан ХАБЭА-ын сургалт, аймгийн прокурорын газраас хуульч Бор, Мөнхтуяа нар хөдөлмөрийн тухай хууль, нийгмийн халамжийн тухай хуулиар 3 байгууллагын ажилчдад явуулсан сургалт, Халамж үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн Пүрэвбаатар “Хандлага ба өөрчлөлт”, Чандмань ХХК-ын “Усаа хэмнэе” сургалт, Онцгой байдлын газрын “Гамшгаас хамгаалах сургалт” зэрэг сургалтуудад хамт олноороо оролцлоо.

1.4.5. Дугуйлан :

Номын сангийн дэргэдэх “Хонгорын хүү” шатрын дугуйланд 5-13 насны 26 хүүхэд анхан, дунд, гүнзгий шатны ангиллаар хичээллэж, аймгийн аварга шалгаруулах “Цодгор хүү” шатрын тэмцээнд амжилттай оролцож багаар 2-р байр эзэлж өргөмжлөл, мөнгөн медалиар шагнагдлаа.

1.5 Соёл танин мэдэхүйн ажил:

1.5.1.Баянхонгор аймгийн Зохиолчдын холбоотой хамтран “Дэлхийн яруу найргийн өдөр” өдөрлөг арга хэмжээг 3 дахь жилдээ зохион байгууллаа. Өдөрлөгт ЕБС-ийн номын санчид, 10, 11 дүгээр ангийн сурагчид, оюутнууд, Сооги Сейко сургуулийн “Хишигтэн” морин хуурын хамтлаг, яруу найрагчид, “ТҮ-10” телевиз, “Баянхонгор” телевиз, “Баянхонгорын мэдээ” сонины сурвалжлагч нийт 60 хүн оролцож, шүлэг яруу найргийн талаар ярилцаж, шинэ залуу яруу найрагчдыг шагнаж, урамшуулсан сайхан арга хэмжээ боллоо.

1.5.2.Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Ээждээ бичих захидал” уралдааныг 5-7-р ангийн сурагчдын дунд зохион явууллаа. Уралдаанд нийт 125 сурагч захидал ирүүлж, тэргүүн байрыг Баян-Өйт цогцолбор сургуулийн 5а ангийн сурагч Т.Сарнай, дэд байрыг Номундалай

лаборатори сургуулийн 7а ангийн сурагч С.Гантуяа, 3-р байрыг Соого Сейко сургуулийн 6б ангийн сурагч Б.Балжинням, тусгай байрыг Номгон ахлах сургуулийн 6б ангийн сурагч Э.Оюунжаргал нар тус тус ээлж өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнууллаа.

1.5.3.Монгол цэргийн баярыг тохиолдуулан "Аавдаа хэлэх чин сэтгэлийн үг" шилдэг захидлын уралдааныг нийтийн уншлагын танхим, гэрээр ном олгох тасгаас зохион явуулж, уралдаанд МСҮТ, ХҮДС, Зэвсэгт хүчний 339 дүгээр анги, ЕБС-ийн ахлах ангийн сурагчид оролцлоо. Уг уралдаанд залуу нас, сурагч насны төрлөөр нийт 86 захидал ирлээ. Залуу насны төрөлд: тэргүүн байрыг Номундалай сургуулийн 12А ангийн сурагч Э.Тулга, дэд байрыг Эрдэнэмандал ахлах сургуулийн 12А ангийн сурагч Г.Ганцэцэг, тусгай байрыг ХҮДС-ХНМ-ийн 2 дугаар дамжааны оюутан Б.Түвшинзаяа, сурагч насны төрөлд: Тэргүүн байранд Соого Сейкео сургуулийн 10В ангийн сурагч Г.Биндэръяа, дэд байранд Эрдэнэмандал ахлах сургуулийн 10Б ангийн сурагч Р.Даваахүү, тусгай байранд Номгон ахлах сургуулийн 10Г ангийн сурагч Т.Дорждэрэм нар шалгарч тус бүр өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа.

1.5.4."Алтан агшин" зохиолч уншигчдын уулзалтыг зохион байгуулж, уулзалтанд аймгийн зохиолчдын холбоо, ЕБС-ийн яруу найраг сонирхогч сурагчид, номын санчид, МСҮТ, ХҮДС-ийн оюутнууд нийт 60 гаруй ахмад, залуу үеийн төлөөлөл оролцон, "Хүрэн морь" яруу найргийн наадмын тэргүүн байрын шагналт,

монгол хэл, уран зохиолын багш С.Мөнхтогтохын шинэ бүтээл “Нууц товчооны нууцаар аялахуй” номын хэлэлцүүлэг, ”АХА” тэмцээн зохион байгуулагдаж, ТҮ-10 телевиз, “Баянхонгорын мэдээ” сонинд мэдээ, ярилцлага өглөө.

1.5.5.Олон улсын хүүхдийн номын баяр, Дани улсын үлгэрийн их хаан хүүхдийн зохиолч Х.К.Андерсены мэндэлсэний өдөрт зориулан Андерсены уран бүтээлээр "Үлгэрийн баатарууд амилсан нь" уралдааныг Баянхонгор аймгийн "Нийгмийн түншлэлийн сүлжээ" ТББ-тай хамтран зохион явууллаа. Уралдааныг ЕБС-ийн 6 дугаар ангийн сурагчдын дунд зохион явуулж, нийт 82 сурагч оролцсон. Уралдааны Тэргүүн байрыг Номгон ахлах сургуулийн 6а анги, Дэд байрыг Эрдэнэмандал ахлах сургуулийн 6г анги, гутгаар байрыг Номгон ахлах сургуулийн 6г анги, тусгай байрыг Эрдэнэмандал ахлах сургуулийн 6б ангийнхан тус тус эзэллээ. Мөн 3 нэр төрлийн дэлхийн хүүхдийн шилдэг номууд болон Х.К.Андерсены уран бүтээлээр үзэсгэлэн гаргаж уншигчдад үйлчилсэн.

1.5.6.Ахмадын холбоо, Зохиолчдын холбоотой хамтран “Ардын өв уламжлалыг залуу үеийнхэнд өвлүүлэх нь” уулзалт, цэнгүүнийг Ахмадын ордонд зохион явуулж,. уг арга хэмжээнд ахмадын хорооны дарга С.Лочинлхам, ард

түмний гавьяат яруу найрагч Х.Дэмбэрэл, уншигчид, оюутнууд, номын санч, багийн иргэд нийт 360 гаруй ахмад, залуу үеийн төлөөлөл оролцлоо.

1.5.7.Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан “Үндэсний бичгээрээ хэн сайхан бичих вэ?” уралдааныг ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион явуулж, эхний гурван байрыг шалгарууллаа. Тэргүүн байранд Номундалай цогцолбор сургуулийн 11Б ангийн сурагч Б.Хулан, дэд байранд Соого Сейкео ахлах сургуулийн 10Б ангийн сурагч Г.Биндэръяа, тусгай байранд Эрдэм ахлах сургуулийн 10Г ангийн сурагч н.Балжинням нар шалгарсан. Уралдаанд нийт 47 сайхан бичиг ирж, шагналд 6600 төгрөг зарцуулсан.



Тусгай байрын шагналт Эрдэм ахлах сургуулийн 10Г ангийн сурагч н.Балжинням

15.8. “Үндэсний бичиг үсэг”-ийн баярыг тохиолдуулан ЕБС-ийн 7-р ангийн сурагчдын дунд “Монгол бичгээр хэн хурдан унших вэ?” уралдааныг зохион явууллаа. Уралдаанд сургууль бүрээс шилдэг 5 сурагч нийт 25 сурагч хамрагдаж, тэргүүн байрыг Номгон ахлах сургуулийн 7а ангийн сурагч Т.Отгонбаяр, дэд байрыг Номундалай лаборатори сургуулийн 7а ангийн сурагч Г.Буянзаяа, гутгаар байрыг Номгон ахлах сургуулийн 7а ангийн сурагч Б.Хулан нар ээлж өргөжлөл, дурсгалын зүйлээр шагнууллаа. Шагналын санд 6900 төгрөг зарцуулсан.

1.5.9. "Зуны зугаатай уншлага" үлгэрийн болон танин мэдэхүйн ертөнцөөр аялах уншлагыг Номундалай лаборатори сургуулийн 1г ангийн 40 сурагчдад зохион явууллаа. Сурагчид 15 хоногийн хугацаанд номын санд 1 цагийн ном уншлаганд хамрагдаж, үлгэрийн чанга уншлага, Хэн нь хамгийн сайн үлгэр ярих вэ?, Уншсан үлгэрээ бусаддаа хэн сайн ярих вэ?, танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн, хөгжөөнт тоглоомуудыг зохион явуулж тэмцээн бүрт 2 хүүхдийг шалгаруулан, нийт 12.800 төгрөг зарцуулсан.

10-р цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн 63 уншигчдад, 3-р цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн 32 уншигч нийт 95 уншигчийг хамруулан, шинээр ирсэн номыг сурталчлах, зургийг үзэж ярилцах, хэн сайн үлгэр ярих вэ?, танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээнийг зохион явуулж 15 уншигчийг шагнаж урамшууллаа. Шагналын санд 12800 төгрөг зарцуулсан.

1.5.10.“Үлгэрийн баатрууд амилсан нь” уралдааныг Боловсрол соёлын газартай хамтран зохион явуулж, баримлын шавраар үлгэрийн баатрууд урласан материалуудыг цэцэрлэгүүдээс авч шалгаруулсан. 20 хүүхэд оролцож, уралдаанд 60.000 төгрөг зарцуулсан.

1.5.11. “Номын баяр” арга хэмжээг 3 дахь удаагаа зохион байгуулж, 350 гаруй багш, номын санчид, сурагчид оролцсон. Энэ үеэр аймгийн зохиолчдын зохиол бүтээлийг олон нийтэд сурталчилах, зохиолчдыг алдаршуулах “Улаан хивсний ёслол”-ын арга хэмжээг зохион байгуулж, 100 номоор үзэсгэлэн гаргасан.

1.5.12. “Надад тохиолдсон хөгтэй явдал- Миний анхны ном” уралдааныг 5-7 дугаар ангийн сурагчдад зохион явуулсан. Уралдаанд 12 сурагч оролцож Тэргүүн байрыг Баян-өйт цогцолбор сургуулийн 5б ангийн сурагч А.Адьяа тэргүүлж өргөжмлөл, дурсгалын зүйлээр шагнууллаа.

1.5.13. “Хүрэн морь” яруу найргийн наадмыг Галуут суманд зохион байгуулж, 150 яруу найрагч оролцсноос “Хүрэн морь”-ны эзнээр Баянбулаг сумын яруу найрагч С.Ганболд шалгарлаа. 42.500 төгрөг зарцуулсан.

1.5.14.“Өсвөрийн яруу найрагч-бид” уралдааныг аймгийн Зохиолчдын холбоотой хамтран өсвөр үеийнхний дунд зохион явуулж, 7 сургуулийн 26 яруу найрагч оролцсон. Шүүгчээр Зохиолчдын холбооны гишүүн н.Зэсэнхүү, н.Ганбаатар нар ажилласан. Ахлах, дунд насны ангилалд 1-3 байр шалгаруулж, өргөмжлөл, медаль, дурсгалын зүйлээр шагнав. Мөн аймгийн залуучуудын холбооноос “Ахлах нас”-ны ангилалд түрүүлсэн яруу найрагчийг “Шилдэг залуу” өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

<u>1.6. “Ном эрдэм” хөтөлбөрийн хүрээнд:</u>

“Ном эрдэм” ТББ-тай хамтран “Ном эрдэм” хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээг 16 дахь жилдээ зохион байгуулж, нээлтийн арга хэмжээнд 350 гаруй хүн оролцсон. Нээлтийн арга хэмжээний үеэр “Ном эрдэм-2015” хөтөлбөрийн удирдамжийг танилцуулан, Баянхонгор аймгийн зохиолнчдын зохиол бүтээлийг сурталчлан, зохиолчдыг алдаршуулах арга хэмжээг зохион байгууллаа.

Тус аяны хүрээнд “Зохиолын шилдэг дүр”-ийн тоглолтыг 4 насны ангиллаар явуулж, сургуулийн өмнөх боловсролын 14 баг, сургуулийн бага, дунд, ахлах насны 13 баг, нийт 270 сурагч оролцож шилдгүүдийг шалгаруулан, 56.370 төгрөг зарцуулсан.

Аймгийн хэмжээнд ЕБС-ийн сурагчдын 2-3-р анги, 4-5-р анги, 6-7-р ангиийн хүүхдүүдийн дунд криллээр хурдан унших, 8-9-р ангийн хүүхдүүдийн дунд монгол бичгээр хурдан унших, 10-12-р ангийн хүүхдүүдийн дунд англи хэлээр хурдан унших олимпиадыг зохион байгуулж, нийт 221 хүүхэд оролцсон байна.

"Шилдэг уншигчийн сүлд модны наадам"-ыг "Ном эрдэм" хөтөлбөрийн хаалттай хамт хийж, 2015 оны шилдэг уншигчдыг шалгаруулсан. "Шилдэг уншигчийн сүлд модны наадам"-ыг "Ном эрдэм" хөтөлбөрийн хаалттай хамт хийж, 2015 оны шилдэг уншигчдыг тэргүүний уншигч Д.Нацагдорж дүр тэмдэгтэн шалгаруулах болзлын дагуу шалгаруулсан.

<u>1.7. Угийн бичгийн ажлын хүрээнд:</u>

Баянхонгор аймгийн хэмжээнд "Ургаа мэдэе, удмаа бататгая" сарын аяны удирдамжийг боловсруулан 2015 оны 11 сарын 10-аас 12 сарын 10-ны хооронд зарлаж, удирдамжийг бүх сумдад тараан, удирдамжийг хэрэгжүүлж ажиллалаа.

"Ургаа мэдэе, удмаа бататгая" сарын аяны хугацаанд Нийтийн номын сан, аймгийн Музейгээс хамтран ажлын төлөвлөгөө гаргаж, нийт 10 ажлыг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Аяны хүрээнд Номундалай, Номгон, Эрдэм, Эрдэнэмандал, Соого Сейкео сургуулийн ахлах ангийн нийт 294 хүүхдэд "Ураг удмаа судлахуй" сургалтыг зохион байгуулж, хүүхдүүдэд угийн бичиг гэж чухам юу болох, угийн бичгээ хэрхэн хөтлөх, угийн бичиг хөтлөхийн ач тусын талаар ойлголтыг өгсөн.

Аймгийн ахмадын холбоо, ахмад багш, геологич, судлаач өндөр настан Г.Цэрэнтэй хамтран Баянхонгор сумын 8 багийн 360 иргэд, аймгийн Цагдаагийн хэлтсийн 55 албан хаагчдад ураг удмаа мэдэх, удамшлаа судлах, угийн бичгээ хэрхэн хөтлөх талаар лекц ярилцлага хийлээ. Энэ үеэр баг тус бүрээс угийн бичгээ хөтөлсөн айл өрхийг шалгаруулан шагнаж урамшууллаа.

2015 онд соёл танин мэдэхүйн ажлыг 28 удаа зохион байгуулж, 5485 хүнийг хамруулан, 1826.170 төгрөг зарцуулжээ. Сургалт семинар нийт 39 удаа явагдаж, 1472 хүнийг хамруулсан байна.

<u>2. МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ</u>: Интернэтээр 395 хүнд үйлчилж, үйлчлүүлэгчдийн бүртгэлийг хөтөлж, номын сангийн цогц программ LiB4U, байгууллагын дотоод сүлжээ, и-оффисс программын хэвийн ажиллагааг хангаж, ажилчдад заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулагдсан соёл олон нийтийн ажлын талаар орон нутгийн телевизээр 10 удаа, Баянхонгор таймс сонинд 2 удаа, байгууллагын Facebook хаягаар тухай бүр тогтмол сурталчлан, электрон каталогт орсон ном, мэдээллийн баазыг архивжуулан CD–нд хуулж хадгаллаа. Орон нутгийн номын санчдад программын талаар утсаар болон биечлэн зөвлөгөө өгч Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст, Хүрээмарал Гурванбулаг, Жаргалант сумын компьютер программд гарсан гэмтлүүдийг засаж, сумдын тайлангийн нэгтгэлийг нөөц бэлтгэн, БСШУЯ-нд явууллаа. Сумдын программд ном оруулалт 97 хувьтай байна.

Байгууллагын принтер, каноны хор цэнэглэж, уншлагын танхимуудын дохиоллын хаалгыг ажиллагаанд оруулан, ном алдагдахаас сэргийлэн, номын үзэсгэлэнгийн хаяг, шилдэг уншигчдийн зураг, соёл олон нийтийн ажлын урилга, өргөмжлөл, дурсамж, талархал, мандат зэрэг хэвлэлийн бүх үйлчилгээг загвар дизайныг тохируулан, түргэн шуурхай хийлээ.

<u>Гарын авлага: </u>Электрон мэдээллийн санг баяжуулахад “Сонгодог шилдэг 500 хөгжмийн аялгуу” 8GSD-г ”DVD” цувралаар бэлтгэн гаргасан. Нэгж танхимуудаас уншигчдад зориулж “Гадаад хэл хялбар сурах аргачлал”, “Англи-Монгол дууны түүвэр”, “Шинэс, заг, сухай, улиас тарьж ургуулах” тухай, “Баянхонгор аймгийн 10 дурсгалт газрууд”, “Номыг бүтээлчээр унших арга”, “Ном уншихын ач холбогдол”, “Үндэсний хувцасны түүх соёл”, “Угийн бичиг хөтлөх” тухай Засгийн газрын тогтоолоор гарын авлагууд, номын санчдад зориулж “Номын сангийн тухай хууль”, “Хүүхдүүдэд зориулж уран сайхан, гоозүйн мэдлэг олгоход баримтлах уран бүтээлийн жагсаалт”, “Хүнтэй харилцах урлаг” санамж ном зүй, “Харилцааны тухай ойлголт” санамж ном зүй зэрэг нийт 13 гарын авлага бэлтгэн гаргаж сурталчлав.

<u>3. УДИРДЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭ:</u>

3.1. Хууль эрх зүйн хүрээнд

МУ-ын Төрөөс баримтлах соёлын бодлого, соёлын тухай хууль, соёлын өвийг хадгалж хамгаалах тухай хууль,Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн хууль,

Номын сангийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлэн, "Архив номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага" MNS ISO 11799:2007, "Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага" MNS 5742:2007 стандартыг ханган ажиллалаа.

3.2. Байгууллагын зорилго зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, зорилго зорилтыг хэрэгжүүлэхэд 2015 оны ажлын төлөвлөгөөг хамт олны саналыг оролцуулан, хамт олны хурлаар батлан, байгууллага болон ажилчдын төлөвлөгөөг сар бүрээр төлөвлөж, тайлан биелэлтийг гарган, тайланг хянан дүгнэж, ажилчидтай хөдөлмөрийн гэрээний сунгалт хийж хэрэгжилтийг хангаж ажиллаа.

Аймгийн Засаг даргын 2012-2016 оны мөрийн хөтөлбөр, аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2015 оны үндсэн чиглэлийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гаргаж ажиллалаа.

Байгууллагын төсөв санхүү, тэтгэмж урамшил болон бусад асуудлаар захиргааны зөвлөлийн хурлыг 3 удаа хуралдаж, шийдвэр гарган ажиллаж байна.

Нийтийн номын санг 2016-2020 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, ажилчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр, ажилтнуубын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинээр боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын тамгын газраас 7 хоног бүр зохион байгуулдаг удирдах ажилтны шуурхайд оролцож, шуурхайн мэдээллийг хамт олонд тухай бүр хүргэн, хамт олны шуурхайг 27 удаа хуралдаж, мэдээлэл солилцсон байна.

Байгууллагын өмнө тулгамдсан асуудал болох барилгын завсар, хана цуурсан, подволоос ус гарсан, агааржуулалтын систем ажиллахгүй байгаа, суулт өгсөн гэх мэт асуудлуудыг шийдвэрлүүлэхээр ИТХ, Мэргэжлийн хяналт, Засаг дарга, Газрын алба, Онцгой байдлын газар болон бусад холбогдох байгууллагуудад хүсэлт гаргаж, албан бичиг хүргэсэн. Бичгийн дагуу Засаг дарга, Мэргэжлийн хяналт, Онцгой, ИТХ-аас хүмүүс ирж нөхцөл байдалтай биечлэн танилцаад явсан ч одоогийн байдлаар ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна.

<u>Ажилчдын нийгмийн баталгааг хангах:</u> Ажилтнууд, ахмадуудын нийгмийн асуудлыг ихээхэн анхаарч өвчин зовлон, баяр баясгаланг хамтдаа хуваалцаж, 2015 онд 11 хүнд 1.070.000 төгрөгийг тэтгэмж урамшуулал олгон, ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, сахарын шинжилгээг үнэ төлбөргүй хийлгэн, захиргаанаас 4Дэхо-д нийт 110.000 төгрөгөөр үзүүлж, ажилчдын эрүүл мэндийн асуудалд анхаарч ажиллалаа.

Номын санч Ц.Сарантуяа нь Соёлын боловсролын сургуулийн “Номын сан судлал-мэдээллийн ажилтан” мэргэжлээр 2 дахь жилдээ онлайнаар суралцаж, сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүллээ.

Сэтгэл ханамжийн судалгаа Уншигч, үйлчлүүлэгчдээс саналын хайрцгаар 8 удаа санал хүсэлт ирж, уншлагын танхимд “Санал хүсэлтийн дэвтэр” нээж нийт 180 уншичдаас сэтгэл ханамжийн болон номын эрэлт хэрэгцээний талаар судалгаа авч нэгтгэхэд номын сангийн номын хүрэлцээ сайн, уран зохиол, утга зохиолын номыг түлхүү уншдаг, үйлчилгээний чанар сайжирсан нь судалгааны үр дүнд харагдаж байна. Үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийг хүлээн авч үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Дотоод хяналт: Дотоод хяналтаар санхүүгийн болон дотоод үйл ажиллагаанд ноцтой зөрчил гараагүй, хэвийн явагдлаа. Дотоод хяналтын ажилтан тайланг улирлаар гаргаж, аймгийн Мэргэжлийн хяналтын газарт хугацаанд нь хүргэдэг.

3.3. Архив, бичиг хэргийн ажил: Даргын 33 тушаал гарч, хамт олны хурал 27 удаа хуралдсан. Ирсэн бичиг 141, явсан бичиг 83. Өргөдөл гомдол 24 ирсэн. Ирсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг бүртгэн, удирдлагад танилцуулан шийдвэрлүүлж, хариуг хугацаанд нь мэдэгдэж ажилладаг. Өргөдөл, гомдлын улирал, жилийн мэдээг Боловсрол соёлын газарт цаг хугацаанд нь хүргэлээ.

Архивын баримт ашиглалтын бүртгэл хөтлөн, баримтуудыг цаг тухайд нь буцаан авч хадгалж байна. Байгууллагын архиваас 23 баримт ашиглагджээ.

Аймгийн Засаг даргын нэрэмжит архив, албан хэрэг хөтлөлтийн үзлэг шалгалтаар аймгийн Архивын тасгийн дарга В.Эрдэнэчимэгээр ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй баг манай байгууллагад ирж, 2013-2014 оны баримт бичгүүдэд хяналт шинжилгээ хийсэн. Энэхүү үзлэгийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлуудын төлөвлөгөө гаргаж биелэлтийг Архивын тасагт хугацаанд нь хүргэлээ. Мөн байгууллагын архивын 2009-2014 оны баримтанд захирлын 2015 оны 21 тоот тушаалаар томилогдсон комисс хяналтын тооллого явуулж, алдаа дутагдлыг дор бүр нь засаж залруулан ажиллаа.

9 сард архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг шалгалт ирж, 2009 оноос хойших баримт бичгүүдэд хяналт шалгалт явуулж, улсын үзлэг шалгалтаар эхний 50 байранд шалгарч сайн үнэлгээтэй дүгнэгдсэн.

2007-2008 оны байнга хадгалах 753 хуудас бүхий 44 баримтыг Төрийн архивт цахим болон цаасан хэлбэрээр шилжүүлээд байна. И-Оффисоор 45 бичиг ирж, бусад байгууллагад олон нийт болон захидлаар 15 бичиг явууллаа.

Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн ажилд хэрэглэгддэг 4 төрлийн дардас, хэвлэмэл хуудсыг зориулалтын дагуу ашиглан, зарцуулсан бүртгэл хөтөлж, үрэгдүүлсэн хэвлэмэл хуудсыг холбогдох хүмүүсээр нь 3 нугалж төлүүлэн шинэ хэвлэмэл хуудас захиалан авч байна.

3.4. Төсөв санхүүгийн талаар.

2015 онд 121.000.000 төгрөгийн төсөвтэйгээр үйл ажиллагаа явуулж ирлээ. Төсвийг жил, сарын төсвийн хуваарийн дагуу үр ашигтай зарцуулж, шилэн дансанд мэдээллийг цаг тухайд нь байршуулдаг. Төсвийн мэдээллийн самбараар сар бүрийн мэдээллийг сурталчилж, хамт олны шуурхай дээр сар бүр мэдээлэл хийж хэвшсэн. Мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн шалгалт, Аудитын шалгалтаар тогтмол зөрчилгүй дүгнэлтийг авдаг.

Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр хуулийн дагуу тогтмол хийж хэвшсэн. Тооллогоор дутагдсан, эвдэрсэн гэмтсэн зүйлийг илрүүлэн, буруутай этгээдээр төлүүлэх, эд хөрөнгийн ашиглалтг сайжруулах тал дээр байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл тусгай журамтайгаар хяналт тавьж ажилладаг.

3.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар.

4, 10 сард Хөдөлмөрийн хэлтсээс “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” тухай хуулийн зарим заалт шинэчлэгдсэнтэй холбоотойгоор зохион байгуулсан ХАБЭА-н сургалтуудад тухай бүр оролцож, ХАБЭА-н төлөвлөгөө, тайлан гаргаж тус хэлтэст хүргэлээ.

4. НОМЫН САНГИЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ, БАЙГУУЛЛАГЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ҮЙЛЧИЛГЭЭ

4.1. Цэвэрлэгээ үйлчилгээ

Байгууллагын өрөө танхимуудыг өдөр бүр цэвэрлэж, цэвэрлэгээний материал бусад хэрэглэгдэхүүнүүдийг үр ашигтай, гамтай зарцуулан, нэгж тасгуудад их цэвэрлэгээг хийн, коридор, ариун цэврийн өрөөнүүдийг тогтмол цэвэрлэн ажиллаж байна. Байгууллагын цэцгүүдийг тогтмол усалж, арчилж тордон, шинээр 3 ширхэг цэцэг үрслүүлэн, байгууллагын ажилтнууд, үйлчлүүлэгчдийн ая тухтай орчинг бүрдүүлэн ажиллалаа.

4.2. Харуул хамгаалалтын ажил.

Харуул хамгаалалтын хуулийг хэрэгжүүлэн, хариуцсан өдрүүдэд ээлжинд гарч, 3 байгууллагын ажилтнуудын цагийн бүртгэлийг үнэн зөв бүртгэн, рабортын дэвтрийг тогтмол хөтлөн ажиллалаа. Өмнөх ээлжнээс бүртгэлийн дагуу эд хөрөнгүүдийг нэгбүрчлэн тоолж хүлээн авч, хүлээлгэн өгч, өрөө танхимуудын лац

ломбо, байгууллагын гадна орчныг шалган авч, хүлээлгэн өгч хариуцлагатай ажиллалаа. Зуны улиралд гадаах зүлэг мод, цэцгийн мандлыг услан, гадна орчныг ээлж бүр дээрээ цэвэрлэн, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллалаа.

4.3. Жолоочийн ажил: Цэргийн анги, 11 дүгээр цэцэрлэг, Дуурсахын хөндийд наадамчдад, нүүдлийн номын сангаар явж үйлчилсэн.

Мөн хот, хөдөө орон нутагт Баянлиг сумын Бичигт хад, цагаан агуйд МҮОНТ-ийн бичлэгээр, 2 сард нутгийн зөвлөлийн золголтоор аймгийн Засаг даргын ахалсан багтай Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Хөтөл, БОАЖГазрын ажлаар Өлзийт, Жинст, Богд, Баянлиг, Баянговь сумдад, Бууцагаан суманд соёлын ажилтны өдөрлөгт оролцох, Галуут суманд Боловсролын ажилтны бүсийн сургалтанд багш нарыг тээвэрлэх, Баян-Овоо суманд нягтлангийн ажлаар, Тэмүжин театрын ажлаар Шаргалжуут гэх мэт орон нутагт машины бүрэн бүтэн аюулгүй байдлыг хариуцан явж ажилласан. Аймгийн төвд "Түйн голын жавар-2015" мөсний баярын арга хэмжээ, хүүхдийн баяраар талбай дээр үзэсгэлэн гаргах, хүүхдийн уншлагын танхимаас зохион байгуулсан "Зугаатай уншлага" Түйн гол дээрх арга хэмжээнд хүүхдүүд зөөж үйлчлэх, Өлзийтийн Нарийн голд хамт олноор амрах зэрэгт машины аюулгүй, бүрэн бүтэн байдлыг хангаж ажилласан.

4.4. Няравын ажил: Бараа материалын анхан шатны бүртгэлүүдийг цаг тухайд нь хөтөлж, ОУННБ-н стандартын дагуу няравын тайланг гаргаж нягтлан бодогчтой тооцоо нийлж ажиллаа.

Төрийн сангаас зохион байгуулсан няравын бүртгэл хөтлөлтийн сургалтанд оролцсон. Ажилчдын өмч эзэмшигчийн гэрээ, эд аж ахуйн картыг хүн тус бүрээр шинэчлэн, эд хөрөнгөнд хяналт тавьж, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл хагас, бүтэн жилээр,

1. Тавилга эд хогшил: 339 ширхэг, 58.596.977 төгрөгийн үндсэн хөрөнгө
2. Аж ахуй: 502 ширхэг, 7.265.410 төгрөг,
3. Бичиг хэрэг: 10ширхэг, 428.620 төгрөг,
4. Пургон автомашин: 21.400.000.00 төгрөг,
5. Барилга: Номын сангийн барилга, 1 тэрбум 98 сая 200 мянган төгрөг
6. Бусад тоног төхөөрөмж 19 нэр төрлийн 23.876.500 төгрөг үнэтэй хөрөнгө, санхүүгийн цогц программын шинэчлэлт 4.835.200₮, Ч.Лхамсүрэнгийн гантиг чулуун хөшөө 6.500000₮, 3 төрлийн төмөр хашаа, сүүдрэвч 8.270000₮ эд хөрөнгийн тооллогыг явууллаа.

Цэвэрлэгээ үйлчилгээний материал, бичиг хэргийн хангалтанд 817900₮, техник, тоног төхөөрөмж засвар сэлбэгт 530300₮, ном хэвлэл худалдан авах 2.052000₮, урсгал засварт 1.674000₮ зарцуулагдсан.

5 .БҮТЭЭЛЧ АЖИЛ

фондонд байгаа электрон мэдээллүүдийг интернэтийн танхим, хүүхдийн уншлагын танхимд байрлуулж, электрон мэдээллийн дансанд бүртгэх, лавлагааны тасгаас фондонд шилжүүлсэн 245 номыг электрон каталогт фондын ном болгон оруулж бар код формулярыг шинээр хэвлэн номонд нааж тавиурт байрлуулж, 18 номыг лавлагааны тасагт буцааж өгөв. Ажилчдын эд аж ахуйн картыг шинээр хийж, эд хөрөнгөө ариг гамтай ашиглаж байгаа ажилтныг урамшуулах, “Сэтгэхүй хөгжүүлэх тоглоомын булан”-гийн хаяг, “Баянхонгор аймгийн 10 дурсгалт газрууд” гарын авлага хийх зэрэг бүтээлч ажлуудыг хийлээ.

6.ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС БУСАД АЖИЛ

1.“Түйн голын жавар-2015” мөсний баярын арга хэмжээ, нээлт, 7 төрлийн тэмцээн уралдаанд хамт олноороо амжилттай сайн оролцсон.

2.БСШУ-ны сайд Р.Гантөмөр Баянхонгор аймагт айлчилж, боловсрол, соёлын байгууллагуудын ажил байдалтай танилцахад, үйл ажиллагаагаа танилцуулсан.

3. Онцгой байдлын хэлтсээс соёл урлагийн байгууллагуудад гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд аймгийн Онцгой байдлын хэлтсээс Номын сан, Тэмүжин театр, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн хамт олонд "Галын аюулгүй байдал" сэдвээр сургалт, үзүүлэх сургалтанд хамт олноороо хамрагдсан.



4. Гадна орчноо тохижуулахад анхаарч мод тарих өдрөөр 10 модны нүх ухаж мод суулгах, гадна талбайд зүлэгний үр тарих, услах, ногоон байгууламжийн ажлуудыг хийж тохижуулсан.

5. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан "Үл мэдэх" хотхон өртөөг аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, МСҮТ, Жи мобайл

компанитай хамтран Баганат талбайд зохион байгууллаа. Оньсого таалцах, ертөнцийн гурвыг хэн сайн мэдэх вэ?, танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн, шинэ номын үзэсгэлэн, “Хүүхэд бүр гэр бүлдээ аз жаргалтай” гар зургийн уралдаан зохион явуулсан. Уралдаанд нийт 150 гаруй хүүхэд оролцож уралдлаа.

6. Монголын Залуучуудын холбооноос зохион байгуулсан “Шинэ зууны илгээлтийн эзэд” аяны хүрээнд мэдээллийн ажилтан М.Дондовжамц Баацагаан сумын малчин Батсүхийнд 7 хоног томилогдон ажилласан.

7. “Аймгаараа бүжиглэе” аяны хүрээнд ажилчид танхимаар бүжиг заалган суралцаж, талбайн арга хэмжээнд хамт олноороо оролцсон.

8. Аймаг байгуулагдсаны 74 жилийн ойн баяр наадмаар хамт олноороо бэлтгэл ажлуудад оролцож, Дуурсахын хөндийд "Соёл, урлагийн хотхон”-ны үйл ажиллагааг БСГ, Музейтэй хамтран зохион явуулж, шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн, номын худалдаа, азын сугалаа, асуулт хариултын тэмцээнийг зохион явуулж, наадмын бэлтгэл ажил, үзэгчдийн тав тухтай орчинг хангахад сандлыг хариуцан ажилласан.

9.Соёлын ажилтны өдөрлөг Бууцагаан суманд зохион байгуулагдаж, соёлын байгууллагууд, хамт олноороо тэмцээн уралдаан, баярын хурал, бусад арга хэмжээнүүдэд оролцлоо. Энэ үеэр тус сумын ард иргэдэд 50 номоор үзэсгэлэн гаргаж, сумын номын санд арга зүйн зөвлөгөө өглөө.

10. Нийтийн номын сангаас аймгийн Ахмадын холбоо, Нийгмийн халамжийн хэлтэс, Зохиолчдын холбоотой хамтран “Ахмадын баяр”-т зориулсан шинэ номын үзэсгэлэн, АХА тэмцээнийг Ахмадын ордонд зохион явууллаа. Уг арга хэмжээнд Соого сейко сургуулийн “Хишигтэн” хамтлаг ая дуугаа өргөж, 8 багийн залуучууд, ахмадууд нийт 360 гаруй ахмад, залуу үеийн төлөөлөл оролцож, үйл ажиллагааг “ТҮ-10” телевизээр сурталчилсан. Аха тэмцээнд тэргүүн байрыг Д.Дашдамба, 2-р байрт Г.Тогооч, 3-р байрт Өнөржаргал нар эзэлж талархал, дурсгалын зүйлээр шагнууллаа.

11. “I love Mongolia ТҮНШЛЭЛ-2015” төслийн баг, 7 телевизийн сурвалжлагч манай аймагт ирж байгууллагуудын үйл ажиллагаатай танилцсан. Энэ ажлын хүрээнд байгууллагын үйл ажиллагааг сурталчилж, бүх нийтийн “Нарын алхалт” арга хэмжээнд оролцож Оготонотой булаг руу алхаж, гимнастик хийв.

12. Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилтанд бүх байгууллагын дарга нар, мэргэжлийн анги албадууд оролцлоо. Аймгийн ард иргэдийг Оготнотой булагт нүүлгэн шилжүүлэх ажилд хамт олноороо оролцов. Байгууллагын захирал Баян-Овоо сумыг нүүлгэн шилжүүлэх, аранзанд байх хэрэгслийг шалгуулах, хээрийн эмнэлэг, хээрийн мал эмнэлэг, гоц халдварын ажил байдалтай танилцах, удирдах ажилтны тэвчээрийг шалгасан уралдаанд оролцох зэрэг өндөржүүлсэн байдлын бүх арга хэмжээнүүдэд оролцсон.

Дүгнэлт: 2015 онд нийт 123 ажил төлөвлөснөөс 1 ажил биелэгдээгүй, 1 ажил хагас биелэгдсэн, 121 ажил бүрэн биелэгдсэн байна. Төлөвлөгөөний биелэлтийн хувь 98.7 %-тай биелсэн байна.

Ахиц дэвшил: Шинээр зохион байгуулсан “Хурдан уншлагын олимпиад”, “Зуны зугаатай уншлага” арга хэмжээнүүд сайхан зохион байгуулагдсан. Архив, албан хэрэг хөтлөлтийн ажил сайжирсан.

Анхаарч ажиллах:

1. Аймгийн төвийн хэмжээнд угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлэх тал дээр анхаарч ажиллах

2. Хувийн номын сантай хүмүүсийн нарийн судалгааг гаргаж, айл өрхийн тоог нэмэгдүүлэх

3. 2015 онд шинээр баталсан сургалтын хөтөлбөр, ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, номын санг хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр зэргийг хэрэгжүүлж ажиллах

4. Соёл танин мэдэхүйн шинэлэг ажлуудыг зохион байгуулж, чанарыг сайжруулах, хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэх

5. Нүүдлийн номын сангийн үйлчилгээг сайжруулах

БУЛГАН АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Манай байгууллага нь “Монгол улсын ерөнхийлөгчийн зарлиг”, “Номын баяр тэмдэглэх” тухай, Аймгийн засаг даргын 2012-2016 оны “Шинэ Булган хөтөлбөр”, “БСШУЯ-ны сайдын 51 тоот тушаал, “Ном” хөтөлбөр, “Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Оны эхнээс ажилчдтай үр дүнгийн гэрээ байгуулан, ажлын байрны тодорхойлолт, 2015 оны ажлын төлөвлөгөө, Соёл олон түмний ажлын календарчилсан төлөвлөгөө боловсруулан байгууллагын “Ил тод байдал”-ыг хангах, “Дотоод хяналт шалгалтын ажлыг сайжруулах” тал дээр анхааран ажиллалаа.

Орон нутаг сумдын номын санчдын сургалт семинарыг Орхон аймагт Монголын номын санчдын консерциумтай хамтран зохион байгууллаа. Үүнд: Увс, Орхон аймгийн номын санчид оролцсон.

Номын сангийн ном зүйн бичилтийг стандартын дагуу шинэчлэх ажлыг 2015 оны 6 сараас эхлэн хийж 2015 оны 12 сарын 31-ний байдлаар 12000 гаруй номыг шинэчлэн хийгээд байна. Байгууллагын мэдээллийн цагийн график гарган 7 хоногийн 2 дахь өдөр бүр цаг үе, хууль эрх зүй, бусад мэдээллийг хийж байна. БСГ-тай хамтран соёлын байгууллагуудын үйл ажиллагааг орон нутагт сурталчилах, номын үзэсгэлэн, явуулын номын сан ажиллуулах, шинэ номын худалдаа, иргэдийн дунд уралдаан тэмцээн зохион байгуулах, номын санчдад арга зүйн зөвлөмж өгөх зэрэг ажлуудыг Сайхан, Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг сумдад зохион байгуулаад байна. Булган сумын багуудад зуны “Нүүдлийн номын сан” ажиллуулж, уншигч хүүхдүүдэд номоор үйлчиллээ. Таны ном ТББ-тай хамтран “Номтой нөхөрлөгч Булганчууд” номын үзэсгэлэн, худалдаа өдөрлөг, “Хүлээж суухаар хүрч үйлчлэе” уриан дор Чин Ван Ханддоржийн талбайд “Номын өдөрлөг”-ийн арга хэмжээнүүдийг зохион явууллаа.

Булган сумын 262 иргэнээс номын сангийн үйлчилгээний чанар, хүртээмжийн тухай судалгаа авч дүгнэлт хийсэн. Уншлагын заал танхимууд нэрэмжит соёл олон нийтийн ажлууд шинээр санаачлан уншигчдын дунд зохион байгуулсан. Мөн байгууллагынхаа уншигчдад үйлчлэх таатай орчинг бүрдүүлэн заал танхимаа будах, хулдааслах, гадна талаа шохойдох, дээвэр, цонхоо будах, тохижуулах ажлыг хийлээ.

УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ:

2015 онд: Уншигч 3597, ирэгсэд 19741, ном олголт 31883 үүнээс тогтмол хэвлэл 5610 байна. Цаасан ном 25149, цахим ном 1124, уншлагын танхимаар 26822, гэрээр 3961, зөөврөөр 1100 ном олгосон.

Уншлага үйлчилгээ графикаар:









Ном олголт графикаар:







ФОНД БАЯЖИЛТ БА НОМТОЙ АЖИЛЛАХ, НОМЫН ТЕХНИК АЖИЛЛАГАА, НОМЗҮЙ

2015 онд нийт 272 нэр төрлийн, 534 ширхэг, 4,721,700 төгрөгний номоор фонд баяжилт хийлээ. Үүнд: худалдаагаар 175 нэр төрлийн 355 ширхэг, 3,186,200 төгрөгний, БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 38 нэр төрлийн, 72 ширхэг, 893,000 төгрөгний, бэлэг хандиваар 59 нэр төрлийн, 107 ширхэг 642,500 төгрөгний ном байна. Дээрх номнуудыг дансанд авч анхан шатны техник ажиллагааг хийж, электрон каталогт оруулж заал танхимуудад хувиарлан өгсөн.

Дээрх бүх номны хавтасны зургийг скайнердэж зарим ном сонингийн зургийг нэтээс татаж каталогт оруулсан.

Электрон каталогт номтой ажилласан тухай графикт тайланг програмаас татаж дор оруулаа.













Фонд баяжилт хийгдсэн бүх шинэ номын мэдээг хавтасны зураг, номын товч агуулга бусад мэдээллүүдийг багтаасан хэлбэрээр word, excel дээр 2 янзаар бэлтгэж цахимаар болон цаасаар заал танхим, уншигчдад хүргэсэн.

Орон нутгийн номзүйн бүртгэл гаргах ажлыг эхлүүлж, судалгаа хийж, баримт материал цуглуулж байгаа.

1-10 хүртэлх номын нэг бүрчилсэн бүртгэлийг дугаарлан ном бичихэд бэлэн болгосон.

2015 оны 6 сарын 17-ны өдрөөс үндсэн фондын номнуудад номзүйн бичилт шинэчлэх ажлыг эхэлсэн.

2015 оны 12 сарын 31-ны байдлаар 11907 номын бичилтийг шинэчлэн, дахин дансалж, баркодыг хэвлэн нааж тавиурт байрлуулсан. Дээрх номнуудыг хийж байх хугацаандаа илүү цагаар шахуу ажилласаны үр дүнд дээр тооны номыг оруулсан.

Шинэчилсэн бичилтийн үр дүн:

1.Номзүйн бичилтийн стандарт

2.Шинжлэх ухаанаар өөр өөр ангилагдсан ижил ном ангилал нь нэг дор болно

3.Зохиогчийн тэмдэгт нь нэг дор болно

4.Заал бүрээр орсон ном нэг дор болно

5.Ижил ном өөр үнэтэй байсан нь засагдсан

6.Бар кодыг дор нь нааж харагдах үзэмж дээрдсэн

7.Давхардсан баркод засагдсан

8.Хаяг ялгагч сайжирсан

9.Түлхүүр үгнүүд нэмэгдсэн

Дутагдалтай тал:

1.Хугацаа их ордог

2.Цаас, скоч гэх зэрэг бичгийн хэрэгсэл их орох

Шинэ ном худалдан авах 2 удаа, сумдад ном хувиарлах 3 удаа

Татгалзалд 6 ном бүртгэгдсэн. Өмнөх онд электрон каталогт оруулж амжаагүй байсан ном, сонинг каталогт оруулсан.

ТЭРГҮҮНИЙ УНШИГЧИД

2015 оны Тэргүүний уншигч Д. Нацагдорж тэмдэгтэн
Булган сумаас 6, сумдаас 8. Нийт 14 сурагч тус тэмдгийн эзэн болсон.

Булган суманд:
“Аймгийн тэргүүний хүүхдүүд”-ийн чуулган Өлзийжаргал
“Бид Монголын ирээдүй” уран илтгэлийн тэмцээнээс
ЭӨЦС-ийн 12 В ангийн сурагч Г. Уранбилэг
“Бид өв соёлоо тээгч түгээг” бичиг соёлын өдрөөр
1-р 12 жилийн 5 В ангийн сурагч Амгаланбаатар
1-р 12 жилийн 5 В ангийн сурагч Отгонбилэг
“Номтой нөхөрлөх өдөр” номын баяраас
ЭӨЦС-ийн 5 А ангийн сурагч О. Баярхүү
1-р 12 жилийн 12 Г ангийн сурагч Б. Янжиндулам
Сумдад:
Баяннуур: 4 ангийн сурагч М. Тодбаяр
Сэлэнгэ: 12 А ангийн сурагч Г. Энхрагчаа
12 А ангийн сурагч О. Сэлэнгэма
Хангал: 9 А ангийн сурагч Хулан
9 А ангийн сурагч Түвшинтөгс
Хишиг-Өндөр: 5 Б ангийн сурагч О. Энхжин
Хутаг-Өндөр: 6 В ангийн сурагч Ц. Эрхэмбилэг
5 А ангийн сурагч Л. Номин-Эрдэнэ

НҮҮДЭЛ ЗӨӨВРИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

- Үндсэн фонднoос явуулсан нүүдэл, зөөврийн номын үйлчилгээгээр уншигч 600, ирэгсэд 978, ном олголт 1100
- Сургуулийн өмнөх насныханд “Явуулын номын сан”-аар 1, 2, 6, 3, 4, 7-р цэцэрлэгүүд дээр жилийн турш хувиар гарган ажилласан. Нийт ирэгсэд 3387, уншигч 826, ном олголт 3800

Булган хотод:

- 2 сарын 5-нд Эрдмийн Өргөө цогцолбор сургуулийн багш, ажилчид, сурагчдад "Явуулын номын сан"-аар үйлчилж 65 номоор үзэсгэлэн гаргаж, дунд болон ахлах ангийн сурагчдын дунд АХА тэмцээн, ахлах ангийн сурагчдын дунд Монгол ардын аман зохиол тэмцээн зохион явууллаа. Ирэгсэд 45

- 5 сарын 29-нд Хөдөө аж ахуйн газарт 2 удаа 75 шинэ номоор үзэсгэлэн гаргаж явуулын номын сангаар 9 хүнд карт нээж 20 ном гэрээр олголоо. Ирэгсэд 25

- 10 сарын 23-нд ALL mart худалдааны төв дээр 40 шинэ номоор үзэсгэлэн гаргаж 4 хүнд карт нээж, 5 ном олгов. Ирэгсэд 38

- УЦУОШГ-т 150 номоор үзэсгэлэн гаргаж, 10 уншигчид карт нээж 91 ном гэрээр олгов. Ирэгсэд 30

- Оны эхнээс Гангат багт 5 удаа 83 ном гэрээр олгов. Ирэгсэд 36

- 10 сарын 22-нд ЭМГ-ийн хамт олонд 1 удаа 45 номоор үзэсгэлэн гаргасан. Ирэгсэд 30, ном олголт 22

- Зуны явуулын номын сангийн үйлчилгээг 2, 3, 6-р багийн иргэдэд хүргэсэн. Ирэгсэд 45, ном олголт 92

- Аймгийн "Хүүхдийн эрхийн өдөр" 75 номоор үзэсгэлэн гаргаж, 300 гаруй ирэгсдэд үйлчилсэн.

- Аймгийн "Нээлттэй хаалганы өдөр" 200 номоор үзэсгэлэн гаргаж, 4 хүнд карт нээж 10 ном гэрээр олгосон. 150 гаруй ирэгсдэд үйлчилсэн.

- "Номтой нөхөрлөх өдөр" номын баяр" 1000 номоор үзэсгэлэн гаргаж, 1000 гаруй ирэгсдэд үйлчилсэн.

- Салбар номын сан, хүүхдийн уншлагын танхим, нийтийн уншлагын танхим нь тэмдэглэлт өдрүүдээр тус бүр нийт 15 удаа, 344 номоор үзэсгэлэн гаргасан.

Сумдад: Доорх 5 сум тус бүрт Явуулын Шинэ номын худалдаагаар үйлчилсэн. Ирэгсэд-158, Уншигч-45, Ном олголт 66

- Сэлэнгэ суманд 110 номоор үзэсгэлэн гаргаж, иргэдэд “Явуулын номын сан”-аар үйлчиллээ.

- Сайхан суманд 150 шинэ номоор үзэсгэлэн гаргаж Явуулын номын сангаар 145 гаруй иргэд, сурагчдад үйлчиллээ. Мөн АХА тэмцээн явуулав.

- Хутаг-Өндөр суманд 150 шинэ номоор үзэсгэлэн гаргаж Явуулын номын сангаар 196 гаруй иргэд, сурагчдад үйлчиллээ. Мөн АХА тэмцээн явуулав.

- Тэшиг суманд 150 шинэ номоор үзэсгэлэн гаргаж 80 гаруй ирэгсдэд “Явуулын номын сан”-аар үйлчиллээ. Мөн АХА тэмцээн явууллаа.

- Баян-Агт суманд 150 шинэ номоор үзэсгэлэн гаргаж Явуулын номын сангаар 140 гаруй иргэд, сурагчдад үйлчиллээ. Мөн АХА тэмцээн явуулав.

НОМЫН МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГАА:

Номын үзэсгэлэнг нийт 61 удаа, 2535 номоор үзэсгэлэн гаргаж үйлчилсэн. Хуулийн булангийн мэдээлэл, гарын авлагыг тогтмол шинэчилж үзэсгэлэн гаргасан ба номын сангийн facebook хуудсанд зохион явуулсан СОНА болон үйл ажиллагааны мэдээллийг тухай бүрт нь нийтэлж мэдээлж байсан. Монцамэд 8 удаа мэдээлэл өгч цахим сайтад нийтлүүлсэн.

НОМЫН САНГИЙН АВТОМАТЖУУЛАЛТ ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

Тус үйлчилгээг 256 гаруй ирэгсдэд, 1033 номоор үйлчилсэн.

- “Интернет танхим”-аар 56 ирэгсдэд: Хэвлэл канон 800 төгрөг, интернет 22520 төгрөг, хугацаа хэтрэлт 9900 төгрөгний үйлчилгээ үзүүлсэн.
- “Нийтийн уншлагын танхим”-аар цахим ном унших үйлчилгээг 100 орчим ирэгсдэд 530 номоор үйлчилсэн.

- “Хүүхдийн уншлагын танхим”-аар цахим ном унших үйлчилгээг 20 орчим иргэсдэд 48 номоор үйлчилсэн.
- “Салбар номын сан”-аар цахим ном унших үйлчилгээг 80 гаруй уншигчдад 495 номоор үйлчилсэн.

2015 ОНД ХАМГИЙН ИХ УНШИГДСАН НОМ

Нийтийн Уншлагын Танхим

- Дэлхийн улс орнууд
- Соёмбо шинжлэх ухааны нэвтэрхий толь 8 цуврал
- Дэлхийн хүүхдийн шилдэг 108 боть цуврал
- Ухаан далай номоос эхтэй 12 цуврал
- ЭЕШ-нд бэлтгэгчдэд зориулсан гарын авлагууд

Хүүхдийн уншлагын танхим

- Динза цуврал
- Ногун цуврал
- Дисней лейнд цуврал
- Монгол ардын шилдэг үлгэрүүд
- Монгол ардын аман зохиол

Салбар номын сан

- Л. Сарантуяа Тавилан 1,2-р боть
- Амаргийн уруул
- Амаргийн дон
- Сайн хаан Бат
- Сорхугтани хатан
- Ану хатан
- Монголын шилдэг үлгэрүүд
- Барби ба баяр хөөр
- Дисней лейндийн цувралууд
- Динза комик цуврал
- Чингис хаан комик цуврал
- Хүүхдийн шилдэг Эрдэнэсийн сан цуврал

Гэрээр ном олгох танхим

- Л. Сарантуяа Тавилан 1,2

- Л. Сарантуяа Газрын нулимс
- Б. Сарантуяа Сайн хаан Бат
- Б. Сарантуяа Сорхугтани

Үндсэн фонд:

- Л. Сарантуяа Тавилан 1,2
- Л. Сарантуяа Газрын нулимс
- Б. Сарантуяа Сайн хаан Бат

ЛАВЛАГАА НОМЗҮЙН АЖИЛ

Уншлага үйлчилгээний 6 танхимын нийт Татгалзалд 66 ном, Ном захиалгад 945, Лавлагаа ном зүйг 466 хүнд

Д/д	Лавлагаа бүртгэлийн дэвтрүүд	Нийтийн уншлагын танхим	Хүүхдийн уншлагын танхим	Гэрээр ном олгох танхим	Салбар номын сан	Үндсэн фонд	Номзүйчийн лавлагаа
1	Номын татгалзлын дэвтэр хөтлөл	26 ном	2 ном	10 ном	19 ном	9 ном	
2	Ном захиалгын дэвтэр хөтлөлт	105 ном	5 ном	675 ном	160 ном	675 ном	
3	Лавлагаа номзүйн дэвтэр хөтлөлт	251 хүнд	25 хүнд	53 хүнд	15 хүнд	17 хүнд	105

ТАТГАЛЗАЛД БҮРТГЭГДСЭН НОМ

Доорх номнууд 1 хувь фондонд байдаг ч гэрээр гарсан эсвэл фондонд огт байдаггүй номнууд болно.

Нийтийн уншлагын танхим

- Эрт эдүгээг иш үзүүлсэн бошгууд
- Монгол хүний нэрийн дэлгэрэнгүй толь
- Б. Сарантуяа Сорхугтани

- Аким Тэнгэрийн нохой
- Достоевский Гэм зэм
- Ц. Оюунгэрэл Ногоон нүдэн лам
- Л. Өлзийтөгс Үзэхийн хязгаар
- Булган аймгийн бага нэвтэрхий толь
- Ч. Наранцэцэг Өөр
- Зусланд болсон хачирхалтай явдал
- Д. Гармаа Анхны хайр
- Буриад ардын дууны ном
- Монгол ардын аман зохиол
- Үүлэн бор Орос ардын үлгэр
- Дональд Грамп Өөдөө тэмүүл
- ЭЕШ-ийн бүх хичээлийн тестийн эмхтгэлүүд 2006-2015 оны
- Газарзүй, Физик, Уран зохиол, Хими, Биологи, Түүхийн 6-12-р ангийн сурах бичгүүд
- Төгөлдөр хуурын сурах бичиг
- Даралтат хөгжмийн сурах
- Морин хуурын сурах
- Норвегийн ой
- 1084 -3-р боть
- Зөгийн үүр бусниулсан бүсгүй
- Харри Поттер цуврал
- Шинжлэх ухааны товчилсон цуврал
- Хүүхдийн Эрдэнэсийн сан цувралын байхгүй байгаа цувралууд

Салбар номын сан

- Харри Поттер

Хүүхдийн уншлагын танхим

- ЕБС-ийн 1-5-р ангийн сурах бичгүүд
- Майдар комиксийн 4, 5-р цуврал

Гэрээр ном олгох танхим

- Банзрагч Зам роман
- Танихгүй цэцгийн үр
- Г. Баяр Азиз
- Солонгос хэлний өөрөө сурах бичиг
- Орос хэлний өөрөө сурах бичиг
- В. Волкер Баавгай

- Хөх тариан талбай
- Төвд банхар
- Нагаанбуу Алтайн тэнгэр
- Ганц худгийн хүүхэн

Үндсэн фонд

- Малын тэжээл бэлтгэх арга
- Сэтгэл зүйн үндэс
- Үзэсгэлэнт Анжелика 3
- Булган хангайн бага нэвтэрхий толь
- Заавал сурч эзэмших зарим аргууд
- Эр бор харцага роман
- Санхүү
- Үнэний хорвоо
- Ногоон нүдэн лам

2015 ОНЫ ПРОГРАММД АЖИЛЛАСАН МЭДЭЭ

Monbiblio программд фонд дахь бүх номоо 100% оруулсан сум Хялганат, Хангал, хамгийн цөөн оруулсан нь 2,9% Сэлэнгэ сум байна.

№	**Сумдын нэрс**	**Суудлын тоо**	**Номын фондын тоо**	**Оруулсан ном**	**Хувь**
1	Баян-Агт	12	8921	3820	42
2	Баяннуур	20	3456	200	5.7
3	Бугат	20	4374	428	9.70%
4	Бүрэгхангай	20	12465	3100	24.8
5	Гурванбулаг	16	5200	510	9.8
6	Дашинчилэн	12	5635	1400	24.8
7	Могод	20	8708	3800	48
8	Рашаант	32	4800	1200	25
9	Сайхан	10	12000	5302	49.9
10	Сэлэнгэ	20	7800	230	2.9
11	Орхон	24	9500	4100	50
12	Тэшиг	12	1370	590	43

13	Хангал	27	3829	3829	100
14	Хишиг-Өндөр	16	9950	1299	13
15	Хутаг-Өндөр	20	2100	392	18.6
16	Хялганат	10	1194	1194	100

НОМЫН ФОНДЫН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ, НОМ СЭЛБЭН ЗАСАЛТ

Үндсэн фондны 11856 номыг программд шинэчлэн бүртгэж, баркод хаяг ялгагчийг нэг бүрчлэн нааснаас 856 орчим гэмтсэн номыг сэлбэн заслаа. Мөн Нийтийн уншлагын танхимаас “Ном эмчлэх 30 хоног”-ийн аянг ЕБС-ийн бага дунд ангийн сурагчдын дунд зарлаж 41 номыг сэлбэн зассан. Хүүхдийн уншлагын танхим тус аяны хүрээнд 8 номыг сэлбэн заслаа. Гэрээр ном олгох, Салбар номын сан элэгдэлд орж хөнгөн гэмтсэн номнуудыг гарын доорх материал ашиглан 20 орчим номыг сэлбэн зассан. Үйчилгээний танхимууд ойрын фонд дахь гэмтсэн номыг сэлбэн засхаас гадна фондын хадгалалт хамгаалалтад анхаарч эмх цэгцтэй байдлыг хангаж ажилладаг.

СУРГАЛТ МЭДЭЭЛЭЛ, МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙ

Орхон аймагт 2015 оны 05 сарын 11-12-ны өдрүүдэд номын санчдын сургалтанд оролцлоо. Энхүү сургалтанд Орхон, Увс, Булган аймгийн төвийн болон сумын 53 номын санч хамрагдсан. Манай аймгаас Баян-Агт, Сайхан, Хутаг-Өндөр, Могод, Дашинчилэн, Рашаант, Хишиг-Өндөр, Орхон, Бугат, Сэлэнгэ, Хангал, Хялганат, Тэшиг сумын номын санчид, АТНС-гийн бүх номын санчид оролцлоо. Сургалтаар номын сан ТББ-уудын хамтын ажиллагаа, сумын номын санд ашиглаж байгаа ‘’Monbiblio’’ програм, номын сангийн лавлагаа мэдээллийн ажлын талаар сургалт

хийлээ. Сургалтыг Монголын Номын Сангуудын дарга Т.Хайдав, УБХТНС-ийн номзүйч В.Түвшинтогтох нар хийлээ. Сургалтын үеэр Орхон аймгийн номын сангуудтай танилцан туршлага солилцох, номын санчид ажил мэргэжлээ сурталчилах, номын санчдын дунд гар бөмбөгийн нөхөрсөг тэмцээн явагдаж Орхон аймгийн номын санчид 1-р байр, Булган аймгийн номын санчид 2-р байр эзэлсэн. Сумдын номын санчдад өгсөн арга зүйн лавлагааны дэвтэр тусгайлан хөтөлж 81 лавлагаа мэдээлэл бүртгэгдсэн байна. Номын санчдад хэрэгтэй мэдээ мэдээлэл, . “Би хөгжих ёстой бас хөгжихийг хүсч байна”, “Ном унших 10 зөвлөмж”, “Номын санчийн 10 С”, “Номын санчдын албан хэрэгцээнд зориулсан зөвлөмж”, “Монгол ардын тоглоом наадгай” гарын авлагуудыг флашаар, мэйлээр, цаасаар хүргэсэн. Орон нутгийн номын санчдад сургалт мэдээллийг 2 удаа зохион явуулсан. Сайхан, Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг сумдын номын сангуудаар очиж ажилтай нь танилцан номын сангийн бүртгэл хөтлөлтүүд, програм, номын фондын хадгалалт хамгаалалт бусад ажилд нь заавар зөвөлгөө өгсөн.

Мөн Ахлах номын санч, номзүйч Т. Мөнгөнтуяа “Улс төр менежментийн академи”-д “Соёлын удирдлага”-аар 3 сарын сургалтанд суралцсан. Номын санч Г. Эрдэнэбулган, Ч. Цэндмаа аймгаас зохион явуулсан морин хуурын 5 хоногийн анхан шатны сургалтанд хамрагдсан. Номын санч Ч. Цэндмаа МСҮТ-ийн архив нарийн бичгийн мэргэжлээр 1 жилийн эчнээд суралцсан. Хамт олноороо Монгол залуу клубын “ Аз жаргалтай амьдарлын нууц” лекц, БСШУЯ-ны сайд Гантөмөрийн “ Дэлхийн дайтай өрсөлдөх Монгол хүн” лекцийг сонссон.

СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

2015 онд нийт 30 нэр төрлийн ажил зохион байгуулж 7025 хүн хамрагдсан байна.

1. 2 сарын 5-16 хүртэл ЭӨЦС-ийн багш сурагчдын дунд “Ном уншлагын 14 хоног”-ийн аян өрнүүлсэн. Нийт 55 иргэсдэд үйлчилсэн. Мөн аяны хүрээнд тус сургууль дээр шинэ номын үзэсгэлэн гаргаж, дунд ахлах ангийнхны дунд МААЗ тэмцээн, АХА тэмцээн зохион явуулсан.

2. 2- сарын 13-нд 3-р цэцэрлэгийн багачуудын дунд 3 дахь жилдээ “Уран жиргээ 2015“ уран уншлагын тэмцээнийг зохион явуулсан. Тэмцээнд 29 хүүхэд, 24 эцэг эх, багш ажилчид оролцсон.

3. 2 сарын 23-наас 3 сарын 8 хүртэл “Ижийдээ захидал бичээрэй”-3 шилдэг захидлын уралдааныг зарлалаа. Уралдааны удирдамжийг 25 байгууллагад хүргэж танилцуулсан. Уралдаанд нийт 130 орчим захидал ирсэн ба бүгд ЕБС-ийн 3-аас 12-р ангийн сурагчдын бичсэн захидал байв. Уралдаанд ирсэн захидлуудаар 10 хоногийн турш үзэсгэлэн гаргаж шилдэг 3 захидлыг байр эзлүүлж дурсамж дурсгалын зүйлсээр урамшуулж, 4 захидлыг тусгай байрт оруулж ээжүүдэд нь захидлыг утсаар уламжиллаа. Мөн 03 сарын 6-ны өдөр “Зохиолчтой уулзая” зохиолч уншигчдын уулзалт зохиож шалгарсан захидлуудыг нийтэд танилцууллаа. Уулзалтанд МЗЭ-ийн гишүүн, Алтан Өд шагналт хүүхдийн зохиолч Ч.Наранцэцэгтэй ЭӨЦС-ийн 7А ангийн 27 сурагч уулзсан юм.

4. Тус илтгэлийн тэмцээнийг 03 сарын 09-нөөс 04 сарын 16 хүртэл хугацаанд 1-р 12 жилийн сургууль, ЭӨЦС, ХААМСҮТ, БТУСТДС-уудад зарлаж уралдааны удирдамж, зурагт зарыг биечлэн очиж сургуулийн нийгмийн ажилтан, номын санч, сургалтын менежерт танилцуулсан. Тэмцээн 1-р 12 жилийн сургууль, ЭӨЦС-ийн 9-12-р ангийн сурагчдыг хамарсан. 04 сарын 13-16-ны хооронд уралдааны

материалыг хүлээн авч нийт 10 сурагч бүртгүүлж Мандат авсан. Уран илтгэлийн уралдаан 04 сарын 17-ны өдөр АТНС-ийн Нийтийн Уншлагын Танхимд 14:30 минутад эхэлсэн ба шүүгчээр МЗЭ-ийн шагналт, СТА Н.Дагвадорж, МЗЭ-ийн шагналт, СТА, хүүхдийн зохиолч Ц.Чинбат, Төв Номын Сангийн Захирал Ч.Баярмаа, Ахлах номын санч Т. Мөнгөнтуяа нар ажиллалаа. Шүүгчид Тэмцээний явцыг дүгнэхдээ оролцогч сурагчид маань өөрийн бэлдсэн илтгэлээ өөртөө итгэлтэй боломжийн тавьсан. Гэвч илтгэлийн мэдээллээ ямар эх сурвалжаас авсанаа дурдаагүй, илтгэлийн материалаа цаг хугацаандаа өгөөгүй зэрэг нь дутагдалтай хэмээн онцоллоо. Тус тэмцээнийг 1, 2 дугаар 12 жилийн 9-12-р ангийн 32 сурагч үзэж сонирхсон. Мөн багш Н.Дагвадорж “Хүн байхын учир” цөөн хормын лекц тавьлаа. Хойшид жил бүр 4 сард тус тэмцээнийг сурагчдын дунд өргөн хүрээтэй явуулж байхаар боллоо.

5. 3 сарын 8-нд Бага ангийн сурагчдын дунд танин мэдэхүйн АХА тэмцээн зохион явуулав. Нийт 22 хүүхэд оролцож. 1-р 12 жилийн 5 В ангийн сурагч Б. Отгон баяр түрүүлэв.

6. 4 сарын 7,8-нд “Номтой нөхөрлөгч Булганчууд” номын өдөрлгийг СО, НХХ, “Таны ном” ТББ-тай хамтран шинэ номын томоохон худалдаа, үзэсгэлэн, байгууллагын албан хаагчдын дунд МААЗ тэмцээн, ЕБС-ийн сурагчдын дунд “Зохиолч уншигчдын уулзалт” зэрэг арга хэмжээ зохион байгуулсан. Нийт 1000 гаруй ирэгсэд хамрагдсан.

7. 5 сарын 5-нд БСГ, СО-той хамтран “Бид өв соёлоо тээгч, түгээгч” Бичиг соёлын өдөрлөг. Тэмцээнд Хөдөлмөрийн Хэлтэс, ЭӨЦС, 1-р 12 жилийн сургууль, МСҮТ, ХААМСҮТ, ЭМГ, СЗДТГ, Халамж үйлчилгээ, БТУСТДС, Улсын бүртгэлийн хэлтэс, Онцгой байдлын газар, 6-р цэцэрлэг, 4,7-р цэцэрлэг, ХГБХХ, Аймгийн Прокурор, Аймгийн Шүүх гэсэн 16 байгууллага оролцосноос дараах байгууллагууд бусдаасаа хошуучлан түрүүллээ.

“Бид өв соёлоо тээгч, түгээгч” тэмцээнд түрүүлсэн байгууллага

1-р байр: Аймгийн Хөдөлмөрийн Хэлтэс- Өргөмжлөл, дурсгалын зүйл

2-р байр: Эрдмийн Өргөө Цогцолбор Сургууль- Өргөмжлөл, дурсгалын зүйл

3-р байр: Аймгийн Эрүүл мэндийн газар- Өргөмжлөл, дурсгалын зүйл

Тусгай байрт: МСҮТ, 1-р 12 жилийн сургууль, Онцгой байдлын газрын багууд

Дээрх өдөрлөгийн үйл ажиллагаанд 300-аад хүн оролцлоо.

8. 5 сарын 25-нд Аймгийн нээлттэй хаалганы өдөрлөг: Тус өдөрлөг Ханддоржийн талбайд зохион байгууллаа. Номын сангийн үйл ажиллагаагаа сурталчилж, 200 шинэ номоор үзэсгэлэн гаргалаа. Нийт ирэгсэд 150 , 4 хүнд карт нээлгэж 10 ном гэрээр авсан.

9. 5 сарын 27-нд Булган сумын цэцэрлэгүүдийн дунд “Миний хайртай үлгэрийн баатрууд” дүрийн тоглолт, “Хүүхдийн зохиолч Ц. Чинбатын шүлгийг хэн сайн унших вэ? “ уран уншлагын тэмцээнд 1, 3, 4,7-р цэцэрлгүүд оролцлоо.

10. 5 сарын 29-нд Аймгийн Хүнс Хөдөө Аж Ахуйн Газрын хамт олны дунд "Ном Уншлагын 14 хоногийн аян" өрнүүлэв. Аяны хүрээнд албан хаагчдад уншигчийн нээж гэрээр ном олгох, номын сангийн үйл ажиллагааг танилцуулах, шинэ сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргах хөгжөөнт тэмцээн явуулах зэрэг ажил зохиолоо. Нийт 23 уншигчид үйлчилсэн.

11. 06 сарын 1-нд “Олон улсын хүүхдийн эрхийн өдөр” Тус өдрөөр зохион явуулах ажлын төлөвлөгөө гаргасны дагуу ажиллаа. Хүүхдийн зохиолч Ц. Чинбат, Ч. Наранцэцэг нартай хамтран “ НОМТОЙ ЖААЛУУД” өдөрлөг өртөөг ажиллууллаа. 05 сарын 27-ны өдөр “Миний хайртай үлгэрийн баатрууд” дүрийн тоглолт “, “Ц. Чинбатын шүлгийг хэн сайн унших вэ?” уран уншлагын тэмцээн явуулж шалгарсан 1,4,7,3-р цэцэрлэгийн багачуудыг 06 сарын 01-ны өдөр жүжиг, уран уншлагыг дахин багачуудад сонирхуулж дээрх зохиолчдын нэрэмжит Цом, өргөмжлөлийг

гардууллаа. Мөн хүүхэд багачуудын дунд “Үсгээр үг бүтээе” тэмцээн явуулж, Монголын хүүхдийн зохиолчдын “Пен” төвийн тэргүүний уншигчаар 1-р 12 жилийн Б.Ишдорж, М.Номин-Эрдэнэ нар шалгарлаа. Шинэ номын үзэсгэлэн, зохиолчийн гарын үсэгтэй ном, шинэ номын худалдаа ажилууллаа.

12. 06 сарын 03-нд ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад “Оюун ухаан тэтгэгч Ламаадан” ном хурав. Нийт ирэгсэд 15

13. Энэ оны 6 сараас эхлэн одоог хүртэл Үндсэн фондны ном нэг бүрийг Lib4U программд шинээр тоолох, номзүйн бичилтэд редакци хийж засах, шинээр баркод хэвлэн наах, тавиурт хаяг ялгагч хийн байрлуулах, 1 бүрчилсэн бүртгэлд бүртгэх ажлуудыг хийж байна.

14. 9 сарын “Ахмадууддаа зориулах өдөр”-үүд Аялах дэвтэр хүлээж авч ХЖТ, музейтэй хамтран аймгийн ахамдуудын дунд дуу, бүжиг, хөгжөөнт тэмцээн зохион явууллаа. Манай байгууллагаас МААЗ тэмцээн, Эд зүйлс олох тэмцээн зохиож, түрүүлсэн ахамдуудад дурсамж дурсгалын зүйл гардууллаа.

15. 9 сарын 18-нд Төрийн соёрхолт хөгжмийн зохиолч, СГЗ Ц. Чинзоригийн “Дууны хорвоо” улсын дуурийн дулаачдын уралдааны хүрээнд “Зохиолч, уншигчдын уулзалт” зохион байгууллаа. Тус уулзалтанд МУГЖ дуучин Чимэдцээ, СГЗ яруу найрагч С. Оюун, СТА, яруу найрагч сэтгүүлч Ж. Батцэцэг нар хүрэлцэн ирсэн. Мөн МСҮТ-ийн 35 орчим сурагч оролцлоо.

16. 9 сарын 23-нд УИХ-ын гишүүн түүхийн ухааны доктор, дипломатич Ё. Отгонбаярын “Шинэ номын баяр” боллоо. Булган аймгийн байгууллагуудын 50 гаруй албан хаагчид оролцож үзэж сонирхосон.

17. 09 сарын 24-нд БСГ-аас “Соёлын ажилтны баярын өдөр” зохион байгуулсан ба тус өдрөөр аймгийн соёлын ажилтнуудын дунд гар бөмбөгийн тэмцээн, теннис, шатрын тэмцээн болсноос манай байгууллага Шатрын тэмцээн явууллаа. Тэмцээнд 1-р байрт ХЖТ-ын морин хуурч Бат-Эрдэнэ, 2-р байр Музейн захирал Жаргалсайхан нар шалгарлаа. Нийт 35 орчим хүн сонирхсон.

18. 10 сарын 12-нд “Зохиолч уншигчдын уулзалт” хийлээ. Уулзалтанд Гавъяат багш, яруу найрагч Мандахсан оролцов. Тус уулзалтанд ЕБС-ийн 30 орчим сурагчид оролцлоо.

19. 2015 оны 10 сарын 14-нд Чинван Ханддоржийн талбайд “Номын өдөрлөг-Нээлттэй хаалга” өдөрлөгийг зохион явууллаа. Энэхүү өдөрлөгийг Соёлын ордоны номын сантай хамтран зохион явуулж ЕБС-ын болон МСҮТ, ХААМСҮТ-ын номын сангууд мөн хамтран оролцож дараах ажлууд хийлээ. Нээлтийн үеэр тэргүүний уншигч “Нацагдорж тэмдэг”-ийн болзол хангасан 1-р 12 жилийн 12 Г ангийн сурагч Б. Янжиндулам, ЭӨЦС-ийн 5 А ангийн сурагч Баярхүү, Ном уншлагын аяны хүрээнд зарласан 9 номинцадид шалгарсан ЭӨЦС-ийн 4В ангийн сурагч Н. Мөнгөнбаяр, 7Г ангийн сурагч М. Бямбагэрэл нарт тэмдэг, дурсамж гардууллаа. Мөн “Бэлгийн дээд НОМ” ном хандивлах хайрцаг байршуулсан. Аймгийн Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын газрууд идэвхтэй оролцсон. АТНС-аас шинжлэх ухааны 15 нэр төрлөөр 1000 гаруй номоор томоохон үзэсгэлэн гаргалаа. Соёлын ордны номын сан англи номоор, ХААМСҮТ-ын номын сан мэргэжлийн чиглэлийн номоор үзэсгэлэн, сурталчилгаа, танилцуулга хийлээ. Оролцогчдын дунд танин мэдэхүйн АХА тэмцээн явуулж МСҮТ-ийн оюутан Б.Чанцалдулам түрүүлж шинэ номоор урамшууллаа. Хүүхэд багачуудад номоо цэвэр нямбай, урж тасадахгүй ашиглаж байх талаар санаа сануулг өгөх зорилгоор хуучирч элэгдсэн, урагдсан номнуудыг санамжуудын хамт байрлуулж, бусад зөвлөмж гарын авлагуудыг үзүүлсэн Ном худалдаалах нөхцлийг бүрдүүлэн өгч номын худалдаа явуулсан

- Гэрээр ном авах сонирхолтой уншигчдад газар дээр нь карт нээн ном олгож үйлчилсэн. 10 уншигч карт нээлгэн 27 ном олгосон байна.
- Уншигчдын санал сэтгэгдлийн хүлээж авах зорилгоор санал хүсэлтийн дэвтэр байрлуулан санал сэтгэгдлийг бичүүлж авсан. Энэхүү өдөрлөгийн үйл ажиллагаанд 500-600 гаруй хүн оролцсон.

20. 10 сарын 27-ны өдөр 2-р цэцэрлэгийн хүүхдүүд, багш ажилчдын дунд АХА тэмцээн зохион явууллаа. Оролцогчдын тоо хүүхэд 86, багш ажиллагсад 17.

21. 10 сарын 16-нд 1-р 12 жилийн 6А, 7Г, 8А, ЭӨЦС-ийн 6А, 7Г, 8А ангийн 70 гаруй сурагчдын дунд танин мэдэхүйн АХА тэмцээн зохион явууллаа.

22. 10 сарын 12 ноос эхлэн Аймгийн Эрүүл мэндийн газарт "Ном уншлагын 14 хоног"-ийн аяны зарласан ба уг аяны хүрээнд мэргэжлийн болон шинэ номын үзэсгэлэн, явуулын номын сан ажлуулж, 21 уншигч, ирэгсэд 56 хүнд үйлчиллээ. Танин мэдэхүйн АХА тэмцээн зохион явууллаа.

23. 10 сарын 23-нд “All mart” худалдааны төвийн хамт олонд үйл ажиллагаа танилцуулж, “Явуулын номын сангийн үйлчилгээг” хүргэлээ. Уншигч 1, ирэгсэд 12, ном олголт 9

24. 10 сарын 19-нөөс 11 сарын 09 хүртэл Даваа гариг бүр 11:00 цагт Нийтийн Уншлагын Танхимд бага дунд ангийн сурагчдын дунд "Номоо уншъя, хайрлая, гамная" уриан дор "Ном эмчлэх" 1 сарын аян өрнүүлж эхэллээ. Тус аянд нийт 30 гаруй сурагчид хамрагдаж 46 номыг сэлбэн заслаа.

25. 10 сарын 29-ны өдөр 7-р цэцэрлэгийн багш нартай хамтран танин мэдэхүйн АХА тэмцээн, Үлгэрийн чанга уншлага явууллаа. Нийт 31 хүүхэд оролцов

26. 2015.11.09-нд ХААМСҮТ-ийн дотуур байрны сурагчдад “Номын уншлагын 14 хоног”-ийн аян зарлаж, карт нээж Явуулын номын сангаар үйлчиллээ. Мөн танин мэдэхүйн АХА тэмцээн явууллаа.

27. 2015.11.20-ны өдөр “Дараагийн хуудас” тэмцээн болон “Зохиолч уншигчдын уулзалт” ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. Тус тэмцээнд нийт 32 сурагч оролцсон. Урилгаар хүүхдийн зохиолч СТА Ч. Наранцэцэг уулзалт ярилцлага хийлээ.

28. 2015.11.18-21 хүртэл Хутаг-Өндөр, Сайхан, Тэшиг, Баян-Агт, Сэлэнгэ гэсэн 5 сумын номын санч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч гарын авлага тараалаа. Мөн сумын иргэдэд “Явуулын номын сан”-ийн үйлчилгээ үзүүлж, СОНА зохион байгууллаа.



29. 1, 2, 6-р цэцэрлэгийн 579 уншигчид 24 удаа 360 номоор Явуулын номын сангийн үйлчилгээг үзүүлж **6 удаа** АХА тэмцээн явуулсан. Нийт ирэгсэд 1800

30. 3, 4, 7-р цэцэрлэг 662 уншигчид 23 удаа 378 номоор Явуулын номын сангийн үйлчилгээг үзүүлж, 5 удаа АХА тэмцээн зохион явууллаа. Нийт ирэгсэд 1587

БУСАД ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

1. **Байгууллагын урсгал засвар:** 7сард Байгууллагын 8 ажилчин уншлага үйлчилгээний бүх танхимын шал, цонх, хаалга, үүдний өрөө, коридорь, дээвэр, гадна цэцэрлэгийн хашаа зэргийг будаж заслаа.

2. **Байгууллагын гадна дотно их цэвэрлэгээ:** Албан хаагчид 5 сарын 15, 25-ны өдрүүдэд хийлээ.

3. Мөн 10 сард Номын сангийн байгууллага болон ном худалдаанд ажиллаж байсан үе үеийн ахамдуудаа хүлээж авч, хөгжилтэй тэмцээн, сугалаа зэргийг явууллаа.

4. Албан бичиг ирсэний дагуу 12 сарын 1-нд Цогт хун тайжийн талбайн цасыг хамт олноороо цэвэрлэв.
5. 3 сарын 19-нд Гамшиг ослоос хамгаалах бүх нийтийн сургуулилтанд оролцлоо.

6. 3 сарын 19-нд БСШУЯ-ны сайд Гантөмөр номын сангийн үйл ажиллагаатай танилцлаа.

ТАНДАЛТ СУДАЛГАА

- **Төв номын сангаас** 1, 10-р сард “Номын сангийн үйлчилгээ” сэдэвт санал асуулгыг 81 хүнээс
- **Нийтийн уншлагын танхимаас** 5, 6, 10-р сард 105 уншигчаас “Номын сангийн үйлчилгээ”,
  “Уртасгасан цагийн хуваарь” сэдвээр
- **Салбар номын сангаас** 1, 10-р сард 41 уншигчаас “Номын сангийн үйлчилгээ” сэдвээр

- **Хүүхдийн уншлагын танхимаас** 1, 10-р сард 35 уншигчаас “Номын сангийн үйлчилгээ” сэдвээр тус тус авчээ.

Нийт 9 удаагийн санал асуулгад 262 уншигч хамрагдсан. Тус санал асуулгын сэдвийн хүрээнд доорх асуултуудыг асуув. Үүнд:

1. Номын сангийн ерөнхий үйлчилгээ ямар байна вэ?

Асуулгад оролцогч нарын 85% нь сайн, 10% дунд, 5% мэдэхгүй гэж хариулсан.

2. Номын сангаар үйлчлүүлхэд бэрхшээлтэй зүйл байна уу? байгаа бол яагаад ....

Асуулгад оролцогчдын 95 % нь бэрхшээлтэй зүйл байхгүй гэж үзсэн. 5% нь үйлчлүүлж байгаагүй гэж хариулсан.

3. Номын санч мэдээллийн ажилтангуудын үйлчилгээний соёл хэр байна вэ?

Асуулгад оролцогчид 96% нь сайн, 4% нь дунд

4. номын сангаас зохион явуулж буй соёл олон нийтийн ажил таньд ямар санагдаж байна вэ?

Асуулгад оролцогчдын 93% нь сайн 7% нь мэдэхгүй гэж тус тус хариулжээ.

Жишээ:

5 сард: Нийт 3 асуулттай санал асуулгад 23 уншигч оролцлоо.

1-р асуултанд: Танд номын сангаар үйлчлүүлэхэд бэрхшээлтэй зүйл байна уу? Хэрвээ байвал:

Тус асуултанд 23 уншигч байхгүй гэж хариулсан.

2-р асуултанд Та уншлагын танхимаас зохион явуулдаг аливаа соёл олон нийтийн ажилд оролцдог уу?

А. 2 уншигч ихэнхдээ оролцдог

Б. 14 уншигч заримдаа оролцдог

В. 4 уншигч оролцдоггүй / нийт 20 уншигч /

3-р асуултанд Та “номын санч-мэдээллийн ажилтан”-уудыг уншигч нарт хандсан өмнөхөөс өөр ямар шинэ ажил хийгээсэй гэж хүсдэг вэ? Санал аа бичнэ үү

-Дулаан орчин бүрдүүлэх-20

-Ангиудын хооронд номын тухай ярилцлага зохиох-1 уншигч

-Сар бүр шилдэг уншигч шалгаруулах-1 уншигч

-Лектор хүмүүсээр сурагчдад лекц тавиулах-1 уншигч

-Номоо улирал болгон солих-1 уншигч

-Хэлэх зүйл байхгүй -10 уншигч

-Одоо байгаа нь таалагдаж байна-6 уншигч / нийт 20 уншигч /

ШИНЭЛЭГ АЖИЛ:

АТНС-аас

- Булган хотын хэмжээнд Таны ном ТББ, НХХ-тэй хамтран “Номтой нөхөрлөгч Булганчууд” номын өдөрлөгийг зохион явууллаа.
- 6 сараас Номын сангийн үндсэн фонд дахь нийт ном нэг бүрийг Lib4U программд номзүйн засалт хийх, түлхүүр үг нэмэх ажил. Мөн фондын номын ангилал хаяг ялгагч наах, ном нэг бүрийн хуучин баркодыг устгаж, шинэчлэх
- ЕБС-ийн төгсөгч нарт зориулан Дашчойнхорлин хийдтэй хамтран Оюун ухаан тэтгэгч Ламаадан номыг айлтгуулсан

Нийтийн уншлагын танхим:

- Анх удаа ахлах ангийн манлайлагч сурагчдын дунд **“Бид Монголын Ирээдүй”** уран илтгэлийн тэмцээнийг зохион явууллаа.
- Ахлах ангийн яруу найраг, зохиол бичих сонирхолтой, манлайлагч хүүхдүүдийн дунд **“Дараагийн хуудас”** тэмцээнийг зохион явуулсан.

Салбар номын сан:

- ЭӨЦС-ийн бага ангийн сурагчдын анги дээр биечлэн очиж карт нээж, номоор үйлчилж байна.

Хүүхдийн Уншлагын Танхим:

- 1-р 12 жилийн бага ангийн багш нартай гэрээ хийж "Явуулын номын сан" ажлуулж байна.

ЦААШИД ХИЙХ АЖЛЫН ТАЛААР

- Номын сангийн 70 жилийн ойг угтаж бүтээлч ажлуудыг зохион байгуулах
- Номын сангийн ном зүйн бичилт шинэчлэх, каталог бичилтийн ажлыг дуусгах
- Сумдын номын сангийн автоматжуулалтын ажлыг эрчимжүүлэх
- Сумдад нүүдлийн номын сан ажиллуулахад санхүүгийн бэрхшээлтэй байгаа тул орон нутгаар асуудлыг шийдүүлэхэд хамтран ажиллах
- Номын фонд бүрдүүлэлтэнд анхаарах
- Номын санчдыг мэргэшүүлэх
- Номын сангийн өргөтгөлийн асуудлыг холбогдох газарт тавих
- Уншигчдад үйлчлэх таатай орчин бүрдүүлэх
- Сантехник, халаалтын асуудлыг холбогдох газраар шийдвэрлүүлэх

SWOT ШИНЖИЛГЭЭ

Давуу тал:

- Уншлага үйлчилгээний шинэ нөхцөлд зохицуулан, шинэлэг хэлбэрээр явуулах ажлын чиг баримжаатай болсон
- Интернэт үйлчилгээний дэвшилтэт арга хэлбэрийг бүтээлчээр ашиглах боломж бүрдсэн
- Техник хэрэгсэлийн хангамж сайжирсан
- Номын сан байршил сайтай хэрэглэгчид ойр
- Уншигч ирэгсэдийн тоо нэмэгдэж байгаа
- Өөрийн номын сандаа авто машинтай

Сул тал:

- Мэргэжлийн боловсон хүчин цөөн
- Алслагдсан сум, багуудад хүрч үйлчлэхэд бинзен шатахууны төсөв хөрөнгө хүрэлцээгүй
- Одоо ашиглаж байгаа барилга байгууламж үйлчилгээний шаардлага хангахгүй болсон
- Үйлчилгээг өргөжүүлэх санхүүгийн дэмжлэг бодит байдлаас хоцорч байгаа
- Шинэ номын хүрэлцээ муу
- Номын санчдын цалин хангамж хангалтгүй

Боломж:

- Аймгийн төр, төрийн бус байгууллага, олон нийттэй хамтран ажиллах тэдний дэмжлэгийг авах боломжтой
- Нийт иргэд, хүүхэд залуучуудын мэдээллийн эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа

Аюул занал:

- Интернэтийн үйлчилгээ эрхлэгчид олширч өрсөлдөөн нэмэгдэх
- Дохиолол, хамгаалалт байхгүй
- Номын сангийн байрны багтаамж нөхцөл, хүрэлцээ муу
- Цахилгаан монтаж шаардлага хангахгүй болсон

- Сантехник, халаалт муу

ДҮГНЭЛТ

- Номын сангийн ном хэвлэлийн номзүйн бичилтийг стандартын дагуу болгон шинэчлэн үндсэн фондын 12000 гаруй номонд редакци хийж, шинээр баркоджуулсан. Энэхүү ажил нь хугацаа их шаарддаг тул илүү цагаар шахуу ажиллаж байна.
- Төлөвлөгөөт СОНА зохион байгуулж чадсан.
- Уншигчдаас санал асуулга болон сэтгэл ханамжийн судалгааг удаа дараа авч дүгнэлт хийн үр дүн гаргахаар ажиллаж байгаа ч номын сангийн үйлчилгээнд хангалтгүй санагдаж байгаа зүйлүүд нь уншигчид хүйтний улиралд уншлагын զааланд суухад халаалт муу байдаг их даарч тав тухгүй, дотроо 00-гүй, номын хүрэлцээ муу, байр савны багтаамж бага зэрэг асуудлууд байна. Эдгээр асуудлуудыг шийдэхэд бидний зүгээс авч болох арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа ч төсөв хөрөнгөөс хамаарах учраас шийдэж чадахгүй байгаа.
- Сумын номын сангуудад ашиглаж байгаа номын сангийн програм хангамж ашиглалт удаашралтай хангалтгүй байгаа нь харагдаж байна. Програмын талаар тайлан мэдээ ирүүлэлт муу байна.
- Шинэ ном худалдан авахад номын үнэ өндөр төсөв бага байгаагаас номын фонд баяжилт муу хийгдэж байна. Ирсэн ном уншигчдад хүрэлцэхгүй байгаа талаар уншигчдаас байнга санал гомдол ирж байна.
- СОНА-д насанд хүрэгчдийн оролцоо, идэвхи, санаачлага хангалтгүй байдаг. Байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах тал дээр цаашид анхаарч ажиллах шаардлаагтай.
- Оны шилдэг “Оюунлаг хүүхэд” шалгаруулах удирдамжийг орон нутгийн номын сангуудад явуулсан боловч аймгийн захиргаанаас зөвшөөрөл өгөөгүй. Зөвхөн сумддаа “Оюунлаг хүүхэд”-ээ шалгаруулсан. Аймгийн төвөөс “Оюунлаг хамт олон” болон “ Оюунлаг анги хамт олон”, Тэргүүний уншигч, 9 номинациас шалгаруулж урамшуулсан.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН

2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Удирдлага зохион байгуулалтын талаар:

Аймгийн Боловсрол Соёлын Газрын даргатай байгуулсан Менежерийн үр дүнгийн гэрээ, төлөвлөгөөг үндэслэн Говь-Алтай аймгийн Нийтийн номын сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг ханган биелүүлэх зорилгоор баталгаажуулан ажиллалаа.

Аймгийн нийтийн номын сан нь Монгол Улсын хууль, бусад хууль тогтоомжууд, УИХ, Засгийн газар, БСШУЯ-ны сайдын тушаал заавар, зөвлөмжүүдэд үндэслэн өөрийн үйл ажиллагааг зохион байгуулж ирлээ.

Орон тоо бүтэц зохион байгуулалтын хувьд үндсэн 12, гэрээт 1 орон тоотойгоор үйл ажиллагаа явагдаж байна. Жилийн болон улирлын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан үүрэгт ажлыг ханган биелүүүлэх зорилгоор ажлын зохион байгуулалтыг сайжруулж ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулж бүтээгдэхүүн нийлүүлэлтийг ханган биелүүлэх үр дүнгийн гэрээг байгуулж ажиллалаа.

2. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр:

2015 онд байнгын болон шинэ уншигч 1500 бүртгэж, 14012 ирцэд 28013 ном олголт хийж, уншигч үйлчлүүлэгчдийг шинэ мэдээ мэдээллээр хангах зорилтын хүрээнд аман болон бичгийн лавлагаа 469 өгч, иргэд олон нийтэд хүрч ажиллах үүднээс зөөврийн номын санг ХААН банк, Шүүхийн Шийдвэр гүйцэтгэлийн алба, Нийгмийн даатгалын Хэлтэс, ХААГазар, ЗӨСТөв,СХЗ, МХГазар, НХҮХэлтэс, Хөдөлмөрийн хэлтэс, Монгол банк, ОНСМузей, Татварын хэлтэс, ИТХ, Орон нутгийн өмчийн алба, Аймгийн ЗДТГазар, ОБХэлтэс, Спорт хороо, 3-р цэцэрлэг, Байгаль орчны газар, Цаг уур, 3-р цэцэрлэг, Аудит, Нисэх, Иргэний бүргэлийн газар, Капитал банк, Тагнуулын ерөнхий газар, Рашаант баг, Хатан плаза дэлгүүрийн хамт олонтой хамтран ажиллах гэрээ хийн шинэ уншигч 136 бүртгэж, 7 хоногоор номоо сольж нийт 1277 ирцэд 2148 ном олголоо. Мөн Есөнбулаг сумын хөгжлийн бэрхшээлтэй Жаргалантын хороо 3-5 тоотод оршин суугч 62 настай П.Энэтэгхүү, Жаргалант хороо 6-4 тоотод оршин суугч 37 настай С.Сарангэрэл, Жаргалант хороо 4-8 тоотод оршин суугч 59 настай С.Буянт, Жаргалант хороо 3-6

тоотод оршин суугч 29 настай Д.Болор-Эрдэнэ нарт зөөврийн номоор үйлчилж байна. Шинэ болон хандиваар, нөхөн бүрдүүлэлт/ өрөнд/ нийт 1402 ширхэг номоор фондоо баяжуулж, данс бүртгэлд авч техник ажиллагаа хийсэн. Татгалзалын судалгааг үндэслэн 88 ширхэг номоор нөхөн бүрдүүлэлт хийсэн.

Үндсэн фонд, хүүхдийн уншлагын танхим, насанд хүрэгчдийн уншлагын танхим, гэрээр ном олгох тасгийн номын санчид нийт 1061 ширхэг номыг сэргээн засварлаж уншлага үйлчилгээнд гаргасан байна.

Номын сэдэвчилсэн үзэсгэлэнг 1 дугаар сард Түүхийн шинжлэх ухааны номуудаар, 2 дугаар сард “Монгол ёс заншил”, 3 дугаар сард “Говь-Алтай аймгаас төрөн гарсан эмэгтэй зохиолчид”, “Зэвсэгт хүчний 90 жилд”, “Эмэгтэйчүүд ба гэр бүл”, 4 сарын 1-нээс 5 дугаар сарын 1 “Хөдөө аж ахуй газар тариалан эзэмшигчдэд“, 5 дугаар сарын 11-нд Үндэсний бичиг үсгийн баяраар Шинэ болон шилдэг ном, ховор ном, номын үзэсгэлэн худалдаа, Англи номын үзэсгэлэн, 06 дугаар сарын 01-нд Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээнд оролцон Аймгийн төв талбайд хүүхдийн номын үзэсгэлэн, номын худалдааг, 10 сард “Нээлттэй хаалга”-ны өдрөөр хүүхдийн шинэ болон ховор номоор, 10 сарын 9-нд Номын баяраар хандиваар ирсэн номын үзэсгэлэн,10 сарын 20-нд Хүүхдийн болон шинэ номоор, 11 сарын 12нд “Монгол бахархал” номын үзэсгэлэнг тус тус гаргалаа. Улаанбаатар хотноо 05 сарын 27-нд Зохиолчдын номын баяр үзэсгэлэн худалдаанд оролцов. 05 сарын 27-30 өдрүүдэд Үндэсний номын сантай хамтран Алтайн зохиолчдын номын үзэсгэлэнг Үндэсний номын сангийн Үнэт ховор номын танхимд гаргалаа.

3. Фонд, каталоги зохион байгуулалт:

Үсэг дараалал 100 %-тай, төрөл ангийн каталоги зохион байгуулалт 80 %-тай явагдаж байна. Гадаад номыг программд 100 %-тай оруулсан. Шинэ болон төсвийн хөрөнгөөр 315 ширхэг 3583,7 төгрөгийн ном, хандиваар 977 ширхэг, нөхөн

бүрдүүлэлт /өрөнд/ 110 ширхэг 421,1 төгрөгийн нийт 1402 ширхэг номыг Lib4U программд оруулан бар коджуулан фонд тасгуудад хуваарилан каталоги хэвлэн байрлуулсан байна. Фондын чийгшилт номын хадгалалтыг сайжруулан ажиллаж байна.

4.Сургалт, аргазүйн зөвлөгөөний чиглэлээр:

Боловсрол Соёлын Газартай хамтран Соёлын ажилтнуудын сургалтыг 2015 оны 04 сарын 14-нд Нийтийн номын сангийн Насанд хүрэгчдийн уншлагын танхимд зохион байгууллаа. Сургалтанд 18 сумын соёлын төвийн эрхлэгчид, соёлын төвийн номын санчид, ННСангийн захирал, номын санчид, ном зүйч, мэдээллийн ажилтан, фондоч зэрэг нийт 42 соёлын ажилтан хамрагдав. Монголын үндэсний номын сантай хамтран 04 сарын 27-29-ны өдрүүдэд ”Номын сангийн үйл ажиллагаа“ сургалтыг Нийтийн номын сангийн уншлагын танхимд зохион байгууллаа.

Сургалтанд 18 сум, сургуулийн нийт 50 номын санчид хамрагдлаа. Номын санчдад Улаанбаатар хотоос МҮНС-ийн Мэдээлэл–арга зүй,эрдэм шинжилгээний хэлтсийн дарга Д.Энхтунгалаг хүрэлцэн ирж 24 цагийн хичээл орж сургалтанд хамрагдсан номын санчдад сертификат гардууллаа. Дэлгэр сумын сум, сургуулийн номын сан, Есөнбулаг сумын 1,2,3,5-р сургуулийн номын сан, МСҮТ-ийн номын сан, АУК-ийн номын сангуудын үйл ажиллагаатай танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв. 04 сарын 29-ны 10 цагт сургалтын хаалтанд Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар, Засаг даргын тамгын газрын дарга П.Золжаргал, ННХ дарга Т.Гансүх, МҮНС-ийн Мэдээлэл–арга зүй, эрдэм шинжилгээний хэлтсийн дарга Д.Энхтунгалаг, ННСангийн захирал Ч.Эрдэнэбулган нар оролцлоо. Мөн Аймгийн ЗДТГазраас 18 сум, сургуулийн номын сан бүрд нийт 47 ширхэг номыг хандивлав.

МҮНС-ийн Мэдээлэл–арга зүй, эрдэм шинжилгээний хэлтсийн дарга Д.Энхтунгалаг, ННСангийн захирал Ч.Эрдэнэбулган, ном зүйч Б.Одсурмаа, мэдээллийн ажилтан Б.Оюун, фондоч Д.Ундармаа нар 12 жилийн 1,2,3,5-р сургуулийн номын сан, МСҮТөвийн номын сан, АУКоллежийн номын сан, Дэлгэр, Гуулин, Тайшир сумуудын соёлын төв болон сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

9-р сард Улаанбаатар хотод болсон Номын баярт ном зүйч Б.Одсурмаа оролцож 2013-2014 оны номын баярын тайлангаар үзэсгэлэн гаргаж Нийтийн номын сангийн үйл ажиллагааг сурталчиллаа.

11 сарын 20-нд Хууль-зүйн хэлтсийн мэргэжилтэн н.Баттайван хуулийн сургалт хийлээ. Сургалтанд АДБАЧуулга, ОНСМузейн хамт олон ирж оролцлоо. Сургалтыг Нийтийн номын сангийн Хүүхдийн уншлагын танхимд зохион явууллаа.

Шарга, Төгрөг сумдад ном зүйч Б.Одсурмаа, мэдээллийн ажилтан Б.Оюун нар 12 сарын 02-04 хүртэл 2 хоногийн хугацаатай ажиллалаа. Соёлын төвийн үйл ажиллагаа болон номын санчдын номын сангуудад хөтлөгдөх данс бүртгэл дутуу хөтлөгдсөн, номзүйн ажил, номын техник ажиллагаа хийгдээгүй зэрэг нийтлэг алдаа дутагдал байна.

5. Соёл олон түмний ажлын чиглэлээр:

2015 оны 03 сарын 06-нд ЕБСургуулиудын 11-р ангийн дунд Б.Лхагвасүрэнгийн уран бүтээлээр уран уншлага болон дууны тэмцээн зохион байгуулав.

Шүлгийн уралдаанд: 5-р сургуулийн 11-р ангийн сурагч Батцэнгэл “Боржигоны бор тал”-г уншиж тэргүүн байр, 1-р сургууль 11-р ангийн сурагч Тэргэл “Ижийгээ байхад би баян байсан” шүлгийг уншиж удаах байрыг, 2-р сургуулийн 11-р ангийн сурагч Тэмүүлэн “Хүүдээ унших шүлэг”-ийг уншиж гутгаар байрыг тус тус эзлэв. Дууны уралдаанд: 2-р сургуулийн 11-р ангийн сурагч Батболд Чамайг тойрон эргэлдэнэ, Дэд байрыг 1-р Сургуулийн сурагч Энхчимэг, гутгаар байрыг 3-р сургуулийн сурагч Эрдэнэбүрэн, Буяндэлгэр нар тус тус эзлэв.

04 сарын 25-нд Төрийн хошой соёрхолт эрдэмтэн зохиолч Ч.Лодойдамбын уран бүтээлээр “Утгын чимэг” богино өгүүллэгийн наадмыг зохион явуулав. Уралдаанд ЕБС-уудын ахлах ангийн 13 сурагч оролцож “Хугараагүй ноён нуруу”, “Шаргачин”, “Гэрээслэл”, “Малгайтай чоно”, “Дусал нулимс юу хэлэв” гэх мэт өгүүллэгүүдийг уншиж өрсөлдөв.

Монгол Улсын ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, үндэсний бичиг хэл бичиг түүнтэй холбоотой ёс заншил, уламжлал, өвийг судлах ард нийтэд сурталчлах зорилгоор 2015 оны 05 дугаар сарын 20-нд Аймгийн Нийтийн номын сан “БИ МОНГОЛ БИЧИГТЭН” үндэсний бичиг үсгийн зохион явууллаа. Бичиг үсгийн баярыг нээж Нийтийн номын сангийн захирал

Ч.Эрдэнэбулган үг хэллээ. Нээлтийн үйл ажиллагаанд БСГ-ын дарга М.Сурахбаяр, БСГ-ын соёл хариуцсан мэргэжилтэн Н.Жаргалсайхан нар оролцов. Мөн АДБАЧ-ын уран бүтээлчид уран бүтээлээсээ толилуулав.

2014 оны ГНОТасгийн тэргүүний уншигч О.Нэргүйд Дурсамж, дурсгалын зүйл, ХУТ-ын тэргүүний уншигч А.Солонгод Д.Нацагдоржийн нэрэмжит “Тэргүүний уншигч-Номын сайн нөхөр” тэмдэг тус тус гардуулав.

Монгол бичгээр уран бичлэгийн уралдаанд нийт 25 гаруй сонирхогчид оролцож өөрсдийн сонирхсон үгээ бичиж уралдав.

Уран бичлэгийн уралдаанд 1-р байрт Хан-Тайшир эрдэм цогцолбор сургуулийн 11-а анги Т.Ууганбадрах, 2-р байрт Хан-Тайшир эрдэм цогцолбор сургуулийн 12-б анги Б.Мөнх-Эрдэнэ, 3-р байрт 12 жилийн 1-р сургууль Н.Шаарийбуу, тусгай байрт МХГазар Ж.Батбаяр нар тус тус шалгарч дурсамж, дурсгалын зүйл мөнгөн шагналаар шагнагдав.

Монгол бичгээр хурдан уншигч шалгаруулах уралдаанд нийт 30 гаруй сурагчид оролцов. Хурдан уншигч уралдааны 1-р байрт Хан-Тайшир эрдэм цогцолбор сургуулийн 10-б анги О.Ихбаяр, 2-р байрт 12 жилийн 2-р сургуулийн 12-а анги Ж.Давааням, 3-р байрт Хан-Тайшир эрдэм цогцолбор сургуулийн 12-б анги Б.Даваасүрэн, тусгай байрт 12 жилийн 3-р сургуулийн 11-в анги З.Нямдарь, Хан-Тайшир эрдэм цогцолбор сургуулийн 12 анги Б.Соёл-Эрдэнэ нар тус тус шалгарлаа.

05 дугаар сарын 26-нд ЕБС-ийн 5 ангийн сурагчдын дунд "Үлгэрийн ертөнцөөр аялацгаая" дүрийн тоглолтыг зохион явуулав. Дүрийн тоглолтонд Оюуны түлхүүр цогцолбор сургуулийн Цэрэннадмид багштай 5-а анги "Цасан охин" үлгэрээр, 12 жилийн 1-р сургуулийн Б.Солонгоо багштай 5-б анги "Шошны үр" үлгэрээр, Н.Энхтуяа багштай 5-а анги Амьтадын тухай үлгэрээр тус тус байр эзлэв. Уг дүрийн тоглолтыг үзэж нийт 30 сурагчид хамрагдав.

Төрийн шагналт, Ардын уран зохиолч, Хөдөлмөрийн баатар, соёлын гавьяат зүтгэлтэн Л.Түдэвийн "Нүүдэл суудал" хоймсон романаар ЕБС-ийн 12-р ангийн сурагчдын дунд уншигчдын бага хурлыг зохион явууллаа. Илтгэлийн тэргүүн байрыг 2-р сургуулийн 12-а ангийн сурагч Д. Тунгалагтуяа, дэд байрыг 5-р сургуулийн 12-а ангийн сурагч Д.Сугармаа, гуравдугаар байрыг 3-р сургуулийн 12-р ангийн сурагч А.Нямсүрэн, тусгай байрыг 3-р сургуулийн 12-б ангийн сурагч

П.Энхсайхан нар, эссэ бичлэгийн уралдааны тэргүүн байрыг 3-р сургуулийн 12-б ангийн сурагч М.Пунсалмаа, дэд байрыг 2-р сургуулийн 12-р ангийн сурагч О.Сарангоо, гуравдугаар байрыг 5-р сургуулийн 12-р ангийн сурагч А.Бархасмаа, тусгай байрыг 3-р сургуулийн 12-в ангийн сурагч М.Даваабаяр нар шалгарч, 120 гаруй төгсөх ангийн сурагчид хамрагдлаа.

Номын баярыг 2015 оны 10сарын 9-ны 10 цагт Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн зааланд зохион байгууллаа. Номын баярын үйл ажилллагааг Нийтийн номын сангийн захирал Ч.Эрдэнэбулган, Аймгийн Засаг Даргын орлогч Д.Батсайхан нар нээж үг хэллээ. Д.Нацагдоржийн нэрэмжит “Тэргүүний уншигч-Номын сайн нөхөр” тэмдэг гардуулав.

Ном унших сарын аяныг 6-9 анги, 10-12 ангийн сурагчдын дунд зохион байгуулж аяныг 2015 оны 10сарын 8-ны 16 цагт дүгнэв. 6-9 ангийн сурагчдын ангилалд 40 сурагч оролцсоноос 1-р сургуулийн 6 –р ангийн сурагч С.Амармэнд, 10-12 ангийн сурагчдын ангилалд 32 сурагч оролцсоноос 1-р сургуулийн 12-р ангийн сурагч Э.Эрхэтбилгүүн нар шалгаран Боловсрол Соёлын Газрын Даргын нэрэмжит шагналаар шагнагдав. 1-5 ангийн сурагчдын дунд явуулсан Номын тухай дууны тэмцээнд 15 сурагч оролцсоноос 1-р байрт 5-р сургуулийн сурагчдын хэсэг “Миний ном“ дуугаар, 2-р байрыг Оюуны түлхүүр сургуулийн 3-а ангийн сурагчид “Алтан ном дэлгээд уггтлаа” дуугаар, 3-р байрт 2-р сургуулийн сурагч Батгэрэл “ Хүүхдийн зохиолч” дуугаар тус тус байр эзлэн өргөмжлөл, дурсгалын зүйл мөнгөн

шагналаар шагнагдав. Шүлгийн тэмцээнд 29 бага ангийн сурагчид оролцсоноос 1-р байрт 3-р сургуулийн сурагч Т.Уранзаяа “Ном“ шүлгээр, 2-р байрт 2-р сургуулийн сурагч Ч.Лувсанвандан “Эрдмийн ном” шүлгээр, 3-р байрт 2-р сургуулийн сурагч М.Урангоо “Ном“ шүлгээр тус тус байр эзлэн өргөмжлөл, дурсгалын зүйл мөнгөн шагналаар шагнагдав.

Номын баярыг тохиолдуулан орон нутагтаа оршин суугаа зохиолч, яруу найрагч Г.Чардаг, Ш.Цоодол нартай зохиолчдын уулзалт зохион явууллаа. “Оюунлаг Алтайчууд” ном хандивлах ба номын аялалд гарцгаая сарын аянаар нийт 2778 ном цугларсан бөгөөд уран зохиолын ном -618 ширхэг, гадаад ном -110 ширхэг, бусад ном -2056 ширхэг байна. Улаанбаатар хотод уг аяныг зохион байгуулсан сэтгүүлч н. Одгэрэл 10 сарын 3-нд ирж хандивласан 1000 ширхэг номыг гардуулан өглөө. Хандивын номуудаар үзэсгэлэн гаргаж ном хандивлах сарын аянд оролцсон байгууллага, иргэдэд “Талархал“ гардууллаа.

11 сарын 27-нд Монголын алдарт яруу найрагч, зохиолч ,орчуулагч,соён гэгээрүүлэгч, сэтгүүлч М.Цэдэндоржийн шүлгээр эссэ бичлэгийн болон яруу найргийн наадмыг зохион явууллаа. Эссэ бичлэгийн уралдааны Тэргүүн байрт 1-р сургуулийн 9-б ангийн сурагч Г.Сайнбилэгт, дэд байрт Хантайшир –Эрдэм цогцолбор сургуулийн 9-а ангийн сурагч Э.Ануужин, гутгаар байрт Хантайшир–Эрдэм цогцолбор сургуулийн 9-а ангийн сурагч Д.Хонгорзул нар шалгарлаа. Уран уншлагын тэмцээнд 16 сурагч оролцсоноос Тэргүүн байрт 2-р сургуулийн 9-а

ангийн сурагч О.Одбаяр, дэд байрыг 3-р сургуулийн 9-а ангийн сурагч Б.Жадамбаа, гутгаар байрыг 3-р сургуулийн 9-б ангийн сурагч Х.Даваахүү, тусгай байрт 5-р сургуулийн 9-а ангийн сурагч Э.Анужин нар тус тус шалгарлаа. Уг уралдаанд нийт 35 сурагчид хамрагдлаа.

<u>6.Тохижилт үйлчилгээний чиглэлээр:</u>

Уншигчдын ая тухтай орчинг бүрдүүлэхийн тулд коридорт хайлтын компьютер байрлуулав. Хүүхдийн уншлагын танхимд засвар хийж шалыг солив. Мөн уншигчдыг цахим мэдээлэл авах орчин нөхцлийг бүрдүүлэх үүднээс Wi-Fi суурилуулан цацаж байна.

Байгууллагын дотор талд Үндсэн фонд, Хүүхдийн уншлагын танхим, Гэрээр ном олгох тасгийн ойрын фондуудын тавиурыг янзлан байрлуулж фонд зохион байгуулалт хийлээ. Насанд хүрэгчдийн уншлагын танхимд Говь-Алтай аймгаас төрөн гарсан төрийн шагналт зохиолчдын буланг хийж байрлууллаа. Хуулийн булан самбар хийж байрлуулав.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НÈÉÒÈÉÍ ÍОМЫН САНГИЙН
2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Иргэдэд ном хэвлэл, мэдээллээр үйлчлилж ашиглуулах ажлын талаар:

- ✓ Шинээр 960 уншигчид карт нээж, уншигчийн соронзон үнэмлэх олгосон.
- ✓ Нийт 13700 ирэгсэд 20100 ширхэг ном олгосон.
- ✓ Гэрээр 423 уншигчидад 913 ном олгож үйлчилсэн
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй 446 иргэдэд 4684 ширхэг ном олгож үйлчилсэн
- ✓ Зөөврөөр 558 уншигчдад 1110 ширхэг ном олгож үйлчилсэн
- ✓ ЕБС-ийн 2, 5 дугаар сургуулийн номын сан гэрээгээр 125 ном хүргэж, Политехник коллежид 30 ширхэг ном солилцоогоор уншуулж үйлчилсэн

Интернет цахим номын үйлчилгээ үзүүлэх. Цахим номын фондыг нэмэгдүүлэх:

- ✓ Иргэдэд интернет мэдээллээр хангах, цахим номоор үйлчлэх зорилгоор 2 ширхэг интернетийн компютер ажиллуулж бүтэн жилийн турш 1102 уншигчдад үйлчилгээ үзүүлсэн.
- ✓ Цахим номын фондыг 253 ширхэг номоор баяжуулсан.
- ✓ Нийт фондыг 100% цахим каталогит оруулсан.
    - ✓ Хувилан олшруулах,скайнердах буюу нэмэлт үйлчилгээг 758 уншигчдад хүргэсэн.
    - ✓ Байгууллагын вэб сайт болон цахим хуудсыг ажиллуулж, шинэ номын мэдээ болон цаг үеийн мэдээ мэдээлэл, зохион байгуулах соёл олон түмний ажил зэргийг сурталчилж байна

Хөдөө орон нутгийн алслагдсан багийн малчдыг ном, хэвлэл мэдээллээр хангаж нүүдлийн номын сангийн үйлчилгээ үзүүлэх.

2015 оны 5 дугаар сарын 16-нд нээлттэй хаалганы өдөрлөгөөр Шивээговь сумын иргэд хөдөлмөрчдөд номын сангийн үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг хүргэж үйлчилсэн.

Сүмбэр сумын хөдөөгийн алслагдсан багийн 150 малчдад 253 ширхэг ном, сонин, сэтгүүл тарааж, шинэ номын үзэсгэлэн гаргаж байгууллагынхаа үйл ажиллагааг танилцуулж үйлчилсэн.

Үүнд:

2015.6.3-нд 4-р багийн 30 малчинд 53 ширхэг ном,сонин,сэтгүүл

2015.8.5-нд 5-р багийн 56 малчинд 81 ширхэг ном,сонин,сэтгүүл

2015.10.4- нд 6-р багийн 35 малчинд 56 ширхэг ном,сонин,сэтгүүл

2015.11.5- нд 4-р багийн 29 малчинд 63 ширхэг ном,сонин,сэтгүүл

Ховор ном судрын фондыг бий болгох судалгаа хийх ажлын талаар:

Сүмбэр сумын 2 дугаар байгийн иргэн Г.Ганхуяг гуайн гар дээр хадгалагдаж байгаа 36 ширхэг ховор ном, судрыг бүртгэж, мэдээллийн сан бий болгосон.

Иргэдийн гар дээр байгаа ховор ном сударыг судалж бүртгэлжүүлэх ажлыг эрж хайн, ажлыг байнга эрэлхийлж байна.

Шинэ фондыг шинэ ном хэвлэлээр баяжуулах ажлын талаар:

Номын фондыг:

Төсвийн хөрөнгөөр*:* 38 нэр төрлийн 175 ширхэг 2,283,000 мянган төгрөгийн ном

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр*:* 151 нэр төрлийн 310 ширхэг 5,000,000 төгрөгийн ном

Иргэд олон нийтийн хандиваар*:* 37 нэр төрлийн 64 ширхэг 277,465 төгрөгийн ном

Нийт 226 нэр төрлийн 549 ширхэг 7,560,465 төгрөгийн номоор фондоо бүрдүүлсэн.

Сумдын номын сангуудын, сан хөмрөгийг электрон хэлбэрт шилжүүлэх ажлыг эрчимжүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлын талаар

Баянтал, Шивээговь сумын соёлын төвийн номын сангийн үйлчилгээнд Monbiblio программ хангамжийг нэвтрүүлэн фондын сан хөмрөгийг электрон хэлбэрт шилжүүлэх ажлыг эрчимжүүлэн тайланг Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яамны сайтанд байршуулсан. Өдөр тутмын үйлчилгээгээ программаас компьютерлуу хуулж back up файлаар хадгалах арга зүйн зөвөлгөө өгсөн. Компьютер, техник хэрэгсэлээ янзлах арга зүйн зөвлөгөө өгсөн.Баянтал сумын соёлын төвийн номын сангийн үйл ажиллагаа “Ном Эрдэм 2 сарын аяны удирдамжийн дагуу хийсэн ажилтай танилцан арга зүйн зөвөлгөө өгч ажилласан.

Орон нутгийн холбогдолтой мэдээллийн санг бүрдүүлж, ном зүй хийх ажлын талаар:

Уншигчдад аман болон бичгээр 145 хүнд лавлагаа өгсөн. “Номын сан, мэдээллийн байгууллагад мөрдөх стандартын эмхэтгэл” ном гарч ном зүйн бичилтийн стандарт шинэчлэн гарсанаар Үсэг дараалал, төрөл ангийн каталогийг шинэ стандартын дагуу засаж янзлан 3400 ширхэг каталоги хэвлэн гаргасан. Орон нутгийн зохиолч, уран бүтээлчдийн материалыг цуглуулж 109 ширхэг шүлэг яруу найргийг ном зүйн бичилтээр шивж бэлтгэсэн.

Шинэ номын тойм танилцуулга хийж, ном хэвлэлийг сурталчилах:

- ✓ Шинэ номын мэдээ танилцуулга 189 төрлийн 485 ширхэг номоор

хийж уншлагын танхимд байрлуулсан.

- ✓ "Ном унших ашиг тус", "Хүүхдээ яаж ном уншиж сургах вэ?"
- ✓ "Номыг зөв унших арга, ач холбогдол" сэдвээр боршур бэлтгэн 200 ширхэгийг тараасан.

Номын үзэсгэлэн зохион байгуулах

Номын үзэсгэлэнг 22 удаа нийт 966 номоор гаргаж 726 уншигч хамрагдсан.

- ✓ Шинэ номын үзэсгэлэнг 6 удаа 485 ширхэг номоор 315 уншигчид хамрагдсан.
- ✓ 16 сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж 581 ширхэг номоор 411 уншигчид хамрагдсан.

Ховор ном судрын үзэсгэлэн зохион байгуулах

Аймгийн музейтэй хамтран 7,9 сард ховор судрын үзэсгэлэнг 2 удаа зохион байгуулж 412 иргэд хамрагдсан.

Үзэсгэлэнд тавигдсан ховор судар:

- ✓ Догсом судар 138 хуудастай, 41x10,3 см хэмжээтэй
- ✓ Ерөөл судар 106 хуудастай 115x6 см хэмжээтэй

Банзрагч судар 162 хуудастай 42x11 см хэмжээтэй

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд болон тусгай байгууламжинд байгаа иргэдэд номын сангийн үйлчилгээг хүргэх ажлын талаар:

1. Хөгжлийн бэрхшээлтэй 320 уншигчдад 2877 ширхэг номоор үйлчилсэн.
2. Тусгай байгууламжинд байгаа иргэдэд :

Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх газар 1-р сард 51 номоор үйлчилсэн./ШШГГ өөрийн байгууллага дээрээ номын сантай болсон тул гэрээгээ цуцалсан/

3-р дугаар сард Аймгийн нэгдсэн эмнэлэгийн халдвартын тасагтай гэрээ байгуулан 50 номоор үйлчилсэн.

2,5 дугаар сургуулиудтай хамтран ажиллах гэрээгээр 358 уншигчдад 880 номоор үйлчилсэн.

Нийт 678 уншигчдад 3850 номоор үйлчилсэн.

Соёл олон түмний ажил /Хүүхэд залуус олон нийтэд ном унших соёлыг сурталчлах, урамшуулах/ **ажлыг зохион байгуулах ажлын талаар:**

1. Монгол ёс заншил сэдэвт уралдааныг 2015.02.16-ны өдөр 1,2,5 дугаар сургуулийн ахлах, дунд, бага насны хүүхдүүд оролцож. 3 насны ангиллаар зохион байгуулж 45 хүүхэд хамрагдсан.
2. "Ном-эрдэм" аяныг 2015.03.01-нээс 05.01 хүртэл 2 сарын хугацаанд зохион байгуулж 753 хүнд шинээр карт нээж 8271 уншигчдад 14000 ном олгож үйлчилсэн.

- ✓ "Тэргүүний уншигч " Д.Нацагдорж тэмдэгтэн
- ✓ "Тэргүүний уншигч" анги хамт олон

3. "Ном-эрдэм" 2 сарын аяны хүрээнд оюунлаг байгуулага, гэр бүл, шилдэг номын сан зэрэг номинацийг шалгаруулсан.

- ➢ "Оюунлаг байгууллага"номинаци
- ➢ "Оюунлаг гэр бүл" номинаци
- ➢ "Шилдэг гэрийн номын сан" номинаци

4. "Уран жиргээ-2015" уран уншлага 6 номинацаар шалгаруулж хаалтын ажиллагааг Дуу бүжгийн боржигон чуулгад зохион явуулсан.
5. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад 7 хоног бүр анги хамт олноороо ном унших хуваарь гарган үйл ажиллагаа явуулж байна.
6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүд, зорилтот бүлгийн хүүхдүүдийн дунд 2 үе шаттай **"Тэргүүний уншигч-2015"** уралдаан зарласаны 1-р үе шатыг шалгаруулж шагнал гардуулах үйл ажиллагааг зохион байгуулсан.
7. **"Тэргүүний уншигч-2015"** уралдаан 2-р үе шат 12-р сарын 16-ны өдөр Боржигон чуулгад замжилттай зохион байгууллагдлаа.
8. Боржигон наадмын үеэр "Боржигон овогтон" номын нээлтийн баярийн арга хэмжээг зохион байгуулсан.
9. **Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 08 дугаар сарын 24ны өдрийн 158 дугаар зарлигийн Номын баярын** арга хэмжээг 2015оны 09 дүгээр сарын 25ны өдөр Боловсрол соёлын газар, Шуудан холбооны газар, "Жанжин чойрын данжин сахиус" ТББ, Сум болон сургуулийн номын сангуудтай хамтран зохион байгуулсан.
10. **Зохиолч уншигчдын уулзалтаар:** Б.Энхтөр "Хүслийн уулын гэгээнд", Д.Батжаргал "Гоо ашлан" шинэ номын нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, зохиолч уран бүтээлчид оролцсон үйл ажиллагаа болсон.

11. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад 7 хоног бүр анги хамт олноороо ном унших хуваарь гарган үйл ажиллагаа явуулж байна.
12. **Зохиолч уншигчдын уулзалтаар:** Б.Энхтөр "Хүслийн уулын гэгээнд", Д.Батжаргал "Гоо ашлан" шинэ номын нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, зохиолч уран бүтээлчид оролцсон үйл ажиллагаа
13. 2015.11.09- нд 1-р сургуулийн багш Л.Лоохууз багшаар монгол бичиг, хэл соёлын талаар ахлах, дунд ангийн 21 хүүхдэд лекц зохион байгууллаа.

Олон улсын болон төрийн бус байгууллагуудтай хамтран ном, соёлын арга хэмжээ зохион байгуулж хамтран ажиллаа.

Үүнд: Дэлхийн Зөн ОУБ, Улаанзагалмайн хороо, Чойр өртөө, Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэс, Хаан, Хас, Төрийн банк, Мобиком, Жанжин Чойрын Данжин Сахиус ТББ, Гэзэгт-ЗБН, "Андууд" Худалдааны Төв, "Түм Буман Ундарга" ХХК байгууллагууд уралдаанд оролцож байр эзэлсэн иргэд, хүүхдүүдийн шагналын санг ивээн тэтгэн хамтран ажиллаа.

Аймгийн Засаг Даргын Тамгын газар, Боловсрол, соёлын газарт гаргах мэдээ тайлан, хариутай бичгийн хариуг цаг хугацаанд нь ирүүлэх ажлын талаар:

- Сар , улирал бүр гаргаж өгдөг тайлан мэдээ

Графикийн дагуу тогтсон хугацаанд гарган, аймгийн
ЗДТГ, алба, хэлтэст хүргүүлж байна.
Тайлан , мэдээ тасалдуулсан ямар нэгэн зөрчил гаргаагүй ажиллаж байгаа болно.

- Ирсэн бичиг-75
- Хариутай ирсэн бичиг-35
- Явуулсан бичиг-114

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах.

Засгийн газрын 143-р тогтоолыг ханган ажиллаж байгууллагын үйл ажиллагааны тайлан, мэдээг сар бүр байгууллагын мэдээллийн самбарт, " ил тодын самбарт" байгууллагын веб сайтад бичиж, байршуулж хэвшүүлсэн

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах

Сар бүрийн 08-ны дотор шилэн дансны хуулийн дагуу холбогдох төсөв, тайлан мэдээг хугацаанд нь шилэн дансанд байршуулан ажиллаж байна.

Холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах

1. Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлж, иргэд уншигчдад ном хэвлэлүүдийг сурталчилах, номтой нөхөрлүүлэх, хэрэгцээт номын талаарх төрөл бүрийн мэдээллийг өгөх зэрэг арга хэмжээг 2015.09.25-ны өдөр "**Номын баярын өдөр**"-ийг хамтран зохион байгууллаа.
2. Номын сангийн хамт олон нийтдээ 23 ширхэг халиас модыг байгууллагынхаа урд талын сааданд тарьж ургуулж, байгуулагынхаа уншлагын заал болон ажилчдын өрөө тасалгааг цэцэгжүүлэн ажиллаж байна.
3. Ажилтнуудын чөлөөт цагаар спортоор хичээллэх боломжоор 1 дүгээр сургуулийн биеийн тамирын заал, фитнесийн өрөөг ашиглах гэрээ байгуулан /сар бүрийн 1,4 дэх долоо хоногийн 5 дахь гаригийн оройн 17.00-19.00 цаг хүртэл / ашиглах боломж нөхцөлийг бүрдүүлсэн.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төрөөс соёлын талаар баримтлах бодлого шийдвэрийг Аймаг, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, БСШУ-ны сайдтай Аймгийн Засаг даргын 2015 онд байгуулсан гэрээ, Аймгийн Засаг дарга, Төв номын сангийн захиралтай 2015 оны эхэнд байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг бүрэн биелүүлэх, номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, уншигчид бие даан боловсрол эзэмших, номын санг иргэд, оюутан сурагчдын мэдээллийн төв болгон хөгжүүлэхэд ном тойрсон соёл олон түмний олон арван ажил, арга хэмжээг зохион байгуулж тэдгээрт оюутан сурагчид, иргэд, уншигчдын оролцоог нэмэгдүүлэхийн төлөө бүхий л ажлаа чиглүүлэн ажиллалаа.

Нэг. Удирдлагын менежментийн талаар.

Аймгийн Төв номын сан нь Номын сангийн тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжууд, БСШУЯам, орон нутгийн засаг захиргаа, нутгийн удирдлагын байгууллагуудаас дэвшүүлсэн зорилт, шийдвэрүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.

2015 онд Аймгийн төв номын сан нь 15 ажиллагсадтай, харъяа 1 салбар, нийт 2 салбар номын сантайгаар, орон нутгийн уншигч иргэдэд үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Номын сан нь 2015 оны төсөв 160,140.7 мян. төгрөг батлагдсанаас

- Цалин хөлсөнд 110.743.3
- НДШ болон бусад тэтгэвэр тэтгэмжид 12.181.9
- Ном хэвлэл худалдан авах зардалд 3.910,0
- Бараа үйлчилгээний бусад зардалд 9.734.8
- өөрийн үйл ажиллагааны орлого 3.048.90 төгрөг

батлагдаж зарцуулагдав.

Байгууллагын үйл ажиллагааны орлогод 3.280.0 мян.төгрөг оруулсан нь 2015 оны орлогын төлөвлөгөөг 107,6 %-иар биелүүлсэн байна.

Төв номын сан нь **“2011-2016 онд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр”**-өө боловсруулж, номын сангийн хэтийн зорилго, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүнгээ тодорхойлсон билээ. Номын сангийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд удирдлагын менежментийн үйл ажиллагааг:

- Номын сангийн материаллаг баазыг бэхжүүлэх
- Номын санд мэдээллийн технологи нэвтрүүлэх
- Олон нийттэй харилцах харилцааг өргөжүүлэх
- Уншлага- үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх
- Хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх зэрэг тэргүүлэх гэсэн гол 5 асуудалд он дараалан гол асуудлуудаа хандуулж ирлээ.

Төв номын сан нь өөрийн үйл ажиллагаагаа улам боловсронгуй болгох, хөдөлмөрийн сахилга батыг чанд сахиж ажиллах, үйлчилгээний соёлыг улам өндөр түвшинд гаргах зорилгоор “Номын сангийн дүрэм”, “Номын сангийн үйлчилгээний дотоод журам”, “Цахим хуудас хөтлөх журам”, “Фонд бүрдүүлэх журам”, “Ёс зүйн дүрэм”, “Номын сангийн ажилтнуудын хөдөлмөрийн дотоод журам”, “Ажлын байрны тодорхойлолт” зэргийг шинэчлэн боловсруулж, хамт олноороо хэлэлцэн номын сангийн захирлын тушаалаар батлан мөрдөн ажиллаж, захирал ажилтан, ажилтнуудтай 2015 оны “Хөдөлмөрийн гэрээ” байгууллаа.

Номын сангийн байрны зураг төсөв, тоног төхөөрөмжийн шинэчлэлт, номын сангийн архивын болон салбар номын сангийн засвар үйлчилгээ, соёл олон түмний ажил, ном хэвлэл авах зардал зэргийг төсвийн тодотголд оруулах буюу 2016 оны төсөвт суулгуулахаар Аймгийн ИТХ, ЗДТГ, БСГ, БСШУЯам, УИХ-ын

гишүүн Д.Хаянхярваа, С.Ганбаатар нар болон Аймгийн удирдлагуудад хандсан ба БСШУ-ны сайдаар ахлуулсан баг бүрэлдэхүүн Сэлэнгэ аймагт ажиллахад төв номын сангийн захирал Д.Цэрэндаваа сайд Л.Гантөмөртэй биеэр уулзан дээрх асуудлаар хандаж холбогдох баримт бичгүүдийг гардуулж өглөө.

Аймгийн ИТХ, Иргэний танхим, Төв номын сан хамтран "Номын сангийн өнөөгийн байдал, хөгжлийн хэтийн төлөв" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлгийг Иргэний танхимын дарга Л.Гүнчин нээж, ЗДТГ-ын дарга Ч.Чүлтэмбат, СТСХ-ийн дарга Жаргалсайхан, Аймгийн ИТХ-ын төлөөлөгч Ч.Баярцэцэг, Г.Алтантуяа нар оролцож, санал бодлоо солилцлоо. Хэлэлцүүлэгт их дээд сургууль, ЕБС, сумдын номын санчид, Аймаг сумын ИХ-ын төлөөлөгчид, уншигчид зэрэг **60 гаруй** хүн оролцож, номын сангийн өнөөгийн байдал, хэтийн хөгжил, үйл ажиллагааны талаар санал бодлоо солилцож дараах дүгнэлтийг гаргалаа. Үүнд:

- ✓ 2016 оны төсөвт номын сангийн зураг төсвийн мөнгийг суулгах арга хэмжээ авах
- ✓ ЕБС-ийн сурагчдын дунд өглөөний уншлага зохион байгуулах ажлыг туршлага болгож хэрэгжүүлэх
- ✓ Соёл олон нийтийн ажил болон нүүдлийн номын сан ажиллуулахад ном хэвлэл, шатахууны туслалцаа үзүүлэх хөрөнгийн асуудлыг орон нутгийн төсөвт суулгаж болох эсэх талаар судлах

БСШУ-ны дэд сайд Б.Тулга болон соёлын өвийн мэргэжилтэн Цэндсүрэн нартай "Залуучууд" театрын дугуй зааланд хийсэн соёлын ажилтнуудтай хийсэн уулзалтанд ажилтан, ажилчид бүгд оролцож, захирал Д.Цэрэндаваа номын сангийн өмнө тулгамдаж байгаа гол асуудал болох орчин үеийн хэрэгцээ шаардлага хангасан номын сангийн байр бариулах, техник технологийн шинэчлэл хийх, ажилтан, ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ном хэвлэл авах, соёл олон нийтийн ажил явуулах, нүүдлийн номын сан ажилууллахад төсөв хөрөнгө шаардлагатай байгаа талаар танилцуулж холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн албан тоотоор сайдад гардуулан өглөө.

Аймгийн Төв номын сангийн 2015-2021 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний гол зорилтуудаа бүлэглэн боловсруулж, мөрдөн ажиллаж байна.

Хамт олны санаачлагаар байгууллагын “ХҮНДЭТ ДЭВТЭР”-ийг болгож, Анхны захирал А.Сэрчин, анхны номын санч Д.Лида, МУСТА С.Лхамсүрэн нарыг хүндэт дэвтэрт бичиж алдаршуулав.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний танхимаас зохион байгуулсан “Орон нутгийн хөгжилд хүүхэд, залуусын оролцоог дэмжих нь” нээлттэй хэлэлцүүлэг дээр номын сангийн талаар гарсан санал шүүмжлэлийн дагуу 1000 хүнээс санал асуулга авч боловсруулан, ажилдаа дүгнэлт хийн ажиллаж байна.

Аймгийн төв номын сан нь орон нутаг болон эх орондоо чанартай, тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаагаа үнэлүүлэн Монгол Улсын Үндэсний Бизнес Хөгжлийн Нэгдэл ТББ-ийн “Монгол чанар” цол, өргөмжлөл, захирал Д.Цэрэндаваа нь “Шилдэг захирал” тэмдэгээр шагнууллаа.

Багийн Засаг даргатай байгуулсан тохижилт хамтын ажиллагааны гэрээний дагуу Төв болон салбар номын сангийн ажиллах цагийн хуваарь, хаягжилтыг кирилл, уйгаржин монгол, англи хэлээр хийлгэлээ.

Ахмад ажилтан, тэдний нийгмийн халамжинд анхаарал тавин ажиллаж Ахмадын баяр, Монголын цагаан сараар хүндэтгэл үзүүлэхээс гадна Ахмад соёлын ажилтан Ч.Бямбаа, Дархан САА-н анхны номын санч Д.Дэжид нарыг МУСТА цол тэмдэг, Ахмад номын санч П.Бадамхандыг Монгол Улсын Төрийн Дээд шагнал “Алтан гадас”–гоор тодорхойлон, шагналыг БСШУ-ны дэд сайд Б.Тулга гардуулан өглөө. Мөн ахмад номын санч Д.Лида, П.Бадамханд нарыг “Лха” телевизээс зохион байгуулсан “Бурхантын хөндийн буурлууд” цэнгүүнд дэмжлэг үзүүлэн оролцууллаа.

Дархан-Уул аймгийн ОБГ Гамшгаас хамгаалах Улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлагын дагуу Төв, салбар номын санд галын аюулгүй байдлын багаж, элсний хайрцаг шинээр хийж, Дэвшил дэх архивын фондын багажны хайрцагийг сэргээж засварлан, бүх газруудад хөрөө, сүх, хүрз, хувин мэтийг шинээр авч байрлуулан 200.0 гаруй мянган төгрөг зарцууллаа. Мөн Дэвшил дэх архивын фондын цахилгааны монтажийг бүрэн шинэчилж 800 гаруй мянган төгрөг зарцуулаад байна.

БСГазраар дамжуулан хүсэлт гаргасны дагуу МХГазраас Төв номын сангийн ажлын байранд төлөвлөгөөт бус шалгалт хийж ажлын байрны физик хүчин зүйлүүдийг хэмжиж, хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах хяналтын хуудсаар эрсдэлийг тогтооход 95.4 хувь буюу “их” эрсдэлтэй ангилалд хамрагдлаа. Энэ

дагуу арга хэмжээ авахаар холбогдох газруудад хандаад байгаа бөгөөд 2016 оны төсөвт агааржуулалт, чийгшүүлэлтийн тоног төхөөрөмж авах, ажилтан ажиллагсадыг эрүүл мэндийн үзлэг, сургалтанд хамруулах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

Дэвшил дэх Архивын фондын эзэмшил газрыг хүсэлт гарган дахин хэмжилт хийлгэж, Газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээгээ шинэчиллээ.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид, Цагдаагийн газрын албан мэдэгдлийн дагуу 2016 оны төсөвт гадна талын камер, гэрэлтүүлэгийг шинээр тавиулах, дохиоллын системүүдийг шинэчлэх, дотор камерийг нэмэгдүүлэх, ажилтан, ажиллагсадыг сургалтанд хамруулах зэрэг асуудлыг тусгахаар төлөвлөөд байна. Мөн гэмт хэрэг зөрчилгүй хамт олон болон ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, төсвийн ил тод байдлыг хангах үүднээс “Шилэн дансны болон төсөв санхүүгийн ил тод байдал” самбарыг цаасан болон цахим хэлбэрээр тогтмол ажиллуулж номын сангийн төсвийн ил тод байдлыг сурталчилж байна.

БСШУхааны сайдын 2012 оны А/51 тоот тушаалаар батлагдсан “Ном” хөтөлбөр, Аймгийн засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 онд батлагдсан “Ном” аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Ном” төсөлд “Зөөврийн нүүдлийн сан” төслөөр оролцон 650.0 мянган төгрөгийн төсөл бичиж амжилттай хэрэгжүүлж ажиллалаа.

Аймгийн Төв номын сангийн дэргэд БСШУ-ны сайдын 2001 оны 180-р тушаал /Номын сангийн үйл ажиллагаанд олон улсын ДДС ангилал нэвтрүүлэх тухай/, 2005 оны 441-р тушаал /номын сангийн данс, маягт шинэчлэн батлах тухай/, Сангийн сайд, БСШУ-ны сайдын хамтарсан 357/406 тоот тушаал /Ном хэвлэлийг дахин үнэлэх тухай/-ыг хэрэгжүүлэх, номын сангийн цахим програм “Lib-4U”-д ном хэвлэлийн бүтээгдэхүүн, каталогийг цахим хэлбэрт оруулах “Ажлын хэсэг” томилогдон ажиллаж, англи хэлний 318 нэр төрлийн 443 боть номонд бүрэн техник ажиллагаа хийн, нэгбүрчилсэн бүртгэлд бүртгэж, цахим хэлбэрийн каталогтой болгон уншигчдад ашиглуулж байгаагаас энэ онд нийт 993 нэр төрлийн 1135 боть номыг оруулж, нийт 16918 нэр төрлийн 42633 боть номын электрон каталогоор үйлчилж, 180.797 удаа хайлт хийсэн байна. 3805 байнгын уншигчийг програмд бүртгэн үйлчилж байна.

Аймгийн төв номын сангийн **www.darlib.mn** веб сайт дээр номын сангийн үйл ажиллагаа, шинэ номын мэдээ, аймаг, орон нутгийн холбогдолтой 548 мэдээ,

мэдээллийг тавьж, давхардсан тоогоор 180797 хүн хандан мэдээлэл авсан байна.

Гадаадын их, дээд сургууль, TOEFL-ийн шалгалтын талаар мэдээлэл авах, гадаад, дотоодын их дээд сургуульд онлайнаар бүртгүүлэх, хууль эрх зүйн актууд болон бусад сонирхсон сэдвүүдээр эрэл хайлт хийж **120500** хүн интернетээр үйлчлүүлсэн байна.

Интернетийн үйлчилгээг ашиглан Дэлхийн банк, Америкийн боловсролын байгууллага, АНУ-ын ЭСЯам, УБ хотын Боловсролын зөвлөгөө мэдээллийн төв, БСШУЯам, Үндэсний номын сан, бусад аймгуудын номын сантай хамтран ажиллаж үйл ажиллагаандаа орчин цагийн шинэ шинэ техник технологийн нөхцөл боломжийг нэвтрүүлэн ажиллаж байна.

Орон нутгийн удирдлагууд, болон Увс, Говьсүмбэр, Архангай аймгийн номын санчдад өөрийн үйл ажиллагааг танилцуулах, тэдэнтэй номын сангийн цаашдын хөгжлийн талаар тулгамдаж байгаа асуудлаар санал бодлоо солилцлоо.

Хоёр. Номын сангийн уншлага үйлчилгээний талаар

2015 онд байнгын уншигч 3805, ирэгсэд 52551, ном олголт 69514 болж, номын сан нь уншлага үйлчилгээндээ ном хэвлэлээ тогтмол сурталчилж, шинэ номын мэдээллийн сангаар үйлчлэх, ном хэвлэлийн тойм, ашигтай зөвлөмж материалуудыг хувилж уншигчдын хүртээл болгох, эрэлт хэрэгцээг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

- “Номтой нөхөрлөе” аян, “Ном” хөтөлбөр”-ийн хүрээнд Төв номын сангийн үйл ажиллагаатай уншигчид, хүүхэд багачуудыг танилцуулах, тэднийг номтой ойртон нөхөрлүүлэх, үйлчилгээний хүрээг өргөтгөх зорилгоор алслагдсан Шарын гол, Орхон, Хонгор сумын иргэд, Онцгой байдлын газар-30 боть ном, ШШГЕГазрын харъяа 435, 445-р ангийн хүмүүжигчдэд “Олуулаа уншъя” нүүдлийн номын сангаар үйлчилж 585 хүнд 866 боть ном, 18 дугаар сургуулийн Соёлмаа багштай 4 дүгээр ангийн 15 сурагч, 1, 4, 10, 12, 18 дугаар цэцэрлэгийн 250 хүүхдэд 425 боть, Аймгийн шүүхийн ажилтнуудад 160 боть ном зөөврөөр уншуулж, нийт 1451 боть ном, хэвлэлийн бүтээгдэхүүн нүүдэл, зөөврөөр олгож үйлчилсэн байна.

Уншигч хэрэглэгчдийн оюуны хөрөнгө оруулалтанд тус дэм болох, бие биеийнхээ оюуны хөрөнгө оруулалтанд харилцан туслахад зориулж номын сангийн гадна **“Та авч болно, өгч болно”** номын чөлөөт сонголтын тавиур ажиллуулж, энэ тавиурт уншигч өөрийн уншиж хэрэглэсэн ном хэвлэлээ авчирч

тавих, бусдын авчирч тавьсан ном хэвлэлээс өөрт хэрэгтэй ном хэвлэлийг чөлөөтэй авч уншиж болох тухай заавры ил тодоор байрлуулан тогтмолжуулан ажиллаж 10 удаа 380 гаруй ном хэвлэл, тараах материалаар баяжуулан ажиллууллаа.

Аймгийн Төв номын сангаар үйлчлүүлж байгаа уншигчдын 40 гаруй хувь нь ЕБС-ийн сурагчид, 60-аад хувь нь их, дээд сургуулийн оюутнууд, насанд хүрэгсэд, өндөр настнууд байна. Нийт ном олголтын 60-80 хувийг нийгэм, улс төр, эдийн засаг, хууль эрх зүй, гадаад хэл, уран зохиолын номнууд, 20-иод хувийг тогтмол хэвлэл эзэлж байна.

Гурав. Номын сангийн фонд, номзүйн лавлагаа мэдээлэл, каталог зохион байгуулалтын ажлын талаар

Төв номын сангийн фондын зохион байгуулалт, бүрдүүлэлт, номзүйн мэдээлэл, каталог картын санг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, уншигчдын хэрэгцээ шаардлагыг хангахуйц шинэ ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр фондоо баяжуулж байна.

- Аймгийн Төв номын сан нь БСШУ-ны сайдын 2001 оны 180, 2005 оны 441-р тушаал, “Аймгийн төв номын сангийн хөгжлийн хөтөлбөр” /2011-2016/ -ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт 16918 нэр төрлийн 42633 боть ном хэвлэлийн бүтээгдэхүүн номын сангийн анхан шатны шинэчилсэн бүртгэлд бүртгэгдэж, олон улсын DDC ангиллаар ангилалагдсан байна. Үүнээс 2015 онд 724 нэр төрлийн 1093 боть ном, номын сангийн Lib-4U програмд буюу цахим каталогт оруулав.

Мөн номын сангийн электрон каталогт 180.797 удаа хайлт хийгджээ. Номын санд нийтдээ 3620 цаасан каталог шинээр бичигдэж, уншигчдын хэрэгцээнд ашиглагдаж байна.

- Төв номын сан нь 2015 онд 3 910,0 мян.төгрөгний 675 боть ном хэвлэлийн бүтээгдэхүүн авч фондоо баяжуулан уншигч олны хүртээл болгосноос хувиарлагдсан төсвөөр 3.910,0 сая төгрөгийн 441 боть, бэлэг, хандиваар 240.0 мян төгрөгийн 305 боть ном хэвлэл авлаа. Шинээр авсан номын “Шинэ номын агуулгын тайлбартай бүртгэл”-ийг 5 удаа гаргаж уншигч хэрэглэгчдэд ашиглуулж байна.

Төв номын сан нь 2015 онд шинээр ирсэн 372 боть номыг зураг, агуулгын тайлбартай бүртгэлийг гарган, мөн товч агуулгатай нь номын сангийн веб сайт,**www.fasebook.com nomiin san darkhan** хаягт байршуулан уншигчдын

хэрэгцээ шаардлагыг хангaн ажилласнаар 556 гишүүнтэй болж, 114362 хүн хандалт хийсэн байна.

2015 онд "Залуу хүний заавал унших ном"-ын нэг "Монголын нууц товчоо", "Цагаан сар", "Иргэний нийгмийн өдөрт", "Хувьсгалчдын өдөрт", "Эмэгтэйчүүдийн баярт", "Ардын армийн 94 жилд", "Монголын түүхээр юу унших вэ?", "Дэлхийн усны өдөрт", "Наурызын баярын өдөрт", "Инээдмийн баярын өдөрт", "Эрүүл мэндийг хамгаалах өдөрт", "Эх үрсийн баярын өдөрт", "Морин хуур", "Уртын дуу", нийт 15 удаа 1118 номоор санамж өгөх ном зүйн бүртгэл, жагсаалт гаргаж, "Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн, Монголын соёл яруу найргийн академийн тэргүүн, яруу найрагч Г.Мэнд-Ооёогийн уран бүтээлийн номзүй", "Хэл шинжлэлийн ухааны доктор, дэд профессор МЗЭ-ийн болон Д.Нацагдоржийн шагналт зохиолч, яруу найрагч Б.Магсаржавын уран бүтээлийн ном зүй" зэргийг боловсруулан хэвлэж уншигчдийн мэдлэг мэдээлэл, эрэл хайгуулд ашиглуулж байна.

Шинэ номын 800 үсэг дараалал, төрөл ангийн каталог, сонин сэтгүүлийн картын санг 960 карт, орон нутгийн картын санг 480 картаар баяжуулан байрлуулж уншигчдын хэрэгцээнд гаргалаа. Мөн картын сангийн баруун зүүн 80 ялгагч хийж байрлууллаа .

2015 онд 810 уншигчдад амаар болон утсаар лавлагаа өгч 44 татгалзал (тус номын санд байхгүй байгаа иргэдийн асуусан ном) бүртгэгдэж татгалзлыг барагдуулахаар бүртгэлд бүртгэн авч ажиллаж байна.

Урагдаж гэмтсэн 78 номыг сэлбэн засварлаж, тогтмол хэвлэлийг сар улирлаар нь боть болгон үдэж хавтаслан уншигчдын хүртээл болгон, өдөр тутмын хэрэгцээ шаардлагыг хангаж ажиллаж байна.

Дөрөв. Төв номын сангаас зохион байгуулсан Соёл олон нийтийн ажлын талаар

Аймгийн төв номын сан нь 2015 онд Монгол Улсын засгийн Газрын хөтөлбөр, Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2013-2016/, БСШУ-ны сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээ, Аймгийн Засаг дарга, Төв номын сангийн захиралтай байгуулсан үр дүнгийн гэрээ болон БСШУхааны сайдын 2012 оны А/51 тоот тушаалын 1-р хавсралт "Ном" хөтөлбөр, Аймгийн 2012 онд баталсан "Ном" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд уншигч, хүүхэд залуусыг номтой нөхөрлүүлэх, тэдний чөлөөт цагийг үр

бүтээлтэй өнгөрүүлэх, танин мэдэхүй, бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэхэд зориулсан соёл олон нийтийн ажлуудыг өргөнөөр зохион байгуулж:

- Соёл урлаг, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай бусдыгаа үлгэрлэн ажиллалаа.

“СОЁЛ УРЛАГ, БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ ТҮНШЛЭЛ–2015” анхдугаар зөвлөгөөнийг 11-р сарын 20, 21-ний өдрүүдэд “Залуучууд” театрт зохион байгууллаа. Уг арга хэмжээнд соёлын байгууллагуудын төлөөлөлөөс гадна хэвлэл мэдээллийн байгууллагууд, “Хаяг реклам үйлдвэрлэгчдийн холбоо”, “Дархчуудын холбоо”зэрэг ТББ-ууд болон Яруу найрагчид, Хөгжмийн зохиолчид оролцож өөрсдийн уран бүтээлийн үзэсгэлэнг гарган иргэдэд хөнгөлөлттэй үйлчилгээг үзүүллээ. Мөн үйл ажиллагааны “Нэгдсэн зөвлөгөөн”-д аймгийн ИТХ-ын дарга П.Эрдэнэбат, БСГ-ын дарга Б.Ганчулуун, “Залуучууд театр”-ын дарга Б.Болорсүх, Төв номын сангийн захирал Д.Цэрэндаваа, аймгийн Музейн дарга Д.Жамбалдорж, Монгол Улсын Соёлын Гавъяат зүтгэлтэн, сэтгүүлч Ө.Рагчаасүрэн нарын албаны төлөөлөлүүд оролцов. Энэ үеэр Монголын сэтгүүлчдийн холбооны дээд өргөмжлөл “Ган үзэгтэн” цол тэмдгээр “Хос Дог уран бүтээлийн нэгдэл”-ийн менежер, сэтгүүлч н.Цэндсүрэн, Засаг даргын “Жуух бичиг”- ээр “Мөнхийн үсэг” ХХК-ийн эх бэлтгэгч Т.Банзрагч нарын нийт 10 уран бүтээлч төр засгийн хүндтэй цол тэмдгээр энгэрээ мялааж, хөдөлмөрөө үнэлүүллээ. Түүнчлэн оролцогч байгууллагуудаас шагналыг ивээн тэтгэж 5 азтан шалгаруулсан нь ирсэн зочдын анхаарлыг ихэд татав. Тухайлбал: ИТХ-ын дарга П.Эрдэнэбатын сугалсан сугалаагаар сэтгүүлч Х.Соёл-Эрдэнийн сугалааны тасалбар таарч “Хос дог уран бүтээлийн нэгдэл”-ийн шагнал болох “Дархан хотын 8 бахархал” зургийг гардан авлаа. Сэтгүүлч Х.Соёл-Эрдэнэ ярихдаа “Анх Дархан хотын 8 бахархалыг аймгийн Иргэдийн хурлаар баталсаны дараагаар "Хос Дог уран бүтээлийн нэгдэл”-ийн захирал н.Анхбаяраас эвлүүлэн, бүтээл болгож өгөхийг хүсэж байсан бөгөөд азтан болж тэрхүү зургийг авсандаа туйлын баяртай байгаагаа илэрхийллээ. Үүнээс гадна сугалаагаар “Залуучууд” театрын үзвэр үйлчилгээг бүтэн жил үнэгүй үзэх эрхийн бичиг Төв номын сангийн арга зүйч Г.Нямцэндэд таарсан ба тэрээр хуран цугларсан олны хамгийн өндөр настан болох н.Ханд гуайд бэлэглэсэн нь сугалаа тойрсон бас нэг сонирхол татам явдал боллоо. Өндөр настан н.Ханд гуай Говийн зэрэглээ киноны холбоочин бүсгүйн дүрээр монгол түмнээ дурсагддаг жүжигчин Я.Оюунцэцэгийн ээж билээ.

- Мөн “СОЁЛ УРЛАГ, БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ ТҮНШЛЭЛ – 2015” нэгдсэн арга

хэмжээгээр соёлын байгууллагуудад тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэхээс гадна ирэх жилээс оны онцлогуудаа тодотгодог, шилдэгээ шалгаруулдаг хүндэтгэлийн арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулах, соёл урлагийн байгууллагуудын бодлогыг тодорхойлон, үйл ажиллагаануудыг төлөвлөн хэрэгжүүлдэг болон гадаад дотоод хамтын ажиллагаануудыг өргөжүүлэх зорилго бүхий мэргэжлийн бүтэцтэй "Соёл урлагийн байгууллагуудын академи"-г байгуулахаар болсон байна. Ийнхүү нэгдсэн зөвлөгөөнөөр уран бүтээлчдээс ирсэн олон санал, хүсэлтүүдийг тусгасан "САНАМЖ БИЧИГ"-ийг аймгийн ЗДТГ-т хүргүүлэхээр болсон байна.

➢ "Морин хуур, уртын дуу" үндэсний хөтөлбөрийн хүрээнд "Монгол түмний үндэсний бахархал" сэдэвт уулзалтыг Тэргүүний уран сайханч МУСТА Р.Содовдорж, Ерөөлч магтаалч МУСТА Ц.Дүйнхэрсүрэн нартай хийж 200 гаруй оюутан сурагч, уншигчид хамрагдлаа.

Энэ ажлын хүрээнд "Морин хуурын түүх", "Уртын дууны гарал үүсэл" сэдвээр яриа хийж, дуучин Р.Содовдорж, морин хуурч Ц.Дүйнхэрсүрэн, "Морин хуур төв"-ийн сурагчид өөрсдийн уран бүтээлээсээ тоглож сонирхууллаа. Мөн "Морин хуур төв"-ийн танилцуулга, уран бүтээлчдийн амьдрал, уран бүтээлийн тухай фото үзэсгэлэн, морин хуур, уртын дууны тухай номын үзэсгэлэн зэргийг 2 өдрийн турш гаргаж, 560 гаруй уншигч үзэж сонирхлоо.

➢ Аймгийн ЗДТГазар, Иргэний нийгмийн нэгдсэн зөвлөлтэй хамтран "Төр, ТББ-ын хамтын ажиллагаа" сэдэвт уулзалт хэлэлцүүлэг хийж 40 гаруй ТББ-уудын төлөөлөл оролцож, иргэний нийгмийн болон ТББ-ын тухай номын үзэсгэлэн гаргав.

➢ Дархан-Уул аймгийн Мэргэжлийн Хяналтын Албаны нэг сарын аяны нээлт 2015.09.02-ны өдөр Дархан 50 цогцолборт "Залуу хүний заавал унших ном" сэдэвт 46 боть номоор үзэсгэлэн гаргаж оролцлоо. Нийт 350 гаруй хүн оролцлоо.

➢ Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн санаачлагаар ивээн тэтгэж хэвлүүлсэн "Монголын эх түүх" 6 боть номын хэлэлцүүлгийг "Залуучууд" театрын дугуй зааланд аймгийн бүх сургуулиудын түүх, нийгмийн ухааны багш нар, оюутан сурагчдын дунд зохион байгуулж 200 гаруй хүн хамрагдлаа. Мөн ШШГүйцэтгэх 445 дугаар ангийн ажилтнуудын хүсэлтээр зохион байгуулж 80 гаруй хүн хамрагдлаа.

➢ Эх орончдын өдрийг тохиолдуулан ШШГүйцэтгэх 435 дугаар ангийн хүмүүжигчдийн дунд "Эх орон" сэдвээр яруу найргийн уралдаан зохион байгуулж 15 бүтээл ирснээс Л.Оюун-Эрдэнэ "Халхын голоор аялахуй" шүлгээр 1 дүгээр

байр, Д.Бямбадорж “Наминчлалыг хүснэм-Эх орон минь”, М.Мөнхжаргал “Холбоос” шүлгээр 2 дугаар байр, Н.Идэрбат “Омогшил” шүлгээр 3 дугаар байр, Б.Хуянсамбуу “Цэрэг байх сайхан” шүлгээр тусгай байранд тус тус шалгарлаа.

➢ “Дэлхийн номын өдөр”-ийг уламжлал болгон 4 дэх жилээ тэмдэглэн өнгөрүүлж МУСГЗ, Монголын соёл, яруу найргийн академийн тэргүүн, яруу найрагч Г.Мэнд-Ооёо, Хэлшинжлэлийн ухааны доктор, дэд профессор МЗЭ-ийн болон Д.Нацагдоржийн шагналт, яруу найрагч Б.Магсаржав нарыг урьж ирүүлэн Дарханыхаа уншигч, оюутан сурагчидтай ХААИС, 9 дүгээр сургууль, “Залуучууд” театрын дугуй зааланд 3 удаа уулзалт зохион байгуулж, зохиолчдын гарын үсэгтэй номын худалдаа болж **1400** гаруй хүн хамрагдлаа.

Энэ ажлын хүрээнд зохиолч Г.Мэнд-Ооёогийн “Шилийн Богд” роман бичигдсэн түүх, түүнд тусгагдсан газар нутаг,үйл явдлын талаар зохиогч ярьж, “Дарханы зохиолчдын бүтээлд өгсөн үнэлгээ” сэдвээр зохиолч Г.Магсаржав мэдээлэл хийж, уншигчид сонирхолтой асуулт тавьж хариулт аван, мөн МУСГЗ, Монголын соёл, яруу найргийн академийн тэргүүн, яруу найрагч Г.Мэнд-Ооёо, Хэлшинжлэлийн ухааны доктор, дэд профессор МЗЭ-ийн болон Д.Нацагдоржийн шагналт, яруу найрагч Б.Магсаржав, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, МЗЭ-ийн Дархан дахь салбар “Хязгааргүй орчлон төв”,”Номын ундраа” номын дэлгүүр зэрэг 5 газрын нэрэмжит “Азтан” шалгаруулж 25 уншигч азтан болж зохиогчийн гарын үсэгтэй болон танин мэдэхүйн номны эзэн боллоо.

Мөн энэ үеэр 2 зохиолчдын намтар, бүтээлийн танилцуулга, уран бүтээлчдийн амьдрал, уран бүтээлийн тухай фото үзэсгэлэн, номын үзэсгэлэн, “Бүтээлийн ном зүйн бүртгэл” зэргийг гарган сурталчилж, “Та авч болно, өгч болно” номын чөлөөт сонголт, “Оюуны чихэр” зэргийг ажиллуулан, Г.Мэнд-Ооёогийн “Монголын яруу найргийн 9 гайхамшиг”-ийг хувилан олшруулж бяцхан ном болгон оролцогчдод тараалаа.

➢ “Залуу хүний заавал унших ном”-ын нэг “Монголын нууц товчоо” номын хэлэлцүүлгийг ХУИС-ийн оюутан сурагчдын дунд зохион байгуулж 170 гаруй багш, оюутан, сурагчид хамрагдлаа.Энэ үеэр “Монголын нууц товчоо” номын үзэсгэлэн, ХУИС-ийн оюутнуудын “Монголын нууц товчоо” зохиолыг уншиж судлаад хийсэн бүтээлийн үзэсгэлэн зэргийг гаргаж 600 гаруй оюутан сурагчид үзэж сонирхлоо.

➢ “Залуу хүний заавал унших ном”-ын нэг “Өөртөө туслах ухаан” номоор

АУИС-ийн оюутнуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, 70 гаруй оюутан, багш нар хамрагдаж санал бодлоо солилцлоо. Мөн энэ үеэр залуу хүний заавал

унших номын үзэсгэлэн, номын сангийн үйл ажиллагааны талаар зурган самбарыг гаргаж энд оролцсон 70 гаруй хүн үзэж сонирхлоо.

- Аймгийн Төв номын сан нь "Ном бидний дотны нөхөр" сэдэвт өдөрлөгийг Хүмүүнлэгийн ухааны Их сургууль дээр зохион байгуулж, 300 гаруй оюутан, сурагч, багш нар оролцож, өөрсдийн уншсан номынхоо ач холбогдлыг бусад оюутан сурагчиддаа хуваалцлаа.

Өдөрлөгийн үеэр "Залуу хүний заавал унших ном", Ном хөтөлбөрийн хүрээнд авсан шинэ номын үзэсгэлэн гаргаж, Төв номын сангийн захирал Д.Цэрэндаваа "Ном уншихын ач тус", ХУИС-ийн захирал Сувд "Номтой нөхөрлөж, номонд үнэн сэтгэлээсээ дурлахын ач холбогдол", номын сангийн аргазүйч Г.Нямцэнд "Электрон каталогоос ном хайх арга" сэдвүүдээр лекц яриа хийж, салбарын эрхлэгч, номын санч Ц.Долгорсүрэн оюутан сурагчдад 50 хувийн хөнгөлттэй үнээр уншигчийн карт нээж, англи номын хямдралтай худалдааг зохион байгууллаа.

- "Ном" хөтөлбөр, Дэлхийн номын өдөр"-ийн тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд ОИЦ сургуультай хамтран "Уншлагын аян"-ыг зохион байгуулж 6-12 дугаар ангийн 1000 гаруй хүүхэд хамрагдаж 6000 гаруй ном уншлаа. Мөн Мон-Турк сургуулийн баг, сурагчидтай хамтран өглөөний уншлага зохион байгуулж, 345 номоор үзэсгэлэн гаргаж, "Та авч болно, өгч болно" номын чөлөөт сонголтын буланг ажиллуулж, онч мэргэн үгсээр хийсэн "Оюуны чихэр"-ийг цаашид баяжуулан ажиллуулаарай гэж тус сургуульд бэлэглэлээ.
- 12 жилийн 4 дүгээр дунд сургуулийн Байгалийн ухааны заах аргын нэгдэлтэй хамтран "Хамтдаа уншья" өдөрлөгийг зохион байгуулж 14 ангийн 306 сурагчийг хамруулан 300 гаруй ном уншуууллаа. Өдөрлөгийн үеэр "Номын сангийн үйл ажиллагаа"-г сурталчилсан самбар, "Шинэ ном", "Үндэсний бичиг соёл-бидний бахархал" номын үзэсгэлэнгүүд, "Зөвлөгөө, Зөвлөмж", "Та авч болно, өгч болно" номын чөлөөт сонголтын булан, "Номын хандивын булан", онч мэргэн үгсийн "Оюуны чихэр" зэргийг ажиллуулж, "Ном уншихын ач тус" лекц зохион байгуулж, 2 дугаар ангийн сурагчдад "Сонин содон ургамал" номоор чанга уншлага хийж, сурагчдын ойлгосон зүйлээр нь зураг зуруулллаа.
- "Ном" хөтөлбөр, Үндэсний бичиг үсгийн баярыг угтсан ажлын хүрээнд "Үлгэрийн баатрууд амилсан нь" өглөөлгийг 1,18 дугаар цэцэрлэгүүд дээр зохион байгуулж, номын санчид бяцхан хүүхэд багачуудтай хамтран дүрийн тоглолт хийж, "Бөмбөлгөөр аялсан нь" номоор чанга уншлага хийн, цэцэрлэгүүд бэлтгэсэн

хөтөлбөрөө харилцан тоглож, бие биенээсээ суралцсан амжилттай ажил боллоо. Цэцэрлэгүүд 7 дүрийн тоглолт хийж, 400 гаруй хүүхэд багачуудад үзэж сонирхууллаа.

➢ Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх Бичиг үсгийн баярыг тэмдэглэн өнгөрүүллээ. Энэ арга хэмжээний хүрээнд:

✓ 30 дугаар сургуулийн сургалтын менежер Ж. Эрхэмсайханы "Мянган жилийн буурал түүхтэй монгол бичиг соёлоо судалцгаая" бүтээлийн үзэсгэлэн,

✓ "Үндэсний бичиг үсгийн баярт" монгол бичгийн судалгааны болон уйгаржин хуучин бичгийн номын үзэсгэлэн зэргийг зохион байгуулж уншигч хэрэглэгчдэд сурталчиллаа. Эдгээр үзэсгэлэнгүүдийг одоогоор 580 гаруй хүн үзэж сонирхлоо.

✓ "Номын санчийн хишиг өдөр"-ийг зохион байгуулж Аймгийн НХХ-ийн мэргэжилтэн О.Мөнхсүрэн, 30 дугаар сургуулийн сургалтын менежер Ж.Эрхэмсайхан нар бидэнтэй хамтран нэг өдөр номын санчаар ажиллаж туршлагаа хуваалцлаа. 70 гаруй хүнд 80 гаруй ном олгож үйлчиллээ.

✓ Төв номын сангийн дэргэдэх БЗМТ-ийн нэрэмжит англи хэлний олимпиад явагдаж 70 гаруй сурагчид амжилттай оролцож, эхний байр эзэлсэн сурагчдын шагналыг мөн энэ үеэр гардууллаа.

➢ ЕБС-ийн сурагчдын дунд "Ном унших аян"-ыг өрнүүлэн дүнгээ гаргалаа. "Ном" хөтөлбөр, Дэлхийн номын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд ОИЦ, 4, 16, 18, "Монгол-Оюу", Мон-турк сургуультай хамтран "Уншлагын аян"-ыг зохион байгуулж 1500 гаруй хүүхэд хамрагдаж 2500 гаруй ном уншлаа.

➢ Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэн ажиллаж Бичиг үсгийн баярыг угтан "Ном" хөтөлбөрийн хүрээнд хуучин Дарханы сургуулиудын дунд зохион байгуулсан "Ном уншлагын аян"- ны хаалтын ажиллагаа болж Аймгийн ЗДТГ-ын дарга Чүлтэмбат, ЗДТГ-ын НХХ-ийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн О.Мөнхсүрэн, БСГ-ын дарга Б.Ганчулуун, ГБХХХ-ийн мэргэжилтэн Ж.Цэцэгмаа, "Дэлхийн зөн" ОУ-ын байгууллагын хөтөлбөрийн зохицуулагч Д.Бямбасүрэн нар оролцлоо. "Ном уншлагын аян"-д түрүүлсэн Туул багштай 4 дүгээр сургуулийн 3 ^{а}, "Монгол оюу" сургуулийн Одхүү багштай 7^{а}, 18 дугаар сургуулийн Соёлмаа багштай 3^{в} ангийнханд шагнал гардууллаа. Мөн 3 амжилттай сайн оролцсон 3 хүүхдэд ГБХХХ, 1 хүүхдэд Төв номын сангийн дэргэдэх БЗМТөвйийн шагналаар, 6 хүүхэд "Тэргүүний уншигч Д.Нацагдорж" тэмдэгээр, 5 хүүхэд Төв номын сангийн шагналаар шагнагдлаа.

➢ ТИС-ийн багш, док.проф. Н.Тэгшжаргалтай хамтран АУИС-ийн оюутнуудын

дунд “Хувийн соёл ба ахуйн соёл” сэдэвт лекцийг зохион байгуулж 88 оюутан сурагч, багш нар хамрагдлаа. Энэ үеэр док.проф. Н.Тэгшжаргалын өөрийнх нь бүтээл болон “Хувийн соёл ба ахуйн соёл” сэдвээр, нийт 38 номоор үзэсгэлэн гаргалаа.

➢ 16 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчдын Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөрийн эмч Б.Тунгалагийг урьж ирүүлэн “Охидын эрүүл ахуй” сэдвээр лекц зохион байгууллаа.Энэ үеэр “Эрүүл ахуй, гоо сайхан”-ны зөвлөгөө, зөвлөмжүүд булан, оны мэргэн үгсийн “Оюуны чихэр”-ийг ажиллууллаа.

➢ Хүүхэд багачуудын ном унших сонирхлыг төрүүлэх, тэднийг номтой нөхөрлүүлж сургах зорилгоор 1,12, 22 дугаар цэцэрлэгийн 194 хүүхдийг номын сантай танилцах экскурс зохион байгуулж Украйн ардын үлгэр “Тариан түрүүхэн”, “Сонин содон ургамал”, “Бэлэн амт хулгана”, “Эрдэм сурсан хүү”, монгол ардын үлгэр “Өвгөн бар хоёр”, “Тааварч гурван хүү”, “Ноён Баадай хоёр” номуудаар чанга уншлага хийлээ.

➢ “Цагаан сарын бэлэгдэл”, Монголын уламжлалт цагаан сар”, “Олон нийтийн газар биеэ хэрхэн авч явах вэ”, “Ном уншихын ач тус”, “Эх орончдын өдөрт”, “Дарханы лидер эмэгтэйчүүд”, “Олон улсын эмэгтэйчүүдмийн баярт”, “Монгол цэргийн баяр”, “Ус чандман эрдэнэ”, “Монгол үндэсний бахархал- Морин хуур”, “Монгол үндэсний бахархал- Уртын дуу”, “Монгол ухаан”, “Монгол улсын хамгийн хамгийн”, “Өглөө бүр уншиж байгаарай”, “ Наурыз казак үндэсний баяр”, “Монголын нууц товчоо”, “Ходоо цөсөө алимаар угаах”, “Бүтээлч хүний заавал унших 20 ном”, “Татварын үйлчилгээ таньд”, “Охидын эрүүл ахуй”, “2015 оны ЭЕШ-ын журам”, “Эмэгтэй хүн бүрийн унших ном” зөвлөмж, зөвлөгөө, эчнээ уншигчдын бага хурлыг сургууль, үйлдвэр, албан газрууд, ШШГГазрын харъяа 435,445 дугаар анги болон уншлагын заалаар 150 гаруй хүнд уншуулж сурталчилсан байна.

➢ Уншигчдын мэдлэгт туслах зорилгоор онч мэргэн үгс, суут хүмүүсийн хэлсэн афоризм үгээр **“Оюуны чихэр”-**ийг тогтмол ажиллуулан үйлчилж байна.

➢ Түүхт ой, тэмдэглэлт өдрүүд, соёл олон түмний ажлын хүрээнд:

“Үндсэн хуулийн өдөрт”

“Д.Сүхбаатарын мэндэлсний 122 жилийн ойд”

“Монголын эмэгтэй зохиолчдын бүтээл”

“ Монголын цагаан сар”

“Монгол түмний уламжлалт баяр цагаан сар”

“Наурыз нарны баяр- ардын бахдал”

“Өвөр монгол ном”

“ Эх орончдын өдөр”

“Олон улсын эмэгтэйчүүдийн өдөрт”

“Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”

“Монголын зэвсэгт хүчний 94 жил”

“Монгол түмний үндэсний бахархал Морин хуур”

“Монгол түмний үндэсний бахархал Уртын дуу”

“Монголын нууц товчоо”

“Үндэсний бичиг үсгийн баярт”

“Хүүхдийн ном”

“Дэлхийн хүүхдийн номын өдөрт”

“Бичиг үсэг үндэсний бахархал”

“Өөртөө туслах ухаан”

“Ногоон байгууламж хотын чимэг”

“Гэр бүлийн өдөрт”

“Хөдөлмөрлөх эрхийн мэдлэг”

“Төр, ТББ-ын хамтын ажиллагаа”

“Дэлхийн усны өдөрт”

“Охидын эрүүл ахуй” гэх мэт сэдвүүдээр сэдэвчилсэн номын үзэсгэлэн 31удаа 2172 боть номоор, шинэ номын үзэсгэлэн 8 удаа 334 боть номоор тус тус гарган өөрийн фондын номоо сурталчилсан байна.

Тав. Сурталчилгаа, сургалт-семинар, арга зүйн ажлын талаар

2015 онд номын сангийн ажилтнууд дараах сургалтуудад хамрагдлаа. Үүнд:

- Номын сангийн захирал Д.Цэрэндаваа БСШУЯам, Соёлын бодлого зохицуулалтын газраас зохион байгуулсан “Соёл урлагийн менежмент ба бүтээлч үйлдвэрлэл” соёл урлагийн удирдах ажилтны сургалт, семинарт 3 хоног Улаанбаатар хотод хамрагдлаа.

- Монгол улсын Ерөнхийлөгчийн 53 дугаар зарлиг, Дархан- Уул аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорил”-ын ажлыг эрчимжүүлэх сургалтанд арга зүйч Г.Нямцэнд хамрагдлаа.

- Ахлах номын санч, бичиг хэргийн ажилтан Ч.Бадамцэцэг Архивын тасгаас зохион байгуулсан архив бичиг хэргийн ажилтны сургалтанд хамрагдав.

- “Дэлхийн номын өдөр”-ийн арга хэмжээний хүрээнд МЗЭ-ийн Дархан

дахь салбар “Хязгааргүй орчлон төв”-өөс зохион байгуулсан танин мэдэхүйн “Тунгаамал” тэмцээнд их, дээд сургууль, хүүхдийн номын ордон, төв номын сангийн номын санчид, зураач, урчуудын холбоо, зохиолчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд хамтран оролцлоо.

- Улс орон даяар гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэлийн дадлага, сургалтанд ажилтан, ажиллагсад бүгд хамрагдаж, дохиоллын дуугаар бүгд зохих зааврын дагуу ажиллалаа.

- Номын сангийн ҮЭ-ийн хорооноос “Хөдөлмөрлөх эрхийн мэдлэг” тэмцээнийг зохион байгуулж ахлах номын санч Ч.Бадамцэцэг, салбарын эрхлэгч Дя.Сарантуяа, ном зүйч Н.Солонго нар тэргүүн байранд шалгарлаа.

- Дархан-Уул аймгийн Иргэний танхимаас зохион байгуулсан Нээлттэй хэлэлцүүлэгт номын сангийн захирал Д.Цэрэндаваа, арга зүйч Г.Нямцэнд, ном зүйч Н.Норжмаа, фондчин-номын санч П.Булгамаа нар оролцлоо.

- Увс, Говьсүмбэр аймгийн номын сангийн ажилтнууд ирж туршлага солилцлоо.

- Дархан-Уул аймгийн их, дээд сургууль, ЕБС, сумдын номын сангуудад тэдний үйл ажиллагаа, номын сангийн програм хангамжийн талаар 5 удаа арга зүйн зөвлөлгөө өгч ажиллалаа.

➢ **Номын сангийн ажилтнуудын графикт сонсгол, мэдээллийн цагаар дараах сургалтуудыг зохион байгууллаа. Үүнд:**

- Монгол улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн санаачилгаар хэвлэгдсэн “Монголын эх түүх” 6 боть номоор түүхийн ухааны ахмад багш Н.Төмөртогоогоор номын сангийн ажилтан ажилчдад мэдээлэл хийлгэлээ.

- ҮЭ-ийн хуулийн зөвлөх Баяржаргалтай хамтран “ҮЭ-ийн гишүүдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх нь” сэдвээр номын сангийн ажилтан, ажиллагсдад сургалт зохион байгууллаа.

- “ХААН” банкны салбарын эрхлэгч н.Долгорсүрэнтай хамтран “Харилцагчийн сургалт”- ыг зохион байгууллаа.

- Архивын улсын үзлэгийг угтаж номын сангийн нийт ажилтан ажиллагсдад “Бичиг хэргийн стандарт”-ын хэрэгжилтийн талаар Аймгийн архивын дарга н.Алтанзултай хамтран сургалт зохион байгууллаа

- Амьдрах ухаан төвийн багш Н.Ганхөлөгийг урьж ажилтан, ажиллагсдад “Эрүүл мэндээ хэрхэн хамгаалах” талаар лекц хийлгэлээ.

- Соёл урлагийн байгууллагуудын бүтээлч "Түншлэл- 2015" хэвлэлийн бага хурлыг Төв номын сан дээр хийж, 10 гаруй төрийн болон ТББ-гууд оролцлоо.
- "Америкийн боловсролын өдөрлөг" сэдвээр 20 минутын зочны цаг нэвтрүүлэг
- УБ хотын UBS-2 телевизын "Номын ертөнц" нэвтрүүлэгийн багийг урьж ирүүлэн Аймгийн ХАА-ны дарга Т.Ганболд, 30-р сургуулийн сургалтын менежер Ж.Эрхэмсайхан, Соёмбо дээд сургуулийн захирал Г.Бямбажав, ХААИС-ийн захирал Ганхуяг, Аймгийн Давж заалдах шатны шүүгч Л.Амарсанаа нарын "ГЭРИЙН НОМЫН САН"-гаар зочлуулж, тусгай нэвтрүүлэг хийлгүүлсэн ба Төв номын сан, ХНО-ны үйл ажиллагааг "НОМЫН ЕРТӨНЦ" нэвтрүүлгээр сурталчуулах бичлэг хийлгүүлсэн болно.
- Төвийн телевиз ТҮ-9, UBS болон орон нутгийн телевиз, радио, сонин, ном хэвлэлээр өөрийн үйл ажиллагаагаа **20 гаруй** удаа сурталчиллаа.

Зургаа. Шинэлэг үйлчилгээ- бүтээлч ажил.

Төв номын сангийн дэргэдэх Боловсролын зөвлөгөө мэдээллийн төв /БЗМТ/ нь Соросын сан, АНУ-ын ЭСЯамнаас зарлагддаг :

- "Болгар дахь Америкийн их сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр",
- "Тэтгэлэгээр суралцах боломж"
- "USAP-2014"
- "USAP-2015"
- "Гадаадад тэтгэлэгээр суралцах боломж"
- www.darlib.mn зэрэг сэдвүүдээр ЕБС-ийн сурагчид, их, дээд сургуулийн

багш, оюутнууд, уншигчдад сурталчлан 6 удаа лекц зохион байгуулж 850 хүн хамрагдлаа.

- 2015 онд БЗМТ нь англи хэлний анхан, дунд, гүнзгий шатны болон конкурс, TOEFL-ийн сургалтыг 6 удаа зохион байгуулж ***45*** оюутан, сурагчид хамрагджээ.

- БЗМТөв нь орон нутагт түвшин тогтоох шалгалтыг 50 хүнээс, Pre TOEFL-ийн шалгалтыг **6 удаа 27** хүнээс авлаа.

- БЗМТөв нь Дэлхийн банк, ННФорум, тэтгэлэгт хөтөлбөрүүдийн талаар:

-ганцаарчилсан зөвлөгөөг	280 хүнд
- группчилсэн зөвлөгөөг	7 удаа, 250 хүнд
- Утсаар	310 хүнд

- Email хаягаар 800 гаруй хүнд тус тус зөвлөлгөө өгч ажилласан байна.

2015 онд “Болгар дахь Америкийн их сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр”-т 6 сурагч, “USAP-2015” тэтгэлэгт хөтөлбөрт 8 сурагч өргөдлийн маягт бөглөн эхний 1,2 дугаар шатандаа тэнцэж, Х.Бумбаяр 11300$, Ц.Сэргэлэнбат 6780$, Б.Цогжавхлан 3390$-ын тэтгэлэг авч Болгар дахь Америкийн их сургуульд суралцахаар урилга авч, 19-р сургуулийн сурагч Х.Бумбаяр, Б.Цогжавхлан нар суралцаж байна.

Долоо. Бусад ажлын талаар

Аймгийн Төв номын сан нь 2015 онд үйл ажиллагаагаа сурталчлах, орчноо тохижуулах, ажилтнууд, уншигч-хэрэглэгчдийн ая тухтай орчинг бүрдүүлэх дараахи ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Номын сангийн соёл олон нийтийн ажил явуулахад болон зар сурталчилгааны 500 гаруй өнгөт хэвлэлийг өөрсдийн хүчээр хэвлэн ашигласан байна.

- Номын сангийн вэб сайт болон блогт шинэ мэдээ мэдээллийг байнга баяжуулан тавьж байна.

- Аймгийн Засаг даргын 01 дүгээр албан даалгавар, Дархан сумын Засаг даргын 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлж байгууллагын гадна талбайн цас, болон хогийн цэвэрлэгээг тогтмол хийж заншлаа.

- Дэвшилийн архивын фондын цахилгааны засварыг 700.0 гаруй мянган төгрөгөөр засварлаж галын аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

- Дархан-Уул аймгийн Засаг даргын 2015 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн 04 тоот албан даалгавар “Мөнх ногоон хот” уриан дор нэг сая мод ургуулах хөдөлгөөнд нэгдэж Хүүхэд залуучуудын амралтын хүрээлэнд 40 мод тарьж “Агч төгөл” байгуулан,тодорхой хуваарийн дагуу усалж арчлан 100 хувь ургуулж чадлаа.

- Цасны баярт бүх ажилчид идэвхтэй оролцож, байгууллагаа сурталчиллаа.

- “Шарилжгүй Дархан” аяны хүрээнд хуваарьт газартаа цэвэрлэгээ хийлээ.

- Аймгийн БОГ-аас зарласан 1000 мод тарих болзолт уралдаанд амжилттай оролцож, хүн бүр 2-3 мод тарьж 96%-ийн амжилттай ургууллаа.

- Байгууллагын гадна орчинг тохижуулах, ногоон байгууламжийг бий болгох зорилгоор 6 тасалгааны, 11 цэцгийн мандалд цэцэг тарьж ургууллаа.

- Бүх улирлын сонин, хэвлэлүүдээ үдэж хавтаслалаа.

Олон нийтийг хамарсан ажлын талаар:

1. Дархан-Уул аймагт анх удаагаа Америкийн 7 сургууль ирж, өөрсдийн сургуулийн танилцуулгаа хийлээ. “Америкийн боловсролын өдөрлөг-2015” үйл ажиллагаанд 1000 гаруй оюутан сурагчид, багш, эцэг эхчүүд оролцож мэдээлэл авав.
2. Дархан-Уул аймгийн Мэргэжлийн Хяналтын Албаны нэг сарын аяны нээлт 2015.09.02-ны өдөр Дархан 50 цогцолборт “Залуу хүний заавал унших ном” сэдэвт 46 боть номоор үзэсгэлэн гаргаж оролцлоо. Нийт 350 гаруй хүн оролцлоо.
3. ОИЦ-ын 5-р ангийн сурагчидтай зохиолч М.Уянсүх, Д.Цэрэндаваа, Д.Мянганзам

нартай уулзалт хийлээ. Уулзалтанд 200 гаруй сурагчид оролцлоо.

4. 2015 оны 09 дүгээр сарын 11-нд Дархан 50 цогцолборт “Үндэсний номын баяр”,

“Дархан хотын өдрийг” угтаж, аймгийн боловсрол, соёлын байгууллагуудын хүрээнд “Нээлттэй хаалганы өдөр”-өөр “Залуу хүний заавал унших ном”, Ном хөтөлбөрийн шинэ ном”, Англи хэлний хямдралтай номын худалдааг зохион явуулж 500 гаруй оюутан сурагчид хамрагдлаа.

5. Номын баярт зориулж Номын санчид, Хэвлэл мэдээлэлийн ажилтаны дунд зохиогдсон “Тунгаамал” тэмцээнд баг хамт олноороо амжилттай оролцлоо.
6. Монголын Эх түүх 6 боть номоор Хүмүүнлэгийн Ухааны Их сургууль, ШШГА, “Залуучууд” театрын дугуй зааланд нийтдээ **3 удаа** мэргэжлийн багш нар болон номын санчид илтгэл тавив.
7. Хонгор суманд болсон Соёлын байгууллагуудын дунд зохиогдсон өвөл цагийн соёл хүмүүжлийн ажлын нээлт нөхөрсөг “Гар бөмбөг”-ийн тэмцээнд багаараа 4-р байрт шалгарлаа.

Найм. Цаашид тавих зорилт.

- ✓ Монгол Улсын засгийн Газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- ✓ Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2013-2016/,
- ✓ БСШУ-ны сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээ,
- ✓ Аймгийн төв номын сан нь “Номын сангийн хөгжлийн хөтөлбөр”-т тусгасан зорилтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх,

- ✓ ССАЖГазрын анхдугаар зөвлөлгөөнөөс дэвшүүлсэн дараах 4 зорилтыг хэрэгжүүлэн ажиллана. Үүнд:
- ✓ Орчин үеийн стандартын шаардлага хангасан зориулалтын байртай болох асуудлыг хөөцөлдөж хөрөнгө, зардлыг төсөвт суулгуулах
- ✓ Номын сангийн орчин үеийн техник, технологи нэвтрүүлж, цахим номын сан болох ажлыг үргэлжлүүлэх
- ✓ Алслагдсан сум, бригад, эрх нь хязгаарлагдмал иргэдэд явуулын номын сангаар үйлчилж, тэдний дунд олон талт соёл, олон түмний ажлыг зохион байгуулах
- ✓ Архивын улсын үзлэгт бэлтгэх
- ✓ “Дархан-Уул аймаг хэвлэлийн хуудаснаа” номзүйн бүртгэлийг хэвлүүлэх 10 боть
- ✓ “Дархан-Уул аймгийн зохиолчдын ном зүйн бүртгэл” 1 боть
- ✓ “Дархан-Уул аймгийн номын сангийн монгол номын бүртгэл”-үүдийг хэвлүүлэх 5-8 боть
- ✓ “ Номын сангийн анхан шатны бүртгэл маягтыг шинэчлэх тухай” БСШУ-ны сайдын 441, 180, Сангийн сайд, БСШУ-ын сайдын хамтарсан 357/406 тоот тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд анхан шатны шинэчилсэн маягтыг хөтлөх, ном хэвлэлээ дахин үнэлэх, олон улсын ДДС ангиллаар ангилах ажлыг үргэлжлүүлэн,номын сангийн програмд орос, англи фондын номыг оруулж дуусгах,
- ✓ 2015 оны 11-р сард зохиогдсон “Соёл урлаг, бүтээлч үйлдвэрлэл -2015” нэгдсэн арга хэмжээнээс гарсан “САНАМЖ БИЧИГ”-ийн зорилтуудыг хэрэгжүүлэх

2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 8 зүйл дээр 56 асуудал төлөвлөснөөс 56 асуудал бүрэн биелж, төлөвлөгөөний биелэлт 100% -тай, төлөвлөгөөнд тусгагдаагүй 7 ажлыг шинээр нэмж хийсэн амжилтаар хуучин оноо угтлаа.

ДАРХАН УУЛ АЙМГИЙН ХҮҮХДИЙН НОМЫН ОРДОНЫ 2015 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

ҮНДЭСЛЭЛ:

Хүүхдийн Номын Ордон /цаашид ХНО гэх/ нь Монгол улсад хэрэгжиж буй хууль тогтоомж, Номын сангийн үйлчилгээний стандарт хэм хэмжээ, аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, ХНО-ны 2013-2017 онд хөгжүүлэх хэтийн болон жилийн ажлын төлөвлөгөө, бусад холбогдох дүрэм, журмыг мөрдлөг болгон аймгийн хэмжээнд хүүхэд багачууд, оюутан залуус, насанд хүргэгчдэд номын сангийн уншлага үйлчилгээг хүртээмтэй хүргэх, номтой нөхөрлөх хөдөлгөөнийг өрнүүлэн тэлэх, бие дааж сурч боловсрох, хөгжихөд нь үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж ирлээ.

Тайлангийн бүтэц:

- ✓ Зохион байгуулалтын талаар
- ✓ Уншлага үйлчилгээний талаар
- ✓ СОТА-ын талаар
- ✓ Фондын баяжилтын талаар
- ✓ Мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар
- ✓ Мэдээлэл, сурталчилгааны талаар
- ✓ Олон нийтийг хамарсан үйл ажиллагааны талаар
- ✓ Бусад ажлын талаар

1. **<u>Зохион байгуулалтын ажлын талаар</u>**

- ✓ 2014 оны үйл ажиллагааны тайлан, СУ 3, СУ 10, СУ 15 маягтаар гаргах тайланг нэгтгэж, холбогдох газруудад хүргүүлэв.
- ✓ ХНО-ны 2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны болон нэгжийн төлөвлөгөө боловсруулж баталгаажуулан гүйцэтгэлийг тухай бүр холбогдох газруудад хүргүүлж ажиллав.
- ✓ Нийт ажиллагсдын өмнөх оны гүйцэтгэсэн ажлын тайланг хэлэлцэн үр дүнг тооцон 2015 оны хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан.
- ✓ ХНО-ны дүрэмд өөрчлөлт хийн найруулж, захирлын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн, төсвийн ерөнхийлэн захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан. Үр дүнгийн гэрээний

хагас, бүтэн жилийн тайланг аймгийн БСГ, НХХ-т хүргүүлж үр дүнг үнэлүүлсэн.

- ✓ Аймгийн Соёл Урлагийг 2015-2021 он хүртэл хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхтэй холбогдуулан санал, зөвлөмж боловсруулан БСГ-т хүргүүлэв.
- ✓ ХНО-ны үйл ажиллагаанд мөрдөж байгаа дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, баталгаажуулав. Үүнд:
    - Номын санд бүртгэх журам
    - Гэр бүлийн уншлагын танхимаар үйлчлүүлэх журам
    - Гэрээр ном олгох журам
    - Оюунлаг уншигч, анги хамт олон, шалгаруулах журам
    - Ажиллагсдын ур чадвар үнэлэх журам
    - Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам
    - Чөлөөт уншлагын танхимаар үйлчлүүлэх журам
    - Явуулын номын сангаар үйлчлүүлэх журам
- ✓ ХНО-оос зохион байгуулах СОТ ажлын удирдамж, төлөвлөгөө боловсруулж, холбогдох газруудад хүргүүлж хамтран ажиллав. Үүнд:
    - “Ургалч санаа, уран бодолт” бага ангийн сурагчдын дунд зохион байгуулсан өгүүлбэртэй бодлогын уралдаан;
    - “Уран сэтгэгчид” дунд ангийн сурагчдын дунд зохион байгуулсан сэтгэх чадварын уралдаан;
    - “Найргийн даага” оны шилдэг шүлэг шалгаруулах уламжлалт уралдаан;
    - “Дүрийг хэн сайн урлах вэ” уламжлалт дүрийн тоглолттой уншигчдын бага хурал;
    - “step by step” англи хэлний уламжлалт уралдаан;
    - “Ном” хөтөлбөрийн хүрээнд БСГ-тай хамтран ЕБС, СӨББ-уудад “Номтой өдөр” арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөө;
    - “Зулзагын голын зуслан” нүүдлийн номын сангийн бэлтгэл ажлыг хүрээнд ХГБХ Хэлтэстэй хамтран ажиллах гэрээ байгуулж, нүүдлийн номын сан ажиллуулах удирдамж боловсруулан ажиллагсдын хуваарь гарган батлуулав. Мөн MSC, АПУ компаниудад хамтран ажиллах хүсэлт илгээж, MSC компани 100 ширхэг бүтээгдэхүүний дээжээр “Нүүдлийн номын сан”-гийн үйл ажиллагааг ивээн тэтгэсэн.

- “Өглөөний цайтай уншлага” зохион байгуулах зөвлөмж боловсруулж ЕБС-дад хамтран ажиллах санал хүргүүлэв.

✓ Шилэн дансны сайтад бүртгүүлж, төсөв, төсвийн гүйцэтгэлийг олон нийтэд нээлттэй тогтмол танилцуулж, иргэд сонирхогчдыг лавлагаа мэдээллээр хангаж ирсэн.

✓ 2015 онд 27 тушаал, 25 албан бичиг боловсруулсан байна. Ирсэн бичиг 25, үүнээс 20-г нь шийдвэрлэсэн.

✓ Тайлангийн хугацаанд БСШУ Яаманд СУ маягтууд 1, АЗДТГ-т үр дүнгийн гэрээний 2, БСГ-т жилийн болон хагас жилийн 2, сар тутмын 12, 7 хоног тутмын үйл ажиллагааны мэдээг 48 удаа тус тус хүргүүлж өгөгдсөн үүрэг чиглэлийг байгууллагын ажил үүргийн төлөвлөгөөнд тусган ажиллаж ирлээ.

✓ Дархан сумын Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 10 тоот захирамжаар шинэчлэн баталсан 2015 онд ажиллах цагийн хуваарийг баталгаажуууллаа.

✓ 2010-2014 оны баримт ялган үдэж, архивын улсын үзлэгт хамрагдан, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтийн дагуу Албан хэрэг хөтлөлт 82,5%, Байгууллагын архив 72% гэсэн үнэлгээ авлаа.

2. <u>Уншлага үйлчилгээний талаар:</u>

Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 57425:2007 стандартын аймаг, дүүргийн номын сангийн жишгээр уншигч, ирц, ном олголтыг төлөвлөдөг. Манай ордонд 2015 онд 3073 уншигч бүртгэгдэж, давхардсан тоогоор 48110 удаа ирж, 77643 ширхэг ном хэвлэл ашиглаж, мэдээлэл авсан нь өнгөрсөн жилээс өссөн байна. Дархан суманд сурч байгаа ЕБС-ийн нийт /16500/ суралцагчдын 18.1% нь 2015 оны байдлаар уншлага үйлчилгээнд хамрагдсан үзүүлэлттэй байгаа юм.

2015 оны уншлага үйлчилгээний тоон үзүүлэлт

Хүснэгт №1

Төрөлжсөн тэнхим	**Байнгын уншигч**	**Ирэгсэд**	**Олгосон ном**

1.	Номын сан	2616	18342	29583
2.	Салбар номын сан	407	7664	15307
3.	Нүүдлийн номын сан	50	325	936
4.	Төрөлжсөн тэнхим	3575	21779	31817
Үүнээс:	Байгалийн ухаан	864	2762	4962
	Гадаад хэл	747	4785	5432
	Гэр бүлийн танхим	9	762	1927
	Цахим ном-мэдээлэл	1413	9812	15363
	Эх хэл-уран зохиолын	542	3658	4133
Нийт		**3073**	**48110**	**77643**

Тайлбар: Төрөлжсөн танхимын уншигч нь ХНО-ы бүртгэлтэй уншигч болно.

2014, 2015 оны үндсэн үйл ажиллагааны харьцуулсан үзүүлэлт

Хүснэгт № 2

	2014 он			**2015**			**Өмнөх онтой харьцуулсан хувь**
	Төлөв-лөгөө	**Гүйцэт-гэл**	**Хувь**	**Төлөв-лөгөө**	**Гүйцэт-гэл**	**Хувь**	
Уншигч	3000	3529	117.6	3800	3073	80.8	- 36.8
Ирц	18000	32657	181.4	22800	44168	193.7	+12.3
Ном олголт	42300	65504	154.8	55000	71450	129.8	-25

Өнгөрсөн жилд төрөлжсөн танхимын ирэгсдийг уншигчаар бүртгэн авч байсан нь уншигч, ном олголтын тоон үзүүлэлт өндөр гарсан. Мэргэжлийн дээд шатны байгууллагаас зөвлөмж авсны үндсэн дээр бүртгэлийг давхардлыг арилгаж энэ жилээс зөвхөн нийтийн уншлагын танхимд ирэгсдийг үндсэн уншигчийг бүртгэж, төрөлжсөн танхимаар үйлчлүүлэгч ирэгсдийг ирцээр бүртгэн авах болсноор уншигч, /37,5/, ном олголт /25/ хувийн бууралттай харагдаж байгааг залруулан авч үзнэ үү.

2009-2013 оны үндсэн үйл ажиллагааны үзүүлэлт:

Хүснэгт № 3

Үндсэн үйл ажиллагаа	2009	2010	2011	2012	2013	2009-2013 оны дундаж
Уншигч	970	1122	3020	3728	3778	2523.6
Ирц	14080	19088	23777	27074	33272	23458.2
Ном олголт	15304	21067	33349	50833	65007	37112

Сүүлийн 5 жилийн уншигчийн байдал

График №1

Ирцийн байдал: /сүүлийн 5 жилээр/

График № 2



Ном олголт: /сүүлийн 5 жилээр/

График № 3



Уншигчийн насны ангилал / 2015 он/

График №



Уншигчдын насны ангилал

Хүснэгт №4

Уншигч	Насанд хүрэгч	Оюутан	1-4- р ангийн сурагч	5-8-р ангийн сурагч	9-12-р ангийн сурагч	Өндөр настан	нийт
тоо	109	106	1657	645	523	5	3045

Хүйсийн ялгаа / 2015 он /

График № 5



2015 оны уншигчдын бүртгэл сургууль тус бүрээр

График № 6



Нийт уншигчдийн:

866 буюу 28.8% нь ОИЦ сургууль

730 буюу 24.3% нь Од цогцолбор сургууль

225 буюу 7.5% нь 9-р сургууль

139 буюу 4.6% нь 19-р сургууль

26 буюу 0.8% нь УБ хотын сургуулиуд

19 буюу 0.6% нь бусад аймаг сумуудаас ирж бүртгэгдсэн уншигчид байна.

Үүнээс харахад Шинэ Дарханд байрлалтай сургуулиудад сурч байгаа сурагчид ХНО-р илүү үйлчлүүлж байгаа нь харагдаж байна.

- ✓ Зөөврөөр өнгөрсөн онд 5-н цэцэрлэгт 107 боть ном, 5-н сургуульд 398 боть номоор үйлчилсэн бол энэ онд 10-н цэцэрлэгт 290 боть, 9-н сургуульд 1987 боть номоор нийт 26 удаа үйлчилсэн байна. / Нийт 2782 боть ном /
- ✓ Гэрээр 398 боть номоор үйлчилсэн.
- ✓ Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэстэй хамтран ажиллах гэрээний дагуу Зулзагын гол дахь хүүхдийн зусланд 6-р сарын 1-нээс эхлэн Нүүдлийн номын сан ажиллуулах байсан ч өвчний хөл хорио, бусад шалтгааны улмаас төлөвлөсөн хугацаанаас хойш эхэлж 3 ээлжинд ажиллаж, 50 уншигч, 325 ирцэд, 936 боть номоор үйлчилсэн байна. Зуслангийн ээлж тус бүрд хүүхдүүдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон СОТА зохион байгуулж ажилласан нь уншигч амрагч хүүхдүүдийн идэвхийг өрнүүлсэн “Тэргүүний уншигч” шалгаруулах, АХА тэмжээн зохион явуулах зэрэг арга хэмжээнүүдийг зохион явуулсан. Нүүдлийн номын сангийн үйл ажиллагаа MSC CoCo Cola компани энэ жил 4 дэхь жилдээ ивээн тэтгэж, 100 ширхэг бүтээгдэхүүний дээжээр бэлэг барилаа.
- ✓ Зулзагын гол, Хүйтний гол, Хараа голын эрэг дагуу зусч байгаа ард иргэд, хүүхэд багачуудад нүүдлийн номын сангаар /тус бүр 2-3 удаа 200-250 боть номоор/, төвөөс алслагдсан сургуулийн / 4, 12, 1-р сургууль, Од цогцолборийн Батальон дах салбар сургуулийн сурагчдад ном солилцоогоор 310 гаруй боть номоор, мөн ХНО-д авчирч уншуулах “Машинтай уншлага” арга хэмжээнд 4-р сургуулийн 2 ангийн 56 хүүхдийг хамруулла.
- ✓ Гэр бүлийн танхимын үйл ажиллагаа: 7-н цэцэрлэгийн 13-н бүлгийн 650 гаруй хүүхэд багачууд ХНО-ны болон Гэр бүлийн уншлага үйлчилгээний танхимын үйл ажиллагаатай танилцсан байна. Гэр бүлийн уншлага үйлчилгээний танхимын үйл ажиллагааны хүртээмж, ашиглалтыг сайжруулахын тулд номын санчид хариуцсан цэцэрлэгүүдийн аргазүйч, багш, эцэг эх, асран хамгаалагч нартай хамтарч ажиллах, мөн ахлах, бэлтгэл бүлгийн багш, эцэх эхчүүдтэй хамтран ажиллаж байна.
- ✓ “Өглөөний цайтай уншлага” зохион байгуулах зөвлөмж боловсруулж, ЕБС-дад хамтран ажиллах санал хүргүүлсэний дагуу:

- “Ном” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд “Дэлхийн номын өдөр”-ийг тохиолдуулан 19-р сургуультай хамтран ХНО-д анх удаа “Өглөөний цайтай уншлага”-ийг Б.Баттамир багштай 4а ангийн хамт олны дунд зохион байгууллаа. Уг арга хэмжээнд тус ангийн 25 сурагч, Аймгийн засаг даргын орлогч Г.Баянмөнх, Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн О.Мөнхсүрэн, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Р.Тунгалаг-Эрдэнэ, 19-р сургуулийн захирал Дэмбэрэл нар оролцож, ном уншиж, уншсан номын тухай сэтгэгдлээсээ бусадтайгаа хуваалцаж, харилцан ярилцав. Цаашид тус сургуультай хамтран уг арга хэмжээг бүх ангиудад зохион байгуулахаар төлөвлөөд байна
- ОИЦ сургуулийн Отгонзул багштэй 6-3, Од цогцолбор сургуулийн Баттулга багштай 8в ангийн хамт олон тогтсон өдрүүдэд ХНО-д хүрэлцэн ирж, ном унших, баг хамт олноороо номын тухай ярилцах, мэтгэлцэх, ном тойрсон уралдаан тэмцээнд бэлтгэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж хэвшсэн.
- 9, 18-р сургуулиудад “Өглөөний цайтай уншлага”-ыг тус бүр 1-2 удаа зохион байгуулсан нь хүүхэд багачуудын сонирхлыг татсан үр дүнтэй арга хэмжээ боллоо.

3. **<u>СОТА-ын талаар:</u>**

Сурагчдын ном унших хандлагыг дэмжих, уншигч номын сангийн харилцаа холбоог ойртуулах зорилгоор зохион байгуулдаг Соёл олон түмний ажлыг “Ном”, “Авьяас”, “Зөв монгол хүүхэд” хөтөлбөрийн хүрээнд төлөвлөж, олон нийтийг хамарсан 12 ажил төлөвлөснөөс 12 ажил хийж гүйцэтгэн 6150 гаруй хүнийг хамруулсан өнгөрсөн онтой харьцуулахад 16%-иар өссөн үзүүлэлттэй байна. Эдгээр ажлаас “Ургалч санаа-Уран бодолт” өгүүлбэртэй бодлого бодох уралдаан, ”Найргийн даага” оны шилдэг шүлэг шалгаруулах уралдаан, “Уран сэтгэгчид” уралдаан. “Зохиолч уншигчдийн уулзалт,“Номтой өдөр-2015” арга хэмжээ, лекц, уулзалт зэргийг онцолж байна.

1. НОМЫН ҮЗЭСГЭЛЭН

- ✓ Шинэ номын үзэсгэлэнг шинээр ном ирсэн тухай бүр 1 давхар дахь үзэсгэлэнгийн шилэн хоргонд гаргаж байсан ба нийт 25 удаа, 284 боть ном

дэлгэн тавьж, уншигчдад сурталчилж, өөрийн Facebook хуудаснаа мэдээлж байлаа.

✓ Сэдэвчилсэн номын үзэсгэлэн:
  - Уламжлалт цагаан сарын баярт зориулан 22 боть номоор;
  - Эмэгтэйчүүдийн баярт зориулан 12 боть номоор;
  - Цэргийн баярт зориулан 29 боть номоор;
  - ЭЕШ бэлтгэгчдэд зориулан 28,
  - Инээдмийн өдөрт зориулж 10 боть ном
  - Андерсены мэндэлсэн өдрөөр 13 ботьномоор;
  - Дэлхийн номын өдөрт зориулан Дарханы зохиолчдын 45 боть номоор;
  - Номтой өдөр аяны хүрээнд -/ ЕБС-ийн нийт сургууль тус бүрд / 110 боть номоор;
  - Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр /Дархан-50 цогцолборт/ - 96 боть номоор;
  - Хичээлийн шинэ жилд зориулан 34 боть шинэ сурах бичгээр;
  - Үндэсний номын баярын өдрийг тохиолдуулан "Ухаан далай номоос эхтэй" 12 цуврал боть, Монголын уран зохиолын 108 цуврал боть номоор;
  - Д.Нацагдоржийн мэндэлсэн өдөрт 19 боть номоор;
  - Чингис хааны мэндэлсний өдрөөр 30 боть ном
  - "Соёл урлаг, бүтээлч үйлдвэрлэл, түншлэл-2015" семинарын үеэр Соёл урлаг, гар урлал, танин мэдэхүйн холбогдолтой 40 боть номоор;

тус тус 1490 ш номоор үзэсгэлэн зохион байгуулж, фондоо сурталчлав. Эдгээр үзэсгэлэнг давхардсан тоогоор 7650 гаруй уншигч үзэж сонирхож, мэдээлэл хүртэж, номын эргэлт сайжирснаар уншигчдын тоо 844-өөр нэмэгдсэн байна.

2. " УРАН ЖИРГЭЭ-2015" АЙМГИЙН НААДАМ

Дархан-Уул аймгийн Хүүхдийн Номын Ордон, Хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн хэлтэстэй хамтран Дэлхийн болон Монголын хүүхдийн шилдэг зохиол бүтээлийг хүүхэд багачуудад таниулах, номд дуртай болгох, номтой нөхөрлүүлэх, тэдний дунд уран уншлагын урлагийг дэлгэрүүлэх, авьяасыг нээн хөгжүүлэх зорилготойгоор "Уран жиргээ-2015" аймгийн уралдааныг 2 дахь жилдээ зохион байгуулж, нийт 52 хүүхэд авьяас билгээ сорив. Тэмцээн 4 насны ангиллаар зохион

байгуулагдсан бөгөөд ангилал тус бүрийн тэргүүн байрны шагналтнууд Улсын уралдаанд оролцох эрх олгов.

3. “УРГАЛЧ САНАА, УРАН БОДОЛТ” БАГА АНГИЙН СУРАГЧДИЙН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ӨГҮҮЛБЭРТЭЙ БОДЛОГЫН УРАЛДААН

“Ургалч санаа-Уран бодолт” өгүүлбэртэй бодлогын уралдаан нь ЕБС-ийн сурагчдын өгүүлбэртэй бодлого бодох ур чадварыг нэмэгдүүлэх, номтой нөхөрлүүлэх, бодлого бодох хялбар оновчтой аргыг эрэлхийлэх, уралдаанаас төрсөн уран арга, өвөрмөц санааг олны хүртээл болгох зорилгоор ЕБС-ийн III, IV, V ангийн сурагчдын дунд 2015 оны 04-р сарын 25-нд амжилттай явагдаж өнгөрлөө. Уралдаанд 9-н сургуулийн нийт 228 сурагч хамрагдан оролцлоо. Үүнээс:

- 3-р ангийн 68 сурагч ,
- 4-р ангийн 84 сурагч,
- 5-р ангийн 76 сурагч тус тус оролцсон байна.

- 3-р ангийн сурагчдаас 1 алт, 1 мөнгө, 1 хүрэл, 1 тусгай байр
- 4-р ангийн сурагчдаас 1 алт, 1 мөнгө, 1 хүрэл, 1тусгай байр
- 5-р ангийн сурагчдаас 1 алт, 1 мөнгө, 1 хүрэл, 1тусгай байр
- Уран бодолтын аварга 3 сурагч нийт 15 сурагчийг урамшууллаа.

Уран бодолтын аваргаар 9-р сургуулийн 3в ангийн сурагч Б.Мөнхтэргэл, 15-р сургуулийн 4а ангийн сурагч М.Батболд, 22-р сургуулийн 5а ангийн сурагч Б.Мөнгөнбагана нар шалгарлаа.

4. НОМТОЙ ӨДӨР АЯН

2015.04.13-ны өдрөөс БСГ-аас батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу ЕБС-иудад “Номтой өдөр” сарын аяныг 9-р сургуулиас эхлэн 05-р сарын 07-ны өдөр Од цогцолбор сургууль дээр зохион байгуулж дуусгалаа.

Тус аянаар ЕБС-ийн сурагчдын дунд ном уншлага зохион байгуулах, “Ном бол хүсэл мөрөөдлийг давах жигүүр мөн” сэдэвт лекц унших, ХНО-ны үйл ажиллагаа болон тус орноос санал болгож буй шинэлэг үйлчилгээг танилцуулах, цахим номын сурталчилгаа хийх, танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн зохион байгуулах, уншигчийн карт нээх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

“Номтой өдөр” аянаар нийт 19 сургуульд хүрч ажиллахаас 18 сургууль дээр ажиллаж, нийт 40 гаруй багш, 2503 сурагчид хамрагдан давхардсан тоогоор 5219

боть номоор үйлчлүүлсэн байна. Цайхун, Союз сургуулийн дотоод ажлаас шалтгаалан арга хэмжээг зохион байгуулаагүй. 9-р сургууль, Монгол-Оюу, Од, ОИЦ, Энэрэл цогцолбор сургуулиуд үйл ажиллагааг дэмжин, сайн хамтран зохион байгуулсан.

Уг арга хэмжээнд зориулан 4 ш сурталчилгааны анонс, 700 орчим цахим ном бүхий DVD, 56 хуудас бүхий номын тухай онч үгс, 250 орчим асуулт бүхий танин мэдэхүйн уралдааны асуулт, бусад хэвлэмэл материал, 470 орчим боть ном, 50 гаруй сэтгүүл бэлтгэж, 60000 төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

5. "УРАН СЭТГЭГЧИД" ДУНД АНГИЙН СУРАГЧДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛСАН СЭТГЭХ ЧАДВАРЫН УРАЛДААН

"Уран сэтгэгчид-2015" сэтгэх чадварын уралдаан нь ЕБС-ийн сурагч багачуудын оюун ухааныг хөгжүүлж, хурдтай, оновчтой, уран сэтгэмжийг төлөвшүүлэхэд шинэ эрч хүч нэмсэн арга хэмжээ боллоо. Уралдаан ЕБС-ийн VI, VII, VIII ангийн сурагчдын дунд 2015 оны 11-р сарын 14-нд явагдаж, 14 сургуулийн нийт 158 сурагч оролцлоо. "Уран сэтгэгч сурагч"-аар ОИЦ сургуулийн 7-1 ангийн сурагч Э.Анхбаяр шалгарлаа.

6. ЗОХИОЛЧ УНШИГЧДЫН УУЛЗАЛТ

"Ном" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, зохиолч, уншигчдын амьд холбоог бэхжүүлэх зорилгоор XV сургуулийн 7,8,9-р ангийн 140 сурагчдад зохиолч уншигчдын уулзалт зохион явууллаа. Үүнд: Дархан –Уул аймгийн ХНО- ы захирал МЗЭ-ийн шагналт, яруу найрагч Л.Мөнхбаатар, МЗЭ-ийн гишүүн, МУСТА хошин шог зохиолч Д.Мянганзам, Дархан-Уул аймаг дах Хүмүүнлэгийн их сургуулийн багш, залуу яруу найрагч М.Баяржаргал нар хүрэлцэн ирж оролцож, зохиол бүтээлээсээ уншиж танилцуулан, сурагчдын сонирхсон асуултад хариулав.

7. "НАЙРГИЙН ДААГА" ОНЫ ШИЛДЭГ ШҮЛЭГ ШАЛГАРУУЛАХ УЛАМЖЛАЛТ УРАЛДААН

ЕБС-ийн хүүхэд багачуудын авьяас билиг, зохион бичих ур чадварыг хөгжүүлэх, дэмжин урамшуулах, өсвөр үеийнхнийг номтой нөхөрлүүлэх зорилгоор их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсэн өдрийг тохиолдуулан /2015.11.17/ оны шилдэг шүлэг шалгаруулах "НАЙРГИЙН ДААГА" уламжлалт тэмцээнийг 6 дахь жилдээ зохион байгууллаа. Энэ удаагийн уралдаанд ЕБС-ийн ахлах ангийн 25

сурагч ур ухаанаа уралдуулан шүлгийн морио сойсоноос Од цогцолбор сургуулийн 10д ангийн сурагч Буянравжих тэргүүн байранд орж, дэд байранд 15-р сур 11а ангийн сурагч Энх-Амгалан орсон бол гутгаар байранд 15-р сургуулийн 12в ангийн сурагч Баярбилэг орсон байна. Тусгай байранд 9-р сургуулийн 10д ангийн сурагч Бат-Ухаан, 18-р сургуулийн 10а ангийн сурагч А.Марал нар шалгарлаа. Тэргүүн, дэд байранд орсон сурагчдийг оны шилдэг шүлэг шалгаруулах “Алтан өд” наадамд урилгаар оролцуулж, бүтээлийг нь “АЛТАН ОД-14” номд хэвлүүлэх юм. Шүүгчээр Дархан-Уул аймгийн төв номын сангийн захирал, МЗЭ-н гишүүн, зохиолч, яруу найрагч Цэрэндаваа, ХНО-ны захирал МЗЭ-н гишүүн, яруу найрагч Л.Мөнхбаатар, ХНО-ны Монгол хэл, бичиг, уран зохиолын уншлага үйлчилгээний танхимын номын санч-мэдээллийн ажилтан О.Даваасүрэн нар ажиллаа. Энэ жилийн уралдааны онцлог нь нэрээ өөрчлөн “Найргийн даага” болов. Цаашид энэ нэрийг уламжлал болгон хэрэглэх аж.

8. “ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ-Д.НАЦАГДОРЖ ТЭМДЭГТЭН”

Хүүхэд, өсвөр үеийнхнийг номтой нөхөрлүүлэх, номын орчинг илүү өргөн хүрээнд хөхиүлэн дэмжих, хөгжүүлэх зорилгоор Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын 2006 оны 6 сарын 18-ны өдрийн 211 тоот тушаалаар батлагдсан “ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ-Д. НАЦАГДОРЖ ТЭМДЭГТЭН” шалгаруулах журмын дагуу 8-18 насны хүүхдүүдээс “Тэргүүний уншигч- Д. Нацагдорж тэмдэгтэн”-ний болзол хангасан сурагчдын шагналыг их зохиолчийн мэндэлсэн өдрийг тохиолдуулан жил бүр шагнаж урамшуулдаг. Энэхүү шагнал нь Д.Нацагдоржийн дүр бүхий тэмдэг үнэмлэх байдаг билээ. Энэхүү шагналд нийт 12 сургуулиас 30 сурагчийн материал, тодорхойлолтууд ирснээс болзол хангасан 18 сурагчдыг шагнаж урамшууллаа. Үүнээс: Бага насанд /8-12 нас / 8, Өсвөр насанд /13-18 нас/ 10 хүүхэд болзол хангаж, тэмдэг үнэмлэхээ гардан авлаа

9. “STEP BY STEP” АНГЛИ ХЭЛНИЙ УЛАМЖЛАЛТ УРАЛДААН

Дэлхийн хэл болох англи хэл, англи хэлтэй орнуудын түүх, соёлыг судалдаг сурагчдын англи хэл сурах сонирхлыг өрнүүлэх, өөрийгөө болон бусдыг хүндэтгэх, бахархах сэдлийг хөхиүлэн дэмжих, англи хэлний сонсгол болон хэл зүйн чадварыг хөгжүүлэх зорилготой “The Step by Step” англи хэлний тэмцээнийг 2015 оны 10-р сарын 16-нд Хуучин Дарханы ЕБ-ын I,IV,XV,XVI,XVIII сургуулиудын 7-р ангийн 50 сурагчдын дунд зохион явуулсан. Уг тэмцээн 4 үе шаттай явагдаж

I Байр -16-р сургууль Dream high

II Байр -15-р сургууль Stars

III Байр – 4-р сургууль High five багууд тус тус шалгарлаа.

10. ДҮРИЙН ТОГЛОЛТТОЙ УНШИГЧДЫН БАГА ХУРАЛ

Номтой нөхөрлүүлэх,зохиолын баатруудын сайн сайхан чанарыг дуурайх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөрийн нууц мэдрэмж, авьяасаа нээх боломжийг уншигчдад олгох зорилгоор “Сургамжит өгүүллэг” номоор уншигчдын бага хурлыг 3 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

Энэхүү арга хэмжээ нь 2013, 2014 онуудад зөвхөн 9,19, 22-р сургуулийн 8-р ангиудын дунд зохион байгуулж байсан бол энэ жил Дархан-Уул аймгийн хэмжээнд болсноороо онцлог юм.

“Сургамжит өгүүллэг” -1,2,3,4,5,6 уншиж дүрийн тоглолт бэлтгэх, дүрдээ тохирсон хувцаслалт, ур чадвар, дүр бүтээсэн байдал зэргийг харгалзан шүүгчид дүнгээ гаргасан.

Тус тэмцээнд 9-р сургуулийн 5-н баг, 15-р сургуулийн 1 баг, 18-р сургуулийн 1 баг, 4-р сургуулийн 2 баг, ОИЦ сургуулийн 1 баг, нийт 10 багийн 80 гаруй сурагчид хамрагдсан байна.

11. НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97-р зарлиг, 2012 оны “*Номын баярын өдөр тэмдэглэх тухай*” 158 дугаар зарлигийн хэрэгжилтийг ханган, байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчлах, иргэд, уншигчдын соён гэгээрүүлэх үйлсэд түүчээлэн хөтлөх зорилготойгоор Дархан хотынхоо өдрийг угтаж 2015 оны 09-р сарын 11-ний өдрийн 14.00-17.00 цагийн хооронд “Дархан-50” цогцолбор дээр зохион байгууллаа. Үүнд:

- ✓ Номын үзэсгэлэн: Шинэ ном болон фондын номыг сурталчлах зориолгоор ЕБС-ийн сурагчдын заавал унших эх зохиолын түүвэр бүхий “УХААН ДАЛАЙ НОМООС ЭХТЭЙ “ цуврал 12 боть ном, мөн сүүлийн үеийн хүүхдэд зориулсан 228 боть шинэ номуудаар үзэсгэлэн гаргав.
- ✓ Цахим номын танилцуулга, худалдаа
- ✓ Арга хэмжээнд хүрэлцэн ирсэн хүүхэд багачууд, насанд хүрэгчид нийт 27 уншигчид үнэ төлбөргүй карт нээн урамшуулав

- ✓ Төв номын сантай хамтран ЕБС-ийн сурах бичиг болон ном сонирхогчдын солилцоо, худалдаа, асуулт хариултын тэмцээн зохион байгуулах зохиогчийн гарын үсэгтэй номын худалдаа зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв.
- ✓ Нээлттэй хаалганы өдрийн арга хэмжээнд зохион байгуулагч байгууллагуудаас гадна 285 орчим хүн оролцсон байна.
- ✓ Хамтран оролцсон байгууллагууд: Төв номын сан, Номын ундраа дэлгүүр, Зохиолчдын салбар, БСГазар, Их дээд сургуулиуд

12. ШИЛДЭГ УНШИГЧ, ХАМГИЙН ОЛОН УНШИГДСАН НОМ

Хүүхэд багачуудын ном унших идэвх сонирхлыг өрнүүлэх, номд дуртай болгох бие даан сурч боловсроход дэмждэг үзүүлэх, урамшуулахын тулд сар бүр шилдэг уншигч, хамгийн олон уншигдсан номын тодруулан нийтэд танилцуулж шилдгийг алдаршуулан урам хайрладаг. Энэ жил “ШИЛДЭГ УНШИГЧ”-аар уншлагын танхимаас 23 уншигч, төрөлжсөн танхимаас 5, салбар номын сангаас 6, нийт 34 хүүхэд тодорч, “ХАМГИЙН ОЛОН УНШИГДСАН ЭРЭЛТ ИХТЭЙ НОМ” –оор Бумбардай цувралууд, Бонго-9, Соёмбо нэвтэрхий толь, Дэлхийн шилдэг 101-н үлгэр, Буратиногийн адал явдал, Бяцхан шулам /хүүхдийн шилмэл зохиол/, Д.Пүрэвдоржийн Бор гэрийн богд, Сургамжит өгүүллэгүүд, Гоц ухаантай Виктор, Хүний бие, Монгол хаад, Гүнжийн үлгэрүүд, Оливер Твист , Том Сойерын адал явдлууд, Жордоны Эхийн хайр, Бяцхан бамбаруушийн нэгэн өдөр, Маша баавгай, Монгол бөхийн нэвтэрхий толь, Ар халхын шилийн сайн эрчүүд, Сарантуяагийн Тавилан, Ногун 7,8 зэрэг номууд шалгарсан байна.

4. <u>Фондын баяжилтын талаар:</u>

Сан хөмрөг бүрдүүлэхдээ хүүхэд багачуудад зориулсан танин мэдэхүй, өөрийгөө хөгжүүлэх, бие даан суралцах, шинэ мэдлэг чадвар бүтээх, мэдээлэл олж авах чиглэлийн номуудыг уншигчдын захиалга, эрэлт хэрэгцээнд түшиглэн ном худалдан авах зарчим баримталдаг. Уншигчдын захиалгыг үндэслэн худалдаж авсан номын ашиглалт 83 хувьтай байна. Ном худалдан авах төсөвт зардал багаснаар худалдан авсан номын тоо, нэр төрөл өмнөх оноос 22.1 хувиар буурсан.

- 2015 онд шинээр 25 удаагийн худалдан авалтаар 5.520.700 төгрөгийн 284 нэрийн 526 боть ном худалдан авч техник ажиллагаа хийн уншлага үйлчилгээнд оруулж, фондоо баяжууллаа. Үүнээс:

Хандиваар:

- ✓ БСШУ Яамны хандиваар 600000 төгрөгийн үнэ бүхий "Монгол музейн шилдэг үзмэрийн дээжис" 3 боть ном,
- ✓ Соёлын өвийн төвийн хандиваар 46000 төгрөгийн 7 нэрийн 12 боть ном,
- ✓ Соёл урлагийг хөгжүүлэх сангийн хандиваар 29000 төгрөгний 7 нэрийн 7 боть ном,
- ✓ Бусад байгууллагын хандиваар 40000 төгрөгийн 3 нэрийн 8 боть ном, нийт 715.000 төгрөгийн 18 нэрийг 30 боть ном хүлээн авлаа.

Төслөөр:

- ✓ Аймгийн засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан "Ном" аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн хөгжлийн сангаас "Түүхийн жимээр ном худалдан авах төсөл" бичиж, 530,000 төгрөгийн дэмжлэгтэйгээр "Монгол хаад" цуврал 123 боть, Д.Төрбатын "Тэнгэрийн соёрхол" түүхэн 12 цуврал ботиудыг тус тус худалдан авч фондоо баяжуулан, уншигчдийн эрэлт хэрэгцээг ханган ажиллаж байна.

- Тогтмол хэвлэлийн захиалгыг улирал бүр хийж, 14 нэр төрлийн хэвлэл /6 сонин, 8 сэтгүүл/ захиалж, жилдээ 418.700 төгрөгний сонин сэтүүлийг захиалан авч уншигчдад үйлчилгээ үзүүлж байна.
- "Ном хандив-2015" аяны хүрээнд сурталчилгааны самбараа шинэчлэн хэвлүүлж, 15 албан байгууллагуудаар аялуулан нийт 215 боть ном хүлээн аваад байна.
- Шинээр ирсэн номуудыг monbiblio программд оруулсан, номуудыг зураг хэлбэрт оруулж мэдээллийн самбарт байршуулан, номын үзэсгэлэнгээр уншигчдад сурталчилж байна.
- Фондын хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих, шаардлагатай ном хэвлэлээр нөхөн бүрдүүлэлт хийх зорилгоор фондын бүх номын тооллогыг жилд 1 удаа /ээлжит/ "Номын нэг бүрчилсэн дансаар тоолох" хэлбэрийг сонгон зохион байгуулж байна.
- Хуучирч элэгдсэн болон гэмтэж урагдсан 93 боть номд сэлбэн засалт хийсэн.

5. **Мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар:**

- ✓ Нийт ажиллагсдад зориулан Номын санч Л.Долгоржав "Бичиг хэрэгт тэмдэгтүүдийг хэрэглэх нь" номын санч Н.Мөнгөншагай "Тайланд хүснэгт, график, диаграм ашиглах нь" сэдэвт илтгэлүүдийг тус тус бэлтгэн тавилаа.
- ✓ Дархан-Уул аймгийн Төв номын сангаас зохион байгуусан Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар эмхэтгэн хэвлүүлсэн "Монголын эх түүх" 6 боть номын хэлэлцүүлэгт тус ордны захирал Л.Мөнхбаатар А.Амарын "Монголын товч түүх" 1-р боть номоор Дарханы ард иргэд хөдөлмөрчид, эрдэмтэн багш, оюутан сурагчдад лекц уншлаа. Уг лекцэд 200 хүн хамрагдсан байна
- ✓ 2015.04.07-ны нийт ажиллагсдын хурал дээр номын санч Т.Цэрэннадмид Шинээр батлагдсан номын сангийн тухай хууль танилцуулав.
- ✓ Дархан-Уул аймгийн Төв номын сангаас зохион байгуулсан "Номын сангийн өнөөгийн байдал, хөгжлийн хэтийн төлөв" хэлэлцүүлэгт захирал Л.Мөнхбаатар, номын санч Т.Цэрэннадмид, Н.Сэлэнгэ, Н.Ганзориг нар оролцов.
- ✓ 2015 оны 05-р сарын 21-23-ны өдрүүдэд Захирал Л.Мөнхбаатар УБ хотноо зохион байгуулагдсан "Соёл урлагийн менежмент бүтээлч үйлдвэрлэл" сэдэвт сургалт семинарт оролцов.
- ✓ Номын санч Ч.Буяннэмэх, О.Даваасүрэн, Г.Гэрэл нар СУИС-ийн Соёлын боловсролын сургуулийг онлайнаар суралцаж төгсөв.
- ✓ Говь-Сүмбэр, Увс аймгийн Төв ном сангийн хамт олон, СУИС-ийн оюутнууд хүрэлцэн ирж ХНО-ны үйл ажиллагаатай танилцан харилцан туршлага солилцов.

6. **<u>Мэдээлэл, сурталчилгааны талаар:</u>**

- ✓ UBS телевизийн "Номын ертөнц" нэвтрүүлэгт орж, үйл ажиллагаагаа сурталчилж, мэдээлэл өгөв. Орон нутгийн мэдээллийн хэрэгслээр 5 удаа мэдээлэл олон нийтэд хүргэлээ.
- ✓ Цаг үеийн холбогдолтой мэдээ, мэдээлэл, шинэ номын мэдээлэл, СОТА-ын мэдээлэл, шилдэг уншигч, хамгийн эрэлттэй номууд зэргийг өөрийн Facebook https://www.facebook.com/Nomiin.ordon/?fref=ts хуудаснаа тухай бүр байршуулж байсан.
- ✓ 12-р сарын 24-нд DBS TV-ийн "Ярилцах цаг" нэвтрүүлгээр захирал Л.Мөнхбаатар мэдээлэл өгсөн.

- ✓ 12-р сарын 31-нд Дархан 50 цогцолборын LED зурагтаар шинэ жилийн мэндчилгээ дэвшүүлэв.

7. **<u>Олон нийтийг хамарсан үйл ажиллагааны талаар:</u>**

- 2015.09.12-13-ны өдрүүдэд Зулзагын голын “Эрэл” амралтан дээр БСШУЯ-ны дэмжлэгтэйгээр Соёл урлагийн хөгжлийн академи, СУИС-ын менежментийн тэнхимийн багш нарын удирдан зохион байгуулсан “Соёл урлагийн бүтээлч үйлдэрлэлийн менежмент” сэдэвт нэгдсэн сургалтанд байгууллага хамт олноороо оролцов.
- “СОЁЛ УРЛАГ, БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ, ТҮНШЛЭЛ-2015” СЕМИНАР 2015 оны 11-р сарын 20, 21-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Соёл урлаг, бүтээлч үйлдвэрлэл, түншлэл-2015” семинарт байгууллага хамт олноороо идэвхтэй оролцов. Уг ажлын хүрээнд байгууллагын танилцуулга шинэчлэн бэлтгэх, “Дарханы мэдээ” сонины эх бэлтгэх, хэвлүүлэх, Музейн фото зургийн үзэсгэлэнд байгууллагын түүхтэй холбогдолтой зураг угаалгах, Азын сугалаанд ном, эрхийн бичиг бэлтгэх зэрэг бэлтгэл ажлуудыг гүйцэтгэж, Соёл урлаг,гар урлал, танин мэдэхүйн холбогдолтой 40 боть номоор үзэсгэлэн гаргаж, үйл ажиллагаанд оролцогсдод зориулан үнэгүй карт нээн, танин мэдэхүйн зугаатай асуулт, хариултын тэмцээн зэргийг зохион явууллаа.
- Жил бүр уламжлал болон зохион байгууллагддаг соёлын ажилтны өдрийг угтаж, шатрын спортыг хөгжүүлэх, харилцан бие биенээсээ туршлага солилцох, найрсаг уур амьсгал үүсгэх, шатарчдын ур чадварыг дээшлүүлэх, шатрын спортыг түгээн дэлгэрүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилготойгоор 2015.08.29-ны өдөр ХНО-ны ажиллагсдын дунд шатрын тэмцээн зохион байгууллаа. Тэмцээнд ХНО-ны нийт ажиллагсдын 88.2% буюу 15 хүн оролцов. Тэмцээнийг номын санч мэдээллийн ажилтан Н.Мөнгөншагай ур чадвар авхаалж самбаагаараа хошуучлан, удаах байруудад номын санч мэдээллийн ажилтан Н.Энхчимэг, харуул Б.Анхбаяр нар удаалж, тусгай байранд номын санч мэдээллийн ажилтан Н.Ганзориг шалгарлаа.

8. **<u>Бусад ажлын талаар:</u>**

- ✓ Аймгийн хэмжээнд “Мөнх ногоон хот” уриан дор 1 сая мод ургуулах хөдөлгөөнийг өөрийн байгууллагадаа зохион байгуулж, хамт олноороо 20 ширхэг шар басгана тарьсан.

- ✓ Соёлын ажилтын өдрийг тохиолдуулан номын санч Л.Долгоржав Соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр энгэрээ мялааж, номын санч Н.Сэлэнгэ 2015 оны байгууллагын тэргүүний ажилтнаар шалгарч цалингийн хувиар урамшууллаа.
- ✓ Галын аюулгүй байдлыг хангах үүднээс галын хорны сийрэгжүүлэлтийн картыг бэлтгэж, ажиллагсад тогтмол бүртгэл хөтөлж байна.
- ✓ Байгууллагын өвөлжилтийн бэлтгэлийг хангах, засвар үйлчилгээний ажлын нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, графикийн дагуу 224.250 төгрөгийн хөрөнгийг зарцуулан бэлтгэлийг бүрэн хангасан.
- ✓ Ялтсан халаагчийн хүчин чадлын тооцоог тусгай зөвшөөрөлтэй компаниар гаргах засварын шаардах хуудасны дагуу Дархан Их Соёолж компаниар тооцоог гаргуулж, гэрээ хийн, дулаанаар хангагдсан.
- ✓ Тохижилт, үйлчилгээний ажлуудаар салхи, жавар ордог газруудаар дулаалгын чигжээс хийж, силикон шахах, салбар номын сангийн ширээ будах, зэвэнд идэгдсэн хашааг солих, хашаан доорх шороог зайлуулах, хөндийлөх, үүдний довжоо өндөрлөх, шон тэгшлэх зэрэг ажлуудыг хийж дуусгасан.
- ✓ Тосгоны номын сангийн шаланд шинээр хулдаас нааж ширээг будав.
- ✓ Ордны төв хаалганы урд хэсгийн 18 м2 талбайг цементлэв.
- ✓ Гадна талбайд дугуйн зогсоол, замын тэмдэг 2ш хийж байршуулсан.
- ✓ Гараашийн дээвэрт хар цаас нааж дээвэрлэв.
- ✓ Автомашины найдвартай үйл ажиллагааг хангах зорилгоор шаардлагатай тос тосолгоо, засвар үйлчилгээг хийж, автомашиныг авто тээврийн байгууллагаас жил бүр шалгадаг үзлэг оношилгоонд бэлдэж оруулсан.
- ✓ Шаардлагатай тохиолдолд мужаан, сантехник, цахилгааны засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэн найдвартай ажиллагааг ханган ажиллав.
- ✓ Гадна орчны болон ордны дотор талын их цэвэрлэгээг тогтмол хийж, ая тухтай ажиллах, үйлчлүүлэх боломжийг ханган ажиллав.

Тулгамдаж буй асуудал:

- ✓ Номын санг цахимжуулах;
- ✓ Явуулын болон нүүдлийн номын сангийн үйлчилгээг өргөтгөхөд бензин шатахууны зардал төсөвт тусгагдаагүй түүнийг хэрэгжүүлэхэд орон нутаг дэмжлэг үзүүлэх;

- ✓ СОТ-ын ажил зохион байгуулах, хэвлэл мэдээллээр үйл ажиллагаагаа сурталчлах зардал байдаггүй;

ДҮГНЭЛТ:

- Хүүхдийн Номын Ордон нь соёл урлагыг хөгжүүлэх төр засгийн бодлого шийдвэр, /“Ном” хөтөлбөр/ номын сангийн соёлжилт үйлчилгээг сайжруулж, уншигч үйлчлүүлэгчдийн тав тухтай орчин нөхцлийг бүрдүүлэх, номын сангийн үйлчилгээнд шинэ арга техник нэвтрүүлэх, фондын баяжилтыг нэмэгдүүлэх чиглэлүүдэд анхааран ажиллаж ирлээ.
- Тайлангийн хугацаанд 49 ажил гүйцэтгэхээр төлөвлөснөөс 47 арга хэмжээ нь биелж гүйцэтгэл 95.9 хувьтай байна.
- Ирц, ном олголт энэ онд өссөн үзүүлэлттэй гарлаа. Өнгөрсөн жилд төрөлжсөн танхимын ирэгсдийг уншигчаар бүртгэн авч байсан нь уншигч тоон үзүүлэлт өндөр гарсан. Мэргэжлийн дээд шатны байгууллагаас зөвлөмж авсны үндсэн дээр бүртгэлийг давхардлыг арилгаж энэ жилээс зөвхөн нийтийн уншлагын танхимд ирэгсдийг үндсэн уншигчийг бүртгэж, төрөлжсөн танхимаар үйлчлүүлэгч ирэгсдийг ирцээр бүртгэн авах болсноор уншигч бууралттай харагдаж байна.
- Мөн үйлчилгээг өргөтгөхөд тээвэр шатахууны зардал, СОТА-д зайлшгүй хөрөнгө санхүүжилт хэрэгтэй байна. Иймд эдгээр зардлыг хэвийн үйл ажиллагааг хангахуйцаар төсөвт тусгаж өгөх шаардлагатай байна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН

2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн нэгжийн гүйцэтгэх ажил, үйлчилгээ, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	Үнэлгээ
1	2	3
НЭГ. БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ		
1.0. “Номын сангийн уншлага үйлчилгээг хэвийн явуулах нөхцөл бололцоог хангах" гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ:		
1. Уншлага үйлчилгээнд шинэлэг хэлбэрүүдийг нэвтрүүлж, тогтмол хэвийн явуулна	- Номын сангийн үйлчилгээг хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн чөлөөт сонголт болон захиалгаар хүргэж 1380 шинэ уншигч, 25672 ирэгсдэд, 36544 ном, сонин сэтгүүл олгож үйлчилсэн. - Төлбөрт үйлчилгээгээр нийт 1.203.000 төгрөгний орлого оруулсан. - Хүүхэд багачуудыг Монгол хэлний үгийн урлагийн гайхамшигт ертөнцөөр аялуулан, үг хэллэгийн арвин баялаг сантай танилцуулж, санасан бодсоноо чөлөөтэй илэрхийлэх, сэтгэхгүйг нь хөгжүүлэх, зохион бүтээн туурвих урлагт сургах зорилгоор Монголын зохиолчдын “Хурмаст тэнгэр” төвтэй хамтран “Тунгалаг анир” яруу найргийн наадмыг анх удаагаа зохион байгуулж 3 сум, ЕБ-ын дөрвөн сургуулийн 50 гаруй хүүхэд хамрагдаж ЕБ-ын I сургуулийн 9в ангийн сурагч Н.Нямдаваа тэргүүн байр эзлэв. - Тэмдэглэлт өдрүүд болон аймаг орон нутаг, байгууллагуудаас зохион байгуулж буй арга хэмжээнүүдэд сэдэвчилсэн болон ховор хуучин номын үзэсгэлэнгүүдийг давхардсан тоогоор 42 удаа гарган 2052 гаруй номыг 4828 хүнд хүргэн үйлчилсэн.	96%

	- Байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээ болон үйл ажиллагааг зурган хэлбэрээр байгууллагын фэйсбүүк хаягт байршуулж, интернэт хэрэглэгч 2162 иргэн номын сангийн үйл ажиллагааны талаар цаг алдалгүй мэдээлэл авч байна. - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон эцэг эхэд нь ном унших, номтой нөхөрлөхийн ач холбогдлыг танилцуулж, номын сантай танилцуулж даам, хөгжөөнт тоглоом тоглуулж урамшуулав. - Гэрээр ном олгох тасгийн чөлөөт сонголтын номыг тавиур тавиураар нь төрөлжүүлэн байрлуулж 1000 номыг үзүүлэн таниулах аргаар сурталчилсан. - Шинэ ирсэн номонд тухайн номын агуулгатай “Шинэ номын мэдээлэл” №1-3 товхимлыг гаргасан. - Хүүхдийн танхимын зарим номыг гэрээр олгох үйлчилгээг шинээр нэвтрүүлж журам гарган ажиллаж байна. Мөн уншигчийн дотно харилцааны дэвтэр гаргав. ГНО тасаг болон Хүүхдийн тасгийн 2011-2015 он хүртэл уншигчдын судалгааг хийсэн.	
2. Иргэд уншигчдын ном унших идэвхийг дээшлүүлэх	-Уншигч, үйлчлүүлэгчдийн ном сонголтоор Б.Сарантуяа “Тавилан”, “Сайн хан Бат”, Ш.Сандберг “Өөдөө тэмүүл”, Д.Карнеги “Шилдэг лекцүүд”, Б.Бёрн “Нууц” зэрэг номууд хамгийн их уншигдсан шилдэг номоор шалгарсан. Ухаарлын алхам төвд 3-р цэцэрлэгийн дарга У.Өлзийсайхантай хамтран "Бэлгийн дээд ном" хандивлах арга хэмжээ зохиов. 30ш ном хандивласан. ЕБ-н 3-р 12 жилийн англи хэлний багш Мөнхсүрэнтэй хамтран Азийн хөгжлийн сангаас ирсэн англи номоор 5б ангийн хүүхэд багачуудын дунд “Хэн сайн уншиж, орчуулж чадах вэ” арга хэмжээ зохиов. 9-р цэцэрлэгийн Б.Батнаран багштай хүүхдүүд номын санд ирж танилцан цээжилсэн шүлгүүдээ уншиж мөн Д.Данзанравжаатай холбоотой номын үзэсгэлэн үзэж танилцсан.	100%

	Д.Данзанравжаагийн богино хэмжээний шүлгээр хүүхдүүдэд гарын авлага бэлдэж өгөв. Номын баяраар 3-р цэцэрлэгтэй хамтран "Шилдэг ном" бүтээлийн уралдааныг 5-н бүлэгт зарлаж, ахлах А бүлгийн Б.Энхтүвшин багш тэргүүлж өргөмжлөл, дурсгалын зүйл гардаж авлаа. Номын баяраар "Тэргүүний уншигч-уулзалт" зохион байгуулав. Уулзалтанд 2013, 2014 оны “Д.Нацагдорж” тэмдэгтэн 1-р сургуулийн 5б ангийн У.Одбаяр, Б.Анар, Н.Номин нар оролцож ном уншихын ач тусын тухай найз нөхөддөө ярьж өгч хүүхэд бүр номын сайн анд нөхөр болохыг уриалав. 2015 оны Тэргүүний уншигчаар 2-р сургуулийн 5б ангийн сурагч Б.Гэрэлбаяр шалгарлаа. Мөн ЕБ-ын II сургуулийн 12В ангиин хамт олон “Тэргүүний уншигч анги”-аар шалгарлаа. Номын баярын үеэр 3-р багтай хамтран хөдөө малчдын 24 өрхийн 28 хүнд нүүдлийн номын сан ажиллуулсан. Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас зохион байгуулсан "ХҮНИЙ ТӨЛӨӨ-ЗӨВ ТУС" сарын аянд 60 ширхэг шинэ номоор үзэсгэлэн гаргаж олон нийтэд номоо сурталчилав Монголын зохиолчдын хурмаст тэнгэр төвийн тэргүүн, МЗЭ, МСНЭ -ийн гишүүн яруу найрагч Ш.Энхбаярын "Зүрхний хураангуй", "Сэтгэлийн хураангуй" шинэ номын баярт, Монголын яруу найрагчдын зохиол бүтээлийн дээжээс номын үзэсгэлэн гаргасан. Үндсэн фондын Ховор хуучин номонд хадгалагдаж буй “Монгол Ганжуур” 2 боть “Монгол Данжуур” 16 боть , “Монгол хаад” 11 боть болон Заваа Дамдин багшийн төвд хэлээр зохиосон 17 боть сүмбэн судрыг гороолж залах үйл ажиллагааг зохион байгууллаа. Аймгийн Хүүхдийн оролцооны байгууллагатай хамтран “Шоо эвлүүлэх” тэмцээн зохион байгуулж ЕБ-ын 2 дугаар сургуулийн 10а ангийн сурагч С.Мөнх-Эрдэнэ түрүүллээ. МУ-ын Ерөнхийлөгчийн 158 дугаар зарлигийн дагуу Номын баярын өдрийг тохиолдуулан номын	

	тэмдэглэл унших, хэрхэн унших талаар зөвлөмжийг бичиж ХНСангийн уншлагын танхим, Мэдээлэл самбар, байгууллагын цахим хаягаар уншигчдад хүргэсэн. - Дэлхийн номын өдөрт зориулан Дэлхийн номын өдөр тэмдэглэдэг болсон тухай мэдээллийг Төв номын сангийн цахим хаягаар иргэдэд хүргэж, байгууллагын гадна талбайд Шинэ номын үзэсгэлэн, Гэрээр ном олгох үйлчилгээ, Онч сургаал үгүүдээр “Оюуны чихэр” түгээж хамтран ажилладаг цэцэрлэгийн хүүхэд багачууд ая дуугаа өргөн барьсан. Уг арга хэмжээний талаар аймгийн ”MNT” телевизэд мэдээ өгсөн. - Аймгийн УЦУОШАлбаны хамт олныг “Тэргүүний уншигч-Хамт олон”, Говийн бүсийн асрамжийн газрын асруулагч Д.Мөнхдоржийг “Идэвхтэн уншигч”-аар шалгаруулан Өргөмжлөл гардууллаа. - Хүүхдийн байгууллагын 90 жилийн ойд зориулсан “Түүх өгүүлнэ“ үзэсгэлэнд “Пионерийн үнэн”, ”Хойчийг залгамжлагч” сонины хуучин дугааруудыг гаргаж сурталчилснаар хүүхдүүдэд зориулсан сонин хэвлэлээс түүхэн өгүүллэг, зурагтай танилцах боломжтой болж, үзэсгэлэнг 500 гаруй хүүхэд үзэж сонирхлоо. - 4-р цэцэрлэгийн Бэлтгэл бүлгийн 2 ангийн хүүхдүүдийн дунд танин мэдэхүйн АХА тэмцээнийг зохион явууллаа. Мөн "Цуутын цагаагч гүү" Монгол ардын үлгэрээр чанга уншлага хийсэн. - Гэрээр ном олгох тасгаас Их жанжин Д.Сүхбаатарын мэндэлсний 122 жилийн ойг тохиолдуулан ЕБ-ын II сургуулийн 1д ангийн сурагчдад Д.Сүхбаатарын намтар түүхээр тойм яриа хийсэн. Мөн номыг цэвэр ашиглах заавар зөвлөгөөг хүргэж хүүхэд бүрт номын хавчуурга бэлэглэв. - 2-р цэцэрлэгийн бэлтгэл бүлэгт нас сэтгэхүйн онцлогт тохируулсан ардын үгийн урлаг, хүүхдийн аман зохиолын төрөл болох үлгэр, оньсого, хэл зүгшрүүлэх үгс, жороо үг, дайралцааны ач холбогдлыг тайлбарлан өглөө.	

3. “Зохиогч-Уншигч” уулзалт зохион байгуулна	- МСҮТөвтэй хамтран “Зохиолч-Уншигч” уулзалт зохион явууллаа. 2015 оны “Алтан-Өд” наадмын Тэргүүн байрын шагналт зохиолч Ж.Заяабаатар, судлаач, яруу найрагч Г.Цагаандэрэм, Э.Эрдэнэдалай, яруу найрагч Н.Зүтгэл нар оролцлоо - МЗЭ үүсэн байгуулагдсаны 86 жилийн ойг тохиолдуулан Тэргүүний уншигч хамт олноор шалгарсан УЦУОША-ы хамт олонд “Шилдэг уншигч Өргөмжлөл”-ийг гардуулан өгч Монголын зохиолчдын “Хурмаст тэнгэр” төвийн гишүүн яруу найрагч Н.Зүтгэл, Сэр-Одын нэрэмжит шагналт яруу найрагч Б.Лхагвадорж нарын уран бүтээлчид шүлэг зохиолоо уншиж номын тухай сонирхолтой яриа өрнүүллээ. Уулзалтад хөдөө сумдын цаг уурч 40 хүн оролцсон. Номын баярыг угтан МУ-ын СГЗ, олон улсын сэтгүүлч Г.Жамъянтай "Зохиолч-уншигчдын уулзалт" зохион байгуулж, АШУҮИС, 1,2,3,5-р сургуулийн сурагчид, оюутнууд болон номын санчид оролцов. Д.Нацагдоржийн шагналт хүүхдийн зохиолч О.Сундуйтай "Уншигч-Зохиолч"-ийн уулзалтыг зохион байгуулж, уулзалтанд ЕБ-ын 1,2,3,5-р сургуулийн сурагчид болон 3,4-р цэцэрлэгийн хүүхдүүд, багш нар оролцож зохиолч намтар уран бүтээлээ танилцуулан хүүхэд багачууд зохиолчийн шүлэг, дууг хамтран дуулах, уран унших, өөрсдийн зохиосон шүлэг зохиолоос уншиж сонирхууллаа.	100%
4. Үндэсний уламжлалт тоглоом наадгайг сэргээх	- Үндэсний уламжлалт шагайн наадгайг хүүхэд багачуудад өвлүүлэх, хүүхэд багачуудад уламжлалт тоглоомыг өвлүүлэх, юмс үзэгдлийг танин мэдэх, дүрслэн бодох, эргэн санах, сэтгэн бодох ур чадварыг нь хөгжүүлэх, туслах зорилгоор ЕБ-ын сургуулийн сурагчдын дунд 3 насны ангилалаар “Шагайн наадгай” зохион явууллаа. - МСҮТ-ийн оюутнуудын дунд “Дөрвөн бэрх” тэмцээнийг зохион явуулж 160 оюутан сурагч хамрагдсан.	100%

5. Хөгжлийн бэрхшээлтэй болон алслагдсан иргэдэд нүүдлийн номоор үйлчлэх	- Аймгийн ШШГАлба, УЦУОШАлба, Улаан Загалмайн хороо, 4,9,3,8 дугаар цэцэрлэгүүд болон МСҮТ, Сайншанд сумын 3-р багийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Зөөврийн номын сангийн үйлчилгээг 680 номыг 900 гаруй хүнд хүргэн үйлчилсэн. - Өргөн сумын нутаг ”Улаан худаг” багийн малчдад 3-р багтай хамтран нүүдлийн номын сан мөн Сайхандулаан сумын иргэдэд нүүдлийн номын сангийн үйлчилгээ үзүүллээ.	93%
2.0. “Номын сангийн орчны нөхцөл, номын хадгалалт хамгаалалтын стандартыг сайжруулна” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ:		
1.Уншигчдын хэрэгцээнд нийцсэн болон ховор хуучин ном хэвлэлээр баяжилт хийх	- Уншигч, үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээг хангах, нөхөн бүрдүүлэх шаардлагатай номоор баяжуулах зорилгоор уншигч үйлчлүүлэгчдээс номын баяжилтын талаар санал, асуулгыг авч худалдаагаар 285 ширхэг, 4060150 төгрөгний, хандив болон бэлгээр 213 ширхэг, 918500 төгрөгний номоор баяжилт хийсэн. - Гэрээр ном олгох тасгаас аймгийн нутгийн зөвлөлд хүсэлт илгээсний дагуу нутгийн зөвлөлөөс эрхлэн гаргаж буй ном, сэтгүүлийг манай номын санд хандивладаг болсон. Тухайлбал: Стив Жобсын Бүрэн цадиг, Дорноговь сэтгүүл, Шинэ алхам 2016, Монгол малчны өврийн ном гэх мэт	100%
2. Ном хэвлэл сэргээн засварлалт	- Нийт фондуудын 3191 ном, хэвлэлийг сэлбэн зассан. - Гэрээр ном олгох тасаг, Хүүхдийн фондын 36053 номыг Номын сан номзүйн ангилалаар ангилж номын нүүр хуудсанд ангилалыг бичсэн.	91%
3. “Номын сангийн орчны	- БСШУСайдын 441 дүгээр тушаалаар батлагдсан Анхан шатны маягт бүртгэлүүдийг хөтлөх журмын дагуу бүртгэлүүдийг үнэн зөв, цэвэр нямбай хөтөлж байгаа.	97%

нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага” стандарт MNS 5474:2007, MNS ISO 11799:2007 шаардлагыг ханган ажиллах	- 45063 ширхэг номын үнэлгээг данснаас харж номын тооцооны хуудас болон ар талд бичсэн. - Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага стандартыг хэрэгжүүлэн номын тоосжилт хуурайшилтаас сэргийлэн саванд ус хийж тавих, агааржуулагч ажиллуулах, гэрэл, чийгээс хамгаалан ажилласан. Фондуудын 28500 ширхэг номын тоосыг зориулалтын уусмалаар арчиж цэвэрлэсэн. Аймгийн засаг даргын 2015 оны А/160 захирамжаар Ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор дэмжлэг үзүүлсэн ба Хяналтын камер-8ш, Авaарын гэрэл-2ш, фондын чийгшүүлэгч-4ш, агаар цэвэршүүлэгч-2ш, шавж устгагч-ариутгалын төхөөрөмж-1ширхэгийг авсан.	
4. Фондын хадгалалт хамгаалалтын стандарт, орчин нөхцлийг бүрдүүлэх	- Аймгийн Төв номын сангийн фондын хадгалалт хамгаалалтын стандарт, аюулгүй байдал, орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор нийт 8ш камер байрлуулан ажиллаж байна. - Аймгийн ОБХэлтсийн зөвлөн туслах үйлчилгээ, зөвлөмжийн дагуу байгууллагын галын хоруудыг шинэчлэн авч байрлуулсан ба ажилчид галын хор ажиллуулан туршиж үзсэн. “Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага стандартын дагуу 137820 төгрөгний ариутгалын багаж, бодисыг худалдан авсан.	91%
3.0 “Номын сангийн үйл ажиллагаанд орчин үеийн мэдээллийн технологи нэвтрүүлэх” стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ:		
1.“Иргэдийн хөгжил төв”-	- Сайншанд сумын 3-р багийн 16 иргэнд компьютерийн анхан шатны сургалт явууллаа. - Компьютерүүдийг форматлаж вирусны 2017 оны 01 сар хүртэлх лицензтэй программ суулгасан	89%

ийн чадамжийг сайжруулах	-Хичээлийн компьютерийг үйлчлүүлэгчдэд үнэ төлбөргүйгээр ашиглуулах үйлчилгээг шинээр нэвтрүүлж 69 үйлчлүүлэгч 207 цаг үйлчлүүлсэн байна. - Байгууллагын цахим хаягаар нийт 24 хүнд лавлагаа, асуултын хариу өгсөн. - Интернэт үйлчилгээний компьютеруудад Handy cafe цагийн программ суулган ажиллаж байна.	
2.Электрон каталогийн программыг нэвтрүүлэх	- 13 сумын электрон каталогийн “Monbiblio” программд оруулсан 53997 номыг яамны сервэрт байрлууллаа. Одоогоор 6 сум номоо бүрэн шивж оруулсан ба сумдын ном шивэлт 65,9%-тай явж байна. - Сумдын электрон каталогт оруулсан номын файлыг back up хийж архивласан. - Гэрээр ном олгох тасаг болон Хүүхдийн тасгийн фондуудын нийт 25129ш номыг электрон каталогийн Lib4U программд оруулан иргэд уншигч номоо цаасан каталог шүүх шаардлагагүй болон цаг хугацааг хэмнэж байна. Нийт тасаг танхим, фондын 45405ш ном Lib4U программд оруулаад байна.	92%
3.Албан хэргийн хөтлөлт, хадгалалтыг сайжруулах	- Аймгийн Архивын тасгийн Албан хэрэг хөтлөлтийн сургалтанд байгууллагын ажилчдыг бүрэн хамруулсан. - Ажилтан бүрээс сар, улирал, жилийн тайланг албан хэрэг хөтлөлтийн стандарт, зөв бичгийн дүрмийн дагуу бичиж байгууллагын захиргаанд ирүүлж байх, бичиг хэргийн стандарт, соёлыг эзэмшин ажиллах шаардлагыг тавин ажиллаж байна.	70%
4. Хууль, дүрэм, журмын хэрэгжилт	- Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам, стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	100%
5.Гадаад харилцааг	Дорно-Сибирийн Соёл урлагийн Улсын Академид айлчлах Монгол Улсын соёл урлагийн байгууллагын 56 хүний бүрэлдэхүүнд аймгийн Төв номын сангийн арга зүйч Л.Цэнд-Аюуш,	100%

хөгжүүлэх	мэдээллийн ажилтан Г.Энхмэнд нар багтан Улаан-Үүд хотноо 03 сарын 30-наас 04 сарын 4-ны өдрүүдэд айлчлан Буриад улсын Үндэсний номын сантай танилцаж туршлага судаллаа.	

ДОРНОД АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН

2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг.Соёлын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх арга зүйг сайжруулах:

Зорилт: Аймгийн сургууль, аж ахуйн нэгж, сумдын нийтийн, ЕБС-ийн номын санчдыг мэргэшүүлэх, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, соёлын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх

Хэрэгжилт: Аймгийн засаг даргын 2015 оны А/33тоот захирамжийг хэрэгжүүлэн Хэрлэн сумын ЕБС-ийн захирал, номын санчдад "Ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн үлгэрчилсэн дүрмийн хэрэгжилт, стандартын зарим заалтууд, номын сангуудын өнөөгийн нөхцөл байдал, анхан шатны бүртгэл хөтлөлтийн талаарх сургалтыг 2015 оны 02 дугаар сарын 24 нд зохион байгуулсан. Сургалтанд ЕБ-ын 9 сургууль, хувийн хэвшлийн 2 сургууль нийт 11 сургуулийн захирал, номын санчид хамрагдлаа.

Сургалтанд мэргэжлийн хяналтын газрын соёл урлагийн хяналтын байцаагч Б. Мангалжав оролцон ЕБС-иудын номын сангийн фонд баяжилт, номын сангийн үйлчилгээний стандарт (MNS 5742:2007)-д нийцүүлэх, стандартын зарим заалтууд, номын санчид хавсарсан ажлыг болиулж дан болгож ажиллуулах журам, ЕБС-ийн үлгэрчилсэн дүрмийг баримтлан хэрэгжүүлэх талаар, аймгийн номын сангийн бүртгэл мэдээллийн номын санч, арга зүйч нар каталоги зохион байгуулалт, соёл олон нийтийн ажлын зохион байгуулалт зэрэг сургалтыг зохион явуулсан.

Сумдын ЕБСургуулийн сургалт:

Сумдын ЕБС-ийн номын санчдын мэргэшүүлэх сургалтыг 2015 оны 01 дүгээр

сарын 23-24ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтанд 13 сумын номын санчид хамрагдаж анхан шатны бүртгэлүүдийг хөтлөх аргачлал дадлага, соёл олон түмний ажлыг зохион байгуулах, номын сан ном зүйн ангилал, номын сангийн каталог зохион байгуулалт, ном тодорхойлох журам, номын фондын хадгалалт хамгаалалт зэрэг хичээлийг тус номын сангийн бүртгэл мэдээллийн номын санчид хичээл зааж сургалтыг зохион явуулсан. Сургалтанд хамрагдсан номын санчдаас дараахь саналуудыг бидэнд тавьсан юм

1. ЕБС-ийн номын сангуудад цахим программтай болгох

2.Улаанбаатар хотод мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах

3. Номын санчдын дунд спортын тэмцээн зохион байгуулах

Номын сангийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх сургалт:

Монголын номын сангуудын консорциум, Монголын номын санч, мэдээллийн ажилтнуудын холбоо, Аймгийн төв номын сан хамтран номын санчдын сертификаттай сургалтыг 2015 оны 06-р сарын 12-14-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Энэхүү сургалтын нээлтэнд Зүүн бүсийн Мэргэжлийн хяналтын соёл хариуцсан улсын байцаагч Б.Мангалжав, Боловсролын газрын соёл хариуцсан мэргэжилтэн Т.Оюунбат, Аймгийн төв номын сангийн захирал Ж.Цагаан, Соёлын сургуулийн албаны мэргэжилтэн Б.Амарзаяа нар нээн үг хэллээ. Сургалтанд Хэрлэн сумын ЕБС, Хилийн цэргийн, сумдын нийтийн болон ЕБС-ийн, аймгийн төв номын сангийн нийт 37 номын санчид хамрагдлаа.

Соёлын сургуулийн сургалтын албаны мэргэжилтэн Б.Амарзаяа “Номын сангийн үйлчилгээнд уншигчдын оролцоог нэмэгдүүлэх нь”, “Номын санчийн харилцаа, хандлага”, “Ном сэлбэн засахад хэрэглэгддэг материал, ном сэлбэн засахад баримтлах ерөнхий шаардлага”, Д.Нацагдоржийн нэрэмжит хотын нийтийн номын сангийн ном зүйч В.Түвшинтогтох, “Номын сангийн үйл ажиллагаанд хөтлөгддөг бүртгэлүүд, тэдгээрийг хөтлөх аргачлал”, “Ном зүйн бичилтийн стандарт”, Монголын номын сангуудын консорциумын захирал Т.Хайдав “Номын сангийн каталог зохион байгуулалт”, Ном хөтөлбөрийн хэрэгжилт, ном унших арга, сумдын номын сангуудад хэрэгжээд байгаа “Monbiblio программын зарим асуудал”, МУБИС-ийн номын сангийн захирал Ж.Баатарсүрэн “Ном хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах”, 30 ном уншъя хөтөлбөр боловсруулах, Ном хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах асуулт, файл боловсруулах, ном хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх гэсэн лекцүүдийг тус тус заасан. Сургалтын

төгсгөлд номын санчдын дунд чөлөөт хэлэлцүүлэг явуулж номын санчдад баяр хүргэн сертификат гардууллаа.

Онцгой байдлын хэлтсийн галын аюулгүй байдлыг хангах сургалт:

Аймгийн онцгой байдлын газартай хамтран үзүүлэх сургалтыг 2015 оны 01 дүгээр сарын 14 зохион байгууллаа. Үзүүлэх сургалтаар болзошгүй аюулын үед дуудлага хэрхэн өгөх уншигчдыг яаж авран гарах, гарц тэмдэг тэмдэглэгээ таних галын хорыг хэрхэн ажиллуулах талаар үзүүлэх сургалтыг хийлээ.

Зүүн бүсийн аймгуудын “Ажил мэргэжлийн өдөрлөг”

Зүүн бүсийн аймгуудын номын санчдын “Ажил мэргэжлийн өдөрлөг” сургалтыг 2015 оны 05-р сарын 1,2-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Чингис хотод 3 дахь жилдээ Мэдээллийн эрин зуунд номын санчдын мэдлэг, харилцаа, хандлагыг өөрчлөх, мэдээллийн идэвхтэй зуучлагч байхад номын санчдын мэдлэг оюуныг дээшлүүлэх, чадавхжуулах бүсийн хэмжээнд харилцан ажлын туршлага солилцох зорилгоор амжилттай зохион байгуулагдлаа. Өдөрлөгт Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгуудын төвийн болон сумдын нийтийн номын санчид оролцлоо.

Ажил мэргэжлийн өдөрлөгийн нээлтийг Хэнтий аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Жавхлан, Нийтийн номын сангийн захирлыг түр орлон гүйцэтгэгч Ц.Одонтуяа, ӨМӨЗОрны Хөлөнбуйр хотын Шинэ барга баруун хошууны боловсролын төвийн мэргэжилтэн Сэчин нар нээж үг хэллээ. ”Ажил мэргэжлийн өдөрлөг” номын санчдын сургалт, ур чадварын тэмцээн, ”Барга угсаатны түүх, ёс заншил” сэдэвт илтгэлийн уралдаан, гар бөмбөгийн тэмцээн тус тус зохион байгуулагдлаа.

Ур чадварын тэмцээнд: номын сангийн ангилал, каталоги, ном зүй, номын санд хөтлөгддөг нэгбүрчилсэн бүртгэл, нэгдсэн бүртгэл, номын сангаас зохион байгуулах соёл мэдээллийн ажил, шинэлэг санааг дэвшүүлсэн илтгэл, багуудын мэндчилгээ, жүжигчилсэн тоглолт гэсэн төрлүүдээр явагдаж шүүгчдээр СУИС-ийн Соёлын боловсролын сургуулийн багш, Монголын номын сангийн консирциум / Т.Хайдав, Д.Нацагдоржийн нэрэмжит хотын номын сангийн мэдээлэл технологийн мэргэжилтэн, Монголын номын сангийн консорциум Л.Гантулга,Удирдлагын академийн номын сангийн захирал Ч.Мөнх-Эрдэнэ нар шүүн явуулж тэргүүн байранд Хэнтий аймгийн нийтийн номын сан Өргөмжлөл мөнгөн шагнал,
дэд байрнд Сүхбаатар аймгийн нийтийн номын сан Өргөмжлөл мөнгөн шагнал, гутгаар байр Хэнтий аймгийн сумдын нийтийн номын сан Өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдаж байр эзэллээ.

Номын санчдын сургалт Орон нутгийн номын сан, Төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, Уламжлалт үйлчилгээнээс мэдээллийн технологид суурилсан үйлчилгээнд шилжих нь, Номын санчдын ёс зүй, харилцаа хандлага, Номын сангаас хүүхэд залуусын дунд явуулж болох шинэлэг ажлуудын загвар гэсэн сургалтуудыг тус тус зохион байгууллаа.

ВОЛЕЙБОЛЫН ТЭМЦЭЭН:

Волейболын тэмцээн эрэгтэй, эмэгтэй холимог 4 баг оролцож, Тэргүүн байр Дорнод аймгийн төв номын сан өргөмжлөл мөнгөн шагнал, дэд байр Хэнтий аймгийн нийтийн номын сан Өргөмжлөл мөнгөн шагнал, гутгаар байр Дорнод аймгийн сумдын нийтийн номын сан Өргөмжлөл мөнгөн шагналаар тус тус шагнагдлаа.

Дүгнэлт: Аймаг сумдын номын санчид УБ хотруу явж зардал чирэгдэл гаргахгүй аймагтаа мэргэшүүлэх сургалтанд хамрагдаж мэдлэг мэргэжлээ дээшлүүлэн, номын сангийн данс бүртгэл, үнэн зөв хөтлөн бусад аймгуудаас туршлага судлан шинэ санаа санаачлага гарган ажиллах болсон.

Хоёр: Төрөөс баримтлах соёлын бодлогын хэрэгжилтийг хангах, байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд:

Зорилт: уншлага үйлчилгээ шинэ дэвшилтэд үйл ажиллагаанд шилжинэ.

Хэрэгжилт: Нийтийн уншлагын танхимыг чөлөөт сонголттой болгох зорилгоор номын ялтас авах зардал 1500000 төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлэн ойрын фондны 8891 номонд ялтас нааж идэвхжүүлэн чөлөөт сонголтын үйлчилгээнд орж,уншлага үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.

Ном хөтөлбөр:

БСШУ-ны сайдын 2012 оны А/51 тушаалаар ном хөтөлбөрийн хүрээнд хүүхдийг номтой нөхөрлүүлэх, номыг бүтээлчээр унших арга зүйд сургах, ном хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэн тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа Хэрлэн сумын сургууль, цэцэрлэгүүдийг Дорнод аймгийн иргэний нийгмийн зөвлөлөөс санаачлан аймгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэн аймгийн БСГ, Хүүхэд, гэр бүл хөгжлийн

хэлтэс, Хэрлэн сумын Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулж хамтарсан баг сургууль, цэцэрлэгүүдийн хийж буй ажлын явцтай танилцаж үр дүнтэй бүтээлчээр ажиллаж буй сургууль, цэцэрлэгүүдийг шагнаж урамшуулах ёслолын ажиллагааг 2015 оны 05-р сарын 13-нд номын сангийн соёл олон нийтийн танхимд зохион байгууллаа.

Энэхүү үйл ажиллагааг 12-р цэцэрлэгийн бяцхан багачууд ном дуугаар мэндчилэн Дорнод аймгийн иргэний нийгмийн байгууллагуудын зөвлөлийн дарга Бүжин нээн үг хэллээ. Уралдаанд Хэрлэн сумын нийт 8 цэцэрлэг, 6 сургуулийн тайланг мэйл-ээр хүлээн авч 5 шалгуур үзүүлэлтийн дагуу ажлын хэсэг хуралдаж эцсийн шалгаруулалтыг сургууль, цэцэрлэг тус бүр очиж танилцаж уралдаанд шалгарсан сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг Мижи орон нутгийн телевизээр сурталчилан, хийсэн бүтээлүүдээр нь үзэсгэлэн гаргалаа.

Цэцэрлэг төрөлд Тэргүүн байр 12-р цэцэрлэг, Өргөмжлөл мөнгөн шагнал 300.000төгрөг, дэд байр 3-р цэцэрлэг Өргөмжлөл мөнгөн шагнал 200.000 төгрөг**,** гутгаар байр 1-р цэцэрлэг Өргөмжлөл мөнгөн шагнал 100.000 төгрөг,

ЕБСургуулийн төрөлд Тэргүүн байр Хан-уул цогцолбор сургууль Өргөмжлөл мөнгөн шагнал 500.000 төгрөг**,** Дэд байр 11-р сургууль өргөмжлөл, мөнгөн шагнал 300.000 төгрөг, гутгаар байр 2-р сургууль өргөмжлөл, мөнгөн шагнал 100.000 төгрөгөөр тус тус шагнагдлаа.

“Миний номын өргөө”:

Дэлхийн банкны санхүүжилттэй Японы Хүүхдийн Ивээх Сангаас хэрэгжүүлж буй “цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа 5-6 настай хүүхдүүдийг гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх нь” төслийн хүрээнд “Миний номын өргөө”-г 2015 оны 5 сарын 8-нд эцэг эхтэйгээ ном ирж унших танхимд “Миний номын өргөө”-г байгууллаа. Танхимыг нээх ёслолын арга хэмжээнд БСШУ-ны дэд сайд Я.Төмөрбаатар, Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөрийн захирал Мицуаки Тоёода, БСШУ-ны сургуулийн өмнөх, бага боловсролын хэлтсийн дарга Гантулга, Японы Хүүхдийн Ивээх Сангийн боловсрол хөтөлбөрийн менежер Ц.Гэрэлтуяа, Азийн Хөгжлийн банкны төслүүдийн зөвлөх Бандий, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэгийн захирал Батжаргал, Насан туршийн боловсролын төвийн захирал Болортунгалаг, Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Бат-өлзий, Хэрлэн сумын Засаг даргын орлогч Т.Энхтөр, Өвөрхангай аймгийн БСГ-ын дарга Самбуу-Ёндон , Зүүн бүсийн МХГ-ын соёл хариуцсан Улсын байцаагч Мангалжав нар оролцсон.

Багцад хамрагдаж буй хүүхдүүд 1 багцыг 10 өдөр хэрэглэнэ.10 хоноод багцаа солино. Багцанд 3 тоглоом, 10 ном байгаа. 6 сарын дараа /180 хоног/ 30 шинэ тоглоомоор тоглож, 100 ширхэг үлгэрийн ном уншсанаар тоо тоолох, өнгө ялгаж, дүрс эвлүүлэх мөн сонсох чадварт суралцаж үгийн сан нэмэгдэнэ.

“Та өөрөө багш”, “Би чадна” номыг хэрэглэснээр 96 өдөр 208 дасгалаа амжилттай хийж дуусгаж сургуульд ороход бэлтгэгдлээ гэж үзлээ.

Энэхүү төслийн 2 дахь ээлжийн 2015 оны 10 дугаар сарын 16-наас эхлэн энгийн багцад 9, хөгжлийн бэрхшээлтэй 5, нийт 14 хүүхдийг хамруулан үнэлгээ, судалгаа хийгдэж, ном тоглоомын багцаа тарааж өгөөд байна.

Номын баяр:

Уламжлалт зан заншлаа хөгжүүлж, ард иргэд, хүүхэд залуусын ном эрдэмд эгээрэн нөхөрлөх, ном унших арга зүйг түгээн дэлгэрүүлэх зорилгоор МУ-ын Ерөнхийлөгчийн 158 дугаар зарлигийн дагуу "Номын баярын өдөр"-ийг 4 дахь жилдээ Боловсрол, соёлын газартай хамтран олон нийтээр 2015 оны 09-р сарын 19-нд Аймгийн төв номын сангийн гаднах талбайд зохион байгууллаа. Номын баярын үйл ажиллагааг Боловсрол, соёлын газрын мэргэжилтэн Б.Эрдэнэтуяа, Аймгийн төв номын сангийн Арга зүйч Ж.Соня нар нээн мэндчилгээ дэвшүүллээ.

Номын баярын арга хэмжээнд: үнэт ховор ном, шинэ ном, ЕБС-ийн сурагчдын хичээлээс гадуур унших номын үзэсгэлэн, залуучуудын унших номын

үзэсгэлэн,11,14-р цэцэрлэгийн эцэг эхчүүдийн “Залхуу зараа”, ”Өвгөний хийсэн бүхэн буруугүй” хуруун хүүхэлдэй дүрийн тоглолт, ахмад уншигчдын дунд “Элсэн цаг”асуулт хариултын тэмцээн, номын сангийн гадна талбайд чөлөөт уншлага зэрэг олон үйл ажиллагааг зохион байгуулсан.

Номын баярыг угтаж зохион байгуулсан уралдаан тэмцээний шагнал гардуулах үйл ажиллагаа:

Хан-уул цогцолбор сургуулийн Бумгарав багштай 3г ангийн хамт олон, 6-р сургуулийн Урантогос багштай 10а ангийн хамт олон идэвхтэн уншигч хамт олон шалгарч “Өргөмжлөл” дурсгалын зүйлээр, ахмадын баярыг угтаж ахмад уншигчдын дунд зохион байгуулсан “Элсэн цаг” асуулт хариултын тэргүүн байр 9-р багийн өндөр настан Д.Бишхорлоо, 2-р багийн иргэн И.Сумъяа нар шалгаран Өргөмжлөл мөнгөн шагнал /18.000/ төгрөгөөр, дэд байр 7-р багийн иргэн Ц.Зоригт,Ё.Чимгээ Өргөмжлөл 14.000 төгрөг тус тус шагнасан. Мөн Орон нутгийнхаа зон олонд оюуны их хөрөнгө оруулдаг зохиогчдод жил бүр уламжлал болгон ГЭРЭГЭ гардуулдаг билээ. Зохиогч М.Мөнхбаатарийн “Гэрээр эмчлэх энгийн аргууд” ном нь түүний анхны уран бүтээл бөгөөд энэ номондоо гэрээр эмчлэх энгийн аргуудын талаар 28 зөвлөмжийг ард иргэд үйлчлүүлэгчдийнхээ хүсэлтээр уншигч олондоо оюуны их хөрөнгө оруулсанд талархан ГЭРЭГЭ гардууллаа.

Хүүхэд залуучуудыг төрөлх нутаг орныхоо арвин баялаг түүх соёлоо хайрлан хамгаалж, бахархах үзэл санааг төлөвшүүлэх зорилгоор Их дээд сургуулийн оюутнуудын дунд “Миний нутгийн бахархал сэдэвт шүлгийн уралдааныг зарласан

шүлгийн уралдаанд нийт 10 гаруй оюутнуудын бүтээл оролцон. тэргүүн байрын шагнал Миний нутгийн бахархал шүлэг Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн төвийн 1-р курсийн оюутан Ө.Одмаа Өргөмжлөл 25.000 мөнгөн төгрөг, дэд байрын шагнал Миний нутаг Эрдэнэцагаан Дорнод их сургуулийн 4-р курсийн оюутан Д.Жаргалан Өргөмжлөл 15.000 мөнгөн төгрөг, Гутгаар байрын шагнал Би айнам Дорнод их сургуулийн 2-р курсийн оюутан Анхцацрал Өргөмжлөл 10.000 мөнгөн шагналаар тус тус шагнагдлаа.

Аймгийн төвөөс алслагдсан малчдын хүүхдүүдийг гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрт хамруулахаар Төв номын санд Миний номын өргөөг амжилттай ажиллуулж анхны төгсөгчдийн хүүхдүүддээ Талархал гардууллаа.

Номын баярын үйл ажиллагааг орон нутгийн Мижи телевизээр сурталчилан нэвтрүүллээ. Ном хандивлах ёслолын ажиллагаа.

Дүгнэлт:

- аймгийн хэмжээний сургууль цэцэрлэгүүд ном хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхааран ном унших арга зүйгээр ханган ажилласан,

-миний номын өргөөг төслийг номын сан дээр байгуулснаар цэцэрлэгт хамрагдаж чадаагүй хүүхдүүд хамрагдаж сургуульд бэлтгэгдэж эцэг эхтэйгээ ирж ном унших орчин бүрдсэн.

-уншигчид өөрсдөө сонирхосон номоо өөрсдөө чөлөөтэй авч унших боломж бүрдсэн.

Гурав: Соёлын үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах

Зорилт: Соёл олон нийтийн ажлуудыг нийтийн хүртээл болгох, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах, Дорнодоос төрсөн зохиолчдын номыг сурталчилах.

Хэрэгжилт: Үйлчилгээний хүрээг өргөжүүлэн зөөвөр номын сан, номын хур аяныг зохион явуулах, анги хамт олноор номын сангийн уншигч болгон ном унших идэвхийг өрнүүлэх, номын сан хоорондын ном солилцоо, гэрээр ном олгох, лавлагаа ном зүйг сайжруулан,соёл олон нийтийн ажлуудыг зохион явуулсан. Үүнд:

Уншлага үйлчилгээ: Тайлангийн хугацаанд 4307 байнгын уншигч, 66560 ирцэд, 84829 ном олгож, номын сангийн үйлчилгээг сурталчилан албан байгууллага аж ахуйн нэгж сургууль, иргэдэд номын хур буулган, шинэ ном мэдээ мэдээллийг хүргэн, номын санчдад арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. 24 анги хамт олныг номын сангийн уншигч болгосон. 2015 оны 09 дүгээр сарын 01-нээс ЕБСурагчид үнэ төлбөргүй карт нээж үйлчилж байна.

Уншигч ном олголтыг мөн үеийнхтэй харьцуулахад байнгын уншигч 22%-иар, ном олголт 9%-иар буурсан, ирц 9.4%-иар өссөн байна.



	Уншигч	Ном олголт	Ирц		
2014	3522	93766	62222		
2015	4307	84829	66560		
Column1					
Column2					
Column3					

Ном солилцоо, зөөвөр: Сүхбаатар аймгийн номын санд-15, Дорнод их сургуульд-68, Политехник 5, орос ном 40, Петрочайна дайчин тамсаг-156, ХЦ-0132 ангид-452, өндөр настан, ахмадуудад-105, 327-р ангиас соёмбо сонин 50 дугаар, эх орны манаа 30дугаар, авч цэргийн байгууллагаас тэтгэвэрт гарсан ахмадууд уншуулж нийт 1171 ном зөөврөөр олгосон.

Солилцоогоор 1,2,5,8 хан-Уул сургууль, Политехник, 0198 анги, Матад, хөлөнбуйр, Чойбалсан суманд солилцоогоор гэрээ байгуулан 972 ном солилцсон.

Лавлагаа ном зүй: уншигчдаас асуусан мэдээллийг амаар болон бичгээр 253 хүнд, электрон каталогоос гадаад ном 5 удаа, цахимаар 94 хүнд, уламжлалт болон цахим сурах талаар 30 хүнд лавлагааг өгсөн.

Явуулын үйлчилгээ, Номын хур

Алслагдсан сум багийн иргэд, албан байгууллага аж ахуйн нэгжид соёлын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор "Номын элч" явуулын, зөөврийн номын сангийн үйлчилгээг Ерөнхий боловсролын 1, 2, 5, 6, 8, 11, Хан-Уул цогцолбор сургууль, МСҮТөв, Дорнод их сургууль, Политехникийн коллеж, ХЦ-ийн 0132-р

анги, Татварын хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэс, Дархан газар, Ус цаг уур шинжилгээний газар, Гааль, Гэр бүл хөгжлийн хэлтэс, ОБХэлтэс, Хэрлэн сумын ЗДТГазар, Ахмадын чөлөөт төв зэрэг аж ахуй нэгжүүдэд удирдамж төлөвлөгөөний дагуу номын сангуудын үйл ажиллагааг танилцуулан, шинэ номын үзэсгэлэн, асуулт хариултын тэмцээн, тата тунгаа, 5 хором 5 асуулт зэрэг уралдаан тэмцээнийг зохион явуулж, 694 уншигчдад 2239 ирцэд 1705 номоор үзэсгэлэн гаргаж, 756 карт шинээр нээж номын хур буулгасан.

<u>**Мэдээлэл сурталчилгаа**</u>:

Соёл олон нийтийн ажлууд, тэмцээн уралдаан, зохион байгуулагдсан үйл ажиллагааны талаар мэдээг байнга мижи телевизээр сурталчилан олон нийтэд хүргэсэн.

Уран жиргээ:

Монгол улсад хүүхдийн байгууллагын хөдөлгөөн үүсч хөгжсөний 90 жилийн ой, Баян Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 90 жилийн ой, Баян-Уул сумын уугуул Монголын зохиолчдын эвлэлийн шагналт яруу найрагч Ц.Бадамдорж агсаны нэрэмжит “Уран жиргээ-2015″ уран уншлагын аймгийн наадам 2015 оны 02 сарын 26нд буюу VII жарны Галзуурууллагч хэмээгч Хөхөгчин хонин жилийн билэгт сайн шинийн наймны өдөр Аймгийн хөгжимт драмын театрт амжилттай зохион байгуулагдлаа. Уран жиргээ наадамд 71 хүүхэд оролцож цэцэрлэг, сургуулийн бага нас, ахлах нас гэсэн ангиллаар шалгаруулсан.

Хүрэл тулга-2015 Өсвөрийн яруу найрагчдын наадам

Өсвөрийн яруу найрагчдыг тодруулдаг “Хүрэл тулга” наадам 2015 оны 02-р сарын 27-нд Аймгийн төв номын сангийн соёл олон нийтийн танхимд зохион байгуулж Баян-Уулсумын уугуул, МЗЭ-ийн шагналт яруу найрагч Ц.Бадамдорж агсны өөрийнх нь хэрэглэж байсан эд зүйлсээр нь үзэсгэлэн гаргаж, уран уншдаг бяцхан багачууд, өсвөрийн яруу найрагч хүүхдүүдээ зориулж Аймгийн төв номын сангаас яруу найраг, шүлгийн номуудаар үзэсгэлэн гаргалаа.

Энэ удаагийн наадмыг Аймгийн Хүүхэд,гэр бүл хөгжлийн хэлтэс, Дамдинсүрэнгийн нэрэмжит аймгийн номын сан, Баян-Уул сумын уугуул, МЗЭ-ийн шагналт яруу найрагч Ц.Бадамдорж агсны гэр бүл, Баян-Уул сумын ЕБС, Дорнод сонин хамтран зохион байгуулсан. Наадам сургуулийн ахлах, дунд насны ангилалаар явагдаж шилдгүүдээ тодруулсан юм.

Нийтдээ 70 гаруй хүүхэд оюун ухаан, авъяас билгээ уралдуулснаас ахлах насанд Баян-Уул сумын сурагч Батхүрэл түрүүллээ. Энэхүү наадмыг МЗЭ-ийн шагналт яруу найрагч Ц.Бадамдорж агсны гэр бүл ивээн тэтгэж, Аймгийн засаг дарга С.Ганбат мэндчилгээ дэвшүүлж талархан дурсгалын зүйлсийг гардуулсан.

Бага насны хүүхдүүдийг ном унших идэвхийг өрнүүлэх, үлгэрээр дамжуулан гоо зүйн мэдрэмжийг олгон, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх зорилготой үлгэрийн цагийг тогтмол ажиллуулан Хэрлэн сумын ЕБС-ийн 1, Хан-Уул сургуулийн 1, 3 анги, 1, 2,10,12,14 цэцэрлэгийн 449 хүүхдэд 16 удаа үлгэр уншиж өгч, шатар даам

тоглох цагийг ажлуулан хүүхдийн сэтгэн бодох чадварыг хөгжүүлэж байна.

- **Оюуны чихэр**

”Оюуны чихэр”-ийг байнга ажиллуулж байна. /ертөнцийн гурав, зүйр цэцэн үг/--ээр хүүхдүүдэд хүргэж байна. Оюуны чихэрийг тогтмол хэрэглэж сурлаа.

Дэлхийн хүүхдийн номын баяр:

Дэлхийн үлгэрийн хаан Дани улсын их зохиолч Ханс Крестианс Андерсений мэндэлсэн өдөр 4 дүгээр сарын 2-ныг Дэлхий дахинаа олон улсын хүүхдийн номын баярын өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлдэгтэй холбогдуулан Хэрлэн сумын цэцэрлэгүүдийн эцэг эхчүүдийн дунд “Дэлхийн шилдэг үлгэр”-ээр хуруун хүүхэлдэй дүрийн тоглолтыг 2015 оны 04 дүгээр сарын 06 нд төв номын сангийн соёл олон нийтийн танхимд зохион байгууллаа. Тус уралдааны Тэргүүн байрын шагналыг Хаан Банк, Дэд, Гутгаар байрын шагналыг Аймгийн засаг даргын тамгын газар ивээн тэтгэж хамтран ажиллалаа.

Энэхүү үйл ажиллагааг нээж Аймгийн төв номын сангийн захирал Ж.Цагаан цэцэрлэгүүдийн сурган хүмүүжүүлэгч, эцэг эх, хүүхэд багачуудад мэндчилгээ дэвшүүллээ. Дүрийн тоглолтын зорилго Ном хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх,тэднээр дамжуулан хүүхдийг номонд дуртай болгох,ном унших сэдэл төрүүлэх,дэлхийн алдартай зохиолчдын бүтээлтэй танилцуулах,эцэг эхчүүдийг хөгжүүлэн жүжиглэх чадвар эзэмшүүлэхэд оршино.

Дүрийн тоглолтонд Хэрлэн сумын 1,3,8,11,14 цэцэрлэгийн эцэг, эхчүүд амжилттай оролцож Ерөнхий шүүгчээр ХДТеатрийн драм ангийн жүжигчин Л.Амарзаяа, шүүгч ХДТеатрийн драм

ангийн жүжигчин С.Мөнхтөр нар шүүн явуулж дүрийн тоглолтыг 3 үзүүлэлтээр дүгнэж Тэргүүн байр 14-р цэцэрлэг Нурефшан Чаглигову зохиол “Залхуу зараа” үлгэр 27 оноогоор өргөмжлөл мөнгөн шагнал 150.000 төгрөг, Дэд байр 11-р цэцэрлэг Андерсены “Өвгөний хийсэн бүхэн буруугүй” үлгэр 24 оноогоор Өргөмжлөл, мөнгөн шагнал 100.000 төгрөг, 3-р байр 8-р цэцэрлэг Шармагийн зохиол “Хөх үнэгний үлгэр” 23 оноогоор Өргөмжлөл, мөнгөн шагнал 70.000 төгрөгөөр тус тус шагнагдаж Шинэ суваг телевизээр сурталчиллаа.

“Барга угсаатны түүх, ёс заншил” сэдэвт илгэлийн уралдаан

Хүүхэд залуусын уламжлалт ёс заншил, түүхийн тухай мэдлэгийг бататгаж нутаг орны түүх соёл,өвөг дээдсээрээ бахархах үзлийг төлөвшүүлэх зорилгоор Сүхбаатар, Хэнтий, Дорнод аймгийн, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шинэ барга баруун хошуу, Шинэ барга зүүн хошуу, хуучин барга хошууны ЕБСургуулийн сурагчдын дунд анх удаагаа “Барга угсаатны түүх, ёс заншил” сэдэвт илтгэлийн уралдааныг зохион байгууллаа.

Илтгэлийн уралдааны эхний шатны шалгаруулалт аймаг тус бүр зохион байгуулсан бөгөөд Дорнод аймаг эхний шалгаруулалтыг 2015 оны 4-р сарын 25 нд зохион байгуулж Хөлөнбуйр, Халхгол сум, Хэрлэн сумын ЕБС-ийн нийт 22 сурагч оролцож эцсийн шалгаруулалтанд Хэрлэн сумын ЕБС-ийн 2-р сургуулийн сурагч Ч.Алтанзул, Хөлөнбуйр сумын ЕБС-ийн сурагч О.Отгончимэг нар шалгарч Хэнтий аймагт болох эцсийн шалгаруулалтанд орох эрхтэй болсон.

Уралдааны эхний шатны шалгаруулалтын шүүгчээр Баргын өв төрийн бус байгууллагын тэргүүн Ц.Түмэн, тэргүүлэгч А.Магванрэнцэн, Г.Цоглхагва нар шүүгчээр ажиллаж, Шинэ суваг телевизээр сурталчиллаа. "Барга угсаатны түүх, ёс заншил" илтгэлийн уралдааны эцсийн шалгаруулалт Хэнтий аймагт зохион байгуулагдаж Сүхбаатар, Хэнтий, Дорнод, ӨМӨЗО-ны Шинэ барга зүүн, баруун хошууны нийт 10 сурагч оролцож Тэргүүн байр Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын ЕБС-ийн 9-р ангийн сурагч О.Отгончимэг, дэд байр Сүхбаатар аймгийн ЕБС-ийн сурагч Мөнхгэрэл, гутгаар байр ӨМӨЗО-ны Шинэ барга баруун хошууны ЕБС-ийн сурагч Начин, тусгай байр ӨМӨЗО-ны Шинэ барга зүүн хошууны ЕБС-ийн сурагч Бат-Эрдэнэ нар байр эзэлж шүүгчээр Хэнтий аймгийн нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн н.Оюунбат, Сүхбаатар аймгийн нийтийн номын сангийн захирал Энэбиш, Дорнод аймгийн Төв номын сангийн захирал Ж.Цагаан, ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хотын Шинэ барга баруун хошууны боловсролын төвийн мэргэжилтэн Сэчин, Дорнод аймгийн Баргын өв төрийн бус байгууллагын тэргүүлэгч Г.Цоглхагва нар шүүн явууллаа.

“Үндэсний бичиг үсгийн баяр”:

“Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны зарлигаар “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг жил бүрийн таван дугаар сарын эхний ням гаригт тэмдэглэн



өнгөрүүлж байхыг зарлигдсан билээ. Энэ удаагийн арга хэмжээ манай аймагт өргөн дэлгэр болж хөрш зэргэлдээ Өвөрлөгч хошууныхан өөрсдийн бүтээлээ дэлгэн сонирхууллаа. ӨМӨЗО-ны Шинэ Барга баруун хошууны Монголчууд хоёр жилдээ энэхүү арга хэмжээг Дорнодчуудтай хамт тэмдэглэж байгаа нь Монгол үндэстний бичиг соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээх, хүн төрөлхтний бичиг соёлын аугаа их өв санд босоо Монгол бичгээ мөнхлөн үлдээх чин зорилго нэг байгаагийн илрэл билээ. Энэ удаагийн арга хэмжээнд Зураач Мэлс, Шинэ хөгжил сургуулийн сурагчид, Өвөр Монголын Хөлөнбуйр, Хянган, Ордос, Хөхнуур, Жирэмийн Монголчуудын бүтээлийг үзэсгэлэнг дэлгэн харууллаа.

Сэтгэхүйн хурд

“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан ЯХИСангаас хэрэгжүүлж

буй “Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх нь” төслийн хүрээнд “Миний номын өргөө”-ний багцад хамрагдаж буй хүүхдүүдийн дунд “Сэтгэхүйн хурд” тэмцээнийг 2015 оны 5 сарын 29-ны өдөр зохион явууллаа. Энэхүү тэмцээн нь хүүхдийн оюун ухаан, сэтгэн бодох чадварыг уралдуулсан оюуны уралдаан юм. Тэмцээн 3 үе шаттай явагдаж, “Сэтгэмж” баг 1-р байр, “Хурд” баг 2-р байрыг тус тус эзэллээ.Хөтөлбөрийн бүх хүүхдүүдэд гарын бэлэг гардуулж, шалгарсан байруудад шагнал гардуулсан. Уг тэмцээнийг 5дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа бөгөөд жил бүр Бургатайн тал ХХК ивээн тэтгэдэг.

Орос хэлний “Старт” клуб:

Аймгийн төв номын сангийн хүүхдийн уншлагын танхимд орос хэлний “Старт” Клуб бага, ахлах, анги гэсэн 56 хүүхэдтэйгээр 2014 оны 10 сарын 22-нд нээгдсэн. Орос хэлний хичээлийг 7 хоног бүрийн баасан гариг бүрт хичээллэж, 2015 оны 06 сард 15 сурагчддаа төгсгөсөн. ОХУ-ын Чита хотод 6 хүүхдийг аялуулж Олон улсын “Фаллас Монгол судлаач” илтгэлийн уралдаанд оролцуулж “Дорнод нутгийн дууны домог” урлагийн тоглолт үзүүлж амжилттай оролцсон. Мөн Чита хотын номын сантай танилцсан. 2015 оны 6 сард 3 хүүхэд Магистр М.Отгонмандах багштай хамт “Өвөр байгалийн даурын сав газрийн” тухай илтгэлд оролцож дархан цаазтай газрын аялалд аялсан. Старт клубын сурагчид аймгийн хэмжээнд зохиогдсон орос хэлний олимпиад оролцож сурагч С.Аззаяа 2-р байр, Х.Хулан 3-р байранд орсон.

ОХУ-ын Өвөр байгалийн Чита мужийн хөдөө аж ахуйн их сургууль болон хөдөө аж ахуйн техникумын 2 багш, 6 оюутан, Дорнод аймгийн политехникийн коллежийн багш Олега Николаевнагийн удирдсан “Матрёшка”- клубын оюутнууд оролцож клубын үйл ажиллагаа болон номын сантай танилцаж хүүхдүүдийн урлагийн тоглолтыг үзэж дурсгалын зураг татууллаа. /Өөрсдийн сурсан дуу бүжиг шүлэг/ сонирхуулсан.

Шинэ ном, сэдэвчилсэн үзэсгэлэн:

“Эсэргүү А.Дашнамжил” шинэ номын баяр:

Төр, нийгмийн зүтгэлтэн, Манхилаг овогт А.Дашнамжил Дорнод аймгийн Булган сумын уугуул, Дорнод аймгийн төв номын сангийн анхны эрхлэгч, үүсгэн байгуулагч А.Дашнамжилын намтар, амьдрал, тэмцлийн түүхийг товчоолон өгүүлсэн ном хэвлэгдэн уншигчдын гар дээр очиж байна. “Эсэргүү А.Дашнамжил” хэмээн нэрлэсэн номын нээлтийг 2015 оны 03-р сарын 14-нд Аймгийн төв номын сангийн соёл олон нийтийн танхимд зохион байгуууллаа.Нээлтэнд А.Дашнамжил агсны дүү, үр хүүхэд найз нөхөд, уншигч олон хүрэлцэн ирж нээлтийг А.Дашнамжил агсны хүү Төрийн өмчийн хорооны дарга асан, Дорнод аймгийн нутгийн зөвлөлийн дарга, Д.Цогтбаатар, Аймгийн төв номын сангийн захирал



Ж.Цагаан номын баярын нээлтийг нээж Булган сумын соёлын төвийн хамт олон мэндчилгээ дэвшүүлж олон сайхан дуу, хуурын дээжийг өргөн барилаа. Тэрээр номондоо аавыг нь “Намын эсрэг бүлэг” гэх улс төрийн зохиомол хэргээр хэлмэгдүүлсэн болон журмын найз нөхдийнх нь түүх, намтар нийгмийн сайн сайхан, шударга ёс, эрх чөлөөний төлөө хийж байсан ажил үйлсийг бодитой баримттай харуулахыг зорьсон байна.

Дашнамжил агсны багын найз, Дарамзагд, дүү А.Гүрбямбаа, А.Дашнамжил ахынхаа тухай дурсамж, халуун дотно сэтгэлийн үгээ хуваалцсан юм. А.Дашнамжил агсны үр хүүхдүүдийнх нь санаачлагаар аавынхаа гавьяат үйлсийг мөнхжүүлэх зорилгоор Дашнамжил агсны нэрэмжит шагналыг номын санд үр бүтээлтэй ажиллаж байгаа номын санч, хамтран ажилладаг байгууллага, ивээн тэтгэгчид болон хувь хүмүүсийг 2 жилд нэг удаа Соёлын ажилтны өдрөөр олгох тухай Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 34 тоот тогтоолын хоёрдугаар хавсралтаар А.Дашнамжилийн нэрэмжит “Хүндэт тэмдэг“ үнэмлэх, мөнгөн шагналыг 2014 оноос эхлэн олгоод байна.

А.Дашнамжил агсны өөрийнх нь хэрэглэж ирсэн эд зүйлс, бичиж хэвлүүлэн гаргасан номын үзэсгэлэн.

МАРШАЛ ЧОЙБАЛСАНГИЙН 120 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ҮЗЭСГЭЛЭН

МУ-ын 13 дахь Ерөнхий сайд, Монгол төрийн зүтгэлтэн, хошой баатар, БНМАУ-ын анхны Маршал Хорлоогийн Чойбалсаны мэндэлсний 120 жилийн ойд зориулж Аймгийн төв номын сан, Аймгийн музей, МУ-ын хошой баатар өрлөг жанжин Маршал Х.Чойбалсангийн нэрэмжит цэргийн гавьяаны одонт хилийн 0132-р анги хамтран зохион байгуулж Маршал Х.Чойбалсангийн намтар түүх, эд өлгийн зүйл, ном, сонин "Тусгаар тогтнол үүрд мөнх" нэртэй үзэсгэлэнгийн арга хэмжээний нээлтийг 2015 оны 2 дугаар сарын 08-ны 11-00 цагт Аймгийн төв номын сангийн соёл олон нийтийн танхимд хамтран зохион байгууллаа.

Нээлтийг Аймгийн засаг даргын орлогч, Маршал Х.Чойбалсангийн мэндэлсний 120 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийн ахлагч М.Бадамсүрэн энэхүү үйл ажиллагааг нээн үг хэлж төрийн дуулал эгшиглүүлэноролцогчид хүндэтгэл илэрхийллээ. Нээлтэнд урилгаар МУ-ын Ардын жүжигчин А.Дашпэлжээ, Кино найруулагч Ч.Болд,Улсын Их Хурлын гишүүн, УИХ дахь МАН-ын бүлгийн дэд дарга Н.Номтойбаяр, Аймгийн засаг даргын тамгын газрын нийгмийн бодлого хөгжлийн хэлтсийн дарга Н.Алтанцэцэг, Аймгийн засаг даргын тамгын газрын штабын дарга, хурандаа Ж.Сүхбаатар, байгууллагуудын удирдлагууд болон оюутан сурагч, ард иргэд үзэсгэлэнгийн нээлтэнд оролцож үзэсгэлэнг сонирхлоо.

Зохиолчдын ой, шинэ номын үзэсгэлэн:

Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэн – 60 жилийн ойд 15 ном, Ш.Гүрбазар 60 жил 2 ном, Л.Түдэв – 81 жил 150 ном, Ш.Сүрэнжав, намтар уран бүтээлээр, Х.Чойбалсан 26 ном, нийт 193 номоор үзэсгэлэн гаргасан. Шинэ номын үзэсгэлэнг 44 удаа 904 номоор үзэсгэлэн гаргасан.

Сэдэвчилсэн үзэсгэлэн:

Хоол хийх урлаг, Бие хүний хөгжил төлөвшил, хүрэл тулга наадам, чингис хаан комик, Х.Чойбалсан агсны 120 жилийн ойд, багш нарын баяр, дорнод аймгийн зохиолчдын, барга үндэстний илгэл, уран жиргээ хүрэл тулга, динза, хичээлээс гадуур унших зохиолоор, хэлмэгдүүлэлт, Дорнод аймгаас төрсөн зохиолч, яруу найрагчдын болон дөл сонингийн 70 жилийн ойд 25 багц сонингоор, 1945 оны гэрэл зургийг сонингоос түүвэрлэн 504 номоор гаргасан.

Äºðºâ. ¯íáýñíèé òºñºë õºòºëáºð õýðýãæ¿¿ëýõ

АНУ-ын ЭСЯам, Боловсролын зөвлөгөө мэдээллийн төвөөс хэрэгжүүлж буй Access хөтөлбөр 2006 оноос номын санд амжилттай хэрэгжиж байна. Хөтөлбөрт манай аймгийн 100 гаруй хүүхэд амжилттай суралцан төгсөж дотоодын болон гадаадын их дээд сургуульд суралцан ажил амьдралын гараагаа эхлэн ажиллаж байна.

Access-6 хөтөлбөрийн сурагчид 2015 оны 4 сарын 25 нд 12 сурагч, 3 багш Хэрлэн голын эрэг, ногоон бүс дагуу хурсан хогийг түүж цэвэрлэлээ.

Сурагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх бие бялдрыг чийрэгжүүлэх, нөхөрсөг харилцаа бие биенээсээ суралцах зорилгоор гар бөмбөгийн тэмцээнийг зохион явуулсан. Тэмцээнд багш сурагчид нийлсэн 2 баг оролцож Энхзаяа ахлагчтай талын ирээдүй баг 1-р байр эзэлсэн.

Нийт сурагчдын дунд “Алтан хонх” тэмцээнийг зохион явуулж оюун ухаан, авхаалж самбааг нь сорьсон тэмцээн болсон. Уг тэмцээнд суралцагч Д.Солонгоо бусдыг тэргүүлэн тэргүүн байр эзэллээ.

Access-6 2013-2015 онд хэрэгжин төгсөлтийн сертификад гардуулах ёслолын ажиллагааг

2015 оны 06 дугаар сарын 15-нд соёл олон нийтийн танхимд зохион байгууллаа. Төгсөлтийн арга хэмжээнд, багш сурагчид, сурагчдын эцэг эх 35 хүн оролцлоо. Нээлтийн үйл ажиллагаанд номын сангийн захирал Ж.Цагаан, access-6 хөтөлбөрийн англи хэлний багш, боловсрол, соёлын газрын гадаад хэлний мэргэжилтэн Д.Хэрлэнмөрөн нар оролцож сурагчдад баяр хүргэн цаашдын сурлага хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөж мэндчилгээ дэвшүүлсэн. Мөн сурагчдын эцэг эхийн төлөөлөл болж Х.Мишээлтийн ээж чин сэтгэлийн баярын

мэндчилгээ хүргэж, сурагчдын бэлтгэсэн бяцхан концертыг үзэж сонирхлоо. Ёслолын арга хэмжээний төгсгөлд сурагчдад сертификат гардуулах ёслол болж, бүх сурагчид дурсгалын зураг татуулж хүлээн авалтанд орсноор төгсөлтийн арга хэмжээ өндөрлөсөн. Эдгээр тэмцээн уралдаан төгсөлтийн арга хэмжээний зардалд Боловсролын зөвлөгөө мэдээллийн төвөөс 1.462.250 төгрөгийн санхүүжилтыг олгосон. Мөн танхимын тохижилтонд вакум хаалт 3.000.000 төгрөг, хөшиг 482.000, номын тавиур 660.000, мэдээллийн самбарт 300.000 төгрөг, нийт 4.442.000 төгрөгийн тохижилт хийсэн.

2015 оны 09 сард access-7 хөтөлбөр зарлагдан Хэрлэн сумын 7 сургуулийн 110 хүүхэд бүртгүүлэн 66 хүүхэд шалгалтанд орсноос 20 хүүхэд үндсэн, нэмэлтээр 8, нийт 28 хүүхэд тэнцсэнээс 2-р сургуулиас 3, 6-р сургуулиас 5, 8-р сургуулиас 7, 11-р сургуулиас-1, 12 сургуулиас 3, Шинэ хөгжил цогцолбор сургуулиас-5, Хан-Уул сургуулиас-4 хүүхэд тус тус суралцах болсон. Хичээл 2015 оны 10 сарын 19 нөөс эхлэн англи багш Jack Noyler, Marcus Kelly, Teo, Any, монгол багш Д.Хэрлэнмөрөн нарын 5 багш 7 хоногийн даваа, лхагва, баасан гаригт 2 ангид 2 цагаар хичээллэж байна. (долоо хоногт 3 удаа 6 цаг) хөтөлбөрт хамрагдсан 20 сурагчдад ном сурах бичгээр хангагдсан. Мөн энэхүү хөтөлбөрөөр зөвхөн англи хэл заахаас гадна сонирхолтой, хөгжөөнт арга хэмжээ, тэмдэглэлт баяр ёслол, АНУ-ын соёлын талаарх ойлголт, сайн үйлсийн аян, урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулан ажиллаа. Үүнд :

Access-7 сурагчид, багш, сайн дурын ажилтнуудын хамтаар 2015 оны 10 сарын 31-нд Halloween баяр, талархалын баярыг тэмдэглэж амттан бэлтгэн хувцас баг зүүж сурагчдаа хүлээн авч, баярын талаар ярилцан, шар манжингаар дүрс хийж, уснаас алим шүүрэх зэрэг уламжлалт тэмцээнийг зохион явуулсан.

2015 оны 12 сарын 06 нд талархалын баярыг тэмдэглэн багш нар сурагчдад америкийн хоол бэлтгэн, сурагчид багш нартаа талархаж баярлан хүлээн авсан.

Сурагчдын авьяасыг нээн илрүүлэх зорилготой “Access Talent show” уралдааныг сурагчдын дунд зарлан, 4 баг болгон мэндчилгээ, хамтлаг бүжиг, гоцлол дуу, үндэсний хөгжим гэсэн номинацаар шалгаруулан 1-р байр ......хамтлаг, шилдэг дуугаар 2 групп Намуундарь, шилдэг уран уншлагын төрөлд Мандуухай нар шалгарч дурсамж дурсгалын зүйлсээр шагнагдлаа.

Боловсролын зөвлөгөө мэдээллийн төвийн зохицуулагч Гантөмөр 2015 оны 09 сарын 19-22 өдрүүдэд хүрэлцэн ирж Access7 хөтөлбөрийн шалгаруулалт хийж, шалгарсан сурагчидтай уулзаж заавар зөвлөгөөг өгч ажилласан.

2015 оны 10 сарын 19-22 өдрүүдэд БЗМТөвийн англи багш Max Mack-Hardiman, мэргэжилтэн Гантөмөр хүрэлцэн ирж Хэрлэн сумын ЕБС 1,2,5, Дорнод их сургуулиар явж тэтгэлэгт хөтөлбөрийн талаар мэдээлэл хийж, америкт суралцах 5 алхам лекц хийсэн. Мөн ACCESS-7 сурагчдын сургалтын явц, багш нартай уулзан, сайн үйлсийн аянд оролцож сурагчдын хамтаар Anna home асрамжийн газрын үйл ажиллагаатай танилцан, хүүхдүүдийн хамт тоглоом тоглож нэг өдрийг хамт өнгөрүүлэн бэлэг дурсгалын зүйл гардуулан, асуулт хариултын АХА тэмцээнийг зохион явуулж, сурагчдын бэлтгэсэн алимны модны үлгэрийг сонирхон үзүүллээ.

АНУ-ын ЭСЯ-ны ажилтан С.Алтанцэцэг 2015 оны 12 сарын 06-09-ны өдрүүдэд манай аймагт хүрэлцэн ирж номын сангийн үйл ажиллагаатай танилцан, Access-7 хөтөлбөрт хамрагдсан үндсэн 20 сурагчдад сертификат гардуулан, Хэрлэн сумын -2, 8, Шинэхөгжил цогцолбор сургуулийн 10-12 ангийн сурагчдад англи хэл дээр Game тоглоом тоглуулсан нь тоглож байгаа хүүхэд бүр англиар үг хэлж хамтаар тоглож, англиар дуу зааж өгсөнд талархан хүлээн авсан. Дорнод их сургуулийн англи хэлний ангийн 3-4 курсын оюутнууд, ЕБС-ийн англи хэлний багш нартай

уулзаж тоглоомын талаар танилцуулан, ЭСЯ-наас зарлагддаг хөтөлбөрүүдийн талаар танилцуулсан. Холоос явдаг 12 сурагчдад 10-11 сарын унааны мөнгө олгогдсон. 235000 төг.

¯ð ä¿í: хөтөлбөрт хамрагдснаар сурагчид аймаг бүсийн хэмжээний олимпиад уралдаанд амжилттай оролцон, хэлний чадвар сайжирсан.

Санхүүжилт:

Òàâ. Ñî¸ëûí ñàëáàðûí ñòàòèñòèê ìýäýýíèé ¿íý çºâ áàéäàë:

Íîìûí ñàíãèéí æèë á¿ðèéí òàéëàí ñóäàëãàààã òºâëºðñºí ÑÓ-3, ÑÓ-5, òºâëºðñºí áóñ ÑÓ-10, ÑÓ-14 ìàÿãòààð ãàðãààæ õ¿ðã¿¿ëñýí,

Çóðãàà. Ñî¸ë óðëàãûí áàéãóóëëàãóóäûí òîíîã òºõººðºìæ, íîìûí õàíãàëò

Çîðèëò: Óíøèã÷äûí õýðýãöýýò øèíý íîì õýâëýëýýð ñàí õºìðºãºº áàÿæóóëàõ.

Õýðýãæèëò: Шинээр 339 ширхэг ,,,,,,, төгрөгийн ном худалдан авсан. Хандиваар 327 ном 434550 төгрөг. Хэвлэл захиалга 25òºðëèéí 585000 òºãðºãèéí õýâëýë çàõèàëñàí. Óðàããààæ ãýìòñýí 1834 íîìûã ñýëáýí çàññàí.

БСШУЯамнаас 2015 оны 05 дугаар сард 7 төрлийн 139 ширхэг 3987000 төгрөгийн номыг аймгийн төв болон сумдын хэрлэн сумын ЕБСургуулиудад, Засгийн газраас Ерөнхийлөгчийн 5 боть номыг 2015 оны 9 сард төв номын сан болон сумдын нийтийн номын сангуудад нийт 132 ш,1.624.500 төгрөгний номыг хандиваар,

зохиолч, албан байгууллага, хувь хүмүүс төв номын санд нийт 238 ш 1.108.550 төгрөгний ном номыг хандивласан байна. Нийт номын тоо…....íîìòîé áîëñîí. Ном хэвлэл алдаж үрэгдэхээс сэргийлэн танхимуудыг камержуулан

¯ð ä¿í: Óíøèã÷èä øèíý õýâëýë ¿çýõ áîëîëöîîãîð õàíãàãäààæ áàéíà.

Ñàíõ¿¿æèëò :

Äîëîî: Õýíàëò øàëãàëò ¿íýëãýý áîäëîãî, èðãýäèéí ñàíàë õ¿ñýëòèéã áàðàãäóóëàõ

Аймгийн аудитын газраас тус номын сангийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэлд аудиторын 2014оны 408 тоот тушаалын 2 дугаар хавсралтын дагуу сүүлийн 3 жилд зөрчилгүй санал дүгнэлт авсан, санхүүгийн ажилтнууд солигдоогүй, санхүүжилтийн хэмжээ бага, өмнөх аудитаар зөрчил илрээгүй, санхүүгийн тайланг стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн гэсэн шалгуур үзүүлэлтийг хангасан тул итгэл үзүүлсэн гэсэн дүгнэлт гаргасан.

Аймгийн мэргэжлийн хяналтын газрын номын сангийн бүртгэл хадгалалт хамгаалалт шалгах үнэлгээгээр дунд эрсдэлтэй гэж дүгнэгдсэн.

Аймгийн Аудитын газрын албан шаардлага шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах өөрийн байгууллагын болон шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулаагүй зэрэг зөрчил илэрснийг арилгуулан оруулах мэдээллийг бүрэн оруулж шилэн дансанд байршуулсан. Мөн нягтлан бодогч Б.Майцэцэгт сануулах арга хэмжээ авч цаашид цаг хугацаанд нь тайлан мэдээг оруулахыг сануулласаа.

Байгууллагын санал хүсэлтийн хайрцганд ирсэн 2, 70584259 нээлттэй утсанд 3 санал ирснийг тухай бүрт нь шийдвэрлэн ажиллалаа.

<u>Албан хэрэг хөтлөлт, архив:</u>

Байгууллагад ирсэн бичиг 35, явсан бичиг-72, захирамжаар ирсэн-8, захирамж тогтоол-4 хариутай -5 бичгийн хугацаанд гаргаж хүргүүлсэн. Ёс зүйн хорооны-1, захиргааны зөвлөлийн 1, шагналын хурлын тэмдэглэл-3 долоо хоног бүрийн мягмар гаригт хийгддэг мэдээллийн цагийн 30 удаа тэмдэглэл хөтлөн

Байгууллагын архивт хадгалагдаж буй байнга, түр хадгалах 123 баримтын эмхлэн цэгцлэж, хуудас дугаарлан, товьеог үйлдэн техник ажиллагааг хийсэн. Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг шалгалтанд бэлтгэх ажлын хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг гарган батлуулан үзлэг шалгалтанд бэлтгэж, аймгийн урьдчилсан үзлэг шалгалтаар 84% -тай дүгнэгдсэн.

Байгууллагын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах комиссоор, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, байнга, түр хадгалах баримтыг батлан гаргаж үйл ажиллагаа сайжирсан. 2010-2013 оны тушаалууд цахим программд оруулаад байна.

Гадаад харилцаа:

БНХАУ-ын ӨМӨЗОрны Хайлаар хотын номын сантай байгуулсан гэрээний дагуу хоёр орны номын сангийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, харилцан туршлага судлах, хайлаар хотын номын санд 2015 оны 5 сард номын сангаас 5 ажилтан ажиллагсад, Хайлаарын номын сангаас 4 хүн ирж харилцан туршлага судлан "Үзэсгэлэнт сайхан Дорнод-Хөлөнбуйр гэрэл зургийн үзэсгэлэнг гаргаж, гэрээний дагуу ном солилцон хамтран ажиллалаа.

Бусад ажлын талаар:

Улсын хэмжээнд нэг сая мод тарьж ургуулах ажлын хүрээнд нисэхийн зам дагуу 60 мод тарьж, өөрийн байгууллагын 3 цэцгийн мандлыг цэцэгжүүлэн усалгаа арчилгааг хийж байна. Нийтийг хамарсан цэвэрлэгээг 3 удаа зохион байгуулж өөрийн эзэмшлийн талбай замыг цэвэрлэн цас шороо хогийг тогтмол авч байна.

Ажилтан ажиллагсдын дунд "Түмэн цэцэг" болзолт уралдааныг зарлаж 12 сард дүнгээ гарган 1-р байранд хүүхдийн уншлагын танхимын номын санч Х.Чулуунцэцэг 118 цэцэг тарьж ургуулан шалгарлаа. 2 байранд тогтмол хэвлэлийн танхимын номын санч Д.Энхчимэг цэцэг, каталогич Э.Учралмаа 3-р байранд шалгарлаа.

Сар шинийн баяр, ахмадын баяраар байгууллагын өндөр настан ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн. Нийт зардал 865.444 төгрөг. Ажилтан ажиллагсдад 3 хүнд түлээ нүүрсний хөнгөлөлт 180.000 төгрөг, шинэ гэр бүл болсон мэдээллийн технологич Ч.Цогтхүүд 100.000 төгрөг, зүүн бүсийн ажил мэргэжлийн өдөрлөгийн уралдаан тэмцээнд 200.000 төгрөг тус тус төсвөөс зарцуулсан.

Сар шинийн баяраар фондоч ажилтай Ц.Оюунноминг, нягтлан бодогч Б.Майцэцэг, Хэрлэн сумын "Жуух бичиг"-ээр, арга зүйч Ж.Соня, жижүүр Ө.Наранбаатар "Хотын тэргүүний ажилтан" цол тэмдэгээр шагнагдсан.

Байгууллагын дотоод хяналт шалгалт, Ёс зүйн хороог байгуулан, дүрэм гаргаж боловсруулан ажилтан ажиллагсдад танилцуулан баталсан. Дүрмийн дагуу ёс зүйн доголдол гаргасан мэдээллийн ажилтан А.Батболдыг ёс зүйн хороогоор хэлэлцэн шийдвэрийг удирдлагад хүргүүлсэн.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах баярыг угтаж ажилтан ажиллагсдын хүүхдүүдийн дунд 1-4 насанд бүжгийн тэмцээн, 5-6 нас шүлэг, 7-11 гар зургийн уралдааныг зохион байгуулан шалгарсан хүүхдүүдэд гарын бэлэг гардуулан байгууллагын ҮЭ-ийн хорооноос бэлэг гардуулсан.

С.БУЯННЭМЭХИЙН НЭРЭМЖИТ ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. ХУУЛЬ ТОГТООМЖ, ШИЙДВЭРҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР

2014 оны үр дүнгийн гэрээгээ дүгнүүлэн, 2015 оны менежерийн үр дүнгийн гэрээ, ажлын төлөвлөгөөг гарган аймгийн Боловсрол Соёлын Газрын даргаар баталгаажуулан хэрэгжүүлж байна.

Төсвийн тухай хуулийн дагуу 2015 онд хийх ажил, нийлүүлэх бүтээгдэхүүний Үр дүнгийн гэрээг төсвийн Ерөнхий менежертэй хийлээ. Ажиллагсдын жилийн ажлын төлөвлөгөөг баталж, биелэлтийг хангуулах үүднээс тайлан, төлөвлөгөөний биелэлтийгхагас болон жилээр дүгнэж Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалын дагуу ажлын амжилтаар урамшуулал, нэмэгдэл зэргийг олгож байна. 2015 оны хагас жилийн үр дүнгийн гэрээний хэрэгжилт, хагас жилийн үйл ажиллагааны тайланг гарган, дүгнүүллээ.

Монгол Улсын 2014 оны 07 сарын 01 өдрийн “Шилэн дансны тухай хууль”, Засгийн газрын 384 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн, байгууллагын шилэн дансанд мэдээллийг үнэн бодитойгоор оруулж, аудитын газар, нийгмийн даатгал, татварын албанд сар бүр мэдээ, тайлангаа өглөө. Мөн хуулийн дагуу байгууллагын ил тод байдлыг хангах үүднээс “Санхүүгийн мэдээлэл”-ийн самбар гарган сар бүр ажилчид болон уншигч, иргэдэд мэдээлж байна.

Уншигч, иргэдийн санал сэтгэгдэл, өргөдөл, гомдлыг сонсох, шийдвэрлэх зорилгоор байгууллагатаа Санал хүсэлтийн байнгын болон зөөврын 2 хайрцагтай болсон.

Соёлын сайд, Сангийн сайдын 2004 оны 83/97 тоот тушаалын “Номын сангийн ном, хэвлэлийн бүтээгдэхүүнийг худалдах, солилцох, данснаас хасах журам”-ын дагуу утга агуулга хуучирсан, уншлага үйлчилгээний шаардлага хангахгүй, элэгдэж хуучирсан 13340 ширхэг номын актын жагсаалтыг Орон нутгийн өмчийн албанд хянуулахаар бэлдээд байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, 3сарын 26-нд “Газар хөдлөлт” сэдвээр зарлан мэдээллийн дохиогоор, хамт олноороо идэвхтэй оролцсон.

Монгол Улсын “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хуулийг хэрэгжүүлж, Цагаан сар, Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Ахмадын өдрүүдийг тохиолдуулан байгууллагаасаа гавьяаны чөлөөнд гарсан сумдын соёлын төвийн номын санчид болон аймгийн төв номын сангийн 16 ахмадуудад:

- Ахмадын өдөрт зориулсан хүндэтгэлийн тоглолтыг үзүүлсэн. Жич: ахмад уншигчдыг хамруулсан
- Хүндэтгэл үзүүлэн уулзалт хийж, туршлагаас хуваалцлаа /2 удаа/
- Гарын бэлэг гардууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн Газрын 2004 оны 163 дугаар тогтоол, “Монгол бичиг”-ийн үндэсний хөтөлбөр болон Аймгийн ИТХ-ын 2014 оны 11 сарын 21-ний өдрийн №265 тогтоолын дагуу “Үндэсний бичиг” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг Сайнцагаан сумын Засаг Даргын Тамгын газар, сумдын Ерөнхий Боловсролын Сургуулийн монгол хэл, уран зохиолын Заах аргын нэгдэл, Аймгийн Боловсрол Соёлын Газар, С.Буяннэмэхийн нэрэмжит аймгийн Төв номын сан, Аймгийн музейтэй хамтран зохион байгууллаа. “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг аймгийн хэмжээнд 2015 оны 04 сарын 16-18-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүллээ. Монгол Үндэсний бичиг, түүх соёлоо эрхэмлэн дээдэлж, хамгаалах, сурталчлах монгол бичгээ хурдан түргэн унших, түгээн дэлгэрүүлэх зорилгоор ЕБС-ын 7-12 дугаар ангийн дунд 3 ангилалаар Монгол бичгийн “Тэргүүний хурдан уншигч” шалгаруулах уралдааныг 2015.04.16-нд зохион байгуулж, нийт 94 сурагч идэвхтэй оролцож өрсөлдлөө.

Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт **“Алслагдсан хөдөөгийн иргэдэд иж бүрэн тоноглогдсон автомашинаар явуулын номын сангийн үйлчилгээг үзүүлэх”,** Дундговь Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт нүүдлийн номын санг ажиллуулах хэмээн тусгагдсаны дагуу Зүүн сумд/Дэрэн, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Гурвансайхан, Өндөршил/, Өлзийт сум, Онцгой байдлын хэлтэс, “Мандал худалдааны” төв, “Цоглог” худалдааны төв, Мандал сургууль, ЭДЦСургууль, МСҮТөвүүдэд тус тус нүүдлийн номын санг ажиллуулж, номын санчдад 9 төрлийн

гарын авлага, музейн 3 боть альбом, Америкийн Монгол судлалын төвөөс ирсэн 345 ширхэг англи ном, БСШУЯамнаас 379 ширхэг ном, 14 сумын Соёлын төв, сургуулиудад хувиарлан тараалаа. Нүүдлийн номын сангаар уншигчдад карт нээж, шинэ болон шилдэг ном, уран зохиолын 643 номоор үйлчилсэн.

Монгол Улсын ерөнхийлөгчийн 2012 оны 8 сарын 24-ний 158 дугаар зарлигийн дагуу “Номын баяр”-ыг жил бүр улс болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг бөгөөд уг арга хэмжээ 9 дүгээр сарын 17, 18-ны өдрүүдэд Улаанбаатар хотод МҮНС, Чингисийн талбайд болсон бөгөөд орон нутгийн нийт номын сангийн захирал эрхлэгч нарын уулзалт, зөвлөгөөнд оролцож, аймгийн номын санг сурталчилах зурагт үзэсгэлэнг амжилттай гарган, яамнаас өгсөн 112 ширхэг номыг авчирч сумдын номын сангуудад тарааж өглөө.

Аймгийн Засаг Даргын 2009 оны 180 тоот захирамжаар баталсан “С.Буяннэмэх тэмдэгтэн”-г шалгаруулах журмын дагууЭДЦС, 3-р сургууль, Дэлгэрцогт, Говь-Угтаал, Луус, Гурвансайхан, Дэрэн, Хулд зэрэг сумдаас өгсөн материалуудыг бүртгэл хөтлөн хүлээн аваад байна.

Хоёр. МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГАА

Нийт 9 удаа шинэ номын, 22 нэр төрлийн сэдэвчилсэн үзэсгэлэнг сонин, сэтгүүл, номоор гаргаж, сурталчиллаа. Үүнд:

- ✓ Хуулийн картын санд Төрийн мэдээлэл сэтгүүлээс шинээр гарсан 3 хууль болон бусад хуулийн нэмэлт өөрчлөлтийг тусгасан 18 карт бичсэн.
- ✓ “Монгол түмний баяр Цагаан сар “
- ✓ “Дөрвөн бэрх”
- ✓ “Гэгээн хайрын өдөр”сэдэвт үзэсгэлэн
- ✓ Монголын шилдэг 25 зохиолч, яруу найрагчдын шилдэг бүтээл, яруу найргийн номоор “Уран үгсийн чуулган” сэдэвт үзэсгэлэн
- ✓ Олон улсын эмэгтэйчүүдийн өдөрт зориулан Тогтмол хэвлэлүүдээс “Орчлонгийн сайхан ээжүүд” сэдвээр төр нийгмийн зүтгэлтэн,урлаг соёлын алдартнуудын тухай ярилцлага, нийтлэл, сонирхолтой мэдээллийг шүүн хайчилбараар сурталчлан таниуллаа.
- ✓ “Монгол хэлний тухай хууль” гарсантай холбогдуулан уг хуулийг сурталчилах, монгол бичгийн аймгийн дэд хөтөлбөр /2014-2019/-ийг хэвлэн уншигч, иргэдэд сурталчилан, мэдээлэл өглөө.

- ✓ Эх хэл, бичиг үсгийн талаар гарсан хууль тогтоомж, материалын санамж өгөх номзүйн бүртгэл хийсэн.
- ✓ Үндэсний бичиг үсгийн баярыг Сайнцагаан сумын ЗДТГ, ЕБС-иуд бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар баярын хөтөлбөр, удирдамж боловсруулан 10 суманд удирдамж хүргүүлж, "Үндэсний эх хэл, бичиг соёл" сэдэвт үзэсгэлэн, уран бичвэрүүдийн бүтээлийн үзэсгэлэнг 2 удаа гаргаж, сурталчилсан.
- ✓ Эрдэм шинжилгээ, хэл судлалын танхимд 10 гаруй сэтгүүл, сонин, хэл судлалын 60 орчим номоор фонд бүрдүүллээ.
- ✓ "Үндэсний бичиг үсгийн баяр" болон БСШУСайд Гантөмөр айлчлах болсонтой холбогдуулан 2012, 2013 оны уралдааны шилдэг 20 гаруй бүтээлээр үзэсгэлэн гаргасан.
- ✓ TV ZONE сэтгүүлээс "Угийн бичиг хөтлөхүй" сэдэвт картын санд 14 карт, зүйлчилсэн карт 20 карт бичиж, номзүйн жагсаалт хийж, уншигчдад сурталчиллаа. Мөн Орон нутгийн картын санд 30 гаруй карт бичиж баяжилт хийв.
- ✓ "Угийн бичиг хөтлөхүй" номын үзэсгэлэн 28 ш номоор үзэсгэлэн гарган, Аймгийн музейтэй хамтран "Угийн бичгийг хөтлөх хэрэгцээ шаардлага ач холбогдол" сэдэвт лекцийг зохион байгуулж, МСҮТөвийн 70 гаруй оюутан, номын сангийн ажилчдыг хамрууллаа.
- ✓ "Аугаа эх орны дайны ялалтын 70 жил"-ийн ойд зориулан сэдэвт номын үзэсгэлэн 25 номоор, идэвхтэн уншигч 7-р багийн иргэн С. Чулуунбат өөрийн номын сангаас "Их ялалтын 70 жилийн ойд" зориулсан 15 ш номоор үзэсгэлэн гаргаж уншигч, иргэддээ сурталчилан хамтран ажиллаа.
- ✓ Монгол Улсын баяр наадамд Дундговь аймгаа сурталчилах зорилгоор Хүй долооон худагт"Уран үгсийн чуулган" сэдэвт үзэсгэлэн.
- ✓ Аялал жуулчлалын улирлыг тохиолдуулан **"Монголын сайхан орноор аялцгаая"-23 номоор, "Дэлхийн улс орнуудаар аялахуй" 18 номоор** үзэсгэлэн гаргав.
- ✓ "Номын сангийн хамгийн хамгийн" 63 номоор үзэсгэлэн гаргасан.
- ✓ Боловсрол, соёлын яамнаас баталсан заавал унших номын жагсаалтыг эвхмэлээр гарган сурталжиллаа. Мөн эцэг эхчүүдийн заавал унших номын жагсаалт, залуучуудын заавал унших номын жагсаалт зэргийг гарган сурталчиллаа.
- ✓ Өндөр настан Д.Аюур багшийн 50 номоор үзэсгэлэн

- ✓ Өндөр настан Давааням багшийн 29 номоор
- ✓ Өндөр настан Лхүндэвдорж гуайн 35 номоор тус тус үзэсгэлэн гаргаж, сурталчиллаа.

Гурав. СОЁЛ, ОЛОН НИЙТИЙН АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЛААР

Монгол түмний баяр Цагаан сарыг тохиолдуулан ЭДЦС, ГИЦСургуулийн 9-10 дугаар ангийн сурагчдын дунд ёс заншил, өв уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, сурталчилах зорилгоор “Дөрвөн бэрх” уралдаант тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Уралдаанд ЭДЦСургуулийн “Тэмээчин” баг тэргүүн байр эзэллээ. 5 нэр төрлийн сэдэвчилсэн үзэсгэлэнг гарган сурталчиллаа. Уншигчийн картыг анги, хамт олноор нь нээж, номын сантай танилцууллаа.

Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Эр цэргийн баярыг тохиолдуулан гар бөмбөгийн боосоот тэмцээнийг Музейн хамт олонтой хамтран зохион байгууллаа.

ГИЦСургуулийн дотуур байрны номын сантай болгох төсөлд 6 диск, 30 ширхэг ном, сэтгүүлээр хандив, тусламж үзүүллээ.

“Номын баяр”-ын хүрээнд ЭДЦС-ийн Ж,Долгорсүрэн багштай 11в ангийн сурагч Ч.Дагиймаагийн хүсэлтийн хариуд 6 ширхэг номыг тус ангийн номын санд хандивлаж, сурлагын амжилт хүсч урамшууллаа. Мөн 3-р сургуулийн Б,Цэцэгсүрэн багштай 2г ангийн номын санд нь 10ш ном, тус сургуулийн номын санд 15ш номыг тус тус хандивлалаа.

3-р сургуулийн захирал Оюунханд, номын санч Должинсүрэн нартай хамтран Найрамдал багштай 8а ангийн 11 сурагчидад уншигчын карт нээж, Уншлагын семинар хийлээ. Хэрхэн зөв, түргэн хугацаанд унших, номтой нөхөрлөх, номноос олсон мэдлэгийнхээ тухай сурагчид хуваалцлаа. 7 төрлийн ном, CD-г Найрамдал багштай 8а ангийн хамт олонд дурсгалаа

3-р сургуулийн Цэцэгмаа багштай 2б анги, ГИЦС-ийн Алимаа багштай 11б анги, Хүүхэд хөгжүүлэх 1, 2, 3-р цэцэрлэгийн 500 гаруй сурагчдад номын сангийн үйл ажиллагааг сурталчилан танилцууллаа. Мөн цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдүүд хүүхдийн уншлагын танхимын 20 ширхэг номонд “Номын хавчуурга” хийж өглөө.

Өндөр насны амралтаа авсан ахмад уншигч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд карт нээн ном, хэвлэл, сонин, сэтгүүлээр үнэгүй үйлчиллээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд соёл, урлагийн үйлчилгээг хүргэх талаар төсөл хөтөлбөр

хэрэгжүүлэхээр судалгаа явуулж байна. Нүүдлийн номын сан, гэрээр ном олгох танхимаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ном, хэвлэлээр үйлчилээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн Газрын 2004 оны 163 дугаар тогтоолын дагуу “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүллээ. “Үндэсний бичиг үсгийн баяр”-аар бүртгэл мэдээллийн номын санч А.Эрдэнэтуяа “Эх хэл, бичиг соёлоо түгээн дэлгэрүүлэгч” медалиар шагнууллаа.

Үндэсний бичиг, түүх соёлоо эрхэмлэн дээдэлж,монгол бичгээ хурдан түргэн унших, түгээн дэлгэрүүлэх зорилгоор ЕБС-ын 7-12 дугаар ангийн дунд 3 ангилалаар Монгол бичгийн “Тэргүүний хурдан уншигч” шалгаруулах уралдаанд нийт 94 сурагч идэвхтэй оролцож өрсөлдлөө.

2015оны 02 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Монгол хэлний тухай хуулийг гарын авлага, товхимол, мэдээллийн самбар хийж уншигч хэрэглэгчдэд сурталчлан, таниуллаа.

Аймгийн Засаг Даргын А/66 захирамжийн дагуу угийн бичгийн сургалтыг 2 удаа зохион байгуулж, картын санд 27 карт хөтөлж, “Угийн бичиг хөтлөхүй” сэдэвт 59 номоор номын үзэсгэлэнгээр 141 сурагч, оюутнуудад сурталчиллаа. ЭДЦСургууль, МСҮТөвүүдийн сурагч оюутнуудад заалаа.

Өлзийт сумын Соёлын төвтэй хамтран “Нээлттэй хаалга, мэдээллийн өдөрлөг”-ийг зохион байгуулж, нүүдлийн номын сан, санал асуулга авч, үйлчиллээ.

“Мандал” сургуулийн номын санд зөвлөн туслах үйл ажиллагааны хүрээнд “Номыг хэрхэн унших вэ” сэдэвт лекцийг 7, 8-р ангийн 100 гаруй сурагчдад, бүртгэл мэдээллийн номын санч Э.Биндэръяа, А.Эрдэнэтуяа нар “Хүүхэд бүр агуу ертөнц” сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргаж, сурталчиллаа.

“Монгол Улсын Генералууд”сэдвээр номзүйн жагсаалт хийсэн. Мөн Манай Дундговь аймгаас төрөн гарсан Хошууч генерал Жамцын Содном, Чимидийн Мижид, Бямбасүрэнгийн Баярмагнай нарын 3 Генералуудын намтар номзүйг эмхтгэн бичиж байна.

Боловсрол, соёл Шинжлэх ухааны сайдын “Үндэсний хөтөлбөр батлах тухай” тогтоолын дагуу цуур хөгжимтэй холбогдолтой номын судалгааг гаргаж, номзүйн материал цуглуулж байна
Хөгжмийн холбогдолтой 59 ширхэг номоор “Монгол цуур” сэдэвт үзэсгэлэнг 86 уншигч, ирэгсдэд сурталчиллаа.

“Номын баяр”-ын хүрээнд

- 09 сарын 07-ны өдрөөс эхлэн 12 сарын 31 хооронд уншигчын үнэмлэх, картыг үнэгүй нээж, үйлчиллээ
- Уншигчын хувийн номын сангаар үзэсгэлэн гаргалаа
- Залуучуудын эерэг хөдөлгөөн ТББ-тай хамтран "Ном уншигчдын клуб" ажиллууллаа. Ахлах ангийнхны дунд Алхимич зохиолоор уулзалт ярилцлага,
- "Ном уншъя, өөрийгөө хөгжүүлье" аян өрнүүлэн "Үлгэрийн цаг" сэдвээр бага ангийн уншигчдын дунд 6 удаагийн уулзалт зохион байгууллаа. Уулзалтын үеэр үлгэр, өгүүллэгийг чанга уншлага хийн, хамтран ярилцаж, дүгнэлт хийлээ.
- Байгууллагуудын номын санд мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.
- Ерөнхий боловсролын сургуулиудын номын санч, анги удирдсан багш нартай уулзалт зохион байгуулж, хамтран ажиллаа.
- Аймгийн ШШГГ-ын эмч, нийгмийн ажилтантай хамтран цагдан хоригдогчдод 92 номоор хүрч үйлчиллээ.
- ЕБСургуулиуд болон сумдын соёлын төвийн номын сангуудад номын баярын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай чиглэл өгсөн.

Дөрөв. ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖЛЫН ТАЛААР

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
2. “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын ажлын хүрээнд хамт олноороо “Монгол бичиг”-ийн сургалтанд идэвхитэй суралцав.
3. Сэлэнгэ аймгийн нийгмийн даатгалын хэлтэсээс Нийгмийн даатгалын шинэ хууль болон даатгалын үйлчилгээ төрийн албан хаагчдад хэрхэн хүрдэг талаар мэдээлэл хийлээ.
4. БСШУ-ны яамны сайд Лу. Гантөмөрийн Соёлын ажлын уулзалт, Дэлхийд өрсөлдөх монгол хүн лекцэнд хамт олноороо хамрагдлаа.
5. Монголын эмэгтэйчүүдийн холбооны “гэр бүл”, лектор Азбаярын лекцэнд хамрагдлаа
6. Лхагва гариг бүр мэдээллийн цагийг тогтмол явуулж ажилтнууд хуваарийн мэргэжлийн болон хууль эрхзүйн шинэ мэдээ мэдээллүүдийг хийж байна.

- Номын сангийн ном тодорхойлох журам –Номзүйч Ч.Үзмээ
- Номын сангийн ангилалын тухай –Аргазүйч Т.Нарандалай
- Дэлхийн сонирхолтой номын сангууд-Фондоч Б.Цолмонбаатар
- Электон каталогийг ашиглах аргачлал – Мэдээллийн ажилтан Г.Батбаяр
- Ном хүүхэд хоёр –Номын санч Н.Оюун-Эрдэнэ
- Хүүхэд хамгаалалын орчин – Номын санч Э. Нэргүй
- Номын санд лавлагаа номзүйн гүйцэтгэх үүрэг – Номын санч Д.Гэрэлцэцэг
- Уншлагийг удирдахуй- Номын санч Б.Баасандорж

Далд ухамсараа хэрхэн удирдах вэ?- Номын санч Д.Бүрэнжаргал МУ-ын Үндэсний Номын Сангийн Мэдээлэл, аргазүй, эрдэм шинжилгээний хэлтсийн дарга Д. Эрдэнэтунгалаг, ахлах аргазүйч Г.Гүнжинлхам, аргазүйч Б.Сарангэрэл гэсэн бүрэлдэхүүнтэй мэргэжилтэнгүүд 2 өдрийн сургалтыг Сэлэнгэ аймгийн сумдын соёлын төвийн номын санчид мөн бүх ЕБ-ын сургуулиудын номын санч нар, Нийтийн номын сангийн номын санчдыг хамруулан сургалтанд хамрагдлаа.

7. Байгууллагын зүгээс залуу ажилтануудын спорт урлагийн идэвх санаачлагыг дэмжин 7 хоногт 2 удаа гар болон сагсан бөмбөгөөр мэргэжлийн багшаар хичээл заалгаж, биеэ чийрэгжүүлж байна.

ТӨВ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. НОМЫН ФОНД БАЯЖИЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ТАЛААР ХИЙСЭН АЖЛЫН ҮР ДҮН

Аймгийн Нийтийн номын сан нь 2015 оны байдлаар төсвөөр 277 ширхэг 11-н төрлийн 3.019.500 төгрөгний шинэ ном, хандиваар 160 ширхэг 5 төрлийн 1.036.000 төгрөгний ном, 5-н төрлийн 211.400 төгрөгний тогтмол хэвлэл нийт 442 ширхэг 4.266.900 төгрөгний ном, хэвлэл захиалан авч ангилал, техник ажиллагаа, электрон каталогийг бичин уншлагын танхимуудад хувиарлаж уншигчдын хүртээл болгож байна.

Мөн МУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газар, БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар ирсэн 5 төрлийн 391 ш 8.360.000 төгрөгний номыг ЕБС-ийн номын сан болон сумдын соёлын төвийн номын сангуудад хувиарлан олгосон.

Он	**Фонд баяжилт**	**Лавлагаа ном зүй**	**Орлого**
2014	5,339,900	562	144000
2015	4,266,900	586	150200

2. БАЙНГЫН УНШИГЧ, ИРЭГСЭД, ОЛГОЖ УНШУУЛСАН НОМЫН ТООГ НЭМЭГДҮҮЛСЭН БАЙДАЛ

Танхимууд	**2014 он**			**2015 он**		
	Байнгын ушигч	**Ирэгсэд**	**Олгож уншуулсан ном**	**Байнгын ушигч**	**Ирэгсэд**	**Олгож уншуулсан ном**
Нийтийн хүрэгчдийн уншлагын танхим	1600	6200	15970	1761	6987	17782
Хүүхдийн уншлагын танхим	1600	6236	20904	1722	6851	21801
Гэрээр ном олгох танхим	664	1989	4482	651	1603	3578
Үндсэн фонд /Лавлагаа/		562		**-**	**586**	**-**
Бүгд	3864	14987	41356	4131	16027	43161
Интернэт канон компьютерийн үйлчилгээ	-	903	-	-	2002	-
Зөөврийн номын	-	2109			2123	3482

сангийн үйлчилгээ						
Нийт уншигч үйчлүүлэгч /байнгын уншигч + ирэгсэд + лавлагаа + интернэт үйлчилгээний бүгд дүн/	21863		41356	24283		46643

2014 онтой харьцуулахад байнгын уншигчдын тоо 3,8%-иар, ирэгсэд 6,5%-иар өссөн үзүүлэлттэй байна.



3. ХӨДӨӨ ОРОН НУТАГТ ЯВУУЛЫН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРГЭСЭН БАЙДАЛ

Хөдөө орон нутгийн алслагдсан хүн амд мэдээллийг тэгш шуурхай хүргэх зорилгоор явуулын номын сангийн үйлчилгээг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Өндөрширээт, Баянжаргалан, Архуст, Баянчандмань, Алтанбулаг, Баян-Өнжүүл, Сэргэлэн, Баянцагаан, Заамар, Аргалант, Батсүмбэр сум, аймгийн төвд МСҮТөв, ШШГАлба, Зуунмод сумын ЗДТГазар, Хот тохижуулах газар, аймгийн Музей, Биеийн тамир спортын газар, Хаан банк, МТТеатр зэрэг нийт 11-н сум, аймгийн төвийн 8-н байгууллагад үйлчлэн нийт 2123 уншигчдад үйлчилж төлөвлөгөөний биелэлт 100%-тай байна.

4. 2015 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН СОЁЛ, ОЛОН ТҮМНИЙ АЖИЛ

Аймгийн Нийтийн номын сан нь соёл олон түмний 8 ажил төлөвлөсөнөөс 8 ажлыг хийж 1361 хүн хамрагдаж 100% гүйцэтгэсэн.

- Жил бүр уламжлал болгон аймгийн төвийн цэцэрлэгүүдийн дунд хүүхэд багачуудын хэл яриа, сэтгэн бодох, жүжиглэх чадварыг хөгжүүлэх замаар номтой нөхөрлүүлэн ирээдүйн уншигчийг бэлтгэхээр зохион явуулдаг "Үлгэрийн баатрууд амилсан нь" тэмцээнийг 2015.04.23- нд аймгийн нийтийн номын санд зохион явууллаа. Уг арга хэмжээнд 7 цэцэрлэгийн 7 баг оролцсоноос 1-р байранд Сувилгаа чийрэгжүүлэлтийн төвийн "Нарны домог" баг, 2-р байр Ирээдүй цогцолборын "Б" байрны "Таван тивийн хүүхдүүд" баг, 3-р байр Дэгдээхэй цэцэрлэгийн "А" байрны "Хөх судар" баг 3-р байр эзлэн өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа. Нийт 7-н багийн 42 хүүхэд хамрагдсан.

- “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-II” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эх хэлний соёлын баялаг өвийг танин мэдэх, хойч үедээ өвлүүлэн сурталчлах зорилгоор Үндэсний бичиг үсгийн баярын тусгай удирдамжийн дагуу “Үндэсний бичигтэн” уралдааныг Аймгийн Нийтийн номын сан зохион байгуулан тэмдэглэн өнгөрүүллээ. Уг тэмцээний хүрээнд байгууллагуудын дунд сонирхолтой тэмцээнийг зохион явуулсан ба тэмцээнд Нэгдсэн эмнэлэгийн “Эрч хүч” баг, Цагдаагийн газрын “Монгол цагдаа” баг, Прокурорын “Үндэстэн” баг, Эрүүл мэндийн газрын “Монгол үндэстэн” гэсэн 4-н баг 20-н хүний бүрэлдэхүүнтэй оролцож Монгол бичгийн мэдлэг, оюун ухаан, авъяас чадвараа сорьсноос Нэгдсэн эмнэлэгийн “Эрч хүч” баг 1-р байр, Цагдаагийн газар “Монгол цагдаа” баг 2-р байр, Прокурор “Үндэстэн” баг 3-р байр, Эрүүл мэндийн газар “Монгол үндэстэн” баг тусгай байрыг тус тус эзэллээ.

- Төв аймгийн Зуунмод сумын ЗДТГ, Аймгийн Нийтийн номын сан хамтран Зуунмод сумын аварга шалгаруулах өсвөрийн шатарчдын “Номын өргөө-2015” тэмцээнийг зохион байгууллаа. Тус тэмцээнийг “Ж.Энхбаяр”-ын гэр бүл, “Ган судар” ХХК ивээн тэтгэж нийт 60 гаруй тамирчид 4 насны эрэгтэй, эмэгтэй 8 ангиллаар оюун ухаан ур яадвараа сорьлоо.

- Аймгийн Нийтийн номын сан, Ахмадын хороотой хамтран Зуунмод суманд ажиллаж амьдарч байгаа зохиолч яруу найрагчдын шинээр гаргасан бүтээлүүдийг иргэд уншигчидад сурталчилах, яруу найрагч хүүхдүүдийг ахмад зохиолчидтой уулзуулах, тэднээс суралцах, туршлага судлуулах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион явуулдаг **“Эрдэм номоо дээдлэе”** арга хэмжээ 2015 оны 05-р сарын 14-ний өдөр болсон. Арга хэмжээнд зохиолч, уран бүтээлчдийн 2014 онд шинээр туурвисан бүтээлийг шалгаруулсан бөгөөд 30 гаруй уран бүтээлч, зохиолч, судлаач, ахмад болон залуу яруу найрагчид оролцсон. 2014 оны “Шилдэг бүтээл шалгаруулах уралдаан”-ы тэргүүн байранд зохиолч, яруу найрагч Ш.Цэрэндоогийн “Шашныг мандуулагч, амьтныг жаргуулагч хоёрдугаар богд Жэвзүндамба хутагт Лувсандамбийдонмэ” бүтээл, дэд байранд АБТАжилтан түүх, газарзүйн багш Ю.Цогзолсүрэнгийн “Газар зүйн хичээлийн сонирхолтой асуулт хариулт” бүтээл тус тус шалгарлаа. Аймгийн Нийтийн номын сан, Ахмадын хороотой хамтран **“Эрдэм номоо дээдлэе”** арга хэмжээг энэ жил өргөжүүлэн зохиолчдын ирээдүй хойч үеийг бэлтгэх зорилгоор Зуунмод сумын ЕБС-ийн сурагчдын дунд “Хүрэл тулга-2015” шүлгийн уралдаан зохион явууллаа. Уралдаанд 14 хүүхэд оролцсоноос тэргүүн байрыг 4-р сургуулийн 7б анги сурагч Ү.Хонгорзул “Гарын алга” шүлгээрээ, дэд байрыг ХЦС-ийн 11-р ангийн сурагч С.Отгонбаяр “Хатуу” шүлгээрээ, гутгаар байрыг ХЦС-ийн 10д ангийн сурагч Д.Отгонгэрэл “Өнжүүлтэйгээ би” шүлгээрээ тус тус эзэлж байгууллагын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдав.
- Хүүхдийн уншлагын танхимын номын санч нь 7 цэцэрлэгийн 21 ангид “Үнэг тогоруу хоёр”, “Туулай яагаад сэтэрхий уруултай болсон бэ”, “Бүтэлгүй тоорой”, “Өвгөн туулай хоёр” зэрэг номоор чанга уншлага хийж 651 хүүхдүүдийг үлгэрийн ертөнцөөр аялуулсан.

- Олон улсын хүүхдийн номын баярыг тохиолдуулан аймгийн Нийтийн номын сан, 4-р сургуультай хамтран "Зохиолч, уншигчдын уулзалт"-ыг 04-р сарын 16-ны өдөр зохион байгууллаа. Уг арга хэмжээнд хүүхдийн зохиолч О.Сундуйг урьж оролцуулснаараа онцлогтой боллоо. Уулзалтын үеэр хүүхдийн зохиолч О.Сундуй уран бүтээлийнхээ талаар товч мэдээлэл хийж, уулзалтанд оролцсон сурагчид зохиолчийн уран бүтээлүүдээс уншиж, дуулж сонирхуулсан. Уулзалтанд нийт 4-н ангийн 64 хүүхэд оролцсон.

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Номын баярын өдөр тэмдэглэх тухай” 158 дугаар зарлиг, Засгийн газрын 2013 оны 295 дугаар тогтоолоор батлагдсан “Зөв монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийн “Ном” дэд хөтөлбөр, аймгийн “Номын сайн нөхөр-сургууль, хамт олон, сурагч” болзлыг хэрэгжүүлэх зорилготой Хүүхэд, өсвөр үеийнхний амьдралд номын гүйцэтгэх үүрэг, эрдэм номын ач тусыг ойлгуулан сурталчилах, нийгмийн оюун санааг номоор соён гэгээрүүлэх зорилттойгоор ***“Бид номд дуртай”*** уриан дор Боловсрол соёлын газар, Аймгийн нийтийн номын сан, “Хүмүүн цогцолбор” сургууль, 4-р сургууль, 5-р сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв хамтран 2015 оны 10 дугаар сарын 20-ны өдөр “Номын баяр-2015” арга хэмжээг зохион байгуулан тэмдэглэн өнгөрүүллээ. Арга хэмжээний хүрээнд “Зохиолч уншигчдын уулзалт”, “Уран уншлагын тэмцээн”, “Ном хөтөлбөрийн тайлан үзэсгэлэн”, “Ном хандивлах аян”, “Сурах бичгийн худалдаа” зэрэг ажлуудыг зохиож 400 орчим хүүхэд хамруулсан.

- Дэлхийн болон Монголын хүүхдийн шилдэг зохиол бүтээлийг хүүхэд, багачуудад таниулан сурталчлах, номонд дуртай болгох, номтой нөхөрлүүлэх, тэдний дунд уран уншлагын урлагийг дэлгэрүүлэх, авъяасыг нээн хөгжүүлэх зорилгоор зохиогдсон "Уран жиргээ-2015" уралдааныг 2015 оны 4-р сарын 3-ны өдөр Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэстэй хамтран зохион байгууллаа.

5. "НОМ" ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

- Засгийн газрын 295 дугаар тогтоолоор батлагдсан "Зөв монгол хүүхэд" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийг эрчимжүүлэх үүднээс аймгийн хэмжээнд 4 дэх жилдээ зохион байгуулсан "Номын сайн нөхөр-Сургууль, анги хамт олон" болзолт уралдаанд Баяндэлгэр, Борнуур, Баянчандмань сумын сургуулиуд болон Баянчандмань сумын ЕБС-ийн 1а, 4а, 5а,7а, 10а, Баяндэлгэр сумын ЕБС-ийн 3а, 9а, Бүрэн сумын ЕБС-ийн 2а, Цээл сумын ЕБС-ийн 6а, Хүмүүн цогцолбор сургуулийн 11и ангиуд шалгарч, 24 сурагч Д.Нацагдорж тэмдгийн болзол хангалаа. Уралдааны үр дүнд номтой нөхөрлөсөн хүүхэд 86.8% буюу өмнөх оноос 0.4%-иар, бүтээлчээр унших чадвартай болсон хүүхэд 85.3% буюу өмнөх оноос 1.4%-иар тус тус ахисан боловч зорилтот түвшингээс 1.6%-иар доогуур үзүүлэлттэй байна.
- "Ном" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Ном унших арга зүй" сэдэвт илтгэлийн уралдааныг хүүхэд залуус, гэр бүлийн ном унших сэдэл тэмүүллийг төрүүлэх, бүтээлчээр унших арга болон ном унших соёлд суралцуулах, номыг эрхэмлэх үзэл санааг төлөвшүүлэх, бусдад түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2015.04.01-нээс 2015.05.01-нд зохион байгуулж 6 бүсээс шалгарсан 7 шилдэг багшийн илтгэл оролцсон.

- “Ном” хөтөлбөрийн хүрээнд гэр бүлийг гэр бүлээр нь ном уншуулах, ном туурвин бүтээх шилдэг арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх, энэ үйлсэд олон нийтийн татан оролцуулах зорилгоор “Оюунлаг гэр бүл” аяныг 2015 оны 3, 4-р сард Боловсролын газартай хамтран зохион байгуулсан. Аянд 26 сум хамрагдсанаас 10 сум амжилттай оролцож 1-р байрыг Батсүмбэр сумын гэр бүл, 2-р байрыг Эрдэнэ сумын гэр бүл, 3-р байрыг Өндөрширээт сумын гэр бүл тус тус эзэллээ. Тэдний арга туршлага амжилтыг орон нутгийн телевизээр сурталчилсан.

6. СУРГАЛТ, СЕМИНАРТ ХАМРАГДАЖ МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙДАЛ.

- Номын санч нарын мэргэжлийг нь дээшлүүлэн чадавхижуулж, иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанарт үр дүн, ахиц гаргах зорилгоор "Номын сангийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх нь" сэдэвт сургалт семинарыг сум, сургуулийн номын санчдын дунд 2015.03.26-27-ны өдрүүдэд аймгийн Нийтийн номын сангийн байранд зохион байгууллаа. Сургалтанд соёлын төвийн номын санчид 92,3%-н ирцтэй, ЕБС, МСҮТ-ийн номын санчид 75%-н ирцтэй, Нийт сургалтанд хамрагдалт 83,6%-тай байлаа. Сургалтанд СУИС-ийн Соёлын сургуулийн багш Тунгалаг, Оюундэлгэрэх нарыг урьж “Соёл олон түмний ажил, зохион байгуулалт, төрлүүд”, “Үйлчилгээний байгууллагын харилцааны соёл” сэдвүүдээр нийт 8 цагийн лекц авч мэдлэг чадвараа дээшлүүллээ.

- Яамнаас баримтлаж байгаа бодлогын дагуу өөр мэргэжлээр төгсөөд номын санчаар ажиллаж байгаа номын санчийг мэргэжлийн болгох 1,6 жилийн сургалтанд Дэлгэрхаан, Баяндэлгэр сумын ЕБС-ийн номын санчдыг сургаж байна.
- Байгууллагын албан хаагчдын Монгол хэл, бичгийн боловсролыг сайжруулах зорилгоор Зөв бичгийн дүрэм, албан бичгийн хэл найруулгын 8 цагийн сургалтанд 12 албан хаагчид хамрагдаж монгол хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлсэн.
- Нийтийн номын сангийн мэргэжлийн албан хаагчид дотоод удирдлагын системд холбогдож захидал харилцааны программыг ашиглан сум, албан байгууллагуудад мэдээ мэдээллээ тогтмол хүргэн ажиллаж байна. Мэдээлэл технологийн ажилтан нь Able Desktop болон E-Office программ хэрхэн ашиглах талаар байгууллагын албан хаагчдад 2 удаагийн сургалт хийсэн.
- Аймгийн Нийтийн номын сангийн боловсон хүчний хангалт 100%, сумдын соёлын төвийн номын сангийн боловсон хүчний хангалтыг 84,6%-д хүргэсэн.



7. 2015 ОНД СУМ, СУРГУУЛИЙН НОМЫН САНГУУДАД АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГЧ, НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЛААР

- Аймгийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн харьяа ХГБХХ, АННСан, ХСЧТөв, аймгийн музей зэрэг байгууллагууд 2015 оны 04-р сарын 23, 24-нд Баянжаргалан, Архуст суманд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулж ажиллалаа. Уг өдөрлөгөөр байгууллагууд нь өөрийн үйл ажиллагааны онцлогийн харуулсан самбар, үзэсгэлэн гаргаж байгууллагын танилцуулга, мэдээлэл хийж 130 гаруй иргэдтэй уулзалт зохион байгууллаа.

Сум, сургуулийн номын сангуудад мэргэжил аргазүйн зөвлөлгөө өгч, 60 гаруй иргэдээс номын сангийн талаархи санал асуулга авч тулгамдсан зарим асуудлаар хариу өгсөн. Дээрхи өдөрлөгийн үеэр явуулын номын сангийн үйлчилгээ үзүүлж,

шинэ номын худалдаагаар 38 ширхэг 100 гаруй мянган төгрөгний шинэ номын борлуулалт хийсэн.

- Өндөрширээт, Эрдэнэсант, Лүн сумын ЕБС-ийн номын санд мэргэжлийн туслалцаа үзүүлж Заамар, Аргалант сумдын сум, сургуулийн номын сангуудад арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Үүнд:

  - Номын сангийн анхан шатны бүртгэл хөтлөлтийг стандартын дагуу хөтлүүлж эхлүүлсэн
  - Нийт 1700 гаруй номыг Номын сан-Номзүйн ангилалаар ангилж төрөл анги, Үсэг дараалалаар байрлуулж хаяг, ялгагчийг хийсэн
  - 150 ш номонд каталогийн карт бичиж үсэг дараалалаар байрлуулж номонд техник ажиллагаа хийх зэрэг ажлуудыг хийж мэргэжил аргазүйн туслалцаа үзүүлсэн.

8. ИНТЕРНЭТ БОЛОН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

- Аймгийн Нийтийн номын сангийн Интернэт мэдээллийн танхимаар 2015 оны байлаар 2002 хүнд үйлчилж 150.200 төгрөгний орлоготой ажилласан.



- Аймгийн нийтийн номын сангийн фондын бүх номыг 100% электрон каталогит оруулсан ба электрон каталогоо өөрийн байгууллагын вэб сайтад байрлуулан уншигчид орон зай харгалзахгүй мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн.

- Иргэдийг мэдээллээр хангах, номын сангийн үйл ажиллагааг уншигч үйлчлүүлэгчдэд нээлттэй байлгах зорилгоор байгууллагын www.library.to.gov.mn вэб сайтын мэдээллийн санг тухай бүр баяжуулж үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. Одоогийн байдлаар вэб сайтад 101164 хүн хандаж мэдээлэл авсан бөгөөд энэ нь сард дунджаар 130-150 хүн хандалт хийж мэдээлэл авсан байна.

- Шилэн дансны хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх үүднээс байгууллагын веб сайт болон шилэн дансны веб сайтад батлагдаж ирсэн төсөв гүйцэтгэл, аудитын дүгнэлтийг ил тодоор байрлуулан хэрэгжилтийг тухай бүр гаргаж байна.

- Дотоод удирдлагын системийг үйл ажиллагаандаа өдөр тутам ашиглахын тулд мэргэжлийн 6 албан хаагчдыг 2 удаа ажлын байрны сургалтад хамруулж

холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй мэдээллийг хурдан шуурхай дамжуулж байгууллагынхаа ажил хэргийг зохион байгуулалттай явуулж байна.

9. 2015 ОНД ХИЙСЭН ШИНЭЛЭГ БҮТЭЭЛЧ АЖИЛ

- Аймгийн Нийтийн номын сангаас номын сангийн үйлчилгээг иргэдэд султалчилах, хүртээмжтэй хүргэх, номыг бүтээлчээр унших арга соёлд суралцах, гэр бүлээр нь ном уншуулах зорилгоор Зуунмод сумын 6 багийг хамруулан **“Зуны зугаатай уншлага”** арга хэмжээг 2015 оны 07-р сарын 22-ноос 31-ны хооронд удирдамжийн дагуу амжилттай зохион байгуулж өндөрлөлөө.

Уг арга хэмжээг 2 үе шаттай явуулсан бөгөөд эхний арга хэмжээ нь ***багуудад зохион байгуулагдах арга хэмжээ*** байлаа.

- Багуудад хуваарийн дагуу очиж явуулын номын сангийн үйлчилгээг хүргэх
- Байгууллагын үйл ажиллагааг танилцуулах
- Номын сангийн үйл ажиллагааны талаар санал асуулга авах
- Танин мэдэхүйн тэмцээн явуулах /АХА, түргэн хэллэг/ зэрэг 4-н төрлийн арга хэмжээ зохион байгуулсан.

2-р шатны арга хэмжээ нь багуудаас ирсэн гэр бүл \эцэг, эх, хүүхэд\-ийн хооронд өртөөчлөн зохион байгуулагдсан ***“Зуны зугаатай уншлага”*** өдөрлөг зохион байгуулж нийт 150 гаруй хүн оролцлоо.

- Өсвөр залуу үеийнхэнд мэргэжлийн чиг баримжаа олгох, хүүхэд бүрийг төлөвшүүлэх, хөгжүүлэх зорилгоор “**Өсвөрийн номын санч**” дугуйлан ажиллуулж эхэлсэн. Тус дугуйланд сургууль тус бүрээс 2, 2 хүүхэд хамруулан “Номын сангийн үйлчилгээний танхимуудын танилцуулга, Номын фондын зохион байгуулалт, ном хадгалах, Номын санд шинээр ирсэн номыг нэгтсэн болон нэгбүрчилсэн бүртгэлд авах, номын

сангийн Lib4U программыг ашиглах, цахим мэдээлэл хүргэх зэрэг сэдвүүдээр сургалт явуулж 14 хоногт 1 удаа хичээллэж номын сангийн тухай ойлголт мэдлэгийг эзэмшин, мэдээлэл авч түүнийгээ ашиглах чадварийг эзэмшсэн. Мөн номын сангаас зохион байгуулсан соёл олон түмний ажлыг зохион байгуулахад туслан хамтран ажиллаж байна.

УВС АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Манай хамт олон "**Үйлчлүүлэгчдийнхээ оюуны эрэлт хэрэгцээг бүрэн дүүрэн хангаж чадахуйц хөгжлийн түвшинд хүрч, Номын санг иргэдэд үйлчлэх нээлттэй "*Мэдээллийн төв"*** болгон хөгжүүлэх эрхэм зорилго тавин ажиллаж байна.

Үйл ажиллагаагаа төрөөс баримтлах соёлын бодлого, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Засаг Даргын үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын Соёлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон түүнийг хэрэгжүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна. Манай байгууллага нь үйл ажиллагааны төлөвлөгөөндөө стратегийн 3 зорилт бүхий 12 ажил үйлчилгээ, 4 тусгай захиалгат бүтээгдэхүүнийг нийлүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнээс 2015 онд хийж гүйцэтгэсэн ажлын биелэлтийг үзэхэд:

Стратеги-1. "**Байгууллагын тогтвортой хөгжил, номын сангийн үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах"** зорилтын хүрээнд :

1. Номын сангийн цахим үйлчилгээг үнэ төлбөргүйгээр хүргэж, байгууллагын фэйсбүк хаяг, блог хаягаар байгууллагын үйл ажилагаа болон шинэ номын мэдээ мэдээлэлүүдийг интернет үйлчилгээний төрлөөр 8000 хүнд хүрч үйлчиллээ
2. Иргэдийн гар дамжин хэрэглэгдэж элэгдэж урагдсан, хуучирсан 5000 ширхэг номыг сэргээн засварласан. Үүнээс номын санч Алтанцэцэг 1300 ширхэг, Номын санч Биньеэ 1300 ширхэг, Номын санч Жаргал 1300 ширхэг, номын санч Уранчимэг 1100 ширхэг ном сэлбэн зассан байна.
3. "Номын сангийн үйл ажиллагааны талаар болон шинэ номын мэдээ мэдээллийг, байгууллагын вэб хаяг болон хувь хүмүүсийн мэйл хаягруу

явуулахаас гадна САМА телевизээр 7 хоног бүр нийтэд сурталчилж хэвшсэн байна.

4. Хилийн цэргийн 0245-р анги, 2-р цэцэрлэг, МХГ, Эрүүл мэндийн газар, Шүүх, Нийгмийн халамж үйлчилгээний газар зэрэг байгууллагуудад зөөврийн номоор үйлчилж байна.
5. Бичиг соёлын хишиг өдрийг тохиолдуулан "**Монгол бичгээр сайхан бичигтэн шалгаруулах"** ээлжит уралдааныг зохион явуулж дүгнэлээ. Үүнд: Бүтээлийн төрлөөр цогцолбор 2 сургуулийн багш Туул 1-р байр, УГПК-ийн багш Батхишиг 2-р байр, Уран бичлэгийн төрлөөр ахлах 3 сургуулийн Тайван багштай 7-а ангийн хамт олон 1-р байрыг тус тус эзэллээ.
6. 2014 оны Уншлагын танхимын рекорд номоор "**Луун шивээст охин"** роман, Тэргүүний уншигчаар Эрүүл мэндийн газрын дарга **Бааст** овогтой **Содном** шалгарлаа.
7. Хүүхдийн танхимын 2015 оны эхний хагас жилийн "**Тэргүүний уншигч"** ангиар **Таван тэс бага сургуулийн С. Оюунгэрэл багштай 3-а ангийн хамт олон**, "**Рекорд** "номоор Д. Дэлгэржаргалын "**Динза**" цуврал ном шалгарлаа.
8. "Хөдөө аж ахуй–газар тариалан" шинэ тосгоны номын үзэсгэлэн, Цогцолбор 2-р сургуулиас солилцоогоор ирсэн номын үзэсгэлэн, Түүхэн сэдэвт үзэсгэлэн, Хүүхдийн уран зохиол, Орчуулгын хүүхдийн уран зохиол, Гэр бүлийн өдөрт зориулсан үзэсгэлэн, Амьдрах ухаан, Шинээр ирсэн номын үзэсгэлэнгүүд Шүүхийн байгууллага дээр гарсан үзэсгэлэнгүүд гэх мэтээр шинэ ба сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 76 удаа гаргалаа.
9. Аймгийн ИТХ, ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийг авч нэгж болгон үдэж иргэдэд мэдээлж байна.
10. 04-р сарын 1-ний өдрөөс эхлэн номын сангийн уншигч бүртгэх, ном олголтыг **LiB 4U** программ дээр гүйцэтгэх шинэ дэвшилтэт ажлыг нэвтрүүллээ. Ингэснээр номын санчид уншигчдад түргэн шуурхай үйлчлэх, цаг хэмнэх, номын санчдын сар бүрийн үйлчилгээний тайлан, бүртгэлийг программ дээрээс шууд харж болох давуу талуудтай боллоо.
11. Хүүхдийг багаас нь номонд дуртай болгох зорилгоор цэцэрлэгийн багачуудыг номын сангийн үйл ажиллагатай танилцуулах ажлыг зохион байгуулж 1,7,2,4-р цэцэрлэгүүдийн бэлтгэл бүлгийн 300 гаруй хүүхдэд үйлчиллээ. Мөн Таван тэс бага сургуультай номын санд ном унших гэрээ байгуулан 5 бүлгийн 100 хүүхдийг уншигчаар бүртгэн үйлчилгээ үзүүллээ.

12. Байгууллагын ажилчдад Цагдаагийн газрын сэтгэл зүйч О. Анугаар "**Харилцааны соёл**" сэдвээр лекц уншуулллаа.
13. Аймгийн засаг даргын А/07 тоот захирамжийн дагуу аймгийн чөлөөт ахмадын холбоотой хамтран ахмадуудын дунд цэнгүүн зохион байгууллаа.
14. Боловсрол соёлын газраас зохион байгуулсан сумдын соёлын ажилтны бүсчилсэн сургалт, сургуулийн номын санчдын бүсчилсэн сургалтаар номын сангуудын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.
15. Сумдын соёлын төвийн номын санчдыг зохион байгуулж Үндэсний номын сан, Эрдэнэт, Дархан, Булган аймгуудын номын сангуудтай танилцах, туршлага солилцох, мэргэжил арга зүйгээр хангах ажлуудыг хийлээ.
16. 2015 оны Номын баярыг Увс аймгийн Төв номын сан, БСГ, Ойрад театр хамтран тэмдэглэж өргөн дэлгэр болж өнгөрлөө.

    Энэ үеэр:

    -Урлагийн тоглолт

    -номын сангийн уншлагын танхимуудад номын үзэсгэлэн гаргах

    -сургуулиудад ном хандивлах үйл ажиллагаа

    -зохиолчдын зохиол бүтээлийг хэн сайн мэдэх вэ хөгжөөнт тоглоом явуулах

    -хөдөөгийн сургуулиудын номын санчдын ном хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажлын тайлан тавих

    -ном хөтөлбөрийн хүрээнд хийсэн бүтээлийн үзэсгэлэн гаргах гэх мэт ажлуудыг зохион байгууллаа
17. Увс аймгийн Төв номын сан,Тод номын гэрэл төв хамтран Нэрт эрдэмтэн зохиолч Б.Ринченгийн мэндэлсний 110 жилийн ойг угтаж түүний амьдрал уран бүтээлийн талаар уулзалт ярилцлага зохион явууллаа. 2015.09.30
18. Увс аймгийн Төв номын сан "Нээлттэй хаалганы өдөр"-ийг шинэлэг хэлбэрээр зохион байгуулах зорилгоор 2015.10.27ны өдөр ШШГА-ны харьяа цагдан хорих байранд хоригдож буй хүмүүст номын үзэсгэлэн гарган сонирхуулж, карт нээн ном олгож үйлчиллээ. Амьдралдаа алдаж оножн яваа тэр хүмүүст оюунд нь бага ч гэсэн хөрөнгө оруулалт хийсэн.
19. 10-15, 16-70 насны иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч тэдний санал хүсэлтэнд дүгнэлт хийж цаашдынхаа үйл ажиллагаанд тусган ажиллаж байна.

Стратеги-2. “Фондын баяжилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах” зорилтын хүрээнд:

- Фондын номын хадгалалт хамгаалалт, орчин нөхцлийг нь сайжруулах талаар тусгай төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.
- Фондын нийт номын ялгагч ба хаягжуулах ажлыг шинэчиллээ.
- Улирал тутам номыг стандартын дагуу ариутгах, хортон шавьжаас хамгаалах ажлыг тогтмолжууллаа.
- 378300 төгрөгний тогтмол хэвлэлийг захиалж уншигчдад үйлчиллээ.

➢ Иргэдийн хүсэлтийн дагуу шаардлагатай 200 гаруй номын жагсаалт гаргаж фонд бүрдүүлэх ажлыг зохион байгууллаа.

➢ Худалдаагаар 18 нэр төрлийн 174 ширхэг 1559400 төгрөгний номоор, хандив бэлгийн журмаар 121 нэр төрлийн 375 ширхэг 4925680 төгрөгний ном хэвлэлээр нийтдээ 139 нэр төрлийн 549 ширхэг 6485080 төгрөгийн номоор фонд баяжилт хийлээ.

- Фондын номын хадгалалт хамгаалалтыг сайжруулахын тулд сар бүр их цэвэрлэгээ хийж, тоос соруулах, хлорамины уусмалаар арчиж цэвэрлэх ажлыг тогтмолжууллаа.

Стратеги- 3. Батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулах ажлын хүрээнд:

- Шилэн халаас, Шилэн данс хөтөлбөрийн хүрээнд байгууллагын төсвийн зарцуулалтыг сар бүр хамт олны цуглаан дээр вэб хаяг болон ил тодын самбарт тавьж мэдээллээ. Монгол Улсын Засгийн Газрын 2012 оны 17-р тогтоолоор батлагдсан “Төсөв санхүүгийн ил тод байдлын хангах журам”, “Шилэн дансны тухай хууль”, “шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажилтан албан хаагчдад сургалт мэдээлэл хийж шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байгууллагын мэдээллийг байршуулан хэрэгжилтийн тайланг аймгийн санхүү хяналт аудитын албанд хүргүүлээ.

  Санхүүгийн мэдээллийг олон нийтэд ойлгомжтой байхаар:

  ✓ Төсвийн гүйцэтгэлийн тайлан, жилийн үйлчилгээний орлого, зардалын батлагдсан төсөв, гүйцэтгэл, төсвийн хэмнэлт, зардлын хэтрэлт төсөвт төвлөрүүлсэн орлого , батлагдсан орон тоо

  ✓ Худалдан авалтын тайланг бэлтгэн нийлүүлэгч тус бүрээр тоо хэмжээ нэгж болон үнээр нь

- ✓ Үзүүлсэн үйлчилгээ, үнэ тариф
- ✓ Орлогын төлөвлөгөө
- ✓ Хууль эрх зүй гэсэн бүтэцтэйгээр санхүүгийн ил тодын байдлын самбарт мэдээлэл гарган танилцуулж ажиллалаа.
- ✓ Шилэн халаас хөтөлбөрийн хэрэгжилт болон монитерингийн үнэлгээгээр “сайн “ дүнтэй шалгагдлаа.

Нийлүүлэх тусгай захиалгат бүтээгдэхүүний биелэлт:

- 2015 онд байнгын уншигчдын тоог 4360 нийт уншигчдын тоог 34050 уншигчдад хүргэж ажиллалаа.
- Нийт уншигчдад 40220 ш ном хэвлэл олгон үйлчиллээ.
- Фондын номнуудыг 100 хувь электрон катологт оруулж баркоджуулан, номнуудаа хайлтын компьютерт тавьж үйлчилж байна. Уншигчид хэрэгцээт ном хэвлэлээ хайлт хийх зааврын дагуу хайлтын компьютерээс олох боломжтой болсон.
- Худалдаагаар 18 нэр төрлийн 174 ширхэг 1559400 төгрөгний номоор, хандив бэлгийн журмаар 121 нэр төрлийн 375 ширхэг 4925680 төгрөгний ном хэвлэлээр нийтдээ 139 нэр төрлийн 549 ширхэг 6485080 төгрөгийн номоор фонд баяжилт хийлээ.

Тайлан мэдээ, хугацаатай албан бичгийн хариу ирүүлсэн байдал:

Жилийн байдлаар нийт 40 албан бичиг ирсэнээс 21 албан бичигт хариуг нь хугацаанд нь шийдвэрлэж бусад албан бичигтэй танилцан ажиллалаа.

Улирал бүрийн үйл ажиллагааны тайлан болон СУ-3, СУ-15, СУ-10 мэдээнүүдийг хуулийн хугацаанд нь үнэн зөв гаргаж холбогдох газруудад нь хүргүүллээ. Албан хэрэг хөтлөлтийн заавар журмын дагуу өмнөх оны бичиг баримтуудыг нэгж болгон ангилж архивласан.

Байгууллагын ил тод, нээлттэй байдлын талаар зохион байгуулсан ажил:

- **Үйл ажиллагааны ил тод байдал:**

Үйлчлүүлэгчдийнхээ оюуны эрэлт хэрэгцээг бүрэн дүүрэн хангаж чадахуйц хөгжлийн түвшинд хүрч, Номын санг иргэдэд үйлчлэх нээлттэй “*Мэдээллийн төв”* болгон хөгжүүлэх эрхэм зорилго тавин ажиллаж байна.

Орон нутгийн САМА телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулан долоо хоногийн 5 дахь өдөр бүр шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг сурталчилж байна. Мөн Увсын өнгө сонин, номын сангийн фэйсбүүк хаяг, uvslibraryblgspot.com, shilendans нэгдсэн хаягуудад үйл ажиллагааныхаа талаар болон мэдээллээ байршуулж ажиллалаа. Байгууллагын үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт зэргийн ил тод байдлыг хангаан ажиллах зорилгоор Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

- **Хүний нөөцийн бодлогын ил тод байдал:**

Байгууллагаас хүний нөөцийн ил тод байдлыг хангах зорилгоор дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Боловсрол соёлын газраас зохион байгуулсан сумдын соёлын ажилтны бүсчилсэн сургалт, сургуулийн номын санчдын бүсчилсэн сургалтаар номын сангуудын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Сумдын соёлын төвийн номын санчдыг зохион байгуулж Үндэсний номын сан, Эрдэнэт, Дархан, Булган аймгуудын номын сангуудтай танилцах, туршлага солилцох, мэргэжил арга зүйгээр хангах ажлуудыг хийлээ.

Ажилчдыг ажлын байран дээрээ хөгжих, мэргэжлийн мэдээлэл арга зүйг хэрэгжүүлэх, бусад номын сангуудаас туршлага солилцох боломжийг нээж интернет цахим үйлчилгээг тогтмолжууллаа.

Төрийн бүх төрлийн ажил үйлчилгээнд технологийн дэвшлийг нэвтрүүлэх, цахимжуулах, иргэдэд шуурхай хүргэх ажлын талаар:

- **Номын сангийн цогц програм Lib4U**

Номын сангийн цогц програм **Lib4U** netversion програмыг 4 сая.төгрөгөөр худалдан авсан.

Энэхүү програмыг нэвтрүүлснээр :

1. Уншигч, үйлчлүүлэгч Номын санд ирэхгүйгээр интернэт ашиглан http://103.242.46.71/ хаягаар манай электрон каталогт байгаа нийт номноос хайлт хийх боломж бүрдсэн. Одоогийн байдлаар үйлчлүүлэгчид 34860 удаа хайлт хийсэн байна.

2. Мөн уншигч электрон хувилбартай номуудыг Номын санд ирэхгүйгээр татан авч унших боломжтой.
3. Номын сангийнхаа үйл ажиллагаанд зураасан кодны үйлчилгээний системийг бүрэн нэвтрүүлснээр номын санчдын бичиг цаас, бүртгэлийн гар ажиллагааг багасгаж илүү шуурхай, орчин үеийн жишигт нийцсэн үйлчилгээ үзүүлдэг болсон.
4. Програмыг ашиглан каталогийн цаасан карт, номын формуляр, зураасан код, уншигчийн зураасан кодтой үнэмлэх хэвлэн гаргадаг. Номын сангийн өдөр тутмын бүртгэлийг автоматаар хөтөлдөг. Програмаас уншигч, ирц, ном олголт, буцааж авсан номын мэдээллийг шинжлэх ухааны салбар, төрөл анги, хэл тус бүрээр нь гарган авч ажилдаа хэрэглэж байна.
5. Уг програм хангамжийг ашиглан, ном, мэдээллийн электрон каталогийн санг бүрдүүлэх, бар кодын туслалцаатайгаар асар их хугацаа, хөдөлмөр шаарддаг номын тооллогын ажлыг богино хугацаанд гүйцэтгэх, уншигчдад дотоод болон интернетийн сүлжээг ашиглан номын сангаар үйлчлүүлэх бүрэн боломжоор хангагдаж байна. Мөн төрөл бүрийн статистик үзүүлэлтийг гаргах зэрэг үйлдлүүд автоматаар хийгдэж бидний дотоод ажиллагааны цаг завыг ихээхэн хэмнэж байна.

- **Номын сан, соёл урлагийн тайлангийн програм MonBiblio**

2013 оны 1-р сард Соёл, спорт, аялал жуулчлалын яамны захиалгаар номын сангийн програм хангамжийг нэвтрүүлэх зорилгоор Увс аймгийн 19 сумын Соёлын төвийн номын санд Monbiblio програм хангамжийг суурилуулсан.

Энэхүү програмыг нэвтрүүлснээр:

1. Номын сангийн ажилтнуудын цаг ашиглалт сайжирсан.
2. Үйлчилгээний хурд болон үр нөлөө, чанар сайжирсан
3. Мэдээлэл түргэн шуурхай цацагддаг болж, үйлчилгээний шинэ хэлбэр, үйлчилгээний бүтээмж нэмэгдсэн
4. Номын сангийн үйлчилгээний төрөл нэмэгдсэн
5. Онлайд суурилсан үйлчилгээг бий болгох боломжтой болсон

6. Нэгдсэн каталог бий болсноор манай аймгийн 19 сумын Соёлын төвийн номын сангаас 45677 ширхэг ном оруулсан байна. Богино хугацаанд тайлан, статистикийн мэдээг нэгтгэх Яамны серверт бүх номын сангийн мэдээлэл цугларсан
7. Тайлангууд нэг стандарт загвараар экспорт, импорт хийж байна.
8. Номын сан бүр мэдээлэл солилцох боломжтой болсон

Байгууллагын тохижилтын талаар:

- Увс аймгийн 90 жилийн ойн баяртай холбогдуулан байгууллагын өнгө үзэмж сайжруулах үүднээс ажилчдын нөөц бололцоог дайчлан байгууллагын гадна талыг шохойдох, будах, ажилчдынхаа хашааг хамтын хүчээр засаж сэлбэх, будах зосдох, хээлэх бүтээлч ажлуудыг хийлээ.
- Улаангом хотын ногоон байгууламжийн хүрээнд наадмын талбайд 20 ш мод тарилаа.
- Байгууллагын өрөө тасалгаануудаа нэмж цэцэгжүүлэлт хийлээ.
- Байгууллагын дотоод тохижилт өнгө үзэмж, уншигч үйлчлүүлэгчдийн үйлчлүүлэх болон ажилтан албан хаагчдын ажиллах орчны тав тухыг сайжруулж ажиллаж байна .

Сахилга хариуцлагын талаар:

- Ажилчдын ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг цаг ямагт сайжруулахын тулд ажилчидтай үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ, хариуцлагын гэрээ байгуулан хагас жил тутам дүгнэн ажиллаж байна.

- Байгууллагын дотоод хяналт шалгалтын хуваарийг гаргаж, хяналт шалгалт хийн шалгалтын мөрөөр арга хэмжээ авч ажиллалаа.

- Цаг ашиглалтын байдалд харуулууд өдөр тутам тэмдэглэл хөтлөж бүртгэж байгаа бөгөөд ня-бо хяналт тавин ажиллаж байна.

- Монгол улсын төрөөс баримтлах соёлын бодлого, соёлын тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг хавтас нээн эмхтгэн нийтэд сурталчилж байна

Хяналт шинжилгээ, тайлан мэдээний байдал:

- Номын сан нь статистикийн СУ-3, СУ-10, СУ-15 гэсэн 3 төрлийн мэдээг гаргаж өгдөг. Үүнээс СУ-3 мэдээг улирал тутам, СУ-10 СУ-15 мэдээг жил эцсээр гаргаж аймгийн БСГ , Статистикийн хэлтэс, МҮҮНС-д хүргүүлж хэвшсэн.
- Байгууллагын ажилчдаас болон үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч үйл ажиллагаандаа тусган ажиллалаа.
- Номын сангийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах стандарт, дүрэм, журам хөтлөгдөх бүртгэл тооцооны хөтлөлтийг улирал тутам шалган дүгнэж зааварчлагаа өгөн ажиллалаа.
- Сайн ажилласан ажилтанг алдаршуулах, жилийн эцэст ажлаа дүгнэж байгууллагын аварга, тэргүүнийг шалгаруулах, аймгийн болон яамны, ЗГ-ын шагналд тодорхойлох зэрэг урамшууллын дэмжлэг үзүүллээ.

ТӨВ НОМЫН САНГИЙН 2015 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээ	Төлөвлөгөө хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрсэн үр дүн ,үр дагавар	Хувь
1	2	3	4
Нэг. Байгууллагын тогтвортой хөгжил, номын сангийн үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах			
Стратеги:1 **Байгууллагын тогтвортой хөгжил, номын сангийн үйлчилгээний**	2015 онд байнгын уншигчийн тоог 4250 нийт уншигчдын тоог 33000 –д хүргэн ажиллах зорилт тавьж	2015 онд байнгын уншигчийн тоог 4360 нийт уншигчдын тоог 34050 –д хүргэн ажиллалаа.	102,5%
	2015 онд 40,200 ширхэг ном хэвлэлээр үйлчилж номын фондын эргэлтийг 54 %-д хүргэнэ.	2015 онд 40220 ширхэг ном хэвлэлээр үйлчилж фондын эргэлтийг 54,1 %-д хүргэлээ.	100%

хүртээмж чанарыг сайжруулах	**-Шинэ ба сэдэвчилсэн номын үзэсгэлэн 70 удаа гаргах**	Уншигчдад Шинэ болон Сэдэвчилсэн үзэсгэлэнг 70 удаа гаргаж сурталчиллаа. Үүнд: Газар тариалан, Мал аж ахуй, Багш нарын баярын өдөр, Дэлхийн яруу найргийн өдөрт, Цагаан сарын баярт, Хүүхдийн уран зохиол, Хүний эрхийн өдөрт, Амьдрах ухаан гэх мэт мөн Мөн САМА телевизээр 7 хоног бүр номын санчид ээлжээр шинэ номын сурталчилгааг байнгын хийж хэвшсэн.	100%
	Интернет үйлчилгээнд 8000 хүн хамруулах	- Номын сангийн цахим үйлчилгээг үнэ төлбөргүйгээр хүргэж, байгууллагын фэйсбүк хаяг, блог хаягаар байгууллагын үйл ажилагаа болон шинэ номын мэдээ мэдээлэлүүдийг интернет үйлчилгээний төрлөөр 8000 хүнд хүрч үйлчиллээ	100%
	5000 ширхэг	Иргэдийн гар дамжин хэрэглэгдэж	

	номонд сэлбэн засалт хийх	элэгдэж урагдсан, хуучирсан 5000 ширхэг номыг сэргээн засварласан. Үүнээс номын санч Алтанцэцэг 1300 ширхэг, Номын санч Биньеэ 1300 ширхэг, Номын санч Жаргал 1300 ширхэг, номын санч Уранчимэг 1100 ширхэг ном сэлбэн зассан байна.	100%
	Соёл олон түмний ажил 6 удаа зохион байгуулах	Номын сангийн үйл ажиллагааны талаар болон шинэ номын мэдээ мэдээллийг, байгууллагын вэб хаяг болон хувь хүмүүсийн мэйл хаягруу явуулахаас гадна САМА телевизээр 7 хоног бүр нийтэд сурталчилж байна Үйл ажиллагаагаа өөрийн блог хаягандаа нээлттэй ил тодоор байршуулан ажиллаа. Хилийн цэргийн 0245-р анги , 2-р	100%

<table>
<tr><td></td><td></td><td>цэцэрлэг, МХГ, Эрүүл мэндийн газар, Шүүх, Нийгмийн халамж үйлчилгээний газар зэрэг байгууллагуудад гэрээний дагуу хамтран ажиллаж , зөөврийн номоор үйлчилж байна.

Эрүүл мэндийн газар, Хилийн цэргийн 0245-р анги, Шүүх, Нийгмийн халамж үйлчилгээний газруудад зөөврийн номын сан ажиллуулж байна.

Бичиг соёлын хишиг өдрийг тохиолдуулан “**Монгол бичгээр сайхан бичигтэн“ шалгаруулах** ээлжит уралдааныг зохион явуулж дүгнэлээ. Үүнд: Бүтээлийн төрлөөр цогцолбор 2 сургуулийн багш Туул 1-р байр, УГПК-ийн багш Батхишиг 2-р байр, Уран бичлэгийн төрлөөр ахлах 3 сургуулийн Тайван багштай 7-а ангийн хамт олон 1-р байрыг тус тус эзэллээ.

2014 оны Уншлагын танхимын рекорд номоор “**Луун шивээст охин”** роман, Тэргүүний уншигчаар Эрүүл мэндийн газрын дарга **Бааст** овогтой **Содном** шалгарлаа.</td><td></td></tr>
</table>

2014 оны Уншлагын танхимын Тэргүүний уншигч, Рекорд ном

Хүүхдийн танхимын 2015 оны эхний хагас жилийн" **Тэргүүний уншигч"** ангиар **Таван тэс бага сургуулийн С. Оюунгэрэл багштай 3-а ангийн хамт олон**," **Рекорд** "номоор Д. Дэлгэржаргалын "**Динза**" цуврал ном шалгарлаа.

2015 оны эхний хагас жилийн Тэргүүний уншигч, рекорд номыг тодруулан сурталчилж шагнаж , урамшуулав.

"Хөдөө аж ахуй –газар тариалан", шинэ тосгоны номын үзэсгэлэн, Цогцолбор 2-р сургуулиас солилцоогоор ирсэн номын үзэсгэлэн, Түүхэн сэдэвт үзэсгэлэн, Хүүхдийн уран зохиол, Орчуулгын хүүхдийн уран зохиол, Гэр бүлийн өдөрт зориулсан үзэсгэлэн, Амьдрах ухаан, Шинээр ирсэн номын үзэсгэлэнгүүд Шуухийн байгууллага дээр гарсан үзэсгэлэнгүүд гэх мэт

		шинэ ба сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 76 удаа гаргалаа. ШИНЭ БОЛОН СЭДЭВЧИЛСЭН НОМЫН ҮЗЭСГЭЛЭНГ ТУХАЙ БҮР 70 удаа ГАРГАЖ УНШИГЧДАД СУРТАЛЧИЛЛАА. Аймгийн ИТХ, ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийг авч нэгж болгон үдэж иргэдэд мэдээлж байна. Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрүүдийг нэгжлэн , үдэж иргэдэд үйлчилж байна. 04-р сарын 1-ний өдрөөс эхлэн номын сангийн уншигч бүртгэх, ном олголтыг **LiB 4U** программ дээр гүйцэтгэх шинэ дэвшилтэт ажлыг нэвтрүүллээ. Ингэснээр номын санчдын үйл ажиллагаа автоматчилагдан уншигчдад түргэн шуурхай үйлчлэх, цаг хэмнэх, номын санчдын үйл ажиллагааны сар бүрийн үйлчилгээний тайлан, бүртгэлийг программ дээрээс шууд харж болох	

давуу талуудтай боллоо.



Хүүхдийг бага наснаас нь номонд дуртай болгох зорилгоор цэцэрлэгийн багачуудыг номын сангийн үйл ажиллагатай танилцуулах ажлыг зохион байгуулж 1,7,2,4-р цэцэрлэгүүдийн бэлтгэл бүлгийн 300 гаруй хүүхдэд үйлчиллээ. Мөн Таван тэс бага сургуультай номын санд ном унших гэрээ байгуулан 5 бүлгийн 100 хүүхдийг уншигчаар бүртгэн үйлчилгээ үзүүллээ.

		Байгууллагын ажилчдад Цагдаагийн газрын сэтгэл зүйч О. Анугаар “**Харилцааны соёл**” сэдвээр лекц уншуулллаа. *Цагдаагийн газрын сэтгэл зүйч О. Анугаар ажилтан албан хаагчиддаа “Харилцааны соёл”-ын талаар лекц уншуулав.* -Онцгой байдлын газартай хамтран нийт ажилчдын дунд галын аюулгүй байдлын талаар сургалт зохион байгууллаа. -Аймгийн засаг даргын А/07 тоот захирамжийн дагуу аймгийн чөлөөт ахмадын холбоотой хамтран ахмадуудын дунд цэнгүүн зохион байгууллаа.	

		Аймгийн чөлөөт ахмадын холбоотой хамтран *Ахмадын цэнгүүнийг зохион байгууллаа* ✓ Боловсрол соёлын газартай хамтран зохион байгуулсан сумдын соёлын ажилтны бүсчилсэн сургалт, сургуулийн номын санчдын бүсчилсэн сургалтаар номын сангуудын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа. *БСГ-с зохион байгуулсан Сумдын номын санчдын бүсчилсэн сургалт, Сумдын соёлын ажилтны бүсчилсэн сургалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.* Монгол Улсын Номын сангийн консерциумтай хамтран сумдын соёлын төвийн номын санчдын	

		дунд сургалт мөн Үндэсний номын сан, Эрдэнэт, Дархан, Булган аймгуудын номын сангуудтай танилцах, туршлага солилцох, мэргэжил арга зүйгээр хангах ажлуудыг хийлээ. *Сумдын номын санчид Эрдэнэт, Булган, Дархан хотын номын сан Үндэсний номын сангуудад очиж туршлага солилцон бие биенээсээ суралцан мэргэжил арга зүйн зөвлөгөө авлаа.* 2015 оны Номын баярыг Увс аймгийн Төв номын сан, БСГ, Ойрад театр хамтран тэмдэглэж өргөн дэлгэр болж өнгөрлөө. Энэ үеэр: -Урлагийн тоглолт -номын сангийн уншлагын танхимуудад номын үзэсгэлэн гаргах -сургуулиудад ном хандивлах үйл ажиллагаа -зохиолчдын зохиол бүтээлийг хэн сайн мэдэх вэ хөгжөөнт тоглоом явуулах -хөдөөгийн сургуулиудын номын санчдын ном хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажлын тайлан тавих -ном хөтөлбөрийн хүрээнд хийсэн бүтээлийн үзэсгэлэн гаргах гэх мэт ажлуудыг зохион байгууллаа.	

МУ-ын Ерөнхийлөгчийн 158-р зарлигийн дагуу
“Номын баяр”-ыг зохион байгууллаа.

Увс аймгийн Төв номын сан,Тод номын гэрэл төв хамтран Нэрт эрдэмтэн зохиолч Б.Ринченгийн мэндэлсний 110 жилийн ойг угтаж түүний амьдрал уран бүтээлийн талаар уулзалт ярилцлага зохион явууллаа.

Увс аймгийн Төв номын сан,Тод номын гэрэл төв хамтран Нэрт эрдэмтэн зохиолч Б.Ринченгийн мэндэлсний 110 жилийн ойг угтаж түүний амьдрал уран бүтээлийн талаар уулзалт ярилцлага зохион явууллаа. 2015.09.30

Увс аймгийн Төв номын сан "Нээлттэй хаалганы өдөр"-ийг шинэлэг хэлбэрээр зохион байгуулах зорилгоор 2015.10.27ны өдөр ШШГА-ны харьяа цагдан хорих байранд хоригдож буй хүмүүст номын үзэсгэлэн гарган сонирхуулж, карт нээн ном олгож үйлчиллээ.

Амьдралдаа алдаж оножь яваа тэр хүмүүст оюунд нь бага ч гэсэн хөрөнгө оруулалт хийсэн.

	Зөөврийн номоор үйлчлэх	ХЦ-ийн 0245-р анги Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, 2-р цэцэрлэгт зөөвөр номоор үйлчилгээ үзүүлж ажиллаа. Мөн цогцолбор 2-р сургууль Нийгмийн халамж үйлчилгээний газар аймгийн Шүүхийн газар болон УГПК-той ном солилцоо хийлээ.	**100 %**
	Аймгийн ИТХ, тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийг авч нэгжлэн үйлчлэх	 Аймгийн ИТХ, тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийг авч нэгжлэн авч иргэдэд мэдээлэн ажиллалаа.	**100%**
	МУ-ын ерөнхийлөгчийн зарлигийн дагуу "Номын баяр"-ыг тэмдэглэн өнгөрүүлэх	Номын баярыг Увс аймгийн Төв номын сан, БСГ, Ойрад театр хамтран тэмдэглэж өргөн дэлгэр болж өнгөрлөө. Энэ үеэр: -Урлагийн тоглолт -номын сангийн уншлагын танхимуудад номын үзэсгэлэн гаргах -сургуулиудад ном хандивлах үйл ажиллагаа -зохиолчдын зохиол бүтээлийг хэн сайн мэдэх вэ хөгжөөнт тоглоом явуулах -хөдөөгийн сургуулиудын номын санчдын ном хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажлын тайлан тавих	**100 %**

		-ном хөтөлбөрийн хүрээнд хийсэн бүтээлийн үзэсгэлэн гаргах гэх мэт ажлуудыг зохион байгууллаа 	
Стратеги:2 **Фондын баяжилт хадгалалт хамгаалалт:**	**Хоёр: Фондын баяжилт, хадгалалт хамгаалалт**		
	5,550,000 төгрөгний номоор фонд баяжилт хийх	Худалдаагаар 18 нэр төрлийн 174 ширхэг 1559400 төгрөгний номоор, хандив бэлгийн журмаар 121 нэр төрлийн 375 ширхэг 4925680 төгрөгний ном хэвлэлээр нийтдээ 139 нэр төрлийн 549 ширхэг 6485080 төгрөгийн номоор фонд баяжилт хийлээ.	**100%**
	300000 төгрөгний хэвлэл захиалж уншигчдад үйлчилэх	Өдөр тутмын сонин болох Өдрийн сонин, Өглөөний сонин, Хүмүүн бичиг, Номын санч сэтгүүл Өрхийн үйлдвэрлэл сэтгүүл, Зууны мэдээ сонин, Утга зохиол урлаг сонин,	100 %

		Боловсрол судлал сэтгүүл, Увсын өнгө сонин зэргүүдийг захиалан нийтдээ 378300 төгрөгний хэвлэлээр уншигчдад үйлчиллээ.	
	Номын фондонд тавигдах MNS5742:2007 стандартыг хэрэгжүүлж ажиллах	Шинээр ирсэн 411 ш номыг программд оруулж, баркод нааж үйлчилгээнд гаргалаа. Фондын номын хадгалалт хамгаалалтыг сайжруулахын тулд улирал бүр их цэвэрлэгээ хийж, тоос соруулах, хлорамины уусмалаар арчиж цэвэрлэх ажлыг тогтмолжууллаа. Фондын нийт номын 100%-ийг электрон катологт оруууллаа	
Стратеги:3 **Батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулах**	**Гурав: Санхүүжилт**		
	Батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулах	Үндсэн цалин-101,935,6 НДШ-11,213,0 Бичиг хэрэг-1,173,0 Гэрэл цахилгаан-977,5 Түлш халаалт -41055,0 Тээвэр шатахуун-478,9 Шуудан холбоо-717,6 Цэвэр бохир ус -263,4 Дотоод албан томилолт-1191,0 Урсгал засвар-1173,0 Төлбөр хураамж -396,0 Ном хэвлэл-4410,1 Нэг удаа-948,2 Холбооны суваг ашигласны төлбөр -1,103,2 Багаж хэрэгсэл-93,5 Мэдээлэл технологи-4053,8 Аудит баталгаажуулалт-160,0	100%

		Бага үнэтэй түргэн элэгдэх зардал-286,0 Тээврийн даатгал-56,9 Татвар -53,2 Үндсэн үйл ажиллагааны орлого-48,900 Төсвөөс санхүүжилт-171,690,0 2015 онд 171738,9 төгрөгийн батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.	
	-Өөрийн орлогоос 48900 төгрөгийг олж улсын төсөвт төвлөрүүлнэ.	Өөрийн орлогоос 48900 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.	100%

ХОВД АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2015 оны эхнээс эхлэн байгууллагын ажлын төлөвлөгөөг жилээр гаргаж БСГ-ын даргатай үр дүнгийн гэрээ байгуулан батлуулж улирал, сар, 7 хоногоор төлөвлөн биелэлтийг тооцон ажиллаж байна.

Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Соёлын талаар төрөөс баримтлах бодлого, Монгол улсын ерөнхийлөгчийн зарлиг, засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлтэнд анхааран Аймгийн Засаг Даргын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллав.

2015 оны байдлаар 191.215.9 сая төгрөгний төсвийг зарцууллаа. АЭСЯ-тай гэрээ байгуулан Америкийн төвд зуны сургалтанд 4.637.500, шинэ тоног төхөөрөмж, тавилга интернетийн төлбөрт 7.952.000, Ном DVD тоглоом 4.354.000, шинээр тоног төхөөрөмж авахад 13.000.000 төгрөг нийт 25.773.500 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ.

2015 оны 09-р сард байгууллагын баримт материалыг эмхлэн цэгцэлж 1987-2014 оны байнга хадгалах 43 хадгаламжийн нэгж, түр хадгалах 56-н хадгаламжийн нэгж , 70-н жил хадгалах 7 хадгаламжийн нэгж бүхий данс үйлдэж, нийт баримтыг

стандартын дагуу хавтаслаж, товъёого хийж, баталгааны хуудас бичиж архив бүрдүүлэн ажиллав.

2015 оны Статистик тоон мэдээллийг 2015 оны төлөвлөгөөтэй харьцуулбал:









Номын сангийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аймгийн Аудитын газраар шалгуулан дүгнүүлж Ховд аймгийн 210 гаруй байгууллагаас шалгарч санхүүгийн асуудалгүй байгууллага болж “Итгэлийн батламж” гардан авлаа.

Монголын боловсролыг судлах үндсэн судалгааны нийгэмлэгээс 2015 оны үйл ажиллагааг хөндлөнгөөс дүгнэлт хийж стандартын хэрэглээг нийтэд түгээн дэлгэрүүлэх, үйлдвэр үйлчилгээний чанар стандартыг сайжруулахад оруулсан хувь нэмэр, нийгмийн сайн сайханд зөв өөрчлөлт бүтээхэд хамт олноороо гаргасан зүтгэлийг үнэлэн 2015 оны “Тор стандарт” байгууллага цомын эзэн боллоо.



www.library.khovdcity.mn хуудсанд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж сар бүрийн тайлан тооцоо санхүүгийн мэдээлийг цаг тухай бүрт нь өөрийн Khowd байршуулан ажиллаж байна. Мөн 2014 оны санхүүгийн баримтанд Ховд АЗД-ын дэргэдэх санхүүгийн хяналт, аудитын албаны гүйцэтгэлийн шалгалт хийгдсэн. *www.library.khovdcity.mn* цахим хуудсанд тогтмол мэдээлэл тавьж баяжуулан ажиллаж байна. 2015 онд нийт 013455 хүн манай хуудсанд хандсан байна.

Аймгийн засаг даргын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс Цахим номын сантай болж 600 ширхэг цахим номыг байршуууллаа.

Цахим уншлагын танхимыг тохижуулан үйлчилгээнд бэлэн болгов.



Номын сангаар үйлчлүүлэгчдийн цаг завыг хэмнэх үүднээс цахим каталогийг ашиглах боломжийг өөрийн сайтаар дамжуулан хийлээ. Энэхүү ажил хийгдсэнээр Ховд аймгийн ард иргэд цахим сүлжээ ашиглан ном унших, номын сангийн талаар мэдээлэл авах бүрэн боломжтой болсон.



https://www.facebook.com/Khovd.library хуудсанд хандах иргэдийн тоо нэмэгдэж зохион байгуулж байгаа үйл ажиллагаагаа тогтмол сурталчилсны дагуу олон нийтийн талархалыг хүлээж хамгийн олон LIKE цуглуулж 3406 хүрч Ховд аймгийн төрийн байгууллагыг тэргүүлж байна.

Өдөр бүрийн мэдээллийн цахим хуудсанд байршуулах ажлыг цаг алдалгүй түргэн шуурхай хэрэгжүүлэн мэдээллийг түгээн ажиллаж байна.

Ховд аймгийн соёлын өдрүүдийг Улаанбаатар хотод зохион байгуулах ажлын хэсэгт орж ажиллав. Орон нутгийн зохиолчдын үзэсгэлэнг гаргах, ном хэвлэлийг нь сурталчилах ажлын хүрээнд өөрийн байгууллагын чиглэлийн дагуу дээрх ажилд оролцлоо. Тус арга хэмжээний хүрээнд Ховд аймгийн эрдэмтэн зохиолч, судлаачдын болон аймгийн түүхийн талаарх ном, зохиол бүтээлийн үзэсгэлэнг Үндэсний номын сантай хамтран Монголын зохиолчдын холбооны дэргэдэх Art gallery-д гаргаж 3 хоногийн турш сурталчилав. Уг үзэсгэлэнд 250 гаруй ном бүтээлийг дэлгэн танилцууллаа.

НОМЫН ФОНДЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГО ХИЙГДЭЖ БАЙНА.

Боловсрол соёл шинжлэх ухааны сайдын 2007оны 11-р сарын 08-ны өдрийн 415 дугаар тушаалыг хэрэгжүлэх үүднээс номын нэг бүрчилсэн тооллого хийв.

Номын сангийн ээлжит номын тооллогыг 2015 оны 06 сарын 13-ны өдөр эхэлж 2015 оны оны 10 сард электрон бүртгэлд орсон номыг тоолж дуусгаад эцсийн тооцоог хийж байна. Нэгдсэн бүртгэлийг нэг бүрчилсэн бүртгэл болон цахим бүртгэлтэй тулгалт хийж ном хэвлэлийг нөхөн бүрдүүлэх ажлыг хийж байна.

2015 ОНЫ ШИЛДЭГҮҮДЭЭ ШАЛГАРУУЛЛАА

Нийтийн номын сангаар үйлчлүүлж байгаа ЕБС-иудын сурагчид, Их дээд сургуулийн оюутан, эрдэмтэн багш нар, тэргүүний уншигчдаа шалгаруулан дүгнэх ажлыг зохион байгууладаг. Тэргүүний уншигч байгууллагаар: Л.Балдорж захиралтай “Цаст-Алтай” цогцолбор сургуулийн хамт олон шаргарлаа.

УНШЛАГЫН ИХ ТАНХИМ:

’’Шилдэг соён гэгээрүүлэгч менежерээр’’: Цаст-Алтай цогцолбор сургуулийн ахлах ангийн менежер Д.Уранбилэг.

Тэргүүний номын санчаар: Прогресс дунд сургуулийн номын санч Д.Туяацэцэг.

Тэргүүний уншигч хамт олноор :

-Прогресс дунд сургуулийн Мөнхцэцэг багштай 11-Б анги.

-ЦАЦСургуулийн Цэцэгмаа багштай 7-А анги, Жаргалсүрэн багштай 7-б анги,

- 6-р сургуулийн Мөнхцэцэг багштай 6-б анги нар шалгарлаа.

Тэргүүний уншигчаар: 6-р сургуулийн 6б анги Ж.Өсөхбаяр, 10б анги М.Батцэцэг.

-Цаст-Алтай цогцолбор сургуулийн 7б анги Б.Цэцэгчулуун, 7а анги Д.Баяржаргал

-Прогресс сургуулийн 11б анги Б.Батчимэг

ҮЛ МЭДЭХ ТАНХИМ

''Шилдэг соён гэгээрүүлэгч менежерээр'': Цаст алтай цогцолбор сургуулийн бага ангийн менежер Ч.Цэрэндагва

-Тэргүүний уншигч хамт олноор : 1-р сургууль Б.Баярмаа багштай 4а анги,

-Прогресс сургуулийн Б.Хоролсүрэн багштай 5б анги,

-Цаст алтай цогцолбор сургуулийн Д.Цэрэндолгор багштай 5а анги,

-3-р сургуулийн Б.Түвшинтөлөв багштай 3а анги шалгарлаа.

Тэргүүний уншигчаар:

- Прогресс сургуулийн 4б анги Ш.Азочир, 5б анги М.Анхцэцэг
- 1-р сургуулийн 4а анги Ц.Сэнгэ очир
- 6-р сургуулийн 5б анги Х.Анужин
- 2-р сургуулийн 5б анги Т.Жанеркей нар шалгарчээ

ГЭРЭЭР НОМ ОЛГОХ ТАСАГ

Тэргүүний уншигчаар: С.Дашдэнзэн

Эрдэм шинжилгээ чөлөөт уншлагын танхим

Тэргүүний уншигч хамт олноор: Политехник коллежийн оюутны 1-р байрны хамт олон

Шилдэг багшаар: Политехник коллежийн багш Н.Золзаяа

Тэргүүний номын санчаар: Политехник коллежийн номын санч Л.Мандахжаргал

Тэргүүний уншигчаар: -ХОИС-ийн бизнес удирдлагын ангийн оюутан З.Батэрдэнэ -Физикийн ангийн оюутан Б.Мөнхбат , -Бага багшийн оюутан Л.Батцэцэг,

-Политехник коллежийн малын эмчийн ангийн оюутан М.Отгонцэцэг нар шалгарсан байна.

АМЕРИКИЙН ТӨВ

Шилдэг багшаар: Боловсролын соёлын газрын Гадаад хэлний мэргэжилтэн Хазел Кероак

Шилдэг уншигчаар: Прогресс сургуулийн 12в ангийн сурагч Г.Амартүвшин

Шилдэг уншигчаар: ЦАЦ сургуулийн 10 дугаар ангийн сурагч Т.Саранчимэг тус тус шалгарлаа.

2015 ОНЫ АВАРГА НОМУУД

ҮЛ МЭДЭХ ТАНХИМ:

1-р байранд 2015 онд ''Эхийн санаа үрд, үрийн санаа ууланд ба бусад домгууд'' ном 168 удаа уншигдаж аварга номоор шалгарлаа

2-р байранд 2015 онд "Чингис хаан" ном 146 удаа уншигдаж аварга номоор шаргарлаа

3-р байранд 2015 онд "Алис гайхалтай оронд'' 109 удаа уншигдаж аварга номоор шалгарлаа.

УНШЛАГЫН ИХ ТАНХИМ:



1-р байранд Д.Нацагдорж ''Шилдэг бүтээлүүд'' 346 удаа аварга номоор шалгарлаа.

2-р байранд С. Эрдэнэ ''Шилмэл өгүүллэгүүд'' 325 удаа уншигдаж аварга номоор шалгарлаа

3-р байранд ''Монголын нууц товчоо'' 463 удаа уншигдаж аврага номоор шалгарлаа.

АМЕРИКИЙН ТӨВ:



1-р байранд 2015 онд''Англи хэлний сурах бичиг'' 218 удаа уншигдаж аварга номоор шалгарлаа.

2-р байранд 2015 онд ''Advanced grammar in USA'' 189 удаа уншигдаж аварга номоор шалгарлаа.

3-р байранд 2015 онд ‘’Oxford Advanced learners dictionary’’ 178 удаа уншигдаж аварга номоор шалгарлаа.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ ЧӨЛӨӨТ УНШЛАГЫН ТАНХИМ





1-р байранд .’’Монголын соёлын түүх‘’ 2015 онд 258 удаа уншигдаж аварга номоор шалгарлаа

2-р байранд ’’Дуун утгын яруу зохист’’ 2015 онд 201 удаа уншигдаж аварга номоор шалгарлаа

3-р байранд ’’Монголын түүхийн лекцүүд’’ 2015 онд 108 удаа уншигдаж аварга номоор шалгарлаа

4-р байранд ’’ Ховд аймгийн хамгийн хамгийн’’ 2015 онд 101 удаа уншигдаж аварга номоор шалгарлаа.

ГЭРЭЭР НОМ ОЛГОХ ТАСАГ:

1-байранд ’’Сорхугтани хатан’’ 118 удаа уншигдаж оны аврага номоор шалгарлаа.

2-р байранд ’’Чонон сүлд’’ 109 удаа уншигдаж оны аварга номоор шалгарлаа.

ХУУЛЬ, ЭРХЗҮЙН СУРГАЛТ МЭДЭЭЛЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Ажилтнуудын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх үүднээс холбогдох албан байгууллагууд болон ажилтнуудынхаа нөөц боломжийг ашиглан 7 хоног бүр мэдээлэл хийлээ.

Ахлах номын санч Д.Саранцэцэг “Номын сан”-гийн тухай хуулиар, Ня-бо О.Чанцалмаа “Эрүүл мэндийн даатгал”-ын шинэчилсэн хуулиар, Фондын эрхлэгч Б.Алимаа “Соёлын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын талаар, номын санч Л.Даваахүү “Архины хор хөнөөл”-ийн тухай, сүлжээний ажилтан Д.Отгонбилэг Тамхины хяналтын тухай Монгол улсын хуулиар, Номын санч М.Чимгээ БСШУЯ-ны сайдын тушаалуудаар, Номын санч Г.Баяраа “Хөдөлмөрийн тухай” хуулийн шинэчлэлийн талаар, Номын санч Д.Оюунчимэг “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулиар, Гэрээр ном олгох тасгийн номын санч Б.Одонпүрэв “Архидан согтуурахтай тэмцэх тухай” Монгол улсын хуулиар, Аймгийн Онцгой байдлын газрын ахлагч Эрдэнэбат, хурандаа Бауржан нарын хийсэн “Гамшгаас урьдчилах сэргийлэх” тухай сургалтыг зохион байгууллаа.



Ховд аймгийн анхан шатны шүүхийн тамгын газраас явуулсан ”Шүүхийн шинэчлэл” сэдэвт сургалтыг Шүүхийн тамгын газрын Мэдээллийн мэргэжилтэн Отгонтулга мэдээлэл хийсэн байна.

Аймгийн Цагдаагийн газрын олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн Ц.Оюунсүрэн Цагдаагийн газрын тайлан тавьж мөн архины хор хөнөөлийн тухай мэдээлэл хийлээ.

2015 оны 10-р сарын 13-нд Эрүүл мэндийн газрын олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн их эмч О.Отгонжаргал, их эмч сэтгэл зүйч Саруул-Од, НҮБ-ийн сайн дурын ажилтан Аманда нар “Эрүүл биетэй-Саруул ажилтан” аяны хүрээнд архи, тамхины хор хөнөөл, эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх талаар сургалт явуулахад нийт 18 ажилтан хамрагдсан сургалтанд суулаа. Сургалтын төгсгөлд сайн дурын ажилтан Аманда нийт ажилтнуудад эрүүл мэндийн хөдөлгөөнүүдийг зааж өгсөн байна.

Соёлын байгууллагын ажилчдын дунд Төрийн албан хаагчийн ёс зүй, “Үйлчилгээний соёл” сэдэвт сургалтанд нийт ажилтнууд хамрагдлаа.

ХОВД АЙМГИЙН НИЙТ НОМЫН САНЧДЫН 2 УДААГИЙН СУРГАЛТ БОЛОВ

Аймгийн ЕБС-ийн болон, соёлын төв, ХИС, Политехник коллеж болон нийт номын санчдад зориулсан арга зүйн сургалтыг 2015 оны 05 сарын 07-09-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтанд төв хөдөөгийн 64 номын санчид оролцлоо. Сургалтанд Монголын Үндэсний номын сангийн Мэдээлэл-Аргазүй, Эрдэм шинжилгээний хэлтсийн дарга Д.Энхтунгалаг мэргэжлийн зүгээс заавар зөвлөгөө өгч номын санчдад сертификат гардууллаа. Ховд аймгийн Эрдэнэбүрэн

сумын номын сангийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судлаж идэвхитэй амралтыг нийт номын санчдын дунд зохион байгуулав.

МҮНС-ийн мэдээлэл арга зүй эрдэм шинжилгээний хэлтсийн дарга Д.Энхтунгалаг болон Нийтийн номын сангийн захирал Т.Эрдэнэтуяа нар холбогдох хүмүүсийн хамтаар Нийтийн номын сан болон ХИС, Политехник коллеж, 12 жилийн 1-р сургууль, ЕБС-ийн номын сангуудын ажилтай танилцаж мэргэжил аргазүйн зөвлөгөө, ажлын чиглэл өглөө.

Мөн МҮНС-аас ажлын үйл явцтай холбоотойгоор ажил сайжруулах санал зөвлөмж ирсэн ба дээрх арга хэмжээний хүрээнд ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сургалтанд хамрагдсадын дунд Спортын нөхөрсөг тоглолт зохион байгуулав. Номын санчдаас нийт 6 баг гарч гар бөмбөгийн тэмцээнийг эхлүүлсэн ба нэгдүгээр байр алтан медалийн эзнээр сумдын соёлын төвийн номын санчид, мөнгөн медалийн эзнээр сумын сургуулийн номын санчид, хүрэл медалийг Нийтийн номын сангийн баг хамт олон хүртсэн. Дээрх арга хэмжээ нь дан ганц онол практикийн мэдлэгийг нэмэгдүүлээд зогсохгүй номын санчдын хоорондын хамтын ажиллагааг сайжруулахад чухал ажил болж чадлаа.

Америкийн номын санчдын туршлагаас суралцав

АНУ-ын Элчин сайдын яамны ажилтан Пэг Волтер Олон нийттэй харилцах албаны ажилтан Болормаа нар Америкийн номын сангийн өнөөгийн байдал сэдвээр Жаргалант сумын номын санчдад сургалт зохион байгууллаа.

АНУ-ын Элчин сайдын яамны ажилтан Пэг Access сурагчидад мэдээлэл хийж уулзалт хийлээ.

Боловсролын газрын мэргэжилтэн Hazeltei хамтран насанд хүрэгсдийн дунд Англи хэлний анхан дунд шатны хичээл зааж байна.

Хүний эрхийн төлөө тууштай тэмцэгч, уран илтгэгч Мартин Лютер Кингийн өдрийг тэмдэглэн Richard багш лекц уншлаа.

Рич багштай хамтран Байгаль дээр хаясан хог хаягдал ямар хугацаанд элэгдэж алга болдог, ямар хор уршигтай талаар лекц хийлээ.

СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД:
“ШУВУУН СААРАЛ” БОГИНО ӨГҮҮЛЛЭГИЙН НААДАМ

Шинэ үеийн утга зохиолыг үндэслэгч Д.Нацагдоржийн мэндэлсний 109 насны ойд зориулан жил бүр уламжлал болгон зохион явуулдаг “Шувуун саарал” богино өгүүллэгийн наадмыг 5 насны ангиллаар зохион явууллаа.

Энэ үйл ажиллагаанд 1-3 –р ангийн 23, 4-6-р ангийн 58, 7-9-р ангийн 33 ,10-12-р ангийн 35 , оюутан залуус 11 нийт 160 хүүхэд, залуучууд, оюутан оролцлоо. Ангилал тус бүрээс эхний гурван байранд орсон сурагчдын бичлэг хийлгэж, онлайнаар санал асуулга авч Дарви сумын сургуулийн 4б ангийн сурагч Ж.Буян-Эрдэнэ хамгийн олон санал буюу 785 хүний дэмжлэгтэйгээр авч Гран-При-шагналтнаар тодорч батламж, үнэ бүхий

зүйлээр шагнагдлаа. Энэхүү ажлын үр дүн ач холбогдол нь Монголын утга зохиол, уран зохиолыг олон нийтэд сурталчилах, сурагчдын чөлөөт цагийг номтой нөхөрлүүлэн өнгөрүүлэх, бие биенээсээ суралцах боломжийг олгож өгсөнөөрөө илүү ач холбогдолтой байлаа.

"ГАН-ҮЗЭГ 2015" ЯРУУ НАЙРГИЙН НААДАМ

Аймгийн нийтийн номын сангаас жил бүр уламжлал болгон зохион явуулдаг “Ган-Үзэг 2015” наадмыг 2015 оны 10 дугаар сарын 23-нд “Дэлхийн зөн Ховд” орон нутгийн байгууллагатай хамтран Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн урлагийн зааланд зохион явууллаа. Наадмыг 4 насны ангилалаар явууллав. Яруу найргийн наадмын арга хэмжээнд 4-6-р анги 43 , 7-9-р анги 39, 10-12-р анги 37, оюутан залуус 23 нийт төв хөдөөны 142 хүүхэд багачууд оролцлоо. Тус наадам нь шинээр төрөн гарах өсвөрийн болоод залуу яруу найрагчдийг тодруулах, тэднийг урамшуулах, зохиол бүтээлийг нь олон нийтэд сурталчилахад чухал нөлөөтэй ажил боллоо. Хөдөө орон нутгийн оролцогчид жил ирэх бүр нэмэгдэж байгаад зохион байгуулагчдын зүгээс талархалтай хүлээн авч байна.

“Ган-Үзэг 2015” наадмын шагналтнууд

4-6 дугаар ангийн насны ангилалд:

I байр М.Гэрэлцолмон Манхан сум 6а анги

II байр А.Анхзул Алтай сум 4а анги

III байр Г.Амарсанаа 12 жилийн I дүгээр сургууль 6г ангиийн сурагчид шалгарлаа

7-9 дүгээр ангийн насны ангилалд:

I байр Ц.Ариунзаяа ЦАЦ 9а анги

II байр Э. Байгалмаа 12 жилийн III сургууль 8б анги

III байр Н.Ариун- Эрдэнэ Буянт сум 8а ангиийн сурагчид шалгарлаа.

10-12 дугаар ангийн насны ангилалд:

I байр Ц.Батболд Алтай сум 11б анги

II байр А. Батболд Манхан сум 11б анги

III байр Ц. Буянбат Зэрэг сум 10б ангийн сурагчид шалгарлаа.

Эхний гурван байр эзэлсэн яруу найрагчиддаа "Ган-Үзэгтэн" тэмдэгээр шагнаж урамшуулав.

Оролцогчдын бүтээлийг онлайнд байршуулан үзэгчдийн санлыг авахад Манхан сумын ЕБС-ийн 11б ангийн сурагч А.Батболд 270 хүний санал авч Гранпри шагналтнаар тодорч Батламж, дургалын зүйлээр шагнагдлаа. Тэмцээний шүүгчээр Нийтийн номын сангийн захирал Т.Эрдэнэтуяа, Ахмад багш нарын холбооны дарга Шоовдой, Ховдын мэдээ сонины эрхлэгч Бямбасүрэн, ХААХ-ийн мэргэжилтэн Ариун-эрдэнэ нар ажиллав. Цаашид тус тэмцээнийг аймгийн хэмжээний томоохон тэмцээнүүдийн нэг болгон улам өргөжүүлж авьяаслаг, чадвартай залуу зохиолчдыг төрүүлэн гаргахаар төлөвлөөд байна.

НОМ СОНИРХОГЧДЫН 2 КЛУБ БАЙГУУЛАГДАН ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ИДЭВХИЖҮҮЛЖ БАЙНА

Нийтийн номын сан Дэлхийн Зөн ОУ Ховд ОНХХ-ийн мэргэжилтэн Нэргүйтэй хамтарч ЕБС –ийн 7–н сургуулийн ном сонирхогч сурагчдын дунд "Ном уншихын ач тус" сэдэвт сургалт ярилцлага, өдөрлөгийг зохион байгуулж явууллаа. Арга хэмжээнд 100 гаруй сурагчид оролцлоо.

Сургалтын үр дүнд 42 гишүүнтэй "Номын цацраг" клуб байгуулагдаж даргаар нь 3-р сургуулийн 8-в ангийн сурагч Э.Байгалмаа олонхийн саналаар сонгогдлоо. Клубын гишүүд хуралдаж

дүрмээ баталж, дараагийн хурлаар уриа, төлөвлөгөө гаргаж ажиллахаар боллоо.

Номонд дурлагсдын клубын хүүхдүүд өөрсдийн гарын доорх материал ашиглан ном бүтээж байна. Мөн цаашид "Номын эмч "аян зохион байгуулахаар ярилцлаа. Ном хөтөлбөрийг дэмжин ажиллах, номын сайн нөхөр, номонд дурлагчдын тоог нэмэгдүүлэн үе тэнгийнхэндээ үлгэр дуурайл болох клубуудыг бий болгохоор зорин ажиллаж байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Монгол улсын ерөнхийлөгчийн 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ"-ын өдрийг 2015 оны 05 сарын 04-05-ны өдрүүдэд зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд: Ховд аймгийн ЕБС-ийн сурагчид ард иргэдийн дунд "Монгол хэлний тухай хууль", "Угийн бичиг хөтлөх аргачлал"-ийн талаар мөн "Уран бичлэгийн тэмцээн, Галиграф бичлэгийн бүтээлийн шалгаруулалт зохион байгуулж шагнаж урамшууллаа.



"Шалгаруулалтанд ирсэн бүтээлүүд"

"ХИЧЭЭНГҮЙ БИЧИГТЭН"-ҮҮД ШАЛГАРЛАА

Нийтийн номын сангийн захирлын нэрэмжит "Уран үзэгтэн" тэмдэгээр нийт 10 сурагч шагнагдлаа. "Уран үзэгтэн "хичээнгүй

бичгийн уралдаанд Ерөнхий боловсролын 7-н сургууль, Политехник коллежээс нийт 70 гаруй сурагчид, оюутнууд оролцлоо.

Оролцогчдын монгол бичгийн мэдлэг болоод бичих чадвараар Цаст-Алтай цогцолбор сургуулийн сурагчид хошуучлан оролцож байлаа.

Номын сангаас зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагаануудад ЕБС болоод бусад байгууллагууд идэвхитэй хамрагдаж байгааг дурдах нь зүйтэй.

НОМ ХАНДИВЛАВ

Аймгийн Цагдаагийн газрын ажилтнуудын номын санд 250 мянган төгрөгний цаасан ном, 300 ширхэг цахим ном хандивлан өгч Ажилтан солилцоо арга хэмжээг зохион байгуулж тус ажлын хүрээнд тус номын сангийнх нь номнуудыг данс бүртгэлд авч, шинжлэх ухааны салбарын дагуу ангилж, техник ажиллагаа хийж өгөв.

БОЭТ-ийн ажилтнууд үйлчлүүлэгчдэд зориулсан Номын санд 250.000 төгрөгний ном, номын тавиур хандивлан өгч нээлтийн арга хэмжээг Улаанбаатар хот дахь Ховд аймгийн Залуучуудын холбоо, Ховд аймгийн залуучуудын холбоотой хамтран зохион байгуулав.

Улаанбаатар хот дахь Ховд аймгийн залуучуудын холбооноос Нийтийн номын санд 200 ширхэг ном хандивлан Монгол улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэн “Номын баяр”-ын арга хэмжээг зохион байгуулав. 2015 оны 9-р сарын 17-19-ны өдрүүдэд Үндэсний номын сан, Хүүхдийн номын ордон, 21 аймгийн Нийтийн номын сангууд хамтран Чингэсийн талбайд үзэсгэлэн гаргаж “Номын баяр”-ын өдөрлөгийг зохион байгуулав.

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО ЗАЛАВ

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 23 дугаар зарлигийг хэрэгжүүлэх үүднээс “Монголын нууц товчоо залах” арга хэмжээг Аймгийн Цагдаагийн газарт зохион байгуулав.

ШИНЭ НОМЫН БАЯР ХИЙВ

2015 оны 11-р сарын 29-нд Ховд аймгийн Мөнххайрхан сумын зохиолч, яруу найрагч Уушийн Батболдын “Сэтгэлийн анир” нэртэй шинэ номын баярыг МЗЭХ-ны Ховд аймгийн салбарын зохиолчидтой хамтран зохион байгуулав. Тус арга хэмжээнд зохиолчын нутаг усны ахан дүүс болоод үзэг нэгт нөхөд оролцож санал сэтгэгдэлээ солилцов. У.Батболд өөрийн гарын үсэгтэй номоо хүрэлцэн ирсэн зочдод гардуулан өглөө. Мөн МЗЭ-ийн Ховд аймаг дахь салбар зөвлөлийнхөн оролцож мэдээлэл хийлээ.

ЗОХИОЛЧДЫН УУЛЗАЛТ БОЛОВ

Болор цомын эзэн яруу найрагч Х.Эрдэнэбаатартай Цаст алтай цогцолбор сургууль болон Политехник коллежийн суралцагч оюутнуудтай хамтран зохион байгуулж харилцан санал солилцох ууузалтыг зохион байгуулав.

УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

Тасаг танхимуудын 2014 оны тэргүүний уншигчид болон аварга номуудыг сурталчлах өдөрлөгийг тасаг танхимын номын санчид зохион байгуулж, хариуцсан тасаг, танхимынхаа шилдэгүүдийг сурталчилж, аварга номуудаар дүрийн тоглолт, тэргүүний уншигчдын урлагийн тоглолт үзүүллээ.

УРИЛГАТ УНШЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАВ

Урилгат уншлагыг 6-12-р ангийн сурагчдын дунд явуулсанаас ЦАЦ

сургуулийн Баасанжав багштай 6-в анги , Гэгээнжаргал багштай 9-в анги, Алтанцэцэг багштай 11-а анги, Цэцэгмаа багштай 6-а

анги, Прогресс сургуулийн Пүрэвсүрэн багштай 6-а анги,Дуламсүрэн багштай 7-а анги, Мөнхцэцэг багштай 10-б ангиуд идэвхитэй оролцлоо. Цаст –Алтай цогцолбор сургуулийн Нямсүрэн багштай 10-а ангиуд идэвхитэй оролцлоо.

Óíøèã÷äûí íîìòîé í°õ°ðë°õ èäýâõèéã °ðí¿¿ëýõ òàíèí ìýäýõ¿éã õ°ãæ¿¿ëýõийн тулд албан байгууллага аж ахуйн нэгжүүдийн ажилчдад ажлын байраар болон гэрээр ном олгох зорилгоор “Ном таны оюуны хэрэгцээ” жилийн хугацааны аян зарлаж уг аяны болзолыг байгууллагад хүргэж ном хэвлэлээр үйлчлэн ажиллаж байна.

Тасаг танхим бүр урагдаж гэмтсэн номоо тухай бүрт нь засварлан сэлбэж 2015 оны 6 дугаар сар хүртлэх захиалсан тогтмол хэвлэл, сонин сэтгүүлийг шуудан холбооноос авч үдэж хавтаслан уншигчдад хүргэх ажлыг хийж байна.

5-р сарын 18–нд Жаргалант сумын 5-р цэцэрлэгийн дунд бүлгийн хүүхдүүдийг номын сантай танилцуулж, үлгэрийн зурагтай ном үзүүлж танилцууллаа.

УЛС ТУНХАГЛАСНЫ БАЯРТ ЗОРИУЛСАН ОНОЛ ПРАКТИКИЙН БАГА ХУРАЛ БОЛОВ.

Бүгд найрамдах улс байгуулагдаж, үндсэн хуулиа батласан баярын өдөрт зориулсан "Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал" сэдэвт уншигчдын бага хурлыг ХИС-ийн Түүхийн тэнхимтэй хамтран зохион байгуулж байна. Түүхийн тэнхимийн нийт 8 оюутан илтгэл тавьж хэлэлцүүлэг зохион байгуулсан ба оролцогч оюутнуудад гарын бэлэг дурсгалын зүйл хадгалуулав.

С.ЭРДЭНИЙН ЗОХИОЛ БҮТЭЭЛИЙГ СУРТАЛЧЛАХ НОМЫН АЯН

Ардын уран зохиолч, төрийн шагналт зохиолч С.Эрдэнийн зохиол бүтээлийг сурталчлах 14 хоногийн номын аяныг Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулиудын дунд тусгай хөтөлбөр удирдамж гарган зохион явуулж дүнгээ гаргалаа. Тус номын аянд бүх сургуулиуд идэвхитэй оролцлоо. “С.Эрдэнийн зохиол бүтээл болон монголын зохиолчдын зохиол бүтээлийг хэн сайн мэдэх вэ?” АХА тэмцээн, С.Эрдэнийн зохиолуудаар дүрийн тоглолт, үгийн сүлжээ хийж, ном бүтээх зэрэг ажлуудыг зохион явуулав.

Цаст-алтай цогцолбор дунд сургууль 66 оноогоор 1-р байр, Прогресс дунд сургууль 64,5 оноо 2-р байр эзэлж бусдыгаа хошуучлан оролцлоо.

С.Эрдэнэ ”Ээжийн авдар” өгүүллэг

тэргүүн байр:Хоролсүрэн багштай 5-Б анги

“МИНУТАНД ХЭН ХАМГИЙН ХУРДАН ЗӨВ УНШИХ ВЭ” ТЭМЦЭЭН

“Үл мэдэх” танхимаас Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2-р ангиудын дунд “Минутанд хэн хамгийн хурдан зөв унших вэ?“ уралдааны 4 дэхь жилдээ амжилттай зохион байгуулан явууллаа. Тус уралдаанд 7 сургуулийн 20 гаруй сурагч оролцож, шүүгчээр нийтийн номын сангийн ахлах номын санч Д.Саранцэцэг, гэрээр ном олгогч Б.Галмандах, 3-р сургуулийн бага ангийн багш Цэрэнханд, 1-р сургуулийн номын санч Ж. Цэвэлмаа нар ажиллав. Минутын уншлагыг Ч.Лувсандэндэвийн “Сайн мэдэх үг” өгүүллэгээс уншууллаа.

Ингээд хамгийн олон үг уншсан байдлыг шалгаруулахад: 12 жилийн 1-р сургуулийн 2-в ангийн сурагч Д.Уугансарнай 119 үг уншиж алт, Цаст-алтай цогцолбор сургуулийн 2-а ангийн сурагч Н.Амартүвшин 117 үг уншиж мөнгө, 12 жилийн 1-р дунд сургуулийн 2-г ангийн сурагч А.Марал 99 үг уншиж хүрэл медаль, 12 жилийн 7-р дунд сургуулийн 2-а ангийн сурагч А.Алтандөш 92 үг, Цаст-алтай цогцолбор сургуулийн 2-а ангийн сурагч Д.Марал-эрдэнэ 89 үг уншиж тусгай байр эзэлж өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнаж урамшууллаа.

“АВЪЯАСЛАГ УНШИГЧ ИХЭРҮҮД” УУЛЗАЛТ ТЭМЦЭЭН

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа 1-12-р ангид суралцдаг ихэрүүдийн дунд “Авъяаслаг уншигч ихэрүүд” сэдэвт уулзалт тэмцээнийг удирдамж хөтөлбөр гарган зохион байгуулж 7 сургуулийн 40 гаруй ихэрүүд оролцлоо. Өдөрлөгаар ихэрүүдийн урлагийн тоглолт, “Бид ирээдүйн мисс” сэдэвт загварын үзүүлэлт, “Би тэднэ-бид чадна” сэдэвт АХА тэмцээн мөн ихэрүүдийн өөрсдийн хийсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж оюун ухаан авъяас чадвараараа уралдаж 1-р дунд сургуулийн

“Үндэс нэгтэй цэцэг” баг 1-р байр, “Прогресс” сургуулийн “ Ховорхон заяа” баг 2-р байр, Цаст-алтай цогцолбор сургуулийн “Хоёр дэлбээ” баг 3-р байр эзэллээ.

НИЙТИЙН НОМЫН САНГААС ЦАСТ АЛТАЙ ЦОГЦОЛБОР СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛСАН “ГЭГЭЭН ҮДШИЙН УНШЛАГА-2” АРГА ХЭМЖЭЭ

Нийтийн номын санд 2015 оны 03-сарын 05-ны өдөр ЦАЦ-р сургуулийн Б.Цэцэгмаа багштай 6а анги Гэгээн үдшийн уншлагад оролцлоо. Гэгээн үдшийн уншлагын нээлтэнд Цаст-Алтай цогцолбор сургуулийн удирдлагууд болон, Нийтийн номын сангийн хамт олон оролцлоо. Нийтийн номын сангийн захирал Т.Эрдэнэтуяа, ЦАЦ сургуулийн захирал Балдорж нар нээж үг хэллээ.

Цаст –Алтай цогцолбор сургуулийн Б.Цэцэгмаа багштай 6а ангийн сурагчид болон эцэг эхийн төлөөллүүд нийтийн

номын сангийн тасаг танхимууд болон фондын үйл ажиллагаатай танилцуулав.

6-а ангийн хамт олон, эцэг эхийн төлөөлөгчдөд ”Ган үзэг” “Шувуун саарал” наадмын тэргүүний уншигчид бүтээлээсээ толилуулав.

7-р сургуулийн 2г ангийн сурагч Цэнд-Аюуш “Эмээгийнх нь алим дууссан шүү дээ”

2-р сургуулийн 9б ангийн сурагч Акерке “Найдвартай нь дээр “богино өгүүллэгээ тус тус толилуулав. Зохиолчтой уулзах цагаар МЧЗЭХ-ны гишүүн, болор цом яруу найргийн наадмын тэргүүн байрын шагналт зохиолч, яруу найрагч Х.Эрдэнэбаатартай уулзалт хийсэн нь маш сонирхолтой, нээлттэйгээр сурагчид сонирхолтой асуулт тавьж, уулзалт үр дүнтэй сайхан боллоо.

17 цагаас оройн уншлага эхэлсэн. Үүнд хүүхдүүд эцэг эхийн хамтаар уншсан номын талаар ярилцаж, санал бодлоо чөлөөтэй солилцов. Мөн 4 багт хуваагдаж, ном бүтээж, дүрийн тоглолт хийхэд хүүхдүүд маш идэвхтэй оролцож тоглов.

Сурагчид эцэг, эхчүүдийн хамт 70 ширхэг номыг өөрсдийн гар доорх материалаар эмчилж өгсөн байна. Энэ нь хүүхэд багачуудыг номыг хайр гамтай хэрэглэх төлөвшилд сургахад чухал нөлөөтэй байлаа.

Хүүхдүүд оройн хоолонд орж, алжаалаа тайлаад цагийн хуваарийн дагуу эцэг, эхийн төлөөлөлтэй чөлөөт ярилцлага

хийлээ. Хүүхдүүд номын санд байх хугацаандаа юуг ойлгож мэдсэн болон бие биендээ талархалын үгээ хэллээ.

Хүүхдүүд эцэг, эхийн төлөөл Америкийн төвтэй танилцаж, англи хэл дээр кино үзэж сонирхсон.

Өглөө 6,30-д босч гар нүүрээ угааж, гимнастикаа хийж, өглөө цайгаа ууцгаав. Цайны дараа хүүхдүүд маань хоносон сэтгэгдлээ бичиж үйлдээцгээв.

Манай энэхүү үйл ажиллагаанд оролцсон сурагчид, эцэг, эхийн төлөөлөл, ангийн багш бүгдээрээ өөрсдийн сэтгэгдэлээ бичиж үлдээж сэтгэл хангалуун буцлаа.

“НЭЭЛТТЭЙ ХААЛГА”, “ИРГЭДЭД ҮЙЛЧЛЭХ ӨДӨР”

ЕБС-ын 12 жилийн 6-р сургууль дээр зохион байгуулагдсан “Нээлттэй хаалга”-ны өдрийн арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээг “Үндэсний ёс заншлаас суралцах нь” сэдвийн дор 1 сарын хугацаатайгаар зохион байгууллаа.

5 –р сарын 6-нд Ард Аюушийн талбайд БСГ –ын "Нээлттэй хаалганы өдөр" зохион байгуулж номын сангийн үйлчилгээг 300 гаруй иргэдэд хүргэлээ.

Óíøèã÷äûí íîìòîé í°õ°ðë°õ èäýâõèéã °ðí¿¿ëýõ òàíèí ìýäýõ¿éã õ°ãæ¿¿ëýõийн тулд албан байгууллага аж ахуйн нэгжүүдийн ажилчдад ажлын байраар болон гэрээр ном олгох зорилгоор "Ном таны оюуны хэрэгцээ" жилийн хугацааны аян зарлаж уг аяны

болзлыг байгууллагуудаар хүргэж ном хэвлэлээр үйлчиллээ.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 0123 ДУГААР АНГИД НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ БОЛОВ

“Угийн бичиг хэрхэн хөтлөх тухай“ сургалтыг зэвсэгт хүчний 123-р анги, 8-р цэцэрлэг, нисэх буудал зэрэг байгууллагуудаар хийж 250 хүн хамрагдлаа. Угийн бичгийн сургалтыг Цэргийн ангийн ажилтан албан хаагчдын дунд явуулахаас гадна хавар 4 сард халагдах цэргүүдийн дунд явуулсан нь үр дүнтэй зүйл боллоо.

3, 4, 5, 7, 8 ДУГААР ЦЭЦЭРЛЭГТ НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ ХИЙВ

Нээлттэй хаалганы өдрөөр 8-р цэцэрлэгийн хамт олонд Нийтийн номын сангийн үйл ажиллагааг танилцуулж, номын үзэсгэлэн гаргаж, угийн бичгийн сургалт явууллаа. Нийт 27 багш ажилчид хамрагдсан байна.

Политехник коллежийн багш ажилчдад номын үзэсгэлэн гаргаж, угийн бичгийн сургалт явуулсан. Сургалтанд Цэцэрлэгийн нийт багш сурган хүмүүжүүлэгчид хамрагдлаа.

Сургалтын холбогдолтой сэдвээр АХА тэмцээн зохион явуулахад нийт 56 багш ажилчид оролцлоо.

ИРГЭНИЙ НИСЭХЭД НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Иргэний нисэхийн хамт олонд номын үзэсгэлэн гаргаж, угийн бичгийн сургалтыг зохион байгуулав. Тус байгууллагын 25 ажилтан хамрагдлаа.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН ЭЦЭГ ЭХИЙН ХОЛБООТОЙ ХАМТРАН ТУС ТӨВД НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэд” уншиж байна нээлттэй хаалганы өдрийг Гэрээр ном олгогч Б.Одонпүрэвтэй хамтран 2 удаа явууллаа. Үүнд: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг харж асардаг иргэд 36, хөгжлийн бэрхшээлтэй 42 хүүхэд хамрагдсан байна. Мөн энэ үеэр барайл ном болон шинэ ном нийт 90 номоор номын үзэсгэлэн гаргалаа. Сонсдог номоор үйлчилгээ үзүүлсэн байна.

ИРГЭДЭД ҮЙЛЧЛЭХ ӨДӨР:

Мэргэжлийн хяналтын байгууллагаас зохион байгуулсан **“Зөв тус”** аяны хүрээнд иргэдэд үйлчлэх өдрийг ХДТ-ын өмнө талбайд зохион байгуулсан арга хэмжээнд оролцлоо.

Аймгийн мэргэжлийн хяналтын албанаас зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдрийг талбай дээр зохион байгуулахад шинэ ном болон нийт 300 гаруй номоор номын үзэсгэлэн гаргаж сурталчилав

“ЭЭЖҮҮД УНШИЖ БАЙНА” ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Эрдэм шинжилгээ-чөлөөт уншлэгын танхим, номзүйн тасаг, фондын эрхлэгч нар хамтран Алагтолгой багийн гэрийн ажилтай ээжүүдиг хамруулан **“ЭЭЖҮҮД УНШИЖ БАЙНА”** өдөрлөгийг 2015 оны 12-р сарын 15 нд тус арга хэмжээг зохион байгууллаа.Нийт 15 эмэгтэй оролцлоо. Энэхүү арга хэмжээ нь гэрийн ажилтай ээжүүдийг номтой нөхөрлүүлэхэд чухал ач холбогдолтой ажил боллоо. Цаашид бид

Жаргалант сумын бүх багийн

эмэгтэйчүүдийг хамарсан ажлыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

ХОВД АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГААС АХМАДЫН ОРДОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН "АХМАДДУУДТАЙ ХАМТ УНШЬЯ" СЭДЭВТ НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ БОЛОВ

Үйл ажиллагааг нээж аргазүйч Д.Саранцэцэг үг хэлж, номын сангийн үйл ажиллагааны танилцуулга хийв.

Ахмаддуудад ном сонин, сэтгүүлээр үйлчиллээ.

Америкийн төвийн номын санч В.Алтанцэцэг өөрийн төвийн талаар танилцуулга мэдээлэл хийсэн. Мөн гэрээр ном олгогч Б.Одонпүрэв тасгийнхаа үйл ажиллагааны талаар мэдээлэл хийв.

Ахмаддуудын санал бодлыг сонслоо. Тэд маань ном сонин унших үнэхээр сонирхолтой байгаагаа, бидний үйл ажиллагааны талаар санал бодлоо чөлөөтэй ярилцлаа.

АМЕРИКИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

АЖИЛТАН АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН АНГЛИ ХЭЛНИЙ СУРГАЛТ

Даваа гариг бүрийн 18.00 цагт Америкийн төвд болдог ажилчин албан хаагчдад зориулсан англи хэлний дунд шатны сургалт зохион байгуулагддаг.

Уг хичээлээр Америкийн тухай асуулт хариултын тэмцээн зохион байгуулж шинэ дуу, мэдээлэл зэргийг хүргэхээс гадна хүн бүртээ ганцаарчилж ажиллах боломж олгодог. Суралцагчдын ихэнх эмч, багш, холбооны мэргэжилтэн, инженерүүд идэвхтэй сайн суралцаж байна. Сургалтанд **2015** онд нийтдээ **65** хүн хамрагдсан.

Жил бүрийн 1 сард зохион байгуулдаг Америкийн нэрт зүтгэлтэн хүний эрхийн төлөө тууштай тэмцэгч, уран илтгэгч Мартин Лютер Кингийн өдрийг тэмдэглэн Ховд их сургуулийн багш Ричард энэ сэдвээр лекц уншлаа.

Бээжинд суугаа Монгол Хятадын англи хэлний хөтөлбөр хариуцсан захирал Kelli Odkhuu Америкйин төвд зочилж **“Англи хэлний хэрэглээ”** сэдвээр олон нийтэд лекц хийж хөгжөөнт тоглоом тоглуулж сурагчдын асуусан асуултан хариулт

өгөв.АНУ-ын Засгийн газраас зарлагддаг тэтгэлэгт хөтөлбөрүүдийн талаар АНУ-ын

Элчин яамны Олон Нийттэй харилцах албаны орлогч дарга Крис мэргэжилтэн Болормаа нар олон нийтэд лекц уншиж танилцуулга хийлээ. Мөн Access хөтөлбөрийн сурагчидтай уулзаж

санал бодлоо солилцлоо.

Сургууль бүрийн ахлах ангийн сурагчдыг Америкийн төвд урьж

Америкийн талаарх мэдээлэл Америкийн боловсролын талаар мэдээлэл хүргэж ажилласан. Баруун бүсийн англи хэлний багш нарт Америкийн талаарх мэдээлэл Багш нарын зуны болон бусад тэтгэлэгт хөтөлбөрүүдийг танилцуулж, танилцуулга материал тараалаа.

АНУ-ын Элчин сайдын яамны дэд консул Патрик Рамли болон Олон Нийттэй харилцах албаны дарга Кристин Яринг нар ирж Ховд аймагт 3 өдрийн турш ажиллалаа. Нийтийн номын сангийн уншлагын их танхимд **“Америкийн виз”**-ний талаар олон нийтэд лекц хийв.

АНУ-ын ЭСЯ-ны орлогч дарга Ричард Америкт төгсөгчдийн холбооны тэргүүн Идэр-Ууган Англи хэлний хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Алтанцэцэг нар аксесс сурагчидтай уулзаж мөн олон нийтэд “**Америкийн Элчингийн ярилцлаганд хэрхэн бэлдэх вэ?”** лекц зохион байгуулж, англи хэлний багш нарт хөтөлбөрийн талаар мэдээлэл өгч ажиллалаа. Америкийн төвийн үйл ажиллагаатай танилцаж, санал бодолоо солилцож 3 өдрийн турш үр дүнтэй ажилласан.

“Миний мэдэх Америк” илтгэлийн уралдааныг ХИС болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн **15** сурагчдын дунд

зохион байгуулж явууллаа. Оюутан сурагчид Америкийн мужууд болон тэмдэглэлт баяр, ёс заншлын талаар илтгэл тавьж америкийн орны талаар өргөн мэдлэг мэдээлэлтэй боллоо.

“Би монголдоо хайртай” төрийн бус байгууллага, боловсрол соёлын газартай хамтран Ерөнхий боловсролын сургуулиудын 8,9,10,11,12-р ангийн дарга нартай уулзалт хийж элсэлтийн ерөнхий шалгалтанд хэрхэн бэлдэх, гадаадад амжилттай суралцах, элчингийн ярилцлаганд хэрхэн бэлдэх талаар мөн

Америкийн төвийн үйл ажиллагаа тэтгэлэгт хөтөлбөрүүдийн талаар ярилцлага хийлээ. Уг уулзалтанд Улаанбаатар хотоос Учрал ТББ дарга, БСГ-ын мэргэжилтэнүүд 67 сурагчид оролцлоо.

ЭСЯ-ны дэд консул Олон ястны телевизийн **“Ярилцах цаг”** хөтөлбөрт оролцож мэдээлэл хийлээ.

Боловсролын зөвлөгөө мэдээллийн төвийн зөвлөх нар **“Америкт суралцах 5 алхам”** лекцийг ахлах ангийн сурагчдад зохион байгууллаа.

ЕБС-ийн 5 сургуулийн **683** сурагч багш нарт Америкийн их дээд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн талаар мэдээлэл хийж зөвлөгөө өгөв.

Долоо хоногийн Даваа гаригийн “Тоглоомын өдөр” хөтөлбөр

Даваа гариг бүрийн 11.00цаг 14.00 цагуудаас **“Тоглоомын өдөр”** явагдаж байна. Америкийн төвийн талаар мэдээлэл өгч тоглоом тоглож өөрсдийн англи хэлний мэдлэгээ дээшлүүлэхийн хамт шинэ шинэ тоглоом мэдэж авч бусдадаа зааж хамтран тоглох боломж бүрдэж байгаа бөгөөд сурагчид дараах тоглоомуудыг шимтэн тоглож байна. Уг хөтөлбөр **50** удаа зохион байгуулж **578** хүн хамрагдсан

байна.

Долоо хоног бүрийн Баасан гаригийн “Кино үдэш” хөтөлбөр

Кино хөтөлбөрийг Долоо хоног болгоны Баасан гаригийн 17.00 цагаас зохион байгуулж байна.Америкийн түүхэн болон уран сайхны баримтат зэрэг кино гаргаж байна. Америкийн төвд кино гаргахаас гадна ХИС-ийн оюутны байр болон Политехник коллежийн оюутануудад оюутны байранд нь кино үзүүлж үйлчилсэн кино үдэш хөтөлбөр **42** удаа зохион байгуулж **632** хүн хамрагдсан байна.

Долоо хоногийн Мягмар, Лхагва, Пүрэв “Англи хэлний багш сургалт” хөтөлбөр

ЕБС-ийн Англи хэлний багш нарыг чадавхижуулах сургалтыг Боловсролын газрын мэргэжилтэн Хазелтэй хамтран зохион байгуулж байна. Сургалт долоо хоног болгоны Мягмар, Лхагва,Пүрэв гаригуудадын 9.30-11.30-ын хооронд явагдаж 2015 онд **98** удаа зохион байгууллагдаж **1256** багш хамрагдсан

байна.

Долоо хоногийн Лхагва гаригийн “Англи хэлний ярианы клуб”

Англи хэлний ярианы клуб нь Долоо хоног бүрийн Лхагва гаригийн 18.00 цагаас зохион байгуулж явуулж байна тус хөтөлбөрт ирсэнээр англи хэлний ярианы сонсох, ярих чадвартай болж байна. Тухайн хөтөлбөр нь **35** удаа явагдаж **456** хүн хамрагдсан байна.



Аксесс багш нартай онлайн уузалт хийв

Боловсролын зөвлөгөө мэдээллийн төвийн зөвлөгч, Аксес хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Гантөмөр Ховд аймгийн Аксесс хөтөлбөрийн багш мэргэжилтэнүүдтэй уулзалт хийж ажлын төлөвлөгөө, хичээлийн сургалтын байдалтай ярилцаж, онлайн Skype уулзалтаар уулзаж харилцан ярилцлаа.

Онлайн уншлага зохион байгуулсан Зуны сургалт

Англи хэлний зуны сургалт

АНУ-ын Элчин сайдын яамнаас 2 дахь жилдээ зохион байгуулж байгаа. **“Summer camp-2015”** сургалтанд ЕБС-ийн 2-6-7-р сургуулийн 30 сурагч10 хоногийн турш англи хэлний вакуумжуулсан сургалтанд хамрагдаж 10 багш мэдлэг мэргэжлээ дээшлүүлэн ажиллаж мөн Улаанбаатар хотоос сургагч багш Жүди ирж ажиллалаа.

МЭРГЭЖЛИЙН БУС БАГШ НАРЫН ДУНД АНГЛИ ХЭЛНИЙ ОЛИМПИАД

Монголын багш нарын баярыг угтаж багш аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын мэргэжлийн бус багш нарын дунд англи хэлний олимпиад зохион байгуулав**.** Уг олимпиадад 5 сургуулийн 22 багш оролцлоо**.**

1-р байр Цаст-Алтай цогцолбор сургуулийн компьтерийн багш П. Сарантунгалаг

2-р байр Прогресс сургуулийн математикийн багш Лхамсүрэн

3-р байр 1-р сургуулийн Химийн багш П.Баасансүрэн нар эзэллээ.

Fun English уралдаан:

"1st place State Governor"

2nd place "Lawyers"

3rd place "Unlimited"

Уралдааныг дараах үе шатуудаар зохион байгуулж байр эзлүүлсэн.

1. "Greeting of the team"- Баг бүр өөрийн онцлогийг харуулсан мэндчилгээ бэлтгэх ба энэ нь ямар ч хэлбэрээр байж болно. (хугацаа 3-5 минут)
2. "Could you sound this?"- Багийн нэг гишүүн оролцох ба бэлтгэсэн урт үгийг зөв үсэглэн хэлснээр багтаа оноо авна.
3. "Loud whisper"- Багийн 2 гишүүн оролцох ба нэг гишүүнд чихэвч зүүлгэн ая сонсгоно. Нөгөө гишүүн өгөгдсөн үгийг амны хөдөлгөөнөөр чихэвч зүүсэн гишүүнд таалгана. (3 минут)
4. "Word order"- Багаараа оролцох ба өгөгдсөн үгүүдийг зөв дараалалд оруулан өгүүлбэр бүтээнэ. Хугацаандаа багтан өгүүлбэрээ зөв дараалал оруулснаар багтаа 5 оноо авна. (3 минут)

"What did you see?"- Багийн 2 гишүүн оролцох ба нэг гишүүн өгөгдсөн үгийг үйл хөдлөл, нүүрний хувирал ашиглан, дуу авиа гаргахгүйгээр багийн нөгөө гишүүнд таалгана. Хугацаандаа багтан таалгасан үгийн тоогоор оноо авна.(2 минут)

Нутгийн Удирдлага –II ангийн "State Governor" баг 26 оноогоор **Нэгдүгээр байр**

Эрхзүй- II ангийн “Lawyers” баг 23 оноогоор **Хоёрдугаар байр**

Нягтлан бодох бүртгэл- II ангийн “Unlimited” баг 21 оноогоор **Гуравдугаар байр** тус тус эзэлсэн.

Танин мэдэхүйн уралдаан:

“Алтан хонх” танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээнийг аксес сурагчдын дунд зохион байгууллаа. 1-р байрыг Прогресс сургуулийн сурагч Т.Сэргэлэн 2-р байрыг Прогресс сургуулийн Н.Содбилэг 3-р байрыг ЦАЦ сургуулийн Г.Батзундуй нар тус тус эзэлсэн.

Пирамид танин мэдэхүйн тэмцээн

1-р байрыг Прогресс сургуулийн 10-р ангийн баг хамт олон

2-р байрыг ЦАЦ сургуулийн 10-р ангийн баг хамт олон

3- р байрыг Аксес сурагчид тус тус эзэллээ.

“Алтан хонх” тэмцээн Алтан хонх тэмцээнд Политехник коллежийн 1-2-р байрны оюутнууд амжилттай оролцлоо. 1-р байрыг Малын бага эмчийн 1-р курсийн оюутан Г.Нямбаяр түрүүлэв

Англиар хэн сайн дуулах вэ? Дууны уралдаан

Англи дууны тэмцээнийг Цаст алтай сургуулийн урлагын зааланд зохион байгуулж явууллаа. 6 сургуулийн 36 сурагч оролцсоноос 1-р байрыг 1-р сургуулийн сурагч Т.Аянур 2-р байрыг ЦАЦ сургуулийн С.Золзаяа 3-р байрыг Прогресс сургуулийн сурагч Ё.Маралгоо нар тэргүүлэв.

Америкийн соёлыг сурталчлах 7 хоногийн хүрээнд ХИС-ийн мэргэжлийн бус 2-3-р дамжааны оюутнуудын дунд **“АХА”** тэмцээнийг зохион байгуулж явууллаа. Асуулт хариултын тэмцээний сэдэв нь **“Америкийн түүх соёл”** сэдвээр явагдлаа. Нийт 74 оюутан оролцсоноос 1-р байрыг Төрийн захиргаа удирдлагын ангийн оюутан Э.Балсанцэрэн 2-р байрыг ТНУ ангийн оюутан Б.Энхзаяа

3-р байрыг ТНС-н ангийн оюутан Ж.Ёлка нар амжилттай оролцлоо.

“Fun English” Танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээнийг ХИС-ийн мэргэжлийн бус ангийн оюутнуудын дунд зохион байгууллагдсан 11 багийн 85 оюутан авхаалж самбай оюун ухаанаа сорьж ороцлоо. 1-р байрыг Accountants баг 2-р байрыг Stars баг 3-р байрыг Happy багууд тус тус эзэлсэн.

“Монгол зан үйлээс суралцъя” танин мэдэхүйн уралдаан тэмцээн зохион байгуулж Цагаан сар болон уламжлалт баяртай холбоотой асуулт хариултын тэмцээн зохиож access сурагчид өөрсдийн бэлдсэн бяцхан концертийг гадаадын иргэдэд толилууллаа. Уг тэмцээнд Боловсролын газрын мэргэжилтэн Боб тэргүүн байр эзэлж бууз хэвийн боов дурсгалын зүйлээр шагнууллаа.

Жил бүр зохион байгуулагддаг **“Олон улсын Эссэ бичлэг**”-ийн уралдааныг амжилттай зохион байгуулж Ховд аймгаас 55 сурагч 22 англи хэлний багш нар уг уралдаанд оролсоноос 11-р ангийн сурагчдаас Access хөтөлбөрийн сурагч Сүхочир Төгөлдөр нар 1,2 р байр эзэлж, багш нараас Цаст алтай сургуулийн багш Арьяабал тэргүүлж эхний 3 байрын материал улсад явж байна. Түрүүлсэн багш сурагчдыг Өргөмжлөл дурсгалын зүйлээр шагнаж урамшуулав.

Америкийн төвөөс "**Good Father**" гар зургийн уралдааныг дунд ангийн сурагчдын дунд зохион байгуулж явууллаа. 1-р байрыг ЦАЦ сургуулийн 7а ангийн сурагч О.Оюунцэцэг 2-р байрыг 6 сургуулийн 6в ангийн Буянзаяа 6 сургуулийн 3-р ангийн Э.Буяндалай нар тус тус эзэллээ.

Америкийн төвөөс Англи хэл дээр зохион байгуулагдсан "**Ээждээ бичсэн захидлын**" уралдаанд
1-р байр 6-р сургууль 12б анги Нямцэцэг
2-р байр 6-р сургууль 12б анги Энхзаяа

3-р байр 2-р сургууль 12а анги А.Гаукер тус тус байр эзэллээ.

3-р сургуулийн англи хэлний багш нартай хамтран **"Үсэглэгч зөгий "** тэмцээнийг ЕБС-ийн 11-р ангийн сурагчдын дунд зохион байгууллаа.

Энх-тайвны корпусын ажилчидтай хамтран зохион байгуулсан ажил

Энхтайвны корпусын ажилчидад Улаанбаатар хотоос сургагч багш Болд-Эрдэнэ Одонтуяа Орон нутгийн багш Уранчимэг нар ирж 3 өдрийн турш Монгол хэлний хичээл зааж сургалт зохион байгууллаа. Сургалтанд Говь Алтай болон Баянөлгий аймгаас мэргэжилтэнгүүд ирж сургалтанд хамрагдлаа.

Энхтайвны корпусын сайн дурын ажилчид Хөдөө орон нутгийн болон төвийн сургуулийн англи хэлний багш нарт з өдрийн турш англи хэлний сургалт зохион байгууллаа.Сургалтанд 30 гаруй багш нар оролцлоо.

Аксесс хөтөлбөр

Спорт өдөрлөг:

Аксесс сурагчдын дунд **“Спортын өдөрлөг“** зохион байгууллаа. Зохион байгуулагдсан тэмцээнүүд:

- ✓ Гар бөмбөг
- ✓ Гүйлтийн тэмцээн /эрэгтэй , эмэгтэй /
- ✓ Сумо /эрэгтэй, эмэгтэй

зэрэг тэмцээнүүдэд багш сурагчид идэвхитэй сайн оролцлоо.

Access-6 хөтөлбөрийн сурагчдын Төгсөлтийн баяр хийж Сертификат гардууллаа.

Аксесс тэтгэлэгт хөтөлбөр зарлагдаж ЕБС-ийн 7-н сургуулиас 80 гаруй өргөдлийн маягт, материал ирсэнээс шалгалт авч ярилцлаганд орж 26 сурагч шалгарсан.

АКСЕСС ХӨТӨЛБӨРИЙН ШИНЭ ЭЛСЭГЧИД

АНУ-ын ЭСЯ-ны тэтгэлэгээр Аксес -7 хөтөлбөрийн хичээл эхлэх бэлтгэл болох анги хувиарлалт, сурагчид болон эцэг эхтэй гэрээ байгуулж, багш сурагчдын хичээлийн сурах бичгийг хуваарилав.

Сайн үйлсийн аян зохион байгуулсан байдал

Англи хэлний сургагч багш Ричард багштай хамтран Байгаль дээр хаясан хог хаягдал ямар хугацаанд элэгдэж алга болдог, ямар хор уршигтай талаар лекц

хийлээ. Байгаль хамгаалах 1 сарын аян зарлаж ажилласан.

Аксес сурагчидтай хамтран сайн үйлсийн аян зохион байгууллаа. Энэ аяны хүрээнд “Буянт гол”-ын хогийг түүж хог хаягдлыг хогийн цэгт авч ирж хаялаа.

Уншлага үйлчилгээ зохион байгуулсан байдал

ЦАЦ-ын сургуулийн В.Янжинлхам багштай 9а анги “**Чанга уншлага**” хийж америкийн талаар мэдлэг мэдээлэлтэй боллоо. Мөн олон сонирхолтой тоглоомоор тоглож оюунаа хөгжөөв.

Прогресс сургуулийн Буянхишиг багштай анги хамт олон Америкийн төвд дээр “**Чимээгүй уншлага**” зохион байгуулж явууллаа. Багш сурагчид идэвхитэй сайн оролцлоо.

Сансар 5- р цэцэрлэгийн бэлтгэл ангийн багш Оюунцэцэг Энхцоож нартай хамтран 2 бүлэгийн 52 сурагчидад буддаг номоор үйлчилж ном будуулж хамтран ажиллаа.

10-р цэцэрлэгийн Батцэцэг багштай бэлтгэл ангийн 30 хүүхдэд тасаг танхимаа танилцуулж ном будуулж, хүүхэлдэйн кино үзүүллээ. Үзсэн киногоо харилцан ярилцлаа. 5р цэцэрлэгийн ахлах бүлгийн багш Оюунцэцэг, Энхцоож нартай хамтран “Ном

хөтөлбөрийн хүрээнд будангаа суралцъя” сэдэвт үйл ажиллагаа зохион байгуулж нийтдээ 34 хүүхэд оролцлоо.

Урилгат уншлага арга хэмжээнд Политехник коллежийн оюутнууд оролцлоо.

Политехник коллежын оюутнууд Америкийн төвтэй танилцаж ном сэтгүүл уншиж тоглоом тоглож оюуны алжаалаа тайлав.

Америкийн тэмдэглэлт баярууд

Америкийн Тусгаар Тогтнолын баярыг Access сурагчдын дунд тэмдэглэн өнгөрүүллээ.

Талархлын баяр:

“Талархлын баяр”-ыг Аксес сурагчид болон ХБЭЭХ-ны зохицуулагч Баярмаа багш нарын хамт тэмдэглэн Хайртай

хүмүүсдээ талархлын баяраар ил захидал бичиж, бэлэг өгч баярласан талархсанаа илэрхийлж бичсэн ил захидлаа сурагчид сугалаа татаж хоорондоо солилцож хайртай хүмүүсдээ хүргүүллээ.

Англи шүлгийн уралдаан :

Англи шүлгийн уралдаанд ЕБС-ийн 1-р сургууль ЦАЦ сургууль Прогресс сургууль 6- р сургуулиуд оролцож нийт **17** хүүхэд хамрагдсан.

БУСАД АЖЛЫН ТАЛААР

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2013 оны А/106 дугаар захирамжийн дагуу “Гамшгийн аюулын зарлан мэдээлэх дохио”-р талбай дээр оролцоход бэлтгэл хангасан талаар ОБГ-ирсэн мэргэжилтэнд шалгуулж санамж мэдээлэл авлаа.

МОД ТАРИХ ӨДРӨӨР

Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигийн дагуу бүх нийтээр мод тарих арга хэмжээний хүрээнд хамт олонтой хамтран 30 ширхэг мод хоёр голын хооронд 2015 оны 10 сарын 13-нд тарилаа.

Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигийн дагуу бүх нийтээр мод тарих арга хэмжээний хүрээнд хамт олонтой хамтран 50 ширхэг мод хоёр голын хооронд 2015 оны 5 сарын 10-нд тарилаа.

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан мод тарих өдрөөр Ховд хотыг “Ногоон хот “ болгох зорилгоор 2 голын завсар ажилчдынхаа хамт нийт 54 ширхэг мод тарив. 2015 онд нийт 104 ширхэг модыг тарьж ургуулав.

ЦЭЦЭГЖҮҮЛЖ ЗҮЛЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Номын сангийн гадна орчинд болон нийтийн эзэмшлийн 30м талбайн хөрс сийрүүлж зүлэг, цэцгийн үр суулган арчилж ургуулав. Өөрсдийн санаачлагаар 30м талбайд суулгаа арчлав.

Аймгийн боловсрол соёлын газраас зохион байгуулсан багш нарын болон соёлын ажилтаны өдөр зохион байгуулах арга хэмжээнд бүх ажилчдын хамт оролцов.

Соёлын ажилтны баярын өдрөөр 5 ажилтныг аймгийн болон засаг даргын шагналаар шагнуулж хөдөлмөр зүтгэлийг нь үнэлүүлэв. Мөн аймгийн ХДТ-тай хамтран ажилтнуудынхаа дунд спортын арга хэмжээ зохион байгууллаа.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Аймгийн нийтийн номын сан нь 2015 онд ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, түүнийг сурталчлан уншигчдад хүргэх, номын сангийн үйлчилгээнд шинэлэг арга барил нэвтрүүлэх, уншигчдад үйлчлэх таатай орчин бүрдүүлэх, орон нутгийн номын сангийн үйл ажиллагааг автоматжуулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаа.

Нэг. Уншлага үйлчилгээний талаар

Уншлагын танхимуудыг 2 ээлжээр ажиллуулан 6104 уншигч шинээр бүртгэж 41416 ирэгсдэд 61752 ш ном хэвлэл олгож үйлчиллээ. Нүүдэл, зөөврийн номын сангаар 1100 уншигч шинээр бүртгэж 4203 ирэгсдэд 6348 ш ном хэвлэлээр үйлчилсэн нь уншигч, ирц, ном олголтын жилийн төлөвлөгөөг 101.4-106%-иар биелүүлсэн.

Уншигч хэрэглэгчдэд интернет үйлчилгээгээр үйлчилж 411 уншигч хүссэн мэдээллээ авсан байна.

Хоёр. Фонд бүрдүүлэлт, ном хэвлэлийн захиалга,

Хэвлэлийн газруудын каталог, интернет, уншигчдын захиалга, татгалзлын дэвтэр зэргийг үндэслэн 700 гаруй нэрийн номын захиалга хийж өгөгдсөн төсвийн дагуу 7.394.698 төгрөгийн 455 ш ном, хэвлэл авч бүрдүүлэлт хийв.

Хандив, тусламжаар 278 ширхэг 1.834.650 төгрөгийн ном товхимол авч нийт 9.229.348 төгрөгийн 733 ш ном хэвлэлээр фондоо баяжуулав.

Гурав. Фондын ажил, хадгалалт хамгаалалт, тооллого

Үндсэн фонд, нийтийн уншлагын танхим, гэрээр ном олгох уншлагын танхим, хүүхдийн уншлагын танхимын ном хэвлэлийн тооллого хийж, тооллого хийгдсэн, уншлаганд гарсан номуудыг буцаан номын тавиурт 125.852 ш ном хэвлэлийг төрөл ангийн байрлалтаар байрлуулж номын байрлалд редактор хийж байрлалын засалт хийв.

Уншлагын танхимуудад уншигчдын захиалгаар 206 ширхэг ном хэвлэл фондоос гаргаж гаргасан ном хэвлэлийн ашиглалтыг шалгаж 550 ширхэг номыг буцаан авч тооцоо хийв.

Ахуйн чийгшүүлэгч болон савтай ус ашиглан фондын өрөөний агаарын чийгшлийн хэмжээг хэвийн байлгах арга хэмжээг авч байна. Фондын өрөөний чийгшил, дулааны хэмжээг өдөр бүр тэмдэглэж байв. 131 ш номонд сэлбэн засалт хийж номын эдэлгээг уртасгалаа.

Дөрөв. Ном хэвлэлд хийх техник үйл ажиллагаа

ННА-ын дагуу 2814 ном ангилахаас 2826 нэрийн ном ангилж шинээр авсан номуудад стандартын дагуу техник ажиллагааг хийж анхан шатны данс бүртгэлүүдэд тусган электрон болон уламжлалт каталогийн санд оруулж уншлага үйлчилгээнд гаргаж байна.

Номын сангийн үндсэн фондонд 442 ш, нийтийн уншлагын танхимд 143 ш, гэрээр ном олгох танхимд 59 ш, хүүхдийн уншлагын танхимд 89 ш ном хуваарилан данс бүртгэлд тусгав.

Тав. Каталог зохион байгуулалтын ажил

Мэдээллийн электрон каталогийн санд оруулах хэвлэлийн бүтээгдэхүүнийг каталогт тулгалт хийн 5930 ном оруулахаас 6794 ш ном оруулж төлөвлөгөөг 114.5%-иар биелүүлсэн байна.

Мэдээллийн электрон каталогийн санд редактор хийж /ангилал, түлхүүр үг, гарчиг, товч агуулгад/ 3000 номыг нэг бүрчлэн тулгалт хийж алдааг засаж орхигдсон мэдээллүүдийг нэмж оруулан баазыг цоожлох байснаас 1214 төрлийн 3477 ш номын бичилтэнд засвар хийв.

3390 ш карт хэвлэж уламжлалт каталогт байрлуулав. 6794 ш бар код хэвлэж хайчлан наав. Үсэг дараалллын уламжлалт каталогийн 20.000 орчим картанд редакц хийж ангилал байрлалын засвар хийв. 3390 ш картыг скочоор бүрж каталогийн картны эдэлгээг сайжруулав.

Зургаа. Лавлагаа номзүйн мэдээллийн ажил

Уншлагын танхим бүрд лавлах ном хэвлэл болон “Хүүхдэд уран сайхан, гоо зүйн мэдлэг олгоход баримтлах уран бүтээлийн жагсаалт” /БСШУЯ-ны сайдын 2011 оны 06 сарын 20ны өдрийн 228р тушаалаар шинэчлэн баталсан жагсаалт/- анд орсон ном хэвлэлийн бүтээгдэхүүнийг олж бүрдүүлэн 261 ширхэг номоор лавлагааны булан зохион байгуулан уншлага үйлчилгээнд ашиглаж байна.

“Шинэ ном”, “Залуу хүний заавал унших ном” “Хувь хүний хөгжилд” зэрэг сэдвийн 648 номоор санамж өгөх номзүй, “Шинэ ном”, “Л.Ванган” “Эмэгтэйчүүдийн

эрхийг хамгаалах өдөрт” “Сурагчдын заавал унших зохиолууд”, “Ц.Доржготовын намтар уран бүтээл”, зэрэг сэдвүүдийн 322 номоор бүртгэн мэдээлэх номзүй, “Шинэ ном”, “Д.Сүхбаатар”, “Монголчуудын уламжлалт цагаан сар”, ”Монгол үндэсний уламжлалт ёс заншлаас”, “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт”, “Монголын зэвсэгт хүчний түүхээс”, “Монгол цэргийн өдөрт”, “Олон улсын хүүхдийн номын баярт”, “Эрүүл мэнд”, “Мэргэжил бүхэн сайхан”, “Монгол бичиг”, “Хүүхдийн ном” “Л.Ванганы 95 нгасны ойд” “МУСГЗ Ч.Дагвадорж” “Ш.Гүрбазарын уран бүтээлээс” “Залуу хүний унших зохиолууд” “ хувь хүний хөгжилд” “Б.Догмидын уран бүтээлээс” “Төрийн шагналт СГЗ, Ардын уран зохиолч яруу найрагч Б.Лхагвасүрэнгийн уран бүтээлээс”, “ЕБС-ийн төгсөгчдөд”, “Хубилай хаан”, “Монголын багш нарын өдөрт”, “Төрийн шагналт, СГЗ Д.Төрбатын уран бүтээлээс”, “Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч, СГЗ, Төрийн шагналт Л.Түдэв”, “Хүний эрх, эрх чөлөө”, “Олон улсын ахмадын баярт” сэдвүүдээр 771 ш номын жагсаалт гаргаж сурталчилгаа хийв.

Мэдээлэл сурталчилгааны самбарт цаг үеийн үйл явдлуудтай холбогдуулан Зохиолчдын эвлэл байгуулагдсан өдөр, “Монгол улсын үндсэн хууль”, Д.Сүхбаатарын мэндэлсэн өдөрт, Тогтмол хэвлэл үүссэн өдөр, Эх орончдын өдөр, Монголын зэвсэгт хүчин, Дэлхийн усны өдөр, Олон улсын театрын өдөр, Инээдмийн өдөр, Дэлхийн эрүүл мэндийн өдөрт, Хөшөө дурсгалаа хамгаалах өдөрт, Ялалтын баяр, Үндэсний бичиг үсгийн баяр, Дэлхийн гэр бүлийн баяр, Дэлхийн мөнгөний өдөр, Нүүдлийн номын сан ажиллуулах тухай зааварчилгаа, Нийтийн номын сан, Архи түүний хор хөнөөл, Оюуны өмчийг хамгаалах өдөр,Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Дэлхийн байгаль хамгаалах өдөр, Дэлхийн хүүхдийн номын өдөр, Хэвлэлийн эрх чөлөөний өдөр, Дэлхийн музейн өдөр, Номын сангаас зохион байгуулах ажлуудын удирдамж гэх мэт сэдвүүдээр 50 гаруй удаа мэдээлэл гаргаж уншигч хэрэглэгчдэд хүргэлээ. Уншигчдын асуусан төрөл бүрийн лавлагаанд тухай бүрд нь хариулт өгч аман лавлагаа 231 удаа өгч аман лавлагааны дэвтэрт бүртгэсэн байна.

Долоо. Соёл олон нийтийн ажил

Цаг үеийн онцгой үйл явдал, түүхэн тэмдэглэл, танин мэдэхүй зэрэг бүхий л сэдвүүдийг сурталчлах уншигчдад хэрэгцээ шаардлагатай төрөл бүрийн мэдээллийг хүргэх, номын санд хадгалагдаж байгаа ном хэвлэлийг уншигчдад хүргэхийн тулд СОНА-ыг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулж явууллаа.

Хүүхдийн ном, Л.Ванганы 95 насны ойд, “Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт” “Сурагчдын заавал унших зохиолууд”, “Ц.Доржготовын намтар уран бүтээл”, “Д.Сүхбаатар”, “Монголчуудын уламжлалт цагаан сар”, ”Монгол үндэсний уламжлалт ёс заншлаас” , “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт”, “Монголын зэвсэгт хүчний түүхээс”, “Монгол цэргийн өдөрт”, “Олон улсын хүүхдийн номын баярт”, “Эрүүл мэнд”, “Мэргэжил бүхэн сайхан”, “Монгол бичиг”, “Хүүхдийн ном” “Л.Ванганы 95 насны ойд” “МУСГЗ Ч.Дагвадорж” “Ш.Гүрбазарын уран бүтээлээс” “Залуу хүний унших зохиолууд” “Хувь хүний хөгжилд” “Б.Догмидын уран бүтээлээс” “Төрийн шагналт СГЗ, Ардын уран зохиолч яруу найрагч Б.Лхагвасүрэнгийн уран бүтээлээс”, “ЕБС-ийн төгсөгчдөд”, “Хубилай хаан”, “Монголын багш нарын өдөрт”, “Төрийн шагналт, СГЗ Д.Төрбатын уран бүтээлээс”, “Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч, СГЗ, Төрийн шагналт Л.Түдэв”, “Хүний эрх, эрх чөлөө”, “Олон улсын ахмадын баярт” зэрэг сэдэвчилсэн номын үзэсгэлэн 34 удаа 1216 номоор, Шинэ номын үзэсгэлэн 18 удаа 475 номоор гаргаж сурталчилгаа хийсэн.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ЕБС-ын сурагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ном эрдэмд шамдуулах, төрөлх нутгийнхаа түүх соёлыг судлуулах, тэдний идэвх сонирхол, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, номын сангийн үйлчлэх хүрээг өргөжүүлэх зорилгоор “Хүүхэд бүр уншигч-2” ном унших аяныг 2015 оны 3-р сарын 16- аас 2015 – оны 5-р сарын 16 хооронд 2 сарын хугацаатайгаар зохион байгуулан явууллаа.

Тус аяныг Аймгийн засаг даргын тамгын газар, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хөвсгөл аймгийн залуучуудын холбоо, Мөрөн сумын ЕБС-тай хамтран зохион байгууллаа. Энэхүү аяны нээлтэнд хамтран ажиллах байгууллагын зочид төлөөлөгчдийг урьж оролцууллаа

Нээлтийн үеэр 2015 оны эхний хагас жилд захиалгаар ирсэн номуудаар “Шинэ ном” нээлттэй хаалганы өдрийг зохион байгууллаа. Мөн “Дэлхийн хүүхдийн номын өдөр”-т зориулсан номын үзэсгэлэн гаргаж уншигчдад сурталчлан, уншигч хүүхдүүд урлагийн номер үзүүллээ.

Хүүхэд бүр уншигч аяны хугацаанд зохиогдох ажил, тэргүүний уншигч хүүхдүүдийг шалгаруулах журмыг танилцуулав. Уг аянаар Хөвсгөл аймгийн залуучуудын дунд “Залуучууд ба ном” хэлэлцүүлэг, Хөвсгөл аймгийн шүүхийн шийдвэрийн харьяа хорих ангид зөөврийн номын сан ажиллуулах, Хөвсгөл аймгийн нийтийн номын сангийн харьяа “Уншигч клуб”-ын залуусын дунд ном солилцоо

ажиллуулах, Ахлах ангийн сурагчдын дунд хүний эрх ба эрх чөлөө сэдэвт сургалт / Сургууль бүр дээр/, Шинэ номоор нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах, Ахлах ангийн сурагчдын дунд АХА тэмцээн /Сэдэв “Хүний эрх, Эрх чөлөө”/, АХА тэмцээн Бага ангийхний дунд /Сэдэв: Танин мэдэхүй/, Уншигч зохиолчдын уулзалт зохион байгуулах, Мэргэжил сонголт сэдэвт лекц зохион байгуулах, Залуу зохиолч П. Майнбаярын нэрэмжит яруу найргийн уралдаан, Бага насны уншигчдын дунд тойм яриа, Чанга уншлага, Урилгат уншлага явуулах, Шилдэг сурагчдыг тодруулж “Тэргүүний уншигч Нацагдорж тэмдэгтэн” цол тэмдэгтэн шалгаруулах зэрэг ажлуудыг зохион явуулсан.

Манай номын сан жил бүр үндэсний “Номын баяр”-ыг зохион байгуулдаг. Манай байгууллага номын баярыг тогтмол хугацаанд тасралтгүй 17 жилийн турш зохион байгуулж, нийгэмд хамрах хүрээг нь тэлэх бодлого баримтлан явуулж байна. Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж номын баярт зориулан 158-р зарлигаа гарган улс орон даяар тэмдэглэж байхыг уриалсан билээ. Манай байгууллага жил бүр энэ баярыг тохиолдуулан 2 сарын хугацаатай ном унших аяныг зохион явуулдаг. Энэ жилийн номын баярыг 9-р сарын 16- 11р сарын 20-ны хооронд МУСГЗ, МЗЭ-ын шагналт Зохиолч яруу найрагч Далантайн Сүрэнжавын нэрэмжит болгон зохион байгууллаа. Аяны хугацаанд:

- *Шинэ номын үзэсгэлэн /131 номоор гаргав/*
- *МУСГЗ зохиолч яруу найрагч Д. Сүрэнжавын зохиол бүтээлийн үзэсгэлэн гаргаж нийтэд сурталчлав. Зохиогчийн 3 боть түүвэр зохиол 1380000 төгрөгийн 276 ш номыг 23 сум, сургуулиудын номын санд хандивлах ажлыг зохион байгууллаа.*
- *Аймгийн нийтийн номын сан Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс хамтран Аймгийн ШШГА-ны харьяа 441-р хорих ангид нүүдлийн номын сан ажиллуулж Сургалт мэдээлэл хүргэлээ.*

Сургалт мэдээллийг Аймгийн хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэнгүүдийн тусламжтайгаар хийлээ.

1. *Ажилд зуучлах сэдвээр Аймгийн хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн Д. Бямбацогт*
2. *Хөдөлмөр эрхэлтийн бүртгэл сэдвээр Аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн Б. Энхбаатар*
3. *Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сэдвээр Аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн М. Батчимэг*

4. *Нүүдлийн номын сангийн талаар Аймгийн нийтийн номын сангийн Гэрээр ном олгох танхимын номын санч Ч. Базар нар мэдээлэл хийж харилцан ярилцлаа.*

Аймгийн нийтийн номын сангаас тус албанд 50ш номыг 1 сарын хугацаанд аялууллаа. Энэ хугацаанд 20 хүмүүжигчийг номын сангийн уншигчаар шинээр бүртгэж 270 ирэгсдэд 435 ш номоор үйлчилсэн.

- *Аймгийн ИТХ-ын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран "Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах нь" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2015 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Нутгийн удирдлагын ордны "Сүлд" танхимд зохион байгууллаа. Уг эрдэм шинжилгээний хуралд зориулж Хүний эрх, эрх чөлөө сэдэвт номын үзэсгэлэн гаргаж нийт 19 илтгэлийг хэлэлцүүлсэн бөгөөд хамгийн залуу илтгэгч нь ерөнхий боловсролын сургуулийн сурагч Б.Хулан, Д.Эрдэнэтуяа нар байлаа. Уг хуралд аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх ГХУСАЗЗ-ийн гишүүн байгууллагууд хамрагдлаа. Тодруулбал, сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нар, аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газар, Шүүх, ШШГА, ИНБ, Эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл оролцож олон сонирхолтой сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүллээ. Тухайлбал, "Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах", "Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх", "Байгаль орчны журмын эсрэг хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх", "Амиа егүүтгэх нь нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болох нь" зэрэг олон сонирхолтой сэдвүүдийг илтгэгч нар сонгон авсан байв.*
- *Тэмцээний ерөнхий шүүгчээр аймгийн Прокурор, Хууль цаазын итгэмжит зөвлөх Н.Ганболд, шүүчээр Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Чулуунцэцэг, Мөрөн сумын ахмадын хорооны дарга, ахмад хуульч Ц.Нянтайсүрэн нар ажиллаж илтгэх чадвар, ач холбогдол, илтгэлийн бүтэц, судалганы арга зүй боловсруулалт, асуудлыг шийдвэрлэх шийдэл, гарц гэсэн шалгуураар үнэлж байр эзлүүлсэн.*

  Тусгай байрыг Чандмань-Өндөр сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Номин "Хятад мотоцикль ба гэмт хэрэг" сэдвээр, Нэгдсэн эмнэлэгээс оролцогч С.Содномбямба "Амиа егүүтгэх нь нийгмийн тулгамдсан асуудал болох нь" сэдвээр, гуравдугаар байрыг Шүүхийн шинжилгээний албаны шинжээч Ч.Ганзориг "Мөрөн суманд үйлдэгдэж буй зарим хулгайлах хэргийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх арга зам" илтгэлээр, дэд байрыг Улаан

тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга Ж.Төмөрсүх "Соёны бүс нутагт байгалын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан ажлын үр дүн, сургамж, бэрхшээл" сэдвээр, тэргүүн байрыг Бүрэнтогтох сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Ё.Баяржавхлан "Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцлийг арилгахад хүүхдүүдийн оролцоо, хувь нэмэр" илтгэлээрээ тус тус шагнал хүртлээ.

- *Шинэ номоор нээлттэй хаалганы өдөр зохион байгууллаа. Нийт 200 гаруй уншигчид хамрагдан үйлчлүүлэв.*
- *Номын баярын хүрээнд нүүдлийн номын сангийн үйлчилгээг Цагаан-Уул сумын иргэдэд хүргэлээ. Энэхүү ажлын хүрээнд Бүрэнтогтох сум, Цагаан-Уул сумын соёлын төвийн номын сан, ЕБС-ын номын сангуудтай танилцаж арга зүйн зөвлөмжүүд өгч зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.*

Шинэ номын мэдээлэл хийж, “Хоймор нутгаа судлая” сэдэвт Алтан хонх тэмцээнийг Цагаан-Уул сумын иргэд, ЕБС-ын ахлах ангийн сурагчдын дунд тус тусад нь зохион байгуулж эхний 3 байр эзлүүлж Өргөмжлөл дурсгалын зүйл хадгалуулав.

Насанд хүрэгчдэд:

1. *1 – р байр П. Зулцэцэг*
2. *2 – р байр Ж. Өлзийсайхан*
3. *3 – р байр Н. Мягмарсүрэн*

Ахлах ангийн сурагчдын дунд:

1. *1 – р байр С. Лхагва-Очир*
2. *2 – р байр Х. Галсанжамц*
3. *3 – р байр Э. Бүдхандсүрэн*

Мөн ахлах ангийн сурагчдад мэргэжлээ зөв сонгох, заавал унших зохиолуудаар номын үзэсгэлэн гаргаж сурталчлав. Нийт 160 гаруй хүнд 200-аад ном хэвлэлээр үйлчлэв.

Уншигч зохиолчдын уулзалт зохион байгууллаа. Уулзалтанд МЗЭ-ийн шагналт яруу найрагч П.Майнбаяр, яруу найрагч сэтгүүлч Б.Сарантуяа нарыг урьж оролцуулав. Уг үйл ажиллагаанд Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа ЕБС-ын сурагчид, багш, яруу найрагт сонирхолтой идэвхтэн уншигчид оролцсон. Мөн энэ үер зохиолч, Яруу найрагч Б. Сарантуяагийн намтар, уран бүтээлээр сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж олон нийт, телевиз хэвлэл мэдээлэлийн байгууллагаар сурталчилсан.

Уулзалтын үер Номын сангийнхаа тэргүүний уншигч нарт “Нацагдорж тэмдэгтэн” – ийг гардуулан өглөө. Нийт 5 сурагч тэргүүний уншигч болсон.

- *МЗЭ-ийн шагналт зохиолч, яруу найрагч Б. Сарантуяагийн нэрэмжит яруу найргийн өдөрлөг зохион байгуулав. Өдөрлөгөөр яруу найргийн наадам зохион байгуулж уг наадмын шүүгчдээр*
  1. *Зохиолч Б. Сарантуяа*
  2. *Зохиолч П. Майнбаяр*
  3. *Зохиолч Ц. Ганболд нар ажиллаж 1-3 байр 2 тусгай байр эзлүүлж өргөмжил ном дурсгалын зүйлээр урамшуулаж мөн тэргүүн байранд орсон 1 оролцогчид Б.Сарантуяа зохиолч өөрийн нэрэмжит цом гардуулж баяр хүргэлээ. Яруу найргийн уралдаанд 30 хүн оролцож авъяас билгээрээ уралдав.*
- *Орчин үеийн утга зохиолыг үндэслэгч Д.Нацагдоржийн уран бүтээлийн үзэсгэлэн гаргаж сурталчилгаа хийв.*
- *Тэргүүний уншигч хүүхдүүдийг шалгаруулж “Тэргүүний уншигч- Д.Нацагдорж тэмдэгтэн” цол тэмдгээр 6 уншигчийг шагнаж урамжуулав.*

Чанга уншлага, тойм яриа. Хүүхдийн уншлагын танхимаас номын тухай тойм яриа 17 удаа, чанга уншлага 18 удаа, бүтээлч уншлага 4 удаа, урилгат уншлага 5 удаа явуулж төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион уншигчдын бүтээлээр үзэсгэлэн гаргаж тэдний амжилт бүтээлийг нийтэд сурталчлан алдаршуулав.

Зөөврийн номын сан. Мөрөн сумын Улсын Тэргүүний 2-р цэцэрлэгийн ахлах А бүлэгт нүүдлийн номын сан ажиллуулж номын сангийн талаар товч мэдээлэл хийв. Нүүдлийн номын сангийн фондыг тухайн хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт нь тохируулан 40ш үлгэрийн номоор бүрдүүлж, уншлага явуулав. Хүүхдүүдэд орос ардын үлгэр “Алтан өндөгт тахиа”, “Цасан гоо ба долоон одой” үлгэрүүдээр чанга уншлага хийв.Орос ардын үлгэр “Алтан өндөгт тахиа” үлгэрээр бүтээлч уншлага явуулж оролцогч хүүхдүүдийн идэвхийг сэргээж хүүхэд бүрийг урамшуулав.
Оролцсон хүүхдүүдийн бүтээлээр үзэсгэлэн гаргаж өөрсдөд нь үзүүлж сонирхуулав.

Авьяас 8 ахлах сургуулийн П.Сарантуяа багштай 8а ангид зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлж, 27 сурагчийг номын сангийн уншигчаар бүртгэн үйлчлэв.

Сурагчдад нийтийн номын сангийн үйл ажиллагааны талаар товч танилцуулга хийж, хэрхэн уншигч болох, номын сангаар хэрхэн үйлчлүүлэх, номоо хэрхэн сонгох, ном унших арга хэлбэрийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч 2015 онд ирсэн шинэ ном

болон Номын санд ямар ямар сонин сэтгүүл захиалдаг талаар мэдээлэл өгсөн. Нүүдлийн номын сангаар уншуулах номнуудаа танилцууллаа.

Ахмадын асрамж үйлчилгээний төв, Хилийн цэргийн 0257-р ангитай зөөврийн номын сан ажиллуулах гэрээ байгуулан үйл ажиллагааг нь тогтмолжуулан хамтран ажиллаж байна. Номын сангийн үйлчилгээ хүрэх боломжгүй алслагдсан газруудад номын сангийн үйлчилгээг хүргэх зорилгоор Аймгийн хилийн цэргийн 0257-р ангийн бие бүрэлдэхүүн болон Аймгийн хилийн цэргийн 10 заставаар 2015 оны 03 сарын 12- оос 2015 оны 9- р сарын 20 хооронд нүүдлийн номын сан ажиллуулав. Уг хугацаанд 736 уншигчдад карт нээж 3550 уншигчдад 5223 номоор үйлчилсэн.

Хатгал тосгонд 2015 оны 07 сарын 5-7 хооронд нүүдлийн номын сан

ажиллуулав. Зөөврийн номын сангийн үйл ажиллагааг 150 орчим ном, тогтмол хэвлэл, төрөл бүрийн амьдрах ухааны болон ахуйн зөвлөмжүүд бүхий фондтойгоор үйлчилгээ үзүүллээ. Зөөврийн номын сангийн үйлчилгээнд нутгийн оршин суугчид, амрагчид хамрагдаж нийт 200 гаруй хүнд номын сангийн үйлчилгээг хүргэсэн. Мөн тус сумын соёлын төвийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж арга зүйн зөвлөгөө өгөв.

11р сард нүүдлийн номын сангийн үйлчилгээг Цагаан-Уул сумын иргэдэд хүргэлээ. Энэхүү ажлын хүрээнд Бүрэнтогтох сум, Цагаан-Уул сумын соёлын төвийн номын сан, ЕБС-ын номын сангуудтай танилцаж арга зүйн зөвлөмжүүд өгч зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.

Шинэ номын мэдээлэл хийж, "Хоймор нутгаа судлая" сэдэвт Алтан хонх тэмцээнийг Цагаан-Уул сумын иргэд, ЕБС-ын ахлах ангийн сурагчдын дунд тус тусад нь зохион байгуулж эхний 3 байр эзлүүлж Өргөжлөл дурсгалын зүйлээр шагнав. Мөн ахлах ангийн сурагчдад мэргэжлээ зөв сонгох, заавал унших

зохиолуудаар номын үзэсгэлэн гаргаж сурталчлав. Нийт 160 гаруй хүнд 200-аад ном хэвлэлээр үйлчлэв.

Зөөврийн номын сангаар нийт 1100 уншигч, 4203 ирэгсэд, 6349 ш номоор үйлчлүүлсэн байна.

Ном хэвлэлийн тооллого. Нийтийн уншлагын танхим, хүүхдийн уншлагын танхимын ойрын фондын тооллогыг 2 удаа хийж үндсэн фондын номын хүлээлцэх тооллогыг хийж дууслаа. Нийт 65884 ном тооллогонд орсон.

Ном хэвлэлийн сэлбэн засалт. Урагдаж гэмтсэн 131 номонд сэлбэн засалт хийж уншлаганд гаргалаа. /Сэлбэн засалтын ажлыг баримтжуулсан/

Мэргэжил арга зүйн талаар. Чандмань-Өндөр, Тосонцэнгэл, Цэцэрлэг, Рашаант сумдын номын санч нарт ном хэвлэлийн ангилал, тэргүүний уншигч шалгаруулах журам, монбиблио програмд ном оруулах дадлага зэрэг арга зүйн зөвлөмжүүдийг утсаар болон амаар, дадлагын хэлбэрээр өгсөн.

Монгол Улсын Үндэсний номын сан, Хөвсгөл аймгийн Нийтийн номын сангаас хамтран Сумын соёлын төвийн номын санч, ЕБС-ын номын санч нарт 2015 оны 9-р сарын 15-17-нд зохион байгуулсан "НОМЫН САНГИЙН АЖЛЫН АРГА ЗҮЙ" сэдэвт 16 цагийн сургалт зохион байгуулж "Сертификат" олгов. Цагаан-Уул сумын ЕБС-ийн номын сан, Цагаан-Уул, Бүрэнтогтох, Хатгал, Алаг-Эрдэнэ сумын нийтийн номын сангийн ажил байдалтай танилцаж арга зүйн зөвлөмжүүд өгсөн.

Захиргаа аж ахуйн талаар. Долоо хоног бүр шуурхай цуглаан хийж, тулгамдаж байгаа асуудал, жил улирал сарын ажлыг дүгнэн ярилцаж, цаашид хийх зүйлээ төлөвлөн, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, өөрийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөн ажиллав.

Улсын төсвөөс 169,078.0 сая төгрөг батлагдсанаас 159,862.7 төгрөгийн санхүүжилт аван зориулалтын дагуу зарцуулан, 9,215.2 сая төгрөг Улс орны санхүүгийн хүндрэлээс шалтгаалан санхүүжил олгогдоогүй .

Байгууллагын өмчийн тайланг хуулийн дагуу гаргаж өгч, нийт ажилтнуудтай эд хөрөнгийн хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулан, галын аюулгүй байдлыг ханган онцгой байдлын албатай хамтран сургалт зохион байгуулан, Галын аюулгүй байлыг хангах гэрээ байгуулан ажиллав.

НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2015 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нэг. Үндсэн үйл ажиллагааны талаар. Бүтээгдэхүүн 1,2,3

№	Нийлүүлэх бүтээгдэхүүний төрөл	2015 онд нийлүүлэх	2015 онд нийлүүлсэн	Чанар	Өртөг
1	Уншигч	6022	6104 Үүнээс зөөврийн номын сангаар 1100	101,4%	63,6 хүн өдөр

2	Ирэгсэд	39048	41416 Үүнээс нүүдэл зөөврийн номын сангаар 4203	106%	345,1 хүн өдөр
3	Ном олголт	59832	61752 Үүнээс нүүдэл зөөврийн номын сангаар 6348	103,2%	514,6 хүн өдөр
4	Интернэт үйлчилгээ	400 уншигчид	411	103%	

Хоёр. Фонд баяжилт, фондын ажил

№	Нийлүүлэх бүтээгдэхүүний төрөл	2015 онд нийлүүлэх	2015 онд нийлүүлсэн	Чанар	Өртөг
1	Татгалзлын дэвтэрт бүртгэгдсэн уншигчдын хэрэгцээний дагуу хэвлэлийн бүтээгдэхүүний захиалга хийх	450	458	102%	
2	Ном хэвлэлийг дагалдах баримтын хамт хүлээн авах	600	733	122,1%	2 хүн өдөр
3	Сонин сэтгүүлийг хүлээн авах /Сонин сэтгүүлийг үсэг дараалаар болгох, сонин сэтгүүлийн карттай тулгах/	9	9	112,5%	0,02 хүн өдөр
4	Хандив тусламжаар фонд баяжилтийг бүрдүүлэх	150	278	185,3%	
5	Номын сангийн фонд, уншлагын танхимуудад ном хуваарилах / танхимуудын дансанд бичих, нэг бүрчилсэн бүртгэлд тэмдэглэл хийх г.м./	600	733	122,1%	

6	Ном хэвлэлийг фонд, уншлагын танхимуудад данс бүртгэлтэй тулгаж хүлээлгэн өгөх	300	733	244,3%	0,3 хүн өдөр
7	Номын тавиурт ном хэвлэлийг төрөл ангийн байрлалтаар байрлуулах	97832	125852	129%	524,3 хүн өдөр
8	Уншлагын танхимуудаас ном хэвлэлийн ашиглалтыг шалгаж ном буцаан авах /фондоос захиалгаар гарсан/	140 ш ном	550	392,8%	1,4 хүн өдөр
9	Уншлагын танхимуудын захиалгаар ном хэвлэл фондоос гаргах	200	206	103%	
10	Фондын номын байрлалыг шалгах	40000	41500	104%	86,4 хүн өдөр
11	Фондын төрөл ангийн байрлалтанд зориулсан ялгагч хийх	1000	1012	101,2%	
12	Үсэг дарааллын байрлалтанд зориулсан ялгагч хийх	50	58	116%	

Гурав. Каталог зохион байгуулалтын ажил

№	Нийлүүлэх бүтээгдэхүүний төрөл	2015 онд нийлүүлэх	2015 онд нийлүүлсэн	Чанар	Өртөг
1	Каталогт карт байрлуулах / урьдчилан ялгасан картыг үсэг дараалал , төрөл анги , зүйлчилсэн каталогт байрлуулах /	3500	3511 /Үүнээс төрөл ангид 590/	100,3%	3,5 хүн өдөр

2	Үсэг дараалын каталогт редакц хийх / номзүйн бичилт зөв эсэхийг шалгах, буруу байрлагдсан картыг авах, нэмэлт картуудыг тулгах /	2 удаа	2 удаа	100%	
3	Төрөл ангийн каталогийг шинэчлэн зохион байгуулах		590		
4	Төрөл ангийн каталогийн ялгагч шинээр бичиж байрлуулах		291		1,2 хүн өдөр
5	Орон нутгийн картын санд карт бичиж баяжуулах	200	203	101,5%	
3	Мэдээллийн электрон каталогийн санд хэвлэлийн бүтээгдэхүүн оруулах	5930	6794	114,5	212,3 хүн өдөр
4	Мэдээллийн электрон каталогийн санд редактор хийх /ангилал, түлхүүр үг, гарчиг, товч агуулгад/ номыг нэг бүрчлэн тулгалт хийж алдааг засаж орхигдсон мэдээллүүдийг нэмж оруулан баазыг цоожлох	3000	1214 төрлийн 3477 ш номонд	116%	
5	Электрон каталогт орсон номуудад түлхүүр үг, товч агуулга, хавтасны зураг оруулна.	85	91	107%	

Дөрөв. Ном хэвлэлд хийх техник ажиллагаа

№	Нийлүүлэх бүтээгдэхүүний төрөл	2015 онд нийлүүлэх	2015 онд нийлүүлсэн	Чанар	Өртөг
1	Ном ангилах /ном хэвлэлтэй танилцах, ННА-ын номноос индексийг олох, ном хэвлэлд индекс бичих/	2814	2826	100,4%	88,3 хүн өдөр
2	Зохиогчийн тэмдэгтийг	2814	2826	100,4%	6 хүн

	тодорхойлох				өдөр
3	Нэгдсэн бүртгэл хөтлөх	20	39	195%	
4	Ном хэвлэлийг данслах ба номын нүүр хуудас болон 17-р хуудсанд дансны дугаарыг бичих тэмдэг тавих	600 аас дээш	733	122,1%	15,2 хүн өдөр
5	Формулярийн уут хайчлах	3316	3503	106%	22 хүн өдөр
6	Ном болон уншигчийн картанд формулярийн уут наах	6632	6837	103,09%	2,8 хүн өдөр
7	Бар код хэвлэх	5930	6794	114,5%	
8	Бар код хайчлах	5930	6794	114,5%	4,2 хүн өдөр
9	Бар код наах	5930	6794	114,5%	3 хүн өдөр
10	Номын формуляр бөглөх	600	733	122,1%	1,5 хүн өдөр

Тав. Мэдээлэл сурталчилгаа соёл олон нийтийн ажил

№	Нийлүүлэх бүтээгдэхүүний төрөл	2015 онд нийлүүлэх	2015 онд нийлүүлсэн	Чанар	Өртөг
1	Сэдэвчилсэн номын үзэсгэлэн	33	34	103%	111 хүн өдөр
2	Шинэ номын үзэсгэлэн	18	18	144,4%	26 хүн өдөр
3	Өдөрлөг	2	3	150%	22 хүн өдөр
4	Тойм яриа	17	18	105%	
5	Чанга уншлага	18	20	111,1%	

6	АХА	5	5	100%	8 хүн өдөр
7	Дүрийн тоглолт	2	2	100%	
8	Алтан хонх тэмцээн	1	2	100%	
9	Уншигч зохиолчдын уулзалт	1	2	200%	60 хүн өдөр
8	Бүтээлч уншлага	4	4	100%	9 хүн өдөр
9	Урилгат уншлага	5	5	100%	40 хүн өдөр
10	Номын аян	2 удаа	2	2	60 хүн өдөр

Зургаа. Лавлагаа номзүйн мэдээллийн ажил

№	Нийлүүлэх бүтээгдэхүүний төрөл	2015 онд нийлүүлэх	2015 онд нийлүүлсэн	Чанар	Өртөг
1	Лавлагааны фонд шинэчлэн баяжуулах	250 ном	261	104,4%	
2	Санамж өгөх номзүй	515 нэр	648	125,8%	20,2 хүн өдөр
3	Бүртгэн мэдээлэх ном зүй	240	322	134,1%	7,3 хүн өдөр
4	Номын жагсаалт гаргах	665	771	116%	13 хүн өдөр
5	Аман лавлагаа өгөх	222	225	101,3%	4 хүн өдөр
6	Аман лавлагааны дэвтэр хөтлөх	222	225	101,3%	0,5 хүн өдөр
7	Татгалзлыг хөтлөх		458	100%	

Долоо. Нүүдлийн номын сан, Номын сан хоорондын солилцоогоор үйлчлэх ажил

№	Нийлүүлэх бүтээгдэхүүний төрөл	2015 онд нийлүүлэх	2015 онд нийлүүлсэн	Чанар	Өртөг

1	ДМЦС-ийн номын сантай солилцоо	Уншигчийн хүсэлтээр	27 ном		
2	2-р сургуулийн номын сантай	Уншигчийн хүсэлтээр	31		
3	Ирээдүй сургуулийн номын сантай	__,,__		__,,__	
4	Хилийн Цэргийн Газрын номын сантай зөөврийн номын сан ажиллуулах	78-аас дээш номтой	81	__,,__	
5	ШШГГазар	50	53		
6	Цагаан-Уул суманд зөөврийн номын сан		102 номтой		
7	Хатгал тосгонд зөөврийн номын сан		151 номтой	100%	
8	Мөрөн сумын Улсын тэргүүний 2р цэцэрлэгт		40ш ном	100%	
9	Мөрөн сумын Авъяас 8-р сургуулийн 8[a] ангид		50 ш номтой	100%	

Найм. Номын тооллогын ажил

№	Нийлүүлэх бүтээгдэхүүний төрөл	2015 онд нийлүүлэх	2015 онд нийлүүлсэн	Чанар	Өртөг
1	Насанд хүрэгчдийн уншлагын танхимын ном ойрын фондын ном тоолох	3640	3640	100%	3 хүн өдөр
2	Хүүхдийн танхимын номын тооллого хийх /ээлжит/	851	851	100%	0,7 хүн өдөр
3	Үндсэн фондын номын тооллого		65884	100%	

Ес. Ном сэлбэн засалт

1	Салсан хуудас наах			__,,__	
2	Номыг цоолж үдэх				
3	Хуудас нөхөх				
4	Ном хавтаслах, салсан хавтас нааж бэхлэх				

5	Ном сэлбэн засалтыг баримтжуулах	124	131	106%	

Арав. Арга зүйн ажлын талаар

	Орон нутгийн номын санчдад номын сангийн үйл ажиллагааг *сайжруулахад зориулсан төрөл бүрийн сэдвийн мэдээлэл өгөх /Бичгээр болон амаар/*	Орон нутгийн номын санч нарт	Чандмань-Өндөр, Тосонцэнгэл, Цэцэрлэг сумын номын санчдад номын ангилал, монбиблио програмд ном оруулах дадлага	100%	
	Орон нутгийн номын санчдыг мэргэшүүлэх сургалтанд хамруулах	Нийт 33 номын санч	Монголын Үндэсний номын сантай хамтран Номын санчдын дунд 2 өдрийн сертфикаттай сургалт зохион байгуулсан	100%	

ТӨРИЙН ШАГНАЛТ ЯРУУ НАЙРАГЧ Р. ЧОЙНОМЫН НЭРЭМЖИТ ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Удирдлага зохион байгуулалт

Монгол Улсын Соёлын тухай хууль, төрөөс баримтлах соёлын бодлого бусад хууль эрх зүй, Монгол Улсын Засгийн газар, Аймгийн Засаг Даргын мөрийн хөтөлбөрүүд, төсвийн ерөнхийлөн захирагч Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд болон аймгийн засаг даргын хооронд засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээ, номын санг 2013-2018 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө болон дэвшүүлсэн зорилго зорилтоо биелүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ирлээ.

Уншигчдын ном хэвлэл унших мэдээлэл авах цар хүрээ өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд тус номын сан нь уншигчдын эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолыг судлан тэдэнд хэрэгцээтэй мэдээ мэдээлэлийг цаг тухайд нь хүргэж үйлчлэхэд гол анхаарлаа чиглүүлэн ажиллалаа.

Уншигчдын нас сэтгэхүйн онцлог хүүхдийн уншлагын танхим нь насанд хүрэгчдийн танхимаас ялгаагүй, номын тавиур нь хүүхдүүдүүдийн өндрөөс өндөр учир хүүхдүүд номтой харьцахад бэрхшээлтэй, уншлагын танхимын доторх эд зүйлсийн байрлал болон өнгө нэгэн хэвийн учир хүүхдүүд чөлөөтэй тоглож харьцахад хэцүү зэрэг байдлыг харгалзаж БНСУ-ын Койка олон улсын байгууллагын буцалтгүй тусламжаар “Орон нутгийн хүүхдийн номын сангийн уншлагын танхим сэргээн засварлах ажил”-ыг 2015 оны 11-12 сарууддад хийж гүйцэтгэлээ. Энэхүү төслийн үр дүнд хүүхдийн уншлагын танхимыг 2 давхар болгож, хүүхдүүд зөвхөн ширээн дээр сууж ном уншихаас гадна зөөлөн сандал буйдан дээр сууж ном унших, 4-7 насны хүүхдүүдэд зориулсан тоглонгоо ном унших, номыг аудио видео хэлбэрээр унших, ахлах ангийн хүүхдүүдэд зориулсан мэргэжлээ хэрхэн сонгох, мэргэжлийн холбогдолтой мэдээллийг олж авах боломжийг олголоо. Төсөлд өрөө тасалгаа нэмэх, хана хаалга хийх, өрөө тасалгааг будахад 9459.8 мянган төгрөг, мөн 259 нэр төрлийн 4166.7 мянган төгрөгийн ном хэвлэлийг шинээр авч өгсөн. Хүүхдийн уншлагын танхим нь СТАжилтан Буяндэлгэрийн Хандын нэрэмжит танхим болсон бөгөөд түүний үр хүүхдүүдээс 1200.0 мянган төгрөгийн шинэ номоор баяжилт хийлээ.



2. Уншлага үйлчилгээний талаар

№	үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
1	Уншигч	1150	1267	110,1
2	Ирэгсэд	13750	14369	104,5

3	Олгосон ном	34500	37691	109,2

Уншигчдын байдлыг өмнөх онтой харьцуулбал: 104.5-110.1%-иар өссөн байна

Номын сангийн үйл ажиллагаанд шинэлэг арга барилыг нэвтрүүлж, байгууллагаа олон нийтэд сурталчлах, уншигчдын ном унших идэвхийг өрнүүлэх, уншигчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1.Төрийн шагналт яруу найрагч Р. Чойномын өвийг хамгаалах “Өд” сантай хамтран Р. Чойномын амьдрал уран бүтээлийг сурталчилах болон “Монголын мянгат малчдын алтан цадиг” /Хэнтий аймаг/, Л. Нямаа “Миний амьдардаг ертөнц” номын

нээлтүүдийг зохион байгуулж уншигч иргэдийг хамруулсан

2. Хэнтий аймгийн сумдын номын сангуудаар дамжуулан нүүдлийн номын сангийн үйлчилгээг үзүүлж, сум баг отрын малчдад номын сангаар үйлчилгээг хүртээмжтэй хүргэж ажилласан

3. Сургуулийн анги танхимуудад урилгат уншлага зохион байгуулсан

4. Уншлагын танхимуудыг тохижуулж, орчны стандарт сайжирсан.

5. Шинэ ном хэвлэлийн тайлбарт танилцуулгыг интернэт, фэйсбүүк хаягаар сурталчилж ажилласнаар номын сангийн үйлчилгээ олон нийтэд танигдаж, уншигчдын тоонд нөлөөлсөн.

6. Идэвхтэн уншигч С. Бат-Эрдэнийн удирдан явуулдаг номын сангийн дэргэдэх “Номонд дурлагсадын клуб”–тэй хамтран хүүхдүүдийн дунд үр бүтээлтэй цагийг өнгөрөөх зорилготой “Бүтээлч уншигч” аяныг Хэнтий аймгийн хэмжээнд зохион байгуулж, уншигчдын дунд ном унших хөдөлгөөн өрнүүлэн ажилласан

7. Номын сангаас зохион байгуулж буй соёл мэдээллийн ажлын чанар хүртээмж сайжирсан.

Эдгээр ажлын хүрээнд “Тэргүүний уншигч-Д. Нацагдорж” тэмдэгтнээр Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Цэнхэрмандал, Батноров, Баянмөнх, Дархан сумын болзол хангасан тэргүүний уншигч хүүхдүүдийг шалгаруулж, “Тэргүүний уншигч Д. Нацагдорж” тэмдэгтэн гардуулан өгсөн. Номонд дурлагсадын клубтэй хамтран ЕБ Сургуулийн сурагчдын дунд “Миний уншсан номууд” сэдэвт уншсан номын тэмдэглэл хөтлөх уралдааныг 06-р сараас 10-р сар хүртэл зохион байгуулж, уралдаанд Тэмүүжин цогцолбор сургуулийн 12б ангийн сурагч Б.Түмэнбаяр, 11б ангийн сурагч Б.Номин-Эрдэнэ, 9б ангийн сурагч Б.Эмүжин, 1-р сургуулийн 8б ангийн сурагч Б.Мөнхбаатар нарын 4 хүүхэд шалгаран Улаанбаатар хотруу аялах эрхийн бичгийн эзэд болон шалгарч хүүхдүүдийг Улаанбаатар хотод Монголын Үндэсний номын сантай танилцах, үнэт ховор номын музей үзүүлсэнээс гадна Төрийн шагналт яруу найрагч

Р. Чойномын нэрэмжит “Өд” сангийн дэргэдэх “Залуу нас” дугуйланд хүрэлцэн очиж залуу яруу найрагчдын уран бүтээлтэй танилцан, 5 хором шүлгийн уралдаанд оролцуулсан.
2015 онд хандиваар 11 нэр төрлийн 27 ширхэг 352,000 төгрөгний ном Төсвийн хөрөнгөөр 250 нэр төрлийн 342 ширхэг 5198.3 төгрөгний нийт 261 нэр төрлийн 369 ширхэг 5550,3 мянган төгрөгийн номоор номоор фонд баяжилт хийсэн.
31 нэр төрлийн 365.3 мянган төгрөгийн тогтмол хэвлэл захиалан уншигчдад ашиглуулж байна. Аз хур номын их дэлгүүрээс зарласан “72 цагийн турш 72 хувь хямдрал” номын хямдралаар уран зохиол болон бусад шинжлэх ухааны номнуудыг хямдралтай авч фондоо баяжуулсан явдал нь ололттой ажил болсон.

Болор судар, Жиком Пресс, Интерном, Аз Хур, Ном коллектор зэрэг шилдэг номын дэлгүүрүүдтэй гэрээ байгуулан номын сонголтонд анхаарч шилдэг борлуулалттай номнуудаас фонд баяжилт хийж ажиллаж ирлээ. Шинээр ирсэн 80 шилдэг номнуудаар зурагт мэдээлэл, тайлбарт танилцуулгыг мэдээллийн самбар фэйсбүүк хуудсуудаар сурталчилж, шинэ номын болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнгүүдийг гаргаж ажилласнаар уншигчдын тоо нэмэгдсэн. Төрийн шагналт зохиолууд 3 боть, Тэнгэрийн зарлиг, Улбар инээдмийн шугуй, “1084” 3 боть, Монголын эх түүхийн 6 боть, Очир эрхшээгч, Сорхугтани зэрэг шинэ номууд, Хэнтий нутгаас гарсан төрийн соёрхолт 4 зохиолчдын зохиол бүтээлүүдээр тайлбарт мэдээлэл хийж уншигчдад сурталчилан ажиллаж байна.
2002 онд БСШУЯамнаас зарласан номын сангийн шилдэг програм шалгаруулах уралдаанд шалгарсан Номын сангийн цогц програм LiB4U Net Versoin 1.9-ийг үйл ажиллагаандаа хэрэглэж байгаа бөгөөд одоогийн байдлаар электрон каталогит **22.679** төрлийн **53.822** ширхэг ном бүртгэгдсэн байна. Мөн номын электрон каталогоос гадна уншлага үйлчилгээ үзүүлэх, каталогийн карт хэвлэх уншигчийн үнэмлэх хэвлэх зэрэг давуу талтай.
Шинээр ирсэн ном болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнгүүдийг Номын баяраар ЕБ-ын 4 сургууль, МСҮТөв, Хэрлэн сумын соёлын төв, цэцэрлэгүүдэд, дэлхийн сонгодог урлаг Чингис хотод Улсын дуурь бүжгийн эрдмийн театр, Хан Хэнтий чуулгын бүжигчдийн хамтарсан тоглолтод, Хан Хэнтий зохиолчдын зохиол бүтээлийг сурталчилах, шинэ номын үзэсгэлэн худалдаа, Жолоочийн нэг өдөр,

ШШГАлбанд зохион байгуулсан “Бид уншигч” өдөрлөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр, Хэрлэн сумын 3-р багаас гаргасан “Үүрдийн баян үргэлжийн мөнх” номын нээлт, “Монголын мянгат малчдын алтан цадиг оршвой” нэгдүгээр боть Хэнтий аймаг номын нээлт, Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигаар жил бүр зохион байгуулагддаг “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг тохиолдлуулан “Бичиг соёл-2015” үзэсгэлэн, уншигчдын бүтээлүүд болох уран бичлэг, гоо бичиг, эссэ бичлэгийн шилдэг бүтээлүүдийг тавьж сурталчилсан, шинэ номын болон Хэнтий аймгаас төрсөн 4 төрийн соёрхолт зохиолчдын үзэсгэлэн болон тэмдэглэлт өдрүүдэд зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилан ажилласан.

Номын сангаас зохион байгуулсан соёл мэдээллийн ажил Зүүн бүсийн номын санчдын өдөрлөгийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 105 дугаар зарлиг

Үндэсний бичиг үсгийн баярыг тэмдэглэж, “Барга ард түмний ёс заншил” сэдэвт илтгэлийн уралдаанд нийт 80 гаруй хүүхдүүд илтгэлээ ирүүлсэнээс хоёрдугаар шатны шалгаруулалтад БНХАУ-ын ӨМӨЗ Орны Хөлөнбуйр хотын шинэ барга баруун хошууны боловсролын газрын мэргэжилтэн Сэчин, Хөлөнбуйр хотын шинэ барга зүүн хошууны барга соёлын судалгааны хурлын дарга Х. Сумьяажав,

соёлын судалгааны хурлын албан гэрийн эрхлэгч Х. Алмааз болон 2 хүүхдийн төлөөлөл, Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймгуудаас шалгарсан 6 хүүхэд оролцож, нийт 10 илтгэгч хүүхэд оролцсоноос Дорнод аймгийн ЕБ сургуулийн сурагч Ч. Алтанзулын "Баргын эрх чөлөөний тэмцэл, нүүдэл суудал" илтгэл тэргүүн байр, Сүхбаатар аймгийн нэгдүгээр бүрэн дунд сургуулийн 11в ангийн сурагч Б. Батчимэгийн "Барга ард түмний хувцас эдлэл" дэд байр, БНХАУ-ын ӨМӨЗ Орны баруун барга хошууны Х. Начингийн "Барга нүүдэл" илтгэл гуравдугаар байр эзэлж, БНХАУ-ын Баруун барга хошуу, Зүүн барга хошуугаар аялах эрхийн бичгээр шагнаж урамшууллаа. Энэхүү "Барга ард түмний ёс заншил" илтгэлийн уралдааныг Дорнод аймгийн Барга угсаатны соёлын өвийн хамт олон шагнаж урамшууллаа. Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд Хэнтий, Дорнод аймгийн номын сангууд "Босоо монгол бичиг мину" үзэсгэлэн гаргаж уншигчид болон оролцогчдод сурталчиллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 08-р сарын 24-ний 158-р зарлигийн дагуу жил бүрийн 9 дүгээр сарын гурав дахь долоо хоногийн Бямба гарагийг "Номын баярын өдөр" болгон тэмдэглэх болсон, энэхүү номын баярын үйл ажиллагаа нь Х. К. Андерсений мэндэлсэний 210 жилийн ойтой давхцаж буйгаараа онцлогтой.

Манай номын сан энэ жилийн "Номын баяр"-ыг 2015 оны 09-р сарын 16-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаатайгаар "Бүтээлч уншлага" уриан дор зохион байгууллаа. Номын баярын нээлтийн үйл ажиллагаанд Нийтийн номын сангийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Одонтуяа, Аймгийн ЗДТГазрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн соёл хариуцсан мэргэжилтэн А.Мичидмаа, Боловсрол Соёлын газрын дарга З.Бат-Эрдэнэ, Боловсрол Соёлын газрын мэргэжилтэн В.Тунгалаг, Улаанбаатар хотоос МЗЭ-ийн гишүүн, залуу шүлэгч Б.Алтанхуяг, Хан Хэнтийн утга зохиолын нэгдлийн яруу найрагчид, Өмнөдэлгэр сумын ЕБС-ийн номын санч Д.Эрдэнэчимэг, Баян-Овоо сумын ЕБС-ийн номын санч Ганцэцэг, Хэрлэн сумын Соёлын төвийн номын санч Н. Мижид, Ахмад номын санчид, ЕБ-ын 1-р сургуулийн номын санч Ж. Алтанцэцэг, Хан Хэнтий цогцолбор сургуулийн номын санч Байгалсүрэн, Номын сангийн дэргэдэх Номонд дурлагсдын клубын идэвхтэн гишүүд, ЕБС-ийн Монгол хэл уран зохиолын багш нар болон уншигч иргэд, хүүхэд багачууд оролцлоо.

Дунд ангийн сурагчдын дунд Х.К.Андерсены уран бүтээлийг сурталчилах ажлыг зохион байгуулж, түүний зохиол бүтээлүүдээр бяцхан ном урлаж сурталчилснаас гадна "Аз жаргалтай гэр бүл" үлгэрээр хэлэлцүүлэг зохион

явууллаа. Хэлэлцүүлэгт МЗЭ-ийн гишүүн, залуу шүлэгч Б.Алтанхуяг оролцсон ба хүүхдүүд түүнээс өөрсдийн сонирхсон асуултандаа хариулт аван сониорхолтой яриа өрнүүллээ.

Ахлах ангийн сурагчдын дунд Хэнтий аймгийн Биндэр сумын харъяат Төрийн шагналт, Ардын уран зохиолч С.Эрдэнийн “Наран тогоруу” туужаар хэлэлцүүлэг зохиогдлоо. Хэлэлцүүлэгт Хэрлэн сумын 5 сургуулийн ахлах ангийн сурагчид оролцсон бөгөөд МЗЭ-ийн гишүүн, залуу шүлэгч Б.Алтанхуяг урилгаар оролцож уншигч хүүхдүүдтэй Нарантогоруу туужийн тухай болон өөрийн уран бүтээлийн тухай яриа өрнүүллээ.

Нийтийн уншлагын танхимд шинэ номын болон монгол бичгээр бичсэн хүүхдүүдийн үзэсгэлэн, Өмнөдэлгэр, Баян-Овоо сургуулийн сурагчдын бүтээлүүдээр үзэсгэлэнг нийт 179 ном, уншсан номоор хийсэн сурагчдын 80 гаруй бүтээлүүдэр үзэсгэлэн гаргаж 300 гаруй уншигчдад суртачиллаа.

“Номын баярын өдөр”-ыг тэмдэглэх ажлын хүрээнд “Тэргүүний уншигч Д. Нацагдорж тэмдэгтэн”-г шалгаруулж нийт аймаг, сумын 7 сурагчдыг шагналаа.

“ЭЭЖДЭЭ ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ” УРАЛДААН

Олон улсын эмэгтэйчүүдийн баяр, мартын 8-ныг тохиолдуулан ЕБС-ын 8-12-р анги, Насанд хүрэгчдийн дунд “Ээждээ захидал бичээрэй” уралдааныг зарлаж, нийт 163-н захидал ирснээс Насанд хүрэгчдэд 1-р байрт Жаргалтхаан сумын иргэн Ц.Цэндбаяр, 2-р байрыг ШШГА хорих 0419-р ангийн хүмүүжигч Р.Отгонбаатар, 3-р байрыг Хэрлэн сумын 2-р багын иргэн П.Тунгалаг, ЕБС-ын 8-12-р ангид 1-р байр Тэмүүжин цогцолобр сургуулийн 12Е ангийн М. Тамир, 2-р байр “Гэгээрэл” төвийн Од бүлгийн сурагч Г.Чулуунцэцэг, 3-р байрыг Хан Хэнтий цргцолбор сургуулийн 12Б ангийн Н.Пүрэвхорол нар тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.

Шалгарсан захидлуудыг Өндөрхаан ТҮ-тэй хамтран орон нутгийн үзэгчдэд хүргэж нэвтрүүлсэн бөгөөд захидлын эздэд нь уг захидлыг хүргэж ажиллалаа.

<u>Насанд хүрэгчдийн ангилалд:</u>

***1-р байр* Жаргалтхаан сумын иргэн Ц.Цэндбаяр**

***2-р байр* ШШГА-ны Хорих 0419-р ангийн хүмүүжигч Р.Отгонбаатар**

<u>ЕБС-ийн 8-12-р ангийн сурагчдын ангилалд:</u>

***1-р байр:* ТЦС. 12Е ангийн сурагч М.Тамир**

***2-р байр:* Насан туршийн Оч бүлгийн сурагч Г.Чулуунцэцэг**

3-р байр: ХХЦС-ийн 12А ангийн сурагч

Н.Пүрэвжаргал

“ААВДАА ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ -2015”

Р.Чойномын нэрэмжит аймгийн нийтийн номын сан болон Өндөрхаан телевизтэй хамтран зохион байгууллаа. ЕБС-ийн 8-12-р ангийн сурагчид болон Насанд хүрэгчдийн дунд зохион явуулж, дүнгээр гаргалаа. Нийт 78 захидалыг хүлээн авч, 2 ангилалд 1,2,3-р байруудыг шалгаруулж, эхний 3 байруудын захидлуудыг эзэнд нь хүргэж өглөө.

Насанд хүрэгчдийн ангилалд:

1-р

байр: Хэрлэн сумын 4-р багийн

2-р байр: Хэрлэн 4-р сургуулийн багш

иргэн Ш.Цэцэгмаа

Э.Эрдэнэсувд

3-р байр: Баянмөнх сумын 4-р багийн өндөр настан О.Цэрэннадмид

ЕБС-ийн 8-12-р ангийн сурагчдын ангилалд:

1-р байр: ТЦС-ийн 12Е ангийн сурагч Б. Анужин

2-р байр: ТЦС-ийн 9А Ангийн сурагч М.Тамир

3-р байр: ТЦС-ийн 10Б ангийн сурагч Г.Номин Эрдэнэ

Ерөнхий зохион байгуулагч:
Р.Чойномын нэрэмжит аймгийн нийтийн номын сан

Ивээн тэтгэсэн:

- Өндөрхаан телевиз
- “Хан Хэнтийн бүсгүйчүүд” ТББ
- “Эвт суврага”ХХК
- “ШШГА”
- “Хэрлэн талст”ХХК

“ГЭГЭЭН ХҮСЭЛ-2015” УРАН УНШЛАГЫН НААДАМ

Архигүй Хэнтийчүүд хөтөлбөрийн хүрээнд Аймгийн Нийтийн номын сан, “Хэрлэнгийн цэнхэр алс” ТББ-тай хамтран “ГЭГЭЭН ХҮСЭЛ-2015” уран уншлагын уралдааныг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлж буй “Архигүй Хэнтий хөтөлбөр”, Хэрлэн сумын засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч Н. Базархандын хэрэгжүүлж буй “Архигүй Хэрлэнчүүд дэд хөтөлбөр”-ийн хүрээнд нийгэмд газар аваад байгаа архидалтын хор хөнөөлийг сурталчилах зорилгоор Ерөнхий боловсролын дунд сургуулиуд болон МСҮТөвийн сурагчдын дунд “ГЭГЭЭН ХҮСЭЛ-2015” уран уншлагын наадмыг зохион байгууллаа. Энэхүү тэмцээнд Үндэсний лаборатори 1-р сургууль, Хан Хэнтий, Тэмүүжин цогцолбор сургууль, ЕБ Сургуулийн 4-р сургууль, МСҮтөвийн сурагчид оролцсоноос Ахлах, дунд насны ангилалд Үндэсний лаборатори сургуулийн 11-р ангийн сурагч Ш. Эрхэмбаяр, ЕБ-ын 4-р сургуулийн 8-р ангийн сурагч А. Чаминцэцэг нар “ТЭРГҮҮН БАЙР”, МСҮТөвийн сурагч 11-р ангийн сурагч Д. Нямдорж, Тэмүүжин цогцолбор сургуулийн 7-р ангийн сурагч Б. Тэмүүжин нар “ДЭД БАЙР”, Тэмүүжин цогцолбор сургуулийн 10-р ангийн сурагч Б. Нандин-Эрдэнэ, тус сургуулийн 9-р ангийн сурагч Б. Үүрийнтуяа нар ”ГУТГААР БАЙР”, Үндэсний лаборатори 1-р сургуулийн 11-р ангийн сурагч А.Цэрэндорж, Хан Хэнтий цогцолбор сургуулийн 9-р ангийн сурагч Г. Нандинцэцэг нар “ТУСГАЙ БАЙР”-ыг эзэллээ

Энэхүү тэмцээнийг ивээн тэтгэж оролцсон байгууллагууд нь хүүхдийн сайн сайхны төлөө болон Архигүй Хэнтийчүүд хөтөлбөрийг ивээн тэтгэн оролцсон бөгөөд Skytel компани тэргүүн байр эзэлсэн хүүхдэд гар утас, эхний 3 байранд шалгарсан хүүхдэд 50 хувийн хямдралтай авах азын дугаар, болон бусад оролцогчдад Skytel-ын 50 хувийн хямдралтай дугаарыг бэлэглэсэн явдал нь хүүхдүүдийг баярлуулсан ажил боллоо.

“Нутгийн удирдлагууддаа бичсэн захидлын уралдаан-2015”

“Удирдлагууддаа илгээх захидал”-ын уралдааныг Хэрлэн сумын 7 багийн иргэдийн дунд зарлаж, 20 гаруй захидал ирүүлсэнээс Хэрлэн сумын 3-р баг Тэмүүжин цогцолбор сургуулийн Б. Түмэнбаярын бичсэн Аймгийн Засаг даргад илгээсэн захидал тэргүүн байр, Хэрлэн сумын 5-р багийн иргэн С.Бат-Эрдэнийн бичсэн Аймгийн ИТХурлын даргад бичсэн захидал дэд байр, Хэрлэн сумын 1 багийн иргэн Г. Чинзоригийн бичсэн Хэрлэн сумын засаг даргад бичсэн захидал гутгаар байр эзэлж, батламж, мөнгөн шагналаар шагналаа. Энэхүү уралдааныг Чингис хот хэмээн нэрлэсний 2 жилийн ойн ажлын хүрээнд зохион байгуулж

байгаа бөгөөд Хэрлэн сумын ИТХурал хамтран зохион байгуулж шагнал урамшууллыг ивээн тэтгэж ажилласан

ШШГАлбаны 0419-р ангид хүмүүжиж байгаа 120 гаруй хүмүүжигчдэд “Бид уншигч” номын өдөрлөг зохион байгуулж, шинэ номын үзэсгэлэн, хамгийн олон ном уншсан уншигч, ном хандивлах үйл ажиллагаа явууллаа. Мөн хүмүүжигчдийн дунд “АХА” тэмцээн зохион явуулж, нүүдлийн номын сангаар үйлчилгээ үзүүллээ.

“Зүүн бүсийн ур чадварын уралдаан тэмцээн”

Зүүн бүсийн номын санчдын “АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ӨДӨРЛӨГ” 2015 оны 05-р сарын 01, 02-нд Чингис хотод зохион байгуулагдаж, Дорнод аймгийн төвийн болон сумын нийт 31 номын санч, Сүхбаатар аймгийн төвийн болон Түмэнцогт, Уул-баян, Наран, Эрдэнэцагаан сумын нийт 17 номын санчид, Хэнтий аймгийн төвийн болон 22 сумын номын санчид болон сумдын нийт 80 гаруй номын санчид оролцлоо.

СУИС-ын харьяа Соёлын сургуулийн багш Т. Хайдав, Удирдлагын академийн номын сангийн захирал Ч. Мөнх-Эрдэнэ, Д. Нацагдоржийн нэрэмжит хотын номын сангийн мэдээлэл технологийн ажилтан Л. Гантулга болон БНХАУ-ын ӨМӨЗОрны Хөлөнбуйр хотын шинэ барга баруун хошуу болон зүүн барга хошууны нийт 11 төлөөлөгчид оролцлоо.

Ажил мэргэжлийн өдөрлөгийн хүрээнд “Ур чадварын уралдаан тэмцээн” зохион байгуулж, Хэнтий аймгийн төвийн номын сангийн хамт олны “Оюуны ундарга” баг ТЭРГҮҮН БАЙР, Сүхбаатар аймгийн “Жаахан шарга” ДЭД БАЙР, Хэнтий аймгийн сумдын номын санчид оролцсон “Хөх судар” баг ГУРАВДУГААР

БАЙР эзэллээ.

Номын сангийн мэргэжлийн ур чадварын уралдаан тэмцээний хүрээнд номын санчдын мэдлэг, харилцаа хандлагыг өөрчлөх, мэдээллийн идэвхтэй зуучлагч байхад номын санчдыг чадавхжуулах зорилгоор “Орон нутгийн номын сан, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа” сэдвээр СУИС-ын Соёлын сургуулийн багш, Номын сангуудын консорциумын гүйцэтгэх захирал Т.Хайдав “Уламжлалт үйлчилгээнээс мэдээллийн технологид суурилсан үйлчилгээнд шилжих нь” сэдвээр Д. Нацагдоржийн нэрэмжит хотын номын сангийн мэдээлэл технологийн ажилтан Л. Гантулга, “Номын санчдын ёс зүй, харилцаа хандлага” сэдвээр, Удирдлагын академийн номын сангийн захирал Ч. Мөнх-Эрдэнэ нар сургалт семинар зохион байгууллаа.

"Зүүн бүсийн номын санчдын ажил мэргэжлийн өдөрлөг"-ийн хүрээнд БСШУЯамнаас сургалт зохион байгуулах зардалд 500.0 мянган төгрөг, Аймгийн Засаг дарга 2015 оны 05-р сарын 14-ны өдрийн А/229 тоот захирамжаар 1800.0 мянган төгрөгийг төсвийг Засаг даргын нөөц сангаас шийдвэрлүүлж ажиллалаа.

4. Сургалт сурталчилгаа

Хэнтий аймгийн 21 сумын соёлын төвүүдийн номын сангуудын 2014 онд хийсэн ажлын үзүүлэлтүүдэд дүгнэлт хийж, сумын номын сангуудыг байр эзлүүлж, сумын засаг дарга болон соёлын төвийн эрхлэгч нарт хүргүүлж ажилласан.

БСГазрын даргын баталсан удирдамжийн дагуу Баян-Адарга, Биндэр, Батширээт, Хурх, Өмнөдэлгэр, Өлзийт, Мөрөн, Баян-Овоо сумдын номын сангуудын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцаж, хяналт шинжилгээ, зөвлөн туслах ажлыг 2015 оны 10 сарын 30-наас 11 сарын 04-ны өдрүүдэд хийлээ. Хяналт үнэлгээ хийхээс гадна мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Хяналт үнэлгээ хийж ажиллахад Баян-Адарга, Хурх, Өлзийт сумын номын сангуудын үйл ажиллагаа сайжирсан, Өмнөдэлгэр, Мөрөн, Баян-Овоо сумдын номын сангууд хангалтгүй ажиллаж байна гэсэн дүгнэлт хийсэн. Сумдын номын санчдын тайланг сар бүр хүлээн авч, ирсэн тайлангуудаар



мэдээллийн танхимд үзэсгэлэн гаргаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөн ажиллаж байна.



3. Хөрөнгө оруулалт

2015 онд БСШУ Яамнаас Хэнтий аймгийн Батширээт, Баян-Овоо, Биндэр, Галшар, Өмнөдэлгэр сумын номын санд 264.6 мянган төгрөг, Өлзийт, Хурх тосгоны номын санд 2177.0 мянган төгрөгийн номын тавиур, сонин сэтгүүлийн тавиур, каталогийн шүүгээ нийт 15415.3 мянган төгрөгийн эд хогшлыг хандиваар олголоо. Сумын соёлын төвийн номын санд болон ЕБСургуулийн номын сангуудад 2 нэр төрлийн 1716.0 төгрөгний ном, номын санчдад МҮНСангаас гаргасан номын санчдын гарын авлага 396 номыг тус тус хуваарилан олголоо.